



# МОНГОЛ УЛС

## ЗЭЛҮҮД ТАЛ-2:

Нэгэн арваны дараах зэрлэг амьтны  
худалдааны хямрал



# МОНГОЛ УЛС

## ЗЭЛҮҮД ТАЛ-2:

Нэгэн арваны дараах зэрлэг амьтны  
худалдааны хямрал

2019 оны 9 дүгээр сар



Энэхүү судалгааны тайланг Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын (ИБУИНВУ) Байгаль орчин, загас агнуур, хөдөө аж ахуйн яамны харьяа Зэрлэг амьтны хууль бус худалдааны сорилтын сангийн санхүүжилтээр Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг (ЛАСН), Лийгэл Атлас болон Монголын Хараат бус судалгааны хүрээлэн хамтран гаргалаа.

ИБУИНВУ-ын Засгийн газар байгаль орчин төдийгүй хүн төрөлхтөнд заналхийлж буй жилийн 6 тэрбум фунт стерлингийн эргэлттэй зэрлэг амьтны хууль бус худалдаатай шийдэмгий тэмцэх үүрэг хүлээсэн юм. Зэрлэг амьтны хууль бус худалдааны сорилтын сангаас дэлхий даяар хэрэгжиж буй төслүүдийг санхүүжүүлдэг бөгөөд дараах зорилготой:

1. Зэрлэг амьтны хууль бус худалдааны сөрөг нөлөөнд өртөж буй хүн амын тогтвортой амьжиргааг дэмжих ,
2. Хуулийн хэрэгжилтийг хангах эрүүгийн эрх зүй, шүүхийн системийн үүрэг ролийг бэхжүүлэх;
3. Зэрлэг амьтны хууль бус худалдаанд хамаарах бараа, бүтээгдэхүүний эрэлтийг бууруулах явдал юм.

Зэрлэг амьтны хууль бус худалдааны сорилтын сангаас 2017 оны байдлаар 34 төсөлд 9.8 сая орчим фунт стерлингийн санхүүжилт олгоод байна.

Энэхүү судалгааны тайланг цахим хэлбэрээр [www.zsl.org](http://www.zsl.org) болон [www.legal-atlas.net](http://www.legal-atlas.net) сайтаас үзэж болно.

### **Иш татах бичвэр:**

Вингард Ж.Р., Паскуал М., Рюд А., Хоул А., Конабой Н., Батачаря Г., С.Гомбобаатар, М.Мөнхжаргал, Ш.Мягмарсүрэн, Т.Батсугар, Т.Болд, 2017, Зэлүүд тал-2: Нэгэн арваны дараах зэрлэг амьтны худалдааны хямрал, Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг, Лондон, ИБУИНВУ, Лийгэл Атлас, Хараат бус судалгааны хүрээлэн

### **Тайлангийн асуудлаар холбогдох хаяг:**

Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын захирал У. Тунгалаг

Цахим шуудан: [tungalag.ulambayar@zsl.org](mailto:tungalag.ulambayar@zsl.org)

Лийгэл Атлас байгууллагын эрх зүйн асуудал хариуцсан захирал Жеймс Вингард

Цахим шуудан: [james.wingard@legal-atlas.net](mailto:james.wingard@legal-atlas.net)

Лийгэл Атлас байгууллагын захирал Мария Паскаул

Цахим шуудан: [maria.pascual@legal-atlas.net](mailto:maria.pascual@legal-atlas.net)

Энэхүү тайлан нь Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг, Лийгэл Атлас, Хараат бус судалгааны хүрээлэнгийн ажилтнууд болон тайлангийн эцсийн

хувилбарыг тунгаан шүүж үнэ цэнэтэй санал зөвлөмж өгсөн бүх хүний хамтын бүтээл юм. Ялангуяа Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамыг төлөөлөн тайлангийн англи эхийн үндсэн бүлгүүдийг хянан тохиолдуулах ажилд чухал хувь нэмэр оруулсан С.Гомбобаатарг онцгойлон талархал илэрхийлье. Энэхүү тайлан хэвлэгдэн гарахад дэмжлэг үзүүлсэн ИБУИНВУ-ийн Монгол Улс дахь Элчин Сайдын Яаманд талархал илэрхийлье.

Тайланд дурдсан үр дүн, дүгнэлтүүд нь дээрх нэр бүхий байгууллага болон Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлээгүй болно. Энэхүү судалгаанд оролцсон аль ч байгууллага тайлан дахь мэдээ мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Мөн тайланд орсон газрын зургийн хил хязгаар, өнгө болон бусад мэдээлэл нь тухайн судалгааны байгууллагын зүгээс тус газар нутгийн эрх зүйн статус, хил хязгаарыг хүлээн зөвшөөрсөн эсэхийг илэрхийлээгүй болно.

Энэхүү тайлан зохиогчийн эрхээр хамгаалагдсан бөгөөд зохих зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүтнээр нь хуулбарлах, хөрвүүлэх нь холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэлд тооцогдоно. Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг болон Лийгэл Атлас байгууллагын зүгээс энэхүү бүтээлийг түгээн дэлгэрүүлэхийг хөхүүлэн дэмжиж, тайланг хэсэгчлэн нийтлэх тухай зөвшөөрөл хүссэн тохиолдолд зохих зөвшөөрлийг даруй олгоно. Тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах эсвэл дахин хэвлэх зөвшөөрөл авах бол бүрэн мэдээлэл бүхий хүсэлтээ Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгт илгээнэ үү.

### **Тайланг монгол хэлэнд хөрвүүлсэн:**

Д.Ганхуяг

### **Монгол эхийг хянан тохиолдуулсан:**

Др. Л.Ариунцэцэг (нэгдүгээр бүлэг)

Р.Болор (хоёрдугаар бүлэг)

П.Цэцгээ (гурав ба тавдугаар бүлэг)

Др. Г.Гомбобаатар (дөрөвдүгээр бүлэг)

Ц.Пүрэвсүрэн (тавдугаар бүлэг)

Др. Ц.Мөнхзул (хүснэгт, график)

Б.Мөнхжаргал (хүснэгт, график)

Др. У.Тунгалаг (ерөнхий редактор)

### **Нүүр хуудасны гэрэл зураг:**

Др. Г.Гомбобаатар

### **Нүүр хуудасны дизайн:**

Лийгэл Атлас

Зохиогчийн эрх

© 2019 Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг

© 2018 Лийгэл Атлас ХХК

Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно.

# Агуулга

УДИРТГАЛ.....	VI	Түүвэрлэлтийн дизайн.....	46
Өмнөх үг: МУ-ын Засгийн газар.....	VIII	• Өрхийн түүвэрлэлтийг сайжруулсан нь	
Өмнөх үг: ИБУИНВУ-ын Засгийн газар.....	IX	• Зах зээлийн судалгааны түүвэрлэлтийг сайжруулсан нь	
Товчилсон үгийн жагсаалт.....	X	• Өрхийн түүвэрлэлт	
		• Зах зээлийн судалгааны түүвэрлэлт	
<b>ХУРААНГУЙ.....</b>	<b>12</b>		
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ТАНИЛЦУУЛГА</b>			
Нөхцөл байдал.....	22	Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх.....	53
Агшны судалгаа.....	25	• Мэдээлэл цуглуулах	
Зорилго, арга зүй.....	27	• Мэдээллийн дүн шинжилгээ	
• Зэрлэг амьтны худалдааны судалгаанд цогц хандлага ашигласан			
• Зэрлэг амьтны худалдааны мөчлөгт нийцүүлсэн ...			
• Судалгааны аргачлалыг харилцан ялгаатай зорилгод нийцүүлсэн			
• Сайжруулсан түүвэрлэлтийн арга зүйг ашигласан			
• Мэргэжлийн судалгааны баг ажилласан			
• Мэдээлэл харилцаа холбооны технологийн шинэ боломжийг ашигласан			
• Мэдээллийг дүржүүлэн зурагласан			
• Судалгааг дэлхий нийтийн нөхцөл байдалтай уялдуулсан1			
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ: АРГА ЗҮЙ</b>		<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ: ГОЛ АСУУДЛУУД</b>	
Оршил.....	32	Олон улсын худалдаа хөтлөгч хүчин зүйл болох нь..	58
Судалгааны асуултууд.....	33	• БНХАУ-ын нөлөө	
Мэдээллийн эх сурвалж.....	34	• ОХУ-ын нөлөө	
Судалгааны баг.....	35	• Монгол Улс дамжуулагч улс болсон нь нотлогдож байна	
Судалгааны календарь.....	37		
Судалгааны хэрэглэгдэхүүн.....	38	<b>CITES-н худалдаанаас өөрчлөлтийг олж харахуй.....</b>	<b>65</b>
• Судалгааны хэрэглэгдэхүүнийг боловсруулсан нь		• Албан ёсны тоо мэдээлэл нь бодит байдлыг бүрэн илэрхийлэхгүй байна	
• Хэрэглэгдэхүүнийг баталгаажуулсан нь		• Монгол Улс гадаадын зэрлэг амьтны бүтээгдэхүүнийг хэрэглэгч орон болжээ	
• Өрхийн судалгааны хэрэглэгдэхүүн		• Амьд зүйлийн худалдаа давамгайлж байна	
• Зах зээлийн судалгааны хэрэглэгдэхүүн		• Экспорт чухал байр суурьтай хэвээр байна	
• Оролцогч талуудын судалгааны хэрэглэгдэхүүн			
		Хяналт тавихад хүндрэлтэй байна.....	73
		• Худалдааны эргэлт ихсэхийн хэрээр чадавхийг сайжруулах шаардлагатай	
		• Чөлөөт худалдааны бүс илүү эрсдэл үүсгэж байна	
		• Хилийн хамгаалалт сулрах нь хууль бус худалдааг өөгшүүлдэг	
		• Өргөн уудам газар нутгийг хамгаалах нь ярвигтай байна	

- Хүчирхийлэл хууль сахиулах ажиллагааг сулруулж байна
- Зэрлэг амьтны хууль бус худалдаа ба мансууруулах бодисын наймааны адил төстэй тал
- Монгол Улсын зэрлэг амьтны хууль бус худалдаа нь олон улсын зохион байгуулалттай гэмт хэргийн нэг хэсэг болж байна
- Хууль бус худалдааг нуун далдлах бизнес эрхлэгчдийн башир арга

#### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ИНСТИТУЦҮҮД БА ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Институцийн орчин ..... 84

- Чадавхыг дахин бэхжүүлэх нь
- Хууль тогтоогчид ба менежерүүд
- Хэрэгжүүлэгчид
- Авлига

Зэрлэг амьтны хууль бус худалдааны эрх зүйн орчин..... 108

- Эрх зүйн иж бүрэн орчин нөхцөл
- Зэрлэг амьтны эсрэг гэмт хэрэг гэж юу вэ?
- CITES-ын хэрэгжилт
- Орхигдлын шинжилгээний тойм

Зэрлэг амьтны хууль бус худалдааг яллах нь..... 129

- Хуваагдмал тогтолцоо
- Зэрлэг амьтны эсрэг гэмт хэргүүд
- Ял ноогдуулах сүүлийн шатан дахь бэрхшээл
- Дүгнэлт

#### ТАВДУГААР БҮЛЭГ: ЗЭРЛЭГ АМЬТНЫ АГНУУР БА ХУДАЛДАА

Зэрлэг амьтны агнуур ..... 144

- Анчид, загасчдын тоо
- Агнуурт өртөж буй төрөл зүйлүүд
- Агнуурын тоо хэмжээ
- Агнуурын хэмжээг тооцоолсон нь
- 2005-2015 оны чиг хандлага
- Ан агнуурын улирал
- Өнгөрсөн, эдүгээ үеийнхний ялгаа
- Хууль бус ан агнуур нэмэгдэж байна
- Загас: тарвагатай адил агнуурт өртөж буй зүйл
- ‘Бид яг л хулгайч шиг загасчилж байна’
- Анчид, загасчдын ерөнхий шинж байдал

Зэрлэг амьтны худалдааны зах зээл..... 162

- Өрхийн борлуулалт
- Өрхийн худалдан авалт
- Ресторанууд
- Уламжлалт эм, эмчилгээ
- Жижиглэн худалдааны зах зээл
- Ил захууд
- Цахим худалдаа
- Трофи ан агнуур

Тохиолдлын судалгаа: Саарал чоно..... 186

Тохиолдлын судалгаа: Тарвага..... 190

Ашигласан бүтээл ..... 195

# УДИРТГАЛ

Зэрлэг амьтны худалдааны асуудлаар Монгол Улсад урьд өмнө хийж байгаагүй томоохон хэмжээний иж бүрэн судалгааг Дэлхийн банкны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн хэлтсийн санхүүжилтээр, Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS) удирдлага дор 30 байгууллагын 50 гаруй төлөөлөл бүхий баг 2005 оны зун хийж гүйцэтгэсэн юм. Энэхүү судалгааны санаа олон талаас гарч гол нь зэрлэг амьтны тоо толгойн аажим боловч мэдэгдэхүйц бууралтын үндсэн шалтгаан байж болзошгүй ан агнуур, худалдааны сэжиг бүхий өсөлтөнд чиглэж байв.

Монгол Улсын 21 аймгийг<sup>1</sup> хамарсан энэхүү судалгааны явцад судлаачид 4,000 гаруй хүнтэй уулзаж ярилцсаны зэрэгцээ зэрлэг амьтны худалдааны бодит байдал, чиг хандлагын талаар олон талын мэдээ мэдээлэл цуглуулах зорилгоор зах зээлийн 1,100 судалгаа хийсэн байна. Үүний зэрэгцээ зохиогчид орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас ан агнуурын тухай мэдээ мэдээлэл цуглуулж, ОХУ болон БНХАУ руу зорчин хил орчмын бүсийн нөхцөл байдлыг нүдээр үзэж, зэрлэг амьтны худалдаанд хамаарах Монгол Улсын болон олон улсын хууль эрх зүй, тэдгээрийн хүрээнд хүлээх үүрэг хариуцлагад орхигдлын шинжилгээ хийж, өнгөрсөн болон ирээдүйн талаарх ойлголт, төсөөлөл өгч чадах бүх хүмүүс тухайлбал хуульч, шүүгч, цагдаа, хил хамгаалах ажилтан, байгаль хамгаалагч, биологич нартай оролцогч талуудын хамтарсан уулзалтыг удаа дараа хийсэн.

Энэхүү нөр их ажлын үр дүнд өмнө нь зөвхөн таамаг, явган яриа төдий байсан зүйлсийг тоо баримт, график дүрслэл, гэрэл зургаар баримтжуулсан зуу гаруй хуудастай “Зэлүүд тал: Монгол улс дахь зэрлэг амьтны худалдааны хямрал” хэмээх тайланг олны хүртээл болгожээ. Хуулиар хамгаалаагүй, бодит амьдрал дээр бүр ч хамгаалалтгүй буй Монгол орны зэрлэг амьтад нь улам бүр өсөн нэмэгдэж буй анчид, хэрэглэгчдийн гол бай болохын хамт хил хязгаараар үл зааглагдах үйлдвэрлэлийн салбар, зах зээлийн хэрэглээний чухал эх үүсвэр болж байна. Өнөөдөр ч урьдын адил агнан худалдаалж байсан төрөл зүйлүүдийг худалдаалсаар байна. Гэвч хяналтгүй эсвэл хяналт сул орчинд зэрлэг амьтны хууль бус худалдаа урьд хэзээ ч байгаагүй том цар хүрээ, зах зээлийг хамран хийгдэж байна. Хүнсний зориулалтаар агнаж байсан тарвага гэхэд л БНХАУ-ын үслэг эдлэлийн зах зээлийн гол эх үүсвэр болжээ. Судалгааны дүнгээс үзэхэд тарвагыг жил бүр хэдэн мянгаар нь бус, харин хэдэн саяар нь агнан худалдаалж байна.<sup>2</sup> Мөн уламжлалын дагуу арьс, үс,

мах, ардын эмчилгээ, мал сүргээ хамгаалах зэрэг олон зориулалтаар агнаж байсан чоныг өнөөдөр уламжлалт анагаах ухаан, спорт агнуур зэрэг орчин үеийн шинэ зах зээлийн хэрэгцээг хангах хэрэглүүр болгожээ. Олон жилийн турш хязгаарлагдмал тооны төрөл зүйлийг худалдаалж ирсэн<sup>3</sup> Монгол Улсын нилээд тооны зэрлэг амьтан айл өрхийн хэрэглээнээс хилийн чанад дахь зах зээлийн бараа бүтээгдэхүүн болон хувирах замыг туулж байна.

Зэрлэг амьтны агнуур, худалдааны хэмжээ эрчимтэй өсөн нэмэгдэж байгаа нь уг асуудалд хамааралгүй мэт санагдах 1989 онд болсон Берлиний хана нуран унасан үйл явдалтай нягт уялдаатай юм. Улс төрийн тавцанд мөрдөж байсан үзэл суртал нь төгсгөл болсон нь хуучин Зөвлөлт маягийн төвлөрсөн эдийн засгийн системтэй байсан Монгол зэрэг улс орнуудад хүндээр туссан юм. Эдийн засгийн шилжилтийн эхэн үеийн хэдэн жилд Монгол Улсын инфляцын хэмжээ гурван оронтой тоонд хүрч, ДНБ нь 30 хувиар буурч<sup>4</sup>, эдийн засгийн бүх салбар хүчтэй хомсдолд өртөн, хоол хүнс, өргөн хэрэгцээний бараа бүтээгдэхүүний хангамж тасалджээ. Нийт хүн амын гурваны нэг нь нэн ядууд тооцогдох болж, 50 хувь нь өдөрт нэг хүрэхгүй долларын орлоготой амьдрах хүндрэл нүүр тулжээ.<sup>5</sup> Шилжилтийн энэхүү хүнд хэцүү үе олон шалтгааны улмаас 2000 оны эх хүртэл үргэлжилсэн байна.<sup>6</sup> Эмчилгээ, үслэг эдлэл, хувцас зэрэг хэрэглээгээ байгалиас зэрэг хангаж ирсэн уламжлал нь алдагдаж, урьдчилан таамаглаагүй нөхцөл байдлаас үүдэн энэхүү уламжлалт эх үүсвэрт хандах хандлагад эргэлт гарчээ.

Олон хүний хувьд ахархан хугацаанд үлэмж хэмжээний хор уршиг гарч болохыг төсөөлөхөд бэрх байдаг. Хэд хэдэн орныг бүхэлд нь багтаам Монголын уужим тэнүүн нутаг, өвс нь халиурсан онгон хээр 90-ээд оны эхээр зэрлэг амьтны үзэсгэлэнг бахдан харж болох дэлхийн хуруу дарамхан цөөн газрын нэг байлаа. Тэр үед царцаа мэт олон тарвага, газрыг бүрхэн нүүдэллэх хэдэн живаа зээрийн сүрэг, Улаанбаатар хотын төвөөс холгүйхэн байх орон сууцны өмнүүр идээшлэх халиун буга, загасчин хүний мөрөөдөл болсон гол мөрөн энэ л нутагт нам гүмхэнээр оршин байв. Эдийн засгийн хямрал нүүрлэж, худалдаа арилжааны хаалга нээгдэх үеэр эд бүгд шуналтны хараа булаасан нөөц баялаг болон хувирсан юм.

1 Монгол улс нь 21 аймаг, нийслэл хотод хуваагддаг ба Улаанбаатар хотыг хараат бус нутгийн өөрөө удирдах байгууллага удирддаг.

2 Wingard, J and P. Zahler. (2006) Silent Steppe: The Illegal Wildlife Trade Crisis in Mongolia. Wildlife Conservation

Society. (Ж.Вингард болон П.Залер, 2006 Зэлүүд тал: Монгол Улсын зэрлэг ан амьтны хууль бус худалдааны хямралтай асуудлууд. Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг)

3 Хуучин ЗХУ-ын үед Монгол улс нь тарвага, үнэг, хярс, чоно, эрлэг гахай, зээр болон улаан хэрэм гэсэн 7 зүйлийг албан ёсоор худалдаалдаг байжээ. Ж.Вингард болон П.Залер, 2006, х. 17.

4 ТТГ Баримтын товчоон, Монгол улс. 2017 оны 1 дүгээр сар; мөн дараах нийтлэлийг үзнэ үү: Sindelar, Daisy. December 9, 2009. Mongolian Democracy: From Post-Soviet Success to Post-Transition Struggle. Radio Free Europe/Radio Liberty.

5 Sindelar (2009).

6 ТТГ Баримтын товчоон.



Улс төр, эдийн засгийн энэхүү шилжилт Монгол Улсын зэрлэг амьтдад шууд бөгөөд эргэн засахад хүндрэлтэй сөрөг нөлөө үзүүлсэн нь аажим боловч улам бүр тодорхой болж байна. Саяхныг болтол бидэнд мэдэгдэж байсан зүйл нь зэрлэг амьтны судалгаа, хамгааллын үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг мэргэжлийн байгууллагуудаас гаралтай ч ихээхэн хязгаарлагдмал, зөвхөн аман мэдээнд суурилаг байв. Үүний шалтгаан нь зэрлэг амьтны хууль бус худалдааны асуудлыг бүрэн хариуцах чиг үүрэг бүхий байгууллага байхгүй, төрөл зүйлийг бүхэлд нь бус цөөн хэдэн зүйлийн хэмжээнд судлаж байсантай холбоотой. Мэдлэгийн энэхүү хоосон орон зайг дүүргэх, зэрлэг амьтны хууль бус худалдааг аль болох өргөн хүрээнд, олон төрөл зүйлийг хамруулан, аль болох олон байгууллагын оролцоотой судлаж, хэн бүхний мэдэх шаардлагатай, таамаглаж буй мэдээллийг баримтаар нотлох нь 2005 онд хийсэн судалгааны гол сэдэл, зорилт байсан юм. Энэ ажлын үр дүнд 2006 оны хавар Зэлүүд тал анхдугаар тайлан хэвлэгдэн гарсан билээ.

Тус судалгаа нь бүхэлдээ биш ч гэлээ олон нийтэд урт хугацааны нөлөөлөл үзүүлсэн нь бага зэрэг гайхал төрүүлсэн юм. Учир нь ийм төрлийн судалгаа нь олон тооны баримт бичгийн дунд уусан алга болж, ийм тайлан судалгаа байсан гэх ул мөр ч үлдэхгүй байх нь хэвийн үзэгдэл байдаг. Харин анхдугаар Зэлүүд тал тайлангийн хувьд азтай (эсвэл азгүй) учир шалтгааны улмаас ийм зүйл тохиолдоогүй юм. Тайланг хэвлэгдэхээс өмнө Нью-Йорк Таймс сонинны шинжлэх ухааны нийтлэлч Жон Вилфорд<sup>7</sup> судалгааны болон олон улсын сонирхолоос илүүтэйгээр өргөн уудам тал хээр, говь цөл, ой хөвчид оршин амьдрах гайхамшигт зэрлэг амьтад бүхий Монгол нутгийн үнэ цэнийг хөндсөн мэдээ сурвалжлага шаргуу гаргасан нь ердийнхөөс илүү олон хүний сонирхолыг татав. Анхдугаар Зэлүүд тал тайлан хэвлэгдсэн 2006 он бол зэрлэг амьтны худалдааг дэлхийн хэмжээний улам бүр хүрээгээ тэлж буй асуудал болохыг олон улсын хамтын нийгэмлэг харахан ойлгож ухаараагүй он жил байсан юм. Одоо хэр нь зэрлэг амьтны худалдааны олон улсын яриа хэлэлцээр Монгол Улсад байдаггүй төрөл зүйл (бар, хирс, заан) болон өргөн цар хүрээтэй худалдаа хийгддэг улс орнууд руу чиглэж байна. Анхдугаар тайлан гарснаас хойшхи хугацаанд Монгол Улс дахь зэрлэг амьтны худалдааг бууруулах чиглэлд гарсан аливаа хүчин чармайлт нь зэрлэг амьдныг аврах үйлсэд Монгол Улсын иргэд болон төр засгийг шавдуулсан буй за.

Энэхүү хүчин чармайлалтын дүнд анхны тайлан хэвлэгдсэнээс хойш арав гаруйхан жилийн дараа статистик, бодлого, практик асуудлуудыг бүхэлд нь хамруулсан шинэ судалгаагаар нь зэрлэг амьтан худалдааны дараагийн түүх бичигдэж, Монгол Улс дахь зэрлэг амьтдын худалдааг цаашид хэрхэн

зохицуулах талаар шийдвэр гаргахад шаардлагатай баримт нотолгоо, тоо мэдээллийг түгээн дэлгэрүүлнэ гэсэн итгэл найдвар төрж байна.

7 Wilford, N. 2005. In Mongolia, an Extinction Crisis Looms. The New York Times. Science Section. Available at <http://www.nytimes.com/2005/12/06/science/in-mongolia-an-extinction-crisis-looms.html> хаягаар үзнэ үү.

# ӨМНӨХ ҮГ

МУ-ын Засгийн газар

## *Монгол Улсын Байгаль орчин аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны газрын дарга П.Цогтсайхан*

Монгол Улс өнгөрсөн хориод жилийн хугацаанд хурдтай шилжилт хийж, өнөөгийн эрч хүчтэй хөгжиж буй олон улсын хамтын нийгэмлэгт өөрийн байр суурь бүхий гишүүн болоод байгаа билээ. Ийм нөхцөлд олон улсын зах зээл, хил дамнасан худалдаанд Монгол Улсын үүрэг роль улам чухал болж, тус улсын байгалийн нөөц баялаг гадаадын зах зээлтэй нягт холбогдох болсон байна. Ялангуяа, зэрлэг амьтны хууль бус худалдааны асуудал нь Монгол Улсад тулгамдаж буй томоохон сорилтын нэг бөгөөд улс орны нийгэм эдийн засгийн хөгжил, байгаль орчин, үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц хэмжээний асуудал болж байна.

Монгол бол зах хязгааргүй хээр талаасаа Их Говийн элсэн манхад хүргэлх өөр өөрийн өнгө төрхтэй өргөн уудам нутгийг эрт үеэс хайрлан хамгаалж ирсэн бахархалт уламжлалтай улс. Нийслэл Улаанбаатарын маань дэргэд орших Богдхан уул бол дэлхийн ууган дархан цаазат газруудын нэг билээ. Харамсалтай нь эдгээр хамгаалалттай газруудын зэрлэг амьтан, ургамал нь хууль бус худалдаанаас үүдэн ихээхэн цөөрч устах аюулд өртөөд байгаа юм. Энэ нь тухайн зүйлүүдээс ихээхэн хамааралтай экосистем болон хэдэн үеэрээ байгальтайгаа харилцан шүтэлцээтэй амьдарч, хишиг буяныг нь хүргэж ирсэн монголчуудын хувьд машид санаа зовоосон асуудал болоод байна.

Зэрлэг амьтан, байгалийн ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эдийн хууль бус худалдааны талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах нь хууль бус худалдааг бууруулах, таслан зогсооход чухал үүрэгтэй. Монгол Улсад зэрлэг амьтны хууль бус худалдааны талаарх мэдлэг ойлголт ихээхэн сайжирч, түүнтэй тэмцэх явдал хэдхэн байгууллага хүний хүрээнээс хальж олон институцийн үйл ажиллагааны нэн тэргүүний зорилт болоод байна. Иргэдийн дунд ч зэрлэг амьтныг олноор агнах, бусад хууль бус үйл ажиллагаанаас байгальд учрах хор хохирлын тухай ойлголт сайжирч, өөрсдийн амьдарч буй газрын бахархалт амьтан ургамлыг зохиистой ашиглах эрмэлзлэлтэй болж байна. Тасралтгүй өөрчлөгдөж байгаа өнөөгийн ертөнцөд хууль бус үйл ажиллагаа хэрхэн явагдаж буйг тухай бүрт нь мэдэх, ойлгох нь цаашид тэдгээрийн шалтгаан үр үндсийг үр дүнтэй арилгах, тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын болоод үндэсний байгууллагыг чадваржуулахад чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын ногоон, тогтвортой хөгжлийг хангах

зорилтын хүрээнд, Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам зэрлэг амьтан, ургамлыг хамгаалах, байгалийн нөөцийг тогтвортой ашиглахад ихээхэн хүчин чармайлт гарган идэвх санаачилгатай ажиллаж байна. Ялангуяа эмзэг өртөмтгий зүйлүүдийг хууль бус ан агнуураас хамгаалах хууль тогтоомжоо эргэн харах, хууль сахиулах чадавхийг сайжруулахад зарим ахиц дэвшил гарч байна. Тухайлбал, 2016 онд Ханой хотноо болсон дэлхийн удирдагчдын уулзалтаар зэрлэг амьтны хууль бус худалдааг зогсооход олон улсын өмнө хүлээсэн үүргээ Монгол Улс баталгаажуулсан. Түүнчлэн, 2018 онд Лондон хотноо болсон Зэрлэг амьтны хууль бус худалдааны олон улсын бага хуралд оролцож, Монгол Улсын зүгээс олон улсын хэмжээнд гүйцэтгэх урт хугацааны үүрэг амлалтаа баталгаажуулсан. Эдгээр ахиц дэвшлийн зэрэгцээ Монгол Улсад зэрлэг амьтны хууль бус худалдааг бууруулахад шаардлагатай олон ажил байна.

2019 онд Женев хотноо болсон зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийн худалдааны конвенцийн Талуудын 18 дугаар хурлаас гаргасан шийдвэр, зөвлөмжийг гишүүн улс орон бүр дагаж мөрдөх, үүнд Монгол Улс хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх нь нэн чухал байна. Тухайлбал, зэрлэг амьтны хууль бус худалдааг цахим сүлжээ, олон нийтийн социал сүлжээгээр хийх асуудалд онцгой анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Ихээхэн ээдрээ төвөгтэй, харилцан уялдаатай асуудалтай тэмцэж байгаагийн хувьд институцуудыг бэхжүүлэх, орон нутгийн түвшинд хамгаалах ажлыг хөхүүлэн дэмжих, үүнд шаардагдах мэдээлэл, мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын түвшинд нягт хамтран ажиллах хэрэгтэй байна. Дэлхий нийтийн төдийгүй Монгол Улсын биологийн олон янз байдалд хүндхэн сорилтууд тулгарч буй энэхүү цаг үед олон улсын хамтын ажиллагааг улам бэхжүүлэх замаар холч ухаант өвөг дээдсээс өнөөгийн Монголчууд бидэнд өвлөн ирсэн зэрлэг онгон байгалийг хойч үе маань ч бас харж бахархах, амьдралаа тэтгэх боломжийг үлдээх үүрэг бидэнд байна.

Байгаль хамгаалах үйлс улам дэлгэрэх болтугай.



# ӨМНӨХ ҮГ

ИБУИНВУ-ын Засгийн газар

## *Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд ноён Филип Малони*

Даян дэлхийн биологийн олон янз байдалд хамгийн ихээр заналхийлж буй аюулын нэг нь зэрлэг амьтны хууль бус худалдаа гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрөх болжээ. Өргөн хүрээнд харвал энэ нь дэлхийн хэмжээний гэмт хэргийг өдөөж хүний амьжиргааг ихээхэн эрсдэлд оруулж байна. Зэрлэг амьтны хууль бус худалдааг тойрсон яриа хэлэлцээний төвд Ази тив оршсоор ирсэн бөгөөд уг асуудлыг шийдэх гол цэг юм.

Монгол Улсын зэрлэг ан амьтнаар баян амьсгал уужрам тэнүүн сайхан нутаг ч энэ аюулд өртөөд байна. Янз бүрийн түвшинд ихэвчлэн үйлдэгддэг хулгайн ан агнуур нь Монгол Улсын олон улсад таних тэмдэг болсон зүйлүүдийн урт хугацаанд оршин тогтноход заналхийлж байна. Байгалийн баялгаас амьжиргаа нь шууд хамааралтай хүн амын амьдрал ч улам ярвигтай болж байна. Үүний эсрэг Монгол Улсын Засгийн газар, олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг хамтран зэрлэг амьтны хууль бус худалдааг таслан зогсоож, Монгол Улсын байгалийн баялаг, соёлын өвийг хадгалан үлдэх талаар идэвхитэй ажиллаж байна.

Нэгдсэн вант улс нь энэ хүрээнд гарч буй бодит санал санаачлагыг удирдан залах, санхүүжүүлэх үйлсэд ямагт тэргүүн эгнээнд явсаар ирсэн. Зэрлэг амьтны хууль бус худалдааны сорилтын сангаар дамжуулан тус улсын Байгаль орчин, загас агнуур, хөдөө аж ахуйн яамнаас 14 сая гаруй фунт стерлингийн санхүүжилтийг дэлхий даяар хэрэгжиж буй 47 төсөлд олгосны нэг нь Монгол Улсад хэрэгжиж буй төсөл юм. Зэрлэг амьтны хууль бус худалдаа нь ярвигтай, нарийн төвөгтэй асуудал бөгөөд түүнтэй үр дүнтэй тэмцэхийн тулд үнэн зөв мэдээ мэдээллээр хангаж, тогтсон ойлголттой болох нь чухал. Асар их нөөц баялагтай, хурдтай хөгжиж буй эдийн засаг бүхий Монгол Улсын хувьд зэрлэг амьтны хууль бус худалдаанд хамааралтай, хамгийн сүүлийн үеийн мэдлэг мэдээлэл бий болох нь байгалийн нөөцийн тогтвортой менежментийн зарчмыг хангахад нэн ач холбогдолтой.

Монгол Улсын Засгийн газар зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүнийг өөрийн хилээр хууль бусаар дамжих өнгөрөхөөс сэргийлэх замаар хулгайн ан агнуурыг зөвхөн Монгол Улсад төдийгүй олон улсад таслан зогсооход бусад улсын засгийн газар, ТББ-уудтай хамтран ажиллаж байна. Энэхүү хамтын ажиллагаа, харилцан ойлголцол бүхий олон улсын хүчин чармайлтын тод жишээ нь “Зэлүүд тал-2 ” тайлан

бөгөөд Монгол Улс дахь зэрлэг амьтны хууль бус худалдаа, түүнийг зогсоох үүрэг хариуцлагын талбарт гэрэл гаргаж буй хэрэг юм.

Мөн энэхүү тайлан нь Монгол Улс дахь зэрлэг амьтны худалдааны талаарх хамгийн том, хамгийн цогц, басхүү хамгийн анхны харьцуулсан судалгааны тайлан юм. Анхдугаар тайлан гарсан 2006 оноос хойш 10 жилийн хугацаанд зэрлэг амьтны хууль бус худалдаанд хувьсал гарсан нь дамжиггүй. Тиймээс дэлгэрэнгүй, үнэн бодит мэдээ мэдээллийн эмхэтгэл, дүн шинжилгээ нь дэвшилтэт сэтгэлгээтэй удирдагчид, шийдвэр гаргагчдад зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх Монгол Улсын чадавхийг бэхжүүлэх хийгээд дэлхийн хамгийн үзэсгэлэнт нутгаа болон зэрлэг амьтдаа хамгаалах үйлсэд нь чиглэл залуур болж, дэмжлэг түлхэц үзүүлэх нь дамжиггүй.



# Товчилсон үгийн жагсаалт

CITES	Convention on International Trade in Endangered Species (Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалар тухай конвенци)
GPS	Geographical Positioning System
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТГ	Авилгалтай тэмцэх газар
БНСУ	Бүгд Найрамдал Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
БОГХТХ	Байгаль Орчны Гэмт Хэрэгтэй Тэмцэх Хэлтэс
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
ДБХС	Дэлхийн байгаль хамгаалах сан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдхүүн
ЕТГ	Ерөнхийлөгчийн Тамгын Газар
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИБУИНВУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын
ЛАСН	Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ТТБ	Төрийн бус байгууллага
ТҮЦ	Түргэн үйлчилгээний цэг
ТХГ	Тагнуулын Ерөнхий Газар
УИХ	Улсын Их Хурал
ХБОБНГ	Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар
ХЗЯ	Хууль Зүйн Яам
ХХЕГ	Хил Хамгаалах Ерөнхий Газар
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий Газар
ШУА	Шинжлэх Ухааны Академи

ХУРААНГУЙ

## Оршил

### Монгол Улсад үргэлжилж буй зэрлэг амьтны худалдааны хямралт байдал

Дэлхийн хэмжээнд хийж буй зэрлэг амьтны хууль бус худалдаа жилд 15 тэрбум ам.доллараас 150 тэрбум хүртэл хэмжээнд эргэлдэж буйг тооцоолон гаргаад байна. Дэлхий дахинаа хийсэн төрөл бүрийн судалгаанаас үзэхэд өнөөгийн зэрлэг амьтны хууль бус худалдаа нь: 1) амьтны зүйлийн тоо толгой хорогдох тусам улам өсөж буй үнэ цэнээс хамааран; 2) мэргэжлийн, уялдаа холбоо бүхий, хурдан дасан зохицох чадвартай гэмт хэргийн бүлэглэлийн хяналт дор; 3) өргөн цар хүрээтэй ба ихээхэн түгээмэл болоод байгаа авлигын улмаас; 4) энэ чиглэлийн худалдааг дэлхийн хэмжээнд явуулах ложистикийн болон харилцаа холбооны тэргүүлэх технологийн хүчээр; 5) зэрлэг ан амьтны худалдаагаар өөрсдийгөө санхүүжүүлэгч зэвсэгт бүлэглэлүүдийн үйл ажиллагаар лавшран даамжирч өнөөгийн нөхцөл байдалд хүрээд буй нь нэгэнт тодорхой болоод байна.

2005 онд гарсан анхдугаар “Зэлүүд тал” тайлан нь Монгол Улс энэхүү хямралт байдалд нөлөөлж хувь нэмрээ оруулсныг илтгэн харуулсан. Зэрлэг амьтны хууль бус худалдаа соёлын нэг хэсэг байгаа хэдийнээ больж зарим зүйлийг жилд хэдэн мянгаар нь, бүр хэдэн саяар нь арилжаалдаг асар том бизнес болон өргөжжээ. Худалдааны нийт орлогын хэмжээ олон арван сая доллараар хэмжигдэж байна.

Харин 2016 онд хийсэн “Зэлүүд тал” хоёрдугаар тайлан нь энэхүү хямралт байдал үргэлжилсээр буйг дахин харуулж байна. Эрхэлж буй зэрлэг амьтны худалдааны чиглэлийн үйл ажиллагааныхаа талаар нээлттэй ярилцах хүмүүсийн тоо цөөрсөн ч ан агнуур хийж, амьтны эд эрхтэн худалдаалж буй хүмүүсийн тоо өөрчлөгдөөгүй хэвээр байна. Нийт агнуурын хэмжээ нь 2005 онд тооцон гаргасан тоо хэмжээнээс доогуур буй ч

зэрлэг амьтны тоо толгой буурч байгаатай илүү хамааралтай гэж болно. Гэхдээ хууль бус худалдаа үргэлжлэн хийгдэж, 10 жилийн өмнө хамгийн ихээр агнаж байсан зүйл ч өнөөдөр мөн л гол бай хэвээр буйн зэрэгцээ ихээхэн тархсан гэмт хэргийн сүлжээ нь зүйл бүрийн арга ашиглан, “эрэлт хэрэгцээнд суурилсан” ханган нийлүүлэлтийн загвараар ажиллаж буй нь Монгол Улсад өнөө тулгараад буй зэрлэг амьтны хууль бус худалдааны томоохон асуудал болжээ.

### Хууль тогтоомжийн хэрэгжилтийн дагуу судалгааны дизайныг боловсруулсан нь

10 жилийн өмнө судалгааны баг нь нууцлагдмал хэлбэртэй, орон нутгийн хэмжээнд явагддаг, хор хохирол багатай хэмээн үзэж байсан нөхцөл байдлыг судлан үзсэн билээ. Хууль тогтоомж хэрэгжиж байсан ч бага хэмжээнд хийж буй зэрлэг амьтны худалдаа нүдэнд ил харагдахуйц байдаг байлаа. Анчид болон худалдаачдыг анхааралдаа авч, зураг авч, ажиглалтыг ил тодоор бүртгэн тэмдэглэх нь ихэнхдээ бүрэн боломжтой байсны зэрэгцээ аюулгүй байдлын хувьд ямар ч асуудалгүй, ярилцлагад хамрагдаж буй хүмүүс мэдээлэл нууна хэмээн санаа зоволгүйгээр судалгааны ажил хийж болж байлаа.

2016 онд судалгааны баг нь зэрлэг амьтны хууль бус худалдаа нь дотоодын зах зээлд гадаад зах зээлийн нэгэн адил нөлөөлж буй талаарх анхны таамгаа баталгаажуулсан ба хууль сахиулах үйл ажиллагаа ч чангарч, хүлээж болох шийтгэл хариуцлагын талаар мэдлэг нэмэгдсэнээр, хувь хүний болоод өрхийн хэмжээнд судалгааны мэдээлэл олж авах нь улам хэцүү болж, худалдааны төв болон зах дээрээс мэдээлэл цуглуулах нь бараг боломжгүй зүйл болсныг тогтоосон.

Эдгээр бүх хүндрэлтэй нүүр тулсан ч “Зэлүүд тал”-ын энэхүү тайлан нь Монгол Улс дахь зэрлэг амьтны худалдааны хамгийн анхдагч

агшны<sup>8</sup> (cross sectional) судалгаа болж, ЗХУ задран унасны дараах Монгол орны зэрлэг амьтны хууль бус худалдааны олон талын түүхэн мэдээллийг харуулах боломжийн нээсэн судалгаа болсон юм.

### Зэлүүд тал-2 нь цар хүрээний хувьд өргөжсөн

Энэхүү “Зэлүүд тал”-2 тайланд Монгол Улс дахь зэрлэг амьтны хууль бус худалдааг өмнө хийсэн тайлангийнхаас илүү дэлгэрэнгүй судалсан материал орсон юм. Тайланд хамаарах жилүүдэд зэрлэг амьтны худалдаа, тус асуудалтай холбоотой харилцааг зохицуулах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцсан байгууллагууд болон хэргийг хянан шийдэх чиг үүрэгтэй шүүх дээр гарсан өөрчлөлтийг хамруулан судалсан. Энэхүү тайланд зэрлэг амьтны хууль бус худалдааг хянах зөвлөмжүүд мөн орсон.

### Олон шинэлэг санаа нь судалгааг сайжруулсан

2016 оны судалгаа нь олон шинэлэг санаа, арга зүйг оруулсан бөгөөд иж бүрэн хандлагаар судалж, агнуур болон худалдааны мэдээллээс лавшруулан цааш гүнзгийрүүлж, зэрлэг амьтны худалдааны ложистикийн, эдийн засгийн, эрх зүйн орчин болон институцийн нөхцөлийг нарийвчлан авч үзсэн.

Судалгааны хугацааг ан агнуурын улиралтай нийцүүлж, нарийвчлалыг сайжруулсны зэрэгцээ, түүврийн аргыг боловсронгуй болгож, хэмжээг нь хадгалан сайжруулсан бөгөөд тоон болон чанарын судалгааны аргачлалыг зорилтот бүлэгт нийцүүлэн ашигласан.

2016 оны энэхүү судалгаа нь мэргэжлийн, орон нутгийн судалгааны баг болон судалгааны программ хангамжийн тусламжаар бүтсэн ба эдгээрийг мэдээлэл цуглуулах болон боловсруулахад ашигласан. Тайланд мэдээллийг дүрсжүүлэн үзүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж,

<sup>8</sup> Цаг хугацааны нэг цэг/агшин дээрх үйлийг судлах арга Ред.

судалгаанаас гарсан үр дүнг нь уялдаатай байдлаар харуулсан.

## Судалгааны арга зүй

### Мэдлэгийн орхигдлыг тогтоохоос судалгаа эхэлсэн

Судалгааны арга зүйг үндсэндээ судалгааны 70 асуулт хөтлөн явуулж, мэдэхгүй буй зүйлийг буюу мэдлэгт буй орхигдлыг тодорхойлсноор, судалгааны зорилгод бүх үйл ажиллагааг чиглүүлж судалгааны ажлын үндэс суурь болж өгсөн юм. Улмаар нийт 53 мэдээллийн эх сурвалжийг олж тогтоож, шаардлагатай хариултыг авч, судалгааны асуултын дагуу өгөгдлийг цуглуулсан. Дээрх жагсаалтад төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд болон эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгүүд багтсан байлаа.

Судалгааны ажил нь ярилцлага хийх, менежментийн, шинжлэх ухааны болон хууль сахиулах байгууллагуудаас мэдээлэл авах замаар зэрлэг амьтны хууль бус худалдааны талаар онлайн судалгаа хийх зэрэг олон хэлбэрээр явагдсан. Товчдоо хэлбэл судалгааны хүрээнд зэрлэг амьтанд хамааралтай бүхий л талууд болон салбарт хүрч ажилласан.

### Мэргэшсэн судалгааны баг

2016 оны судалгааны баг нь 2005 ажилласан багаас цөөн хүнтэй жижиг хэмжээтэй байсан ба үндсэн багийн гишүүд дизайнаас эхлээд мэдээлэл цуглуулах, задлан шинжилгээ хийх хүртэл бүх үйл явцыг гардан хийж гүйцэтгэсэн. Биологийн чиглэлээр мэргэшсэн баг нь бусад хууль, эдийн засаг, олон улсын худалдаа, бизнес, судалгааны дизайн, статистик, мэдээлэл дүрсжүүлэх зэрэг холбогдох салбарын экспертүүдтэй туршлагаа нэгтгэж ажилласан.

Судалгаанд гурван байгууллага оролцсон нь Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг (ЛАСН), Лийгэл Атлас болон Хараат бус

судалгааны хүрээлэн байсан. ЛАСН нь үйл ажиллагааг ерөнхийд нь тэргүүлэх байгууллагын үүргийг гүйцэтгэж, Лийгэл Атлас нь судалгаа, дүн шинжилгээний үндсэн багийг гаргаж харин Хараат бус судалгааны хүрээлэн нь орон нутаг дахь судалгааг гүйцэтгэсэн.

### Судалгааны хугацаа

Энэхүү тайланг бэлтгэн гаргахын тулд нийт 14 сарын судалгааны ажлыг эрхлэн явуулсан (2016 оны 3 сараас 2017 оны 4 сар). Эхний хоёр сарын хугацаанд 2016 оны судалгааны стратегийн зөвлөмжүүдийг мөрдөх зорилгоор суурь судалгааг шинжлэн үзэж, судалгааны арга зүйг боловсруулсан. Өрхийн судалгааг 2016 оны 5-8 дугаар сард хийсэн. Улмаар зах зээлийн судалгааг 8-12 дугаар сард хийж гүйцэтгэсэн. Үүнтэй зэрэгцүүлэн оролцогч талуудтай хийх ярилцлагыг 6-7 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулсан. Тайлангийн бүрдэл хэсгийн төслийг гаргах үйл ажиллагаа мөн энэ үед эхэлсэн ба баримт бичгийн судалгааг үүнд ашигласан. Сүүлийн шатанд олон улсын болон дотоодын гол экспертүүдийг урьж, үр дүнг судлах, санал авах ажлыг хийж, оролцооны аргаар зөвлөмжүүдийг тодорхойлж гаргасан.

### Судалгааны арга зүйг төрөлжүүлж гол хандлагаа тодорхойлсон

Судалгааны хэрэглэгдэхүүнийг төрөлжүүлэх, зорилгодоо нийцүүлэн боловсруулах нь судалгааны үндсэн стратеги байсан бөгөөд, ялангуяа ан агнуур эрхлэгчид судалгаанд оролцохоос таггалзах магадлалтайг урьдчилан тооцсон. Иймд өрхийн судалгаанд анхдагч судалгаа болон ам дамжсан мэдээллийг баримтжуулах ажиглалтын хуудсыг оруулж өгсөн. Зах зээлийн судалгаа нь зах зээлийн сегмент бүр дээр өөр өөр арга зүйг ашигласан. Үүнд, жижиглэн худалдааны дэлгүүрийн судалгаа, уламжлалт эмнэлгийн судалгаа, аялал жуулчлалын агентлагуудын

судалгаа, ресторануудын судалгаа, ажиглалтын хуудас, үнийн тайлан мэдээ болон гол мэдээлэгчтэй хийх хагасчилан бэлдсэн ярилцлагын заавар зэрэг багтаж байлаа. Эцэст нь оролцогч талуудын санал бодлыг авахдаа хагасчилан бэлдсэн ярилцлагын хэлбэрээр 7 төрлийн оролцогч талуудын асуулгаар цуглуулж нэгтгэсэн.

### 2005 оны арга зүйг хадгалж, шинэчлэн сайжруулсан

Зэлүүд тал-2 нь 2005 оноос хойш Монгол Улсад зэрлэг амьтны хууль бус худалдааны чиглэлээр хийж буй анхны иж бүрэн агшны (cross-sectional) судалгаа бөгөөд үүнд баримталсан гол стратеги нь анхлан ашигласан арга зүйг аль болохоор хадгалахын зэрэгцээ дутагдалтай сул талыг нь сайжруулахад чиглэсэн. 2016 оны судалгаанд өрхийн түүвэрлэлтийн дизайн ба өгөгдөл цуглуулах хоёр чухал аргыг хэвээр хадгалж зарим сайжруулах өөрчлөлтийг хийсэн. Өмнөх түүврийн 4,070 өрхийн хэмжээг хэвээр хадгалж, өрхийн сонголт хийхдээ шатлалын, шугаман солбицлолын болон санамсаргүй түүвэрлэлтийн аргуудыг хослуулан хэрэглэсэн. Өрхийн судалгаа хийх бүс нутгийн тоог 44 байхаар тооцож, үүнд улсын хэмжээнд нийт 39 сум, нийслэлийн 5 дүүргийг хамруулсан.

Зах зээлийн судалгааны хувьд судалгаа хийх 20 газрыг тогтоохдоо дараах худалдааны холбогдолтой хоёр хүчин зүйлийг харгалзсан: 1) Хятад болон Орос Улстай хиллэсэн хилийн боомтууд болон 2) зэрлэг амьтны бүтээгдэхүүн борлуулдаг захуудын байршил багтаж байна. Судалгаа хийх газруудыг сонгон авсны дараа зах зээлийн сегмент (аялал жуулчлалын компани, ресторан, дэлгүүр гэх мэт) нэг бүрийн хүн амын тоог тооцож, судалгааг хийсэн. Энэхүү үр дүнд үндэслэн нийт 850 удаагийн ажиглалт хийж гүйцэтгэсэн. Энэ нь 2005 онд хийсэн ажиглалтаас 250-аар (зах зээлийн 1,100 судалгаа) бага ч судалгаанд хамрагдсан хүн амын сегментчлэл болон сайжруулсан судалгааны

хэрэглэгдэхүүн ашигласан нь тооны цөөнийг нөхөхүйц болж, дүн шинжилгээ хийхэд хангалттай их мэдээлэл олж авсан юм.

### Мэдээлэл цуглуулах

Мэдээлэл цуглуулах ажлыг гурван шатлалаар хийж гүйцэтгэсэн. Юуны өмнө олон улсын зэрлэг амьтны худалдааны мэргэжилтэн 2016 оны 5-6 сард нийт 27 удаагийн нарийвчилсан ярилцлага хийсэн. Хоёрдугаар шатанд 4,070 өрхийн судалгаа, 46 ажиглалтын судалгааг сургалтад хамрагдсан нийт 25 судлаач 29 хоногт хийсэн. Эцсийн намар явагдсан шатанд 9 судлаачтай баг зах зээлийн сегмент нэг бүрээр судалгаа хийж гүйцэтгэсэн. Нийтдээ 5,013 ажиглалтыг гурван шатанд хийж, мэдээлэл цуглуулахад нийт 1,564 цагийг зарцуулжээ.

Мэдээллийн чанарыг шалган баталгаажуулах ажлыг тусгайлан мэдээллийн чанарын баталгаажилтын баг ажиллах замаар, мэдээллийн олон технологи (судалгааны программ ашиглах, гар утас, хаалттай цэсийн сонголт гаргах, урьдчилан бэлдсэн асуултын дараалал тогтоох, автоматаар ярилцлагын бичлэг хийх, газар зүйн байршил тогтоох) ашиглах замаар хянан баталгаажуулсан. Олон төрлийн хэрэглэгдэхүүнийг хослуулан ашигласан нь мэдээллийг эргэн шалгах, алдаа гарах боломжийг бууруулах, хуурамч оролцогчоос сэргийлэх боломжтой болгосон. Үүний үр дүнд нийт түүврээс маш цөөхөн (10 хүрэхгүй буюу 0,2%) нь л хүчингүйд тооцогдсон.

## Гол асуудлууд

**Олон улсын худалдаа Монгол дахь зэрлэг амьтны хууль бус худалдааны хөтлөгч хүчин зүйл болох нь**

Монгол Улсын хувьд өөрийн нутаг дахь зэрлэг амьтны худалдааны нийт эрэлтийг дангаар бүрдүүлдэггүй, бусад улсаас гаралтай зэрлэг амьтны бүтээгдэхүүнийг гол

хэрэглэгч ч болдоггүй юм. Харин тус улс нь дэлхийн болон бүс нутгийн зэрлэг амьтны худалдааны урсгалын нэгэн бүрэлдүүн хэсэг хэдийнээ болчихоод байгаа нь түүнд Монгол Улсын гүйцэтгэх үүрэг ролийг болон маш нууцлагдмал байдалд явагддаг зэрлэг амьтны худалдаанд тус улсын эмзэг байдлыг тайлбарлах шижим болж байна. Товчоор хэлбэл хүчирхэг эдийн засаг бүхий хоёр том улсын (ОХУ болон БНХАУ) хооронд хавчуулагдсан, далайн боомтоос алслагдсан Монгол Улсын гадаад худалдаа, зах зээл, улс төрийн ашиг сонирхолд хоёр хөршийн нөлөө давамгайлж буй нь бодит зүйл болж, энэ байдал улам гүнзгийрч байна.

Монгол Улсын өмнөд хөрш Хятад Улсын эдийн засаг хүчирхэгжин, нийгмийн дундаж давхаргын хэмжээ нэмэгдсэн нь хууль бус худалдааг шинэ түвшинд гаргаж, зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний хэзээ ч үл хангагдах эрэлт бий болгосноор зэрлэг амьтны хууль бус худалдааг улам ихээр хөөрөгдөж байна. Зэрлэг амьтны хууль бус худалдаанд хамгийн их өртөж буй амьтны тоонд чоно, баавгай (доньд болон цөсний хүүдий), буга (цусан эвэр), хүдэр (заар) багтаж байна. Түүнчлэн тарвага, бусад амьтны арьсийг Хятадын хувцас үйлдвэрлэлийн салбарт нийлүүлж байна.

Оросын хувьд хуучин цаг үетэй харьцуулбал нөхцөл байдал бүрэн өөрчлөгдөөд байна. Хуучин ЗХУ-ын үед Орос Улс нь Монгол Улсын худалдааны гол түнш байж, улсын гадаад худалдааны бараг дийлэнхийг буюу 80%-ийг Оростой хийж байсан бол одоо Хятадтай хийх худалдаа гол хувийг эзэлж байна. Өнөөдөр Монгол Улс нь үндсэндээ Оросоос зэрлэг амьтны бараа бүтээгдэхүүн импортлогч болжээ. Хэдий Монгол улсаас Оросод гаргадаг зэрлэг амьтны экспорт бараг хэвээр байгаа ч Оросоос импортлох нь эрс нэмэгдэж, 1996 онд 0.5 сая доллар байснаа 2015 онд бараг 9 сая доллар болж нэмэгджээ. Монгол

Улсаас албан ёсоор экспортолж буй үслэг эдлэл 1996 оны экспортын дөнгөж 5%-тай тэнцэх хэмжээнд хүрч буурсан бол Оросоос авах импорт нь энэ хугацаанд 30 дахин нэмэгдээд байна.

### Монгол Улс дамжуулагч орон болжээ

2005 оны Зэлүүд тал тайланд шийдээгүй үлдсэн нэг асуудал нь Монгол Улс хууль бусаар худалдаалж буй зэрлэг амьтныг дамжуулагч улс мөн эсэхийг тодорхойлоогүй явдал юм. Иймд энэхүү судалгаагаар Монгол Улсын дамжуулагч орны статус одоо үүсэн буй болж, зэрлэг амьтны дэлхийн худалдааны бүрэлдүүн хэсэг болсныг баримтжуулан гаргасан. Өнөөгийн байдлаар Монгол Улс нь зэрлэг амьтны худалдааны дамжин өнгөрөх томоохон маршрут бус ч мансууруулах бодис болон хүний наймаа зэрэг бусад төрлийн хууль бус худалдаа дамждаг зам хэдийн болсон тээврийн дэд бүтэцтэй (Орос улсаас Монголоор дамждаг төмөр зам, авто зам) улс юм. Энэхүү судалгаа нь гуравдагч орнуудаас оруулж ирсэн зарим зэрлэг амьтны зүйл, тухайлбал, арслан, хотон, бөхөн зэрэг амьтны эд эрхтнийг Монгол Улсаар дамжуулан Хятадад гаргаж буйг мөн баримтжуулсан. Монгол Улсын Эрүүгийн хуулинд 2016 оны 9 дүгээр сард нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнө гадаадаас гаралтай зэрлэг амьтны бүтээгдэхүүн худалдаалах, тэдгээрийг эзэмших нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогддоггүй байсан. Хуулийн энэхүү цоорхой нь дамжуулан худалдаалж буй тохиолдлыг баримтжуулах, мөрдөн шалгах боломжийг хааж, тэр ч байтугай хамааруулах хууль тогтоомж байхгүй, харьяалал тодорхойгүйн улмаас шүүх хэргийг хэрэгсэхгүй болгож байсан нь одоо л засагдан залруулагдаад байна.

**Конвенцын хүрээнд хийж буй худалдаа нь томоохон асуудлын өнгөцхөн илрэл болж байна**

Зэрлэг амьтан, ургамлын аймгийн



ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-д заасан зүйлийг худалдаалж буй тоо хэмжээ зарим бүс нутгийн хувьд хэдэн мянга, хэдэн саяар яригдаж буй ч Монгол Улсын хувьд энэхүү хэмжээ нь хараахан ийм түвшинд хүрээгүй буюу хэдэн арваар (жишээ нь чоно) эсвэл хэдэн зуугаар (шонхор) тоологдож байна. Гэвч тоо хэмжээ бага буй нь эдийн засгийн хувьд үнэ цэнэ багатай гэсэн үг огт биш, эсвэл экологийн хувьд хохирол багатай гэсэн үг биш юм. Монгол Улсын зэрлэг амьтад нь хуурай ширүүн уур амьсгалтай нутагт тэмцэж амьдардаг учраас тоо толгой цөөтэй бөгөөд зөвхөн мэрэгч болон шавьж л олон саяар тоологдох хэмжээний байдаг. Тиймээс Монгол Улсад агнуур болон худалдааны квот доогуур баймааж зүйлүүд амьд үлдэж, тоо толгой нь тэнцвэртэй байх боломжийг хангах юм.

Дунджаар авч үзвэл CITES-ын хүрээнд экспортолох тоо нь Монгол Улсын зэрлэг амьтны мэргэжилтнүүдийн зохистой хэмээн үзэж буй хэмжээнд байна. Бүх тохиолдолд хууль бус худалдааны тоо хэмжээ нь энэхүү албан ёсны худалдааны хэмжээнээс цар хүрээний хувьд хавьгүй илүү байна. Зарим нэг тохиолдол болон хууль сахиулах байгууллагын бүртгэлээс үзэхэд хууль бус худалдаа нь хууль ёсны худалдааны хэмжээнээс хол давж буй болохыг албан ёсны тоо баримтаар харж болно. Үүнийг тодорхой харуулах нэг жишээ нь чонын худалдаа юм. ГЕГ-ын мэдээллээр сүүлийн жилүүдэд хууль бусаар нэвтрүүлэх гэснээс гааль дээр хамгийн ихээр хураагдаж буй амьтан нь чоно, түүний эд эрхтэн байна. 2009 онд л гэхэд албан ёсны экспортын зөвшөөрөл 56 (17 арьс, 15 трофи агнуур, 2 амьд чоно, 20 эд эрхтэн болон 2 гавал) байжээ. Гэтэл тухайн жилд гааль дээр хураасан чонын тоо энэ хэмжээнээс 6 дахин их буюу 312 чонын гулууз байжээ. Энэ мэт хураан авсан тоо хэмжээ нь асар өргөн хүрээтэй хууль бус худалдааны өчүүхэн хэсэг ч байж болох юм.

### **CITES-ын худалдаа нь Монгол Улс гадаадын зэрлэг амьтны бүтээгдэхүүн хэрэглэгч орон болсныг харуулж байна**

Монгол Улс нь гадаадын зэрлэг амьтны бүтээгдэхүүний хэрэглэгч орон болж байна. 1996 онд CITES-д нэгдэн орсны дараах 10 жилд импортын зөвшөөрөл маш цөөн байжээ. Харин 2006 оноос хойш зөвшөөрлийн тоо эрчимтэй нэмэгдэж, өмнөхөөсөө 3 дахин илүү болоод байна. Гадаад улс орноос зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн худалдан авах эрэлтийг дагалдан, нийлүүлэгч орны тоо мөн өсөж, өнгөрсөн 10 жилд 24-өөс 43 болтлоо нэмэгджээ. Ийм худалдааны гол түншүүдэд АНУ, Колумб, Тайланд, Энэтхэг, Хятад, Вьетнам улсууд орж эхний байрыг эзлэх болжээ.

CITES-ын импортын бүртгэлээс үзэхэд амьд дээжийн худалдаа нь Монгол Улсын хувьд хамгийн чухал ангилал болж буйг харуулж байна. Өмнөх үед ийм худалдааг Монгол Улсын хувьд бараг хийж байгаагүй юм. 2006-2015 оны хооронд амьд амьтны худалдаа бараг 2 дахин нэмэгдсэний ихэнхи нь хилэм загасны худалдаа болж байна. Шивэр хилэм нь хурдан хугацаанд нас бие гүйцдэг, цэнгэг усанд түгээмэл тархсан зүйл юм. Судалгааны үеэр ам дамжсан ярианаас олж сонссон, батлагдаагүй мэдээллээр Монгол Улсад хилэм загас үржүүлэх аж ахуй байгуулах чиглэлээр ажил хийгдэж буй ажээ.

### **Идлэг шонхор, чоно, аргаль зэрэг нь CITES-ын гол амьтад байна**

Зэрлэг амьтны экспорт нь ач холбогдолтой хэвээр байгаагаас гадна хэд хэдэн зүйлийн хувьд их нөлөөтэй байна. Монгол Улсаас экспортолж буй 5 гол амьтны тоонд чоно, идлэг шонхор, аргаль ордог.

Сүүлийн жилүүдэд CITES-ын хүрээнд олгосон чоно худалдаалах зөвшөөрөл нь Монгол Улсын CITES -ын хүрээнд олгосон нийт зөвшөөрлийн гуравны нэг орчим болж, зөвшөөрлийн тоогоор (нийт 2,700 чоно, түүний эд эрхтэнд

291 зөвшөөрөл) хамгийн ихээр экспортлогдсон амьтан болж байна.

Шонхор, ялангуяа, идлэг шонхор нь Монгол Улсаас CITES-аар худалдаалдаг өөр нэг зүйл юм. Үндсэндээ Монгол Улсаас 8 төрлийн шонхрыг CITES-ын хүрээнд экспортолдогос хамгийн ихээр худалдаалдаг нь идлэг шонхор бөгөөд 1996-2015 онд нийт 24,748 шонхрыг амьдаар нь гаргаснаар нийт CITES-ын худалдааны 97%-ийг бүрдүүлжээ.

Сүүлийн жилүүдэд саарал чонын экспортын адил аргаль агнахад олгож буй CITES-ын зөвшөөрөл нь нийт худалдааны гуравны нэг орчим хувийг (1996-2015 онд нийт 263) эзлэх болсноор нийт зөвшөөрлийн тоогоороо хамгийн их экспортолдог хоёр дахь амьтан болжээ. Худалдаалж буй амьтны тоо толгой нь саарал чонынхтой ойролцоо буюу нийт 1,322 трофи бүртгэгдэж, бас бараг нийт 2,369 амьтны 1000 орчим дээж худалдаалжээ.

### **Олон улсын худалдаа өсөн нэмэгдэж буй нь зэрлэг амьтны хууль бус худалдааг хянахад хүндрэл учруулж байна**

Олон улсын худалдаа нэмэгдэхэд хууль ёсны болон хууль бус худалдааны урсгалыг бий болгож байдаг. Дэлхий даяар олон сая худалдааны боомтоор өдөр бүр хэдэн сая тонн ачаа эргэлдэж, тэдгээрийн багахан хувь нь л хяналт шалгалтаар орж байдаг. Ингэж ачаа эргэлт нэмэгдэх тусам боомтууд илүү ачаалалтай болж, хяналт сулардаг байдал Монгол Улсад ч мөн тулгарч байна. Монгол Улсын гадаад худалдаа сүүлийн 20 жилийн хугацаанд хурдтай өсөн нэмэгдэж, 1996 онд 0.75 тэрбум ам.доллар байснаа 2015 онд 8 тэрбум болж нэмэгджээ.

Түүнчлэн Монгол Улсын экспортод түүхий эд, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувийн жин өндөр байдаг нь Монгол улсын хилээр өдөрт нэвтрэх ачааны тоо хэмжээ, давтамжид шууд

нөлөөлдөг. Улсын өмнөд хил дээр 100-200 тооны даацтай хоосон автомашинууд хилээр нэвтрэн орж, уурхайгаас ачаа аван буцдаг ба ихэнхдээ уурхай дээр вагонуудыг битүүмжилдэг тул хилийн боомт дээр шалгалт хийх боломжгүй байдаг. Нүүрс болон бусад төрлийн ашигт малтмал тээвэрлэж буй автомашинуудад хийсэн гаалийн үзлэгээр зэрлэг амьтны эд эрхтэн нуун хил давуулах хэд хэдэн оролдлогыг олж илрүүлжээ.

Худалдаа, тээвэрлэлтийн хэмжээ нэмэгдсэнээр хүн хүч хүрэлцээгүй, хөрөнгө санхуужилт дутмаг гааль, хилийн албадад ачаалал улам нэмэгдэж, ялангуяа рентген тоног төхөөрөмж хомс тул эдгээр хүнд даацын машинд хяналт шалгалт хийгдэхгүй байна.

Эдгээр асуудал дээр нэрмээс болж чөлөөт худалдааны бүсэд ачаа барааны хяналт шалгалтыг хөнгөвчилсөн байдаг нь хууль бусаар хил дамнуулан худалдаа хийгчдэд улам амар хялбар болгожээ. 2002 онд Чөлөөт бүсийн тухай хууль баталсны дараа Монгол болон Хятад Улс гэрээ байгуулан, Замын-Үүдэд Хятад- Монголын хэлэлцээрээр худалдааны чөлөөт бүсийн шав тавьжээ. Энэ нь Монгол Улсын зэрлэг амьтны худалдааны зөрчил хамгийн их гардаг бүс нутаг бөгөөд чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын ажил 2018 оноос нааш дуусахгүй ч ирээдүйд зэрлэг амьтны хууль бус худалдааг даамжруулж болох талаар зөвшилцөж байгаа юм.

#### **Хилийн аюулгүй байдлын асуудал хууль бус худалдаатай холбогдох нь**

Монгол Улсын Орос, Хятад Улстай хиллэдэг нийт хилийн шугам 8,252 км үргэлжилдэг нь аюулгүй байдлын томоохон асуудал байсаар ирлээ. Хил хамгааллын чиглэлээр ажилладаг бие бүрэлдэхүүний тоо тодорхой бус ч зарим эх сурвалжийн үзэж буйгаар 300-350 орчим хилийн застав ажиллаж буй ажээ. Хилийн аюулгүй байдлыг хангахад анхаарал хандуулж буйн нэг илрэл нь Монгол Улс нь өөрийн

хилийг бүрэн хашаажуулсан цөөн улсын нэг юм.

Хил хамгаалах хүн хүч, хашаанаас үл хамааран Монгол Улсын хил нь харьцангуй нээлттэй, хянахад хүндрэлтэй юм. Алтайн нуруугаар тусгаарлагдах баруун хилээс бусдаар ямар нэгэн байгалийн саад байхгүй (жишээ нь уулархаг нутаг, гол ус гэх мэт) тул аль ч газраар хил нэвтрэхэд саадгүй байна. БНХАУ-тай хиллэсэн өмнөд хил нь цөл эсвэл тал нутгийг дамнан оршдог, ОХУ-тай хиллэсэн хэсгийн дийлэнх нь тал газрыг дамнан орших тул засмал замаар явж буй нэгэн адил автомашинаар нэвтрэх бүрэн боломжтой юм. Маш урт, үндсэндээ хойд болон урд хөршүүдтэйгээ цөлөрхөг газраар хиллэсэн улсын хил нь зэрлэг амьтны худалдаа эрхлэгчдийг саатуулахгүй, ямар ч хашаа, саад бүхий газраар хялбархан, баригдах эрсдэл багатайгаар контрабандын хил дамнанас худалдаа хийх боломжтой байна.

#### **Өргөн удам нутагт хяналт тавих нь гол сорилт болж байна**

Монгол Улсын хувьд байгаль хамгаалагчид нь нийт 265,000 км<sup>2</sup> газар буюу тус улсын нутаг дэвсгэрийн бараг 17%-ийг хянаж байх үүрэг хүлээдэг. Эргүүл хяналтын ажлыг хүндрүүлж буй өөр нэгэн зүйл нь эдгээр хамгаалалттай газрууд нь бүх нутаг дэвсгэрээр тархан байрласан 75 салангид хэсэгт хуваагдаж буй явдал бөгөөд эдгээрийн дотор ихээхэн алслагдсан, цөл болон уулархаг нутгуудад ордог байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд усан орчны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл эрс нэмэгдэж буйтай холбоотойгоор нийт 10,409 км урттай голууд, 13,418 км<sup>2</sup> нуурын талбайг хянаж мониторинг хийх хэрэгцээ гарч байна. Дүгнэн үзвэл дэлхий дээрх маш цөөн тооны улс л Монгол Улсын адил цөөн хүн, хязгаарлагдмал нөөцөөр хянах шаардлагатай том газар нутагтай байдаг нь гайхалтайн зэрэгцээ, яаж ч үзсэн хүнд хэцүү үүрэг юм.

Монгол Улс дахь тусгай хамгаалалттай газар нутагт хамаардаг Тосон Хулстайн байгалийн нөөц газарт 6, Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газарт 15 байгаль хамгаалагч ажиллаж байна. Эдгээр нь нийт 4,699 км<sup>2</sup> болон 8,380 км<sup>2</sup> газар нутагтай бөгөөд нэг байцаагчид 783км<sup>2</sup> болон 559 км<sup>2</sup> газар нутаг ноогдож байна. Аймгийн хэмжээнд үзвэл хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагч нарын нөхцөл бүр муу байна. Сэлэнгэ аймагт 28 байгаль хамгаалагч 41,000 км<sup>2</sup> газар нутгийг хариуцаж буй бол Баян-Өлгий аймагт 30 байгаль хамгаалагч 45,700 км<sup>2</sup> газрыг хариуцаж байна. Энэ хоёр газрын дундажийг үзвэл нэг байгаль хамгаалагчийн эргүүл хийж, хянах газар нутгийн дундаж хэмжээ нь 1,500 км<sup>2</sup> байгаа нь хүн хүч цөөтэй, асар их ажил үүрэг гүйцэтгэх шаардлагатай нь тодорхой байна.

Судалгааны үеэр байгаль хамгаалагч, байгаль орчны байцаагч, гаалийн байцаагч, цагдаа зэрэг хууль сахиулах байгууллагын ажилтнууд нөөц эх үүсвэр хангалтгүй буй асуудлаар санаа зовниж буйгаа илэрхийлжээ. Нөөц санхүү дутагдалтайгаас тэдний цалин бага, багаж, тоног төхөөрөмж (дүрэмт хувцас болон дуран гэх мэт) хуучирч, ашиглах боломжгүй болжээ.

#### **Хүчирхийллийн эрсдэл байгаль хамгаалагчдын хичээл зүтгэлд саад болж байна**

Байгаль хамгаалагч нарт тулгардаг үндсэн сорилт нь зөвхөн тэдний эргүүл хийж, хамгаалах ёстой талбайн хэмжээнээс гадна гарч болзошгүй хүчирхийлэл байна. Дэлхий даяар байгаль хамгаалагч нар хулгайн анчидтай хийх тэмцлийн тэргүүн шугамд байдаг. Сүүлийн 10 жилийн хугацаанд дэлхийн хэмжээнд 10,000 орчим байгаль хамгаалагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсаны 80% нь хулгайн анчид, зэвсэгт бүлэглэлүүдийг гарт үрэгджээ.

Гэвч бусад улстай харьцуулбал хүчирхийлэл нь Монгол Улсын байгаль хамгаалагчдад тулгарч буй гол аюул хараахан биш юм. Судалгаагаар хүч хэрэглэсэн тохиолдлын талаар тусгайлан судлаагүй ч хулгайн бүлэг анчид болон байгаль хамгаалагчид хоорондоо тулгарсан олон тохиолдол байсан, аль аль тал нь мөргөлдөөн үүсэхээс зайлсхийсэн талаар сонссон. Ихэнхдээ хурдан машинтай хулгайн анчид зугтах эсвэл байгаль хамгаалагч тухайн газрыг орхин явж амь насаа хамгаалах зэргээр өнгөрдөг байжээ.

### [Зохион байгуулалттай гэмт хэрэг зэрлэг амьтны хууль бус худалдааны гол хүчин зүйл болжээ](#)

Өндөр ашигтай, хууль бус бизнес нь зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл оршин тогтнох, үйл ажиллагаа явуулж хөгжин цэцэглэх үндэс суурь нь болдог. Одоо үед гэмт хэргийн сүлжээнд олон тооны хүмүүс хамаарч, боловсронгуй тоног төхөөрөмж ашиглаж, өндөр үнэтэй тээвэр ложистикийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийж, өөрийгөө хамгаалах нарийн арга хэмжээг авч, цэргийн зориулалтын техник хэрэгсэл ашиглаж байна. Энэхүү үйл ажиллагаа нь олон улсын хэмжээнд хийдэг ээдрээтэй бүтэц бүхий мөнгөн шилжүүлэг ашиглан олон шатанд байнга хээл хахууль өгөх замаар өөрийн бүтээгдэхүүнийг (мансууруулах бодис, зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн, хуурамч бүтээгдэхүүн аль нь ч гэсэн) олж авах, тээвэрлэх, боловсруулах, хадгалах болон борлуулах сүлжээг аюулгүй болгон баталгаажуулж байдаг.

Монгол Улсын зэрлэг амьтны хууль бус худалдаанаас ашиг хүртэж буй зохион байгуулалттай гэмт хэрэг нь нэн ховордсон амьтны (жишээ нь халиун буга, хүдэр, хүрэн баавгай, саарал чоно, мануул, тахь, бөхөн гөрөөс) өндөр үнэтэй, ашигтай бүтээгдэхүүнийг зарах замаар үйлдэгдэж байна. Мөн хувцас үйлдвэрлэлийн салбарын материал болгон тарвага, үнэг, хярс

зэргийг ч борлуулж байна. Арга замын хувьд өөрсдийн захиалгыг орон нутаг дахь хулгайн анчдад өгч, тэд нь тусгайлан тоногдсон хурдан автомашин болон бусад олон төрлийн хууль бус аргууд, тухайлбал, шөнийн гэрэлтүүлэг, автомат буу, автомашинаар цуцтал элдэх, дайрч алах зэргээг бүлэглэн үйлдэж байна. Мөн гэмт хэргийн бүлэглэлүүд зэрлэг амьтны байршлыг тогтоохын тулд дрон ашиглаж байсныг цагдаагийн байгууллага тогтоожээ. Хууль сахиулах байгууллагын гол мэдээлэгчийн хэлснээр сүүлийн жилүүдэд 12 зохион байгуулалттай бүлгийг мөрдөн шалгасан бөгөөд тэдний хууль бус худалдааны нийт хэмжээ нь 15 сая ам.доллар хүрдэг ажээ.

### [Хувь хүмүүстэй бус сүлжээтэй тэмцэх нь](#)

Зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэрэг нь зэрлэг амьтны хууль бус бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэхдээ зэвсэг, мансууруулах бодис, хүний наймаа болон алмаз худалдаалагчдын ашигладагтай адил ложистик, санхүүгийн аргуудыг ашигладаг, схем бүхий үйлдэл байдаг. Энэхүү гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд улс орнууд хамгийн дэвшилтэт шинэ арга зүйг боловсруулан хэрэгжүүлсэн тохиолдолд хууль сахиулах ажил үр дүнд хүрч байдаг. Ялангуяа тухайн хууль бус ачааг эцсийн цэг хүртэл нь хянах замаар тухайн сүлжээг илрүүлэн, холбогдогч этгээдийн эсрэг баримт нотолгоог цуглуулж авдаг ба мөн саатуулан шалгах урьдчилсан зөвшөөрлийг ашиглаж байна. Эдгээр нь тодорхой газарт, тодорхой цагт гэмт хэрэг үйлдэгдэж магадгүй гэсэн сэжгийн үндсэн дээр шүүхэд хүсэлт гаргаж урьдчилан авдаг зөвшөөрөл юм. Энгийн зөвшөөрөл нь зөвхөн гэмт хэрэг үйлдэгдсэн дараа авах шаардлагатай эсвэл хууль сахиулах байгууллагын ажилтан нь гэмт хэргийн нотолгоог олж авах боломжтой хэмээн үзсэн тохиолдолд авч болдог. Эдгээр аргыг хослуулан хэрэглэснээр нэгжлэг хийх зөвшөөрөл урьдчилан

авч, хууль бус бүтээгдэхүүнийг хүлээн авах үед нь саатуулах, нэгжлэг хийх, борлуулагч болон тээвэрлэгчээс цааш шатанд хүрэх боломжтой болно.

Монгол Улсад эдгээр аргачлалыг ашиглах хэрэгцээг (ялангуяа ГЕГ-ын мөрдөн шалгах эрх мэдлийн хүрээнд) тодруулан энэхүү судалгаа нь орлого багатай монгол эмэгтэйчүүдийг хил дамнуулан бага хэмжээний хууль бус бараа тээвэрлэхэд ашиглаж, гар ачаа болон жигнэмгийн саванд нуун гаргаж буй түүхийг илрүүлсэн. Энэ тохиолдолд хууль сахиулах үйл ажиллагааны зорилт нь тухайн эмэгтэйчүүдэд (хууль бус худалдааны ертөнцөд mule буюу “луус” гэж нэрийддэг) чиглэж байснаас, үүний цаана байж болон хууль бус сүлжээнд огт хүрч чадаагүй ажээ.

## Институцийн орчин нөхцөл

### [Монгол Улс хууль бус худалдаатай тэмцэх чадавхаа сэргээж байна](#)

Өнгөрсөн жилүүдэд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй менежментийн болон хууль сахиулах байгууллагууд нь чадвараа сэргээх чиглэлээр ихээхэн хүчин чармайлтыг гаргаж иржээ. Сүүлийн 10-15 жилийн хугацаанд гарсан тэмдэглүүштэй зүйл нь хяналт шалгалт, хууль сахиулах байгууллагуудад өөрчлөлт зохион байгуулалт хийсэн явдал юм. Хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн салбарын 15 шахам байгууллага өнөөдөр зэрлэг амьтны худалдаатай холбоотой асуудлыг хэрэгжүүлэх чиг үүргийг гүйцэтгэж байна.

### [Зэрлэг амьтны хууль бус худалдааг олон байгууллага удирдаж буй ч чадавх дутагдсаар байна](#)

УИХ-ын Байгаль орчны байнгын хороо нь зэрлэг амьтны удирдлагад

хамаарах байгаль орчны болон байгалийн нөөцийн чиглэлийн гурван хуулийн төслийг боловсруулан, батлан гаргахад чухал үүргийг гүйцэтгэжээ. Эдгээрийн тоонд Ойн тухай хууль (2012), Ховор төрөл зүйлийн шинэчилсэн жагсаалт (2012) болон Амьтны тухай хуулийн шинэчилсэн найруулга (2012) багтаж байна. Байнгын хороо нь зэрлэг амьтны хамгааллын менежментийг сайжруулах чиглэлээр бусад суурь хуулиуд болох Татварын хууль (2008), Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль (2010), Эрүүгийн байцаан шийтгэх хууль (2015), Эрүүгийн хууль (2016) зэрэг хууль тогтоомжид зэрлэг амьтантай холбоотой зүйл заалтуудыг тусгахад мөн хичээнгүйлэн ажиллажээ.

Ерөнхийлөгчийн тамгын газар нь чоно ба тарвага агнахыг хориглох тухай Ерөнхийлөгчийн зарлиг гаргах зэргээр зэрлэг амьтны хууль бус худалдааны асуудлыг хөндөж иржээ. Тодорхой үйл ажиллагаа хориглох эрхийг төрийн бусад байгууллага, албан тушаалтан мөн эдэлдэг бөгөөд (жишээ нь БОАЖЯ, Засгийн газар) тэдгээр яамд мөн чоно, тарвага агнахыг хориглох, зохицуулах олон тооны арга хэмжээг авч иржээ. Гэхдээ Ерөнхийлөгчийн зарлиг хэлбэрээр тухайн үйл ажиллагааг хориглох нь тодорхой ач холбогдолтой. Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд гол үр дүн нь олон нийтийн мэдлэгийг бий болгоход оршдог юм.

БОАЖЯ-ны Байгалийн нөөцийн удирдлагын газар нь зэрлэг амьтны чиглэлээрх хууль, журмыг боловсруулан гаргах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Монгол Улсын гол байгууллага бөгөөд үндсэн чиг үүргийн тоонд орон нутагт зэрлэг амьтны менежментийг удирдан чиглүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийг хариуцах, ан агнуур болон загасчлалын горим, шаардлагуудыг тогтоох, CITES-ын жагсаалтад багтсан амьтны хууль ёсны худалдааг зохицуулах, зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх зэрэг үүрэг мөн багтана. Зэрлэг амьтны хууль

бус худалдааны хувьд тухайн яам нь хэрэгжүүлэгч гэхээсээ захиргаа бодлогын байгууллага болохыг дурдах нь зүйтэй. Тус газар нь орон нутагт шууд үйл ажиллагаа явуулдаггүй, харин орон нутаг дахь менежментийн чиг үүргийг нь бусад байгууллагууд эрхлэн гүйцэтгэдэг. Тус газар нь мөн Нэн ховор болон ховордсон төрөл зүйлийн жагсаалтад өөрчлөлт оруулах ажлыг удирдаж, өөрийн саналыг холбогдох байгууллагад хүргүүлдэг. Одоогоор тус жагсаалтад 31 зүйлийн нэн ховор, 76 ховор зүйл бүртгэгдээд буй бөгөөд нийт 107 зүйлийн амьтанг бүрэн эсвэл хэсэгчилсэн байдлаар агнах, худалдаалах хориг хязгаарлалт тавиад байна. Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхтэй холбоотойгоор тус газрын хүлээдэг өөр нэг үүрэг нь амьтдын “экологийн үнэлгээг” тооцон гаргах үүрэг байдаг.

Энэхүү газрын дарга нь мөн CITES-ын удирдан зохион байгуулах тэргүүний үүргийг гүйцэтгэдэг. Боловсон хүчин, санхүүжилт бага энэхүү байгууллагын үүрэг нь хязгаарлагдмал, CITES-ын конвенцын газарт тайлан хүргүүлэх болон конвенцын хамаарах үйл ажиллагааг сайжруулах ерөнхий чиг үүргийг гүйцэтгэж байна.

Конвенцод заасны дагуу CITES-н шинжлэх ухааны зөвлөх нь эрсдэлийн шинжилгээ буюу хор хохирол учрахгүй хэмээх дүгнэлт (NDFs) гаргах гол үүргийг хүлээнэ. Энэхүү дүгнэлт нь CITES-ын Хавсралт I болон II-т орсон зүйлийн санал болгож буй худалдаа нь тухайн зүйлд болон экосистемийн үүрэгт ямар нэг хор хохирол үл учруулах тухай шийдвэр юм. Монгол Улсад дүгнэлт гаргах ямар нэгэн стандарт, журам байхгүй, сүүлийн жилүүдэд CITES-ын хүлээн авсан нотолгоог буюу амьтдын тархац, популяц, хандлага болон аюулын талаар тайлагнаж, нийлжээгүй байна.

Аймаг, сумын засаг захиргаа нь Монгол улсын нутаг дэвсгэрт зэрлэг амьтны, загас агнуурын нөөцийг удирдахад оролцдог чухал

талуудын нэг байдаг. Орон нутгийн төрийн албан хаагчдад хуулиар олгосон эрх, үүрэгт зэрлэг амьтны тоо толгойн судалгаа, зэрлэг амьтан хамгаалал, олон нийтийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлээр БОАЖЯ-тай нягт хамтран ажиллах, мөн Амьтны тухай хуулийн хэрэгжилтийг хангах (жишээ нь квот болон хориг) зэрэг багтана. Монгол Улсын хэмжээнд нийт 69 ан агнуурын бүсийг тогтоож, агнуурын удирдлага нь орон нутгийн түвшинд хийгдэж байна. Өөрийн хамаарах бүсэд нь хуваарилсан квотын хэмжээнд нийцүүлэн ан агнуурын зөвшөөрөл олгох эрхийг сум эдэлдэг. 2012 онд Амьтны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар ан агнуурын зөвшөөрөл, трофи ангийн орлого нь Сангийн яамны хяналтад байдаг улсын төсөвт бус харин сумын төсөвт шууд орж байна. Энэхүү дэмжлэгээс үүдэн орон нутгийн захиргаад зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд түлхэц болж, орон нутаг ч мөн өөрийн нөөцийг хадгалан үлдэх илүү сонирхолтой болжээ.

### [Хууль сахиулах байгууллагуудад илүү дэмжлэг шаардлагатай байна](#)

Зэрлэг амьтны менежментийн нэгэн адил хууль сахиулах чиг үүрэг олон байгууллагын дунд хуваагдаж, төрийн нийт 8 байгууллага хууль бус ан агнуурыг илрүүлэх, нэгжих, хураан авах болон мөрдөн байцаахад эрх мэдэл нь давхацсан байдлаар ажиллаж байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь Засгийн газрын Шадар сайдын хариуцах асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Тус газарт зэрлэг амьтны худалдаатай хамааралтай хоёр нэгж ажилладаг нь Байгаль орчны хяналтын алба болон Гаалийн хяналтын алба юм. Эдгээрт ойролцоогоор 700 гаруй байцаагч, байгаль хамгаалагч ажиллаж ан агнуур болон бусад байгаль орчны холбогдох зөвшөөрөл олгож, харин хилийн алба нь хилийн боомтууд дээр хяналтаа тавьж, CITES-ын зөвшөөрлийг шалган нэвтрүүлдэг.

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяанд үйл ажиллагаа явуулдаг Цагдаагийн ерөнхий газар нь Монгол Улсад үйлдсэн бүх гэмт хэргийг (хууль бус ан агнуур болон зэрлэг амьтны хууль бус худалдаа орно) мөрдөн шалгах, хуулийн хэрэгжилтийн хангах чиг үүрэг бүхий гол байгууллага юм. Цагдаагийн байгууллага нь 2010 онд Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс байгуулан ажиллуулж эхэлсэн нь анхдугаар Зэлүүд тал тайлан гарснаас хойш Монгол Улсад зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх чиглэлээр гарсан эерэг өөрчлөлтүүдийн нэг юм. Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нь байгаль орчны эсрэг гэмт хэргийг дагнан хариуцаж, энэхүү тусгайлсан гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай мэдлэг, туршлагыг хуримтлуулах боломжийг ханган ажилладаг. Хэдий тус хэлтсийн анхаарал өнөөгийн байдлаар уул уурхайд холбоотой хэргүүд дээр илүү төвлөрч буй ч тэдний шалгаж буй хэргийн 15% нь зэрлэг амьтны хууль бус ан, худалдааны хэргүүд байна.

Бусдын нэгэн адил тус хэлтсийн боловсон хүчин, шаардлагатай нөөц эх үүсвэрийн хангамж нь үүсгэн байгуулагдсанаас хойш жилээс жилд буурч байна. Анхлан 2010 онд үүсгэн байгуулахад 30 ажилтантай байсан тус хэлтэс 2016 оны байдлаар 12 ажилтантай болсон байна. Хэлтсийн төлөөлөл болох гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлагаар энэ хэмжээний хүн хүчтэй байх нь улсын хэмжээнд гарч буй байгаль орчны бүх гэмт хэргийг бүрэн шалгах боломжгүй, зэрлэг амьтны гэмт хэрэг дээр бүр ч нөхцөл байдал тааруу байдгийг дурджээ. Сүүлийн гурван жилд Цагдаагийн байгууллага хууль бусаар ан хийсэн 168 хэргийг мөрдөн шалгаж, 112 хэргийг шүүхэд шилжүүлсэн (67%) ба 8,000 гаруй зэрлэг амьтны материал хураан авчээ.

Хууль бус ан агнуурын талаар мэдээлэл өгсөн тохиолдолд тухайн ноогдуулсан торгуулийн 15%-тай тэнцэх хэмжээний

мөнгөн урамшуулал олгох замаар мэдээлэгч нартай хамтран ажиллах боломжийг хуулиар тогтоон, дэмжиж өгчээ. Хэдийгээр ийнхүү урамшуулал олгох нь дэлхийн олон оронд амжилттай хэрэгждэг аргачлал хэдий ч үүнийг хэрэгжүүлэх дүрэм журам нь амжилт, үр дүнг тодорхойлдог. Урамшууллын систем ойлгомжгүй, жишээ нь мэдээлэгчийн нууцлалыг хадгалах болон төлбөрийн механизм нь тодорхой бус байх нь иргэд тухайн тогтолцооны талаарх сэтгэгдэл, мэдээлэл өгөх хүсэл эрмэлзэлд сөргөөр нөлөөлдөг.

Устах аюулд ороод буй зүйлийг хууль бусаар агнах нь нэмэгдсэнтэй холбоотойгоор Монгол Улсад авч хэрэгжүүлсэн өөр нэгэн арга хэмжээ бол Монгол Улсын баруун, зүүн, төв хэсэгт үйл ажиллагаа явуулж буй Хууль бус ан агнууртай тэмцэх явуулын нэгжийг байгуулж ажиллуулсан явдал юм. Энэхүү явуулын нэгжид Гааль, МХЕГ, Цагдаагийн газрын төлөөлөл орж, байгаль хамгаалагчидтай хамтран зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцдэг. Хууль бус ан агнууртай тэмцэх явуулын нэгж нь зэрлэг амьтны хамааралтай гэмт хэрэгтэй тэмцэхэд гарч буй цоорхой болон хууль сахиулах байгууллагууд хоорондын байнгын, үр дүнтэй харилцаа холбоо, мэдээлэл солилцох явдал дутмаг буй асуудлыг шийдэх зорилгоор байгуулагдаж үйл ажиллагаа явуулж эхэлжээ. Бодит үйл ажиллагааны хувьд сумын эсвэл тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагч дангаар ажиллах үед түүнд тулгардаг асуудлуудыг шийдэж өгдөг. Хууль сахиулах бүх байгууллагын ажилтнуудыг нэг бүлэг болгон ажиллуулснаар байгууллага хоорондын мэдээлэл солилцоо нэмэгдэх боломжтой.

Олон улсын зэрлэг амьтны худалдааны журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хилийн бүс дээр гаалийн байцаагч нар хяналт хийж, зохих зөвшөөрлийг шалгаж, тээвэрлэлтийн баримт бичиг, тээврийн хэрэгслийн бүртгэл зэрэг баримт бичгийг нягталж,

тухайн худалдааны хууль ёсны байдлыг шалгах зорилгоор бараа бүтээгдэхүүнд үзлэг хийхээс эхэлдэг. Энэхүү шалтгааны улмаас гаалийн байгууллага нь CITES-ыг хэрэгжүүлэхэд дэлхий нийтийн хэмжээнд чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улсын Гаалийн ерөнхий газар нь Сангийн яамны нэг томоохон үндсэн чиг үүрэг бүхий байгууллага юм. Үүнээс үзэхэд экспорт, импортын чиглэлээрх хууль сахиулах чиг үүрэг нь тэргүүлэх ач холбогдолтой асуудал болжээ. Монгол Улсын гааль нь 2011 онд нийт 3 их наяд төгрөгийн (1.3 тэрбум ам.доллар) гаалийн татварыг улсын төсөвт төвлөрүүлсэн нь улсын төсвийн орлогын 40%, ДНБ-ний 6%-тай тэнцэж байна. Ашигт малтмалын экспорт, газрын тосны бүтээгдэхүүн, автомашин, барилга, уул уурхайн тоног төхөөрөмжийн импорт нь гаалийн татварын орлогын үндсэн хэсгийг бүрдүүлэх тул хамгийн их анхаарал татдаг байна. Экспорт, импортын барааны 90 орчим хувь нь Алтанбулаг (Сэлэнгэ), Сүхбаатар, Замын-Үүдийн боомтуудаар дамждаг тул гаалийн үйл ажиллагааны ихэнх нөөц, эх үүсвэр нь эдгээр боомтуудад төвлөрч байна.

Гаалийн мэдээгээр улсын хэмжээнд 2014 онд хууль бус зэрлэг амьтны худалдаатай холбоотой гэмт хэрэг 3, 2015 онд 6, 2016 оны эхний 5 сарын хугацаанд 7-г илрүүлсэн байна. Нэгээс бусад бүх хэрэг нь БНХАУ-тай хийж буй худалдаатай холбоотой байсан бөгөөд энэ чиглэлд нийт асуудлын 90% нь төвлөрдөг болохыг гаалийн ажилтнууд баталж буй юм. Тус улс руу хууль бусаар зарж буй зэрлэг амьтны зүйл, тэдгээрийн бүтээгдэхүүн нь байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн тайланд дурдсантай ижил ба үүнд зээр (эвэр), саарал чоно (гулууз болон арьс), тарвага (арьс), баавгай (савар, шинэ болон хатаасан доньд), халиун буга (цусан эвэр, чив, засаа, сүүл), борцгор хотон (хошуу), үнэг болон хярс (арьс) багтаж байна.

Гаалийн харьяа Үнэрч нохойн алба

өнгөрсөн гурван жилийн хугацаанд зэрлэг амьтны хууль бус худалдааны нийт 310 хэрэг (үүний 80% нь хууль бусаар худалдаалахаар оролдсон арьс) илрүүлсэн хэмээн мэдээлжээ. Энэхүү тоо нь өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд мөрдөн байцаасан хэргээс бараг хорь дахин илүү байгаа бөгөөд эрүүгийн болон захиргааны хэргийн аль аль нь орсон. Өмнө дурдсанчлан хэдэн хэргийг захиргааны хэргээр шийдсэн нь тодорхойгүй тул цагдаагийн мөрдөн байцаалтын тоонд ороогүй байна.

Тагнуулын аппаратыг шинэчлэн зохион байгуулахаар олон жил ажилласны эцэст 2000 онд Монгол Улс нь орчин үеийн түвшинд хүрсэн Тагнуулын ерөнхий газрыг эмхлэн байгуулж, үндэсний аюулгүй байдалд хамаарах 25 хууль, журмын хэрэгжилтийг хангах, үүнд зэрлэг амьтны эсрэг гэмт хэргийг мөн багтаан, үндсэн чиг үүргийг нь тогтоож өгчээ. Тиймээс Тагнуулын ерөнхий газар нь зэрлэг амьтны олон улсын хууль бус худалдаанд холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах гол хэрэгжүүлэгч байгууллага юм. Тагнуулын ерөнхий газрын ажилтнууд мөнгө угаах, хүний наймаа, галт зэвсэг худалдаалах, авлига болон хил дамнуулан хууль бус худалдаа хийх зэрэг гэмт хэргийн талаар тагнуулын ажиллагаа явуулдаг.

Хил хамгаалах ерөнхий газар нь тус улсын 8,252 км урт хилийн бүсийг, 15 км өргөн хилийн зурвасын хамтаар хамгаалан, хуулийн хэрэгжилтийг хангах үүргийг хүлээдэг ба хамрах нийт газар нутгийн хэмжээ нь 123,780 километр<sup>2</sup> болж байна. Тус байгууллагын үндсэн чиг үүрэг нь террористууд болон тухайн үйл ажиллагаанд ашиглаж болох зэвсэг хэрэгсэл хил нэвтрэн орж ирэхээс сэргийлэхээс гадна хууль бусаар хил зөрчигч, цагаач иргэд орж ирэхээс хамгаалах, хууль бус зүйлсийг хил дамнуулан худалдахыг таслан зогсоох үүрэгтэй. Тус газрын мэдээгээр 3 сая зорчигч, 1.5 сая тээврийн хэрэгсэл жилдээ Монгол Улсын хилээр нэвтрэж байна.

### Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд авлига саад учруулж байна

Удирдлага болон хууль сахиулах үйл ажиллагаа нь Монгол Улс дахь авлигын нөхцөл байдлын сөрөг нөлөөнд байна. Транспаренси Интернейшнл байгууллагын 2016 оны Авлигын индексээр 38 оноо авч (0 оноо нь авлига өндөр хэмжээтэй, 100 оноо нь авлигагүй), 176 улсаас 87 дугаарт эрэмбэлэгдсэн Монгол Улс индексийн дунд хавьд, хөрш БНХАУ (40) болон ОХУ-ын (29) хамтаар доогуур байр бүхий улсуудын тоонд багтаж байна. Монгол Улсын энэхүү байранд сүүлийн 5 жилд олигтой өөрчлөлт гараагүй, харин 2017 онд хоёр оноогоор буурч 180 орноос 103 дугаарт орох болсон нь авлигатай тэмцэх хүчин чармайлт олон жилийн хугацаа шаардахыг харуулж байна.

Монгол Улсад хийсэн хараат бус судалгаагаар дээрх асуудлыг нотлох зарим тоо баримтууд дурдагдсаны дотор бизнесийн байгууллагын 31% нь “төрийн албан хаагчдад бэлэг сэлт өгөх нь ажлаа бүтээхэд хэрэг болдог”; худалдааны компаниудын 10% нь “авлигатай нүүр тулдаг”; хувь хүмүүсийн 7% нь “судалгааны өмнөх 3 сарын дотор ямар нэгэн байдлаар авлига өгч байсан”; гэснээс гадна иргэд гаалийн ажилтнуудыг хамгийн их авлига авдаг хэмээн үзсэн байна.

Зэлүүд тал тайлан нь хувь хүмүүсийн мэдээлсэн зэрлэг амьтны худалдаатай холбоотой зөрчил, хээл хахууль болон хөрөнгө шамшигдуулах асуудлаар баримтыг судалсан. Ярилцлагад хамрагдсан хүмүүсийн хэлсэн, батлагдаагүй мэдээллээр бол худалдаачид хил дээр шалгуулахаас зайлсхийхийн тулд гаалийн ажилтнуудтай хуйвалдах, байцаагч нар нь зөрчилд торгууль ноогдуулахдаа зохих баримт өгөхгүй байх, торгуулиа тайлагнахгүй байх, төрийн албан хаагчид ангийн зөвшөөрлийг найз нөхөд, гэр бүлийнхэндээ өгч оронд нь махыг нь авах, байгаль хамгаалагч нар зөрчлийг хараагүй мэт өнгөрөөх явдал түгээмэл ажээ.

Эерэг зүйл гэвэл авлигатай тэмцэх эрх зүйн орчин сайжирч, өндөр түвшний авлигын зарим хэргийг илрүүлээд байна. Монгол Улс нь Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллагын (OECD) Авлигатай тэмцэх конвенцод нэгдэн ороогүй ч НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийг соёрхон баталсан улс юм. Мөн дотоодын хоёр хуульд; Авлигатай тэмцэх тухай хууль (2006) болон Эрүүгийн хуульд (2016) тухайн гэмт хэргийн асуудлыг зохицуулжээ. Эрүүгийн хуулиар албан үүргээ урвуулан ашиглах, мөнгө угаах болон төрийн албан хаагчдын шууд болон дам байдлаар хахуульдах зэрэг хэрэгт эрүүгийн хариуцлага ноогдуулахаар тусгажээ. Хариуцлага нь 10 хүртэл жил хорих болон торгууль ноогдуулах зэрэг шийтгэл юм. Авлигатай тэмцэх тухай хуулиар авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий гол байгууллага болох **Авлигатай тэмцэх газрыг** байгуулжээ. АТГ нь авлигын хэрэгт хяналт тавих, мөрдөн байцаалт явуулах эрхтэй бөгөөд үүний хүрээнд гааль, хилийн ажилтнууд, байгаль хамгаалагчдыг шалгах эрхийг эдэлнэ.

## Зэрлэг амьтны хууль бус худалдааны эрх зүйн орчин

### Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх олон талт хандлага

Өмнөх хэсэгт дурдсан институцыг хөгжүүлэхэд сүүлийн арван жилд үзүүлсэн дэмжлэг тусалцааны хүрээнд зэрлэг амьтан хамгааллын менежментийг сайжруулах, хууль бус худалдаатай тэмцэх зохистой орчныг бүрдүүлэх эрх зүйн сайжруулалтыг хийж гүйцэтгэжээ. 2002 онд шинээр CITES-ын хэрэгжилтийг хангах тусгайлсан хууль, 2015 онд Зөрчлийн тухай хуулийг шинээр

батлан гаргасны зэрэгцээ Амьтны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Эрүүгийн хууль гэсэн 4 гол хуульд шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг хийсэн. Сүүлийн жилүүдэд бий болгосон ангийн хорио, хязгаарлалтууд, шинээр хэрэгжүүлэх болсон хууль тогтоомжуудыг оруулахгүйгээр авч үзвэл өнөөгийн эрх зүйн орчин үндсэндээ 20 гаруй хууль, журмаас бүрдэж байна.

Зэрлэг амьтны агнууртай холбоотой процедур болон зарим хязгаарлалтыг тодорхойлоход менежментийн хоёр хууль үйлчилж байна. Эдгээр нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон Амьтны тухай хууль юм. Амьтны тухай хууль нь эрх зүйн орчны үндсэн хэрэглүүр бөгөөд тухайн зүйлийн статус, ангийн квот, хорио, санхүүжилт болон зөвшөөрөл олгох үйл явц зэргийг тодорхойлсон шүхэр хууль юм. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль нь тодорхой бүс нутагт ан агнуур, загас агнуурыг хориглосон газар зүйн байршилд тулгуурласан хууль юм.

Зэрлэг амьтны худалдааг зохицуулах удирдах чиглэлээр, өөр 5 хуулийг чухал хэмээн үзэж байна. Үүнд хамаарах хуулиуд нь Зар сурталчилгааны тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль (уламжлалт эмтэй холбоотой) болон Татварын тухай хууль юм. Олон улсын худалдаанд хамаарах эрх зүйн орчинд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль болон CITES-ын хүрээнд Монгол Улсын хүлээх үүргийг хэрэгжүүлдэг Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай хууль багтана.

Эрх зүйн орчны дүн шинжилгээ нь зэрлэг амьтны гэмт хэрэгтэй холбоотой хоёр хууль болох Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиас гадна Зөрчлийн тухай хууль, түүнчлэн зэрлэг амьтны асуудалд шууд хамааралгүй ч эрх зүйн

орчинд багтаж болох Авлигатай тэмцэх тухай хууль, Мөнгө угаахтай тэмцэх тухай хуулийг судлан үзсэн. Монгол Улсын мөнгө угаах болон авлигатай тэмцэх чиглэлийн хуулиуд нь зэрлэг амьтан, зэрлэг амьтны хууль бус худалдааны талаар шууд дурдаагүй. Харин тухайн хуулиуд нь илүү ерөнхий хандлагатай, онолын хувьд хэрэглэх боломжтой бөгөөд гол мэдээлэгчдийн баталж хэлснээр зэрлэг амьтны хамааралтай гэмт хэргийг багтаан авч үзэж болох ажээ.

#### **Торгууль, эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд гарсан ахиц дэвшил**

Илт харагдах гол өөрчлөлт нь 1992 оны Захиргааны хариуцлагын тухай хуулийг орлон 2015 онд шинээр баталсан Зөрчлийн тухай хууль юм. Энэхүү хууль нь өмнө нь 220 гаруй тусдаа хуулиар зохицуулагдаж байсан захиргааны олон төрлийн зөрчил, хариуцлагыг нэгтгэх зорилготой юм. Тус хуульд нэг бүлэг нь байгаль орчны эсрэг зөрчлүүдийг тусган, Амьтны тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдах тухай хууль зэрэгт хамаарах зөрчлүүдийг тусгажээ. Бусад бүлгүүд нь мөн л хамаарах хууль тогтоомжоор заасан зөрчлүүд буюу Гаалийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Авлигатай тэмцэх тухай хууль, Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль зэрэгт хамаарах зөрчлүүдийг хамруулсан. Ийнхүү өргөн хүрээг хамарсан өөрчлөлт хийснээр Монгол Улс захиргааны хариуцлагын тогтолцооны зохистой байдал, ил тод байдлыг сайжруулж чаджээ. Тухайн зөрчлийг давтан гаргуулахгүй байхад шаардлагатай торгуулийн хэмжээ хангалтгүй байсан өмнөх хуультай харьцуулбал торгуулийн хэмжээг ихээхэн нэмэгдүүлсэн нь ахиц болсон.

Дараагийн нэг томоохон дэвшил нь Эрүүгийн хуульд чухал өөрчлөлт оруулж, зэрлэг амьтанд

хамааралтай гэмт хэргийн агуулга, хэлбэрийг нарийн тодорхойлсон. Өмнө нь зөвхөн хоёр заалт л зэрлэг амьтны эсрэг гэмт хэрэг дээр төвлөрч байсан бол шинэ хууль нь Зөрчлийн хуулийн нэгэн адил иж бүрнээр тухайн асуудлыг тодруулж, торгуулийн хэмжээ, хуулийн этгээдэд ноогдуулах шийтгэлийг заажээ. Судалгааг хийж байх үед тухайн хууль нь хүчин төгөлдөр хэрэгжиж эхлээгүй байсан тул цаашид үр дүнг харах хэрэгтэй ба ямартаа ч хуулийн агуулга сайжирсан нь ил байна.

Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд хийсэн орхигдлын шинжилгээгээр 77 төрлийн тусдаа үйлдлүүдийг (хууль бусаар борлуулах, худалдан авах, хадгалах гэх мэт) зэрлэг амьтны холбогдолтой гэмт хэрэг хэмээн үзсэнийг тогтоосон. Хууль нэг бүрийн дагуу зөрчил болон гэмт хэргийг тус тусад нь яллаж байна. Ихэнх хэрэг нь хууль бусаар агнах (27 хэрэг) болон хууль бусаар худалдаалах (26) хэрэг байна. Үлдэж буй хэргүүд нь галт зэвсэг (15), зохион байгуулалттай гэмт хэрэг (6) болон бусад үйлдэл дээр (3) гарч байна. Нэгтгэн үзвэл өмнөх хуультай харьцуулбал эдгээр нь зэрлэг амьтны худалдааны сүлжээний илүү өргөн хэсгийг хамаарч, үүнд хууль бусаар борлуулах, худалдан авах, бэлтгэх, авах, тээвэрлэх, хадгалах, импортлох, экспортлох багтаж байна.

Ноогдуулж буй торгуулийн хэмжээ нь тухайн амьтны экологийн үнэлгээнээс хамаарах ба хувь хүн болон хуулийн этгээдэд ноогдуулах торгуулийн хэмжээ ялгаатай, мөн албадан ажил хийлгэх болон баривчлах ял ч ялгаатай байна.

Ховор амьтны хувьд торгуулийн доод хэмжээ нь 5,400 нэгж (5,4 сая төгрөг буюу 4,700 ам.доллар), дээд хэмжээ нь 27,000 нэгж (27 сая төгрөг буюу 23,500 ам.доллар), нэн ховор амьтан бол торгуулийн доод хэмжээ 10,000 нэгж (10 сая төгрөг буюу 8,700 ам.доллар), дээд хэмжээ нь 40,000 нэгж (40 сая төгрөг буюу 34,700 ам.доллар) буй нь худалдаачид энэ гэмт хэргийг

үйлдэхээс татгалзуулах боломжтой ял юм. Хамгийн багаар нь бодоход торгуулийн хэмжээ нь нэн ховор болон ховор амьтны жагсаалтад орсон зүйлийн үнээс өндөр байна.

Хорих ялын хэмжээ ховор ан амьтан дээр 1-5 жил, нэн ховор ан амьтан дээр 2-8 жил байгаа ба эрүүгийн хариуцлагын тогтолцоо нь жагсаалтад орсон амьтны хувьд “хүнд гэмт хэрэг” хэмээн зүйлчилж байна.

### Орхигдлын шинжилгээ цаашдын шинэчлэл шаардлагатай салбарыг тогтоолоо

Хэд хэдэн чиглэлд сайжирсан зүйлс байгаа ч судалгаагаар хийсэн орхигдлын шинжилгээ нь цаашид эрх зүйн шинэтгэл шаардлагатай хэд хэдэн чиглэлийг тодорхойлон гаргасан.

Тухайлбал, Эрүүгийн хууль нь хууль бус худалдааны бүхий л хэсгийн хамарсан боловч хэд хэдэн чухал орхигдол байна.

Жишээ нь, зэрлэг амьтны хууль бус худалдаатай холбоотой зохион байгуулалттай гэмт хэргийг шууд зохицуулан заасан ямар нэгэн заалт байхгүй. Харин хуулиар хориглосон болон хязгаарласан барааг зохион байгуулалттайгаар худалдаалах гэсэн ерөнхий байдлаар зүйлчилж 5-12 жилийн хорих ял ноогдуулахаар заажээ. Зохион байгуулалттай гэмт хэрэгт хамаарах зэрлэг амьтны эсрэг ямар нэгэн үйлдэл, гэмт хэргийг үүнд хамруулаагүй. “Захиалгаар” ан хийдэг сүлжээ байнга илэрч буйтай холбоотойгоор үүнийг хуульд буй цоорхой хэмээн тооцож байна.

Үүний нэгэн адил хуулийн этгээд нь зэрлэг амьтны хууль бус худалдаатай холбоотойгоор ямар нэгэн хариуцлага хүлээхээргүй байна. Зохион байгуулалттай гэмт хэргийн нэгэн адил аж ахуйн нэгжид ноогдуулах хариуцлага нь гол санаа зовоож буй асуудал бөгөөд худалдааны компани болон зэрлэг амьтан хууль бусаар худалдаалагчдын дунд хэлхээ

холбоо тогтсон байдгийг анхаарах шаардлагатай байна. 2015 онд боловсруулсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад ховор болон нэн ховор амьтны хууль бус худалдаанд холбогдсон аж ахуйн нэгжид шийтгэл ноогдуулахаар заасан байсан ч 2017 онд энэхүү заалтыг хуулиас хассан байжээ.

Хуулиар хориглосон үйлдлийн жагсаалт нь нийт худалдааны бүхий л хэсгийг бүрэн хамраагүй байна. Хуульд зөвхөн дараах зүйлийг заажээ:

- худалдах,
- худалдан авах,
- ашиглах.

Худалдааны сүлжээнд багтдаг ч хуульд ороогүй үйлдэл нь дараах байна -

- бэлтгэх,
- цуглуулах,
- эзэмших,
- тээвэрлэх
- хадгалах.

Хуульд хэрэглэсэн үг хэллэгээс харвал экспортыг багтаасан эсэх нь тодорхойгүй, ямар төрлийн амьтныг хууль бусаар худалдаалсан тохиолдолд торгууль ноогдуулах нь харагдахгүй байна. Зохих зөвшөөрөлгүйгээр ямар ч төрлийн амьтан экспортлоход шууд хариуцлага ноогдуулахын оронд Зөрчлийн тухай хууль нь “хориглосон” болон “хязгаарлалт бүхий” бараа бүтээгдэхүүнийг борлуулсан тохиолдолд ял ноогдуулахаар заажээ. Зөвшөөрөл шаардагдах тохиолдолд тухайн зэрлэг амьтан нь “хязгаарлалт бүхий” хэмээх ангилалд орох ч энэ нь хуулийн эх дээр БОАЖЯ нь бүх төрлийн зэрлэг амьтны худалдаанд зөвшөөрөл шаарддаг эсвэл зөвшөөрөл олгодог эсэх нь тодорхой харагдахгүй байна.

Нэн ховор болон ховор амьтны хувьд хууль бусаар эзэмших, эм бэлдмэл зарах эсвэл зэрлэг амьтан гаршуулах зэрэг дээр заасан эрүүгийн хариуцлага байхгүй. Тээвэрлэлт, хадгалалт болон боловсруулах зэргийг

эрүүгийн хэрэг хэмээн үзээгүй, зохицуулалтгүй байна. Өөрөөр хэлбэл ямар зүйл эрүүгийн бүрэлдэхүүнтэй болох нь тодорхойгүй байна. Хууль ёсны байдлыг тодорхойлоогүй тул хууль бус байдал гэдэг дээр ямар ч тодорхойлолт гарахгүй юм.

Зөрчлийн тухай хууль нь ан агнуурын хориг зөрчих үйлдлийг шууд заагаагүй. Харин энэхүү хууль дээр “хориглосон бусад зүйл” гэдэгт үүнийг хамруулж байна. Энэ нь ангийн хориг дээр энэ нь үйлчилнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэж буйн зэрэгцээ шууд заасан зүйл заалт байхгүй байна.

Квотын талаар ганцхан заалт байгаа нь гэрээнд тусгасан ан хийх, хавх тавихыг хязгаарласан заалтыг зөрчих асуудал байна. Хууль нь гэрээнд үл хамаарах аливаа хязгаарлалтад шийтгэл тогтоогоогүй, мөн загас агнууртай холбоотой зөрчлөөр зүйл заалт байхгүй байгаа юм.

## Зэрлэг амьтны хууль бус худалдааг яллах нь

### Зэрлэг амьтны хууль бус худалдаа прокурорын яллах үйл ажиллагааны өчүүхэн хувийг эзэлж байна

Тус алба нь шүүх эрх мэдлийн байгууллагын нэг хэсэг бөгөөд гүйцэтгэх засаглалаас бүрэн хараат бус бүтэц юм. Газар зүйн хувьд Прокурорын газар нь 39 хэсэгт хуваагдах нийт 700 гаруй прокурор ажилладаг бөгөөд өнгөрсөн 10 жилийн хугацаанд 20,000 хэрэг жилд шийдэж иржээ. Эдгээрийн дөнгөж 1 хүрэхгүй хувь нь байгаль орчны эсрэг гэмт хэрэг бөгөөд үүнээсээ ч бага хувь нь зэрлэг амьтангай холбоотой хэрэг байна. Иймд тэдэнд буй нөөцийн (ажилтан, хуваарилсан цаг, зарцуулсан төсөв, тусгайлсан сургалт) маш бага хувь нь зэрлэг



амьтны хууль бус худалдаанд хамаарч буй хэмээн үзэж болно.

### **Хяналт шалгалт, мөрдөн байцаалтын чиг үүргийн хуваагдал асуудал дагуулах нь**

Зэрлэг амьтны холбогдолтой гэмт хэргүүд нь өмнөх хэсэгт дурдагдсан хууль сахиулах үүрэг бүхий ажилтнуудын оролцоотойгоор орон нутагт илрэх байдлаар эхэлдэг. Үндсэндээ энэхүү үйл явц нь байгаль хамгаалагч, гаалийн байцаагч эсвэл хил хамгаалалтын ажилтан зэрлэг амьтны хууль бус худалдаа байж болох сэжигтэй тохиолдлыг саатуулж, улмаар Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст мэдэгддэг. Цагдаагийн газар тухайн асуудлаар хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт явуулж, эрүүгийн байцаан шийтгэх журмын дагуу эд мөрийн баримт, нотолгоог бүрдүүлдэг. Хэрэв баримт нотолгоо хангалттай гэж үзвэл прокурорт хандах ба энэ шатанд тухайн хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах эсвэл яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлэхэд хангалттай үндэслэл буй эсхийг магадлан шалгадаг. Энэ тохиолдолд прокурор нь төрийг төлөөлөн, хэргийг хамаарах анхан шатны шүүхэд шилжүүлдэг. Үүнээс харвал яллах үйл ажиллагаа нь шүүхэд шилжүүлэн, тухайн гэмт хэрэгт ял ноогдуулахаас өмнө хэд хэдэн байгууллагыг дамжсан олон шат дараалал бүхий үйл явц юм.

Цуглуулсан нотлох баримтын чанар, бүрдэл зэргээс үүдэн прокурор нь тухайн хэрэг дээр дээр яллах дүгнэлт үйлдэх эсвэл хэрэгсэхгүй болгох шийдвэрийг гаргана. Илрүүлэх, мөрдөн байцаах, яллах зэрэг эдгээр шатыг дамжсанаар шаг нэг бүрт чанарын шаардлагыг хангах ба энэ нь эрүүгийн хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэглэх, зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэрэгт ял шийтгэл ноогдуулах болон цаашид гарч болохуйц гэмт хэргийг таслан зогсоохуйц шийтгэл ноогдуулах зэрэгт чухал нөлөөтэй байдаг.

Энэ нь эргээд эрүүгийн хууль тогтоомжийг үр дүнтэй ашиглаж,

зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэрэгт шийтгэл ноогдуулж, ирээдүйд гарч болох гэмт хэргээс татгалзах хэмжээний шууд нөлөөллийг үзүүлж байдаг. Гэмт хэргийн газар дээр хамгийн түрүүн ирж ажиллаж буй ажилтнууд нь тухайн хэргийн газрыг хамгаалалтад авах, эд мөрийн баримтуудыг бэхжүүлэх, түүнчлэн биет баримт нотолгоо цуглуулах, дээж сорьц болон нотолгоог шүүхийн шинжилгээнд хамруулахад голлох үүргийг гүйцэтгэнэ.

### **Баримт нотолгооны протокол хангалтгүй нь зэрлэг амьтны хууль бус худалдааны хэргийг яллах ажлыг үр дүнгүй болгож байна**

Гэмт хэргийн бодит баримт нотолгоо нь эрүүгийн гэмт хэрэг шалган шийдэхэд чухал үүрэгтэй. Зэрлэг амьтны хууль бус агнуур болон худалдааны хэрэг дээр тухайн хууль бус үйлдлийг зэрлэг амьтныг биет байдлаар нь (амьд амьтан, эд эрхтэн гэх мэт) нотлох шаардлагатай тул буу, автомашин, баримт бичиг болон бусад төрөл бүрийн нотолгоо шаардлагатай байдаг. Ийм төрлийн нотолгоог баталгаажуулаагүй, зөв хадгалаагүй тохиолдолд, гэмт хэрэгт холбогдогч тухайн нотолгоог хялбархан няцаах боломжтой. Няцаах боломжгүй нотолгоо хомс байх нь тухайн хэргийг яллах прокурорын ажилд сөргөөр нөлөөлдөг.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиар хууль сахиулах байгууллагын ажилтан баримт нотолгоотой харьцах, хадгалах, ашиглах арга зүйг тодорхой заагаагүй байна. Үүнээс үүдэн зарим тохиолдолд зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэрэг нь нотолгоог батлан харуулахаас эхлэн асуудал үүсч, нэгэнт прокурорт шилжүүлсэн л бол гарсан алдааг засах боломжгүй байдалд хүргэж байна.

Тухайн нөхцөл байдлыг үүсгэж буй өөр нэг зүйл нь Монгол Улсад баримт нотолгоог хадгалах байгууламж дутмагаас тухайн

баримт нотолгоог бэхжүүлэхэд түр зуурын аргацаасан арга хэрэглэж буйг ярилцлага өгсөн хүмүүс дурдсан байна. Тухайлбал, хууль бус загасчинд загасыг буцаан өгөх, хураасан зүйлүүдийг зарж борлуулах, муудах бүтээгдэхүүнийг хаях устгах, шархадсан амьтныг байгальд нь эргүүлж тавих зэрэг арга хэмжээг авдаг байна. Үүний улмаас шүүх хуралдаан хийх үед баримт нотолгоо тэр бүр хангалтгүй байдаг нь тухайн хэргийг амжилттай яллах нь боломжгүй болж ноцтой сөрөг нөлөө гардаг байна.

### **Ял шийтгэсэн хувь хэмжээ, хэрэгжилт ерөнхийдөө хангалтгүй байна**

Монгол Улс дахь эрүүгийн хэргийн шүүх хурлаар ял ноогдуулж буй хувь хэмжээ нь 2005-2014 онд 43% байжээ. Энэ нь Прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэн, шүүхэд шилжүүлсэн нийт гэмт хэрэгт ял ноогдуулсан (өнгөрсөн 10 жилийн хугацаанд 19,927 байсан нь жилд ойролцоогоор 2000 орчим) хувь хэмжээ юм (8,248 яллагдагч буюу жилд ойролцоогоор 800).

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь зэрлэг амьтны эсрэг хууль бус гэмт хэрэгт шийтгэл ноогдуулж байгаа байдлыг тодорхойлдог чухал үзүүлэлт юм. Яллах, ял эдлүүлэх гэдэг нь харилцан адилгүй зүйл бөгөөд энд багагүй цоорхой байна. 2004-2014 оны 10 жилийн хугацаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн улсын дундаж ойролцоогоор 70% байна. Үүнтэй холбоотой өөр нэг үзүүлэлт нь эдийн засгийн хохирлын үнэлгээ болон хохирол барагдуулсан хэмжээний харьцаа юм (төр болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд). 2005-2016 оны хооронд үнэлгээгээр тооцсон хохирол болон нөхөн төлсөн хэмжээний харьцаа 3:1 байсан буюу үнэлгээгээр тооцсон нийт хохирлын 36% нь л эргэн төлөгдсөн гэсэн үг юм. Нийт дүнгээр нь үзвэл 2005-2016 онд үнэлгээгээр тогтоосон, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ нь 348 сая төгрөг буй нь мөрдөн байцаалтын үеэр тогтоосон 953 сая төгрөгтэй харьцуулбал маш

бага үзүүлэлт юм. Үндсэндээ бараг 600 сая төгрөгийн хохирол нөхөн төлөгдөөгүй үлдсэн нь алдагдсан боломжийн зардал болж, баримт нотолгоог бүрэн бүрдүүлээгүй, тоног төхөөрөмж дутмаг, эрүүгийн гэмт хэрэг мөрдөх дэд бүтэц дутуу буйгаас үүдсэн зардал болж байна.

### **Зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэрэгт тавих анхаарал сул байна**

Өнгөрөгч арван жилийн туршид байгаль орчны эсрэг гэмт хэрэг нь нийт гэмт хэргийн багахан хувь буюу нийт 250,000 хэргийн 2,500 орчим болж ойролцоогоор 1%-тай л тэнцэж байна. Эдгээрт зэрлэг амьтны хууль бус худалдаанд холбогдох гэмт хэргийн тоо бүр ч бага, дээрх 1%-ийн 15%-ийг буюу 1,000 хэрэг тутмын нэг нь зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэрэг байна. Хэдий энэхүү судалгаа нь зэрлэг амьтанд хамааралтай хэргийг яллах үйл ажиллагааны талаар үндэсний хэмжээний статистик мэдээлэл ашиглаагүй ч Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн гаргасан тооцоогоор тэдний мөрдөж буй нийт хэргийн ердөө 15% нь л зэрлэг амьтантай холбоотой байдаг ажээ (уул уурхайн холбогдолтой хэрэг түлхүү байдаг тул илүү анхаарал орж, нөөц эх үүсвэрийг түүнд зарцуулдаг). Прокурорын газраас өгсөн 17 аймгийн зэрлэг амьтны хамааралтай гэмт хэргийн тухай мэдээлэл болон зураг 20 дээр байгаа мэдээлэл нь үүнтэй ижил үр дүнг харуулж байна. Тэдгээрт харуулснаар 2007-2017 оны арван жилийн хугацаанд мөрдөн байцаалт хийсэн зэрлэг амьтны хамааралтай гэмт хэргийн тоо 263 (220 нь хууль бус ан агнуур, 43 нь зэрлэг амьтны худалдаа) байсан нь тухайн хугацаан дахь байгаль орчны эсрэг нийт гэмт хэргийн 11%-тай тэнцэж байна. Энэхүү судалгааны хүрээнд 2013-2015 оны 3 жилийн мэдээллийг Прокурорын газраас гаргаж өгөөгүй ч тус албаны ажилтнууд прокурорын байгууллагын хянаж буй нийт хэргийн тоонд зэрлэг амьтны эсрэг гэмт хэрэг маш бага байдгийг

баталсан бөгөөд нийт 8,000 эрүүгийн хэрэгт зэрлэг амьтны хамааралтай гэмт хэрэг ердөө 17 байна. Эдгээрийн 65% орчмыг нь шүүхэд шилжүүлж, үлдсэн 35%-ийг нь прокурорын шатанд хэрэгсэхгүй болгосон байна. Өмнөх хэсэгт тайлбарласанчлан шүүх дээр тухайн хэргийг нотлох баримт нотолгоо хангалтгүй шалтгаанаар ийнхүү хэрэгсэхгүй болгож байна. Мэдээлэл олж авсан 17 аймагт зэрлэг амьтны хууль бус агнууртай холбоотой 142 хэрэг, хууль бус худалдаатай холбоотой 27 хэргийг шүүхэд шилжүүлсэн ч ноогдуулсан ял, үүний хэрэгжилтийн талаар мэдээлэл байхгүй байна.

### **Олон сул талууд зэрлэг амьтны эсрэг гэмт хэргийг эрсдэл багатай, ашиг өндөртэй гэмт хэрэг болгож байна**

Дүгнэж үзвэл сүүлийн арван жилийн хугацаанд зэрлэг амьтанд холбогдох гэмт хэргийг Монгол Улсад мөрдөн шалгах болон яллах үйл явц хязгаарлагдмал байна. Орон нутагт, ялангуяа ан агнуурын нутагт ажилладаг хууль сахиулах чиг үүрэг бүхий ажилтнуудад үйл ажиллагааны явуулах чадавх болон мөрдөн шалгалт хийх эрх мэдэл дутмаг буй бол гаалийн ажилтнуудын хувьд тамхи, архи зэрэг гаалийн татвараас зайлсхийсэн хэргүүд дээр түлхүү анхаарал хандуулж байна. Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нь үндсэндээ ашигт малтмалын нөөцийн төлбөр болон татварын орлогод илүү нөлөөтэй уул уурхайн салбарт үйлдэж буй гэмт хэрэгт төвлөрч байна. Энэ бүхний үр дүнд харьцангуй цөөн тооны гэмт хэрэг илэрч, тулгарч буй олон тооны асуудлуудаас (жишээ нь баримт нотолгоо цуглуулахтай холбоотой бүтцийн, процедурын, ложистикийн асуудлууд, хураан авсан зэрлэг амьтны бүтээгдэхүүнийг зохих ёсоор хадгалах, экспертийн чадавх дутмаг байх, шүүхийн шинжилгээ хийх чадавх, дотоод гадаадын хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоо сул зэрэг) үүдэн олон хэргүүд шийдэгдэхгүй

үлдэж, маш цөөн тохиолдолд л шүүхээр шийдэж буй нь гэмт хэрэгтнийг шударга шийтгэлээс мултрахад дөхөм болж байна. Шүүхийн шийдвэрээр тухайн гэмт хэрэгт тохирсон ял ноогдуулж буй ч Өршөөлийн хуулийн дагуу шийтгэлээс чөлөөлөгдөж, хохирлын хэмжээнд нийцүүлэн ноогдуулж буй торгуулийг бүрэн төлөхгүй тохиолдол элбэг байна.

Энэ бүхний эцэст Монгол Улсад үйлдэж буй хууль бус ан агнуур, худалдаа өнөөг хүртэл үргэлжилж, эрүүгийн болон санхүүгийн багахан хариуцлага л хүлээхүйц хэмжээнд хэргийг шийдэж, илрүүлэхэд хүндрэлтэй, эрсдэл багатай хэмээн тооцох болжээ. Сүүлийн үед хийж буй эрх зүйн шинэтгэлийн хүрээнд ноогдуулах ял шийтгэл, торгуулийн хэмжээг нэмж, эрүүгийн хэргээр зүйлчлэх болсон нь цаашид тухайн төрлийн гэмт хэргийг яллах хэмжээ нэмэгдэх итгэл төрүүлж буйн зэрэгцээ шинэтгэлийн үйл ажиллагааг цааш үргэлжлүүлэх шаардлагатай хэвээр байна.

## **2015 оны зэрлэг амьтны агнуур**

### **Ан агнуураас загас агнуурт шилжиж байна**

Арав гаруй жилийн өмнөөс галт зэвсгийн хяналт суларч, сум тоног хэрэгслийн үнэ хямдарч, олдоц нь сайжирч, хууль тогтоомж хэрэгжүүлэх үйл ажиллагаа суларснаас гэх мэт олон шалтгааны улмаас зэрлэг амьтны хууль бус ан агнуур ихээхэн хэмжээнд нэмэгджээ. 2005 оны байдлаар 15-65 насны эрчүүдийн 30 гаруй хувь нь агнуур хийдэг байснаас ихэнх нь зэрлэг ан агнадаг, харин багахан хувь нь загасчилдаг байсан нь 250,000 орчим байв. Харин 2015 онд хийсэн судалгаагаар ан хийж буй хүмүүсийн тоо үндсэндээ өмнөх түвшиндээ буюу 247,504 (25%) хадгалагдаж буй ч энэ талаараа мэдээлэл өгөхөөс цааргалах нь их болсныг тогтоосон. Түүнчлэн тус судалгаагаар загасчдын тоо ихээхэн нэмэгдсэнийг тогтоожээ.

Анчид өөрийнхөө тухай мэдээлэл өгөхдөө доогуур хэмжээ хэлэх эсвэл загасчдын хувьд эрсдэл багатай гэсэн ойлготоос үүдэн илүү ихээр “загас барьдаг” гэсэн хариултыг сонгож болохоос үүдэн гарах алдааг тооцон шинжилгээ хийхэд ан агнуураас загас агнуурт шилжих шилжилт явагдаж буй нь тодорхой болж байна. Судалгааны дүнгээс үзвэл ан агнуур эрхэлж буй хүмүүс нь илүү олон жилийн туршлагатай (дунджаар 12 жил), харин загас агнуур эрхэлж буй хүмүүсийн хувьд туршлага арай багатай (8 жил) байна. Үүнийг баталгаажуулах өөр нэг зүйл нь анчид ба загасчдын бүлэгт байгаа 5 хүртэлх жилийн туршлагатай, тухайн салбарт харьцангуй шинээр орж буй хүмүүсийн тоо өндөр буй үзүүлэлт юм. Тухайлбал, анчдын бүлэгт ийм шинэ хүмүүсийн хувь хэмжээ 38%, загасчдын бүлэгт 68% байна. Өөрөөр хэлбэл харьцангуй болон абсолют утгаар нь авч үзвэл маш олон хүн зэрлэг амьтны агнуур, худалдааны салбарт загасчин гэсэн статусаар шинээр орж ирж буй нь анчдын эгнээнд шинээр нэгдэж буй хүмүүсийн тооноос өндөр байна. Анчдын хувьд нас нь ч мөн ахиж байна. 2005 оны судалгаагаар ан агнуур эрхлэгчдийн 44% нь 15-28 насныхан байжээ. Харин 2015 онд хийсэн судалгаагаар 15-30 насныхан нийт анчдын дөнгөж 30%-тай тэнцэж байна. Ан хийсэн нийт жилийн дундаж хугацаанд гарч буй энэхүү өөрчлөлтийг харгалзан үзвэл ан агнуур эрхэлж буй хүмүүсийн 41% нь ахимаг настай болж, 31-50 насныхан зонхилж байна. Зэрлэг ан агнадаг хүмүүсийн 58% нь хөхтөн амьтан, шувуу агнадаг бол 82% нь загас агнуур эрхэлж байна. Гэтэл 2005 онд загасчдын хувь хэмжээ нь дөнгөж 10% байжээ.

2005 оны судалгаа нь агнаж буй 34 зүйлийн амьтан бүрийн 4 нь загас хэмээн тогтоож байсан бол (12%) арван жилийн дараа энэхүү хувь хэмжээ 46%-иар нэмэгдэж хамгийн багадаа л 11 төрлийн загасыг агнаж байгаа бөгөөд тэдгээрийн 7 нь өмнө нь огт агнасан гэж мэдээлж байгаагүй төрөл байна. Одоогийн байдлаар Монгол Улсын зэрлэг

амьтны агнуурт загасны хувь хэмжээ өсөж буй нь худалдааны хандлага өөрчлөгдөж хараахан судлагдаагүй нөлөөлөл буй болж байгааг харуулж байна. Мөн энэ асуудлыг Монгол Улсын бодлого гаргагчид ч хараахан анхааралдаа аваагүй байна. Шинээр хэрэгжиж буй Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуулиар хууль бусаар загас барих тохиолдолд хариуцлага тооцох маш цөөхөн заалт байгаа юм (Бүлэг 4-ийг үзнэ үү).

### **Анчид ярих дургүй байгаа нь хууль бус үйлдлийн талаар тэд мэдээлэлтэй буйг харуулж байна**

Өрхийн судалгаагаар 2005 онд анх 34 төрлийн амьтан агнадаг хэмээн мэдээлж байсангай харьцуулбал энэ удаад 24 амьтныг нэрлэжээ. Анчдын хариултанд дурдагдаагүй амьтдын тоонд нэн ховор болон ховор амьтад болох ирвэс, хүрэн баавгай, хүдэр, хойлог болон хулан зэрэг багтжээ. Гэвч эрүүгийн цагдаагийн газрын бүртгэлээс үзвэл тухайн амьтдыг агнаж, борлуулж байна.

Тухайн амьтад нь 2005 оны судалгааны үеэр ч ховор болон нэн ховор хэмээх жагсаалтад багтаж байснаас үзэхэд нь ингэж тоо нь цөөрсөн үзүүлэлт нь тухайн амьтдын хамгаалалтын статусаас бус харин хууль сахиулах үйл ажиллагааны өөрчлөлтөөс болж байна. Судалгаагаар анчид тухайн амьтдыг агнадаг амьтны тоонд оруулан дурдаагүй нь санамсаргүй хэрэг ч бус, судалгааны арга зүй хэрэгжсэн хэрэг ч бус, харин хүн амын дунд эрх зүйн талаарх мэдлэг мэдээлэл бий болсныг баглан харуулж байна.

### **Агнуурын тоо багассан ч эрчимжилт нэмэгдсээр**

Зэрвэс харвал судалгаагаар Монгол Улсад зэрлэг амьтны ан агнуур, худалдааны чиглэлийн үйл ажиллагаа 2005 оноос хойш ихээхэн багассан мэт харагдаж байна. Тухайн оны нийт зэрлэг амьтны эд эрхтэний тоо нь (12 амьтан дээр) 4.4 сая байсан бол энэ удаагийн

судалгаагаар нийт тоо нь 2.4 сая болжээ (18 төрлийн амьтан). 2015 онд хийсэн судалгааны мэдээллийг улсын хэмжээний нийт агнуурын тоо болгон тархахад гарч буй түвшин нь ан хийдэг хүмүүсийн тоо бага, агнадаг амьтны тоо цөөн байсан 2005 онтой харьцуулбал байдал илүү хүндэрсэн харагдаж байна.

Хамгийн олон тоогоор агнаж буй амьтдыг ихээс нь бага руу нь бууруулсан байдлаар авч үзвэл: **тарвага** (849,764), зэвэг (216,890), алгана (192,075), цурхай (96,782), болон **чоно** (17,000, дутуу тайлагнаснаар нь залруулга хийлгүй оруулав) байна.

Хамгийн ихээр агнадаг амьтдын жагсаалт нь 2005 оныхтой ерөнхийдөө ижил ч бага зэрэг өөрчлөлт орсон бөгөөд энэ нь 1) Монгол тарвага, 2) чоно, 3) Алтайн тарвага (38,000), 4) үнэг (19,000), 5) зэрлэг гахай (9,000), 6) бор гөрөөс (8,000), 7) зээр (6,000) болон 8) улаан үнэг (4,000) гэсэн дараалалтай болжээ.

Монгол тарвага болон чоно нь хамгийн ихээр агнадаг амьтан хэвээр буй бөгөөд анчдын хамгийн багадаа 44% нь тарвага, (121,000 hunters), 16% нь чоно агнаж байна (44,000 анчин). Нэг анчинд ноогдох тухайн хоёр амьтны агнуурын дундаж хэмжээ нь 2005 онтой харьцуулахад буурсан ч нийт агнасан тоо хэмжээнээс харвал квотоос хэтрүүлэн хууль бусаар агнах их хэмжээнд байсаар байна. Ялангуяа чонын хувьд нийт тоо толгойд нь харгалзуулж үзвэл маш өндөр байна. 2015 оны чоно агнуурын хамгийн доод тооцсон тоо болох 17,000-ийг нийт тоо толгойтой (10,000-20,000) харьцуулбал сонин үзүүлэлт гарч байна. 2005 оны болон энэхүү судалгаагаар агнуурын дундаж хэмжээ ижил буйг тогтоосон ч чонын тоо толгойн талаарх дэлгэрэнгүй судалгааг цаашид хийж, улмаар шинжлэх ухааны аргаар агнуурын тоо толгойг тогтоох шаардлагатай байна. Одоо албан ёсоор тогтоосон ангийн квот болох жилийн 20 чонын тоог

хэтрүүлж буй нь ойлгомжтой бөгөөд 1000 дахин хэтрүүлж буй нь ч тодорхой байна.

Судалгаагаар агнуурыг жилийн турш хийж, зун намрын улиралд хамгийн их идэвхжидэг нь харагдлаа. Өвөл нь дараагийн хамгийн гол ангийн улирал бөгөөд 14 төрлийн амьтан агнадаг; дараа нь хаврын улиралд 12 төрлийн амьтан агнаж байна. Тоо хэмжээ нь хавар огцом унадаг ч бүх улирлын туршид зэрлэг амьтан агнаж буй анчид байна. Амьтны тухай хуулиар заасан ангийн нээлттэй болон хориотой улиралтай харьцуулахад хууль бус ан агнуур нь жилийн туршид тогтмол явагдаж буй нь тодорхой байна. Ангийн бус улиралд ан агнуур хийх нь гөрөөс (зөвхөн намар агнахыг зөвшөөрдөг ч жилийн 4 улирал агнадаг); хярс (намар болон өвөл зөвшөөрдөг, гэхдээ 4 улиралд агнадаг); Монгол болон Алтайн тарвага (намар орой агнахыг зөвшөөрдөг гэвч 3 улиралд агнадаг); болон тул загас (зун болон намар зөвшөөрдөг ч 4 улирал агнадаг) зэрэг амьтад дээр их байна.

#### Агнуурт буунаас илүү автомашиныг хэрэглэх болжээ

2015 оны судалгаанд хамрагдсан ан агнуур эрхлэгчдийн 58% нь галт зэвсэг эзэмшдэг хэмээн хариулсан. Энэ нь 2005 онд бараг бүх анчид (96%) галт зэвсэг эзэмшдэг хэмээж байсантай харьцуулбал эрс өөрчлөлт гарсан хэрэг болжээ. Энэ хэмжээний өөрчлөлт гарсан шалтгааныг галт зэвсэг ихээр хураан авсан, зөвшөөрөлд хязгаарлалт хийсэн, сум хэрэгсэл авахад хүндрэлтэй болсонтой холбон тайлбарлаж болох ч дангаараа гол шалтгаан болохгүй. Галт зэвсэг эзэмших зөвшөөрлийн хязгаарлалт, орон нутагт сум хэрэгсэл хууль ёсоор худалдан авах нь хүндрэлтэй байдаг нь ан агнуурын аргадаа өөрчлөлт хийхэд хүргэж, буудахаас илүүтэйгээр автомашин ашиглах нь түлхүү болж буйн нэг шалтгаан байж болно. Гэвч энэхүү судалгаа нь хууль бус, хор хөнөөл ихтэй ан агнуурын аргыг ашиглаж буйг баримтжуулсан ба

эдгээр нь олон жилийн өмнө их ховор, бараг ашигладаггүй байсан аргууд юм. Эдгээрийн жишээнд автомашинаар дайрч алах, амьтныг цуцах хүртэл машинаар элдэн хөөх зэрэг багтжээ. Үүнээс үзвэл агнуурын арга нь хуучин галт зэвсэг дээр тулгуурлаж байсан бол одоо автомашин орлох хандлагатай болсон нь харагдаж буй бөгөөд хууль сахиулагчид ч үүнийг баталж байна.

Анчдын дунд хавхтай хүний тоо 2005 онд 8% байсан бол энэ удаагийн судалгаагаар 21% болж нэмэгджээ. Үүнийг батлан Монголын Улсын гаалийн мэдээлэл дээр хавхны импорт нэмэгдсэн болохыг тэмдэглэжээ.

Загасчлах арга болон тоног хэрэгслийн хувьд судалгаагаар уурга дэгээ (74%), гараар хийсэн тоноглол (15%) болон тор (13%) хэрэглэдэг нь харагдлаа. Өрхийн хэмжээнд загас агнуурт импортын уурга дэгээ хэрэглэж байна.

## Өрхийн хэмжээний зэрлэг амьтны худалдаа

### Өрх айлын зэрлэг амьтны худалдааны талаар хэн ч үл дуугарна

2005 онд хийсэн судалгааны дүнгээс эсрэгээрээ айл өрхүүд нь ямар нэгэн байдлаар зэрлэг амьтан агнадаг болохоо мэдүүлэхээс ихээхэн цааргалж, цөөн тохиолдолд л мэдээлж байв. Харин энэ талаар өөрсдийнх нь хэлсэн зүйлээс зах, ресторанууд болон дэлгүүрт хийсэн ажиглалт нь огт өөр түүхийг өгүүлж байна.

Судалгаагаар олж авсан борлуулалт/худалдааны мэдээллийг энд харуулсан ч худалдааны сүлжээний нөгөө талд буй хүмүүсийн хувьд хууль эрх зүйн орчин тодорхой нөлөөтэй байгаа нь харагдаж байна. Иргэд нийт агнаж буй загасны хэмжээгээ хэлэхдээ зөвхөн өрхийн хэрэглээний хэмжээгээр авдаг

хэмээн мэдээлж байв. Тухайлбал, тарваганы 4%-ийг, чонын арьсны 10%-ийг л борлуулдаг хэмээн хариулжээ. Эдгээр тоог улсын хэмжээнд жил тутамд агнаж буй тоотой харьцуулан үзвэл өрхийн түвшинд зэрлэг амьтны борлуулалтыг тархаан тооцвол 15,431 тарвага, 4,422 чоныг 2005 онд агнажээ. Судалгаагаар тогтоосон мэдээллийг ашиглан 15,431 тарвага Монгол Улсад жил тутам агнаж байна хэмээн тооцсон бөгөөд энэ нь нийт орлогын хувьд 216,000 ам.доллар болж, 4,422 чоноос олох орлого буюу арьсны борлуулалтын орлого нь 280,000 ам.доллар болж байна.

### Өрхийн худалдан авалт өөр түүхийг өгүүлэх нь

Айл өрхийн хувьд зэрлэг амьтан, эд эрхтэн худалдан авч буй байдлыг судалсан хэсгийн үр дүн нь харьцангуй өөр дүр зургийг гаргаж байна. Ан агнуур эрхлэгчдийн мэдээлснээр хоёр л амьтан (чоно, тарвага) зарж борлуулдаг гэж буй бол нөгөө талаас өрхийн судалгаагаар 35 төрлийн амьтан, эд эрхтэй худалдан авдаг хэмээн мэдээлжээ. Ерөнхийдөө зэрлэг амьтан, эд эрхтний худалдан авалтанд өрхийн оролцох оролцоо нь ихээхэн идэвхтэй харагдаж байгаа ба нийт 175,000 өрхийн 20% нь зэрлэг амьтантай холбоотой худалдан авалт хийдэг байна.

Судалгаа нь мөн өрхийн худалдан авах чадвар нэмэгдэхэд худалдан авалт нэмэгдэж буйг харуулсан. Ядуу өрхүүдийн 11% нь л зэрлэг амьтан худалдан авдаг бол чинээлэг өрхүүдийн хувьд энэ хэмжээ нэмэгдэж 34% болтлоо өсөж байна.

Хүнсний хэрэглээ нь зэрлэг амьтан худалдан авах хамгийн түгээмэл хэрэглээ бөгөөд амьтныг бүтнээр нь эсвэл килограммаар (мах) худалдан авахын зэрэгцээ түүхий эсвэл боловсруулалт хийсэн байдлаар мөн худалдан авч хэрэглэж байна (жишээ нь чанаж болгосон тарвага, утсан загас гэх мэт). Арьс, үс эсвэл тос зэрэг бүтээгдэхүүн худалдан авах нь дараагийн хамгийн түгээмэл хэрэглээ байна. Цөс,

тархи, ходоод эсвэл элэг зэрэг дотоод эрхтэн худалдан авах явдал судалгаагаар гурван амьтан дээр (чоно, дорго, баавгай) тогтоогдсон. Бариад эргүүлэн тавих нөхцөлтэй тул загасыг 2015 онд худалдан авч хэрэглэсэн тохиолдол цөөн бүртгэгдсэн ба тухайн тохиолдолд мах, тосыг нь ашиглажээ.

Худалдан авч хэрэглэдэг гол 5 амьтны тоонд тарвага, чоно, зээр, гөрөөс болон зэрлэг гахай багтаж байна. Харин загасны хувьд цагаан загас, зэвэг, алгана болон тул орж байна. Айл өрхийн зэрлэг амьтны худалдан авалтыг тархаан тооцвол нийт орлого нь 4 сая орчим ам.доллар болох ба энэ нь өрхүүдийн мэдээлсэн зарж борлуулж буй хэмжээтэй нь тооцвол 8 дахин илүү байна (0.5 сая ам.доллар).

## Ресторанууд дахь зэрлэг амьтны хууль бус худалдаа

Өрхийн судалгаагаар тогтоосон загас агнуур, худалдааны хэмжээ, энэхүү нөхцөл байдал анхаарал татахуйц хэмжээнд хүрсэн учир зах зээлийн судалгааны асуулгад загасны хэрэглээний талаар нэмэлт асуултууд оруулан судлахад хүргэсэн бөгөөд монголчуудын хувьд мах, сүүн бүтээгдэхүүн нь уураг авах уламжлалт эх сурвалж хэмээн бид ойлгож байсан юм. Хэдийгээр судалгаанд хамрагдсан өрхүүд өөрсдийн барьсан загасаа зарж борлуулдаг гэж хэлээгүй ч зах зээл, ресторануудад орон нутгаас нийлүүлсэн загас, загасан бүтээгдэхүүн борлуулагдаж буй нь 2005 болон 2015 оны судалгаагаар тогтоогдсон.

Нийт түүврийн 42% дээр уламжлалт монгол хоолны ресторан нь загасаар бэлтгэсэн хоол хүнсээр үйлчилж байлаа. Дараа нь солонгос (30%), хятад, итали, европ хоолны ресторанууд (тус бүр 17%) орж

байна. Бусад ресторанууд үйлчилж буй хоолны төрлөөр нийт түүврийн багахан хувь хэмжээг эзэлж байна. Бүх ресторануудын нийт тооцоо байхгүй эсвэл аль төрлийн ресторан болохыг мэдэхгүй байх тохиолдолд нийт хүн амд хамааруулан хуваарилах боломжгүй юм.

Өөрийн рестораны хэрэгцээнд худалдан авдаг загасных нь төрлийн талаар асуухад оролцогчид нийт 37 төрлийн загас нэрлэсэн. Өрхийн судалгаанаас ялгаатай нь бүх оролцогчид худалдан авдаг загасны төрлийн нэрийг сайн мэддэг, “том загас” эсвэл “жижиг загас” гэх мэт хариулт огт өгөөгүй байв. Хэдийгээр энэхүү судалгаа нь бүхий л рестораныг хамарсан иж бүрэн судалгаа биш ч үүнээс ажигласан хандлага нь рестораны салбарт түгээмэл ашигладаг дөрвөн төрлийн загас (цагаан загас, хулд, туна) байгаа ба бусад төрөл нь ресторануудын 1-5% дээр ажиглагдсан.

Худалдан авалтын улирлын нөхцөл байдлын талаар хийсэн судалгааны дүн шинжилгээ нь орон нутгийн зах зээл дээр дөрвөн улирлын туршид загас зарагддаг, ресторанууд ч бүтэн жилийн туршид загас худалдан авах боломжтой байдгийг харууллаа. Зөвхөн шивэр хадран болон Алтайн сугас зэрэг загас л хавар олдохгүй байдаг ба шивэр хадран мөн намар ховорддог ажээ. Мөн ресторануудын худалдан авч буй хэлбэр нь тэр бүр хөлдөөсөн загас биш байгаагаас гадна борлуулалтын улирал нь агнуурын зөвшөөрөгдсөн улиралтай тэр бүр нийцэхгүй байна.

Эцэст нь ихэнх ханган нийлүүлэгчид нь бөөний худалдаачид (худалдан авалтын 67%) харин шууд загасчдаас худалдан авдаг хувь нь (15%) бага, жижиглэн худалдаачид багахан хувь (17%) нь байдаг ажээ.

Жишээ нь бариад, тавих ёстой тул загасны агнуурын улирал зун, намар байдаг ч бараг л бүхий л улирлын туршид зарагдаж байна. 2005 оны судалгаагаар зах, ресторануудад тул загас зарж буйг тогтоосон ч нарийн тоо гаргаж

чадаагүй. 2015 оны судалгаанд хамрагдсан ресторануудын 9% нь цэс дээрээ тул гэж тавьсан байв. Одоо ийнхүү хууль бусаар барих тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэж, 1-5 жил хүртэл хорих, эсвэл доод тал нь 4,500 ам долларын захиргааны торгууль ноогдуулдаг. 2005 оны тайланд дурдсанчлан тул загас 6-7 нас хүртлээ үржилд ордоггүй, 30 орчим жил насалдаг байна. Үүнээс үүдэн тул нь хэт их загасчлалд маш эмзэг зүйл юм.

Нийт хэмжээг сараар тооцон, жилд үржүүлэн үзвэл 337,000 ам.доллар болж байна. Энэхүү судалгаанаас гарсан мэдээллийг нийт улсын хэмжээний бүхий л ресторануудад тархаан тооцох боломжгүйн учир нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх рестораны нийт тоо эсвэл загасаар үйлчилж буй ресторануудын тоо байхгүйд оршино. Албан ёсны статистик мэдээлэл дээр тус салбарын 2015 оны нийт орлогын хэмжээг 205,5 тэрбум төгрөг буюу ойролцоогоор 90 сая ам.доллар хэмээн тооцоноос нийт орлогын 86%-ийг Улаанбаатар хотод төвлөрүүлснийг дурджээ. Энэ түвшний орлого нь загастай холбоотой бизнес судалгаагаар тогтоосноос хэд дахин илүү байж болохыг харуулж байна.

## Уламжлалт эмнэлэг

Монгол уламжлалт эмнэлгүүд болон эмч нарын хувьд үндсэндээ эмчилгээ хийхдээ ургамлын гаралтай бэлдмэл ашигладаг бөгөөд харьцуулан үзвэл амьтны гаралтай эм, бүтээгдэхүүн багахан хувийг эзэлж байна. Судалгаагаар хамгийн түгээмэл ашигладаг зургаан төрлийн амьтныг олж тогтоосон.

Баавгай. Хүрэн баавгайн тос, цөсийг үе мөчний өвчин, архаг өвчнүүд, үрэвсэлт өвчин, арьсны түлэгдэлт болон ходоодны өвчинд тустай хэмээн үздэг. Судалгаанд оролцогчид нь Монгол Улсаас гаралтай баавгайн тосыг үйлчлүүлэгчид илүүд үздэг гэж

хэлсний зэрэгцээ зах зээл дээр мөн ОХУ-аас оруулж ирсэн, арай хямд бүтээгдэхүүн байгааг дурдаж байсан.

Дорго. Доргоны тосыг арьсны түлэгдэлт, ходоодны шарх, бүдүүн гэдэсний шархлаа зэрэгт түгээмэл хэрэглэдэг болохыг дурдаж байсан.

Тарвага. Тарваганы тосыг ходоодны шарх болон үе мөчний өвчинд (артрит, ясны шохойжилт) хэрэглэдэг хэмээн хэлж байсан.

Үнэг. Уушгины өвчин эмчлэхэд үнэгний уушги ашигладаг хэмээн судалгаанд дурдаж байсан.

Чоно. Хоёр оролцогчийн хэлснээр чонын махыг урьдчилан сэргийлэх журмаар нийслэлчүүд хэрэглэхийн зэрэгцээ, ханиад, томуу эдгээхэд хэрэглэдэг байна.

Хүдэр. Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан оролцогчид нь хүдрийн заараар бэлтгэсэн бүтээгдэхүүнийг (төмсөг, сав) нийслэлд хэрэглэдэг хэмээсэн ч хэрэглээний хувьд түгээмэл бус байна. Эдгээр бүтээгдэхүүнийг төрөл бүрийн өвчнөөс сэргийлэх, дархлааны системийг сайжруулахад болон мэдрэлийн өвчин, саажилт, үрэвслийг эдгээхэд хэрэглэдэг ажээ.

## Жижиглэн худалдааны дэлгүүр

Жижиглэн худалдааны зах зээлийн судалгааг зэрлэг амьтан, тэдгээрийн эд эрхтэн худалдаалдаг 106 дэлгүүр хамгийн сайн зарагддаг зэрлэг амьтны худалдаанаас жил тутамд нийт дүнгээр 600,000 ам долларын орлого олдог болохыг судалгаанд дурдсан. Очиж судалгаа хийсэн дэлгүүрийн ихэнх нь олон төрлийн бүтээгдэхүүн зардаг, зарим тохиолдолд хэдэн зуун төрөл байна. Энэхүү судалгаанд зөвхөн Улаанбаатар болон 8 аймаг орсон. Зэрлэг амьтны худалдааны бодит үнэ цэн нь мэдээж хавьгүй илүү,

тооцсон дүнгээс хэд дахин өндөр байх магадлалтай.

### Дэлгүүрүүдэд зэрлэг амьтны бүтээгдэхүүн ихээр зарагдаж байна

Гутал, хувцас нь судалгааны үеэр олж тогтоосон хамгийн чухал бараа бүтээгдэхүүний ангилал юм. Нийт дэлгүүрийн тэн хагасаас илүү нь (54%) зэрлэг амьтны арьс, үсээр үйлдвэрлэсэн бэлэн хувцас хамгийн сайн борлуулалттай бараа хэмээн мэдээлсэн. Тэдний мэдээлсэн сарын борлуулалтын хэмжээнд үндэслэн тооцвол зах зээлийн энэхүү сегмент нь дангаараа бүх сегмент нийлээд төвлөрүүлж буй орлогын 83%-ийг бүрдүүлж байна. Бэлэн хувцасны төрөлд малгай, гутал, хүрэм зэрэг багтана. Бэлэн хувцасны үйлдвэрлэлд хамгийн түгээмэл ашигладаг зэрлэг амьтан нь чоно, булга, цаа буга болон дорго юм. Дэлгүүрүүдээр зарагдаж буй хоёр төрлийн (матрын арьсан гутал, могойн арьсан гутал) бүтээгдэхүүнээс бусад бүх бүтээгдэхүүнийг хийхэд ашиглаж буй зэрлэг амьтан нь Монгол Улсаас гаралтай. Ихэнх тохиолдолд дэлгүүрүүд ч тухайн зэрлэг амьтныг орон нутгаас эх үүсвэртэй болохыг баталж байсан. Зарим дэлгүүр нь Хятад, Орос Улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болох үнэг, булганы арьсан бүтээгдэхүүнийг нөөцлөн хадгалсан байв.

Хамгийн борлуулалт ихтэй дараагийн бараа нь үнэт эдлэл бөгөөд түүвэрт хамрагдсан дэлгүүрийн 40% нь энэхүү ангиллыг чухал үүрэгтэй болохыг баталсан. Нийт орлогод эзлэх хувь хэмжээний хувьд зах зээлийн бүх сегментийн бүрдүүлж буй орлогын 8%-ийг эзэлснээр хоёрдугаарт эрэмбэлэгдэж байна.

Бэлэн хувцаснаас ялгаатай нь дэлгүүрүүдийн мэдээлж буйгаар энэ ангиллын бүтээгдэхүүнд ашиглаж буй бүхий л зэрлэг амьтан, тэдгээрийн эд эрхтэн нь Монголоос гаралтай байна. Хийсэн ажиглалтын дарааллаар авч үзвэл тухайн амьтдын тоонд чоно (шагай, соёо), бүргэд, ёл шувууны сарвуу,

зэрлэг гахайн соёо, баавгайн соёо, идлэг шонхрын сарвуу зэрэг бүтээгдэхүүн үнэт эдлэлд ихээр ашиглагдаж байна.

Рестораны судалгааны хэсэгт дурдсанчлан жижиглэн худалдааны дэлгүүрүүдийн хувьд загас нь борлуулалтын өөр нэгэн чухал бүтээгдэхүүн хэдийнээ болжээ. Судалгаанд хамрагдсан дэлгүүрүүдийн гуравны нэгээс арай доогуур хувь нь (28%) загас борлуулж байна. Борлуулалтын үнэ доогуур ч энэ чиглэлийн худалдааны нийт орлого нь нийт борлуулалтын орлогын 2-оос илүү хувийг бүрдүүлж байна.

Дэлгүүрүүдийн хариултад дурдсан 13 төрлийн амьтнаас 8 нь Монгол Улсаас эх үүсвэртэй байна. Бүх бараа бүтээгдэхүүний дундаас хамгийн түгээмэл орон нутгийн гаралтай бүтээгдэхүүн нь зэвэг загас юм.

Зах зээлийн бусад сегментийн адил түгээмэл бус ч нийт дэлгүүрийн 16% нь уламжлалт эмчилгээний бүтээгдэхүүнийг борлуулалт ихтэй хэмээн мэдээлсэн. Судалгааны энэхүү хэсэгт уламжлалт эмнэлгүүдийн дунд хийсэн судалгаанд дурдсантай ижил амьтан, бүтээгдэхүүнийг тайлбарласан (жишээ нь баавгайн тос). Уламжлалт эмнэлгийн судалгаатай ижил тухайн төрөл зүйл, эх үүсвэр нь бүрэн тодорхой бус (зарим тохиолдолд зөвхөн “загас”, ‘шувуу’, ‘баавгай’ гэж хариулсан) байна. Нэр төрлөөр нь заасан амьтны хувьд халиун буга, Алтайн хойлог болон Халздай дорго орж байна.

Бэлэг, дурсгалын бүтээгдэхүүний хувьд нийт дэлгүүрийн борлуулалтын 13%-ийг бүрдүүлж буй энэ ангиллын бүтээгдэхүүн нь зах зээл дээр хамгийн сайн зарагддаг гэж үзэж байна. Гэвч Монгол Улсаас гаралтай 3-4 төрлийн бүтээгдэхүүний талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй тул нийт борлуулалтын хэмжээг тооцох боломжгүй байв.

Анхаарах нэг зүйл нь “Нэн ховор”, “Ховор” амьтны жагсаалтад

багтсан цоохор ирвэс, аргаль зэрэг амьтны бүтээгдэхүүнийг ил худалдаалж буй явдал юм.

## Ил захууд

### Зэрлэг амьтны худалдаа харагдахгүй болсон ч олдоцтой хэвээр байна

Ил захуудаар хийсэн ажиглалтаас үндсэн хоёр баримт тодорхой болсон. Нэгдүгээрт, хууль сахиулах байгууллагуудын зүгээс зэрлэг амьтны худалдаа эрхлэгчдэд тодорхой хэмжээнд шахалт үзүүлж, хар захаас шахан гаргаж буй ч бүрэн хэмжээнд хараахан гаргаагүй байна. Худалдаачид ч бараа, бүтээгдэхүүнээ ил ил байрлуулан санал болгохгүй, ихэнхдээ бага хэмжээний барааг ил тавьж, худалдан авагч сонирхох тохиолдолд цаанаасаа гаргаж ирэх эсвэл өөр газарт байгаа хэмээн зарах болжээ. Хэд хэдэн тохиолдолд худалдаачдын зүгээс сонирхож буй дүртэй судлаачдыг гэртээ очих эсвэл захтай ойрхон аль нэг газарт ирж сонирхож буй бараагаа бүтнээр нь үзэхийг урьж байсан тохиолдол гарсан. Үүнээс харвал нууцлагдмал байдлаар худалдаалах нь хэвийн зүйл болжээ. Нууцлалыг хангах нь тэдэнд хэвшил болсны зэрэгцээ бүтээгдэхүүнийг үзэж шалгах, зарах хүнийг хайж олох нь харьцангуй хялбар байсаар байна.

### Захиалгаар нийлүүлдэг худалдаа ердийн зүйл болжээ

Хоёрдугаарт, Монгол Улсад хийж буй зэрлэг амьтны хууль бус худалдаа нь “эрэлтэд суурилсан” (захиалгаар хийдэг) бизнесийн үйл ажиллагаа болжээ. Ажиглалт хийж явсан хүмүүсээс хэдий хэмжээний бүтээгдэхүүн худалдан авах хүсэлтэй буйг олон удаа асууж байв. Худалдаа хийж буй олон хүн чоно, үнэг, булга, тарвага зэргийг хүссэн хэмжээгээр нь олж өгөх боломжтой гэж байв. Нэг тохиолдолд судлаачид худалдаа эрхэлж буй хүнд утасны дугаараа өгч, улмаар Замын-Үүдэд байдаг

худалдаачинтай утсаар холбоо тогтоожээ. Тухайн худалдаачин хэлэхдээ ямар ч амьтны арьс, хэдий ч хэмжээгээр байсан бусдаар агнуулж нийлүүлэх боломжтой гэж байжээ. Энэ төрлийн эрэлтэд суурилсан худалдаа нь мөн Улаанбаатар хотын албан ёсны жижиглэн худалдааны дэлгүүрүүдэд бас байдгийг тогтоосон. Эдгээр тохиолдлууд нь зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээнд ихээхэн ойр очиж, Бүлэг 5 дээр дурдсан зэрлэг амьтны хууль бус худалдааны ерөнхий дүр зургийг гаргахад түлхэц болсон.

### Зэрлэг амьтны бүтээгдэхүүн, үнэ ханш

Боломжтой бүхий л тохиолдолд судлаачид борлуулж буй зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний үнийг асуун судалж явсан. Үүний үр дүнд бүтээгдэхүүний төрлийн хувьд ижил төстэй буйг харуулсан ч үнийн ялгаа ихээхэн буй нь үндсэндээ байршил, улирал, хэмжээ, чанар зэргээс шалтгаалж байна. Ялгаатай байдлын хувьд нууцаар үйл ажиллагаа явуулдаг албан бус эдийн засгийн нөхцөл байдалтай ижил, зах зээлтэй холбоо бага, бараа борлуулах, санал болгоход стандарт бага тогтсон байна. Энэ тохиолдолд тооцоо гаргах нь хүндрэлтэй ч гарсан үр дүн нь тодорхой тоо баримтыг харуулж байна.

Бүтэн амьтны худалдаа нь ил захууд дээр түгээмэл, үнийн хувьд чоно \$85, хойлог \$52, зээр \$28, тарвага \$17, хар сүүлт зээр \$11, дорго \$9, цагаан цээр \$6 байна. Мөн олон төрлийн загас худалдаалж буйгаас үнийн хувьд 1-6 ам.доллар байна. Захууд дээр тул загас зарж буй тохиолдол байгаагүй.

Хөхтөн амьтны махыг мөн кг-аар зардаг ба хамгийн үнэтэй нь зэрлэг гахайн мах 6 ам.доллар/кг, хамгийн хямд нь зээрийн мах 1 ам.доллар/кг байна.

5 амьтны үслэг эдлэлийг зарж буйг тогтоосны тоонд чонын арьс 300 ам.доллар, үнэгний арьс 100 ам.доллар, туулайн арьс 80 ам.доллар, булга 60 ам.доллар

харин тарваганы арьс хамгийн хямд буюу 3 ам.доллар байна.

Цусан эврийг бүтнээр нь эсвэл хэсэгчлэн борлуулж байна. Үүнээс үүдэн үнийн судалгаа бүрэн гараагүй байж болно. Цаа бугын эвэр хамгийн үнэтэй буюу ширхэг нь 90 доллар, дараа нь бөхөнгийн эвэр 75 доллар байна. Харин зээрийн эвэр хямд буюу ширхэг нь 10 доллар, бугын эвэр ширхэг нь 7 доллар байна.

## Цахим худалдаа

Монгол Улсад зэрлэг амьтны худалдаанд интернетээр хийх нь хэлбэрийн хувьд онлайнаар зараа тавьж, холбоо барих мэдээллийг байршуулан, улмаар борлуулж буй этгээдтэй холбогдон оффлайн худалдан авалт хийх боломж олгосон хэлбэртэй байна. Судалгааны баг зэрлэг амьтанд хамаатай 40 зар бүхий хоёр вэбсайтыг олж тогтоосон. Эдгээрийн нэг нь зарын хамгийн том сайт болох [www.unegui.mn](http://www.unegui.mn), нөгөө нь олон нийтийн сүлжээ болох Фейсбүүк байна.

Хамгийн олон тоогоор зар нь явж буй таван төрлийн амьтан нь тарвага, чоно, буга, баавгай болон дорго байна. Мөн эдгээр нь хамгийн ихээр сурталчлан борлуулдаг 5 амьтан болж байна. Өрхийн, зах зээлийн, хууль сахиулах байгууллагын гээд бүх төрлийн судалгаанд Монголын чоно нь хамгийн ихээр агнаж, худалдаалдаг амьтан болсныг харуулж байна. Онлайн зах зээл ч ялгаагүй ямар ч амьтныхаас илүүтэйгээр эдгээр амьтны эд эрхтнийг түлхүү сурталчлан борлуулж байна. Тарваганы хувьд 300 ширхэг тарваганы шагайг нэг удаагийн зараар борлуулахаар зарласан явдал ч байна.

Гэхдээ хамгийн үнэ цэнтэй бүтээгдэхүүн нь эдгээр амьтдын дунд ороогүй нь борцгор хотон шувууны хошуу буюу нэг бүрийг нь 3,5 сая төгрөгөөр (1,500 ам.доллар) зарахаар санал

болгож байна. Энэхүү шувуу нь нэн ховор төрөл зүйлд багтаж буй тул хориотой бүтээгдэхүүнд тооцогдож, онлайнаар худалдаалах нь хууль бус үйлдэл юм. Хамгийн сүүлд хийсэн хуулийн шинэчлэлээр зэрлэг амьтны бүтээгдэхүүн сурталчлахад илүү өндөр торгууль ноогдуулах ба хэрэв нэн ховор амьтан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.

нутгийн зах зээл дээр борлуулах, трофи агнуурын олзыг экспортлох CITES-ын зөвшөөрөл авах зэрэг үйлчилгээг мөн үзүүлж байна.

## Трофи ан агнуур

Трофи ан агнуурын тухай мэдээлэл цуглуулах нь энэхүү судалгаанд нэгтгэхэд шаардлагатай бусад мэдээлэл цуглуулахаас хамгийн их хүндрэл, сорилт бүхий мэдээлэл байв. Хоёр компани л судалгаанд оролцож, мэдээлэл хуваалцсан ч тэдний гаргаж өгсөн мэдээлэл нь ямар нэгэн байдлаар тооцоолол хийх, гарсан үр дүнг улсын хэмжээнд тархаан тооцох боломжгүй байсан. Тиймээс гарсан үр дүнг зөвхөн анхдагч байдлаар ерөнхий ойлголт өгөх зорилгоор харуулсан.

Эдний нэг нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Хөвсгөл аймагт загасчлалын аялал зохион байгуулдаг. Тус компанийн мэдээлснээр 2015 онд АНУ, Их Британи, ОХУ, Япон болон Францаас 40 орчим загасчин хүлээн авч, нийт 12 тул, 250 шивэр хадран, 250 зэвэг загас барьжээ. Компани нь гадаадын загасчдын зөвшөөрлийг хариуцдаг

Хоёр дахь компани нь Баян-Өлгий аймагт үйл ажиллагаа явуулдаг, том хэмжээний хөхтөн амьтны ан зохион байгуулдаг компани байсан. Тус компани нь Испани хэлтэй улсуудын (Испани, Латин Америк) зочдыг хүлээн авч, аргаль, янгир, буга агнуулах үйлчилгээ эрхэлж байна. 2015 онд тэдний хүлээн авсан 6 анчин 6 аргаль, 2 халиун буга агнаж, янгир агнаж чадаагүй ажээ. Тус компани нь галт зэвсэг болон ангийн зөвшөөрөл авч өгөх (квотын дагуу), чихмэл хийх, үлдсэн эд эрхтнийг орон



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:

# ТАНИЛЦУУЛГА

# Нөхцөл байдал

2005 оны үед зэрлэг амьтны хууль бус худалдаа нь аль хэдийн дэлхий нийтийг хамарсан ноцтой асуудал болоод байсан ч олон нийтийн анхааралд төдийлөн өртөөгүй, зөвхөн мэргэжилтнүүдийн хүрээнд яригддаг сэдэв байв. Дэлхийн олон хэвлэлд энэ сэдвийн талаар хөндсөн өгүүлүүд гарч байсан ч нэр хүндтэй томоохон сонинуудын тэргүүн нүүрэнд гардаг, байнгын сэдэв<sup>9</sup> нь хараахан болоогүй байсан. 2017 оноос л дэлхий нийтийн сонорт хүрч нөлөө бүхий сэдэв болж эхэлсэн байдаг. Томоохон сонинуудын үндсэн нүүрт зэрлэг амьтны худалдааны тухай нийтлэлүүд гарах болсноор шинжлэх ухааны жижиг буланд үлдэхээ больж, онлайн гардаг нилээд олон сонинууд зэрлэг амьтны хууль бус худалдааг мөшгөн, эрэн сурвалжлах чиглэлд иж бүрнээр ажиллаж эхэлжээ.<sup>10</sup> Улс орны Засгийн газрууд ч энэхүү хяналтаас гадуурх хууль бус худалдаа нь тухайн орны нөөц, эдийн засаг, соёл, тэр ч байтугай аюулгүй байдалд нөлөөлж буйг анзаарч, мэдэрдэг болсон байна. Олон оронд тухайн асуудлыг хариуцсан байгууллага, тусгайлан мөрдөн байцаах алба байгуулах, зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх зорилго бүхий хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх болжээ.<sup>11</sup> Үүний нэг

9 Жишээ нь Нью-Йорк Таймс сонин Бизнесийн өдөр болон бусад булангууддаа хэд хэдэн өгүүлэл нийтэлсэн: (Ron Nixon and Coral Davenport. 2015 оны 10 сарын 5. "Environmentalists Praise Wildlife Measures in Trans-Pacific Wildlife Pact"); Дэлхийн мэдээ: (Ron Nixon. 2015 оны 12 сарын 22. "U.S. Pours Millions into Fighting Poachers in South Africa" болон Bettina Wassener. 2013 оны 3 сарын 12. "No Species is Safe from Burgeoning Wildlife Trade"); болон Үзэл бодол булан (Tristan McConnell. 2015 оны 10 сарын 29. "The Ivory-Funded Terrorism Myth"). [www.nytimes.com](http://www.nytimes.com) хаягаар үзэж болно. Үүний нэгэн адил Уолл Стрит Журнал мөн Дэлхийн мэдээ буландаа Хятад дахь зэрлэг амьтны худалдааны талаарх өгүүллийг нийтэлсэн: Chun Han Wong. 2016 оны 12 сарын 31. "China to Shut Down Ivory Trade by End of 2017." [www.wsj.com](http://www.wsj.com) хаягаар үзэж болно.

10 [www.wildlifetracker.org](http://www.wildlifetracker.org), [healthmap.org/wildlifetrade/](http://healthmap.org/wildlifetrade/) болон [poachtracker.oxpeckers.org](http://poachtracker.oxpeckers.org) зэрэг хэд хэдэн жишээ байж болно.

11 Үүний жишээнд Кени улсын Зэрлэг амьтны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 1989 онд Кени улсын зэрлэг амьтан хариуцсан газрыг (KWS) байгуулсан. (UN Chronicle Vol. LI No. 2 2014, <https://unchronicle.un.org/article/fighting-wildlife-trade-kenya> хаягаар үзнэ үү); Түгээмэл арилжаалдаг зэрлэг амьтны төрөл зүйлсийг таньж мэдэх чиглэлээр Тайланд улс нисэх буудлын ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлжээ (Voice of America. 2009 оны 11 сарын 2. "Thailand calls for Wildlife Trade Enforcement." <http://www.voanews.com/a/a-13-2009-03-09-voa34-68635822/407764.html> хаягаар үзнэ үү; мөн 2014 онд Зэрлэг амьтны худалдаатай тэмцэх үндэсний стратегия боловсруулан гаргасан АНУ нь холбооны 17 агентлагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулан ажиллуулж байгааг <https://www.state.gov/e/oes/ecw/wlt/> хаягаар үзнэ үү. НВУ-ын Байгаль орчин, хүнс болон хөдөө орон нутгийн харилцааны яам нь дэлхий даяарх практик төслүүдэд санхүүжилт олгох замаар дэлхийн хэмжээнд явагдаж буй зэрлэг амьтны худалдааг бууруулах зорилго бүхий Хууль бус зэрлэг амьтны худалдааны сорилтын санг (Illegal Wildlife

нотолгоо нь CITES-ын 2016 оны хуралд урд өмнөхөөс илүү олон гишүүн орнууд оролцсон явдал бөгөөд энэ нь тухайн асуудлаар мэдлэг, ойлголт өсөн нэмэгдэж буйтай салшгүй холбоотой юм. Бүс нутгийн болон олон улсын хэмжээнд хүний нөөцийн ба шүүхийн шинжилгээний чадавхийг нэмэгдүүлэх, хил дамжсан мэдээлэл солилцоо, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх санал санаачлагууд гарсаар байна.<sup>12</sup> Эдгээр улсуудын олонх нь хууль бус худалдааг ноцтой гэмт хэрэг хэмээн зүйлчилж, үүнийг хэрэгжүүлэх өөрийн боломж бололцоог сайжруулах эрх зүйн механизмуудыг батлан хэрэгжүүлж байна.<sup>13</sup>

Ийнхүү зэрлэг амьтны хууль бус худалдаанд анхаарал нэмэгдэж байгаа нь асуудал улам гүнзгийрч байгааг харуулж байна. Зарим тохиолдолд худалдааны хэт хөөрөгдсөн спекуляци зэрэг эдийн засгийн явуургүй түр өсөлтөөс шалтгаалан зэрлэг амьтдын хууль бус худалдаа улам ихэссээр байна.<sup>14</sup> Гэхдээ л энэхүү зүйлд шинэ асуудал хэмээх шошго наахдаа болгоомжтой хандах шаардлагатай юм. 2001 онд хийсэн тооцоогоор зэрлэг амьтны хууль бус худалдаа нь мансууруулах бодисын наймааны дараа эрэмбэлэгдэж жилийн эргэлт нь 5 тэрбум ам.долларын хэмжээнд хүрснийг тогтоосон.<sup>15</sup> 2016 онд өөр нэгэн эх үүсвэрийн тооцооноор зэрлэг амьтны хууль бус худалдаа дэлхийн хэмжээнд 4 дэх том хууль бус худалдаагаар эрэмбэлэгдсэн (мансууруулах бодис, хуурамч мөнгөн дэвсгэрт болон хүн худалдаалах гэмт хэргийн дараа)<sup>16</sup> ба энэ нь зэрлэг амьтдын хууль бус худалдаа буурсны улмаас бус харин хууль бус худалдааны бусад хэлбэр илүү өсөн нэмэгдэж, нарийн судалгаатай хийгдэх болсноос үүдэлтэй. Өнөөдөр зэрлэг амьтдын хууль бус худалдааны хэмжээ нь эх сурвалж болон ашигласан үнэлгээний аргачлалаас хамааран жилийн 15 тэрбум ам.доллараас 150 тэрбум доллараар хэмжигдэх болжээ.<sup>17</sup>

Trade Challenge Fund) байгуулжээ.

12 АСЕАН-ны зэрлэг амьтны үйл ажиллагааны сүлжээ (ASEANWEN) болон илүү зорилтот Ирвэс, зэрлэг амьтны үйл ажиллагааны сүлжээ SLAWEN) нь үүний хоёр жишээ болно.

13 Жишээ нь Кени улс Зэрлэг амьтан хамгаалах болон удирдлагын тухай бие даасан хуулийг батлан зэрлэг ан амьтны худалдаанд хуулийн зорилгыг төвлөрүүлсэн.

14 Conniff, R. (2016) Chinese Investors Are Driving the Slaughter of Rhinos, TakePart. <http://www.takepart.com/article/2016/08/26/chinese-investors-are-driving-slaughter-rhinos> хаягаар үзнэ үү.

15 Jagodinski G. 2001. "Region 3 News. e Federal Wildlife Officer." Federal Wildlife Officers Association, Inc. 15 (1) (Winter).

16 НҮББОХ- Интерполын тайлан/UNEP-INTERPOL Report: Value of Environmental Crime Up 26%. 2016 оны 6 сар.

17 Жишээ нь НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Жилийн товхимол 2014 (Emerging Issues Update: Illegal Trade in Wildlife. <http://www.unep.org/yearbook/2014/PDF/chapt4.pdf>) нь зэрлэг амьтны хууль бус худалдааны жилийн орлого нь 50-150 тэрбум ам доллар хүрдэг хэмээн тооцсон [http://www.unep.org/documents/itw/ITW\\_fact\\_sheet.pdf](http://www.unep.org/documents/itw/ITW_fact_sheet.pdf) хаягаар үзнэ үү. TRAFFIC байгууллага нь энэхүү худалдааг US\$24.8-40 тэрбум хэмээн тооцсон: (<http://www.traffic.org/trade/> хаягаар үзнэ үү).

Эдгээр тоон мэдээлэл нь үндсэндээ тойм тооцоо төдий юм. Нарийвчилсан тоон мэдээллийг хууль ёсны худалдаан дээр гаргах нь ихээхэн хүндрэлтэй байдаг бол зэрлэг амьтдын худалдаа зэрэг хууль бус үйл ажиллагааны хувьд бүр ч илүү хэцүү байх нь ойлгомжтой. Гэхдээ тооны ард буй бодит байдал нь хууль бус худалдаа 15 жилийн өмнөхөөс улам муудаад зогсохгүй үүнийг илрүүлж чадахгүй байгаа нь ноцтой асуудал юм. Бодит үнэнийг олж мэдэхэд ихээхэн хол байгаа хэдий ч дэлхийн болон улс орны хэмжээнд явагдаж буй зэрлэг амьтны хууль бус худалдааны үзүүрээс барьж аваад байгаа билээ. Заан, хирс гэх мэт бэлгэдэл болсон зүйлийн хууль бус худалдаанд илүү их анхаарч байгаа хэдий ч зэрлэг амьтдаас хүртэхийг хүссэн хүний барагдашгүй шуналаас болж устан алга болохын ирмэг дээр буй зүйлүүдийг илрүүлэн судалсаар байна. Жишээ нь Кени улсад шар шувууны нэг өндгийг 3,800 ам.доллараар буюу 1 грамм нь 89 ам.доллараар (89\$/грамм) худалдаалж байгаа нь хирсний эврээс 2 дахин (35\$/грамм)<sup>18</sup>, зааны соёноос 80 дахин (1.10\$/грамм)<sup>19</sup> өндөр үнэтэй байна. Ийм үнээр борлуулж буй тохиолдолд Кенийн шар шувуу сүйрлийн ирмэгээс зайлсхийх бараг боломжгүй юм. Эдгээр үнийг мэдээлсэн судалгаанд дурдсанаар Кенийн шар шувууны популяци нь сүүлийн хоёр жилийн хугацаанд ганц ч үр төлөөр нэмэгдээгүй ажээ.<sup>20</sup> Хууль бус худалдаанд өртдөг хэдий ч энэ тухай мэдээлэл багатай байгаа зүйлүүдийн жагсаалт маш урт бөгөөд бүрэн жагсаалт гараагүй байна.

Энэ бүхнээс бидэнд тодорхой буй зүйл бол хэрхэн хэмжиж, тоолсноос үл хамааран хууль бус худалдааны хямрал нүүр тулаад ирсэн нь гарцаагүй. Зэрлэг амьтны худалдаанд өртөж буй зүйлүүд өөрсдийн тархац нутгаас хэдийн шахагдаж, зарим зүйл устах босгон дээр ирээд байна.<sup>21</sup> Жишээ нь Хятадын Гуандонг муж дахь хуягт гүрвэлийн (rangoline) тоо толгой 2000 оноос хойш 90%-иар буурсны зэрэгцээ бусад гурван мужид (Хайнан, Хена, Жиангсу) үндсэндээ устаад байна.<sup>22</sup>

Энэ хямралын шалтгаан, үр нөлөө ноцтой хэмжээнд хүрчээ. “Зэлүүд тал”-ын анхдугаар тайланд дурдсанаар зэрлэг амьтны тоо толгой хурдтай буурч, устан үгүй болох нь махчин, өрсөлдөгч болон симбиоз холбоо үүсгэдэг (экологийн нягт харилцан хамаарал бүхий зүйлүүд, жишээ нь тарваганы нүхийг орон байр болгон

ашигладаг зүйлүүд) зүйлүүдэд ихээхэн нөлөөлөөд зогсохгүй ургамалжилтыг өөрчилж байна. Бусад улсын адилаар Монгол Улсад хууль бус худалдаанд өртдөг зэрлэг амьтдын экологийн үүргийг судалсан судалгаа маш цөөн байна.

Хэдий олон жилийн өмнөөс тодорхой болчих байсан ч өнөөгийн зэрлэг амьтны хууль бус худалдаа нь:

- o Хүн амын тоо нэмэгдэж, зэрлэг амьтны бүтээгдэхүүний эмчилгээний чанар, эдгээрээс үүдэн бий болох нийгмийн статусын төлөөх олон сая хэрэглэгчийн тогтвортой бус хэрэглээнээс үүдэн идэвхжиж;
- o Биологийн зүйлийн тоо буурах тусам эдгээрийн үнэ өссөнөөр үлдсэн цөөн амьтны араас ангуучлахад хөрөнгө цутгаж, уйгагүй элдэн хөөж буйгаас үүдэн;<sup>23</sup>
- o Өмнө нь олж авах боломжгүй байсан ховор бүтээгдэхүүний өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангагч мэргэжлийн, хэлхээ холбоо бүхий, дасан зохицох чадвартай гэмт хэргийн бүлэглэлийн хяналтад захирагдаж;<sup>24</sup>
- o Хянахад хүндрэлтэй, өргөн тархсан авлигын улмаас;<sup>25</sup>
- o Хулгайн анчид болон худалдан авагчдыг холбох жимийг богиносгон, энэ худалдааг дэлхийн хэмжээнд түгээгч ложистик болон харилцаа холбооны тэргүүлэх технологийн хүчээр;<sup>26</sup>
- o Зэрлэг амьтны худалдаагаар санхүүгээ тэтгэгч зэвсэгт бүлгүүд, мөргөлдөөний улмаас,
- o өнөөгийн нөхцөлд хүрээд буйг үгүйсгэх боломжгүй юм.

18 Odaga, D. (2016) Where an Owl Egg Is Worth More Than Ivory or Rhino Horn, *Explorers Journal*, 2016 оны 10 сарын 4, 2016 – 2015 оны 11 сарын байдлаарх Хятад дахь зааны соёоны үнийг баримталсан. Хирсний эврийн үнийг 2016 оны 9 сарын байдлаарх Вьетнамын зах зээлийн үнээр тооцсон.

19 Мөн тэнд. Хятад дахь 2015 оны 11 дүгээр сарын зааны соёоны үнэ.

20 Мөн тэнд.

21 Олон улсын байгаль хамгаалах холбоо (IUCN) нь нийт 5,157 төрөл зүйлсийг устах аюулд орсон төрөл зүйлсийг жагсаалтад оруулсан. IUCN Улаан данс. Хувилбар 2017-1. <[www.iucnredlist.org](http://www.iucnredlist.org)>. 2017 оны 5 дугаар сарын 23-ны өдөр татан авсан.

22 Block, B. (2017) Illegal Pangolin Trade Threatens Rare Species. WorldWatch Institute, Eye on Earth online news service.

23 Энэхүү үзэл баримтлалын талаар Африк дахь зааны соёоны худалдаанд хамаарах Бруукинге дээр гарсан блогын нийтлэлтэй холбоотой дурдсан: Kimenyi, Mwangi S. 2015 оны 3 сарын 6. “The Dilemma of Destroying Ivory as an Anti-Poaching Strategy.” Хууль сахиулах байгууллагууд хураан авсан зааны соёог шууд устгаж буйгаас үүдэн зааны соёо ховордож, үүний улмаас зах зээлийн үнэ нэмэгдэж буй нь хууль бус ан агнуур нэмэгдэхэд хүргэж байна. Энэ асуудлыг мөн: Plumer, Brad. 2013 оны 11 сарын 6. *Washington Post*. Wonkblog. “The Grisly Economics of Elephant Poaching” дээр мөн хэлэлцсэн.

24 Steyn, Paul. 2015 оны 5 сарын 26. *National Geographic*. “As Animal Poaching Surges, Organized Crime Plays Bigger Role.” [news.nationalgeographic.com](http://news.nationalgeographic.com) хаягаар үзнэ үү.

25 UNODC. 2016. *World Wildlife Crime Report: Trafficking in Protected Species*. United Nations, New York. Мөн жишээ болгон Fernquest, Jon. 2013 оны 3 сарын 5. *Bangkok Post*. “Rhino Horn Smuggling: Caught on Suvarnabhumi Video хэмээх нийтлэлийг үзнэ үү. <http://www.bangkokpost.com/learning/learning-news/338953/rhino-horn-smuggling-caught-on-suvarnabhumi-video> хаягаар үзнэ үү.

26 Интернет нь олон улсын хэмжээнд зэрлэг амьтны хууль бус худалдааны гол зах зээл болж буй бөгөөд үүнийг зохицуулахад ихээхэн хүндрэлтэй байна. Hastie, Jo and Tania McCrea-Steele. 2014. “Wanted- Dead or Alive: Exposing Online Wildlife Trade.” International Fund for Animal Welfare. [ifaw.org](http://ifaw.org) хаягаар үзнэ үү.

“Зэлүүд тал” анхдугаар тайлан нь Монгол Улс энэхүү хямралд мөн өртөөд байгаа болохыг харуулсан. Зэрлэг амьтны хууль бус худалдаа хэдийн соёлын болон ёс зүйн хэм хэмжээнээс хальж зарим зүйлийг жилд хэдэн мянгаар нь, бүр хэдэн саяар нь арилжаалдаг асар том бизнес болон өргөжжээ.<sup>27</sup> Худалдаа нь зөвхөн улирлын болон орон нутгийн хүрээнээс илүү тогтвортой, мэргэжлийн, олон улсыг хамарсан хэлбэрт шилжжээ. Худалдааны нийт орлогын хэмжээ олон арван сая доллараар хэмжигдэж байгаа ч энэхүү тооцоо нь мөн бодит байдлаас хавьгүй доогуур тооцсон дүн юм. Нөхцөл байдал хэзээ ч бүрэн тодрохгүй хэдий ч энэ худалдааны дийлэнх нь Хятадын өмнөд хэсэг рүү шууд хэрэгцээнд (жишээ нь чоно) эсвэл боловсруулалт хийж, дараагийн зах зээлд борлуулах (үслэг эдлэл хийх зорилгоор тарвага) зорилгод чиглэж байгааг бүхий л үзүүлэлт харуулж байна. Зохион байгуулалттай гэмт хэрэг нь тооцооны нэг хэсэг хэдий ч харьцангуй нууц хэвээр байсаар байна. Монгол Улсаас Хятад улсруу хийж буй зэрлэг амьтны худалдааны тухай танилцуулга тайлан 2005 онд гарсан ба энэ тайлан нь олны анхаарлыг ихээхэн татаж гайхшралыг төрүүлсэн. Зохион байгуулалттай гэмт хэрэгт оролцогч хувь хүмүүсийг судалгаанд татан оролцуулсны үр дүнд энэхүү тайлан гарчээ. Товчхондоо, Монгол Улс нь бараа бүтээгдэхүүнээ хүмүүсийн бодож байснаас илүү хурднаар шавхаж буй дэлхийн дэлгүүрийн нэг нийлүүлэгч аль хэдийн болжээ.

Эдгээр нь 2016 онд судалгааны нөхцөл байдал өөр байсан, 2005 онд учирч байсан хүндрэлээс илүү төвөгтэй нөхцөл бий болсныг харуулж байна. Одоогоос 10 жилийн өмнө судалгааны баг зөвхөн таамаг төдий, үндсэндээ орон нутгийн чанартай, тэр ч байтугай хор хөнөөл багатай худалдааг судалж байжээ. Хууль тогтоомжийн хэрэгжилт тааруу, худалдаа арилжааг ч ил хийж байжээ. Аюулгүй байдлын талаар болон ярилцлагад хамрагдагсад санаатайгаар мэдээллээ нуун дарагдуулах вий гэх мэт санаа зовох зүйлгүйгээр анчид, худалдаачидтай ярилцаж, зураг авч, ажигласан зүйлсээ ил тодоор зураглах зэрэг боломжтой байжээ. Харин 2016 онд судалгааны баг нь Монгол Улсад явагдаж байгаа зэрлэг амьтны хууль бус худалдааг олон улсын хэмжээний худалдаатай ижил хэмжээнд үзэж, өнгөрөгч жилүүдэд хуулийн хэрэгжилт сайжирч, энэ худалдаанд оролцогчдын хариуцлагын тухай мэдлэг нэмэгдсэнээр зах, худалдааны төв байтугай өрхийн түвшинд мэдээлэл олж авахад хүндрэлтэй байх болно гэсэн төсөөлөлтэй ажлаа эхэлсэн.

Тиймээс энэхүү судалгаанд өмнөх судалгаанд шаардлагагүй гэж тооцож байсан аргачлалуудыг ашигласан ба үүний нэг нь Үл ижилсүүлэх тооллогын аргачлал (unmatched count technique- UCT) (Хоёрдугаар бүлэг Аргачлал хэсэгт тайлбарласан). Үл ижилсүүлэх тооллогын аргачлал судалгаанд оролцогчдын асуултад үнэн хариулахад нөлөөлөх зорилго бүхий эмзэг/эсвэл буруутгасан шинжтэй асуултаас бүрдсэн тусгайлсан асуулгын аргачлал юм. Судалгаанд мөн ажигласан

27 Wingard and Zahler, (2006).

зүйлийг газар дээр нь тэмдэглэх, шууд асуух зэрэг аргуудыг хасаж оронд нь гол мэдээлэгч нартай хийх ярилцлагыг тухайн орон нутагт нь хийхгүй байх зэрэг энгийн аргуудыг ашигласан. Эдгээр болон бусад арга зүйн өөрчлөлтийг хоёрдугаар бүлэг дээр дэлгэрэнгүй тайлбарлаж, судалгааны аргачлал нь үр дүнгийн шинжилгээний нэгэн адил судалгааны чухал бүрэлдэхүүн хэсэг болсныг харуулсан.

2005 онд хийсэн анхны тайлангаас хойш Монгол Улсад зэрлэг амьтны чиглэлээр нилээд олон судалгаа хийсэн нь эерэг тал болохын зэрэгцээ энэхүү судалгааг хийхэд чухал ач холбогдолтой байсан. Эдгээр судалгаа нь 2016 оны судалгааны арга зүйг сайжруулахад чухал үүрэгтэй байсан. Эдгээрт дараах судалгаанууд багтаж буй юм:

- Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг 2007-2008 онуудад Дэлхийн банкинд зориулан Улаанбаатар хотын түүхий эд, хүнсний захууд дээр худалдаалж буй зүйлүүд болон хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлох судалгаа;<sup>28</sup>
- Хамгааллын зорилгоор говийн бүсийн чонын үхэл хорогдлыг тогтоох томоохон судалгааны хүрээнд хийсэн зах зээлийн судалгааны багийн тайлан
- Худалдааны захууд дээр зэрлэг амьтны хууль бус худалдааг хариуцсан агентлагууд хамтран эргүүл хийх бэлтгэл ажлын хүрээнд Улаанбаатар хотын захууд дээр 2008 оны 12 дугаар сараас 2009 оны дүгээр сарын хооронд оюутнуудын гүйцэтгэсэн ажиглалт судалгаа;<sup>29</sup>
- БОАЖЯ, ДБХС-тай хамтран хэрэгжүүлж буй байгаль хамгаалах хөтөлбөрийн хүрээнд 2009 оны 10 дугаар сард уулархаг болон тал нутгийн туурайтан амьтны популяцийн үндэсний хэмжээний судалгаа;<sup>30</sup>
- БОАЖЯ, ШУА-ийн Биологийн хүрээлэнтэй хамтран хийсэн идлэг шонхорын тоо толгойг тогтоох үндэсний хэмжээний судалгаа (CITES конвенцийн хэрэгжилтийг хангаж тогтвортой ашиглах түвшинг тогтоох);<sup>31</sup>
- TRAFFIC байгууллагын 2016 онд хэвлүүлсэн

28 Parkinson, Andrew M., Odonchimeg Nyamtseren, Tuvshinjargal D., Amanda Fine. 2008 оны 8 дугаар сар. “World Bank FLEG Ulaanbaatar Wildlife Trade Survey: Wildlife Conservation Society Report.” Wildlife Conservation Society үзнэ үү.

29 Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг (WCS). 2009 оны 3 сарын 31. “Protecting Mongolia’s Wildlife through Wildlife Trade Law Enforcement” үзнэ үү.

30 “Монгол Улсын туурайтан амьтны судалгааг бэлтгэх болон хэрэгжүүлэх шатанд Монгол дахь Дэлхийн банкны төлөөлөгчийн газарт хүргүүлсэн баримт бичгүүд, NEMO II төслөөс санхүүжүүлсэн.” documents.worldbank.org хаягаар үзнэ үү.

31 CITES конвенцийг үзнэ үү. “Programme for the Conservation and Sustainable Use of *Falco Cherrug* in Mongolia.” Зэрлэг амьтны хорооны 25 дугаар уулзалт. Женев, Швейцар. 2011 оны 7 сарын 18-22. cites.org хаягаар үзнэ үү.

Монгол гэх мэт улсуудыг багтаасан цоохор ирвэсийн зах зээл дээрх худалдааны тухай тайлан<sup>32</sup> болно.

## Агшны судалгаа

Асуулгыг зэрлэг амьтны нөөцийн мониторингоос гадна тэдгээрийн хууль бус худалдааг илрүүлэх судалгаанд ч ихээхэн ашигласаар байна. Өнгөрөгч 10 гаруй жилийн туршид төрөл бүрийн судалгааг олон тооны байгууллага хийж, амьд амьтны худалдаанаас эхлээд гэрийн тэжээмэл амьтад (шувуу,<sup>33</sup> хэвлээр явагч,<sup>34</sup> халуун орны загас<sup>35</sup>), эмчилгээний зориулалтаар борлуулагддаг зэрлэг амьтны бүтээгдэхүүн (хирсийн эвэр,<sup>36</sup> барын яс<sup>37</sup>), урагийн үнэ бүхий зүйлс (зааны соёо,<sup>38</sup> улаан соёо<sup>39</sup>) болон хүнсний хэрэглээнд борлуулагдаж буй зэрлэг амьтны бүтээгдэхүүн (хуягт гүрвэл, яст мэлхий)<sup>40</sup> зэрэг өргөн хүрээг хамруулсан байна. Энэхүү шинээр цугларч буй багц мэдээлэл, тэдгээрт хийсэн дүн шинжилгээ нь зөвхөн гарч буй өөрчлөлтийг баримтжуулахаасаа худалдааны энэхүү хямралт байдлын тод томруун зураглалыг гаргаж, дэлхий нийтийн хэмжээнд энэ сэдвийн тухай мэдлэгийг нэмэгдүүлж, зэрлэг амьтны хууль бус худалдааны

асуудлыг дэлхийн удирдагчдын анхааралд хүргэх болжээ. Жишээ нь Зэрлэг ан амьтны төлөө нэгдэхүй эвсэл (United for Wildlife) нь зэрлэг амьтны чиглэлээр ажилладаг дэлхийн тэргүүлэх буяны байгууллагуудыг нэгтгэдэг бөгөөд тус эвслийг Хатан Хааны сан болон Кембрижийн гүн, гүнгийн ахайтан, ханхүү Харри нар байгуулжээ. Эдгээр байгууллагуудыг олон улсад төлөөлж буй элчээр спортын алдартнууд, жишээ нь теннисчин Энди Мюррей, дугуйчин Крис Фруум нар ажиллах болжээ.

Гэхдээ энэ удаагийнх шиг өргөн хүрээнд хийсэн зэрлэг амьтны худалдааны агшны судалгаа үндсэндээ маш ховор байна. Үүний гол шалтгаан нь тухайн судалгааг хийж гүйцэтгэхэд ихээхэн цаг хугацаа шаарддаг оршино. Эдгээр төрлийн судалгаа нь нэг ижил ажиглалтыг удаан хугацааны туршид ихэвчлэн олон арван жилээр үргэлжлүүлэх замаар гарч буй өөрчлөлтийг тогтоох, хэв маягийг ойлгох зорилгоор давтан хийхээр төлөвлөгддөг. Тиймээс энэхүү урт хугацаанд үргэлжлэн хийх судалгаанд шаардлагатай нөөц эх үүсвэрийг баталгаажуулж, судалгааны хугацааны туршид хуваарилж байх хэрэгцээ нь санхүүжилтийн богино мөчлөг, санхүүгийн хязгаарлагдмал чадавх, улс төрийн байнгын өөрчлөлтөөс үүдэн хязгаарлагдмал байдаг. Өөр нэгэн томоохон сорилт нь ижил үзүүлэлт бүхий бүлэг/хувь хүмүүсээс ижил мэдээллийг, ижил арга замаар хийх урьдчилан тогтоосон арга зүй нь өөрөө юм.

- 32 Nowell, Kristin, Juan Li, Mikhail Paltsyn, and Rishi Kumar Sharma. 2016 оны 10 сар. "An Ounce of Prevention: Snow Leopard Crime Revisited." TRAFFIC.
- 33 Chow, A., S. Cheung, and P. Yip. *Human-Wildlife Interactions* 8(1). Spring 2014. "Wildlife Markets in South China." 108-112. [berghainstitute.org](http://berghainstitute.org) хаягаар үзнэ үү
- 34 Мөн тэнд үзнэ үү.
- 35 Дараах өгүүлэл нь Коста Рика улсад өрхүүдийн дунд хийгдсэн зэрлэг амьтны худалдаа, гэрээр тэжээн өсгөж буй тохиолдлын тухай судалгааны үр дүнг тусгасан: Drews, Carlos. *Society and Animals* 9:2. 2001. Wild Animals and Other Pets Kept in Costa Rican Households: Incidence, Species, and Numbers. Koninklijke Brill NV, Leiden, 2001.
- 36 Энэхүү судалгаа нь 2012 онд Хятад улсад хийгдсэн хирсний эврийн хэрэглээ, энэ талаарх мэдлэгийн тухай судалгааны талаар бичигдсэн: Vallianos, Christina. 2014. "Rhino Horn Demand." WildAid. [www.wildaid.org](http://www.wildaid.org) хаягаар үзнэ үү. TRAFFIC байгууллага нь барны яс болон эврийн худалдааны талаар өмнө нь Хятад улсад судалгаа хийжээ: TRAFFIC. 1997 оны 5 сар. "Rhinoceros Horn and Tiger Bone in China: An Investigation of Trade Since the 1993 Ban."
- 37 TRAFFIC. 1997 оны 5 сар. "Rhinoceros Horn and Tiger Bone in China: An Investigation of Trade Since the 1993 Ban."
- 38 Vallianos, Christina. "Ivory Demand in China 2012-2014." WildAid. [awf.org](http://awf.org) хаягаар үзнэ үү. Мөн: TRAFFIC. 214 оны 7 сарын 3. "Market Survey Finds Disturbing Increase in Thai Ivory Market." [traffic.org](http://traffic.org) хаягаар үзнэ үү.
- 39 Jenkins, Anna, Neil Bridgland, Rachel Hembery, Ulrich Malessa, James Hewitt, and Chen Hin Keong. Chatham House Workshop: Tackling the Trade in Illegal Precious Woods. 2012 оны 4 сарын 23-24. Background Paper 1: "Precious Woods: Exploitation of the Finest Timber." TRAFFIC. Accessed via [illegal-logging.info](http://illegal-logging.info). (Энэхүү өгүүлэлд улаан ясан модыг "ягаан" гэж нэрийдсэн бөгөөд энэ нь утгын хувьд ижил зүйлсийг зааж буй болно.)
- 40 Chow, et al. 2014.

Зэрлэг амьтны хууль бус худалдааны практик бодит байдал нь ямар ч төрлийн судалгааг хийж гүйцэтгэхэд хүндрэлтэй болгодог. Зарим тохиолдолд худалдааны нууцлагдмал хэв шинж нь судалгааг зөвхөн явган ярианы хэмжээнд л (мэдээлэгч нар нь юу харснаа л хэлдэг) хийхэд хүргэж байсан нь стандартчилагдсан, харьцуулах боломжтой мэдээллийг жигд цуглуулан авах хэрэгцээг хангаж чаддаггүй.<sup>41</sup> Өөр нэг бодит байдал гэвэл энэхүү худалдаа нээлттэй байсан ч үүнийг судлах, ажиглалт хийх нь хялбар бус байсан. Худалдаа арилжаа нь зэрлэг, амьтны суурьшин амьдардаг алслагдсан эзлүүд, хүрч очих боломжгүй нутгаас эхэлдэг. Зарим агнуурыг цөөхөн тоогоор хийдэг учраас нуун далдахад ч хялбар. Үүний зэрэгцээ худалдаа хийх хэлбэр нь олон янз, албан болон албан бус янз бүрийн зах зээл дамжин гараас гарт шилжин хийдэг. Энэхүү судалгаагаар хууль бус худалдаанд өртдөг зүйлийн олон янз байдал их биш, Монгол Улсад 32 зүйлийн амьтан алслагдсан нутгаас худалдааны зах, ресторан, айл өрх, аялал жуулчлалын болон үнэт эдлэлийн дэлгүүрт хүрч, хил дамнан арилжаалагдаж буйг бүртгээд байна. Харин халуун тропикийн улс орнуудад хууль бус худалдаагаар дамжиж буй зүйлийн

- 41 Энэхүү үзэл баримтлалын талаар зах зээлийн судалгаа хийгдсэн Хятад улс дахь зэрлэг барын гаралтай бүтээгдэхүүний талаар хэлэлцсэн: Gratwicke, Brian, Judy Mills, Adam Dutton, Grace Gabriel, Barney Long, John Seidensticker, Belinda Wright, Wang You, and Li Zhang. 2008 оны 7 сарын 2. *Plos One*. 3(7). "Attitudes Toward Consumption and Conservation of Tigers in China."

тоо хэдэн мянгад<sup>42</sup> хүрч, худалдаалах цэгүүд, хэлбэр нь тэр хэмжээгээр нэмэгджээ. Нийтэд нь дүгнэн хэлбэл зэрлэг амьтны худалдааны тодорхой хэсэг үзэгдэхүйц байж болох ч ихэнх хэсэг нь үл үзэгдэх байдалтай буй юм.

Тулгарч буй сорилтуудыг түр хойш тавиад харвал агшны судалгаа нь нилээд тооны давуу талуудтай. Цаг хугацааны давуу тал, хэв маяг болон өөрчлөлтийг баримтжуулах тал дээр түүнийг орлохуйц сайн сонголт байхгүй. Энэхүү судалгаанд харуулсанчлан зэрлэг амьтны судалгаа нь зарим тохиолдолд эрс өөрчлөгдөж, өчигдөр хэрэглэсэн аргачлалыг хэрэглээнээс шууд гарган үр дүнгүй болгож ч болно. 2005 оны байдлаар Монгол Улс дахь зэрлэг амьтны худалдааны хямралт байдал үндсэндээ хөхтөн амьтныг хамарч байсан учраас судалгааны хүрээнд авч хэрэгжүүлсэн ихэнх хүчин чармайлт нь хөхтөн амьтдыг хамгаалах чиглэлд төвлөрчээ. Харин энэ байдал өнөөдөр өөрчлөгдөж, үндсэндээ цэнгэг усны загасны худалдаа түлхүү болоод байна.

Агшны судалгаа нь мөн зарим талаар уян хаган байдлыг хангаж, нийт хугацааны туршид судалгааны үндсэн асуудлыг өөрчлөх, сайжруулах боломжийг олгодог. 2016 судалгаа нь энэхүү давуу талыг ашиглаж, өмнө 2005 онд хийсэн судалгааны асуулт, аргачлалуудыг өнөөгийн нөхцөлд нийцүүлсэн. Өрхийн асуулгын хувьд 2016 оны судалгаанд багтсан нийгэм-эдийн засгийн асуултуудыг (боловсрол, орлого, эд хөрөнгө) улсын хэмжээний тооллогын мэдээлэлтэй нийцүүлэн, хариултаудын зохист байдал, улсын хэмжээний мэдээлэлтэй харьцуулах боломжийг баталгаажуулсан. Түүнчлэн 2005 оны судалгаагаар хариулт цөөнтэй, тогтмол бус байсан бүх асуултуудыг хасах, ялангуяа агнасан амьтны жингийн тухай асуултуудыг (жишээ нь агнасан амьтны махны хэмжээг асуусан ч хөдөө орон нутгийнхны хувьд килограммаар тооцдоггүй) оруулахгүй байх боломж нээгдсэн. Зах зээлийн судалгааны 2005 оны мэдээлэл дээр хийсэн шинжилгээгээр олон төрөл зах зээлийн бодит байдлыг зах зээлийн нэг л судалгааны хэрэглэгдэхүүнд нэгтгэсэнээс (жишээ нь Улаанбаатар хотын дэлгүүрүүд болон хотоос гадуурх зэрлэг ан амьтны зах зээл гэх мэт) үүдсэн хүндрэлийг тогтоон, тухайн сургамжийг судалгаанд тусгасан. Энэхүү туршлага нь 2016 онд судалгааны багт зах зээлийн сегментүүдэд (ресторан, жижиглэн худалдааны дэлгүүр, аялал жуулчлалын байгууллагууд, уламжлалт эмийн сан) нийцсэн шинэ хэрэглэгдэхүүнийг боловсруулан гаргах боломж олгосон.

Эцэст нь энэ судалгаагаар шалтгаан, үр дагавар хоорондын хамаарлыг илүүтэй судалж, харилцан уялдаа холбоог зураглан гаргах боломжтой болсон. Цаг хугацааны хувьд урт үргэлжилсэн нь илүү нарийвчлал бүхий үр дүн гаргах боломжийг мөн нээсэн. Жишээ нь Монгол улсад сүүлийн 10 гаруй жилийн туршид хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр гаргасан хүчин чармайлтын үр дүнг өнөөдрийн олон нийтийн мэдлэгийн түвшин, хууль бус худалдааг илрүүлэн хураан авч буй тохиолдлуудын тоо, ноогдуулсан торгууль шийтгэлээс тодорхой харж болно. Энэ бүх үр нөлөө нь 2005 онтой харьцуулбал их хэмжээгээр өсөн нэмэгджээ. Гэхдээ зэрлэг амьтны нэг эх үүсвэрээс нөгөө эх үүсвэрт шилжиж буй хандлагыг ч эндээс харж болно. Арав орчим жилийн өмнө ан агнуур зэрлэг амьтны худалдааны зах зээлд тэргүүлж байсан бол одоо загасчлал тэргүүлэх болсныг баримт нотолгоо илтгэн харуулж байна. Төгсгөлд нь хэлэхэд энэхүү судалгаа нь зохицуулах үйл ажиллагааны нөлөөллөөс үүдэн харагдах байдал, нуун далдлах арга барилд гарч буй өөрчлөлтийг (жишээ нь хууль бус худалдааг шөнийн цагаар хийх, хараа хяналтгүй хилийн хэсгийг сонгох, дрон болон бусад техник ашиглах зэргээр хангалт, харилцаа холбоо сайжрах) баримтжуулахад дэмжлэг болж буй юм.

Монгол Улс дахь зэрлэг амьтны худалдааны агшны анхдагч судалгаа болохын хувьд энэхүү тайлан нь хуучин ЗХУ нуран унаснаас хойших Монгол Улс дахь зэрлэг амьтны худалдааг бүрдүүлж буй олон талын түүхэн замналыг ч гарган ирэх боломжийг мөн бүрдүүлсэн. Гэхдээ л энэхүү судалгаа өөрийн гэсэн хязгаарлалт, сул талтай бөгөөд эдгээр нь юу болох, хэрхэн нөлөөлж буй талаар судалгааны арга зүйг дэлгэрэнгүй тайлбарласан хоёрдугаар бүлэгт үзнэ үү.

42 Хууль бусаар худалдаалагдаж буй зүйлсийг тоог тодорхойлон гаргах нь хүндрэлтэй юм. Гэхдээ жишээ нь Вьетнам улсад л гэхэд ургамлын 21,017, амьтны 11,458 төрөл зүйлс байдаг хэмээн тооцдог. Эдгээрээс ургамлын 6,000 төрлийг хүнс болон бусад зорилгоор хэрэглэдэг бол 2004 оны судалгаагаар 130 төрлийн шавьж худалдаалдаг ба хуулиар зөвшөөрсөний дагуу бусад 147 хуурай газрын ургамал худалдаалж буйг тогтоожээ. The CITES Scientific Authority of Vietnam. 2008. "Report on the Review of Vietnam's Wildlife Trade Policy."

# Зорилго, арга зүй

“Зэлүүд тал” хоёрдугаар тайлан нь Монгол Улс дахь зэрлэг амьтны хууль бус худалдааг тодорхойлох, ойлгох чиглэлээр хийсэн өмнөх тайлангуудыг улам илүү дэлгэрүүлэх зорилготой. Тайлан нь сүүлийн 10 жилийн хугацаанд зэрлэг амьтны худалдаанд ямар өөрчлөлт гарсныг, тухайн асуудлыг зохицуулахаар гарсан хуулиас эхлээд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албадын үйл ажиллагаа, гарсан хэрэг зөрчлийг шийдэж буй шүүхийн практик хүртэл бүхий л зүйлсийг баримтжуулсан. Эцэст нь хууль бус худалдааг хяналтад байлгахад шаардагдаж буй практик хүчин чармайлт болон бодит алхмуудыг нарийвчлан оруулсан болно.

Хоёрдугаар бүлэгт тайлбарласан аргачлалуудаас гадна хэд хэдэн анхаарах ерөнхий сэдэв, шинэлэг санаанууд нь энэ тайланг бичихэд гол чиглүүлэгч нь болсон. Эдгээр нь 2005 оны тайлангийн судалгааны арга зүйг сайжруулах зорилго бүхий хэлэлцүүлгийн үед стратеги төлөвлөлтийг хэлэлцэх явцад төрөн гарсан. Судалгааны үндсэн баг 2005 онд хийсэн судалгааны арга зүй, өгөгдлүүдийг нарийвчлан судалж, аль асуулт үр дүнтэй байсан, аль нь хүсэж байсан хэмжээнд хүрээгүй зэргийг үнэлсэн. Мөн судалгааны зорилтыг тодорхойлохоос эхлээд орон нутаг дахь ажлын календарь, судлаачдын мэдээлэл, мэдээллийн шинжилгээ, олон нийтэд хүрч ажиллах болон эцсийн үнэлгээ хүртэл бүхий л шат нэг бүрийг хянаж, анализ хийж, үнэлж байсан. Үүний үр дүнд судалгааны баг нь 2016 оны судалгаанд зориулсан стратегийн 20 зөвлөмж боловсруулсан. Эдгээр зөвлөмжүүд нь 2016 оны судалгааг чиглүүлэх үндсэн зарчим болсон. Энэхүү бүлэгт өмнөх тайлангийн судалгааг сайжруулах болон шинээр оруулж ирэх стратегийн зөвлөмжүүдийг танилцуулж байна.

## ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХУДАЛДААНЫ СУДАЛГААНД ЦОГЦ ХАНДЛАГА АШИГЛАСАН

2016 оны тайлангийн судалгаанд хэрэглэсэн хамгийн анхны сайжруулалт нь системийг бүтнээр нь авч үзэх цогц хандлагыг баримталсан явдал байлаа. 2005 оны тайланг эргэн харвал, тайланг хийх явцдаа авсан нэг сургамж нь зарим салбаруудад, жишээ нь, эрх зүйн тогтолцоо, институциудын экосистемийг нягтлан үзэхэд зөвхөн нэгдмэл хүчин чармайлт ч бус худалдаанд оролцогч талуудын өргөн хүрээг хамарсан мэдээлэл гаргуулан авах системтэй хандлага шаардлагатай байсан явдал юм. 2005 оны судалгааны гол зорилго зэрлэг амьтны худалдаанаас олж буй ашиг болон худалдааны асуудлууд дээр төвлөрсөн. Харин 2016

оны судалгааны зорилго нь зөвхөн юу болоод байгааг ойлгохоос гадна хууль бус худалдааг бууруулах, өөгшүүлж буй механизмууд, тэдгээртэй тэмцэх бодит арга хэмжээнд түлхүү анхаарсан.

Үүний үр дүнд энэ тайланд баримтлах үзэл баримтлалыг боловсруулсан үеэс эхлэн тус тайлан нь зэрлэг амьтны худалдааны эргэн тойрон дахь системийн талаар мэдээлэл цуглуулах зорилтыг тавьсан. Өрхийн болон зах зээлийн судалгааг сайжруулахын зэрэгцээ судалгааны арга зүйн сүүлийн хувилбар нь олон салбарын мэдээлэл цуглуулах нэмэлт болон салбар бүрд нийцсэн аргачлалуудыг багтаасан. Үүнд дараах аргачлалууд багтаж байна:

- Эрх зүйн үнэлгээний харьцуулах боломжтой, орхигдлын шинжилгээ, үүнд эрх зүйн судалгаа болон бусад улс орнуудтай харьцуулсан судалгаа;
- Хууль сахиулах чиг үүрэг бүхий ажилтнууд, тэдгээрийн үйл ажиллагаа болон чадавхийн талаарх дэлгэрэнгүй асуултууд;
- Гаалийн албан хаагчдаас мэдээлэл хүссэн маягт болон ярилцлагын формат;
- Хилийн бүс нутгийн зураглал хийх, худалдаа их хэмжээнд явагддаг сэжиг бүхий газруудыг тодорхойлох;
- Худалдааны шилжилт хөдөлгөөнийг баримтжуулах зорилго бүхий тээвэр, ложистикын тухай асуултууд;
- Хууль тогтоомж хэрэгжүүлэх ажлын хэрэгцээ, үр дүнтэй байдлын талаарх олон нийтийн санал бодлын тандалт судалгаа;
- Олон улсын хэмжээний зэрлэг амьтны худалдаан дахь Монгол Улсын үүрэг ролийг харьцуулан шинжлэх боломж олгох нэмэлт судалгаа;
- Захиргааны зардал, хамаарах торгууль шийтгэл болон хууль бус бараа бүтээгдэхүүний зах зээлийн үнэ зэрэг хууль бус худалдааны эдийн засгийн нөхцлийн тухай гүнзгийрүүлсэн асуулга болно.

Арга зүйн эдгээр сайжруулалтын үр дүнд зарим бие даасан аргачлалуудыг (жишээ нь хагасчилан бэлдсэн ярилцлагын хуудас, мэдээллийн эрэмбэлсэн жагсаалт) бий болгосон. Зарим тохиолдолд судалгаанаас гарсан үр дүнгүүд нь нэгээс олон аргачлалд нэгтгэгдэж байсан. Жишээ нь зах зээлийн болон өрхийн судалгаа, гол мэдээлэгчтэй хийх ярилцлага болон баримт бичгийн судалгааны зааварчилгаа зэрэг багтана.

## ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХУДАЛДААНЫ МӨЧЛӨГТ НИЙЦҮҮЛСЭН

2005 онд хийсэн судалгааны бүх ярилцлагыг зуны улиралд явуулсан. Монгол Улсад ан агнуурын дийлэнх нь намрын улиралд явагддаг нь өрхийн судалгаанд

нөлөөлсөн байж болзошгүй бөгөөд харин зах зээлийн судалгаанд илт нөлөөлсөн гэдэг нь тодорхой.<sup>43</sup> Төлөвлөж байсны дагуу, өрхийн судалгаа нь үндсэндээ судалгаанд хамрагдсан хүмүүсийн өмнөх ой санамж дээр суурилж байсан ба ангийн талаарх статистик мэдээ цуглуулах оролдлого хийгээгүй болно. Харин зах зээлийн судалгааны хувьд 10 жилийн өмнө хийж байсан аргыг хэвээр нь ашигласан ба анхлан төлөвлөсөнтэй харьцуулбал шууд ажиглалт илүү хийхээр төлөвлөсөн. Зуны улиралд захиуудад шууд ажиглалт хийх нь нэлээд хязгаарлагдмал, худалдаалж буй хэлбэр, ямар зүйлийг худалдаалж буйг тогтоогоогүй. Харин 2016 онд хуулийн хэрэгжилт, хяналт илүү сайжирсан нь шууд ажиглалтын аргаар тодорхой төрлийн мэдээлэл цуглуулах цорын ганц боломжит арга болсон.

Хуулийн хэрэгжилт сайжирсныг үл тооцвол, зах зээлийн судалгааг намар болгон шилжүүлэх нь шууд ажиглалт хийх боломжийг нэмэгдүүлж, илүү сайн, тодорхой мэдээлэл цуглуулах боломж олгохоор байсан. Иймээс 2016 оны судалгааны дизайнд хоёр томоохон өөрчлөлт оруулсан.

Нэгдүгээрт зах зээлийн судалгааны хуваарийг 9 дүгээр сард эхлэхээр өөрчилсөн нь бүх төрлийн загасчлалаас гадна олон тооны хөхтөн амьтад ба шувуудын ангийн улиралтай бараг давхцаж байсан. Загасчлалын улирал нь харьцангуй урт учраас зах зээлийн судалгааны хугацаанд нөлөөлөхүйц бус. Харин эсрэгээр хөхтөн амьтад, шувуудын агнуурын улирал илүү богино тул хамгийн гол анхаарах хүчин зүйл байсан. Судалгаа хийсэн хугацаа нь ихэнх зүйлүүдийн ангийн хугацаатай давхцаж байсан ч 11 төрлийн үслэг ангийн хугацаанаас зөрж байсан.<sup>44</sup> Энэ мэтийг харгалзан үзвэл ажиглалтад зарим зөрчил гарсан байх магадлалтай.

Зах зээлийн судалгаанд шаардлагатай мэдээллийг нэмэхийн тулд судалгааны баг нь Улаанбаатар хотоос гадна ажиллаж байх үедээ аман яриагаар дамжуулан хууль бус ангийн тухай мэдээлэл цуглуулах үүрэгтэй байсан. Энэ мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд ажиглалтын маягт ашиглах замаар стандартчилж өгсөн. Багууд өөрсдийн ажигласан ямар нэгэн ангийн холбоотой үйл ажиллагааг бүртгэн авсан ба үүнд зураг, мэдээлэл болон анчдын хэлж ярьж буй зүйлсийг бүртгэх зэрэг орсон. Хууль бус ангийн өөрийнх нь хэв маяг болон хууль хяналтын арга хэмжээ нэмэгдэж буйг харгалзан судалгааны үйл ажиллагааны аюулгүй байдлыг тусгайлсан зааварчилгааны хүрээнд хангасан. Ажиглалтын хуудас хэрхэн ашиглах тухай 2016 оны намар зохион байгуулсан зах зээлийн судалгааны албан ёсны сургалтаар заасан болно.

43 Монгол Улсын Амьтны тухай хуулинд (2012) багтсан 26 хөхтөн амьтны ихэнхийн агнуурын хугацаа 9-12 дугаар сарын хооронд үргэлжлэх ба зарим амьтны агнуурын хугацаа 2 дугаар сарын эх хүртэл үргэлжилдэг.

44 Дараах ан амьтан дээр агнуурын хугацаа нь 11 дүгээр сарын 20-ноос эхэлж 2 дугаар сарын 11-нд дуусдаг: Ойн булга, хадны суусар, илбэнх, шилүүс, нохой зээх, шар үнэг, хярс үнэг, бараан хэрэм, Сибирь үен, усны булга, өмхий хүрэн, хотны үен, үен, мануул, туулай, чандага, урт сүүлт зурам.

Судалгааны аргачлалыг харилцан ялгаатай зорилгод нийцүүлсэн

2005 онд хийсэн судалгааны бүх өгөгдлийг уг судалгааны албан ёсны хоёр аргачлал болох өрхийн судалгаа болон зах зээлийн судалгаагаар цуглуулсан. Зах зээлийн ялгаатай сегментүүдэд нийцсэн судалгааны аргачлал, институцын болон эрх зүйн судалгаа дутмаг байсан нь мэдлэгийн орхигдол үүсэхэд нөлөөлсөн. Үүнийг шийдэхийн тулд 2016 оны судалгаанд нийт 12 судалгааны багц аргачлал оруулан сегмент хоорондын уялдааг хангасан. Дараах аргачлалуудыг хослуулан оруулсан:

- o Тоон мэдээлэл (хаалттай хариулт бүхий судалгаа);
- o Судлаач нар шууд ажигласан зүйлсийн талаарх мэдээлэл цуглуулах аргачлал (үнэ, түүх, зураг зэргийг системтэй арга замаар); болон
- o Чанарын мэдээлэл цуглуулах аргачлал (хагасчилан бэлдсэн ярилцлага).

Үндсэндээ судалгааны багц аргачлалд таван (5) тоон судалгаа (айл өрх, ресторан зоогийн газар, айл өрх, уламжлалт эмнэлэг болон үйлчлүүлэгчид, аялал жуулчлалын байгууллагууд болон жижиглэн худалдааны дэлгүүрүүд), санамсаргүй олдсон түүх, зураг зэргийг тэмдэглэн цуглуулах ажиглалтын нэг (1) хуудас, нэг (1) үнийн мэдээллийн тайлан (захууд болон онлайн худалдаанд ашиглах) болон таван (5) хагасчилан бэлдсэн ярилцлага (ерөнхийдөө гол мэдээлэгч нар, удирдах эрх бүхий хүмүүс, байгаль орчны эрх бүхий албан тушаалтан, шинжлэх ухааны судлаачид болон ТББ/олон улсын байгууллагуудад чиглэсэн) багтсан. Эдгээрийг хамтад нь ашигласан нь судалгааг илүү бодитой болгосон.

## САЙЖРУУЛСАН ТҮҮВЭРЛЭЛТИЙН АРГА ЗҮЙГ АШИГЛАСАН

2016 оны судалгаагаар өмнө 2005 онд хийсэн судалгаатай ижил тооны ажил гүйцэтгэсэн ба нийт 4,010 өрхийн, 1,100 зах зээлийн судалгааны хуудас бүхий мэдээлэл цуглуулсан. Түүвэрлэлтийг хэт олон эсвэл хэт бага хийхээс зайлсхийх, мөн энэ том судалгааны зардал, үр дүнтэй байдлыг сайжруулах зорилгоор судалгааны аргачлалд өөрчлөлт оруулсан. 2005 онд хийсэн судалгаа нь хот суурин газруудад энгийн санамсаргүй түүвэрлэлт, хөдөө орон нутагт шугаман солбицлолын түүвэрлэлтийн (line-intercept sampling) арга ашигласан. Зай, цаг хугацаа болон төслийн зохицуулалттай холбоотойгоор таван бүс нутагт түүвэрлэлт арай бага тоогоор хийсэн. 2016 оны судалгаанд түүвэрлэлтийн хэд хэдэн өөрчлөлт хийсний дотор түүвэрлэлтийн газар зүйн үечлэл багтсан. Анх удаа эдгээр судалгаанд мэдрэмтгий зан төлөвийн тухай мэдээлэл бага цуглуулж болохыг, жишээ нь хууль бус ангийн талаарх статистикуудийг тооцох аргачлалыг оруулж өгсөн. Үл ижилсүүлэх тооллогын



(УСТ) аргачлал дээр боловсруулсан тусгайлан асуултуудыг ашигласнаар судалгаанд хамрагдсан хүмүүс санаатайгаар мэдээлэл өгөхгүй байхаас үүдэн судалгааны үр дүн хэр хэмжээнд гажиж болохыг тооцоолох боломжтой болсон.

## МЭРГЭЖЛИЙН СУДАЛГААНЫ БАГ АЖИЛЛАСАН

Өмнөх судалгаатай харьцуулбал энэ судалгаанд гарсан томоохон дэвшил нь мэргэжлийн байгууллага болох Монголын Хараат бус судалгааны хүрээлэнг (IRIM) хэрийн судалгааны аргачлал боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулсан явдал байв. 2005 онд хийсэн судалгааг үндсэндээ нийгмийн судалгааны бус харин зэрлэг амьтны чиглэлийн судалгааны мэдлэг, туршлагатай төрөл бүрийн байгууллагуудын ажилтнуудыг оролцуулан гүйцэтгэсэн. Түүнчлэн газар зүйн хязгаарлагдмал байдлаас хамааран бүх ажилтан сургалтад нэгэн зэрэг хамрагдах боломжгүй байв. Тиймээс сургалтыг олон газарт хийсний улмаас чанарыг нь баталгаажуулах ажиглалт хийгдэх боломжгүй байсан.

Хараат бус судалгааны хүрээлэн нь мэргэшсэн судлаачдын багтай, судалгаанд тулгарах түгээмэл асуудлуудыг бууруулсан судалгааны стандарт, протоколтой, ялангуяа Монгол Улсын нөхцөлд тодорхой судалгааны үйл ажиллагааг (жишээ нь сонгуулийн мөчлөгт давхцуулахгүй байх, нүүдэлч малчдын бүс нутгаас хэрхэн түүвэрлэлт хийх гэх мэт) хэрэгжүүлэх чадвартай, мэргэшсэн байгууллага юм. Хараат бус судалгааны хүрээлэнгийн оролцоо нь бүхий л ложистик хангамж, түүвэрлэлтийн дизайн, мэдээллийн чанарын хяналт, хариултаудыг баталгаажуулах дотоод аудитын систем, англи хэлэнд орчуулах зэрэг үйл ажиллагааг багтаасан. Тус хүрээлэнтэй түншлэн ажилласнаар 2005 оны судалгаанд шинжлэн судлах, сайжруулалт хийх (жишээ нь шаардлагагүй асуултуудыг хасах, асуултуудыг сайжруулах, үр дүнг баталгаажуулах, талбайд гарсан алдааг илрүүлэх болон бусад) зэрэг олон боломж бий болсон юм. Ийнхүү сайжруулалт хийснээр үйл явцын үр ашигтай байдалд хувь нэмэр оруулж, алдааг бууруулах, илүү нарийвчлалтай болж, бодит үр дүнд хүрсэн билээ.

## МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ШИНЭ БОЛОМЖИЙГ АШИГЛАСАН

Өнгөрөгч 10 жилийн хугацаанд гарсан технологийн дэвшлийн үр дүн нь 2016 оны судалгааг дахин боловсруулах, сайжруулах боломжийг олгосон. Өмнө хийсэн судалгаагаар орон нутагт ажиллахдаа олон хуудас судалгааны материалыг олон тоогоор урьдчилан хэвлэн авч явж, орон нутаг дахь цаг агаарын хүнд нөхцөлд үзэг, цаастай ноцолдоход хүрч байв. Улмаар багийн хоёр гишүүн зөвхөн 5,000 гаруй ярилцлагын үр дүнг Эксель програмд шивж оруулахад л хамаг цагаа

зарцуулсан. Ийм байдлаар мэдээлэл шивж оруулахад алдаа гарах магадлалаас гадна тус арга зүй нь мэдээлэл шалгахад нэмэлт цаг ихээр шаардсан.

Энэ нь 2016 оны нөхцөл байдалтай харьцуулах аргагүй нөхцөл юм. Мэдээлэл харилцаа холбооны технологид гарсан дэвшил нь судалгааны дизайн болон хөгжүүлэлт, хэрэгжүүлэх процедууд, мэдээлэл оруулах арга зэргийг улам хялбаршуулсан нь судалгааны багийнханд 10 жилийн өмнө байгаагүй боломж байлаа. Нэгдүгээрт таван өөр газар байгаа экспертүүдийг онлайн хэлбэрээр хамтран ажиллах боломжийг олгосон ба энэ нь 2005 онд Монгол Улсад боломжгүй зүйл байсан. Хоёрдугаарт судалгааны програм хангамжийг судалгааны бүхий л талбар дээр ашигласнаар онцлогтой болсон. Үүнээс улбаалан: i) сургалтын үйл ажиллагааг судалгаатай уялдуулах, ii) явцын дунд асуултуудад өөрчлөлт оруулах, iii) мэдээлэл оруулах үйл ажиллагааны хурд, нарийвчлалыг сайжруулах, iv) үр дүнг бодит цагаар гаргах, болон v) статистикийн шинжилгээг нэгтгэх зэрэг үр дүнд хүрсэн.

Энэхүү судалгааны хүрээнд мэдээлэл оруулах платформ болгон таблет ашигласан нь бусад чухал цахим үйлчилгээг хэрэгжүүлэх боломжийг мөн ханган өгсөн. Үүнд GPS систем (газар зүйн байршлыг тогтоох, ярилцлага нэг бүрийг сүүлд нь зураглах); суурин камер (ярилцлагын байршил болон оролцогчтой хамаарах зургийг авах); дуу бичигч (оролцогчдын хэлж буй зүйлс болон өгч буй тайлбарыг тухайн хэлснээр нь бичих, мэдээллийн чанарын баталгаажилт хийх) зэрэг багтсан. Үүрэн технологийн өөр нэг давуу тал нь судлаачийн гаргаж болох алдааг бууруулсанд оршино. Өмнөх систем дээр судлаачид судалгааны цэг дээр очиж, ярилцлага хийлгүйгээр гэртээ сууж судалгааны хариултыг өөрөө зохион бөглөх тохиолдол гарах магадлалтай байсан. Үүрэн утасны технологи нь хэрэгслийн байршил, судалгаа хийсэн цагийг бүртгэж авч буй тул хуурамч үр дүн гарах эрсдэлийг бууруулсан.<sup>45</sup> Түүнчлэн сургалтын үйл ажиллагааг судалгаатай уялдуулсан нь судлаачдад асуултыг хэрхэн асуух талаар ойлголт, хэрэгтэй бол тухайн асуултын тайлбарыг үзэх эсвэл тодорхой нэг нөхцөлд мэдээлэл хэрхэн оруулах зэргийг нарийвчилж өгсөн. Нээгдсэн өөр нэгэн боломж нь судалгааны үеэр залруулга хийх (гэхдээ ихэнх алдааг туршилтын шатанд залруулсан) боломж байв. Хэрэв ямар нэг алдааг ирүүлбэл (жишээ нь “Бусад” хэмээх сонголт байхгүй бол олон сонголттой асуултыг ашиглах гэх мэт), хамаарах залруулгыг бодит цагаар хийж, судлаач нь тухайн залруулсан хувилбарыг нэн даруй хүлээн авах боломжтой байсан. Судалгааны програм хангамж нь төв компьютерээс хянаж, орон нутагт гарч буй алдааг илрүүлэн, хязгаарлах боломжтой тул цаасан асуултыг нэгтгэх, мэдээлэл оруулах бүхий л үйл явцад хэмнэлт гаргасан. Эцэст нь судалгааны мэдээллийг дамжуулахад хариуцсан ажилтнууд тухайн хүснэгтэлсэн мэдээллийг шууд хүлээн авах боломжтой

45 2005 оны судалгаагаар нэг багийг татан буулгаж, энэ шалтгаанаар тус багийн цуглуулсан мэдээллийг устгасан байна.

байлаа. Эдгээр технологийн дэвшил нь 2005 оны судалгааг эрс сайжруулж мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг хурд найдвартай болгож өгсөн юм.

## МЭДЭЭЛЛИЙГ ДҮРСЖҮҮЛЭН ЗУРАГЛАСАН

Анхдугаар тайлан нь текст бус элементүүд болох газрын зураг, фото зураг, график болон хүснэгтийг багтааж байсан. Харин энэ удаагийн тайлан нь мэдээллийг дүрслэн харуулах чиглэлд илүү ахиц гаргасан тайлан болсон. Уншигчдад хүрэх ойлголтыг илүү тодорхой болгох зорилгоор ихээхэн хэмжээний мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийж, мэдээллийг дүрсжүүлэх тал дээр ихээхэн анхаарал хандуулсан. Тайлангийн төслийг бэлтгэн гаргах үйл явцад зураг төслийн экспертийг ажиллуулснаар судалгааны үр дүнд багтсан ээдрээтэй харилцааг график дүрслэлээр тодорхой гаргах боломж сайжирсан.

## СУДАЛГААГ ДЭЛХИЙ НИЙТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛТАЙ УЯЛДУУЛСАН

Эцэст нь хэлэхэд энэхүү тайлан нь Монгол Улсын нөхцөл байдлыг дэлхийн нөхцөл байдалтай уялдуулан судлахыг зорьсон. Зэрлэг амьтны хууль бус худалдааны олон улсын элементүүд нь 2005-2006 оны судалгаанд орхигдоогүй хэдий ч дэлхийн хандлага цухас төдий дурдагдсан. Тухайн үед судалгааны баг нь Хятад болон Орос Улстай хийж буй хил дамнасан худалдааг хязгаарлагдмал хэмжээнд судалсан ба тайлан нь хууль бусаар худалдаалж буй зэрлэг амьтдыг Монголоос нөөц бүрдүүлж буй улс хэмээн үзэж Монголд тулгарч буй асуудлуудад илүү төвлөрсөн. Зэрлэг амьтны худалдааны олон улсын хамрах хүрээ өргөжин тэлж буйг нэгэнт мэдэж байгаа учраас энэхүү тайлан нь хаана энэ хууль бус худалдаа явагдаж байж болох, хаагуур дамжиж байгааг холбохыг зорих нь логикийн хувьд зөв юм. CITES-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр Монгол Улсын гаргасан ахиц дэвшлийг бусад улсаас илүүд үзэх хэрэгтэйг дурдсан болно. Монгол Улс нь мөн НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц (UNTOC) болон НҮБ-ын Авлигын эсрэг конвенц (UNCAC) зэрэг бусад зэрлэг амьтадтай холбоотой олон улсын гэрээ, конвенцийн гишүүн орон юм. Олон улсын сайн туршлага, ижил төстэй асуудлууд тулгарч буй бусад улсын туршлага, систем болон эрх зүйн баримт бичгийн агуулга зэргийг харьцуулснаар Монгол Улсын эрх зүйн орчныг илүү сайн ойлгох боломжтой болно. Үүнээс гадна энэхүү тайланг ижил сорилт тулгарч буй бусад улсууд, ялангуяа биологийн төрөл зүйл болон худалдаа, хуулийн хэрэгжилтийн ижил асуудалтай Төв Азийн орнууд болон тэдгээрийн судлаачдад хүртээмжтэй болгох нь бас нэгэн зорилго байсан билээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ:

АРГА ЗҮЙ

# Оршил

Энэхүү бүлэгт судалгааг зохион байгуулах, задлан шинжилгээ хийхэд ашигласан нэлээд хэдэн төрлийн арга зүйг танилцуулж байна. Үүнд судалгааны явцыг үе шат бүр дээр чиглүүлэх зорилготой судалгааны үндсэн асуултуудыг тайлбарлахаас гадна өгөгдөл цуглуулах, тэдгээрийг баталгаажуулах хэрэглэгдэхүүн, түүвэрлэлт болон орон нутгаас мэдээлэл цуглуулах ажлыг хэрхэн зохион байгуулсан талаар мэдэж авч болно. Түүнчлэн судалгааны баг бүрдүүлж, гишүүдийг сургах, судлаач бүрийн үүрэг хариуцлагыг хэрхэн хуваарилсан тухай тайлбар буй. Ялангуяа судалгааны үнэн зөв, сайн мэдээлэл олж авахын тулд чанарын хяналт хэрхэн тавьсан талаар бүлэгт тусгалаа.

Энэхүү бүлэг дараах долоон дэд хэсгээс бүрдэж байна:

- **Судалгааны асуулт** – Зэрлэг амьтны хууль бус худалдааны мэдээлэл цуглуулах үндсэн найман чиглэлээр асуулт боловсруулсан. Үүнд 1) зэрлэг амьтан хамгаалах, 2) зэрлэг амьтан агнах, бүтээгдэхүүн олж авах, 3) худалдаалах, 4) зэрлэг амьтны худалдаатай холбоотой эрх зүйн тогтолцоо, 5) хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа, 6) зах зээл, 7) олон нийтийн мэдлэг мэдээлэл, 8) Монгол Улсын нийгэм-эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал зэрэг багтсан.
- **Мэдээллийн эх сурвалж** – Анхдагч эх сурвалж болох өрхийн болон зах зээлийн судалгаанаас гадна мэдээллийн бусад эх сурвалжуудын жагсаалт
- **Судалгааны баг** – Судалгааны багийн гишүүд, тэдний мэргэшил, өмнөх судалгаанд оролцсон туршлагын тухай танилцуулга
- **Судалгааны ажлын календарь** – Судалгааны болон зохион байгуулалтын үйл ажиллагаа бүрийн огноо, ажлын хуваарь
- **Судалгааны хэрэглэгдэхүүн** – Өрхийн болон зах зээлийн судалгаа авах, баримт бичгийн судалгаа хийхэд ашигласан 13 төрлийн хэрэглэгдэхүүний тайлбар
- **Түүвэрлэлтийн арга** – Өрхийн ба зах зээлийн судалгааны түүвэрлэлтийн дизайны талаарх дэлгэрэнгүй тайлбар
- **Мэдээлэл цуглуулах, задлан шинжилгээ хийх** – Орон нутгаас мэдээлэл цуглуулахад ашигласан аргачлал, үйл ажиллагааны талаарх мэдээлэл орлоо.

Бид судалгааны арга зүйн талаар “Зэлүүд тал”-ын анхдугаар тайлангаас илүү дэлгэрэнгүй нарийн мэдээллийг өгч байгаа бөгөөд бүх асуулгын агуулга, түүвэрлэлтийн аргачлал, мэдээллийн шинжилгээ хийх үйл явцыг тодорхой тайлбарласан. Үүний гол

зорилго нь судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүн, задлан шинжилгээг бүх талаас нь иж бүрэн харуулах замаар харьцуулж болохуйц судалгааг цаашид хийх, холбогдох чиглэлд авч ашиглах боломжийг бий болгох явдал юм.

Иймд энэ удаагийн судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүнийг боловсруулах суурь зарчим нь 2005 оны судалгааны ерөнхий аргачлалыг хэвээр хадгалах, аль болох гажихгүй байх бодлого байсан юм. Гэхдээ тухайн нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс (жишээ нь хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирснаас үүдэн судалгааны зарим арга хэрэгцээгүй болох гэх мэт), эсхүл өмнөх судалгааны хүрээнд зарим арга зүйн сайжруулалт хийх (жишээ нь судалгааны үр дүнг газар зүйн хувьд судлах боломжтой шинэ технологи ашиглах, эсхүл хоёрдмол утгатай тааруухан асуултуудыг хасах гэх мэт) зэрэг илүү чамбай болгох судалгааны стратеги баримтлан ажилласан юм. Судалгааг төлөвлөх явцаас болон багийн гишүүдийн саналд үндэслэн өмнөх судалгааны арга зүйг зохих хэмжээнд сайжруулахгүйгээр чанартай сайн мэдээлэл цуглуулах боломжгүй нь тодорхой болсон юм. Чухам ямар өөрчлөлт хийсэн талаар нэгдүгээр бүлэг болон энэхүү бүлэгт мэдээлсэн байгаа.

Дараагийн бүлгүүдэд Монгол Улс дахь зэрлэг амьтны худалдааг тойрсон даян дэлхийн худалдааны нөхцөл байдал (Гуравдугаар бүлэг); институцийн болон эрх зүйн орчны дүн шинжилгээ (Дөрөвдүгээр бүлэг); судалгааны голлох үр дүн (Тавдугаар бүлэг), Монгол Улсад зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх тэргүүлэх үйл ажиллагааны зөвлөмжүүд (Зургаадугаар бүлэг) зэргийг багтаалаа.

# Судалгааны асуултууд



## АН ХИЙЖ БУЙГ ХАРУУЛСАН ХҮРЛИЙН ҮЕИЙН ХАДНЫ ЗУРАГ

Өвөрхангай (МЭӨ 3000 жил)  
Монгол улсын Байгалийн түүхийн музей

Судалгааны арга зүйг тодорхойлох анхдагч алхам нь зэрлэг амьтны худалдаанд чухал үүрэгтэй үндсэн найман чиглэлийг тодорхойлон гаргах явдал байв. Үүнд 1) зэрлэг амьтан хамгаалах, 2) зэрлэг амьтан агнах, бүтээгдэхүүн олж авах, 3) худалдаалах, 4) зэрлэг амьтны худалдаатай холбоотой эрх зүйн тогтолцоо, 5) хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа, 6) зах зээл, 7) олон нийтийн мэдлэг мэдээлэл, 8) Монгол Улсын нийгэм-эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал орж байна. Тухайн чиглэл бүрийг доорх байдлаар тодорхойлж өгсөн:

- 1. Хамгаалах** – Зэрлэг амьтны төрөл зүйлийн нөхцөл байдлын талаарх цуврал асуултууд, хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны санхүүжилт, хөтөлбөр, санаачилга (жишээ нь нутгийн иргэдэд түшиглэсэн зэрлэг амьтны менежмент, зэрлэг амьтны мониторинг).
- 2. Агнах/олж авах** – Ан агнуурын талаар тусгайлсан асуултууд, сүүлийн 10 жилд гарсан өөрчлөлтүүд, жишээ нь анчдын тоо, тэдгээрийн тодорхойлолт, түлхүү агнадаг амьтны зүйл, агнаж буй хэмжээ, улирал, агнах шалтгаан гэх мэт.
- 3. Худалдаалах** – Зэрлэг амьтны худалдаа, явагдах байдал, тоо хэмжээ, үнэ цэнэ, өрхийн орлогод ан агнуурын үүрэг роль, CITES-р зөвшөөрсөн зэрлэг

амьтны худалдааг Монгол Улсад болон гадагшаа хэрхэн хийж буй тухай асуултууд

- 4. Эрх зүйн тогтолцоо** – Холбогдох эрх зүйн орчны өнөөгийн нөхцөл байдал, түүнд гарч буй өөрчлөлт, CITES-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомжууд, зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх чиглэлээрх эрх зүйн орчин хэр үр дүнтэй буй талаар асуултууд.
- 5. Хэрэгжүүлэх** – Зэрлэг амьтны хууль бус худалдааны хяналт, мониторинг, хэрэгжүүлэх болон мөрдөн шалгах үйл ажиллагааны төрлүүд, тэдгээрийг гүйцэтгэгч байгууллагуудын чиг үүрэг, хүчин чадал, арга ажиллагааны тухай цуврал асуултууд.
- 6. Зах зээл** – Зах зээлийн томоохон цар хүрээг хамарсан асуултууд, тухайлбал дотоод болон гадаадын зах зээлийн дүр төрх, хоорондоо ялгаатай эсэх, юунаас бүрддэг (жишээ нь уламжлалт эм, ангийн мах, загас гэх мэт) зэргийг судалсан асуултууд.
- 7. Олон нийтийн мэдлэг** – Зэрлэг амьтны худалдаатай холбоотой агуулга хэвлэл мэдээллээр явж буй эсэх, холбогдох хууль тогтоомж, хууль бус ан агнуур, хүлээх хариуцлагын талаар иргэдийн ерөнхий мэдээлэл ямар байгааг мэдэх зорилго бүхий асуултууд.
- 8. Нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал** – Монгол Улсын нийгэм-эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал, хүн ам зүйн бүтцэд сүүлийн арван жилд гарсан өөрчлөлт, зэрлэг амьтны хууль бус худалдааны гол хүчин зүйлс, тэдгээрийн хамаарлын талаарх багц асуултууд орж байна.

Эдгээр найман чиглэлээр судалгааны баг нийт 70 асуулт боловруулсныг нэгдүгээр хавсралтаас үзэж болно. Энэхүү жагсаалт нь судалгааны дизайн хийх гол үндэс болсон бөгөөд тухайн асуулт ядаж нэг эсвэл түүнээс дээш тооны судалгааны хэрэглэгдэхүүнд орж чадсан эсэхийг баталгаажуулахад чухал ач холбогдолтой байсан. Түүнчлэн баримт бичгийн судалгаа хийх, бусад шаардлагатай эх сурвалжийг олох зэрэгт чиглэл болж өгсөн. Эдгээр асуултад зөв хариулт авах эсэх нь мэдээллийн хүртээмж, тухайн ярилцлагад орж буй хүмүүсийн хүсэл эрмэлзэл, зарим төрлийн мэдээллийг цаг тухайд нь гаргуулан авах боломж, цуглуулсан мэдээллийн хэмжээ, чанар зэргээс хамаарч байлаа.

# Мэдээллийн эх сурвалж

Асуултуудаа тодорхойлон гаргасны дараа судалгааны баг нь шууд мэдээлэл цуглуулах боломжтой эх сурвалжуудыг тодорхойлсон хүснэгт гаргасан. Үүний зорилго нь өрхүүд болон худалдаа эрхлэгчдээс цуглуулсан үндсэн өгөгдлийг бусад оролцогч талуудын үзэл бодол, статистик болон хэвлэн нийтлүүлсэн материалуудаар баяжуулах явдал байсан юм.

Боломжит мэдээллийн эх сурвалжийн жагсаалтад нийт 53 эх сурвалж багтсаны дотор институцийн тогтолцоо, тухайлбал зэрлэг амьтны худалдааны удирдлага, зохицуулалт, худалдааны болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагууд, дотоод гадаадын ТББ-ууд, судалгааны байгууллага, судлаачид, дотоод гадаадын санхүүгийн байгууллагууд, хувийн хэвшлийнхэн багтсан. Эдгээр 53 эх сурвалжийн 36-аас нь мэдээлэл цуглуулсан (нэгдүгээр хүснэгтэд цэнхэр өнгөөр тэмдэглэсэн) бөгөөд эдгээрт бүх институцийн төлөөлөл, хууль хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагууд, иргэний нийгмийн зорилтот бүлгүүд, хэд хэдэн дотоодын ба олон улсын ТББ-ууд орсон.

Аймаг, сумдын албаны хүмүүсээс мэдээлэл авах ажлыг зохион байгуулж чадаагүй нь чухал ач холбогдол бүхий мэдээллийн эх сурвалжийг алдсан хэрэг болсон. Чухамдаа ан агнуур нь орон нутагт хийгддэг тул энэ түвшнээс мэдээлэл цуглуулах нь ихээхэн чухал, энд буй нөхцөл байдлыг үнэлж чадвал улсын хэмжээнд чиг хандлага ямар буйг ерөнхийд нь тодорхойлох, нарийн ойлголт авах боломжтой байсан юм.

Энэ мэтчилэн зарим эх сурвалжийг ашиглаж чадаагүй ч маш их хэмжээний судалгааны мэдээлэл цуглуулсан юм. Гол мэдээлэгч болон оролцогч талуудтай ярилцлагыг сайн зохион байгуулсан нь чухал ач холбогдолтой болсон. Тухайлбал, эдгээр эх сурвалжаас авсан мэдээлэл судалгааны гол үр дүнг баталгаажуулах, тайлбарлах, үр дүнг илүү сайн ойлгох, зарим тохиолдолд шууд тайлбар тайлал болох зэргээр үнэтэй хувь нэмэр оруулсан. Иймэрхүү нэмэлт эх сурвалжийн мэдээллийг тайлангийн бүхий л хэсэгт ашигласан ба шаардлагатай тохиолдолд шууд иш татан оруулсан байгаа.

## Хүснэгт 1. Мэдээллийн эх сурвалжууд

ЗЭЛҮҮД ТАЛ II	
Мэдээллийн эх сурвалж	
Монгол улсын Засгийн газрын удирдлага зохицуулалтын чиг үүрэг бүхий байгууллагууд	1 Байгаль орчны яам
	2 Сангийн яам
	3 Гадаад харилцааны яам
	4 Аялал жуулчлалын яам
	5 Гаалийн ерөнхий газар
	6 Улсын/орон нутгийн ан агнуур хариуцсан байгууллага
	7 Сумын/аймгийн захиргаа
	8 Үндэсний статистикийн хороо
Монгол улсын Засгийн газрын хууль сахиулах чиг үүрэгтэй байгууллагууд	9 Хууль бус агнууртай тэмцэх хөдөлгөөнт эргүүл Цагдаагийн ерөнхий газар, Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс
	10
	11 Авилгатай тэмцэх газар
	12 Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газар
	13 Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
	14 Гаалийн ерөнхий газар
	15 Хил хамгаалах ерөнхий газар
Үндэсний төрийн бус байгууллагууд	16 Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар
	17 Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Монгол дахь хөтөлбөрийн газар
	18 Тул сан
	19 Ирвэс хамгаалах сан
Эрдэм шинжилгээний байгууллагууд	20 Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн
	21 Монгол улсын их сургууль
	22 Нью-Йоркийн хуулийн сургууль
	23 Биологийн хүрээлэн
	24 Оксфордын их сургууль
Иргэний нийгэм ба хувийн хэвшлийн салбар	25 Агнуур ба загасчлалын холбоод
	26 Агнуур ба загасчлалын худалдаачид
	27 Аялал жуулчлалын компаниуд
	28 Уул уурхайн компаниуд
	29 Уламжлалт анагаах ухааны холбоод/ эмнэлгүүд
	30 Айл өрхүүд
	31 Зэрлэг амьтан худалдаалах захууд
	32 Зэрлэг амьтны махаар үйлчилдэг зоогийн газрууд
	33 Зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний дэлгүүрүүд
	34 Хуулийн ассоциаци
Олон улсын төрийн бус байгууллагууд	35 НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр
	36 Дэлхийн байгаль хамгаалах холбоо
	37 Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг
	38 Зэрлэг амьтан, ургамлын худалдаа, мониторингийн сүлжээ
	39 Де Нэйче Консерванси
	40 Ээртвотч хүрээлэн
	41 Даян дэлхийн байгаль орчны сан
	42 Бөхөн хамгаалах сүлжээ
	43 Пантерра
	44 Фауна энд Флора Интернешнл
Олон улсын тусламж, санхүүгийн байгууллагууд	45 Дэлхийн банк
	46 Европын сэргээн босголт хөгжлийн банк
	47 Германы Сэргээн босголт зээлийн банк
	48 АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
	49 ИБУИНВУ-ын Засгийн газрын тусламж болон ИБУИНВУ-ын Байгаль орчин, хүнс ба хөдөө аж ахуйн яам
	50 Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
Гадаад улс орнуудын Засгийн газар	51 БНХАУ-ын Гаалийн байгууллага
	52 ОХУ-ын Гаалийн байгууллага
Олон улсын хэлэлцээр	Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц
	53

# Судалгааны баг

2005 оны судалгаа газар зүйн хувьд өргөн уудам орон зайг буюу бүх нутаг дэвсгэрийг хамрах зорилготой байснаас 30 гаруй байгууллагын ажилтан, албан хаагчид оролцож байжээ. Үүнээс хамаараад судалгааны зарим шатанд бүгд тууштай үргэлжлүүлж чадаагүй, мөн судалгаанд оролцогчдыг сургах, өгөгдөл оруулах, баталгаажуулах, хянах үйл ажиллагааг хэд хэд тасалж хийх хэрэгтэй байсан.

Харин 2016 оны судалгааны баг өмнөх багаас цөөн гишүүнтэй, үндсэн судлаачид нь дизайн хийх, төлөвлөхөөс эхлээд өгөгдөл цуглуулах, задлан шинжилгээ хийх зэрэг судалгааны бүх шатны ажлыг гардан тууштай хийж чадсан. Түүнчлэн судалгааны сэдвээр мэргэшсэн, салбарт хамаарал бүхий гишүүд сайн орсноор биологи, хууль эрх зүй, эдийн засаг, олон улсын худалдаа, бизнес, судалгааны төлөвлөлт, статистик, өгөгдөл мэдээллийг дүрсжүүлэх зэрэг олон талын мэдлэг туршлагыг нэг дор авчирсан. Үүний үр дүнд судалгааны дизайн хийх, хэрэгжүүлэх ажлыг иж бүрэн гүйцэтгэж, бүх мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг нэгтгэн зангидах, үйл явцыг үе шат бүрт уялдуулах, гишүүн бүр тодорхой стандарт, нэгдмэл арга зүйн дагуу ажиллаж чадсан юм.

Оролцогч талуудын ажил үүргийг дараах байдлаар хуваарилсан. Үүнд:

- **Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг (ЛАСН)** нь үйл ажиллагааг ерөнхийд нь удирдан чиглүүлж, стратеги төлөвлөлтөөс эхлээд хэрэгжилтийн бүхий л шатанд төслийн үйл ажиллагаанд бүрэн хэмжээнд оролцсон. Тус байгууллагыг төлөөлөн ЛАСН-н төслийн зохицуулагч Натан Конабой (ерөнхий менежмент, тайланг хамтран бичих, баримт бичгийг хянах ажлыг голлон хариуцсан), М.Мөнхжаргал (байгаль хамгааллын биологич, техникийн мэргэжилтэн), С.Гомбобаатар (баримт бичгийг хянах), ЛАСН-ийн Өмнөд ба Төв Азийн хөтөлбөрийн зохицуулагч, төслийн дэд тэргүүн Гитанжали Бхаттачариа (хамтран зохиогч, редактор) нар ажилласан. Мөн тус тайлангийн монгол эхийн орчуулгыг хянан тохиолдуулах, хүснэгт зургийн нэр томъёог зохистой зөв болгох ажлыг ЛАСН-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын захирал Др. У. Тунгалаг, тус газрын ажилтан Б.Мөнхжаргал, Ц.Мөнхзул нар гардан хийж, тайланг хэвлүүлэх, тайлангийн нээлтийг зохион байгуулах ажлыг ЛАСН-ын ажилтан Ш.Мягмарсүрэн, Ц.Халиун нар хариуцан ажилласан.
- **Лийгэл Атлас (Legal Atlas)** нь судалгаа, дүн шинжилгээний үндсэн багаар ажилласан

бөгөөд багийн бүрэлдэхүүнд Жеймс Вингард (судалгааны дизайн, эрх зүйн дүн шинжилгээ, тайлан бэлтгэх), Мария Паскуал (судалгааны дизайн, статистик мэдээллийн шинжилгээ, мэдээллийн зурган дүрслэл, тайланг бэлтгэх, төслийн менежмент), Аманда Рюд (судалгааны газарт хийсэн ярилцлагууд, баримт бичгийн судалгаа, тайлан бэлтгэх), Абигали Хоуле (эрх зүйн дүн шинжилгээ, баримт бичгийн судалгаа, тайлан бэлтгэх) нар ажилласан.

- **Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM)**-ийн судалгааны багт А.Долгион (Гүйцэтгэх захирал), Ц.Батсугар (Үйл ажиллагаа хариуцсан захирал), Ц.Болд (Зөвлөх), С.Нямхорол (Судалгааны менежер) болон Ө.Батсайхан (Ахлах судлаач) нар ажиллаж, тэдний удирдлага дор 25 судлаач орон нутагт ажилласан. Хараат бус судалгааны хүрээлэн нь судалгааны бүхий л үе шат болох дизайн төлөвлөлт, сургалт, судалгааны хэрэглэгдэхүүнийг шалган баталгаажуулах, судалгааны ложистик, мэдээлэл цуглуулах, мэдээллийг нягтлах, тайлан бэлтгэх зэрэгт хамтран ажилласан.

Доорх зурагт эдгээр байгууллага бүрийн оролцоо, үндсэн чиг үүргийг харууллаа.

Зураг 1. Судалгааны баг, гишүүдийн үндсэн үүрэг

ЗЭЛҮҮДТАЛ II	
Судалгааны баг, чиг үүрэг	
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ	la ZSL
СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛУУД	
ӨРХИЙН СУДАЛГАА	la ZSL IRIM
ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА	la ZSL IRIM
ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН СУДАЛГАА	la
БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГАА	la
ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ БЭЛТГЭХ	la ZSL
ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ЗӨВЛӨЛДӨХ	ZSL

Судалгааны олон чиглэлийн ажлыг тал талаас нь хэрэгжүүлж буй хоорондоо ялгаатай талуудад зориулан нэгдсэн сургалт хийсэн нь судалгааны амжилтад чухал нөлөөлсөн. 2005 онд эхний шатны сургалтад тэргүүлэх судлаач нарыг хамруулан, улмаар тэдгээр нь багийн бусад гишүүдийг сургаж ажилласан. Энэ удаагийн сургалтыг үндсэн хоёр хэсэгт хувааж, 5 дугаар сард хийсэн Өрхийн судалгаа болон 9 дүгээр сард хийсэн Зах зээлийн судалгаатай цаг хугацааны хувьд тааруулж ажилласан. Сургагч багш нарт зориулан бүх сургалтыг Улаанбаатар хотод ЛАСН болон Лийгэл Атласын экспертүүд хамтран зохион байгуулсан.

Өрхийн судалгааны хувьд гурав хоногийн сургалтад (5 дугаар сарын 13-14, 16) нийт 5 чиглүүлэгч ажиллаж Хараат бус судалгааны хүрээлэнгийн үндсэн багийн долоон чиглүүлэгчийг сургасан. Дараа нь 5 дугаар

сарын 18-19-ний өдрүүдэд багийн бусад гишүүдэд зориулан хийх үед Хараат бус судалгааны хүрээлэнгийн 8 чиглүүлэгч мөн судлаачаар ажиллахаар хүсэлт гаргасан нийт 24 судлаач хамрагдсан.

Зах зээлийн судалгааны сургалтыг ч иймэрхүү маягаар хийж, Лийгэл Атлас, ЛАСН-ийн дөрвөн чиглүүлэгч-сургагч, Хараат бус судалгааны хүрээлэнгийн үндсэн багийн долоон гишүүнийг сургаж, дараа нь тэд өөрсдийн багийн бусад судлаачдад сургалт хийсэн. Судалгааны хэрэглэгдэхүүний тоо, зах зээлийн олон талт байдлаас үүдэн сургалтыг гурван тусдаа хэсэг болгон явуулсан. Эхний сургалт нь гол мэдээлэгчтэй хийх ярилцлага, үнэ ханшийн мэдээ, хоёрдугаар сургалт нь ресторан, аялал жуулчлалын компаниуд, жижиглэн худалдааны дэлгүүр болон уламжлалт эмийн сангуудыг хамруулсан зах зээлийн судалгааны асуудлаар байв. Сүүлийн сургалтаар бүх судлаачдыг Ажиглалтын хуудас хэрхэн ашиглах талаар заасан.

Сургалтад шаардлагатай тооноос илүү судлаачдыг хамруулсан нь нэгдүгээрт, судалгаа хийх чадамжгүй судлаачдыг хасч солих, хоёрдугаарт шаардлагатай тохиолдолд нөөц судлаачдыг бэлэн байлгах хоёр шалтгаантай байсан. Бүх судлаачдаас шалгалт авч, судалгааны ажилд тэнцэх эсэхийг мөн үнэлсэн. Өрхийн судалгаанд зориулан нийт 31 хүн сургалтад хамрагдсанаас мэдээлэл цуглуулахад 20 судлаач, харин зах зээлийн судалгаанд анхлан 11 судлаач сургаснаас 10 нь үндсэн судалгаанд оролцсон.

2005 оны судалгаанаас ялгаатай нь судалгааны багийн гишүүдийг сургахдаа ажиглалт хийх, судалгааны дизайн хийсэн болон анхны сургалт зохион байгуулсан хүмүүсийг оролцуулсан. Үүний үр дүнд судалгааны үндсэн баг сургалтын хөтөлбөрийг үнэлж цэгнэх боломжтой болсон.



# Судалгааны календарь

Энэхүү 2016 оны судалгааг мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тайлан гаргах ажлыг оролцуулаад нийт 12 сарын хугацаанд хийсэн нь 2005 оны судалгаанд шаардагдсан хугацаатай ойролцоо байгаа юм. Гэхдээ стратегийн зөвлөмжийн дагуу судалгааны календарьт зарчмын ялгаа гарсан нь өрхийн, зах зээлийн, оролцогч талуудын гэсэн гурван төрлийн судалгааг тус тусад нь боловсруулж, хэрэгжүүлсэн явдал юм. Ингэхэд хүрсэн дараах гурван шалтгаан буй:


- Монгол Улс дахь зэрлэг амьтны худалдааны зах зээлийг илүү нухацтай судлах.** 2005 онд хийсэн судалгааны бүх ярилцлага зуны улиралд хийгдсэн. Гэтэл ан агнуур ихэнхдээ намрын улиралд явагддаг тул энэ нь зах зээлийн судалгаанд тохиромжгүй үе байжээ. Зуны улиралд зах дээр ажиглалт хийхэд зарим төрлийн ан хийгдээгүй учир олигтой үр дүн гараагүй байна. Тиймээс 2016 онд зах зээлийн судалгааг 9 дүгээр сараас эхлүүлэн өөрчилсөн.
- Бусад цаг үеийн арга хэмжээ, үйл ажиллагаатай зөрүүлэх.** Жил бүрийн 7 дугаар сард тэмдэглэдэг Үндэсний их баяр наадам зэрэг арга хэмжээ нь ихэнх хүмүүсийн судалгаанд хамрагдах боломжид ямар нэгэн байдлаар нөлөөлөх нь зайлшгүй. Үүнд нийцүүлэн оролцогч талуудын судалгааг хийх цаг хугацааг тааруулснаар ярилцлагад оролцогчийн зав чөлөө боломжийг тохируулах

нь чухал байлаа. Түүнчлэн 2016 оны 6 дугаар сарын 29-ний өдөр УИХ-ын сонгуулийг товлосон байв. Сонгуулийн өмнө олон тооны судалгаа хийдгээс хүмүүс судалгаанд оролцохыг хүсэхгүй байх боломжтой хэмээн IRIM-ийн судлаачид үзсэн. Иймд өрхийн судалгааны хугацааг өөрчлөн 5 дугаар сард эхлүүлж 6 сард багтаан дуусгахаар төлөвлөсөн.

- Судалгааны онцлогт таарсан сургалт, арга барил.** Зах зээлийн судалгааны хувьд, багууд зорилтот зах зээлийн мэдээлэл цуглуулахаас гадна гол мэдээлэгчтэй хийх ярилцлага, ажиглалтын хуудсаар дамжуулан ан агнуурын тухай явган яриа, иргэдийн дундах мэдээлэл цуглуулах сургалт авсан. Харин оролцогч талуудын судалгааг тусгай баг хариуцаж, эх сурвалжид таарсан, хагасчилан бэлдсэн ярилцлагад шаардлагатай төхөөрөмж, хэрэгцээт зүйлсийг хангаж өгсөн.

2005 оны судалгаатай харьцуулбал 2016 оны судалгаа нь чанарыг улам сайжруулах, дүн шинжилгээг нухацтай хийхэд ихээхэн цаг хугацаа гаргасан. Судалгаа 2015 оны 3 сараас 2016 онд 4 сар хүртэл нэлээд хэдэн сарын туршид үргэлжилсний зэрэгцээ үр дүнг эцэслэх, тайлан бэлтгэх, хэвлэн нийтлүүлэх зэрэг үйл ажиллагаанд их хугацаа зарцуулсан.

Зураг 2. Судалгааны календарь



# Судалгааны хэрэглэгдэхүүн

Өмнө 2005 онд хийсэн судалгааны нэг томоохон сургамж нь судалгааны хэрэглэгдэхүүнийг нэмэх, сайжруулах шаардлага байсан юм. Энэ хэсэгт тухайн хэрэгцээний цаад учир шалтгааныг хэрэглэгдэхүүн нэг бүрт хамаарах тайлбарын хамт дурдсан. Эдгээр тайлбарыг судалгааны гурван гол төрөл болох өрхийн, зах зээлийн болон оролцогч талуудын судалгааны хүрээнд бүтэцлэн оруулсан. Судалгааны хэрэглэгдэхүүнийг ийнхүү өргөжүүлэх гурван гол шалтгаан байсан.

- Зах зээлийн өөр өөр сегментүүдэд нийцүүлэх.** Зах зээлийн судалгааны хувьд энэхүү шалтгаан үл ажиглагдахуйц хэмжээнд байсан. 2005 оны судалгаа нь “зах зээлийн судалгааны” нэг л асуулга ашиглан зах зээлийн бүхий л мэдээллийг цуглуулахаар хичээжээ. Гэвч энэхүү хандлага нь төвөгтэй, зах зээлийн ялгаатай олон төрлүүд, тэдгээрт хамаарах зэрлэг амьтны худалдааны өвөрмөц байдлыг тодруулан гаргах боломжийг үгүйсгэжээ.
- Судалгаанд оролцогчид татгалзах.** Зэрлэг амьтны чиглэлээр явагдаж буй үйл ажиллагаа нь 2005 оны судалгаанд зарим нөлөө үзүүлж байсан ч 2016 онд үүнтэй бодит харьцуулалт хийгдээгүй. Шинээр бий болсон, илүү мэдрэгдэхүйц байдлаар хэрэгжиж буй үйл ажиллагаанаас хамааран оролцогчдын зүгээс зах зээлийн судалгаа гэлтгүй бусад судалгаанд

оролцохоос цааргалах нь их байсан. Судалгааны дизайнд үзүүлсэн хамгийн том нөлөөлөл нь өрхийн судалгаан дээр гарсан. Оролцогчид цааргалах боломж өндөр буйн улмаас судалгааны өөр өөр аргачлал болох Үл ижилсүүлэх тооллогын аргачлал хэмээх мэдрэмтгий эмзэг асуултад хүлээгдэж буйгаас доогуур хэмжээнд хариулах магадлалтай үед хэрэглэдэг аргачлал шинээр ашигласан.

- Аман мэдээллийн ач холбогдлын талаарх хүлээлт.** 2016 оны судалгааны хувьд стандарт судалгаа (өрхийн болон зах зээлийн) хийх тохиолдолд бүрэн бус мэдээлэл авах магадлал өндөр байсан. Тиймээс гол мэдээлэгч болон бусад талуудтай хийх ярилцлага нь судалгааны эцсийн дүн шинжилгээнд чухал үүргийг гүйцэтгэхээр байсан. Үүнд дэмжлэг үзүүлэх зорилгоор тухайн ярилцлагын үеэр зорилтот мэдээллийг зохистой байдлаар гаргуулах тусгайлсан хэрэглэгдэхүүнийг боловсруулан гаргасан.

2016 оны судалгаанд 13 хэрэглэгдэхүүн боловсруулан гаргасан нь төрөл бүрийн тоон болон чанарын мэдээллийг стандарт байдлаар, нарийвчлан цуглуулах үйл явцыг хангаж өгөх зорилготой байсан. Зураг 3 дээр судалгааны хэрэглэгдэхүүн бүрийг судалгааны гурван зорилтот бүлгийн дагуу – өрх, оролцогч талууд болон зах зээл- бүтцээр нь харуулсан. Харин дараагийн хуудсанд буй Зураг 4 нь бүх 13 хэрэглэгдэхүүнийг жагсааж, түүврийн хэмжээ, хэрэглэгдэхүүний төрөл, судалгааны үргэлжлэх хугацаа, тусгайлсан зорилтот хувь хүмүүс эсвэл салбарын тухай дэлгэрэнгүй мэдээлэл оруулсан. Дараагийн хэсгүүдэд хэрэглэгдэхүүний агуулга, зориулалтын тухай тайлбарласан.

Зураг 3. Судалгааны хэрэглэгдэхүүнийг бүтцээр нь харуулав

ЗЭЛҮҮД ТАЛ II	
Судалгааны хэрэглэгдэхүүн	
АЙЛ ӨРХҮҮД	ЗАХ ЗЭЭЛ
1 Өрхийн судалгаа	8 Үнийн тайлан мэдээ
2 Ажиглалтын хүүдас	9 Ажиглалтын хүүдас
3 Эрх бүхий удирдах байгууллагуудын ярилцлага	10 Аялал жуулчлалын компаниудын судалгаа
4 Хууль сахиулах байгууллагын асуулга	11 Уламжлалт эмийн судалгаа
5 CITES шинжлэх ухааны зөвлөлийн асуулга	12 Ресторануудын судалгаа
6 ТББ-үүдэн асуулга	13 Жижиглэн худалдааны дэлгүүрийн судалгаа
7 Боловсрол, судалгааны байгууллагуудын асуулга	13 Гол мэдээлэгчийн судалгаа

Зураг 4. Судалгааны хэрэглэгдэхүүн

				Зорилтот бүлэг						
		Түүврийн хэмжээ	Хэрэглэгдэх үний төрөл	Хугацаа	Анчид, загасчид	Төрийн байгууллага	Хууль сахиулах байгууллага	Судлаачид	Бизнес эрхлэгчид, зах зээл	Иргэний нийгэм
1	Өрхийн судалгаа	4,010		20"						
2	Ажиглалтын хуудас	50		5"						
3	Үнийн мэдээ	300		5"						
-	Ажиглалтын хуудас	100		5"						
4	Жуулчлалын компаниудын судалгаа	50		15"						
5	Уламжлалт эмнэлгийн судалгаа	30		15"						
6	Ресторануудын судалгаа	100		15"						
7	Дэлгүүрүүдийн судалгаа	120		15"						
8	Гол мэдээлэгчтэй хийх ярилцлага	150		30"						
9	Захиргааны байгууллагын ярилцлага	5		90"						
10	Хууль сахиулагчидтай хийх ярилцлага	10		90"						
11	Шинжлэх ухааны байгууллагын ярилцлага	1		90"						
12	Иргэний нийгмийн ярилцлага	10		90"						
13	Судлаачидтай хийх ярилцлага	4		90"						

## Судалгааны хэрэглэгдэхүүнийг боловсруулсан нь

Судалгааны хэрэглэгдэхүүн бүрийг боловсруулан гаргахдаа судалгааны баг нь 2005 онд ашигласан хэрэглэгдэхүүнд үе шаттай үнэлгээ хийж, зөвлөмж болгосон өөрчлөлтүүдийг оруулж, үр дүнг судалгааны төрөл бүрээр эмхлэн зохион байгуулсан. Энэ шатанд хийж гүйцэтгэсэн ажлын тоонд дараах үйл ажиллагаа багтсан:

### o Багц асуултуудыг цэгцлэн сайжруулах.

Өрхийн болон зах зээлийн судалгаанд зориулан 2005 оны судалгаанд ашигласан бүх асуултыг доорх зүйлсийг олж тогтоохын тулд дэлгэрэнгүй судлан үзсэн:

1. Хариултын хувь хэмжээ доогуур байх – жишээ нь зарим асуултад зөвхөн цөөн тооны оролцогчид хариулсан бөгөөд энэ нөхцөл байдал 2016 онд өөрчлөгдөнө хэмээн тооцоогүй,
2. Хэрэгцээгүй хариулт – жишээ нь зэрлэг амьтны махны жинг асуухад хариултын тоо өндөр ч найдвартай, үнэн зөв мэдээлэл гаргах авах боломжгүй,
3. Хариултын үнэн зөв байдал муу байх – жишээ нь зарим тохиолдолд асуултууд нь эргэлзээтэй улмаас өгсөн хариултууд нь хүлээгдэж байсантай нийцэхгүй байсан.

### o Хэрэглэгдэхүүнд асуултаа хуваарилах.

Хэрэглэгдэхүүн бүрээр анхлан гаргасан судалгааны багц асуултын дагуу хариулт авах боломжтой эсэхийг үнэлсэн. Эдгээр анхдагч асуултуудыг дараа нь хэрэглэгдэхүүн бүрт тархаан хуваарилж, “сайн тохирч” буй эсэхийг хянаж баталгаажуулсан.

### o Хяналт бүхий цэсийн сонголт.

Өрхийн болон зах зээлийн судалгаанд цахим платформ ашигласнаар хариултуудын цэсийн сонголт боловсруулах, ингэснээр нээлттэй асуултаас зайлсхийх боломжтой болсон. Энэ нь мэдээлэл оруулахад гарч болох алдаанаас сэргийлж, оролцогчдын өгсөн хариултыг судлаачид заавал бичиж тэмдэглэх шаардлагагүй болсноор мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг илүү үр ашигтай болгож өгсөн. Хариултуудын сонголтыг 1) тухайн сэдвийн талаарх багийн гишүүдийн туршлага (жишээ нь худалдан борлуулагддаг зэрлэг амьтны төрлийн жагсаалт); 2) 2005 оны судалгаагаар түгээмэл гарсан хариултууд (жишээ нь автомашины төрөл) болон 3) Монгол улсын нийгэм-эдийн засгийн тооллого (жишээ нь оролцогчдын боловсролын түвшин, өрхийн орлогын түвшин зэрэгт өгсөн хариулт) гэсэн гурван гол эх сурвалжаас сонгон авсан.

## Хэрэглэгдэхүүнийг баталгаажуулсан нь

Өрхийн болон зах зээлийн судалгааны хэрэглэгдэхүүний (хэрэглэгдэхүүн #1 - #8) баталгаажуулалтыг 5 ба 8 дугаар сарын сургалтын дараа шууд хийсэн. Харин оролцогч талуудын судалгааны хэрэглэгдэхүүнд (#9 - #13) баталгаажуулалт хийгээгүй. Хэрэглэгдэхүүний ойлгомжтой байдал, түгээлт, хэрэглэхэд хялбар байдал, эргэлзээ гарах магадлал, цэсийн сонголт хангалттай эсэхийг шалгах 239 судалгааг хийсэн. Үүнд 139 өрхийн судалгаа, ажиглалтын 10 хуудас, үнийн 5 тайлан мэдээ, аялал жуулчлалын компаниудын 15 судалгаа, уламжлалт эмийн 10 судалгаа, рестораны 10 судалгаа, жижиглэн худалдааны дэлгүүрүүдийн 40 судалгаа, гол мэдээлэгчдийн 10 судалгаа багтсан. Үүний үр дүнд шаардлагатай тохиолдолд бага зэргийн өөрчлөлт, засварыг хийсэн. Үүнд хамаарсан бүх 8 судалгааны төрөл нэг бүр дээр баталгаажуулалт хийх зорилгоор дараах нэмэлт үе шатуудыг хэрэгжүүлсэн:

1. **Анхдагч баталгаажуулалт** – Хэрэглэгдэхүүн нэг бүрийг ЛАСН, Лийгэл Атласын ажилтнууд үнэлэн, эдгээрийг судалгааны анхдагч багц асуултуудтай тулган шалгаж, тухайн хэрэглэгдэхүүн нь зорилтот мэдээллийг цуглуулахуйц хэмжээнд төлөвлөгдсөн эсэхийг үнэлсэн.
2. **Орчуулга** – Хоёрдугаар шатанд асуултуудыг Монгол хэлэнд орчуулж, Хараат бус судалгааны хүрээлэнгийн ажилтнууд шалгаж, нэгдүгээрт орчуулгын үнэн зөв байдлыг, хоёрдугаарт оролцогчдод эргэлзээ төрүүлэхүйц алдаа байгаа эсэхийг шалган үзсэн.
3. **Туршилтын тест** – Бүх асуултуудыг анхдагч шалгалтад хамруулан, орчуулсны дараа хот болон орон нутаг дахь хоёр байршил дээр цөөн тооны оролцогчдын дунд туршилтын тест хийсэн. Энэхүү үйл ажиллагаанд сургалтад хамрагдсан бүх судлаач оролцож, судалгааны үеэр ашиглах системийг ашиглан туршилт хийсэн.
4. **Фокус бүлгийн хэлэлцүүлэг** – Мэдээлэл оруулах програмын үүсгэсэн автомат тайланг ашиглан, өмнөх туршилтад оролцсон бүх судлаач судалгааг бүхий л талаас нь хэлэлцэж цэсийн мэдээллийг ашиглахад хялбар байдал, асуултуудын асуух үед тохиож болох хүндрэлүүд, мэдээлэл оруулахад тулгарах асуудлууд зэргийг хэлэлцсэн.
5. **Эргэн хянаж, засвар оруулах** – Зарим асуултууд, мэдээлэл оруулах зөврийн судалгааны хэрэгслийн програм хангамж дахь мэдээлэл оруулах процессыг илүү боловсронгуй болгохын тулд багахан өөрчлөлт хийх шаардлага гарсан.

## Өрхийн судалгааны хэрэглэгдэхүүн

Өрхийн түвшинд хийх судалгаанд хоёр хэрэглэгдэхүүн ашигласан нь өрхийн судалгаа ба ажиглалтын хуудас байсан. Судалгаа нь мөн 2005 онд хийсэн судалгааны асуултын дийлэнхэд өмнө дурдсан өөрчлөлтүүдийг хийсэн ба гол нь үл ижилсүүлэх тооллогын аргад хамаарах асуултуудыг багтаан оруулсан явдал байсан (хуудас 11 дээр тайлбарласан). Ажиглалтын хуудас болон үл ижилсүүлэх тооллого дээрх асуултууд нь 2016 онд шинээр нэмэгдэж орсон ба үндсэндээ зэрлэг амьтны чиглэлээрх хуулийн хэрэгжилт чангарч, үүний улмаас оролцогчид өөрт буй мэдээллээ бүрэн гарган өгөхгүй байх эрсдэл, үндсэн оролцогчид болон аман мэдээлэлд найдах болсон зэргээс энэ шаардлага үүдэн гарсан. Хэрэглэгдэхүүнийг дараах хэсэгт нэг бүрчлэн тайлбарласан бөгөөд эдгээрийг тайлангийн хавсралтаас үзэж болно.

### ӨРХИЙН СУДАЛГАА

Өрхийн судалгаа нь 2005 онд хийсэн судалгааны үндсэн хэрэглэгдэхүүн байсан бол 2016 онд өрхийн судалгааг хэд хэдэн судалгааны хэрэглэгдэхүүнтэй хослуулан хэрэглэсэн ч өрхийн судалгаа нь үндсэн аргачлал хэвээр байсан. Үүний шалтгаан нь Монгол Улс нь зэрлэг амьтны дотоодын хэрэглээний эх үүсвэр байж, олон улс дахь зэрлэг амьтны худалдааны оролцогч болохыг сайтар баримтжуулж буйгаас хамаарсан юм. Энэ нөхцөлд, хамаарах өрх, хувь хүмүүс нь худалдааны сүлжээний томоохон хэсэг (ханган нийлүүлэгч эсвэл хэрэглэгч) болж буй юм. Судалгаанд хамрагдсан нэг нэгжид хамаарч буй ч өрх, хувь хүмүүс нь бодит байдал дээр харилцан адилгүй өөр өөр зорилтот бүлгүүд юм. Тэднийг нэг судалгаанд нийлүүлэн багтаах нь өвөрмөц түүврийн хэмжээг (хамгийн олон тоотой дээр нь суурилах) тодорхойлох, үр дүнг гаргахад (аль алиных нь тоон дээр суурилах шаардлагатай) нөлөөлөл үзүүлэх юм.

Өмнө 2005 онд хийсэн судалгаанд үндэслэн 2016 оны өрхийн судалгаа нь үндсэндээ өрхүүд болон 15-аас дээш насны хүмүүст шууд чиглэсэн. Нийт 21 асуултыг зэрлэг амьтан агнах, худалдаалах, ашиглах болон худалдан авах (Хавсралт II дээр үзнэ үү) хэмээх дөрвөн чиглэлд хуваасан.

ӨРХИЙН нэгжид хандсан асуултууд нь зэрлэг амьтны худалдааны суурь болж буй өрхийн нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг, тухайлбал, ам бүл, орлогын эх үүсвэр, эд хөрөнгө зэрэг мэдээллийг тодорхойлон гаргах зорилттой байсан. Хэрэглээ болон худалдаатай холбоотойгоор судалгаанд амьтны зүйл, эд эрхтэн, хэрэглээ, тоо хэмжээ болон үнийн талаар тусгайлан асуултууд оруулан, өрхүүд ямар эрхтнийг нь өөрсдөө ашиглаж, ямрыг нь борлуулж буй талаар мэдээллийг, мөн зах зээл дээр худалдан авч буй бусад зэрлэг амьтны

тухай мэдээлэл авах зорилго тавьсан.

ХУВЬ ХҮМҮҮСТ хандсан асуултууд хоёр үндсэн хэсгийг агуулсны эхнийх нь ерөнхий, бүх оролцогч нарт хандсан хэсэг байв. Энэ хэсгээр тодорхой үүрэг гүйцэтгэж буй хэмээн үзсэн оролцогчдын нас, хүйс, оршин суугаа газар болон бусад шинж байдал, жишээ нь боловсрол, зэрлэг амьтан болон холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдлэгийг судалсан. Эхний багц асуултууд нь мөн 5 болон 10 жилийн өмнө Монгол Улсын зэрлэг амьтны тоо толгой, нөхцөл байдлын талаарх мэдлэгийг тандахын зэрэгцээ төрийн зүгээс зэрлэг амьтны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх боломж, чадавхын тухай судалсан. Төрийн хэрэгжүүлдэг 9 арга хэмжээний (боловсрол, эрх зүй, эдийн засаг болон хууль сахиулах арга хэмжээг хамруулан) жагсаалтыг оролцогчдод үзүүлэн, тухайн арга хэмжээ нэг бүр нь Монгол Улс дахь зэрлэг амьтан хамгааллыг сайжруулах боломжийн тухай санал бодлыг нь асуун тодруулсан.

Хоёрдугаар хэсэг нь оролцогчид 2015 онд загас эсвэл ан амьтан агнасан эсэхийг асууж тодруулсны дараа гүнзгийрүүлэн асуух асуултаас бүрдсэн. Хэрэв тухайн жил загас эсвэл амьтан агнасан гэж хариулах тохиолдолд цааш үргэлжлүүлэн ямар төрөл зүйл болох, тоо хэмжээ, байршил, агнуур/загасчлалын туршлага, агнуурын тоног төхөөрөмж, эд хэрэгсэл эзэмшдэг эсэх, ашигладаг арга техникийн тухай асуусан.

### ҮЛ ИЖИЛСҮҮЛЭХ ТООЛЛОГЫН АРГА (УСТ)

Судалгаанд багтсан эмзэг эсвэл хууль бус асуултад оролцогчдын зүгээс хангалтгүй хариулт өгөх нь олон жилийн туршид гарсаар ирсэн нь тухайн үйлдлийн талаарх үнэн зөв тооцоо, мэдээлэл гарган авахад хүндрэл учруулдаг.<sup>46</sup> Үл ижилсүүлэх тооллогын аргачлал нь эмзэг, хариулахад таагай бус, өөрийгөө буруутгасан шинжтэй хариулт шаардсан асуултад өгөх үнэн зөв хариултын тоог нэмэгдүүлэх зорилго бүхий судалгааны аргачлал юм.<sup>47</sup> Энэхүү аргачлалын талаар судалгааны ажил хийгдэж, тасралтгүй сайжруулж буй бөгөөд үүнийг өргөн хүрээнд ашиглаж, дээр дурдсан нөхцөлд өгч буй үнэн зөв хариултын тоо нэмэгдэж буйг олонтоо мэдээлэх болжээ.<sup>48</sup> Тухайн хариултыг өгч буй хүний нууцлалыг хангах боломжтой тул энэ аргачлалыг амжилттай хэрэглэж буй юм. Дүн шинжилгээний хэсэгт нууцлалыг хэрхэн хангадаг тухай дурдсан ч энд товч хэлэхэд оролцогч нарыг тохиолдлын (case) болон хяналтын бүлэг болгон санамсаргүй хуваах


46 Coutts, E. and B. Jann (2008). Sensitive Questions in Online Surveys: Experimental Results for the Randomized Response Technique (RRT) and the Unmatched Count Technique (UCT). ETH Zurich Sociology Working Paper No. 3

47 Raghavarao, D. болон W. T. Federer (1979). Block Total Response as an Alternative to the Randomized Response Method in Surveys. Journal of the Royal Statistical Society, Series B. 41 (1): 40–45.

48 Жишээ нь., Tsuchiya, Hirai, болон Ono 2007; Holbrook болон Krosnick 2010; Coutts болон Jann 2011.

байдлаар нууцалдаг.<sup>49</sup> Хоёр бүлэгт өөрсдийнх нь хувьд “Үнэн” хэмээн хариулт өгөх зүйлсийн жагсаалт эсвэл өгүүлбэр/хэллэг үзүүлэн, эдгээрт хамаарах “Үнэн” гэсэн хариултыг сонгохыг хүсдэг. Гэхдээ хариулт “Үнэн” гэсэн хариултаар бус зөвхөн тоон байдлаар гарна. Ийм хариултын арай богино жагсаалт ашиглан хяналтын бүлгээс асуух ба эдгээр нь үндсэндээ дундыг баримталсан, ямар нэгэн хүндрэлгүй хариулах боломжтой асуулт байна. Харин тохиолдлын бүлэгт буй хариултаар нэг нэмэлт хариулт байх ба энэ нь тухайн судалгаагаар тогтоон гаргахыг хүсч буй эмзэг зүйлийн талаар байна. Аль асуултад өөрийн тоон хариултыг оруулсан болохоо ил болгохгүй байснаар тухайн эмзэг асуултад илүү өндөр тооны үнэн зөв хариултыг авдаг. Жагсаалтад буй хариултын тоо ялгаатай байснаар (жишээ нь хяналтын бүлэг дээр 3, тохиолдлын бүлэг дээр 4) өөрийн тоон сонголтоор хариулт өгсөн хүмүүсийн дундаас тухайн эмзэг асуудлыг хариултдаа тоог нь математик тооцооллоор гарган ирэх боломжтой болдог.<sup>50</sup> Энэхүү аргачлалыг арьсны өнгөний талаар үзэл бодол<sup>51</sup>, мансууруулах бодисын хэрэглээ<sup>52</sup> болон сүүлийн үед зэрлэг амьтны худалдаа<sup>53</sup> зэрэг олон арвигтай нөхцөлд ашигласаар иржээ.

Зураг 5. Асуулт #1; Хууль бус арга



Хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны орчноос хамааран оролцогчид нь өөрсийн үйлдсэн агнуур, загасчлалын тухай мэдээлэл өгөхөөс цааргалах магадлалтай хэмээн үзсэн тул 2016 оны судалгаанд үл ижилсүүлэх тоон арга ашигласан гурван асуулт багтаасан. Судалгааны багт энэ төсөөллийг бодит байдлаар турших хугацаа байгаагүй ч өөрт буй баримт дээрээ үндэслэн үл ижилсүүлсэн асуултууд нь өөрийгөө буруутгасан шинжтэй нь тодорхой байсан. Энэхүү судалгааны өмнө хийсэн төслүүдийн үйл ажиллагаа, өмнөх судалгаанаас

49 Энэхүү хуваалт нь мөн дотоод хуваалт байх бөгөөд оролцогчид өөрсдөө аль бүлэгт хамаарч буйгаа мэдэх боломжгүй. Судалгааны програм хангамж нь оролцогчийг автоматаар тохиолдлын эсвэл хяналтын бүлэгт тэгш эсвэл сондгой дарааллаар хуваарилдаг.

50 Энэхүү тооцоог гаргахын тулд хэд хэдэн аргачлал ашигладаг ч энэхүү судалгаа нь хамгийн түгээмэл хэрэглэдэг арга болох энгийн ялгааг тодорхойлогч (simple difference-in-means estimator) ашигласан.

51 Kuklinski, Cobb, and Gilens 1997.

52 Droitcour et al. 1991.

53 Hinsley, A., A. Nuno, M. Ridout, F. St John, and D. Roberts (2016). Estimating the Extent of CITES Noncompliance among Traders and End-Consumers; Lessons from the Global Orchid Trade. Conservation Letters, October 2016, 00(0), 1–8.

үзвэл зорилтот хүн ам нь ийм төрлийн асуултуудад нээлттэй, шударгаар хариулт өгөхөөс цааргалах магадлал өндөр байсан.

Зураг 6. Асуулт #2; Хууль бус хэрэгсэл



Асуултад оруулсан үл ижилсүүлсэн асуулт бүр дээр судалгааны баг нь цэсийн сонголтын багцыг ( $j_i$ ) боловсруулан оролцогчид үүнээс 0-оос 'j' хүртэлх хариултыг тоолж, энд 'j' нь тодорхой багц асуултад жагсаалтаар гаргасан цэсэд хамаарах зүйлсийн нийт тоо байна ( $j = \sum j_i$ ). ‘Хяналтын’ хэсэг нь тухайн асуудлыг нээж гаргах магадлал өндөртэй ба багатай хариуг<sup>54</sup> багтааснаар оролцогчийн бүх эсвэл аль ч биш хэмээх хариултыг сонгох боломжийг бууруулдаг.<sup>55</sup> Энэ тохиолдолд тухайн эмзэг асуулт нь бусад асуултаар хамгаалагдсан байдлаа алдаж, үнэн зөв хариулт өгөх магадлалыг бууруулна.<sup>56</sup> Сөрөг хамааралтай хариултыг<sup>57</sup> оруулах нь сайн төлөвлөсөн хэмээн үзэх нэг арга зам хэдий ч хяналтын багцыг үүнийг үл харгалзан боловсруулсан. Сонгууль дөхөж буйтай холбоотойгоор өрхийн судалгаа хийх цаг бага байснаас үүдэн сөрөг байдалтай хариулт зохиож, туршихад цаг гараагүй юм. Цаашид үнэн зөв үр дүн гарган авахын тулд ашиглах шаардлагатай нийт судалгааны тоог бууруулах замаар статистикийн үр ашигтай байдлыг хангах тул туршилтыг заавал хийж байх шаардлагатай.<sup>58</sup>

Үл ижилсүүлсэн #1 болон #2 дугаар асуултуудыг Өрхийн судалгаан дээр хамтад нь хэрэглэсэн. Эдгээр нь өргөн тархсан хэмээн таамаглаж буй хоёр төрлийн хууль бус ан агнуур болох автомашинаар хөөж буудах, шөнө гэрэлтүүлж агнах тухай асуултууд юм.

Гэхдээ асуултуудыг зөвхөн өмнөх нэг жилийн хугацаанд ан хийсэн хэмээн хариулсан хүмүүс дээр ашигласан ба энэхүү баримтад өөрийгөө буруутгасан хариулт өгөхөөс цаарагласнаас үүдэх хазайлтыг тооцон үзээгүй.

54 Хүн амын өндөр болон бага хувь хэмжээнд хандсан мэдээлэл нь баталгаажуулах замаар хариулт өгөх боломжтой.

55 Glynn, A.N. (2013). What can we learn with statistical truth serum? Design and analysis of the list experiment. Public Opin. Quart., 77(S1), 159-172.

56 Hinsley et al, 2016; Droitcour et al. 1991.


57 Сөрөг хамааралтай хариулт гэдэг нь аль алиныг нь үйлддэг хувь хүнийг тодруулан гаргахаас зайлсхийх хариулт юм. Өөрөөр хэлбэл эрүүл хоол байнга худалдаж авдаг хүн байнга түргэн хоол идэх магадлалгүй, эсвэл эсрэгээр байх магадлалгүйг харуулдаг.

58 Glynn (2013).

Зун хийсэн өрхийн судалгааны анхны үр дүнгээр ан хийж байсан хэмээн хариулсан хүмүүсийн тоо илт, огцом бууралтыг харуулсан. 2005 оны судалгаагаар 15-аас дээш насны эрэгтэйчүүдийн бараг 30% нь өмнөх жил ан агнаж байсан гэсэн бол 2016 оны судалгаагаар энэхүү хувь хэмжээ 8% болж буурсан.<sup>59</sup> Гэхдээ тухайн үед орон нутагт ажиллаж байх үедээ аман байдлаар цуглуулсан мэдээллээс харвал энэхүү 8% нь бодит байдлаас хамаагүй доогуур байна.

Энэхүү шалтгааны улмаас Үл ижилсүүлэх тооллогын аргачлалд багтах гурав дахь асуултыг намар боловсруулсан ба энэ удаад ан агнуурт оролцох оролцоонд тулгуурлан асуултыг гаргасан. Хараат бус судалгааны хүрээлэнгийн байнгын хийж гүйцэтгэдэг судалгааны үйл ажиллагаанд тулгуурлан энэхүү нэмэлт үл ижилсүүлсэн асуултыг 2016 онд 9 дүгээр сард үндэсний хэмжээнд хийсэн, хөндлөнгийн өөр судалгаанд оруулж өгсөн. Тэрхүү үл хамаарах судалгааны түүврийн хэмжээний хувьд үндэсний хэмжээнд санамсаргүй сонгосон 16-аас дээш насны эрэгтэй, эмэгтэй 1,500 оролцогч байсан. Энэ нь оролцогчдын нөхцөл, зэрлэг амьтны худалдааны судалгааны зорилгод нийцүүлэн өрхийн судалгааны үр дүн дээр нэмэлт хяналт хийж, ан агнуурын тухай мэдээлэл авах боломжийг хангасан.

Зураг 7. Асуулт #3; Ан агнуурын тухай олж мэдэх



#### Ажиглалтын хуудас

Ажиглалтын хуудсыг (Хавсралт III дээрх хэсгийг үзнэ үү) судалгааны багт албан ёсны асуулга ашиглан судалгаа хийж байхдаа чанарын мэдээллийг зэрэг цуглуулах зорилгоор боловсруулсан. Ярилцлага нэг бүрд зарцуулах хугацаа нь зарим тохиолдолд богинохон (ямар нэгэн харилцаа үүсэхгүй бол) зарим тохиолдолд 30 хүртэл минут үргэлжилсэн бөгөөд өрхийн болон зах зээлийн судалгааны нэг ижил хэрэглэгдэхүүн ашигласан.

Гол зорилго нь үндсэн мэдээлэл, хувь хүнд тохиолдсон явдал, ерөнхий зураглал зэргийг цуглуулахын тулд нэмэлтээр аман байдлаар нотолгоо цуглуулан судалж буй үйл ажиллагааны жишээг баяжуулах байв. Бүх судлаачдад зэрлэг амьтантай холбоотой нөхцөл байдлыг тодорхойлох, жишээ нь судалгааны үеэр

байгаль хамгаалагч нартай санамсаргүй уулзах, гол, нуурын ойролцоо загасчидтай уулзах, ил ил зарж буй үслэг эдлэлтэй холбоотой нээлттэй ярилцах, эсвэл хувиараа эсвэл олон нийтийн дунд зэрлэг амьтантай холбоотой бүтээгдэхүүний талаар ярилцах зэрэг нөхцөлд ажиллах арга барилын талаар сургалт хийсэн.

Эдгээр хуудсуудыг богинохон түүх, явдал болон амьтны зүйлийн талаар мэдээлэл авахаар төлөвлөн боловсруулсан бөгөөд цахим хувилбарт 5 хүртэл тооны зураг, хамаарах баримт бичиг оруулах, огноо болон газрыг бүртгэх, мөн товч тайлбар оруулах (200-аас доош үгэнд багтаан) замаар оролцогчтой ярилцсан зүйлсийг нотлон тайлбарлах боломжтой.

## Зах зээлийн судалгааны хэрэглэгдэхүүн

2016 оны зах зээлийн судалгааны асуултыг боловсруулах эхний шатанд 2005 оны судалгааны үр дүнд гарсан зөвлөмжүүдийг иж бүрнээр нь дахин судлан үзсэн. Үүний зорилго нь агшны судалгааны хэв шинжийг хадгалах явдал байхын зэрэгцээ ихээхэн өөрчлөлт оруулах тохиолдолд өмнөх судалгаанд нөлөөлөхгүй байсанд оршино. Анхдугаар Зэлүүд тал тайлангийн өрхийн судалгаанаас ялгаатай нь зах зээлийн судалгаа нь үндсэндээ ажиглалтын байдалтай байж, статистик шинжилгээ хийхүйц багц мэдээллийг гаргаж ирээгүй. Урьд хийж байсан туршлагагүйгээр өмнөө тавьсан зорилго нь юуг (зүйл, эд эрхтэн, бүтээгдэхүүн), хэнд, ямар үнээр, хэр хэмжээтэйг, хаана худалдаалж буйг баримтжуулах (зарим түвшинд зохистой байдлаар) явдал байсан. Ашигласан аргачлал нь ч улсын хэмжээнд буй зах зээлд хамаарах тоон үзүүлэлт гарган авах зорилго агуулаагүй байсан.

2005 онд хийсэн зах зээлийн судалгаа нь үндсэндээ хоёр үндсэн хэрэглэгдэхүүн ашигласны нэг нь ресторануудын асуулга, нөгөө нь зах зээлийн төрлүүд болох бөөний зах, хүнсний дэлгүүр, контейнер, ТҮЦ-үүд, жуулчдын дэлгүүр, эмнэлэг болон бэлэн хувцасны зах зээл зэргийг хамарчээ. Үндсэндээ боломжит мэдээллийн төрөл нь тухайн зах зээлийн сегментээс хамааралтай байсан. Хоёр хэрэглэгдэхүүнийг аль болох өргөн хэмжээнд байхаар боловсруулж, зарим тохиолдолд зөвхөн загасчлалд хандуулж контейнер дэлгүүрүүдэд хэн юуг борлуулж буйг олж тогтооход чиглэж байсан. Харсан, сонссон ямар нэгэн зүйлийг илүү мэдэж авахын тулд мэдээллийн хуудас нь урт, хэрэглэхэд хэцүү байдаг байв. Гэхдээ эдгээр нь ашиглахад боломжийн, тодорхой үр дүнтэй байсан ч цаашид сайжруулах хэрэгцээ байсаар байгаа билээ.

Боломжит бүх эх сурвалжаас зах зээлийн тухай мэдээлэл цуглуулах зорилгоор нийт 7 хэрэглэгдэхүүнийг боловсруулан ашигласан:

- Жижиглэн худалдааны дэлгүүрийн судалгаа
- Аялал жуулчлалын компаниудын судалгаа

59 15-аас дээш насны 2,518 эрэгтэйгээс 199 нь өмнөх жил ан хийсэн хэмээн хариулсан нь 7,903%-тай тэнцэж байна.

- o Ресторануудын судалгаа
- o Уламжлалт эмийн судалгаа
- o Үнийн тайлан мэдээ
- o Гол мэдээлэгчийн судалгаа
- o Ажиглалтын хуудас

Ажиглалтын хуудасны талаар өмнөх Өрхийн судалгааны хэрэглэгдэхүүн тайлбарлахад дурдсныг санаж буй бизээ. Үлдэх зургаан хэрэглэгдэхүүний зорилт, агуулгыг дараагийн хэсэгт тоймлон харууллаа. Хэрэглэгдэхүүн тус бүрийг энэхүү тайлангийн хавсралтад оруулсан болно.

## ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ ДЭЛГҮҮРИЙН СУДАЛГАА

Энэхүү хэрэглэгдэхүүнийг (Хавсралт IV) зэрлэг амьтны бүтээгдэхүүн борлуулж буй бүх дэлгүүрүүд, үүнд жижиглэн худалдааны захууд, хувцас хэрэгслийн дэлгүүр, үнэт эдлэлийн дэлгүүр, эртний эдлэлийн дэлгүүр болон зэрлэг амьтны бүтээгдэхүүн, загас зарж буй дэлгүүрт судалгаа хийхэд зориулан боловсруулсан. Энэхүү ярилцлагыг 15 минутад хийхээр төлөвлөж, дэлгүүрт худалдаалж буй гурван гол зэрлэг амьтны хамааралтай бүтээгдэхүүн дээр хийсэн. Судалгаагаар бүтээгдэхүүн нэг бүр дээр тухайн зүйлийг тогтоох, гарал үүсэл, хэрэглээ, үнэ болон улиралд, сард борлуулдаг хамгийн дээд хэмжээг судалсан.

## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН КОМПАНИЙН СУДАЛГАА

Судалгааны багийн зүгээс аялал жуулчлалын компаниудыг чухал оролцогч тал хэмээн тооцож зах зээлийн судалгаанд хамруулсан ба үүнд ан агнуурын үйл ажиллагаа явуулдаг, бизнесийн үйл ажиллагаа нь Монгол Улсын байгаль орчин, зэрлэг ан амьтанд суурилан явагддаг (байгалийн зураг, байгалийн аялал, шинжлэх ухааны аялал гэх мэт) компаниудын аль алиныг багтаасан. Эдгээр компаниудын төв оффис нь Улаанбаатар хотод байдаг тул энэ судалгааг үндсэндээ нийслэлд хийсэн. Нэг судалгааг ойролцоогоор 15 минутад багтаан хийхээр төлөвлөсөн ба компанийн менежер, эзэмшигч болон ажилтнуудад чиглэсэн.

Судалгаанд (Хавсралт V) үйлчлүүлэгч, агнуур/загасчлалболон ерөнхий үзэл бодол хэмээх гурван хэсэгт хуваасан нийт 12 асуултыг багтаасан. Эхний хэсэг нь бүх оролцогч нарт чиглэсэн ба тэдгээрийн үйлчлүүлэгч нар аль улсын иргэд болох, нийт үйлчлүүлэгчдийн тоо, тэдний зорилго зэрэг мэдээллийг цуглуулсан. Ан агнуурын хэсэг нь агнуурын, загасчлалын аялал зохион байгуулдаг компаниудад чиглэн агнадаг амьтны зүйл, өнгөрсөн жил агнасан хэмжээ зэргийг судалсан. Мөн энэ хэсэгт галт зэвсэг, ан агнуур, чихмэл болон гадаадад гаргах зөвшөөрөлтэй холбоотой компанийн үүрэг рольд хамаатай асуултыг оруулсан. Хариулах сонголтууд нь чихмэлийн үйлчилгээ үзүүлэгч зэрэг байгууллагын оролцоо, CITES-ын зөвшөөрөл, орон

нутгийн зах зээлд мах борлуулах зэрэг шууд бус оролцооноос иж бүрэн оролцоо хүртэл бүхий л сонголт багтсан. Сүүлийн хэсэгт зэрлэг амьтны статус, хууль бус худалдаатай тэмцэх төрийн чадавх зэрэг ерөнхий санал бодлыг Өрхийн судалгаагаар асуусны адил оруулсан (солбицуулан эшлэх).

## РЕСТОРАНЫ СУДАЛГАА

Өрхийн судалгааны үр дүнгээр тухайн үйл ажиллагаа нь чухал ач холбогдолтой хэмээн тогтоогдсоны дараа энэхүү судалгааг загасны махаар үйлчилж буй ресторануудыг зорилтот бүлэг болгон хийхээр төлөвлөсөн. Судалгааны зорилго нь ресторануудаар үйлчлүүлэгчдийн загасны махаар бэлтгэсэн хоолны хэрэглээ нэмэгдэж буй сүүлийн үеийн хандлагыг судлах, ресторануудад ямар бүтээгдэхүүнээр түгээмэл үйлчилж буйг олж тогтоох, ханган нийлүүлэлтийг сүлжээ нь хэрхэн ажилладаг болохыг ойлгох, гол үйлчлүүлэгчид нь хэн болох, жишээ нь гадаадын иргэд эсвэл хэрэглээний энэхүү хэв шинж нь монгол үйлчлүүлэгчдийн гол хандлага болоод буй эсэх зэргийг олж тогтоох явдал байлаа. Рестораны эзэд, менежерүүдэд шууд хандсан энэхүү судалгааг 15 минутад багтаан авахаар төлөвлөсөн (Хавсралт VI дээр үзнэ үү).

Жижиглэн худалдааны дэлгүүрүүдийн хувьд энэхүү судалгаагаар ресторануудад зарагдаж буй загасны гурван гол бүтээгдэхүүнийг асуусны дараа загас нэг бүрийн талаар дэлгэрэнгүй хэд хэдэн асуултыг асууж, жишээ нь гол загасны орц эсвэл төрөл, хаанаас, хэзээ, ямар хэлбэрээр (лаазалсан, хөлдөөсөн, шинээр нь), ямар давтамжтай, ямар үнээр худалдан авдаг болохыг тодруулсан. Энэ бизнесийн сегментийн хэмжээг тооцох зорилгоор ресторануудаас сард борлуулдаг загасан бүтээгдэхүүний дээд хэмжээг мөн асуусан. Улмаар ресторануудаас энэхүү сегментийн динамикийн болон өрсөлдөөний хандлага, үнэ, ханган нийлүүлэлт, бүтээгдэхүүн, худалдан авалтын төлөвлөгөө, хэрэглэгчдийн сонголт зэрэгт гарч буй хандлагыг судалсан. Эцэст нь оролцогчдоос ресторануудад зарагдаж буй загасаар бэлтгэсэн хоолны зах зээлийн сегмент нь нэмэгдэж буй, тогтвортой буй эсвэл буурч буй нь ажиглагдаж байгаа эсэхийг лавласан.

## УЛАМЖЛАЛТ ЭМИЙН СУДАЛГАА

Судалгааны энэ хэсэг нь (Хавсралт VII) зэрлэг амьтны худалдааны гол салбар болох уламжлалт эмийн бүтээгдэхүүнд төвлөрсөн.<sup>60</sup> Уламжлалт эмнэлгийн талаарх судалгаанд хамрагдагч нь хувь хүмүүс буюу уламжлалт эмийн үйлдвэрийн ажилтнууд, уламжлалт эм хэрэглэгч өвчтөнүүд, бүтээгдэхүүн борлуулагч нар

60 Англи хувилбар дээр TCM буюу “Хятад уламжлалт эмнэлэг” хэмээх товчлолыг “ТМ” буюу уламжлалт эмнэлэг хэмээх үгтэй хослуулан хэрэглэсэн бөгөөд энэхүү тайланд “уламжлалт эмнэлэг” хэмээх ерөнхий нэрийг ашигласан нь Англи хувилбарын адил “Хятадын уламжлалт эмнэлэг” хэмээх утгыг илэрхийлээгүй болно.



юм. Гол асуултууд уламжлалт эмийн талаар мэдлэг бүхий тухайн хүмүүст шууд хандаж, тухайн газар нутагт ашиглаж, худалдаалж буй түгээмэл эмийн бүтээгдэхүүнийг олж тодруулах зорилготой байв. Оролцогчийн өөрийнх нь туршлагад тулгуурласан асуултууд буюу тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэдэг эсэх талыг хөнддөггүй. Асуулга нэг бүр нь 15 минутад багтахаар бодож төлөвлөсөн.

Асуулгаар уламжлалт эмийн зориулалтаар хамгийн түгээмэл ашигладаг зэрлэг амьтны нэр болон эд эрхтэн, эмчилгээний төрөл, ханган нийлүүлэлтийн сүлжээний тухай мэдээлэл (нийлүүлэгчийн төрөл, гарал үүсэл) зэргийг судалсан. Эхний асуулгаар уламжлалт эм хэрэглэгчид Монголд үйлдвэрлэсэн эсвэл гадаадад үйлдвэрлэсэн (Хятад маягийн эмчилгээ Монгол улсад дэлгэрсэн байдаг тул Хятад улс ч үүнд багтсан) бүтээгдэхүүний алийг илүүд үздэгийг асуусан. Хоёр дахь асуулт нь тухайн оролцогчийн амьдран суудаг газарт уламжлалт эмнэлэгээр хэр үйлчлүүлдэг тухай асуусан нь Монгол Улс дахь зэрлэг амьтны худалдаанд уламжлалт эмнэлэг томоохон үүрэгтэй хэвээр буй эсэхийг баталгаажуулах зорилготой байсан.

## ҮНИЙН ТАЙЛАН МЭДЭЭ

Энэ хэрэглэгдэхүүнийг (хавсралт VIII) судлаачид нэг байршил дээрх (зах, дэлгүүр) зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний үнийг судлан тэмдэглэхэд ашигласан. Системд жагсааж оруулсан төрөл зүйл нь Зэлүүд тал анхдугаар тайланд орсон 62 төрөл зүйл дээр үндэслэсний зэрэгцээ 2016 оны өрхийн судалгаанд багтсан төрөл зүйлээр хязгаарлагдаагүй. Аюулгүй, боломжтой хэмээн үзсэн тохиолдолд тодорхой бүтээгдэхүүний зах зээлийн үнийг шууд асууж, дараа нь (борлуулж буй этгээдийн хажууд бус) тэмдэглэн авч байсан. Мэдээллийн хүснэгт нь борлуулж буй этгээдийн хэлж буй нөхцөлөөр, жишээ нь үслэг эдлэлийг ширхгээр, махыг килограммаар, бүтэн амьтнаар, хувцас болон үнэт эдлэлээр тэмдэглэн авах боломжийг судлаачид олгож байсан. Энэхүү маягыг мөн Монгол Улсын зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн борлуулж, сурталчилж буй вэбсайтын үнийг баримтжуулахад мөн ашигласан.

## ГОЛ МЭДЭЭЛЭГЧИЙН АСУУЛГА

Энэхүү асуулгыг (Хавсралт IX) оролцогч талуудын ярилцлагаас илүү хурдан хугацаанд (ойролцоогоор 30 минут үргэлжилдэг) чанарын мэдээлэл цуглуулах зорилгоор боловсруулсан. Асуултыг гаргахдаа гол сонирхож буй сэдвийг олж тогтоох, үүний тулд судлаачийн хийх ярилцлагыг чиглүүлэх асуултыг гарган өгсөн нь ярилцлагад хамрагдаж буй хүний байдлаас хамааруулан уян хатан хандах боломжийг нээсэн.

Зорилгот мэдээллийн сэдвийн хувьд тухайн бүс нутагт ямар зүйлийг агнан, худалдаалдаг (төрөл, хэрэглээ болон улирал), “хэн” оролцдог (анчид, худалдаачид,

боловсруулагчид, үйлчлүүлэгчид, хууль сахиулах ажилтнууд), амьтныг “хэрхэн” агнадаг (тоноглол, арга), худалдааны эдийн засгийн нөхцөлүүд (зөвшөөрлийн төлбөр, торгууль, ан агнуур хийх зардал, борлуулах үнэ, сүлжээний дагуу олох ашиг), ложистик (тээврийн хэрэгсэл, зам, хилийн боомт, хадгалах байгууламж) болон хууль сахиулах үйл ажиллагаа, чадавх (эргүүл хяналт, олж илрүүлэн хураан авах, хууль сахиулахад ашиглах тоног төхөөрөмж, иргэдийн хамтын ажиллагаа гэх мэт) зэргийг олж тогтоон, дүрслэн үзүүлэхэд чиглэсэн.

## Оролцогч талуудын судалгааны хэрэглэгдэхүүн

Голлох оролцогч талуудтай хийх хагасчилан бэлдсэн ярилцлагад зориулан нийт 4 асуулгыг боловсруулсан. Тэдгээрийг Лийгэл Атласын баг Улаанбаатар хотод хийсэн судалгааг чиглүүлэхэд болон тухайн сэдвээр суурь мэдээлэл цуглуулахад ашигласан. Ярилцлага нэг бүр нь дунджаар 90 минут үргэлжилсэн. Асуултууд нь тухайн оролцогч талын мэдлэг сайтай байх магадлал бүхий мэдээлэл, зэрлэг амьтны худалдааны талаар, үүнд төрийн байгууллагаас гарсан мэдээлэл, статистик, өмнө хийсэн судалгаа, тайлангууд, хууль тогтоомж болон бусад сэдвийг хамарсан. Асуулгыг зорилтот оролцогч тал нэг бүрд тааруулсан ба үүнд:

- **Эрх бүхий удирдах байгууллагуудын асуулга (Хавсралт X дээр үзнэ үү)**
- **Хууль сахиулах байгууллагын асуулга (Хавсралт XI дээр үзнэ үү)**
- **SITES шинжлэх ухааны зөвлөлийн асуулга (Хавсралт XII дээр үзнэ үү)**
- **ТББ-ууд болон олон улсын байгууллагуудын асуулга (Хавсралт XIII дээр үзнэ үү)**

Эдгээр асуулга нэг бүр нь тухайн чиглэлд хамаарах сонирхож буй сэдвийг (жишээ нь зэрлэг амьтны худалдааны эдийн засгийн нөхцөл байдал, хамгааллын асуудлууд, хил дамнасан хамтын ажиллагаа гэх мэт) тодорхойлон, тухайн асууж тодруулах зүйлсийн хэсэг бүр дээр холбогдох асуултуудыг оруулж өгсөн.

# Түүвэрлэлтийн дизайн

Эзлүүд тал хоёрдугаар тайлан нь 2005 оноос хойш Монгол Улсад хийсэн зэрлэг амьтны худалдааны талаарх анхдагч, иж бүрэн агшны судалгаа юм. Судалгааны арга зүйг боловсруулан гаргахдаа хамгийн анх ашигласан аргачлалыг үндсэнд нь баримталж, зарим нэгэн дутагдалтай талуудыг нь сайжруулах стратегийг баримталсан. Энэ шалтгааны улмаас 2016 онд хийсэн судалгаа нь өрхийн түүвэрлэлтийн дизайн, мэдээлэл цуглуулах тал дээр хоёр чухал зүйлийг нь давтан хэрэгжүүлсний тоонд түүвэрлэлтийн хэмжээ болон судалгаанд хамрагдах өрхүүдийг тодорхойлох гаргахад ашигласан арга техникүүд (давхарга, шугаман огтлолцол болон санамсаргүй аргачлал) байв. Гэхдээ 2016 оны судалгааны дизайны хувьд цөөн тооны өөрчлөлт хийх шаардлагатай, хэрэгцээтэй байсан. Дараах хэсэг дээр анхдугаар болон хоёрдугаар судалгаа хоорондын түүврийн дизайн дахь үндсэн ялгаатай талуудыг тоймлон харуулсан.

## ӨРХИЙН ТҮҮВЭРЛЭЛТИЙГ САЙЖРУУЛСАН НЬ

2005 онд хийсэн судалгааг үндэсний хэмжээнд төлөвлөж, 21 аймаг болон Улаанбаатар хотод түүврийг тэгш тархаан хуваарилжээ. Судалгааны үйл ажиллагаанд ложистикийн зарим асуудал тулгарсны улмаас бүх аймгийг судалгаанд тэгш хамруулж чадаагүйгээс зарим аймгийн төлөөлөл хэтрэх, зарим нь багадаа хүргэсэн. Үндсэндээ нийт судалгааны бараг 70%-ийг зөвхөн 7 аймгаас (Төв, Завхан, Дорноговь, Хөвсгөл, Увс, Өвөрхангай, Өмнөговь), мөн Улаанбаатар хотоос цуглуулсан бол бусад 14 аймаг нь түүврийн ердөө 30%-ийг л хангасан.

Зэрлэг амьтны төрөл зүйлээр баялаг аймгууд болох Сэлэнгэ, Ховд, Архангай, Дорнод, Хэнтий аймгууд нь түүврийн хэмжээ багатай болсон. Аймаг бүр дээр статистик дизайны (жишээ нь тодорхой газар нутагт очих боломж болон түншлэгч байгууллага үйл ажиллагаа явуулж буй эсэх) дагуу бус харин амар хялбар, тухтай байдлыг харгалзан зарим түүврийн кластерийг тогтоосон.<sup>61</sup> Эцсийн түүвэрлэлт болон аймгийн хүн ам хоорондын корреляци хамаарлыг судлан үзэхэд хялбар байх шалгуураар ажилласнаар ихээхэн хазайлт үүсжээ. Жишээ нь Дорноговь аймгаас 1,000 оршин суугч бүрээс 7 судалгаа авсан бол Орхон аймагт энэ харьцаа 0.1/1,000 байсан. Эдгээр бүхий нөхцөл байдлыг үндсэн тайлан дээр судалгааны сул тал болон үүнээс үүдэн гарч болох буруу тал хэмээн ил тод дурдан тайлбарласан.

Үндэсний хэмжээнд судалгааг явуулах гол зорилго

61 Wingard, J. and P. Zahler, 2006.

2016 онд хэвээр байсан ч өмнөх сургаждаа үндэслэн газар зүйн кластеруудыг илүү үр дүнтэй сонгох, улсын хэмжээний хандлагыг төлөөлөхүйд мэдээлэл цуглуулахын тулд сайжруулсан аргачлалыг боловсруулан ашигласан. Тиймээс эдгээр хоёр судалгаа хоорондын үндсэн ялгаа нь түүврийн дизайнд оршиж байсан. 2016 оны энэхүү судалгааг нь тав тухтай байдлын шалгуурыг үл хайхран нийгэм, эдийн засаг болон байгаль орчны шалгуурын хүрээнд олон шатлалт түүврийн аргачлалыг мөрдөн хийсэн. Энэ нь дүгнэлт хийхэд илүү тохиромжтой иж бүрэн мэдээллийг ханган өгснийг дараах хэсэгт тусган үзүүлээ.

## ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТИЙГ САЙЖРУУЛСАН НЬ

2005 онтой харьцуулбал 2016 оны судалгаанд зэрлэг амьтны зах зээлийн сонголтоор газар зүйн хувьд бүх нутаг дэвсгэрийн бүрэн төлөөллийг хамруулах зорилгыг урьдал болгоогүй. Шууд зорилт нь зэрлэг амьтны худалдааны өртгийн сүлжээний дагуух худалдааны цэгүүдийг судлах, үүнд улсын хэмжээний бөөний болон жижиглэнгийн захууд, онлайн (интернетэд суурилсан) худалдаа болон олон улсын худалдааг хамруулах явдал байсан. Худалдааны эдгээр цэгүүд нь тодорхой газруудад байх ч улсын хэмжээнд нэгэн зэрэг ажилладаггүй. Тиймээс түүвэрлэлт нь зэрлэг амьтны худалдааны үүсээд буй өртгийн сүлжээнд илүүтэй суурилан хийгдсэн.

2005 оны судалгаанд 1,100 байсан зах зээлийн судалгааны түүврийн хэмжээ 2016 оны судалгаагаар 850 болж буурсан ч зах зээлийн сегментүүд, тохиргоо хийсэн хэрэглэгдэхүүн, түүвэрлэлтэд ашигласан нэмүү өртгийн сүлжээний аргачлал зэргийн үр дүнд чанарын хувьд илүү сайжирсан.

## Өрхийн түүвэрлэлт

### ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ

Өмнө хийж байсан 2005 оны судалгаагаар түүврийн хэмжээг ( $n=4,010$ ) гаргасан явц нь статистик тооцоолол гэхээсээ илүүтэйгээр судалгааны баг нь олон байгууллагын төлөөллөөс бүрдсэн, судалгааны мэдээлэл цуглуулах боломж зэргээс хамааралтай байжээ. Харин бидний жишээн дээр 100,000 дээш хүн амд 400 орчим түүврийн хэмжээ байх нь статистикийн зохистой итгэлцлийн түвшинг бүрдүүлэхэд хэт том байсан. Алдааны хүлцэх түвшин болон итгэлцлийн түвшин ( $\alpha$ ) нь хамтдаа тухайн мэдээллийн үнэн зөвийг харуулдаг статистикийн хоёр параметр бөгөөд өөрөөр хэлбэл түүвэр нь хүн амын зан төлөвийг тодорхойлон гаргахдаа хэр найдвартай сайн болохыг харуулдаг. Түүврийн дизайн нь санамсаргүй байх үед 400 хүнийг

түүвэрлэлтэд хамруулах нь 5% алдааны хүлцэх түвшин<sup>62</sup> болон 95% итгэлцлийн түвшинтэй<sup>63</sup> байх нь статистикийн хувьд түгээмэл хүлээн зөвшөөрдөг үзүүлэлт юм. Түүврийн дизайн нь бүхэлдээ санамсаргүй бус бол, жишээ нь энэхүү судалгаан дээр, түүврийн хэмжээг нэмэгдүүлэх нь гарч болох хазайлтыг нөхөж болох стандарт арга зам юм. 2005 оны судалгааны түүвэрлэлт нь санамсаргүй түүвэрлэлт бүхий судалгаанд шаардагдах минимум хэмжээнээс 10 дахин их байжээ. Үүнийг түүврийн хэмжээ тооцох томьёонд эргүүлэн оруулахад<sup>64</sup> 4,010 хэмээх түүврийн хэмжээ нь 99% итгэлцэх түвшин, 2% хүлцэх алдааны түвшинд буй нь санамсаргүй түүвэрлэлт ашиглахад аль ч тохиолдолд хэвийн стандартаас дээгүүр байна.

Иймд түүврийн хэмжээнд 2016 оны судалгаагаар ямар нэгэн өөрчлөлт ороогүй ба түүврийн хэмжээ өндөр буйд түшиглэн энэ цэвэр санамсаргүй түүвэр ашиглаж болохгүй гэсэн үзүүлэлтийг тэнцвэржүүлж өгснийг дараах хэсгээс үзэж болно.

## ОЛОН ҮЕ ШАТААР БҮЛЭГЛЭХ

Шаардлагатай түүврийн стратеги, Монгол Улсын газар зүйн өвөрмөц нөхцөл байдал, хүн амын нягтрал зэргийг харгалзан үзэхдээ 2016 оны судалгааны түүврийн дизайн, мэдээлэл цуглуулах стратеги нь бүлэглэлт, шугаман системт түүвэр болон санамсаргүй сонголт хэмээх гурван аргачлалд суурилсан. Дараах хэсгүүдэд өрхийн судалгааны түүврийн сонголтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл, үе шатуудыг харуулсан.

## НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТ: АЙМАГ СОНГОХ

Монгол Улсын засаг захиргааны нэгжээр 21 аймаг, нийслэл Улаанбаатар хот нь түүвэрлэлтийн дизайны суурь болсон. Эдгээр 22 бүлгээр нийт хүн амыг хуваан ашигласан. Судалгааны төсөв нь нийт газар нутгийн ойролцоогоор 60%-д хүрч ажиллах хэмжээнд байсан тул 22 бүлгээс 14-ийг нь сонгох хэрэгтэй байсан.

Бүлэг сонголтын эхний шатыг санамсаргүй

62 Алдааны хүлцэх түвшин (margin of error) гэдэг нь тодорхой нэг үр дүнгийн бодит байдлын түвшнийг хэлэх ба жишээ нь түүвэрт буй оролцогчдын 21% нь тодорхой нэг үйлдэл хийдэг бол үүнийг нийт хүн амын 21% +/- алдааны хүлцэх түвшинтэй тухайн үйлдлийг хийдэг гэж үзнэ. Хэрэв манай алдааны хүлцэх түвшинд нь 5% бол А үйлдлийг зорилгот хүн амын 16-26% нь хийдэг гэсэн үг юм.

63 Итгэлцлийн түвшин гэдэг нь түүврээр гарган авсан үр дүн нь нийт хүн амыг хэрхэн бодитоор төлөөлж буйд итгэх бидний итгэлийг хэлнэ. Итгэлцэх түвшнийг тодорхой нэг зан үйлийг хийдэг хүн амын бодит хувь хэмжээ нь тодорхойлсон алдааны хүлцэх түвшинд байх магадлалаар илэрхийлэгдэнэ. Хамгийн түгээмэл ашигладаг итгэлцэх түвшин нь 95% байдаг нь тодорхой үр дүн, жишээ нь А үйлдлийг 16-26% нь үйлддэг гэдэг нь үнэн байх 95%-ийн боломжтой гэсэн үг юм.

64  $n = (Z\alpha)^2 (\sigma) (1 - \sigma) / MOE^2$ ; “n” нь түүврийн хэмжээ; “Z-score” энгийн тархалтын санамсаргүй хувьсагч; “α” нь итгэх эсвэл ач холбогдлын түвшин; “σ” нь стандарт хазайлт; болон “MOE” алдааны хүлцэх түвшнийг илэрхийлнэ.

түүвэрлэлтээр сонгоогүй. Хамгийн гол нь сонгон авсан бүлэг нь Монгол орны нийгэм-эдийн засаг болон экологийн нөхцөл байдлыг төлөөлсөн байх нь чухал ач холбогдолтой байсан. Монгол орны өргөн уудам газар нутаг, хүн амын нягтаршил бага байдал нь бүлгийг санамсаргүй сонгосноор зэрлэг амьтны худалдаанд нягт уялдаатай параметруудийг, жишээ нь өрхийн худалдан авах чадвар эсвэл тухайн нутагт нутагшсан төрөл зүйл зэрэг параметрууд дээр хазайлт үүсгэх боломжтой юм. Энэ шалтгааны улмаас авч хэрэгжүүлсэн эхний алхам нь Монгол Улс дахь зэрлэг амьтны худалдааны хөдөлгөгч хүчин зүйлсийг олж тогтоох, улмаар энэхүү эхний шатны сонголтын үйл явцад шаардлагатай мэдээлэл авахуйц үзүүлэлтүүдийг тодорхойлох явдал байсан.

Үүнийг харгалзан 5 үзүүлэлтийг гарган авсан нь 1) голлох зүйлийн хамрагдалт; 2) экологийн бүсчлэл; 3) хүн амын нягтшил; 4) нэг хүнд ноогдох ДНБ; болон 5) өрсөлдөх чадварын индекс зэрэг байсан. Эдгээр 5 шалгуур бүр дээр албан ёсны статистикийн эх сурвалжаас холбогдох утгуудыг олж тогтоосон. Дөрвөн шалгуур дээр өндөр, дунд болон бага хэмээн ангилж болохуйц тоон утга тогтоосон. Харин нэг шалгуурын (голлох зүйлийн хамрагдалт) утга нь газрын зураг хэлбэрээр гарсан. Зураг дээр заасан тодорхой утгыг тооцохын оронд энгийн байгаа/байхгүй хэмээх үзүүлэлтийг ашигласан. Үүний нийтлэг зорилго нь түүвэрлэлтийг бүх ангиллаар төлөөллийг өндөр зэрэглэлтэй хийх, хоорондоо ижил эсвэл төстэй аймгуудын орхих явдал байв. Ашигласан үзүүлэлтүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доор үзнэ үү:

- **Зэрлэг амьтны голлох зүйлийн хамрагдалт** – Судалгааны багийн зүгээс нийт 25 гол зүйлийг Монгол Улсын ан агнуур, худалдаанд эзлэх хувь нэмрийнх нь дагуу сонгон авсан.<sup>65</sup> Дараа нь Олон улсын байгаль хамгаалах холбооноос (IUCN)<sup>66</sup> гаргасан тоо хэмжээ, тархац нутгийн зургийг ашиглан тухайн 25 зүйлийг идээшил нутаг болох аймаг болон сумдаар хуваарилан авч үзсэн. Тухайн төрөл зүйл тэрхүү газарт байдаг/байдаггүйг харуулах энгийн матриц ашиглан аймаг бүрд буй төрөл зүйлийг тооцон гаргасан. Жишээ нь 5 оноо нь тухайн аймагт 5 төрлийн амьтан байгаа, тархац нутаг нь болохыг заасан (жишээ нь Дархан-Уул аймагт); 17 гэсэн оноо нь нийт 25 төрөл зүйлийн 17 нь байдаг (жишээ нь Завхан, Увс болон Ховд аймгууд) болохыг заана. Эцэст нь аймгуудыг төрөл зүйл амьдарч буйгаар нь их, дунд болон бага хэмээн тэгш бүлгүүдэд хуваасан.

65 Үүнд ирвэс, голын халиу, борцгор хотон, баданга хүдэр, Монгол бөхөн, хандгай, буга, минж, гургуул, хун, шивэр хилэм, хулан, аргаль, зэрлэг гахай, халиун буга, янгир, хар сүүлт зээр, тул, саарал чоно, идлэг шонхор, тарвага, Алтайн тарвага, хярс, бор гөрөөс багтсан.

66 <http://maps.iucnredlist.org> хаягаар үзнэ үү.

- o Экологийн бүсүүд** – Монгол Улс нь экологийн олон янз байдлын хувьд судалгааны сонирхол татахуйц олон зүйл, ялгаатай экосистемийг хамарсан, ялангуяа тухйн нутагт идээшин амьдардаг төрөл зүйл болон тэдгээрийн ховордсон байдлын хувьд онцлог нутаг билээ. Тиймээс экологийн бүсийг энэхүү анхан шатанд нэмэлт шалгуур болгон ашигласан. Дэ Нэчэ Консерванси (The Nature Conservancy) байгууллагын гаргасан ангилалд түшиглэн, уулархаг, ой тайгын, ойт хээрийн, хээрийн, хагас цөлийн болон цөлийн бүсүүдэд хуваан авч үзсэн.<sup>67</sup> Эдгээр бүс нэг бүрийн газрын зургийг засаг захиргааны зурагтай давхцуулан үзэх замаар түүвэрлэж экологийн бүсийг бүхэлд нь төлөөлөхүйц болохыг шалган баталгаажуулсан.
- o Хүн амын нягтшил** – Энэхүү үзүүлэлтийг Үндэсний статистикийн газраас хамгийн сүүлд 2015 онд хийсэн хүн амын тооллогын мэдээллээс авч, аймаг бүрд нэг км<sup>2</sup> талбайд ноогдох хүний тоог тооцон гаргасан.<sup>68</sup> Түүвэрлэлтийн тархац нь хүн амын тархалтыг төлөөлөхөөр хэмжээнд байхаар зорьсон тул энэхүү үзүүлэлтийг ашиглан аймгуудын хүн амын нягтрал их, дунд болон бага хэмээх бүлэгт хамруулсан.
- o Нэг хүнд ноогдох ДНБ** – Эдийн засгийн энэхүү үзүүлэлт нь аймаг хоорондын эдийн засгийн ялгаа, худалдан авах чадварын ялгаат байдлыг харуулна. Зарим аймаг нь бусадтай харьцуулбал нэг хүнд ноогдох ДНБ нь хоёр дахин их, жишээ нь Өмнөговь аймагт 7,694 ам.доллар байхад Баян-Өлгий аймагт 3,109 ам.доллар байна. Эдийн засгийн энэ үзүүлэлтэд хамаарах мэдээллийг Үндэсний статистикийн газраас авсан.<sup>69</sup> Үүнийг ашиглан аймгуудыг (давхарга) өндөр, дунд болон бага хэмжээний ДНБ-тэй хэмээн хувааж үзсэн.
- o Өрсөлдөх чадварын индекс** – Эдийн засгийн үйл ажиллагаа нь худалдаатай шууд уялдаатай, мөн хууль бус худалдаа нь энэхүү үзүүлэлттэй хамааралтай эсэхийг харуулах ямар нэгэн судалгаа байхгүй ч 2005 оны судалгаа, бусад ажиглалтаас харвал худалдаа нь эдийн засгийн үйл ажиллагаа их буй захууд дээр төвлөрдөг байна. Эдгээр газруудыг түүвэрлэлтэд илүү дутуу хамруулахгүйн тулд, өрсөлдөх чадварыг нэмэлт шалгуур болгон ашиглахаар шийдсэн.

Үүний үр дүнд Улаанбаатар хот болон 13 аймгийг Монгол улсын нийгэм, эдийн засаг болон байгаль орчны олон янз байдлын төлөөлөл болгон авлаа.

## Хүснэгт 2. Сонгосон аймгууд, бүсээр

<b>БАРУУН БҮС</b>	(1)	Увс
	(2)	Ховд
	(3)	Завхан
	(4)	Говь-Алтай
<b>ХАНГАЙН БҮС</b>	(5)	Өвөрхангай
	(6)	Архангай
	(7)	Хөвсгөл
	(8)	Баянхонгор
<b>ТӨВИЙН БҮС</b>	(9)	Дархан-Уул
	(10)	Сэлэнгэ
	(11)	Өмнөговь
<b>ЗҮҮН БҮС</b>	(12)	Хэнтий
	(13)	Дорнод

Монгол улсын **Баруун бүсээс** дөрвөн аймгийг (Увс, Ховд, Завхан, Говь-Алтай) оруулж, харин нэг аймаг (Баян-Өлгий) багтаагүй. Судалгааны ажлын шаардлага, тохиромжтой байдлыг харгалзан Баян-Өлгий аймгийг сонгоогүй. Нутгийн баруун хэсэгт орших энэхүү аймагт хүрч очиход хүндрэлтэй, боломжит цаг хугацааг харгалзан үзвэл түүвэрлэлтэд хамруулах нь өндөр зардалтай, цаг ихээр зарцуулахаар байсан. Тус аймгийн багтаалгүй үлдээх нь зарим талаар хазайлт үүсгэж болох ч энэхүү аймаг нь зэрлэг амьтны худалдаанд хамаарах нэг амьтны (Алтайн тарвага буюу *Marmota baibacina*) тоо толгой болон тархалт нь бусад аймагтай давхцдаггүй, дангаар байдаг аймаг юм. Мөн тус аймаг нь соёлын цөөнх болох казах үндэстэн голчлон амьдардаг нутаг юм. Казах иргэдийн ан агнуурын аргачлал нь бусад Монгол Улсын үндэстэн, ястнаас ялгаатай бөгөөд бүргэдээр ан хийдэг газар юм. Гэхдээ энэхүү аргачлал нь агнаж буй төрөл зүйл болон/эсвэл худалдааны түвшинд нөлөөлж буй эсэх нь тодорхойгүй. Бусдаар Баян-Өлгий нь бусад аймагтай төстэй, жишээ нь тус аймгийн экологийн бүс нь бусад зургаан аймгийг даган үргэлжилж, амьтны голлох төрөл зүйл, нийгэм-эдийн засгийн үзүүлэлтийн хувьд ижил төстэй байсан.

Монгол орны төв болон баруун хэсгийн дунд жийргэвч болон орших Хангайн нуруугаар нэрлэгдсэн **Хангайн бүсээс** дөрвөн аймгийг сонгосон (Өвөрхангай, Архангай, Хөвсгөл, Баянхонгор). Энэ бүсийн хувьд сонголтод багтаагүй цорын ганц аймаг нь Булган юм. Нутгийн хойд хэсгийн ой бүхий бүсэд орших, усны нөөц ихтэй энэхүү аймаг нь Хэнтий, Сэлэнгэ болон Хөвсгөл аймгуудтай ижил төстэй хэмээн тооцсон.

67 Heiner, M., G. Davaa, J. Kiesecker, B. McKenney, J. Evans, T. Enkhtsetseg, Z. Dash, U. Vanchindorj, O. Baast, S. Dolgorjav, G. Radnaabazar, E. (???) Identifying Conservation Priorities in the Face of Future Development: Applying Development by Design in the Grasslands of Mongolia. Available at <https://www.nature.org/media/asia-pacific/east-mongolia-grasslands-ecoregional-assessment.pdf>

68 Үндэсний статистикийн газар. Статистикийн мэдээллийн сан ([www.1212.mn](http://www.1212.mn))

69 Үндэсний статистикийн газар. Статистикийн мэдээллийн сан ([www.1212.mn](http://www.1212.mn))

**Төвийн бүсээс** Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь гэсэн гурван аймгийг сонгосон. Сонголтод хамрагдаагүй үлдсэн аймгууд нь Төв, Дундговь, Орхон, Говьсүмбэр аймгууд байв. Орхон аймгийн хувьд 844 км<sup>2</sup> буюу аймгийн дундаж газар нутгийн 1%-тай л тэнцэх хэмжээний нутаг дэвсгэртэй хамгийн жижиг аймаг юм. Мөн хот суурин газар хэмээх ангилалд багтах цөөн газрын нэг бөгөөд хүн амын нягтрал нь км<sup>2</sup> газарт 125 хүн байна. Тус аймагтай зэргэлдээ Сэлэнгэ, Дархан-Уул зэрэг суурин газрууд бүхий аймгууд, (Улаанбаатар хот сонгогдсон буй тул) Орхон аймгийг судалгаанд хамруулаагүй. Дундговь, Говьсүмбэр аймгууд нь Төв аймгийн өмнөд хэсгээр шууд хил залгаа оршдог тул хүн амын нягтрал, зүйлийн бүрэлдэхүүний хувьд Өмнөговь аймагтай ижил төстэй олон тал байгаа. Төв аймаг нь Монгол Улсын хойд хэсгийн ой бүхий бүсэд багтаж, нөгөө талаар өмнө хэсэгтээ тал, цөлийн бүсийн томоохон хэсгийг багтааж байдаг. Төв аймаг нь түүвэрлэлтэд сонгосон бусад гурван аймагтай ижил экосистемтэйн зэрэгцээ аймгийн эдийн засгийн гол бүсэд байрших Улаанбаатар хот дахь судалгааны хүрээнд багтан орж буй юм.

Эцэст нь **Зүүн бүсэд** хамаарах дөрвөн аймгийн хоёрыг нь (Хэнтий, Дорнод) сонгож, Сүхбаатар болон Дорноговь аймгуудыг сонголгүй үлдээсэн. Монгол орны зүүн бүс нь тал газар, хагас цөлөрхөг болон цөлөрхөг газар нутаг хамарсан, ойн сан бүхий газар нь зүүн хойд хэсэгт Хятад улстай хиллэж буй хэсэгт багахан хэмжээтэй байдаг. Хагас цөлөрхөг болон цөлийн бүсийг өмнөд болон зүүн өмнөд хэсэгт хийсэн судалгаанд түлхүү хамруулсан тул энэ төрлийн экосистем зонхилсон нэг аймгийг (Сүхбаатар) түүврээс хассан. Дорноговь аймаг түүвэрлэлтэд хамрагдалгүй үлдсэн шалтгаан нь хүн амын нягтшил багатай, тал хээр, хагас цөлөрхөг болон цөлийн бүс бүхий нутаг дэвсгэр судалгаанд орсон байсанд оршино.

Нийт хүн амын тоо нь Монгол Улсын нийт хүн амын 50%-ийг эзэлж буй Улаанбаатар хотыг жагсаалтад судалгааны 14 дүгээр давхарга болгон нэмж оруулсан. Үүнтэй ижил 60% хамрагдалтын хязгаарлалтаас үүдэн Улаанбаатар хотын 9 дүүргээс зөвхөн 5-ыг нь судалгаанд хамруулахаар болсон.

Зураг 8 Өрхийн түүвэрлэлт (нэгдүгээр үе шат) дээр ялгаатай үзүүлэлт нэг бүрээр аймгуудаас мэдээлэл цуглуулсан ажлыг зураглан тоймлосон. Сонгосон аймгуудыг цэглэсэн бүсээр харуулж, Монгол Улс дахь олон янз байдлыг хамруулах зорилгыг энэхүү 14 систем/давхарга бүхий бүлгээр төлөөлүүлсэн болно.

Зураг 8. Өрхийн түүвэрлэлт (Нэгдүгээр Үе шат)



## ХОЁРДУГААР ҮЕ ШАТ: СУМ СОНГОХ

Нийт хүн амын тоо, нийт түүврийн хэмжээнд хамаарах хүн амд хүрэх боломж зэргийг харгалзан 13 аймаг бүрээс сонгон авах сумдын тоог гурваар хязгаарлаж, нийт 39 сум сонгосон. Үндсэндээ тухайн аймгийн хүн амын дийлэнх нь оршин сууж буй бүх аймгийн төвийн сумдыг сонгосон. Аймгийн төвөөс гадна аймаг бүрээс дахин хоёр сумыг сонгосон ба энэ удаад санамсаргүй сонголтоор оруулсан. Энэхүү сонголтыг хийхдээ юуны өмнө сумдыг дугаарлаж, улмаар санамсаргүй тоо сонгох програм<sup>70</sup> дээр хоёр оронтой тоог гарган, хамаарах сумдыг сонгон авсан.

Улаанбаатар хотын хувьд нийт 9 дүүргийг дугаарлан, тухайн дугаараас санамсаргүй сонгох байдлаар 5 дүүргийг нь сонгон авсан.

Зураг 9 дээр сонгосон 44 нэгжийн жагсаалт (39 сум, Улаанбаатар хотын 5 дүүрэг), тэдгээрийн газар зүйн байршлыг хоёрдугаар шатанд тодорхойлсны дагуу харуулсан.

70 www.random.org

Зураг 9. Өрхийн түүвэрлэлт (Хоёрдугаар үе шат)



Аймаг	# Сум	Түүврийн хэмжээ	Аймаг	# Сум	Түүврийн хэмжээ
АРХАНГАЙ	1 Эрдэнэбулган	100	СЭЛЭНГЭ	23 Алаг-Эрдэнэ	29
	2 Түвшрүүлэх	15		24 Чандмань-Өндөр	14
	3 Хотонт	21		25 Сүхбаатар	109
БАЯНХОНГОР	4 Баянхонгор	138	УЛААНБААТАР	26 Хүдэр	11
	5 Баянцагаан	16		27 Хушаат	9
	6 Эрдэнэцогт	20		28 Багануур	135
ДАРХАН-УУЛ	7 Дархан	375	29 Налайх	163	
	8 Орхон	15	30 Багахангай	18	
	9 Шарын гол	39	31 Хан-Уул	646	
ДОРНОД	10 Хэрлэн	201	32 Чингэлтэй	757	
	11 Дашбалбар	16	33 Даланзадгад	105	
	12 Саргалан	9	34 Баяндалай	10	
ГОВЬ-АЛТАЙ	13 Есөнбулаг	91	35 Манлай	12	
	14 Халиун	11	36 Улаангом	131	
	15 Цогт	16	37 Давст	8	
ХЭНТИЙ	16 Хэрлэн	96	38 Зүүнговь	12	
	17 Биндэр	19	39 Арвайхээр	145	
	18 Цэнхэрмандал	9	40 Таргагт	15	
ХОВД	19 Жаргалант	127	41 Уянга	44	
	20 Алтай	15	42 Улиастай	75	
	21 Манхан	19	43 Завханмандал	5	
ХӨВСГӨЛ	22 Мөрөн	180	44 Яруу	9	

## ТҮҮВЭРЛЭЛТИЙН ТАРХАЛТ

Тодорхойлон гаргасан судалгааны нийт 44 газар нутагт (39 сум, Улаанбаатар хотын 5 дүүрэг) нийт 4,010 судалгааны материалыг хүн амын тоонд нь үндэслэн хуваарилан судалгааг гүйцэтгэхээр анхлан төлөвлөсөн бөгөөд судалгааны нийт 44 газрын хүн амыг 100% хэмээн тооцсон (835,851 хүн). Аймаг бүрийн хүн амын тоог Монгол Улсын 2015 оны статистик мэдээллээс авч ашигласан.<sup>71</sup>

Зураг 9 нь нийт түүврийг 44 судалгааны нэгжид хэрхэн тархаан хуваарилсныг харуулж буй бол Хүснэгт 3 дээр жишээ болгон судалгааны нэг нэгжид энэхүү тархалтыг хэрхэн хуваарилсан болохыг харууллаа (Нэгж #42).

Хүснэгт 3. Түүвэрлэлтийн тархалтын жишээ (А)

Судалгааны нэгж #42 Улиастай сум (ЗАВХАН аймаг)				
	ХҮН АМ	ТҮҮВЭР		
Судалгааны нэгжийн хүн ам	$N_i$ 15 679	75 $n_i$		Судалгааны нэгжийн түүвэр
Судалгааны нэгжүүдийн нийт хүн ам	$N = \sum N_i$ 835 851	4 010 $n = \sum n_i$		Судалгааны нэгжүүдийн нийт түүвэр
%	$N_i / N$ 1,876%	1,876% $n_i / n$		%

Судалгааны нийт нутгийг судалгааны нэгжүүдэд хувь тэнцүүлэн хуваасны дараагаар хот суурин газар, орон нутгийн хүн амын ялгаатай байдлыг харгалзан нэгж

71 Монгол улсын Үндэсний статистикийн газар, Монгол улсын статистикийн мэдээллийн үйлчилгээ. www.1212.mn/en хаягаар үзнэ үү.

бүрд хамаарах түүврийн хоёрдогч хуваарилалтыг дахин тооцож гаргасан. Энэхүү алхмыг хийхэд нийт хүн ам нь орон нутгийн бус хэмээн тооцогдох Улаанбаатар хотын дүүргүүдэд ижил тооцоо хийх шаардлагагүй байсан. Монгол Улсын 2005 оны тооллогын албан ёсны мэдээллийг хүн амын мэдээллийн эх сурвалж болгон дахин ашигласан. Энэхүү алхмын жишээг Хүснэгт 4 дээр өмнөх нэгж #42 дээр харуулсан.

Хүснэгт 4. Түүвэрлэлтийн тархалтын жишээ (Б)

Судалгааны нэгж #42 Улиастай сум (ЗАВХАН аймаг)				
	ХҮН АМ	ТҮҮВЭР		
Судалгааны нэгжийн хүн ам	$N_i$ 15 679	75 $n_i$		Судалгааны нэгжийн түүвэр
Судалгааны нэгжийн хот суурин газрын хүн ам	$N_{i(u)}$ 3 606	17 $n_{i(u)}$		Судалгааны нэгжийн хотын түүвэр
%	$N_{i(u)} / N_i$ 23%	23% $n_{i(u)} / n_i$		%
Судалгааны нэгжийн орон нутгийн хүн ам	$N_{i(r)}$ 12 073	58 $n_{i(r)}$		Судалгааны нэгжийн хөдөө орон нутгийн түүвэр
%	$N_{i(r)} / N_i$ 77%	77% $n_{i(r)} / n_i$		%

## Зах зээлийн судалгааны түүвэрлэлт

Монгол Улс дахь зэрлэг амьтны зах зээлийн судалгааг чанарын бүрэлдэхүүн хэсэгтэй нягт уялдаатайгаар боловсруулан гаргасан. Үнэлэмжийн сүлжээн дэх эдийн засгийн үнэлгээг тооцохын тулд зэрлэг амьтны худалдааны үнэ ханшийн талаарх тоон мэдээлэл цуглуулахаас гадна чанарын судалгаа хийх шаардлагатай оролцогч талууд, холбогдох процедурууд байдаг. Эдгээрт хамаарах зарим асуултыг эхний шатанд (Судалгааны асуултууд хэсгээс үзнэ үү) боловсруулан, зэрлэг амьтны худалдааны сүлжээнд оролцогч талууд, тээвэрлэх, хадгалах, хил дамнуулан борлуулах тусгайлан процедурууд болон зэрлэг амьтны гаралтай ямар бүтээгдэхүүнийг Монгол Улсын хэрэглэгчид түлхүү ашигладаг болохыг харгалзан боловсруулан гаргажээ. Судалгааны эдгээр хэрэгцээнд үндэслэн нийт тоон болон чанарын 7 хэрэглэгдэхүүнийг хослуулан зах зээлийг тусгайлан судалснаас аль нь ч статистик төлөөллийг хангахад зориогүй.

Эдгээр зорилтоос үүдэн судалгааны газар нутгийн сонгоход санамсаргүй түүвэрлэлт, статистик түүвэрлэлтийн аль алиныг ашиглаагүй. Харин арилжааны үйл явц нь улсын хэмжээнд ижил хэлбэрээр явагддаггүй хэмээх ойлгосноос үүдэн тухайн сонголтыг үнэлэмжийн сүлжээний дагуу зэрлэг амьтны худалдааг ажиглах замаар хийсэн. Үндсэндээ зэрлэг амьтны худалдаа нь Монгол Улсын хот суурин газруудад, тэдний эргэн тойронд явагдаж байна. Ялангуяа зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн борлуулж буй сегментүүд болох аялал жуулчлалын

компаниуд, рестораниудын хувьд илүү бодитой бөгөөд эдний дийлэнх нь Улаанбаатар хотод төвлөрөн ажиллаж байна. Түүнчлэн зэрлэг амьтны худалдаа нь олон улсын шинж чанартай, Монгол Улс нь Хятад болон Орос улсуудын хувьд эх үүсвэр буюу анхдагч нийлүүлэгч орон болжээ. Энэ талаарх мэдээллийг цуглуулах зорилгоор эдгээр улсуудтай хил залгаа буй газруудад судалгаа хийх шаардлага үүссэн.

## ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ ХИЙХ ГАЗРЫГ СОНГОСОН НЬ

Зах зээлийн судалгааны түүвэрлэлтийн бүсийг сонгоход гурван үе шат бүхий үйл явцыг ашигласан (зураг 10). Эхний шатанд Монгол улсыг гурван бүс (баруун, төв болон зүүн) болгон хувааж, бүс бүрээс түүвэрлэлт хийхээр зорьсон. Бүс бүрээс гурван аймгийг сонгон, нийт 9 аймгийг энэ шатанд сонгосон. Төвийн бүсээс хоёр аймаг, нэмээд Улаанбаатар хотыг үүнд багтаасан. Сонгон авсан аймаг бүр дээр судалгааны бүсийг хумин, 2 сумыг сонгон нийт 16 болгож, дээр нь Улаанбаатар хотын 4 дүүрэг, хотын гадна байдаг зэрлэг амьтан зарж борлуулдаг гурван захыг багтаасан. Зэрлэг амьтны худалдааны зах зээл, сүлжээний судалгааг бүх улсыг газар зүйн нийт 20 цэг дээр хийж гүйцэтгэсэн. Дараах хэсэгт хоёрдугаар үе шат (аймаг сонголт) болон гуравдугаар үе шат (сум сонголт) дээр ашигласан шалгуурын тухай нэмэлт мэдээллийг оруулсан.

Зураг 10. Зах зээлийн судалгааны түүвэрлэлтийн бүсүүд



## ХИЛ ОРЧМЫН БҮСҮҮДИЙГ СОНГОСОН НЬ

Монгол Улсын Гаалийн ерөнхий газраас ОХУ болон БНХАУ-тай хиллэдэг хилийн дагуу нийт 42 боомтын жагсаалтыг гаргасан байдгаас ОХУ-тай 29 боомт, БНХАУ-тай 13 боомт ажиллаж байна.<sup>72</sup> Энэхүү жагсаалтад багтсан боомтуудаас өрхийн судалгааны үед 30 боомт нь хаалттай эсвэл судалгаанд хамрагдсан аймгуудад хамаарахгүй байв. Иймд Баруун бүсийн Ховд, Увс, Төвийн бүсийн Сэлэнгэ, Зүүн бүсийн Дорнод, Дорноговь, Сүхбаатар аймгуудын 10 боомтоос сонголт хийхээр болсон. Эдгээр 6 аймгийг бүгдийг сонгож, нэг бүсээс гурван аймаг сонгох зорилтын дагуу хоёр аймаг нэмж оруулсан нь баруун бүсийн<sup>73</sup> Баян-Өлгий, төвийн бүсийн Төв аймгууд байсан. Эдгээр сүүлийн хоёр аймагт байнгын үйл ажиллагаа явуулдаг гаалийн алба байхгүй ч хилийн боомтод хүрэх авто замын дагуу байрших тул зэрлэг амьтны хууль бус худалдаа, хил дамнасан худалдаанд ашиглаж байх боломжтой юм.

Сонгон авсан 8 аймгаас аймгийн төвүүдийг бүгдийг нь оруулсан шалтгаан нь жижиглэн худалдааны цэгүүд, ресторан, уламжлалт эмнэлгүүд нь үндсэндээ эдгээр төв суурин газруудад төвлөрч байдгаас хамааралтай юм. Аймгийн төвүүд дээр нэмээд улсын хилтэй шууд залгаа сумдад боловсруулах болон худалдаалах үйл ажиллагаа явагддагаас үүдэн сонгогдох боломжтой сумд хэмээн тооцсон. Харин нэгээс дээш тооны сум энэхүү шалгуурт нийцэх тохиолдолд зэрлэг амьтны худалдаа ихтэй эсвэл тээврийн гол замд байрлах сумдыг сонгон авсан. Зах зээлийн судалгааны түүвэрлэлтэд хамруулахаар сонгон авсан 16 сумыг Зураг 10 дээр жагсаан харууллаа.

## УЛААНБААТАР ХОТ БОЛОН ОЙРОЛЦООХ ЗАХУУДЫГ СОНГОСОН НЬ

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй голлох зургаан зах болох Хархорин, Нарантуул, Номин, Баянзүрх, Хүчит шонхор болон Барс захуудыг юуны өмнө тогтоосон. Эдгээрээс гадна Улаанбаатар хотын ойролцоо түүхий эдийн худалдаа хийдэг гурван цэгийг тодорхойлсон нь 2005 оны судалгаанд мөн хамрагдсан Эмээлт, Багануур болон Налайх дахь түүхий эдийн захууд юм.

Судалгаанд тухайн захуудыг сонгосон ч энэ нь нийслэл хотын хэмжээнд хийж буй зах зээлийн судалгаанд (хитшээ нь аялал жуулчлалын компаниуд, жижиглэн худалдааны дэлгүүрүүд болон үндсэн оролцогч талуудын ярилцлага) ямар нэгэн байдлаар хязгаарлалт үүсээгүй. Иймээс Улаанбаатар хот нь бүхэлдээ

72 Эх сурвалж: <http://www.customs.gov.mn/2014-03-24-09-28-57>.

73 Тус аймагт Цагааннуурын эдийн засгийн чөлөөт бүс байгаа ч бүсийн бүтээн байгуулалтын ажил хийгдээгүй байна.

зах зээлийн судалгаанд хамрагдаж, зарим төрлийн судалгааг хотын хэмжээнд худалдаанд оролцогч хаана байж болох тэрхүү цэгүүд дээр хэрэгжүүлсэн.

## ЗАХУУДААР ҮЙЛЧЛҮҮЛДЭГ ХҮН АМЫН ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ

### Нэгдүгээр алхам: Захуудаар үйлчлүүлдэг хүн амыг тооцох

Зорилтот зах зээлийн сегмент нэг бүрд хамаарах тухайн захаар үйлчлүүлдэг хүн амын тоог тооцон гаргахын тулд олон тооны эх үүсвэрээс<sup>74</sup> мэдээлэл цуглуулах шаардлагатай болсон. Жишээ нь аймгуудын ЗДТГ руу утсаар асууж лавлах, биечлэн уулзах, онлайн судалгаа хийх болон үндэсний хэмжээний утасны лавлагаас судлах зэрэг олон эх үүсвэрүүд багтсан. Улаанбаатар хотын статистик мэдээллийг вэбсайтуудаас<sup>75</sup> болон утасны лавлах ашиглан цуглуулсан. Энэ бүхнээс гарсан үр дүнг Зураг 11 дээр харуулсан.

Зураг 11. Захуудын түүврийн хэмжээ



### Хоёрдугаар алхам: Түүврийн хэмжээг тодорхойлох

Сонгон авсан түүвэрлэлтийн 20 газрын хэмжээнд нийт зэрлэг амьтны холбоотой бараа бүтээгдэхүүн худалдаалдаг 17 зах, аялал жуулчлалын 50 оператор, уламжлалт эмчилгээний 9 эмнэлэг, 103 ресторан, зоогийн газар, жижиглэн худалдааны 90 дэлгүүр болон 200 үндсэн мэдээлэгч нарыг тодорхойлсон. Энэ нь ойролцоо байдлаар тоймлон гаргасан тоо хэдий ч зах зээлийн судалгааны хэрэглэгдэхүүн бүрт хамаарах түүвэрлэлтийн зорилгыг хангахад хангалттай байсан.

Зураг 11 дээр үзүүлснээр түүврийн зорилт нь бөөний худалдааны захууд дээр 400 удаагийн (300 үнийн мэдээ болон 100 ажиглалтын хуудас) ажиглалт, уламжлалт эмнэлгийн 30 эмчийг хамруулахаар тогтоосон. Бусад хэрэглэгдэхүүний хувьд тавьсан зорилго нь түүврийн 20 газарт буй бүх зах зээлийг буюу аялал жуулчлалын

компаниудаас 50 судалгаа, ресторануудаас 100 судалгаа, зэрлэг ан амьтны гаралтай бүтээгдэхүүн борлуулж буй жижиглэн худалдааны дэлгүүрүүдээс 120 судалгаа авахаар төлөвлөсөн.<sup>76</sup> Үүн дээр нэмээд 150 үндсэн мэдээлэгч нарыг хамруулах зорилгыг өмнөө тавьсан.

Эдгээр бүх хэрэглэгдэхүүнийг нийлүүлж үзвэл зах зээлийн судалгааны нийт түүврийн хэмжээ нь 850 байх юм. Үүнд 2005 оны судалгаагаар хийснээс (1,100 зах зээлийн судалгаа) арай цөөн тооны буюу 850 ажиглалт багтсан. Гэхдээ судалгаанд хамрагдсан хүн ам, ашиглаж буй сайжруулсан судалгааны хэрэглэгдэхүүн нь ажиглалтын тоо цөөн буйг нөхвөрлөж, дүн шинжилгээ хийх хүчинтэй мэдээллийн томоохон багцыг үүсгэсэн.

### Гуравдугаар алхам: Түүврийн хэмжээг бүс нутгуудад хуваарилах

Дээр дурдсан үндэсний хэмжээний зорилтыг гаргасны дараа түүврийн бүс бүрийн дэд зорилтыг тооцон гаргахдаа Улаанбаатар хот дахь судалгаанд оролцогчдын томоохон төвлөрлийг тооцон үзсэн. Зарим тохиолдолд нөхцөл байдал маш тодорхой буйг харахад хялбар байсан нь аялал жуулчлалын жишээн дээрээс харж болно. Учир нь бараг бүх аялал жуулчлалын компаниуд нийслэлд байршин үйл ажиллагаа явуулдаг явдал юм. Аялал жуулчлалын хэрэглэгдэхүүний хувьд нийт түүврийн хэмжээг (50 судалгаа) Улаанбаатар хотод бүхэлд нь хуваарилсан. Үлдсэн хэрэглэгдэхүүний хувьд Улаанбаатар хот, түүний орчин тойрны захуудад түүврийн хэмжээний 40% болон 70%-иар тооцон сегментээс хамааруулан хуваарилсан ба үлдэх 16 сумдад бусад хэсгийг нь тэгш хуваарилсан.

74 [www.touristinfocenter.mn](http://www.touristinfocenter.mn), <http://tugeene.mn>, [www.ikon.mn](http://www.ikon.mn) болон аймгуудын захиргааны вэбсайтууд

75 <http://www.touristinfocenter.mn>, [www.ikon.mn](http://www.ikon.mn) гэх мэт.

76 Жижиглэн худалдааны дэлгүүрүүдийн хувьд лавлах болон бусад эх сурвалжид багтаагүй албан бус дэлгүүрүүдийн төлөөлөл доогуур тогтоогдсон хэмээн үзэж байна. Энэ шалтгааны улмаас түүвэрлэлтийн хэмжээ нь тооцсон тооноос илүү байгаа.



# Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх


## Мэдээлэл цуглуулах

Өрхүүдийн хувьд сонгон авсан 44 судалгааны нэгжээс судалгаанд хамруулах өрхийг тогтоохын тулд мэдээлэл цуглуулах ажлыг шугаман огтлолын арга ашиглан зохион байгуулсан. Гүүгл Map програмын хиймэл дагуулын зураг ашиглан судалгааны нэгжийг зам болон газар зүйн тэмдэглэгээт цэгээр нь хуваах замаар судалгааны багууд мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг үр ашигтайгаар явуулахаар зохион байгуулсан. Зураг 12 дээр судалгааны нэгж #42-ыг хэрхэн гурван хэсэг болгон хуваасныг үзүүлсэн (цэглэсэн шугамаар хуваагдаж, дугаарлан тэмдэглэсэн).

Хэсэг дотроо судлаачдын явах замыг тэмдэглэн нэмэлт шугамыг санамсаргүй байдлаар зурж оруулсан. Тухайн шугамын дагуу явах чиглэлийг санамсаргүйгээр зааж, эхлэх болон дуусах цэгийг оруулсан.

Зураг 12-ын доод хэсэг нь нэгдүгээр хэсгийг томруулан харуулж, явах замыг мөн харуулсан.

Зураг 12. Өрхийн судалгааны шугаман огтлолын аргачлал



Судлаач нарт тухайн шугамын эхлэл цэгээс эхлэн төгсгөл цэг хүртэл явж, тухайн хэсгийн шаардлагатай түүврийн хэмжээ, нэгжийг дуусгах хүртэл бүхий л боломжит өрхүүдийг судалгаанд хамруулах зааварчилгааг өгсөн.

Зах зээл, оролцогч талуудын судалгааны хувьд лавлах болон бусад материалыг ашиглан урьдчилан тогтоосон зорилтот бүлэгт хэрэглэгдэхүүнийг тохируулсан байсан тул мэдээлэл цуглуулах тусгайлсан арга зүй шаардлагагүй байв.

26 дугаар хуудасны Зураг 13 нь Зэлүүд тал -2 дээрх мэдээлэл цуглуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн хүчин чармайлтуудыг тоймлон тусгасан. Судалгааны 13 хэрэглэгдэхүүнийг (өрх, зах зээл болон оролцогч талуудыг хослуулсан) жагсаан, эдгээрийг хийх сар, шаардагдах хугацаа, оролцох судлаачдын тоо, эцэслэн цуглуулах нийт судалгааны тоо зэргийг гаргаж өгсөн. Эдгээр хэрэглэгдэхүүнийг ашиглан нийт 5,013 ажиглалт хийж, зөвхөн мэдээлэл цуглуулахад л 1,564 цаг зарцуулсан болохыг хэрэглэгдэхүүн бүрээр зарцуулсан дундаж хугацаагаар тооцон гаргасан.

Өрхийн асуулгыг нийт 25 судлаач бүхий баг 2016 оны 5 болон 6 дугаар сард авсан. Эдгээр судлаачид 29 хоногт багтаан 4,070 асуулга бөглөсөн юм. Судлаачдын ойролцоогоор тал нь нийт 46 ажиглалтын хуудсыг 13 хоногийн хугацаанд гарган ирсэн.

Намрын эхээр 9 судлаачийн бүрэлдэхүүнтэй хоёр дахь баг хэрэглэгдэхүүн #3- #8-ыг ашиглан 2016 оны 9- 11 дүгээр саруудад зах зээлийн судалгааг хийсэн. Зураг 13 (х. 26) дээр энэхүү үйл ажиллагаанд зарцуулсан нийт ажлын өдрийг харуулсан. Зургийн доод хэсэгт хагасчилан бэлдсэн ярилцлага ашиглан, нэг судлаач дагнан эхний гурван сарын хугацаанд оролцогч талуудыг хамруулан хийсэн мэдээлэл цуглуулах үйл явцыг тоймлон харууллаа.

Зэрлэг амьтны хууль бус худалдааны талаар мэдээлэл цуглуулахад тулгардаг гол сорилт нь тухайн төрлийн худалдааны нууцлагдмал орчин байсан бөгөөд сүүлийн жилүүдэд энэ чиглэлээр хууль сахиулах арга хэмжээ чангарснаар илүү нууцлагдмал байдалд орсон нь тодорхой. Өмнө хийсэн судалгаагаар тийм ч өндөр хэмжээнд байгаагүй нь харагдсан энэхүү шинэ орчин нь судалгаанд оролцогчдын судалгааны багтай хамтран ажиллах хүсэл, нээлттэй байдалд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ хууль бус худалдааг шууд ажиглах судлаачдын боломжийг ч хязгаарласан. Өрхийн түвшинд үл ижилсүүлсэн асуулт нь оролцогчид эмзэг асуултад тэр бүр үнэн зөв хариулт өгдөггүй болохыг баталсан байдаг. Зах зээлийн судалгааны хувьд зорилтот сегментүүдийн хоёр нь тухайн судалгаанд оролцохоос шууд татгалзсан. Энэ байдал мөн ан агнуурын холбоод, ангийн болон загасчлалын аялал зохион байгуулдаг аялал жуулчлалын компаниуд (нэгээс бусад нь) дээр ч давтагдсан. Судалгааны ажлыг дэмжин БОАЖЯ-ны гарган өгсөн албан бичгийг ашиглан хийхээр оролдсон уулзалт, утсаар ярих зэрэг нь итгэлцэл бага байсны

улмаас олигтой амжилттай болоогүй. Түүнчлэн олон хүмүүс хууль бус худалдааг шөнийн цагаар эсвэл нууц газарт л хийдэг хэмээн үзэж байсан. Тиймээс орон нутагт ажиллах үедээ судлаачдын цуглуулсан цөөн тооны шууд ажиглалт нь (Ажиглалтын хуудас болон Үнийн тайлан мэдээний хүрээнд) бодит байдлын зөвхөн өнгөн тал байсан гэж үзэж байгаа юм.

Ложистикийн асуудлаас үүдэн гаалийн байцаагч нар, сумын байгаль хамгаалагч нартай хийх гол мэдээлэгчийн ярилцлагыг хийх судалгааны багийн боломж чухал үүрэг гүйцэтгэж байв. Судалгааны багаас холбоо барихад ажил дээрээ байхгүй, орон нутагт хяналтын ажлаар явж байх зэрэг нь түгээмэл тохиолдож байсан. Зарим үед орон нутагт судлаачдын багийг бүхлээр нь солих шаардлага гарсан нь тухайн ажилтнууд дэлгэрэнгүй хариулт олж авах туршлагагүй, мэдээлэлгүй байснаас үүдэлтэй байв. Ямартай ч түүвэрлэлт нь хангалттай их (150 ярилцлага хийсэн), зэрлэг амьтны асуудлаар ажилладаг бүхий л байгууллагуудын ажилтнуудыг хамруулж амжилттай өндөрлөсөн.

## Мэдээллийн чанарын хяналт

Өмнөх судалгааны тайлантай харьцуулбал мэдээлэл цуглуулах үйл явц дахь мэдээллийн чанарын хяналтад мэдээллийн технологи ашигласны үр дүнд ихээхэн сайжирсан. Үүний эхний давуу тал нь хаалттай цэсээс сонгох, асуулга доторх урьдчилан тогтоосон асуултын дарааллыг ашиглах замаар мэдээлэл оруулахад тохиолдож болох алдааг бууруулсан. Хийсэн ярилцлагыг цахим төхөөрөмж автоматаар бичиж авч байсан тул тодорхой нэг хариулт дээр эргэлзээ үүсэх тохиолдолд анхлан хийсэн ярилцлагыг эргэн санахад хялбар байв. Судалгааны газар зүйн байршил, зураг нь оролцогчийн өгөх мэдээллийг хуурамчаар үйлдэх явдлыг зөрүүлэн шалгах боломжоор хангасан. Түүнчлэн өрхийн судалгаанд хамрагдсан хүмүүсийн утасны дугаарыг тэмдэглэн авснаар зөвхөн тэдний оролцсон төдийгүй бусад гол асуултаар утсаар холбогдох замаар эргэн баталгаажуулах боломжтой байсан. Улаанбаатар хотод чанарын баталгаажилт хариуцсан багийн гишүүн нь хээрийн судалгаагаар цуглуулсан бүхий л мэдээллийг зайнаас хүлээн авч, онлайн байдлаар хадгалах боломжтой байв. Ингэснээр мэдээлэл цуглуулахтай холбоотой ямар нэгэн асуудал дээр шуурхай арга хэмжээ авч байсан. Эдгээр арга хэмжээний үр дүнд нийт түүврээс 10 хүрэхгүй цөөн тооны хэрэглэгдэхүүн (0.2%) хүчингүй болсон.

## Мэдээллийн дүн шинжилгээ

Шаардлагатай мэдээлэл цуглуулж, чанарын хяналтыг хийсний дараагаар гарах үр дүнгийн найдвартай,

үнэн зөв байдлыг хангах зорилгоор тухайн мэдээлэлд олон төрлийн дүн шинжилгээ хийсэн. Гэвч зарим тохиолдолд асуултад хариулсан байдал их доогуур байснаас хамааран мэдээлэлд иж бүрэн харьцуулсан шинжилгээ хийх явц хязгаарлагдмал байсан. Энэ талаарх мэдээллийг холбогдох хэсгүүдэд дурдсан болно.

## МЭДЭЭЛЭЛД ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН НЬ

Судалгааны багийн хийсэн үнэлгээгээр зэрлэг амьтан агнах агнуурт оролцогчид болон анчид, загасчдын өгсөн мэдээлэл хангалтгүй байсан нь 2016 оны судалгааны мэдээллийн нарийвчлалд зарим талаар сөрөг нөлөө үзүүлсэн болохыг тогтоосон. Тулгарсан энэхүү асуудал болон Үл ижилсүүлэх тооллогын аргачлалын (УСТ) талаар энэ бүлэгт дээр дурдсаны зэрэгцээ тавдугаар бүлэгт мөн дахин тайлбарласан. Түүнчлэн өрхийн, зах зээлийн болон бусад судалгааны явцад тулгарсан бусад асуудлын талаар дараах хэсэгт тоймлон орууллаа.

### Өрхийн болон зах зээлийн судалгаа

Ерөнхийдөө 2016 оны судалгааны дизайн болон хэрэгжилт нь өмнө хийсэн судалгаанаас илүү нягт нямбай түвшинд хийгдсэн. Тиймээс цаг хугацаа хэмнэсэн, гарах үр дүнг зарим талаар сайжруулсан зэрэг ахицыг авчирсан ч нөгөөтэйгүүр урьд нь хэрэглэж туршиж байгаагүйгээс асуудал байсныг хэлэх нь зүйтэй.


1. **Түүвэрлэлтийн дизайн** нь судалгааны төлөөлөх чадварыг баталгаажуулах зорилгоор хэд хэдэн сонголтын аргачлалыг ашигласан ч зарим түвшинд зарим хазайлт бий болгосон эсвэл болгоогүй байх магадлалтай. Үүнд:
  - a. Өрсөлдөх чадварын индексийг тодорхой нэг бүсийн ерөнхий нөхцөл, эдийн засгийн байдлын үзүүлэлт болгон ашиглах. Өрсөлдөх чадварын индекс нь бизнес эрхлэхэд нөлөөлдөг олон тооны хүчин зүйлийг хэмжин үздэг өргөн хүрээ бүхий концепц юм. Гэхдээ энэхүү индекс нь цэвэр эдийн засгийн хүчин зүйлийг хэмжихгүй тул эдийн засгийн чухал ач холбогдол бүхий бодит байдлыг, жишээ нь хүчтэй боловч хууль бус эдийн засгийг нуун далдалж болно.
  - b. Хэд хэдэн шалгуур **байгаа эсэхэд** найдах. Жишээ нь түүвэрлэлтийн дизайн нь сонгон авсан газруудад амьтны төрөл зүйлийг бүрэн төлөөлсөн байх зорилго тавьсан. Хамаарах аймгуудыг судлан үзсэн ч тухайн зүйл нь тухайн аймгийн газар нутагт байдаг эсэх дээр л зөвхөн тулгуурлаж байсан. Тухайн төрөл зүйл байдаг эсэх талаар илүү дэлгэрэнгүй тооцоог жишээ нь Х аймагт Х төрөл зүйлийн нийт тоо толгойн Х% нь тархсан гэх мэтээр ашиглах

- боломжтой юм. Сонгох үйл явцад ашигласан бусад шалгуурыг ч ингэж үзэж болно.
- c. Түүвэрлэлтийн дизайнд ашигласан зарим шалгуурыг хослуулан хэрэглэх нь бусад судалгаагаар туршигдаагүй байсан. Гэхдээ түүвэрлэлтийн дизайн болон түүврийн хэмжээ нь болзошгүй хазайлтыг бууруулахад хангалттай байсан.
  2. Өрхийн болон зах зээлийн судалгааг оролцогчийн **ой санамжид** найдан хийсэн тул зарим талаар мэдээллийн хувьд зөрүү үүсэх магадлалтай. Энэ байдал 2005 онд ч мөн гарсан бөгөөд энэ удаагийн судалгаанд ч харьцуулалт хийж болохуйц бие даасан тэмдэглэл, бүртгэл байхгүй байв. Үл ижилсүүлэх аргачлалаар авахад хүмүүс бүрэн хариулаагүй тохиолдолд их байх нь анчид, агнуурын болон худалдааны түвшнийг тооцоолоход алдаа гарахад хүргэх нь тодорхой. 2005 оноос ялгаатай нь энэхүү судалгаагаар үр дүнг хараат бусаар баталгаажуулах зорилгоор гол мэдээлэгч нартай уулзах цагийг ихээр гаргаж өгсөн явдал юм.
  3. Мэдэхгүй байгаа зүйлийг нөхөж авахад **Үл ижилсүүлэх аргын** хязгаарлагдмал байдал. Үл ижилсүүлэх арга нь тодорхой нэг үйлдлийг олж илрүүлэх чиглэлээр үр дүнтэй байдаг. Харин тодорхой нэг хууль бус үйлдлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл гарган авахын тулд энэхүү аргачлалыг ашиглахад төвөгтэй. Өөрөөр хэлбэл нийт хэдэн хүн хууль бус үйлдэл хийж буй болохыг олж тогтоох боломжтой ч тухайн хүмүүсээс ан агнах, загасчлах үйлдлийнх нь тухай лавшруулан асуух тохиолдолд үр дүнгээ өгөхгүй байх магадлалтай юм.
  4. **Судалгааны хугацаа**. 2005 оны зун хийсэн судалгаа нь улирал бүрийг төлөөлж чадаагүй. Энэ удаагийн судалгаанд зөвхөн өрхийн судалгааг л зуны улиралд хийсэн ч Монгол Улсын Их Хурлын сонгуультай цаг хугацааны хувьд давхцаж таарсан. Судалгааны хувьд сонгуулийн үйл ажиллагаатай давхцуулан хийгээгүй ч судалгаанд оролцогчдын идэвхэд сонгууль нөлөөлж байсан нь тодорхой юм. Энэ нь зарим талаар нэг талыг барьсан мэдээлэлд хүргэсэн байж болно.
  5. **Шөнийн цагаар хийдэг худалдаанд** ажиглалт хийгээгүй. Энэ нь гол мэдээлэгч нартай хийсэн ярилцлагын үеэр тодорхой болсон худалдааны шинэ хэлбэр юм. Судалгаанд энэ чиглэлээрх ямар нэгэн шууд ажиглалт эсвэл аман мэдээлэл зэрэг ороогүй.
  6. **Загасан бүтээгдэхүүн борлуулдаг ресторануудад** дагнан төвлөрсөн. Зах зээлийн судалгааны асуулга зөвхөн загасан бүтээгдэхүүнд төвлөрсөн. Судлаачид нь бусад амьтны махыг орлох болон зээр зэрэг бусад зэрлэг амьтны хэрэглээний талаар мэдээлэл цуглуулаагүй.
  7. **Оролцогчид судалгаанд хамрагдахгүй байх**. Ан агнуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд тухайн үед үндсэн үйл ажиллагаа явуулахгүй, эзгүй байсан бөгөөд эдгээр байгууллагууд нь ан агнуурын талаар үнэ цэнэтэй мэдээлэл гарган өгөх боломжтой байсан. Гэвч эдгээр байгууллагуудын үйл ажиллагаа спорт агнуурын (трофи) төрлөөр хязгаарлагдах тул зах зээлийн бусад хэсгийн талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байдаг.

Зураг 13. Мэдээлэл цуглуулах үйл явц

# ЗЭЛҮҮДТАЛ II

## Мэдээлэл цуглуулах



№	Төрөл	Мэдээлэл цуглуулсан сарууд	Орон нутагт ажилласан хугацаа	Оролцсон судлаачид	Судалгаа
1	Өрхийн асуумж	5 6 7 8 9 10 11	29	4,070	4,070
2	Ажиглалтын хуудас	5 6 7 8 9 10 11	13	46	46
3	Үнийн мэдээлэл	5 6 7 8 9 10 11	15	300	300
-	Ажиглалтын хуудас	5 6 7 8 9 10 11	26	121	121
4	Жуулчлалын компанийн судалгаа	5 6 7 8 9 10 11	9	55	55
5	Уламжлалт эмнэлгийн судалгаа	5 6 7 8 9 10 11	11	34	34
6	Рестораны судалгаа	5 6 7 8 9 10 11	17	108	108
7	Дэлгүүрийн судалгаа	5 6 7 8 9 10 11	25	106	106
8	Гол мэдээлэгчийн ярилцлага	5 6 7 8 9 10 11	20	146	146
9	Удирдах хорооны ярилцлага	5 6 7 8 9 10 11	6	7	7
10	Хууль сахиулах байгууллагын ярилцлага	5 6 7 8 9 10 11	6	8	8
11	ШУХ-ны ярилцлага	5 6 7 8 9 10 11	-	-	-
12	Иргэний нийгмийн ярилцлага	5 6 7 8 9 10 11	10	11	11
13	Судлаачдын ярилцлага	5 6 7 8 9 10 11	1	1	1

ГУРАВДУГААР БҮЛЭГ:

ГОЛ

АСУУДЛУУД

# Олон улсын худалдаа хөтлөгч хүчин зүйл болох нь

Монгол Улс зэрлэг амьтны худалдааны эрэлт хэрэгцээг дангаар дотооддоо бий болгох боломжгүйн зэрэгцээ бусад улс орны зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний худалдааг ч шингээх нөхцөл үгүй билээ. Гэхдээ Монгол Улс нь дэлхийн хэмжээний болон бүс нутгийн зэрлэг амьтны худалдааны урсгалын нэгэн хэсэг аль хэдийн болсон байна. Иймээс зэрлэг амьтны худалдааны хөгжил динамикийг илүү сайтар ойлгож судлах нь энэ хүрээнд Монгол Улсын гүйцэтгэх үүргийг тодорхойлох, улмаар өөрийн орны зэрлэг амьтны худалдааны зах зээлийн нуугдмал, зохицуулалт муутай, эмзэг өртөмтгий байдлыг нарийвчлан авч үзэх эхлэл болох юм. Зэрлэг амьтны худалдаа нь Монгол Улсын дотоодын зах зээлийн нэг чухал салбар хэдий ч 2005, 2016 онуудад хийсэн судалгаагаар зэрлэг амьтны худалдааны эргэлтийн зонхилох хэсгийг олон улсын зах зээлд шууд ба шууд бусаар зориулан нийлүүлж буйг тогтоосон байна.

**Нөхцөл байдал** хэмээх Нэгдүгээр бүлэгт товч өгүүлсэнчлэн зэрлэг амьтны худалдаа нь (хууль бус, эсвэл зохицуулалтгүй) зөвхөн зарим улс оронд тулгараад байгаа өвөрмөц арилжаа, эсвэл хэвлэл мэдээллээр ихээхэн ярьдаг заан, хирс, бар, сүүлийн үед анхаарлын төвд орсон хуягт гүрвэл зэрэг цөөн төрлийн амьтдаар хязгаарлагдах худалдааны асуудал биш, харин ч дэлхий нийтийн өмнө тулгарч буй нийтлэг асуудал юм. Энэ төрлийн худалдааны цар хүрээ, тоо хэмжээг тодорхойлох нь ихээхэн хүндрэлтэй боловч нийтээр хүлээн зөвшөөрөх болсон нэгэн үнэлгээгээр “зэрлэг амьтны худалдаа нь хэдэн зуун сая зүйлийн ургамал, хэдэн арван мянган зүйлийн амьтныг” хамарч байгаа аж.<sup>77</sup> Үндсэндээ дэлхийн бүх улс, газар нутаг үүний нөлөөнд өртөж, урьд өмнө хэзээ ч сонсож байгаагүй олон зүйлийг хамарч буйгаас цөөн хэдийг нь дурдвал: сийлбэр, гоёл чимэглэлийн зориулалтаар “улаан соёот” хошууг нь борлуулдаг хуягт бүрэн хошуут (*Rhinoplax vigi*), Зүүн Өмнөд Азид гэрт тэжээх зорилгоор зарж буй питта (*Pittidae*) гэж нэрлэгддэг таргалжийн овгийн шувуу,<sup>78</sup> Зүүн Өмнөд Азийн зах

77 TRAFFIC, *Background: Trade*, <http://www.traffic.org/trade/> хаягаар үзнэ үү.

78 Shepherd, C., Eaton, J., & Chng, S. C. L. *Pittas for Pittance: Observations on the Little Known Illegal Trade in Pittidae in West Indonesia*, *BirdingASIA* 24(2015): 18-20, available at <http://www.traffic.org/home/2016/2/17/indonesias-little-known-pitta-trade.html> хаягаар үзнэ үү.

зээлд мөн гэрт тэжээхээр худалдаалж байгаа лорис (*Nycticebus*) хэмээх сармагчны зүйлд хамаарах амьтан, болон сийлбэр, аквариумын чимэглэлийн зориулалтаар худалдаалж буй аварга хясаа (*Tridacna gigas*) гэх мэтээр урт жагсаалт цааш үргэлжилнэ. Монгол Улсын зарим жишээг дурдвал эмчилгээнд хэрэглэхээр эврийг нь худалдаалж буй бөхөн гөрөөс, Хятадын худалдан авагч нарт хөлдүүгээр, бүхэл гулуузаар нь худалдаалж байгаа саарал чоно зэргээс гадна тэдгээрийн эд эрхтэн болох чонын шагай, шүд, үнэртний болон эмчилгээний зориулалтаар хүдрийн заар, түүнчлэн харахан танигдаагүй байгаа өвөрмөц соёо (хүдрийн байж болох) гээд олон жишээ хэлж болно.

Зэрлэг амьтны худалдаа нь нарийн төрөлжсөн, ихээхэн тоо хэмжээгээр хийж болдог, дийлэнхдээ алс хол тээвэрлэн худалдаалж болдгийн зэрэгцээ асар их ашигтай байдаг. Жишээ нь 2016 онд Перу Улсын эрх баригчид Хятадын далбаа бүхий хөлөг онгоцоор Ази тив рүү тээвэрлэж явсан, 5 тэрбум орчим ам. долларын үнэ бүхий 8 сая ширхэг хатаасан далайн морь хураасан байдаг.<sup>79</sup> Тэр жил мөн Хонконгийн албаны хүмүүс “зүсмэл хуванцар” гэж хаягласан дөрвөн тонн хуягт гүрвэлийн хайрс хураан авсан байна. Камерун Улсаас гаралтай энэхүү нэг удаагийн худалдаа гэхэд л 6,600 амьтны хайрс байсан бөгөөд тэр үедээ 1.25 тэрбум ам.доллараар үнэлэгдэж байв.<sup>80</sup> Азид өргөн дэлгэрсэн бэлгийн чадавх нэмэгдүүлэх бэлдмэлийн орцонд ордог хирсний эвэр гэхэд өндөр үнэ бүхий зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн бөгөөд алтнаас бараг 1.5 дахин өндрөөр үнэлэгдэж байна.<sup>81</sup> Хирсний нэг эвэр дунджаар 1.5-3.0 кг байдаг бөгөөд энэ нь 65,000 орчим ам. доллараар худалдаалагддаг байна.<sup>82</sup>

Эдгээрийн нэгэн адил Монгол Улс ч зах зээлд өндөр үнэлэгдэх өөрийн гэсэн зэрлэг амьтан олонтой. Хүрэн баавгай л гэхэд Азийн зарим зах зээл дээр хэдэн мянган доллараар үнэлэгддэг бөгөөд хүрэн баавгайн нунтаглан бэлтгэсэн нэг грамм цөс буюу доньт 200 ам.доллар<sup>83</sup> хүрч байгаа нь нэг килограмм тутам нь 200,000 ам.долларт хүрнэ гэсэн үг юм. Энэхүү зах зээлийн үнийг тооцоолсон Тайланд, Өмнөд Солонгосын зах дээр Монголоос гаралтай баавгайн цөсөөр хийсэн бүтээгдэхүүн зарагдаж байгааг тогтоожээ. Персийн

79 ABC News Australia, *Peru Seizes 8 Million Seahorses Illegally Bound for Asia On Chinese-Flagged Vessel*, (Jun. 22, 2016) <http://www.abc.net.au/news/2016-06-22/peru-seizes-8-million-seahorses-illegally-bound-for-asia/7531550> хаягаар үзнэ үү.

80 Actman, Jani, *Four Tons of 'Plastic' Discovered to Be Smuggled Pangolin Scales*, *National Geographic: Wildlife Watch* (Jun. 26, 2016), <http://news.nationalgeographic.com/2016/06/pangolin-scales-smuggling-hong-kong/> хаягаар үзнэ үү.

81 Harper, Jennifer. *\$60K a Pound: Illegal Rhino Horn Now Declared More Valuable than Gold, Diamonds, and Cocaine*, *Washington Times* (May 2015). <http://www.washingtontimes.com/news/2015/may/17/rhino-horn-considered-cure-all-and-aphrodisiac-now/> хаягаар үзнэ үү.

82 Prices of Exotic Animals and Wildlife. Harvoscope Global Black Market Information.

83 Foley, K., Stengel, C., & Shepherd, C., *Pills, Powders, Vials, and Flakes: The Bear Bile Trade in Asia*, TRAFFIC Southeast Asia Report (2011).

булангийн Арабын орнуудад эрэлт ихтэй идлэг шонхор шувуу хэдэн мянгаараа худалдаалагдаж байгаагийн гол ханган нийлүүлэгчид нь Төв Азийн орнууд бөгөөд тэдгээрийн дотор Монгол Улс орж байгаа юм. Нэг идлэг шонхор шувуу 25,000 орчим ам.долларт хүрч байна.<sup>84</sup> Саудын Арабын 2014 оны худалдааны тайланд дурдсанаар ховор төрлийнх бол энэ үнэ хоёр дахин нэмэгддэг ажээ.<sup>85</sup>

Бусад олон тохиолдлыг дурдаж болох ч зөвхөн эдгээр цөөхөн жишээ гэхэд л зэрлэг амьтны худалдаа Өмнөд Америк, Африк, Төв Азийн ханган нийлүүлэгч орнуудаас Ойрхи Дорнод, Ази, Европ, Хойд Америкийн зах зээлд хүрэхээр алс хол замыг туулан өндөр ашиг хийж байдгийг тодхон харуулж байна. Зэрлэг амьтны худалдаа нь (дүнг мод, загасны хууль бус худалдааг оруулаад)<sup>86</sup> одоогоор жилийн 20 тэрбум ам.доллар болон түүнээс дээш хэмжээний ашиг орлого олдог хууль бус худалдааны хамгийн том таван төрлийн нэг хэмээн тооцогдож байна.<sup>87</sup>

Хууль сахиулах байгууллагууд энэ чиглэлд ихээхэн анхаарал хандуулж байгаа ч олон улсын зэрлэг амьтны худалдаа нь улам өргөжин тэлсээр илүү олон зүйлийг хамрах аюулын харанга дэлдэж байна. Эдийн засгийн хөгжил, хүн амын өсөлт, тээвэр холбооны дэвшилтэт технологи, тээвэрлэлтийн сүлжээний тэлэлт, хувиараа хөрөнгө оруулагч нарын хийж буй дамын худалдаа<sup>88</sup>, илүү боловсронгуй агнуурын технологи зэрэгт дулдуйдан нэмэгдэх болсон зэрлэг амьтны худалдаа нь олон зүйл амьтны урьд өмнө байгаагүй их хурдтай устах гол хүчин зүйл болж байна.

Монгол орны зэрлэг амьтдад олон аюул (дэд бүтэц сул<sup>89</sup>, уур амьсгалын өөрчлөлт, идээшил нутгаа алдах гэх мэт) тулгарч байгаагийн зэрэгцээ Монгол Улс нь олон улсын зах зээлд ханган нийлүүлэгчийн үүрэг гүйцэтгэж байгаа нь хамгийн гол аюул болж байна. Хүчирхэг эдийн засаг бүхий хоёр улсын (ОХУ болон БНХАУ) хооронд хавчуулагдсан, далайд гарцгүй Монгол Улсын гадаад худалдаа, зах зээл, улс төрийн ашиг сонирхолд хоёр хөрш нь ихээхэн нөлөөтэй нь бодит зүйл бөгөөд энэ утгаараа харилцаагаа улам өргөжүүлэн хөгжүүлэхийг зорьж байна. Монгол Улс

“2020 он гэхэд хөрш хоёр улстайгаа жилд хийх гадаад худалдааны эргэлтийг тус бүр 10 тэрбум ам.долларт хүргэх замаар БНХАУ-тай хийх худалдааны эргэлтийг хоёр дахин, ОХУ-тай хийх худалдааны эргэлтийг дөрөв дахин нэмэгдүүлэх” зорилт дэвшүүлжээ.<sup>90</sup> Энэ хүрээнд олон арга хэмжээ авч байгаагийн дотор бизнесийг дэмжих хууль тогтоомжийг батлан хэрэгжүүлэх (2013 онд), ОХУ, БНХАУ-тай хоёр талын худалдааны гэрээ хэлэлцээр хийх (2014 онд) зэрэг ажлыг хийж байна.<sup>91</sup> Экспортын хувьд Монгол Улсаас хөрш орнуудаа санал болгох бараа бүтээгдэхүүний төрөл зүйл хязгаарлагдмал<sup>92</sup> боловч ДНБ-нийхээ 50 орчим хувийг экспортоосоо бүрдүүлж байна<sup>93</sup> (дэлхийн дундаж 30 хувь байна).<sup>94</sup> Экспортын дийлэнх хувийг БНХАУ-д нийлүүлж байгаа бөгөөд 2016 оны байдлаар нийт экспортын 79 хувийг БНХАУ-д нийлүүлжээ.<sup>95</sup> Монгол Улсын импортын бараа эргэлт мөн л өндөр бөгөөд (34%) худалдааны гол түнш нь БНХАУ юм.<sup>96</sup> Монгол Улсын экспорт болон импортын нийт бараа эргэлтийн 71 хувийг хөрш хоёр улстайгаа хийж байгаа бөгөөд гадаад худалдааны бусад зургаан түнш улстай нийт экспорт, импортын бараа эргэлтийн 18 хувийг хийж байгааг График 1-д үзүүлжээ.<sup>97</sup> Улсын эдийн засагт гадаад худалдаа томоохон байр суурь эзэлж байгаа нь хууль ёсны болон хууль бус зэрлэг амьтны олон улсын зах зээлийг Монгол Улсад илүү нээлттэй болгож байгаа юм.

84 <https://www.forbes.com/sites/guymartin/2015/12/30/the-250000-bird-falcon-hunting-in-qatar/#3465b0e34bc1>. (2017 оны 5 дугаар сарын 17-ний байдлаар)

85 Ховор зүйлийн идлэг шонхрыг Саудын Арабт ойролцоогоор 56,000 ам доллараар худалдаалж байна. <http://www.arabnews.com/offbeat/news/651846>. 2017 оны 5 сарын 17-ны байдлаар.

86 UNODC, Estimating Illicit Financial Flows Resulting From Drug Trafficking and Other Transnational Organized Crimes, Oct. 2011 (38). [https://www.unodc.org/documents/data-and-analysis/Studies/Illicit\\_financial\\_flows\\_2011\\_web.pdf](https://www.unodc.org/documents/data-and-analysis/Studies/Illicit_financial_flows_2011_web.pdf) хаягаар үзнэ үү.

87 Haken, Jeremy, Global Financial Integrity, Transnational Crime in the Developing World, February 2011 (11) [http://www.gfintegrity.org/storage/gfip/documents/reports/transcrime/gfi\\_transnational\\_crime\\_web.pdf](http://www.gfintegrity.org/storage/gfip/documents/reports/transcrime/gfi_transnational_crime_web.pdf) хаягаар үзнэ үү.

88 Platt, J. (2016). China's Wealthy Are Banking on Extinction. Participant Media.

89 Wingard, J. et. al. (2014).

90 Оксфордын бизнесийн бүлэг. Mongolia builds new partnerships in trade and investment, with China and Russia and beyond. Accessed online at <https://www.oxfordbusinessgroup.com/overview/mongolia-builds-new-partnerships-trade-and-investment-china-and-russia-and-beyond-0> хаягаар үзнэ үү.

91 Монгол Улс нь ОХУ-тай 15, БНХАУ-тай 26 гэрээ байгуулсан байдаг. Мөн ОХУ, БНХАУ-аас гадна худалдаа, хөрөнгө оруулалтын шинэ түншлэлийг бусад улс орнуудтай тогтоож байна.

92 2013 онд нүүрс болон зэсийн худалдаа тус улсын ашигт малтмалын худалдааны 26.1%, 22.2% хувийг тус тус бүрдүүлж байсан нь ДНБ-ний 28%-тай тэнцэж байсан. Төмрийн хүдэр (15.3%); түүхий газрын тос (12.1%), алт (7.3%) зэрэг бусад ашигт малтмалыг мөн экспортолж байна.

93 Монгол Улсын нийт экспортын худалдаа эргэлт 2016 онд 4.917 тэрбум ам.долларт хүрсэн нь тухайн жилийн ДНБ-ний тэн хагастай (9,878 тэр бум ам.доллар) тэнцэж байгаа юм. Эх сурвалж: Статистикийн мэдээллийн сан ([www.1212.mn](http://www.1212.mn))


94 World Integrated Trade Solution. The World Bank. [www.wits.worldbank.org](http://www.wits.worldbank.org) (2017 оны 4 сарын 20-ны байдлаар)

95 2016 онд Монгол улс олон улстай худалдаа хийсэн ч худалдааны барааг 80% нь хөрш Хятад (79%) болон Оростой (11%) хийгджээ. Үлдэх хувийг НВУ (9%), АНУ олон Өмнөд Солонгос (5%) болон Японтой (4%) хийсэн худалдаа эзэлж байна. WTO (2014).

96 Монгол улсын статистикийн мэдээллийн систем ([www.1212.mn](http://www.1212.mn))

97 Монгол улсын нийт худалдааны дүн нь 2016 онд 8.275 тэрбум (экспорт 4.917 тэрбум, импорт 3.357 тэрбум) байжээ. Худалдааны гол түншүүд нь Хятад (USD 4.926 тэрбум эсвэл нийт хэмжээний 60%, Орос (USD 0.936B эсвэл 11%), НВУ (USD 0.585B эсвэл 7%), Япон (0.344 тэрбум, 4%), Швейцар (USD 0.240B, 3%), Солонгос (USD 0.206B, 2%) болон Герман (USD 0.163B, 2%). Үлдэх арван хувь нь бусад улсуудад ноогдоно. Эх сурвалж: Статистикийн мэдээллийн систем ([www.1212.mn](http://www.1212.mn)).

График 1. Монгол Улсын гадаад худалдааны гол түншүүд, 2016 (гадаад худалдааны бараа эргэлт, экспорт, импортын нэгдсэн дүн)



## БНХАУ-ын нөлөө

Монгол Улсын өмнөд хөрш БНХАУ-ын эдийн засаг хүчирхэгжин, хүн амын дундаж давхаргын аж амьдрал, орлого нэмэгдэхийн хирээр зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний дундаршгүй эрэлт хэрэгцээ нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж, улмаар хууль бус худалдаа нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна. Нэгэн үе зөвхөн тансаг хэрэглээний хэмээн тооцогдож, цөөн тооны бийлэгжүү хүмүүсийн хэрэглээ болж байсан бараа бүтээгдэхүүнийг өнөөдөр илүү олон хүн худалдан авах чадвартай болж, урлагийн бүтээлээс эхлээд, этгээд сонин амьтан, хүнсний зүйлс, уламжлалт эмийн бүтээгдэхүүн зэрэг өргөн хүрээг хамрах болсон байна. Эрчимтэй хөгжиж буй БНХАУ-ын зах зээлтэй ойр хөрш, өргөн уудам газар нутгаар хил залгаа оршиж байгаагаараа Монгол Улс нэг талаас зэрлэг амьтны хууль бус экспортын хялбархан бай болж байж мэдэх юм. Бусад холбогдох тайлангууд болон энэхүү судалгаанд хамрагдсан албаны хүмүүсийн үзэж буйгаар БНХАУ-тай дипломат харилцаа улам бүр хөгжиж, бизнесийн түншлэл өргөжихийн хирээр зэрлэг амьтны хууль бус худалдаа ч мөн нэмэгдэж байгаа ажээ.<sup>98</sup> Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын мэдээлэл ч үүнийг нотолж байгаа бөгөөд гааль дээр хураагдсан хууль бусаар худалдаалахыг завдсан зэрлэг амьтны бүтээгдэхүүний дийлэнх нь БНХАУ-руу тээвэрлэгдэх замдаа хураагджээ.<sup>99</sup>

Гаалийн ерөнхий газрын мэдээгээр сүүлийн жилүүдэд БНХАУ руу хууль бусаар хамгийн ихээр худалдаалж буй зүйл нь чоно, баавгайн цөс буюу доньт, бугын цусан эвэр, хүдрийн заар зэрэг эд эрхтэн, бүтээгдэхүүн байна.

- **Чоныг** гулуузаар нь болон хэсэгчлэн хөлдөөсөн байдлаар, мөн эд эрхтэнээр нь салгаж худалдаалж байна. Сүүлийн 10 жилд Монгол Улс нь CITES-ын дагуу (арьс, гулуузыг худалдааны тусгайлсан нөхцөлөөр) албан ёсны зөвшөөрөлтэйгээр БНХАУ руу 56 чоно экспортложээ. Үүний зэрэгцээ чонын эд эрхтэн олон тоогоор хууль бусаар худалдаалах асуудал их байгааг гаалийн мэдээлэл, гаалийн байцаагч нар нотолж байна. Ялангуяа хятадын цагаан сарын өмнөхөн хөлдөөсөн чоныг хамгийн олноор хууль бусаар экспортолдог ажээ.<sup>100</sup>
- **Баавгайн цөс буюу доньтыг** хятадын уламжлалт эм хийхэд ашигладаг учир хууль бусаар худалдаалж байгааг гааль, цагдаагийн байгууллага илрүүлэн таслан зогсоож байна. Энэ төрлийн худалдаа нь CITES-аар тодорхойлсон хууль бус худалдаа тул 2015 оноос хойш Монгол Улс хүрэн баавгайн эд эрхтэнийг худалдаалахыг бүрэн хориглосон. Гэхдээ дотоодын хууль тогтоомжоор, тухайлбал, зөвхөн Амьтны тухай хуулиар “нэн ховор” ангилалд багтсан мазаалай баавгайг агнахыг хориглосон байдаг. 2014 оныг хүртэл Монгол Улс баавгайн цөс буюу доньтыг экспортлох зөвшөөрөл олгож байжээ.

Энэхүү судалгааны явцад баавгайн цөс буюу доньт нийлүүлэх зорилгоор байгуулсан аж ахуйн нэгж тус улсад үйл ажиллагаа явуулж байгаа эсэх талаар судлаачид судлах оролдлого хийсэн хэдий ч дорвитой баталгаа олж чадаагүй.<sup>101</sup> Судалгаанд оролцогчидтой хийсэн ярилцлагаас үзэхэд эрэлт өндөр хэвээр байгаагаас үүдэн баавгайн доньтын худалдаа цааш үргэлжлэх хандлагатай байгаагийн зэрэгцээ хэрэглэгчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн гэхээсээ зэрлэг баавгайн доньтыг илүүд үзэж байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд БНХАУ нь CITES-н хүрээнд Монгол Улсаас нийт 109 ширхэг баавгайн гаралтай бүтээгдэхүүн импортлон авсны дотор 38 баавгай, 150 савар, 20 доньт, 67 амьд баавгай, 147 арьс, 72 чихмэл, 5 гавал болон 70 трофи агнуур тус тус багтаж байна.<sup>102</sup>

98 Судалгаанд оролцогчидтой хийсэн ярилцлага; мөн дараахыг үзнэ үү, N. Otgonsaikhan, *The Current Situation for Mongolian Foreign Trade and Cooperation with Northeast Asian Countries*, Erina Report 127 (Dec. 2015) (8), [http://www.erina.or.jp/en/wpcontent/uploads/2015/02/se12712\\_tssc.pdf](http://www.erina.or.jp/en/wpcontent/uploads/2015/02/se12712_tssc.pdf) хачгаар үзнэ үү

99 ГЕГ-ын мэдээлэл

100 Гол оролцогчидтой хийсэн ярилцлага #UB5 болон #UB6 (Улаанбаатар хот дахь Гаалийн газар)

101 МХЕГ-ын уламжлалт эмийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлага

102 САЙТИС худалдааны мэдээллийн сан (<https://trade.cites.org>) 2017 оны 5 сарын 17-ны байдлаар



- o **Бугын цусан эврийн худалдаа** нь Монгол Улсын хувьд өвөрмөц зүйл биш<sup>103</sup> бөгөөд өнөөгийн байдлаар БНХАУ-ын зах зээлд энэ бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэгч болчихоод байна. БНХАУ-тай хийж байгаа энэ төрлийн бүтээгдэхүүний бүх худалдаа хууль бус юм. Халиун буга нь CITES-ын 2 дугаар хавсралтад багтсан, албан зөвшөөрөлтэйгээр экспортлох бүтээгдэхүүн юм. Сүүлийн 20 жилийн хугацаанд Монгол Улсаас БНХАУ-д албан ёсны зөвшөөрөлтэй хийсэн халиун буганы худалдаа бүртгэгдээгүй байна. Гааль, цагдаагийн ажилтнуудын гаргаж өгсөн мэдээллээс үзвэл бугын цусан эвэр нь хил дээр хамгийн ихээр хураагддаг бүтээгдэхүүн байна.<sup>104</sup> Цусан эвэр нь эмчилгээний зориулалтаар ашигладаг буюу хятадын уламжлалт тамиржуулах бэлдмэлийн найрлагад ордог.<sup>105</sup> Цусан эврийг бугын өсөлтийн эхний шатанд буюу цус агуулж байх үед нь (тиймээс цусан эвэр хэмээн нэрлэдэг) авдаг. Уламжлан ирсэн туршлагаас үзэхэд цусан эврийг дөнгөж ургах шатанд нь тайран авах шаардлагатай болдог тул тухайн амьтныг асар их өвтгөн тарчлаах, улмаар амь насанд нь аюул учруулах нь түгээмэл байдаг ажээ. Монгол Улсад энэ чиглэлээр үржүүлгийн аж ахуй байгуулах оролдлого хийж байгаа нь бугын хорогдол их, нөхцөл тааруу байгаа зэрэг хүчтэй шүүмжлэлд өртөж байна.<sup>106</sup> Мөн зэрлэг бугын эврийг авахын тулд хулгайн анчид буга агнаж эврийг нь тайрч авдаг тул асуудлыг улам бүр хурцатгаж байна.
- o **Хүдрийн заар** нь заримдаа Монгол Улсаас гадаадад хууль бусаар худалдаалж байгаа бүтээгдэхүүний төрөлд орсон байдаг. Өмнө нь хүдрийн заарыг үнэртний салбарт ашигладаг байсан ч сүүлийн үед түүнийг нийлэг бүтээгдэхүүнээр орлуулах болсон.<sup>107</sup> Гэвч Монгол Улсаас худалдаалж буй хүдрийн заарыг уламжлалт эмийн үйлдвэрлэлд (өвчин намдаах, хавдар буулгах, таталт багасгах, ухаан алдахад сэргээх) ашигласаар байна. Өмнө нь Монгол Улсад эр хүдэр үржүүлэн,

заар гарган авах оролдлого хийж байжээ.<sup>108</sup> Одоогоор Өмнөд Солонгосын компанитай хамтарсан, эмийн зах зээлд нийлүүлэх нийлэг бүтээгдэхүүн гарган авах зорилготой төсөл хэрэгжиж буй талаарх яриа байсан.<sup>109</sup> Гэхдээ энэ төслийн үйл ажиллагааны талаар хөндлөнгийн судалгаа хийж нотолгоо гаргах боломж гараагүй болно. Хураасан хүдрийн заарын тоо хэмжээнээс харахад энэ төрлийн худалдаа үргэлжлэн явагдаж байгаа нь ажиглагдаж буй ч худалдааны гарал үүсэл нь тодорхойгүй байна. Хүдрийн тоо толгой буурч байгаатай холбон авч үзвэл<sup>110</sup> энэ төрлийн худалдааны зарим нь ОХУ-аас Монгол Улсаар дамжин Азийн зах зээлд нийлүүлэгдэж байх магадлалтай юм.

Дээр дурдсан нэн ховордсон дөрвөн зүйлээс гадна бусад олон зүйлийг БНХАУ руу хууль бусаар экспортолсоор байна. Үүний тоонд бугын чив болон засаа, бөхөнгийн эвэр зэрэг бүтээгдэхүүн ихээхэн хэмжээгээр худалдаалагдаж буйг хил гаальд хураагдсан бараа бүтээгдэхүүн нотолж байна. Түүнчлэн өмхий хүрэн, тарваганы арьс<sup>111</sup> зэрэг Монгол Улсад нутагшдаг бусад зүйлийг хувцасны үйлдвэрлэлд зориулан БНХАУ руу гаргасаар байна. Эдгээр бүтээгдэхүүнийг БНХАУ-д нийлүүлж, улмаар олон улсын бэлэн хувцас, үслэг эдлэлийн зах зээлд гаргаж байна. БНХАУ-ын үслэг эдлэл боловсруулах үйлдвэрлэл болон зах зээлийн хэмжээ сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж байна. БНХАУ-ын савхин эдлэлийн салбарын 2014 оны тайланд “булга, үнэг болон элбэнхийн үсэн эдлэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөж ... булганы 60 сая, үнэгний 13 сая, элбэнхийн 14 сая арьс боловсруулснаар бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг жилд 50 хувь, 30 хувь, 16.7 хувиар тус тус өсөхөд нөлөөллөө” хэмээн мэдээлжээ.<sup>112</sup>

## ОХУ-ЫН НӨЛӨӨ

ОХУ Монгол Улсын засаглалд тодорхой хэмжээгээр нөлөөлж ирсний нэгэн адил эдийн засагт үзүүлэх Оросын нөлөө ч байсаар байна. 1990-ээд оны үед Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 80 орчим хувийг ОХУ бүрдүүлж гадаад худалдааны гол түнш нь байсан бол өнөө үед БНХАУ хол тэргүүлж, ОХУ нь тус улсын нийт гадаад худалдааны

103 Id. “... Шинэ Зеланд нь цусан эврийн хамгийн том үйлдвэрлэгч бөгөөд дараа нь Австрали болон Канад ордог (хурдтай өсөж буй), бөгөөд Солонгос нь хамгийн том хэрэглэгч юм.”

104 Myagmaruren, Sh., Gombobaatar, S., Munkhjargal, M., Conaboy, N., *The First National CITES Report of Mongolia*, MEGD, Steppe Forward Programme, Zoological Society of London, Mongolica Publishing (2014) (54), 451.7 цусан эвэр, халиун бугын 150 цусан эвэр 2002-2014 онд хураагджээ.

105 Deer Antler to Nourish Blood, Bone, and Joints by Subhuti Dharmananda, Ph.D., Director, Institute for Traditional Medicine, Portland, Oregon.

106 Wingard, J. and P. Zahler (2006).

107 The Conversation, *The Changing World of Perfume and Why Some Chemicals are Being Taken Out*, (Nov. 27, 2014) <https://theconversation.com/the-changing-world-of-perfume-and-why-some-chemicals-are-being-taken-out-34502> хаягаар үзнэ үү.

108 Ферм дээр 2005 оны судалгааны үеэр очсон ба энэ судалгааны хүрээнд очоогүй.

109 МХЕГ-тай хийсэн хувийн ярилцлага. Хараат бусаар баталгаажуулсан

110 Nyambayar, B., Mix, H. & Tsytsulina, K. 2015. *Moschus moschiferus*. The IUCN Red List of Threatened Species 2015: e.T13897A61977573.

111 Id. 1,253 арьс 2012 онд хураагдсан. 2002 оны эхний хагасаас 2014 онд 30,000 гаруй арьс хураасан.

112 China Daily, *Official Statistics Key to China's Fur Farming Industry*, (Aug. 20, 2016) [http://www.chinadaily.com.cn/business/2015-08/20/content\\_21659731.htm](http://www.chinadaily.com.cn/business/2015-08/20/content_21659731.htm) хаягаар үзнэ үү.

эргэлтийн дөнгөж 11 хувийг бүрдүүлэх болсон.<sup>113</sup> БНХАУ-ын худалдааны энэхүү давамгайллыг сөрөн тэнцвэржүүлж, ОХУ-тай тогтоосон эдийн засгийн харилцаагаа гүнзгийрүүлэх зорилго тавьж буй Монгол Улсын хүсэл эрмэлзэл нь хөрш орнуудтайгаа хийх ОХУ-ын худалдааны байр суурийг нэмэгдүүлэх талаар ерөнхийлөгч Путины сонирхолтой нийцэж байгаа юм.

Монгол Улс гадаад худалдааны харилцаагаа сайжруулах ашиг сонирхол ихээхэн байгаа ч ОХУ-тай хийх худалдааны тэнцлийг сайжруулах тал дээр амжилтад хараахан хүрээгүй байна. Сүүлийн жилүүдэд экспортын хэмжээ нэмэгдсэн ч импортын хэмжээ илүү их өсчээ. ОХУ-тай хийж байгаа худалдаанд Монгол Улсын хүлээж буй гадаад худалдааны алдагдал сүүлийн 20 жилийн хугацаанд хурдацтай ихсэж, 2012 онд гадаад худалдааны алдагдал хамгийн өндөр хэмжээндээ буюу 1.769 тэрбум ам. доллар хүрчээ.<sup>114</sup>

Ийм дүр зураг хоёр орны хоорондын зэрлэг амьтны худалдаанд ч харагдаж байна. Хуучин Зөвлөлт засгийн үед Монгол Улсын бүхий л нөөц, түүний дотор зэрлэг амьтны нөөцийг шууд хянах боломжтой байсан. Тухайн үед Монгол Улсаас импортоор авдаг зэрлэг амьтны гаралтай гол бүтээгдэхүүний тоонд төрөл бүрийн үслэг эдлэл болон тарвага, чоно, өмхий хүрэн, үнэгний арьс багтдаг байв. Монгол Улсаас импортлон авсан бүтээгдэхүүнээрээ ОХУ хүрэм болон үслэг эдлэл үйлдвэрлэж байв. 1991 онд ЗХУ задран унасны дараа ч Монгол Улс зэрлэг амьтны гаралтай үслэг эдлэлийг ОХУ-ын үслэг эдлэлийн салбарт нийлүүлсээр байжээ. Түүнээс хойш зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний албан ёсны худалдааны талаарх мэдээллийг CITES-н хэрэгжилтийн мэдээллээс салгаж мэдээлэхээ больж харин зэрлэг амьтан, үслэг эдлэл, арьс ширний худалдааны ерөнхий мэдээлэл гаргаж байв. Ийм ерөнхий мэдээлэл нь зэрлэг амьтны зүйлээр задаргаагүй байдаг ч гадаад худалдааны эргэлтэд зэрлэг амьтан орж байгаа нь тодорхой юм. Хоёр орны хоорондын худалдааны тэнцэлд гарч буй эрс өөрчлөлт нь зэрлэг амьтны худалдаанд гарч буй өөрчлөлтийг ч мөн илэрхийлэх үзүүлэлт болж байдаг. 1996-2015 оны хооронд хийсэн худалдааны мэдээллийг График 2-т үзүүлээ. Эхний ангилал буюу мал, амьтан хэмээх ангилалд амьд амьтны худалдаа багтдаг бөгөөд энд зэрлэг амьтныг мөн хамруулдаг. Өнөөг хүртэл энэ төрлийн худалдаа Монгол Улсын худалдааны эргэлтэд дорвитой хүчин зүйл болж чадаагүй байгаа юм. CITES-н хэрэгжилтийн тайланд цөөн хэдэн амьтны худалдааг дурдсан ч циркийн амьтан төдийхнөөр хязгаарлагдсан байна. Хоёрдугаар ангилалд бүх төрлийн арьс ширний

113 Sneath, David, *Russia's Borders: Mongolia Looks to Its Old Big Brother to Counterbalance China*, The Conversation (Jan. 27, 2015), <https://theconversation.com/russias-borders-mongolia-looks-to-its-old-big-brother-to-counterbalance-china-36721> хаягаар үзнэ үү.

114 (footnote 20) N. Otgonsaikhan, *The Current Situation for Mongolian Foreign Trade and Cooperation with Northeast Asian Countries*, Erina Report 127 (Dec. 2015) (8), available at [http://www.erina.or.jp/en/wp-content/uploads/2015/02/se12712\\_tssc.pdf](http://www.erina.or.jp/en/wp-content/uploads/2015/02/se12712_tssc.pdf) хаягаар үзнэ үү.

гадаад худалдааны эргэлтийг харуулж буй бөгөөд үүнд зэрлэг амьтны арьс, үс мөн хамаарна. 1996 оны байдлаар ОХУ-д албан ёсоор 412 мянган ам.долларын үнэ бүхий арьс шир экспортсон бол ОХУ-аас авсан импортын хэмжээ харьцуулшгүй бага байжээ. Харин 2015 онд гадаад худалдааны эргэлтэд эрс өөрчлөлт гарч, ОХУ-аас авсан импортын бараа эргэлт 793 сая ам.долларт хүрсэн бол, Монгол Улс дөнгөж 22 мянган ам.долларын бүтээгдэхүүн экспортложээ.

Магадгүй худалдааны тэнцэлд гарсан энэхүү огцом өөрчлөлт нь зах зээлд гарсан өөрчлөлттэй ерөнхийдөө хамааралтай байж болно. Өнөөдөр дэлхийн зах зээл дээр үслэг эдлэлийн түүхий эдийг аж ахуйн нэгжүүдээс шууд авдаг болсноор хямд, хялбар, нийлүүлэлт нь баталгаатай байх болжээ. Одоогоор дэлхийн үслэг эдлэлийн зах зээлийн нийт хэрэгцээний дөнгөж 15 хувийг л зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүнээр хангаж байгаа бол үлдсэн 85 хувийг нь фермийн аж ахуйнуудаас хангаж байна.<sup>115</sup>

Товчхондоо, эдгээр ангиллын худалдааны тэнцэл болон түвшин Монгол Улсад ч эрс өөрчлөгдөж, тус улс нь экспортлогч гэхээсээ илүү импортлогч улс болжээ. Хэдийгээр Монгол Улсын мал, амьтны экспортын хэмжээ үндсэндээ өөрчлөлтгүй байгаа ч ОХУ-аас авах импортын хэмжээ огцом нэмэгдэж, 1996 онд 0.5 сая ам, долларын хэмжээнд байсан импортын бараа эргэлт 2015 он гэхэд бараг 9 сая ам. долларт хүрсэн байна. Монгол Улсаас хийж буй үслэг эдлэлийн албан ёсны экспорт 1996 оны түвшний дөнгөж 5 хувь болтлоо унасан бол ОХУ-аас авах импортын бараа эргэлт энэ хугацаанд 30 дахин нэмэгджээ. Судалгааны явцад хойд хөршөөс гаралтай үслэг эдлэл зарж буй бэлэг дурсгалын зүйлсийн дэлгүүрийн тоо нийслэл хотод олноор нэмэгдсэн нь ажиглагдсан.<sup>116</sup>


Үүнд голлох нөлөө үзүүлсэн хоёр хүчин зүйл байж болох ч эдгээрийн чухам аль нь шийдвэрлэх хүчин зүйл болж байгаа, улмаар үслэг эдлэлийн үйлдвэрлэлээс хамаарч зэрлэг амьтны худалдаанд гарсан өөрчлөлтөд дээрх хүчин зүйлүүд чухам ямар нөлөө үзүүлсэн нь тодорхойгүй байна. Нэгдүгээр шалтгаан нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх Монгол Улсын чадавх нэмэгдсэн байж болно. Олон тооны дэлгүүрүүд Монгол Улсад үйлдвэрлэсэн сайн чанарын үслэг эдлэл борлуулж байгаа нь арьс ширнийг боловсруулахаар гадаадад экспортолдог байсан 2005 оны нөхцөл байдлаас эрс ялгаатай юм. Хоёрдугаарт, зарим төрлийн зэрлэг амьтан агнахыг бүрмөсөн хориглосны зэрэгцээ заримыг нь агнах хорио, хязгаарлалтыг тогтоосон (тухайлбал, чоно, тарвага гэх мэт) байна. Эдгээр хүчин зүйлс нь Монгол Улс болон ОХУ-ын хоорондын зэрлэг амьтны худалдаанд гарсан гэнэтийн өөрчлөлтийг

115 *Farmed Fur*; Int 'l Fur Trade Fed 'n, <http://www.iftf.com/#/farmed-fur/>; We Are Fur, *Fur Farming*, [www.wearefur.com/about-fur/fur-farming](http://www.wearefur.com/about-fur/fur-farming); SPCA

116 Бодит эх үүсвэрийг баталгаажуулаагүй. Энэ мэдээлэл нь зөвхөн ажиглалт дээр суурилсан бөгөөд ОХУ-аас авчирсан хэмээн мэдээлж байсан.

авчирсан гэж тайлбарлаж болох юм.

График 2. Монгол Улс болон ОХУ хоорондын Зэрлэг амьтны худалдааны харилцааны түүхэн хөгжил (1996, 2015 он)<sup>117</sup>



## Монгол Улс дамжуулагч улс болсон нь нотлогдож байна

Монгол Улс нь зэрлэг амьтны хууль бус худалдааг дамжуулагч улс мөн эсэхийг 2005 оны анхдугаар “Зэлүүд тал” тайланд хараахан тодорхойлж чадаагүй билээ. Энэ тайлангийн өмнөх хэсэгт Монгол Улс нь зэрлэг амьтны худалдааг дамжуулагч улс болон хувирах эхлэл тавигдаж байгаагийн зэрэгцээ зэрлэг амьтны худалдааны асуудлууд тулгамдаж байгааг нотлон өгүүлсэн.

Өнөөгийн байдлаар Монгол Улс дамжин өнгөрүүлэх илэрхий том маршрут биш ч тээвэрлэлтийн дэд бүтэцтэй (Монгол Улсыг хойноос урагш нэвт дамжин өнгөрөх Монгол Улс, ОХУ-ыг холбосон төмөр зам, авто замын сүлжээ), мансууруулах бодис, хүн худалдаалах зэрэг бусад төрлийн хууль бус худалдааны дамжин өнгөрөх зам хэдийнээ болчихоод байгаа нь тодорхой болоод байна.<sup>118</sup> Зэрлэг амьтны хууль бус худалдаа нь дэлхийн зохион байгуулалттай гэмт хэргийн нэг хэсэг болж, энэхүү худалдааны томоохон зах зээл болох БНХАУ-тай хаяа нийлэн тээвэрлэх гол чиглэлд оршдог Монгол Улс нь зэрлэг амьтны хууль бус худалдааны дамжуулагч улс хэмээн хэдийнээ тооцогдох болсон. Цаашид ч энэ байдал үргэлжлэн нэмэгдэх магадлалтай төдийгүй илүү нарийсах нөхцөл байдал бий болоод байна.

Судалгааны үеэр цагдаа, гаалийн газраас авсан мэдээлэл ч энэхүү дамжуулагч улс болсон статусыг бататган өгч

117 Дэлхийн худалдааны нэгдсэн мэдээллийн сангаас авсан-World Integrated Trade Solution (<http://wits.worldbank.org>)

118 Mongolia. Trafficking in Persons Report 2016. US State Department (July 1, 2016).

байгаа юм. Судалгааны тайланд худалдаалагдах эрсдэлд орж байгаа хэд хэдэн зүйл байгааг ч мөн тодорхойлсон. Нэг тохиолдлыг жишээ болгон дурдвал, Казахстан Улсаас Монгол Улсаар дамжуулан худалдаалж байсан бөхөнгийн 100 эвэр БНХАУ руу тээвэрлэгдэх замдаа Монгол Улсад саатуулагдаж байжээ.<sup>119</sup> Мөн өөр нэг худалдаачин Монгол Улсад огт байдаггүй арслангийн арьс авч явсан тохиолдол гарчээ.<sup>120</sup> 2016 онд Баян-Өлгийн хилийн боомтоор дамжуулан Борцгор хотонгийн хошууг (CITES-н Нэгдүгээр хавсралт) Монгол Улсаар дамжуулан БНХАУ руу тээвэрлэж байсан тохиолдлыг Гаалийн албаныхан илрүүлсэн байдаг.

Өнөөгийн байдлаар Монгол Улс нь ямар түвшинд дамжуулагч улс болоод буйг тодорхойлоход хүндрэлтэй байгаа нь Эрүүгийн хуулийн зарим цоорхой (Тавдугаар бүлэгт дэлгэрэнгүй дурдсан), бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт сул байгаа (тухайлбал, Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцод (CITES) заасан хоригийг дотоодын хууль тогтоомжид тусгаагүй) зэргээс үүдэлтэй байна. Монгол Улсын Эрүүгийн хуульд 2016 оны 9 дүгээр сард нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнө Монгол Улсаас гарал үүсэлгүй зэрлэг амьтны бүтээгдэхүүн эзэмшихийг эрүүгийн гэмт хэрэгт тооцогдгүй байсан. Хуулийн энэхүү цоорхойгоос болж дамжуулан худалдаалж байсан олон тохиолдлыг ‘орхигдуулж’ байсны зэрэгцээ гэмт хэргийг баримтжуулах, мөрдөн шалгах боломжийг хааж, тэр ч байтугай, зохицуулах хууль тогтоомжгүй, гарал үүсэл тодорхойгүй гэх шалтгаанаар шүүх хэргийг хэрэгсэхгүй болгож байжээ.

Гэхдээ энэ нь ерөнхий эрх зүйн орчинд бий болсон “орхигдол” биш юм. 2002 оноос CITES-н хэрэгжилтийг зохицуулж байгаа Монгол Улсын хууль тогтоомжуудад тус конвенцийн Нэгдүгээр хавсралтад орсон зүйлүүдийг олон улсын хэмжээнд арилжааны зорилгоор худалдаалах<sup>121</sup> нь хууль бус хэмээн заасан байна.<sup>122</sup> Дамжуулан өнгөрүүлэхтэй холбоотой тавигдах шаардлагуудын нэг бол ре-экспорт хийх зөвшөөрлийг CITES-н Удирдан зохицуулах зөвлөлөөс авч байх явдал байдаг.<sup>123</sup> 2015 онд Зөрчлийн тухай хуулийг багшлахаас өмнө зохих зөвшөөрөлгүйгээр гадаад худалдаа хийсэн тохиолдолд иргэнд 50,000, төрийн албан хаагчид 60,000, аж ахуйн нэгжид 250,000 хүртэл төгрөгийн торгууль ногдуулдаг байжээ.<sup>124</sup> Түүнчлэн ногдуулж болох шийтгэлийн доод хэмжээ ямар байхыг заагаагүй, хорих төрлийн ял ногдуулаагүй төдийгүй Монгол Улсад байдаггүй зэрлэг амьтны худалдааны

119 Гаалийн мэдээлэл; Судалгаанд оролцогчидтой хийсэн ярилцлага

120 Гаалийн мэдээлэл; Судалгаанд оролцогчидтой хийсэн ярилцлага

121 Зэрэг амьтан, ургамлын ховордсон зүйлсийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль. 7.1.

122 Мөн адил. 7.6 дугаар зүйл.

123 Мөн адил. at 8 болон 9 дүгээр зүйл

124 Мөн адил. at 15.1.1 дүгээр заалт

зохицуулалт байхгүй байжээ. Жишээ болгон дээр дурдсан хил дамжуулан худалдаалсан хэргүүдийг Эрүүгийн хуулийн энэхүү цоорхойгоос үүдэн, CITES-ын хэрэгжилтийг хангах зорилготой Монгол Улсын хууль тогтоомжийг үл хэрэгсэн хүчингүй болгосон байдаг. Харин хуулийн энэхүү цоорхойг Монгол Улсын шинэчлэгдсэн Эрүүгийн хуулиар нөхсөн бөгөөд үүнээс гарах үр дүнг үнэлэхэд арай эрт байна (Олон улсын зэрлэг амьтны худалдааны асуудлаарх Монгол Улсын эрх зүйн орчин гэсэн Дөрөвдүгээр бүлгийг үзнэ үү).

Дээрх хуулийн цоорхой нь хэргийг шүүн таслах үйл ажиллагаа явуулахад ч мөн нөлөөлсөн байх магадлалтай. Нотлох баримтыг хадгалж байхыг шаардсан протокол байхгүйн улмаас хураан авсан нотлох баримтыг хадгалдаггүй учир дахин үргэлжлүүлэн шалгах боломжгүй болдог. Илт тодорхой болсон нэг зүйл бол өөр улсаас “хил дамжуулан худалдаалсан” зарим хэргүүдэд Монгол Улсад бас байдаг зүйлүүд болох бөхөн гөрөөс болон борцгор хотон зэрэг амьтад хамрагдсан явдал юм. Гэхдээ тухайн зүйлийг Монгол Улсад хууль бусаар агнасан эсэх нотолгоо, эсвэл Монгол Улсаас гаралтай эсэх талаарх шинжээчийн дүгнэлтгүйгээр прокурорын байгууллага нь харьяаллын асуудлаар хуучин Эрүүгийн хуулийг эргүүлэн ашиглах боломжгүй юм. Тухайн амьтан, бүтээгдэхүүний гарал үүсэл Монгол Улсад харьяалалгүй хэмээх нэхэмжлэл нь тухайн хэргийг хүчингүй болгох хангалттай нөхцөл болдог байжээ.

Нөгөө талаар CITES-ын холбогдох зохицуулалтыг баримталж байгаа хэдий ч ногдуулж буй торгуулийн хэмжээ нь тухайн гэмт хэргийг цаашид гаргуулахгүй байх үр дүнтэй нөхцөл болох эсэх нь тодорхойгүй байна. Нэг эврийн үнэ 250 гаруй ам.доллар гэж үзвэл<sup>125</sup> Казахстан Улсын худалдаачдын нэг удаагийн худалдаа 25.000 ам.долларын хэмжээнд хүрч байна. Гэтэл CITES-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор хувь хүнд 50.000 төгрөгийн (20 ам.доллар) торгууль ногдуулж байгаа нь бөхөнгийн нэг ширхэг эвэрний үнийн аравны нэгд ч хүрэхгүй байна. Худалдаалахаар завдсан эврийг хураан авсан ч тухайн гэмт хэргийг үйлдэхээр завдсаны төлөө ногдуулж буй шийтгэл нь олохоор зорьж байсан ашгийнх нь маш бага хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн нэг удаагийн хууль бус худалдаа хийх үйлдлээрээ олохоор зорьж байгаа ашгаас нь мянга дахин бага хэмжээгээр торгож байна. Гэтэл зохицуулалтын орчин бүрдүүлсэн олон туршлагаас харахад ногдуулж буй торгууль нь олох байсан ашгаас нь хэд дахин илүү байх тохиолдолд л тухайн хууль бус үйлдлийг дахин гаргуулахгүй байх боломжтой юм. Өөрөөр хэлбэл, торгуулийн хэмжээ нь бизнес эрхлэхэд тулгарах энгийн зардлуудын нэг хэсэг хэмээн тооцогдохоор бага хэмжээтэй байж болохгүй.<sup>126</sup>

125 Мэдээлж буй үнэ нь ялгаатай ч нэг эврийг 30 доллараар зарж байсан 1990 оноос хойш эрс нэмэгдсэн. 2013 онд БНХАУ-ын албаны хүмүүсийн мэдээлснээр Казахстангаас оруулж ирсэн 4,470 эврийг хурааж нийт үнийг тооцоход 22 сая ам.доллар хүрсэн буюу нэг эвэр бараг 5,000 ам.долларт хүрсэн байна.

126 “Crime and Punishment: An Economic Approach” by Gary S.

Дамжуулан худалдаалах хэргүүдийг иж бүрнээр нь мөрдөн шалгаагүй ч энэхүү судалгааны хүрээнд хийсэн ярилцлагууд, хууль сахиулах ажиллагааны мэдээллээс үзвэл Монгол Улс нь хууль бус зэрлэг амьтны бүтээгдэхүүний худалдааг дамжуулагч улс аль хэдийн болсныг илэрхийлж байна. Эрүүгийн хуульд орсон шинэ өөрчлөлтүүд нь тулгамдаж байсан хуулийн цоорхойг хааж, зэрлэг амьтны хууль бус худалдаанд гүн гүнзгий орооцолдоод байгаа Монгол Улсаа татан гаргахад чухал хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

Becker, Journal of Political Economy, Vol. 76, No. 2 (Mar. - Apr., 1968), pp. 169-217

# CITES-н худалдаанаас өөрчлөлтийг олж харахуй

Энэ хэсэгт Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах CITES-ын хүрээнд Монгол Улсад хийж буй худалдаа, түүний хандлагыг хэлэлцэх юм. Юуны өмнө тайланд яригдах тоо хэмжээ нь бусад зүйлүүд болон бүс нутгийн худалдаа эргэлтийн тооноос ихээхэн доогуур, бага гэдгийг дурдах нь зүйтэй. Зарим зүйлийн болоод бүс нутгийн худалдаа эргэлтийн тоо хэмжээ нь хэдэн мянга, саяар яригддаг бол Монгол Улс дахь худалдааны зүйлүүд хэдэн арваар (тухайлбал, чоно), эсвэл хэдэн мянгаар (тухайлбал, идлэг шонхор) тооцогдоно. Гэхдээ тоо хэмжээ цөөн байгаа нь эдийн засгийн болон экологийн үнэ цэнэ бага байна гэсэн үг биш юм. Монгол Улсын хуурай газар нутагт шавж, мэрэгч гэх мэт зүйлүүд маш олон тоогоор амьдрах боломжтой байдгаараа онцлог. Тарвагыг эс тооцвол хууль бус худалдааны бай болж, аюулд өртөж буй зүйлд том хэмжээний өвсөн тэжээлтэн, махан идэштэн, мөн өндөр үнэ хүрдэг шувуудын зарим төрөл зүйл орж байна. Халуун орны амьтны худалдааны квоттой харьцуулахад Монгол Улсын ан агнуурын болон худалдааны квот нь маш бага юм. Тухайлбал, жилд агнах саарал чонын квот гэхэд 2015 онд чонын нийт тоо толгой нь 10,000- 20,000 байхад дөнгөж 20 байжээ.<sup>127</sup> Үүнийг Монгол Улсын газар нутгийн гуравны нэгтэй тэнцэх хэмжээний нутаг дэвсгэртэй, чонын нийт тоо толгой нь 2,000-2,500 хүрдэг мөртлөө жилд 200 чоно агнах квоттой Испани Улстай харьцуулахад маш бага тоо билээ.<sup>128</sup>

Монгол Улсын ан агнуурын болон худалдааны квотыг ийнхүү бага тогтоож байгаа нь газар нутгийн хатуу ширүүн орчинд амьдарч буй зүйлүүдийг тогтвортой амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилго агуулдаг. Ихэнхдээ, CITES-ын хүрээнд экспортлох зэрлэг амьтны албан ёсны тоо хэмжээг мэргэжилтнүүд тогтоохдоо тухайн амьтны байгалийн хатуу ширүүн нөхцөлд тэсч амьдрах, өсч үржих магадлалыг хангахуйц тоо хэмжээг тооцдог. Гэтэл бүхий л тохиолдолд хууль бус худалдаа энэ хязгаарыг давж байгаа юм.

127 Mech, D.L and L. Boitani (2003) Wolves: Behaviour, Ecology and Conservation. P. 448.

128 Espaca autoriza la caza de centenares de lobos pero oculta el número total de muertes, in El Diario online available at [http://www.eldiario.es/sociedad/Espana-autoriza-caza-lobos-oculta-muertes\\_0\\_371663169.html](http://www.eldiario.es/sociedad/Espana-autoriza-caza-lobos-oculta-muertes_0_371663169.html) хаягаар үзнэ үү.

## Албан ёсны тоо мэдээлэл нь бодит байдлыг бүрэн илэрхийлэхгүй байна

CITES-ын дагуу албан ёсны худалдаа хийж байгаа хандлага Монгол Улсад ажиглагдаж байгаа хэдий ч хамгийн ноцтой хэсэг нь ил тод биш байна. Конвенцийн хүрээнд хийж буй албан ёсны худалдаа хэрхэн өөрчлөгдөж байгаа, шинээр үүсэн бий болж буй хэрэглээ болон худалдааны хэв шинжийг дараах хэсэгт үзүүлээ. Албан ёсны тоо мэдээнээс үзэхэд: 1) жилээс жилд импорт нэмэгдэхийн хэрээр Монгол Улс нь зэрлэг амьтны худалдааны хэрэглэгч орон болж буйг нотолж байна; 2) энэ төрлийн худалдаанд амьд амьтны худалдаа давамгайлах болж байна, 3) нэн ховор зүйлийн экспортод үндсэндээ өөрчлөлт гараагүй байгаа хандлага харагдаж байна.

Эдгээрээс ялангуяа, сүүлчийн хандлагын цаана бүүр анхны “Зэлүүд тал” тайланд онцолсон зэрлэг амьтны хууль бус худалдааны асуудал нуугдаж буй юм. Хууль бус экспорт нь албан ёсны экспортоос хавьгүй их (зарим тохиолдолд хэд дахин их) хэмжээтэй байгааг илрүүлсэн зарим тохиолдол болон хууль сахиулах байгууллагуудын мэдээллийг ашиглан хангалттай байдлаар нотолж болно.

Үүнийг чонын худалдаа маш тод томруун харуулж байна. Гаалийн ерөнхий газрын мэдээллээс үзэхэд сүүлийн жилүүдэд хууль бусаар хил нэвтрүүлэх оролдлого хийсний улмаас хамгийн ихээр хураагдаж буй амьтан нь чоно, түүний бүтээгдэхүүн байна. 2009 он гэхэд албан ёсны 56 зөвшөөрлийн хүрээнд (17 арьс, 15 трофи агнуур, 2 амьд чоно, 20 эд эрхтэн, 2 гавал) чонын бүтээгдэхүүн экспортоложээ. Гэтэл тэр жилдээ гааль дээр хураасан нь зөвшөөрсөн хэмжээнээсээ 6 дахин олон буюу 312 чонын хөлдөөсөн гулууз хураажээ. Мөн 2018 онд 8 арьс, 2 трофи агнуурын зөвшөөрөл олгосон ч хууль бус худалдаанаас 232 шүд, хоншоор хураажээ.<sup>129</sup> Хууль бусаар худалдаалж буй хичнээн хэмжээний ийм бүтээгдэхүүн хурааж болохыг бүрэн тогтооход төвөгтэй ч чухамдаа хураагдаж байгаа нь Монгол Улсын зэрлэг амьтны хууль бус худалдааны өчүүхэн хэсгийг илэрхийлж байх магадлалтай.

Эдгээр жишээнээс гадна БНХАУ руу манайхаар дамжин гарч байсан Казахстан Улсаас гаралтай бөхөнгийн эвэр, гарал үүсэл нь тодорхойгүй борцгор хотонгийн хошуу болон арслан авч гарах оролдлого зэргийг гаалийн бүртгэлд тусгаагүй байсан талаар анхдугаар “Зэлүүд тал” тайланг бэлтгэх явцад олж тогтоосон байдаг. Мөн

129 Myagmaruren, Sh., Gombobaatar, S., Munkhjargal, M., Conaboy, N., *The First National CITES Report of Mongolia*, MEGD, Steppe Forward Programme, Zoological Society of London, Mongolica Publishing (2014) (54), 2009 онд 312 хөлдүү чоно хил дээр хураасан, 2013 онд 232 чонын шүд хураасан.

эдгээр нь CITES-ын хүрээнд олгодог зөвшөөрөлтэй импортын мэдээлэлд ч ороогүй байсан юм.

Нөгөөтэйгүүр, албан ёсны худалдаатай харьцуулахад хууль бус худалдаа ямар хэмжээнд явагдаж буйг бодитойгоор тодорхойлох хялбар арга зам байхгүй юм. Хил дамнуулан хууль бусаар худалдаа хийхэд амьтны арьс, гулуузыг авто машины дугуйд нуух, тусгайлан тэмдэглэсэн нууц газар хийх, нөөц дугуйны хонхорт хийх зэрэг олон аргыг ашиглаж байна.<sup>130</sup> Ил болсон нэг арга бол дотоодын хэрэгцээнд ан агнах албан ёсны зөвшөөрөл авсан тоо хэмжээнээсээ зориуд хэтрүүлэн агнаж, улмаар гадаад худалдаанд оруулах явдал юм. Ан агнуурын квот маш багаар олгож байгаа ч<sup>131</sup> дотоод худалдааг үндсэндээ хориглоогүй байна. Жишээлбэл, чонын арьсыг Улаанбаатар хотын төв Их дэлгүүрт ил чөлөөтэй худалдаалж байна. Улаанбаатар хотын бараг бүх хорооллын дэлгүүрүүдээр гоёл чимэглэлийн зориулалт бүхий чонын соёо, арьс худалдаалж, зах зээлийн судалгаа хийж явсан судлаачдад худалдан авахыг санал болгож байх жишээтэй. Эдгээр бараа бүтээгдэхүүнийг гадаадын худалдан авагчдад хэрхэн борлуулж буйг бүрэн тогтоох боломжгүй бөгөөд гадаадын худалдан авагчид бол зорилтот зах зээлийн нэг хэсэг болох нь гарцаагүй.

Хууль сахиулах байгууллагуудын мэдээлэл болон CITES-ын хэрэгжүүлэх хүрээнд хийсэн экспортын мэдээллийг харьцуулан үзэхэд олгосон зөвшөөрлийн тоо нь олон улсад худалдаалсан тоо хэмжээнээс ихээхэн доогуур байна. Гаалийн ерөнхий газрын Эрэлч нохойн алба нь гаалийн 15 агуулах, салбарт 50 эрэлч нохой ажиллуулж, 2011-2013 оны хооронд буюу 3 жилийн хугацаанд зэрлэг амьтны гаралтай үслэг эдлэлийг хууль бусаар худалдаалсан 245 хэргийг илрүүлжээ.<sup>132</sup> Гэтэл тухайн гурван жилийн хугацаанд CITES-ын хүрээнд экспортын зөвшөөрөл 110 ширхэгийг олгосон байдаг.<sup>133</sup> Цаашилбал, Эрэлч нохойн албаны илрүүлсэн нийт эд зүйлийн 80 орчим хувь нь зэрлэг амьтны үс байсан бол үлдсэн 20 орчим хувь нь согтууруулах ундаа, тамхи, эм, түүхий мах болон ноолуур хууль бусаар тээвэрлэж байсан хэрэг байжээ. Харамсалтай нь бодит байдал дээрээ, Эрэлч нохойн алба нь хууль бусаар худалдаалж буй зүйлийн зөвхөн багаахан хэсгийг л илрүүлэх боломжтой байдаг тул хууль бус худалдааны дийлэнх нь далд нууцлаг хэвээр үлдэж байна.

130 Эх үүсвэр: Гаалийн гэмт хэргийн мэдээллийн сан, 2016.

131 2016 ангийн квот: Дугаар 463 ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР 2016 ОНД АГНАХ АГНУУРЫН АМЬТНЫ ТООГ ТОГТООХ ТУХАЙ

132 Гаалийн эрэлч нохойн алба <http://www.customs.gov.mn/en/2012-03-14-03-21-37/2012-03-14-03-24-07>. 5 сарын 17, 2017

133 CITES худалдааны мэдээллийн сан (<https://cites.org>) Retrieved on November 12, 2016

## Монгол Улс гадаадын зэрлэг амьтны бүтээгдэхүүнийг хэрэглэгч орон болжээ

CITES-ын тайлан мэдээнээс үзэхэд Монгол Улс гадаадын зэрлэг амьтны бүтээгдэхүүн хэрэглэгч орон болж байгаа нь харагдаж байна. Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжсэний дараахан буюу 1996 онд CITES-д нэгдэн орсон тэр үед зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах зах зээлд ханган нийлүүлэгч орон хэмээх статустай байв. Харин CITES-д нэгдсэний дараах 10 жилийн хугацаанд Монгол Улсын экспортын зөвшөөрлийн тоо огцом нэмэгдэж эхний жил болох 1996 онд 20 байснаа 2005 онд 60 болж өссөн. Хоёрдахь 10 жилийн хугацаанд экспорт аажмаар багасч, 2013 он гэхэд зөвшөөрлийн тоо 30-с доош болж буурсан. Энэхүү CITES-ын хүрээнд хийсэн экспортын бараа эргэлт, импортын бараа эргэлтээс эрс тэс ялгаатай байна. Тухайлбал, CITES-д нэгдсэнээс хойших эхний арван жилд олгосон импортын зөвшөөрөл жилд дунджаар 10 хүрэхгүй байсан нь гадаад худалдааны тэнцэлийн өчүүхэн хувийг эзэлж байв. Харин дараагийн 10 жилд огцом өөрчлөлт гарч 2006 онд импортын 10 зөвшөөрөл олгож байсан бол 2013 он гэхэд 40 гаруй болж нэмэгджээ.<sup>134</sup> Эхний арван жилийн хугацаанд нийт олгосон импортын зөвшөөрөл 85 байсан бол дараагийн арван жилд энэ тоо бараг гурав дахин нэмэгдэж 249 болсон. Өөрөөр хэлбэл, CITES-н дагуу олгосон импортын нийт зөвшөөрлийн 75 хувийг нь 2006-2015 онуудад олгожээ. Энэ хугацаанд олон улсын конвенцийн дагуу хийсэн экспортын хэмжээ буурч байсан бөгөөд 2011 онд, анх удаа, экспорт, импортын зөвшөөрлийн тоо бараг тэнцүү болсон байдаг.

График 3. Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенцийн (CITES) дагуу Монгол Улсын олгосон зөвшөөрөл (1996-2015)




Зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр ханган нийлүүлэгч улс орнуудын тоо ихээхэн нэмэгдэж байна. CITES-д нэгдсэнээс хойших эхний арван жилд Монгол Улс гадаадын 24 орноос зэрлэг амьтны бүтээгдэхүүн импортолсон байна.

134 Сонирхолтой нь сүүлийн арван жилээс 2015 онд ганцхан зөвшөөрөл олгосон байдаг

Импорттын дийлэнхийг нь зэрлэг амьтны хамгийн том экспортлогч арван орны тоонд ордог Европын 6 орноос, тухайлбал, (ач холбогдлын дарааллаар) Дани, Швейцар, Нидерланд, Франц, Австри болон Их Британиас авсан байна. CITES-д нэгдсэнээс хойших хоёр дахь арван жилд зэрлэг амьтны бүтээгдэхүүн ханган нийлүүлэгч буюу Монгол Улсын импортлогч орны тоо 24-өөс 43 болж нэмэгджээ.<sup>135</sup> Энэ хугацаанд худалдааны ихэнх түншүүд нь бүс нутаг дахь худалдааны хөгжлийн ерөнхий хандлагын дагуу Америк болон Ази тив рүү шилжиж, АНУ, Колумб, Тайланд, Энэтхэг, БНХАУ болон Вьетнам зэрэг улс эхний байруудыг эзлэх болсон (График 4-г үзнэ үү).

График 4. 1996-2005 болон 2006-2015 онуудад CITES-ын дагуу хийсэн Монгол Улсын импортын чиг хандлага



Импорттын албан ёсны мэдээлэл нь гадаад худалдаа эргэлтийн бүрэн дүр зургийг харуулахгүй байгаа ч Монгол Улсын зэрлэг амьтны бүтээгдэхүүний эрэлт, хэрэгцээ хэрхэн нэмэгдэж, өөрчлөгдөж буйг харуулах үзүүлэлт болж чадна. Өөрөөр хэлбэл, тус улс нь зөвхөн дотоодынхоо бус гадаадын орнуудын зэрлэг амьтны бүтээгдэхүүнд дурлагч, хэрэглэгч болжээ.

135 Үүнд Монгол Улс руу экспорт хийж буй 39 улс болон ре-экспорт хийж буй 4 улс орсон. Конвенцийн дагуу хийсэн импорттын дийлэнх нь экспортлогч орноосоо бус гурав дахь орноос гаралтай байна. 1996-2015 онуудад олгосон 304 импорттын зөвшөөрлийн 211 (69%) нь ханган нийлүүлэгч орноос өөр улсаас импортлох зөвшөөрөл байв.

Албан ёсны мэдээллээс үзэхэд CITES-ын жагсаалтад орсон 73 зүйлийг импортлосны 97 хувийг 27 орноос, үлдсэн багахан хувийг өөр орнуудаас импортлосон байна (График 5, 6-г үзнэ үү). Бусад олон төрөл зүйл энэхүү худалдаанд өртөж байгаа хэдий ч CITES-ын хэрэгжилтийн тайлан, бусад мэдээлэл, судалгаанд тусгагдаагүй байна. Судалгааны үеэр эртний эдлэлийн болон гоёл чимэглэлийн дэлгүүрээр орж үзэхэд хязгаарлагдмал тоотой ч зааны соёогоор хийсэн савх, хөөрөг зэрэг эд зүйлс худалдаалж байгаа нь ажиглагдаж байлаа.

Өнөөгийн байдлаар Азийн бусад оронд түгээмэл байдаг аварга загасны сэрвээ, хуягт панголин гүрвэл зэрэг өвөрмөц этгээд хоол хүнсний зүйлсийн импортын албан ёсны бүртгэлд (конвенцийн хэрэгжилтийн тайлан бүртгэл, гаалийн бүртгэл болон бусад) байхгүй байна. Түүнчлэн ресторануудад явуулсан судалгаагаар ийм төрлийн хоол хүнс худалдаалж байгаа эсэх нь тогтоогдоогүй. Үүний нэгэн адил гадаад орнуудад үйлдвэрлэсэн уламжлалт эмийн бүтээгдэхүүний хэрэглээ тус улсын ардын уламжлалт эмийн хэрэглээтэй дүйцэхүйц түгээмэл болоогүй байна.<sup>136</sup>

Анхаарал татсан нэг зүйл бол Азийн бусад орнуудын нэгэн адил ард иргэдийнх нь орлого нэмэгдэж, хэрэглээ өсөхийн хэрээр эргээд зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэж байгаа хандлага Монгол Улсад ч мөн ажиглагдаж байна. Хөрш зэргэлдээ орнуудтай нь харьцуулахад тус улсын эдийн засгийн өсөлт харьцангуй өндөр биш байгаа ч нийгмийн тодорхой хэсгийн аж байдал хурдацтай сайжирч байна. Тайлан мэдээллээс харахад, Монгол Улсын чинээлэг хэсэг нь эдийн засгийн өсөлтийн үр шимийг давуу хүртэж байна.<sup>137</sup> Монгол Улсын зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ нь БНХАУ-тай харьцуулахад их биш юм. Гэхдээ л орлогын хуримтлал нэмэгдэхийн хэрээр зэрлэг амьтны бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэж байгаа Ази тивийн ерөнхий хандлага Монгол улсын цөөн жишээн дээр ч ийнхүү батлагдаж байна.

## Амьд зүйлийн худалдаа давамгайлж байна

Гэрийн тэжээмэл амьтны зах зээл хөгжихийн хэрээр амьд амьтан импортлох явдал олон улс оронд ихээхэн түгээмэл болдог. Харин Монгол Улсын хувьд гэрийн тэжээмэл амьтны худалдаа, этгээд сонин амьтан тэжээх асуудал тийм түвшинд хараахан очоогүй байна. Судалгааны явцад нийслэлд үйл ажиллагаа явуулж буй амьтны дэлгүүрүүдийг судалж үзэхэд яст мэлхий, муур, нохой, тоть, болон зарим төрлийн ховордсон далайн загас худалдаалж байна. Энэ нь ийм төрлийн

136 Албаны хүмүүсийн хэлж байгаагаар БНХАУ руу нийлүүлэх зорилгоор баавгайн аж ахуй байгуулан ажиллуулж байгаа тухай яриа байна.

137 The Mongolist блог нь УИХ-ын гишүүдээс АТГ-т ирүүлсэн тоо.

дэлгүүрийн судалгаа хийгээгүй 2005 оны судалгаатай харьцуулахад шинэ зүйл болсон бөгөөд өвөрмөц этгээд төрлийн амьтны том зах зээл ажиглагдсангүй.

Нөгөөтэйгүүр CITES-ын тайланд орсон албан ёсны импортын мэдээллээс үзэхэд өмнө дурдсан импортын зөвшөөрлийн өсөлтийн хандлагыг даган амьд зүйлийн импорт ерөнхийдөө нэмэгдсэн байна. Хүснэгт 1-с харахад 1996-2005 онуудад CITES-ын хүрээнд хийсэн нийт импортын 99 орчим хувийг амьд кактус ургамал, тахь, идлэг шонхор зэрэг амьд зүйлийн импорт бүрдүүлж байна. Энэхүү импортын нийт бараа эргэлт 14,175 ширхэг байгаагийн 90 орчим хувь нь кактус байна.

Өнөөгийн 10 жилд амьд шонхор шувууны импортын худалдаа нилээд анхаарал татаж байна. Импортын худалдааны гол дөрвөн төрөл зүйлийн тоонд идлэг шонхор (*Falco cherrug*), цагаан шонхор (*Falco rusticolus*), эгэл шонхор (*Falco peregrinus*) болон эрлийз шонхор шувуунууд орж байна. Эрлийзжүүлэхдээ хоёр төрлийн шонхрыг (тухайлбал, идлэг, эсвэл цагаан шонхрыг бусад харь төрлийн юмуу шилийн шонхортой) эрлийзжүүлэх замаар үржүүлдэг бөгөөд бие томтой, тэвчээртэй, Ойрхи Дорнодын уур амьсгалд илүү нийцсэн, гоо зүйн хувьд илүү үзэмжтэй хэмээн шонхор үржүүлэгчид цэвэр үүлдрээс нь илүүд үздэг байна.<sup>138</sup>

Гэхдээ эрлийз шонхрыг зэрлэг байгальд тавих нь генетикийн давамгайллыг үүсгэн зэрлэг зүйлсийг мөхөөж магадгүй хэмээн судлаачид үздэг.<sup>139</sup> Иймээс Олон улсын шувуу судлалын (Birdlife International) байгууллагын зүгээс үүнийг хориглох, улмаар эрлийз шонхрыг идлэг шонхор үржүүлж буй газруудад байгальд сул чөлөөтэй тавихыг хориглох чиглэлээр холбогдох байгууллагууд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг олон улсад уриалсан.<sup>140</sup> Монгол Улсын холбогдох хуульд харь амьтныг нутагшуулах, өсгөж үржүүлэхийг хориглодог<sup>141</sup> бөгөөд тэдгээрийн хэрэглээг БОАЖЯ зохицуулахаар заасан.<sup>142</sup> Мөн хуулиар гадаад орноос гаралтай болон түрэмгийлэгч зүйлүүдийг үржүүлэхийг хориглодог хэдий ч эрлийзжүүлэх асуудлыг байгаль орчныг хамгаалах тухай ерөнхий хуулиуд, тусгайлсан төрөл зүйлийг хамгаалах тухай хуулиуд, худалдааны хууль тогтоомжид тодорхой заагаагүй байна.

Хүснэгт 1. CITES-ын дагуу Монгол Улсын хийсэн импортын бараа эргэлт, зүйлээр

1996 - 2005				
САЙТИС-н Импортын Зөвшөөрлүүд				
Тоо хэмжээ, нөхцлөөр				
Нөхцөл	Тоо хэмжээ	Төрөл	Зүйлийн тоо	Зүйл
АМЬД 99%	13,800	Кактус	2	Echinopsis chamaecereus ба Gymnocalycium mihanovichii
	258	Адуу	1	Equus przewalskii
	90	Шонхор	4	Falco cherrug, Falco peregrinus, Falco hybrid ба Falco rusticolus
	27	Бусад	8	
АМЬД БУС	84	Бусад	11	
	14,259		26	

2006-2015 оны хооронд CITES-ын хавсралтад багтсан амьд зүйлийн худалдаа бараг хоёр дахин нэмэгдсэн, ялангуяа, амьд хилэм загасны худалдаа үлэмж хэмжээгээр нэмэгдэж, тахь, идлэг шонхорын худалдаа удаалж байгаа ба тоо нь багасч байна. Хилэм загасны төрөл болох, Хойд Америкийн Номхон далайн эрэг хавиар тархацтай цагаан хилэм (*Acipenser transmontanus*) нь спорт загасчлал сонирхогчдын дунд хамгийн алдартай зүйл юм. Гэхдээ Монгол Улсад энэ зүйлийн худалдаа зөвхөн түрсний худалдаагаар хязгаарлагдаж байна. Өөр нэг зүйл болох шивэр хилэм (*Acipenser baeri*) нь Сибирийн болон Монгол Улсын гол нуурын сав газруудад байдаг. Нийтдээ 32,400 шивэр хилэм импортлосон нь CITES-д нэгдсэнээс хойших хоёр дахь арван жилийн Монгол Улсын амьд зүйлийн импортын нийт бараа эргэлтэд тэргүүлэх байрыг эзэлж байна. Шивэр хилэм нь цэнгэг усны загас бөгөөд түргэн хугацаанд нас бие гүйцдэг усан орчинд тархсан түгээмэл зүйл юм. Судалгааны үеэр Монгол Улсад хилэм загас үржүүлэх загасны аж ахуй байгуулах чиглэлээр зарим ажил хийгдэж байгаа тухай ам дамжсан яриа гарч байсан ч нотолгоо олдоогүй билээ.<sup>143</sup>

138 Dixon, A. (2012). Conservation of the Saker Falcon (*Falco cherrug*) and the use of hybrids for falconry. *Aquila* (2012), Vol. 119, p. 9–19

139 Id.

140 CMS Technical Series No. XX (2014). Saker Falcon (*Falco cherrug*) Global Action Plan (SakerGAP), including a management and monitoring system, to conserve the species.

141 Монгол Улсын Амьтны тухай хууль. 36.4, 2012.

142 Мөн адил. зүйл 36.5.

143 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага.



Хүснэгт 2. CITES-ын хүрээнд Монгол Улсын импортын бараа эргэлт, зүйлээр

2006 -2015 САЙТИС-н Импортын Зөвшөөрлүүд Тоо хэмжээ, нөхцлөөр				
Нөхцөл	Тоо хэмжээ	Төрөл	Зүйлийн тоо	Зүйл
<b>АМЬД</b> 90%	32,400	Хилэм	2	Acipenser transmontanus ба Acipenser baeri
	51	Адуу	1	Equus przewalskii
	3	Шонхор	2	Falco cherrug ба Falco hybrid
	27	Бусад	8	
<b>АРЬСАН ЭДЛЭЛ</b> 5%	735	Аварга могой	3	Phyton bivittatus, Phyton brongersmai ба Phyton reticulatus
	352	Матар	5	Crocodylus siamensis, Crocodylus acutus, Crocodylus niloticus, Crocodylus porosus
	776	Аллигатор	1	Alligator mississippiensis
	103	Кайман	5	Caiman crocodilus yacare, Caiman crocodilus fuscus, Caiman crocodilus, Caiman crocodilus crocodilus, Caiman latirostris
	46	Бусад	3	
<b>АМЬТНЫ ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН</b> 4%	816	Хилэм	2	Acipenser transmontanus ба Acipenser baeri
	219	Цахирам	2	Orchis mascula ба Orchis morio
	117	Вансэмбэрүү	1	Sausarea costus
<b>БУСАД</b>	149	Бусад	5	
	339	Бусад	21	
	<b>36.133</b>		<b>61</b>	


## Экспорт чухал байр суурьтай хэвээр байна

Экспорт давамгайлж байсан үетэй харьцуулахад одоогийн олгож байгаа экспорт, импортын зөвшөөрлийн тоо хэмжээ бараг тэнцэлд хүрч байгаа нь Монгол Улсын CITES-ын дагуу хийж байгаа худалдаанд гарч буй чухал өөрчлөлт юм. Гэхдээ гадаад худалдаанд экспорт чухал байр суурь эзэлсэн хэвээр байгаа бөгөөд зарим зүйлийн хувьд илүү үүрэгтэй байна. Экспортын нэр төрөлд чоно, идлэг шонхор болон Алтайн аргаль тэргүүлж байна.

Урд жилүүдэд трофи ан агнуур болон эрдэм шинжилгээ судалгааны зорилгоор Алтайн аргаль, янгирын трофи агнуур<sup>144</sup> экспортод давамгайлж байсан бол Монгол Улс зах зээлд шилжсэнээс хойш эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлийн экспорт түлхүү болсон байна. Энэхүү экспортын худалдааны томоохон түншүүдээр нь тухайн экспортын зорилгыг тодорхойлох боломжтой юм. CITES-д нэгдсэний дараах 10 жилд Монгол Улсын экспортын гол түнш нь АНУ байсны зэрэгцээ Европын цөөн орнуудтай мөн экспортын худалдаа хийж байжээ. Эдгээрээс гадна Монгол Улсын зэрлэг амьтны худалдаанд БНСУ оролцож байсан бөгөөд тоо хэмжээний хувьд бусад түнш орнуудыг бодвол их биш байжээ.

144 Түүхээс сөхвөл, АНУ, Япон, Герман улс нь Монгол Улсын CITES-ын төрөл зүйлийн гол зах зээл байж ирсэн байна.

Зураг 1. 1996-2005 ба 2006-2015 онуудад CITES-ын хүрээнд Монгол Улсын экспортын худалдааны чиг хандлага



CITES-д конвенцод нэгдсэнээс хойших хоёр дахь арван жилд төрөл зүйлийн экспортын чиг хандлага өөрчлөгдөж, худалдааны түншүүд, худалдаалж буй зүйлийн тоо, нэр төрөл илүү олширсон байна.


Чоно бол CITES-ын дагуух Монгол Улсын зэрлэг амьтны худалдааны нэг гол бүтээгдэхүүн юм. Сүүлийн жилүүдэд олгосон чоно худалдаалах зөвшөөрөл нь Монгол Улсын зүгээс CITES-ын дагуу олгосон нийт зөвшөөрлийн гуравны нэг орчмыг (291) бүрдүүлж байгаагаараа экспортын хамгийн топ зүйл болж байгаа бөгөөд удаад нь 263 зөвшөөрөл олгосон аргаль орж байна. Дунджаар эхний арван жилийн хугацаанд олгосон нийт экспортын зөвшөөрлийн 33 орчим хувийг чононы зөвшөөрөл эзэлж байсан бол энэ нь хоёр дахь арван жилд 25 хувь болж буурчээ.

Гэхдээ зөвшөөрөл бүрийн ард нэгээс олон тооны зүйл байх магадлалтай. Сүүлийн 20 жилийн хугацаанд 2,700 гаруй чоно, түүний эд эрхтэн<sup>145</sup> экспортлосон бүртгэл байгаа бөгөөд энэ нь идлэг шонхортой харьцуулахад өндөр тоо биш юм (Дараагийн хэсгийг үзнэ үү). CITES-ын бүртгэлд трофи агнуур болон амьтны арьс экспортын гол бүтээгдэхүүн хэмээн бүртгэгдсэн байгаа ч амьд чононы эрдэм шинжилгээний зорилгоор, мөн Япон Улс болон Барууны орнуудын амьтны хүрээлэнд

145 CITES худалдааны статистик - CITES худалдааны мэдээллийн сан, НҮБ БОХ- Байгаль хамгааллын мониторингийн төв, Кембриж НВУ.

нийлүүлж байгаа мэдээлэл байна. Чоныг амьдаар нь болон гулуузаар нь худалдаалахаас гадна, чонын шүд, арьс зэрэг эд эрхтнийг мөн худалдаалж байна.

График 5. CITES-ын дагуу хийсэн Саарал чонын экспорт, 1996-2015



Шонхор шувуу, ялангуяа, идлэг шонхор нь Монгол Улсын зэрлэг амьтны худалдааны өөр нэг түгээмэл зүйл юм. Монгол Улсад Амарын шонхор (*Falco amurensis*); идлэг шонхор (*Falco cherrug*); хайргууна шонхор (*Falco columbarius*); зээрд шонхор (*Falco naumanni*); эгэл шонхор (*Falco peregrinus*); цагаан шонхор (*Falco rusticolus*); шууман шонхор (*Falco subbuteo*); начин шонхор (*Falco tinnunculus*); шилийн шонхор (*Falco pelegrinoides*) зэрэг 9 зүйлийн шонхор шувуу тархан амьдардаг. Шилийн шонхроос бусад зүйл нь CITES-ын дагуу албан ёсны бүртгэлд хамрагддаг.<sup>146</sup> Экспортын жагсаалтад мөн эрлийз шонхор шувуу орж байгаа ч энэ талаар тодорхой заалт байхгүй байна. Дээр дурдсан 8 зүйлээс идлэг шонхор шувууг хамгийн ихээр худалдаалсан бөгөөд 1996-2015 онд нийт 3,646 шонхрыг амьдаар нь, 12,560 шонхрыг тодорхой бус байдлаар экспортолжээ.<sup>147</sup> Үүнийг тухайн хугацаанд худалдаалсан бусад зүйлийн нийт тоо болох 476 зүйл буюу эрлийз шонхрыг оруулсан нийт 510 зүйлтэй харьцуулахад идлэг шонхор нь зэрлэг амьтны худалдааны тэргүүлэх төрөл зүйл болж байна.<sup>148</sup> CITES-

146 CITES худалдааны мэдээллийн сан

147 Мөн адил.

148 1996-2015 онд нийт 24,873 шонхор худалдаалсан (амьд, өд, болон тодорхойгүй хэлбэр гэх мэт бүгд ороод).

ын жагсаалтад орсон бусад төрөл зүйлийн худалдааг бүрэн тооцсон эсэх, эсвэл буруу тодорхойлсон байж болох, түүнчлэн идлэг шонхрын худалдааны мэдээлэл үнэн зөв эсэхэд монголын биологичид эргэлзэж байна. Энэхүү эргэлзээ нь 'төрөл зүйл'-ийн ерөнхий ангиллыг буруу ашигласнаас худалдааны төрлийг алдаатай тогтоож, үүний уршгаар амьтны зүйлийн нарийвчилсан үнэлгээ хийхэд саад учирч болзошгүй байгаатай холбоотой.

График 6. CITES-ын дагуу хийсэн Идлэг шонхор шувууны экспорт, 1996-2015



Саарал чонын худалдаанд тулгарч байгаа асуудал мөн шонхор шувууны худалдаанд байгаа бөгөөд мэдээлэл бүрэн эсэх нь эргэлзээтэй байна. Урд өмнө нь CITES-ын хүрээнд Монгол Улс өөрийн худалдааны тайлангаа бүрэн гаргаж илгээхгүй<sup>149</sup> байснаас анхааруулга авч байсан бөгөөд шонхрын худалдааны зохисгүй байдлын талаар олон улсын хэвлэл мэдээллийн шүүмжлэлд ч өртөж байсан.<sup>150</sup> Судалгаанд оролцогчид дээрх байдал хэвээр үргэлжилж байгааг тэмдэглэж байсны зэрэгцээ хууль сахиулах чиглэлээр гарсан нэгэн баримт бичигт энэ талаар онцлон баримтжуулсан байна.

149 CITES SC66, Agenda Item 30.1. January 2016, Geneva.



150 Al Jazeera, Mongolia's Nesting Program Helps Save the Prized Saker Falcon, (Jul. 2016), video available at <http://video.aljazeera.com/channels/eng/videos/mongolias-nesting-programme-helps-save-the-prized-saker-falcon/5020070661001.jsessionid=8AC15BEC25296C2528340C84BF28773Vхаяаар> үзнэ үү.

Аргаль нь CITES-ын жагсаалтад орсон Монгол Улсаас хамгийн их хэмжээгээр экспортолж буй гурван зүйлийн нэг бөгөөд трофи ан агнуурын хүрээнд худалдаалагдаж байна. Саарал чонын экспортын нэгэн адил аргаль агнуурын чиглэлээр олгож буй зөвшөөрөл нь нийт экспортын худалдааны гуравны нэг орчим хувийг (1996-2015 онуудад, нийт 263 зөвшөөрөл) сүүлийн жилүүдэд бүрдүүлж байгаагаараа зэрлэг амьтны экспортын тэргүүлэх хоёр дахь зүйл болжээ. Худалдаалсан аргалийн нийт тоо нь саарал чонын тоотой ойролцоо буюу 1,322 трофи агнуур, 1000 орчим зүйл худалдаалснаар, нийтдээ 2,369 зүйл экспортолсон байна.<sup>151</sup>

“Трофи” ан агнуур нь CITES-ын хүрээнд хийдэг худалдааны хамгийн том ангилал бөгөөд дэлхий дахины трофи агнуурчдын сонирхолыг татдаг зүйлүүд энэ ангилалд ордог. Алтайн аргаль нь зэрлэг хонины хамгийн том зүйл гэж тооцогддог учир маш өндөр үнэтэй. Аргаль нь хамгийн үнэтэй зүйлийн нэг байснаар энэхүү салбарт амжилт олох хүсэл эрмэлзлэл бүхий хүмүүст ашигтай бизнес хийх боломжийг бий болгодог. Анхны “Зэлүүд тал” тайланд өгүүлснээр энэхүү ашигтай бизнест татагдан аргаль агнах тусгай зөвшөөрөл бүхий аргалийн ан хийх бизнес эрхэлдэг компанийн тоо огцом нэмэгдэж, 1993 онд дөнгөж 3 компани бүртгэлтэй байсан бол 1999 онд 18, 2003 онд 43 компани болж нэмэгджээ. Харамсалтай нь 2015 оны тоо мэдээлэл байхгүй байгаа учир энэ салбарт үнэлгээ өгөх боломжгүй болгож байна.

Нэг талаар Монгол Улсын тусгай зориулалтын аялал жуулчлалын хамгийн том сегмент болдог, нөгөө талаар зэрлэг амьтан хамгаалахад чиглэсэн санхүүгийн боломжит эх үүсвэр бүрдүүлэх гэдэг утгаараа энэхүү судалгаанд ан агнуурын компаниуд ихээхэн чухал байсан юм. Харамсалтай нь ан агнуурын бүх компани, холбоод судалгаанд оролцохоос татгалзсан юм. Аргаль агнах квот болон экспортолж буй трофи ангийн тоо хэмжээ зөрүүтэй байгаад тодорхой тайлбар олдохгүй байгаа нь хууль бус трофи ан агнуур Монгол Улсад түгээмэл хэвээр байгаа гэсэн эргэлзээ төрүүлж байна. Тухайлбал, 2014 онд 28 аргаль агнах зөвшөөрөл олгосон бол конвенцийн хүрээнд аргаль экспортлох 37 зөвшөөрөл олгожээ. 2015 онд ч энэхүү нөхцөл байдал давтагдаж экспортын 78 зөвшөөрөл олгосон байхад тухайн жилийн аргаль агнах квот нь 50 байжээ. Орон нутгийн засаг захиргаанаас ан агнуурын зөвшөөрөл, квотын хэрэгжилтэд тавих хяналт чухам ямар түвшинд байгаа нь тун ойлгомжгүй байна. Энэ байдал нь CITES-ын хүрээнд хийж байгаа экспортын худалдаа болон албан ёсны квот хоорондын ялгаа гарахад нөлөөлж байгаа нь дамжиггүй. Энэ нь Монгол Улсад зөвхөн тохиолдож байгаа асуудал биш юм.

График 7. CITES-ын хүрээнд хийсэн Аргаль угалзын экспорт, 1996- 2015 он



CITES-ын хүрээнд зүйл тус бүрт ялгаатай ангилал ашигладаг учир энэхүү конвенцийн хэрэгжилтийн тайлан мэдээллийг ашиглан зүйлийн худалдааны тоо хэмжээг хооронд нь харьцуулахад хүндрэлтэй. Ялангуяа ямар амьтан худалдаалагдаж байгааг түүний бүтээгдэхүүн эд эрхтэнээр ялган тодорхойлоход амаргүй байхад, зарим худалдаалагдаж байгаа эд эрхтэний (тухайлбал, шүд, өд, зарим эд гэх мэт) цаана хэдэн амьтан байгааг тодорхойлох боломжгүй байдаг. Харьцуулалт хийх зорилгоор олгосон экспортын зөвшөөрлийнх нь тоог харгалзан 10 төрөл зүйлийг эрэмбэлж, хамгийн ихээр экспортолж байгаа гурван зүйлийг харьцуулан Хүснэгт 3-д үзүүлээ. Харин Хүснэгт 4-т дээрх арван төрөл зүйлийн жинхэнэ экспортолсон тоо хэмжээг нэгтгэн харууллаа. Аль ч тохиолдолд арилжааны зорилгоор хамгийн ихээр худалдаалж байгаа гурван зүйл нь саарал чоно, идлэг шонхор болон аргаль байна. Хүрэн баавгай нь тооны хувьд хамгийн ихээр худалдаалж байгаа хоёр дахь зүйл боловч худалдсан бүх зүйлийг зөвхөн эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор ашигласан гэжээ.<sup>152</sup>

151 CITES худалдааны мэдээллийн сан

152 Конвенцийн (CITES) мэдээллийн сан

**Хүснэгт 3. Монгол Улсын зэрлэг амьтан экспортлох зөвшөөрөл олгосон байдал, зүйлээр**

1996-2015		
МОНГОЛУЛС ЗЭРЛЭГ АМЬТАН ЭКСПОРТЛОХ ЗӨВШӨӨРӨЛ		
Хамгийн олон 10 зүйл		
#	Зүйлийн нэр	Зөвшөөрөл
#1	Саарал чоно	291
#2	Аргаль	263
#3	Идлэг шонхор	83
#4	Цармын бүргэд	30
#5	Мануул	28
#6	Хүрэн баавгай	23
#7	Говийн Еврази шилүүс	16
#8	Ирвэс	16
#9	Нөмрөг тас	15
#10	Янгир	14
	Бусад	166
		<b>945</b>

**Хүснэгт 4. Монгол Улсын экспортолсон зэрлэг амьтны тоо хэмжээ, хамгийн ихээр худалдаалсан 10 зүйл**

1996-2015		
МОНГОЛУЛС ЭКСПОРТОЛСОН ЗЭРЛЭГ АМЬТНЫ ТОО ХЭМЖЭЭ <sup>(*)</sup>		
Хамгийн олон 10 төрөл зүйл		
#	Төрөл зүйлс	Зөвшөөрөл
#1	Идлэг шонхор	24,873
#2	Хүрэн баавгай	3,402 <sup>1</sup>
#3	Саарал чоно	2,708
#4	Аргаль	2,369
#5	Хонин тоодог	1,912
#6	Цармын бүргэд	1,529
#7	Хулан	980
#8	Ирвэс	664
#9	Мануул	527
#10	Баданги хүдэр	309
	Бусад	2,098
		<b>41,371</b>

\* Дараах зүйлсийг хамруулсан (амьд зүйл, үс, дээж, гавал, трофи агнуур, дагавар бүтээгдэхүүн гэх мэт.)

Худалдаалсан зэрлэг амьтны бодит тоон харьцуулалтыг худалдаалсан ангилал бүрээр нэг амьтан болгон нэгтгэн тооцож гаргах боломжтой. Тухайлбал, идлэг шонхрын хувьд амьд зүйл, трофи, гулууз гэсэн гурван ангиллыг нэгтгэн тооцох юм. Энэхүү нэгдсэн тооцоонд 'эд' болон 'өд' гэсэн ангиллыг оруулаагүй. 'Эд' хэмээх ангилалын цаана үнэндээ амьд зүйлийн худалдаа ч байх боломжтой боловч тодорхой мэдээлэлгүйгээр үүнийг дээрх нэгтгэлд шууд оруулах боломжгүй. Аргалийн хувьд трофи агнуур, эвэр болон гавал гэсэн ангиллыг тус бүрт нь нэг амьтан хэмээн ингэж нэгтгэн тооцдог. Гэхдээ л 'эд', 'үс', 'гавал', 'араг яс' болон 'арьс' хэмээх бусад ангиллыг хасах хэрэгтэй болсон. Идлэг шонхрын хувьд шонхрыг бүхлээр нь худалдах нөхцөл байж болох ч тодорхой мэдээлэлгүйгээр бүх ангиллыг нэгтгэлд оруулах боломжгүй. Саарал чонон хувьд 'арьс', 'трофи', 'амьд чоно' болон 'гулууз' хэмээх ангиллаар нэгтгэж, харин 'эд', 'үс', 'шүд' гэсэн ангиллыг нэгдсэн тооцооноос хассан.

Энэхүү шүүлтүүрийг ашиглан тооцвол Монгол Улс нь 1996-2015 онуудад хамгийн багадаа 3,524 идлэг шонхор экспортолжээ (жилд дунджаар 176 шонхор). Хорь орчим жилийн хугацаанд нийтдээ 2,249 саарал чоно экспортолсон нь жилд дунджаар 112 байжээ. Мөн хугацаанд хамгийн багадаа 1,384 аргаль экспортолсон нь жилд дунджаар 69 аргаль экспортолсон байна. Эдгээрээс чоно болон шонхрын экспортын худалдааны албан ёсны мэдээлэл нь бодит байдлаас хамаагүй бага байх магадлалтай. Эдгээр хоёр зүйлийн нэгдсэн тооцоонд оруулалгүй үлдээсэн ангиллын хувьд нэг бол тоо хэмжээний хувьд хэт бага, эсвэл тухайн амьтан мөн гэж тодорхойлоход ярвигтай байсантай холбоотой. Тухайлбал, дээр дурдсан идлэг шонхрын нэгдсэн мэдээлэлд 'эд' (12,560) болон 'өд' (8,664) гэсэн ангиллын мэдээлэл ороогүй байгаа. Гэтэл 'эд' хэмээх энэ ангилалд амьд зүйл орж байна уу аль эсвэл зөвхөн эд эрхтэн нь орж байна уу гэдэг нь тодорхойгүй байна. Саарал чонон хувьд нэгдсэн тооцооноос хасагдаж байгаа ангилал цөөн байгаа хэдий ч 'эд' хэмээх ангилалын худалдааг анхаарах нь чухал юм (319).<sup>153</sup>

<sup>153</sup> Монгол Улсад тархан амьдардаг хүрэн баавгай нь Олон улсын конвенцийн Нэгдүгээр хавсралтад орсон бөгөөд зөвхөн эрдэм шинжилгээ, судалгааны зориулалтаар экспортлох боломжтой. Арилжааны зорилгоор хамгийн олноор худалдаалж байгаа 3 төрөл зүйлийг цэнхэр өнгөөр тодруулав.

# Хяналт тавихад хүндрэлтэй байна

## Худалдааны эргэлт ихсэхийн хэрээр чадавхийг сайжруулах шаардлагатай

Зэрлэг амьтны олон улсын худалдаа өргөжихийн хэрээр зэрлэг амьтны хуулийн дагуу болон хууль бус худалдааны урсгал ч мөн хүрээгээ тэлдэг. Дэлхийн өнцөг булан бүрт хил гаалийн боомтоор өдөрт олон сая тонн ачаа тээвэр<sup>154</sup> дамжиж байдаг ч тэдгээрийн багахан хэсэг нь л хяналт шалгалтаар орж байна. Энэ нь бүх боомтуудын ачаалал их байдагтай холбоотой бөгөөд Монгол Улсын хилийн боомтууд дээр ч байдал ийм байгаа юм. Монгол Улсын гадаад худалдааны эргэлт сүүлийн 20 жилийн хугацаанд эрс хурдтай өсөн нэмэгдэж, 2005 онд 2.2 тэрбум ам.доллар байсан бол 2011 онд 11.4 тэрбум ам.доллар болж, харин 2015 онд 8.5 тэрбум ам.доллар болсон.<sup>155</sup> Монгол Улсын худалдааны энэхүү эрчимтэй өсөлт (300-400%) нь мөн үеийн БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн хурдацаас багахан хамааралтай байгаа юм.<sup>156</sup> Монгол Улсын гадаад худалдааны эргэлтэд эрдсийн түүхий эдийн экспорт, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний импорт тэргүүлэх байр эзэлдэг (График 8). Эдгээр хоёр төрлийн худалдааны эргэлт нэмэгдэхийн хэрээр өдөр тутам хил гаалиар нэвтрэх ачаа эргэлтийн тоо хэмжээ, давтамж нэмэгдэж<sup>157</sup> буй нь нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл давамгайлсан эдийн засагтай улс орнуудад тэр бүр тохиодоггүй асуудал юм.

154 UNCTAD тээвэрлэлтийн талаар мэдээлэл цуглуулдаг. Контейнерийн хэмжээ гэдэг үзүүлэлт зөвхөн далайн тээвэрт хамаарах ба энэ нь 2013 онд 651 сая TEUS, (Twenty Feet Equivalent Unit) харин 2015 онд 684 сая TEUS-д хүрсэн. <http://unctadstat.unctad.org> on May 30<sup>th</sup>, 2017

155 Статистикийн мэдээллийн үйлчилгээ ([www.1212.mn](http://www.1212.mn)).

156 Хятадын нийт худалдаа эргэлт 1996-2015 онд 3,765-с 5,977 тэрбум ам.доллар болж өссөн (барэг 2 дахин өссөн). World Integrated Trade Solution ([www.wits.worldbank.org](http://www.wits.worldbank.org)).

157 UNCTAD-аас гаргасан тайланд контейнерийн тоо хэмээх үзүүлэлт байхгүй байсан тул бусад орнуудын нэгэн адил Монгол Улсын Засгийн газраас мэдээллээ гаргаж өгөөгүй гэж үзсэн. (<http://unctadstat.unctad.org/CountryProfile/GeneralProfile/en-GB/496/index.html>)

График 8. Гадаад худалдааны бараа эргэлт



Худалдааны эргэлт, ачаа тээвэрлэлтийн цар хүрээ нэмэгдэхийн хэрээр хүн хүчний хүрэлцээ, хөрөнгө санхүүжилт дутмаг Монгол Улсын хил, гаалийн албадын ачаалал илүү хүнд болж байна. Рентген аппарат, гамма туяаны аппарат, нейтрон бүтцийн шинжилгээ болон backscatter рентген туяа зэрэг нь Дэлхийн худалдааны байгууллагын түгээс зөвлөж байгаа ачаа тээврийг түргэн шуурхай шалгах хамгийн түгээмэл техник технологи юм.<sup>158</sup> Эдгээр тоног төхөөрөмжийг ашигласнаар гаалийн ажилтнуудыг заавал биечлэн оролцуулалгүйгээр ачаа бараанд шуурхай хяналт шалгалт, аудит хийх боломжтой. Гэхдээ эдгээр тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлд цөмийн технологийг ашигласан байдаг учир худалдан авах болон ажиллуулах зардал нь өндөр юм. Улаанбаатар хотын болон хилийн боомтын гаалийн албадаас тус судалгаанд оролцогчид ачаа тээвэрт хяналт шалгалт хийх зориулалтын тоног төхөөрөмж дутмагаас ялангуяа хүнд машин механизмд давтан хяналт шалгалт хийхэд хүндрэлтэй байдаг талаар ярьж байсан. Үнэндээ ашигт малтмал тээвэрлэж байгаа машин, механизмд хийсэн гаалийн үзлэгээр зэрлэг амьтны эд эрхтэн нуун хил давуулж хууль бус худалдаа хийх гэсэн нилээд хэдэн оролдлогыг олж илрүүлж байжээ. Энэ нь БНХАУ-тай хиллэдэг өмнөд хил дээр түгээмэл гардаг хэрэг юм. Монгол Улсын өмнөд хилээр 100-200 тонны даацтай ачаагүй автомашинууд олноор нэвтрэн орж ирж, уурхайгаас бараагаа ачин буцаагчид бөгөөд ихэнхдээ тухайн уурхай дээрх гаалийн байцаагчид ачааг битүүмжлэн илгээдэг тул хилийн боомтын байцаагчид дахин шалгах боломжгүйгээр нэвтрүүлдэг.<sup>159</sup> Гаалийн албадыг шаардлагатай тоног

158 World Customs Organization. Guidelines For The Procurement And Deployment Of Scanning/NII Equipment. April 2015. <http://www.wcoomd.org/en/topics/facilitation/instrument-and-tools/tools/~media/1BC3CBC9189B4BECB21BC5F261E43694.ashx> хаягаар үзнэ үү.

159 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага # 1.8, #1.10 (Ховдын

төхөөрөмжөөр хангасан тохиолдолд зэрлэг амьтны бүтээгдэхүүнийг хилээр хууль бусаар машиндаа нууцлаг нүх завсар, саванд хийж далдлах, машины эд анги, галт тэргэнд нуух, хуурамч шал, тааз хийж нуух зэргээр тээвэрлэх тохиолдлыг хялбархан илрүүлэх боломжтой.<sup>160</sup>

## Чөлөөт худалдааны бүс илүү эрсдэл үүсгэж байна

Өмнөх хэсгүүдэд өгүүлсэн олон тулгамдсан асуудал байгаагийн зэргэцээ чөлөөт худалдааны бүсүүдэд ачаа тээвэрт хийх хяналт шалгалтыг хөнгөвчилж байгаа нь хууль бусаар хил дамнуулан худалдаа хийгчдийн ажлыг улам хялбар болгож байна. Бусад улс орнуудад ч чөлөөт худалдааны бүс болон худалдааг чөлөөлөх арга механизмыг зэрлэг амьтны эд эрхтэн худалдаалагчид овжноор ашиглаж байна. Хилээр орж гарч байгаа ачаа тээврийг түргэн шуурхай нэвтрүүлэх зорилгоор ачаа тээврийн хяналт шалгалтыг аль болох хялбар түргэн хийх журам дүрэм баримталж байгаа нь үүний гол шалтгаан болж байна. Ерөнхийдөө ачаа бараанд иж бүрэн шалгалт хийх гэхээсээ илүүтэй тухайн ачаа тээврийн талаарх баримт мэдээллийг түлхүү шаардах болж байна.

Гадаад худалдаагаа хөгжүүлэх зорилгоор Монгол Улс нь хэд хэдэн бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Эдгээрийн тоонд Чөлөөт худалдааны бүсийн тухай хууль боловсруулан батлуулах ажлыг 2002 онд хийж, өмнөд, хойд болон баруун бүс нутагтаа (Замын-Үүд, Алтанбулаг болон Цагаан Нуур) чөлөөт худалдааны бүс байгуулахаар<sup>161</sup> ажиллаж байна. Тус хуулийн хэрэгжилт 10 гаруй жил сунжирч, 2015 онд чөлөөт худалдааны тухай шинэчилсэн хууль батлагдмагц Замын-Үүдийн чөлөөт худалдааны бүсийн тухай хэлэлцээрийг Монгол Улс, БНХАУ хамтран хийж, тус чөлөөт бүсийн шавыг тавьснаар хуулийн хэрэгжилт идэвхжсэн байна. Бүтээн байгуулалтын ажил 2018 оныг хүртэл үргэлжлэх бөгөөд эдгээр чөлөөт бүсийн үйл ажиллагаа жигдрэхэд зарим хүндрэлтэй асуудлууд гарч байгаагийн дотор зэрлэг амьтны худалдааны асуудал ч хамаарч байгаа юм.

Дээрх чөлөөт бүсүүдийг байгуулах байршлыг тогтоосны дараа олон улсын байгууллагын зүгээс Монгол Улсын чөлөөт худалдааны бүсийг хөгжүүлэх

хөтөлбөр болон Алтанбулаг, Замын-Үүдийн чөлөөт бүсэд үнэлгээ хийжээ.<sup>162</sup> Тус үнэлгээний дүгнэлтэд Монгол Улсын чөлөөт худалдааны бүсийг хөгжүүлэх хөтөлбөр нь ‘агуулга, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хувьд ихээхэн сул’ байгааг тэмдэглээд стандартын шаардлагад нийцүүлэхийн тулд ‘хууль эрх зүйн зохицуулалтын томоохон хэмжээний өөрчлөлт хийж, сайжруулах шаардлагатай’ хэмээн дүгнэжээ.<sup>163</sup> Шууд дурдаагүй ч энэхүү дүгнэлт нь чөлөөт худалдааны тухай жуулинд хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулахаар үлдээсэн нь асуудал үүсгэж буйг онцолжээ. Зэрлэг амьтны хууль бус худалдаанд хамаарах гол санаа зовоож байгаа асуудал хуулийн хоёр зүйл дээр байнав Тухайлбал, хуулийн 4.2 дугаар зүйлд чөлөөт худалдааны бүсэд нэвтрэхдээ ‘Гаалийн байгууллагаас тогтоосон журам’-ыг баримтлах, 10.1 дүгээр зүйлд чөлөөт бүсийн хэлбэр, зориулалт, байршлаас хамааран хараат бус хяналт шалгалтын нэгж байгуулна хэмээн заасан нь эдгээр журам нь зэрлэг амьтны хууль бус худалдаатай холбоотой асуудлуудыг зохистой сайн зохицуулж чадах уу гэдэг асуудлыг хариултгүй үлдээж байна.

## Хилийн хамгаалалт сулрах нь хууль бус худалдааг өөгшүүлдэг

Ямар ч тохиолдолд хил, гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагаа нь ихээхэн хүчин чармайлт, өртөг зардал шаардсан ажил байдаг бөгөөд зарим улс орон энэ ачааллыг нь даах боломж муутай байдаг. Монгол Улсын гадаад орнуудтай хиллэсэн хилийн шугам 8,252 км<sup>164</sup> үргэлжилдэг бөгөөд энэ нь АНУ-ын Мексиктэй хиллэсэн шугамын нийт уртаас 2.5 дахин урт юм. Хоёр том гүрний хооронд хавчуулагдан оршдог Монгол Улсын хувьд хил хамгаалалтын асуудал байнга анхаарлын төвд нь байж, тоног төхөөрөмж, хангамжийн хувьд ч сайн байсан. Хүйтэн дайны үед хилийн цэргийн бие бүрэлдэхүүний тоо 15,000 хүрч, хил хамгааллын болон цагаачлалын асуудлыг хариуцаж байсан. Нисэх онгоц, нисдэг тэрэг, автомашин, мотоцикл, радио холбоо, инженерийн тоног төхөөрөмж, автомат галт зэвсэг зэрэг баглан хамгааллын техник тоног төхөөрөмж ашиглан хил хамгааллын үүргээ гүйцэтгэж байжээ.<sup>165</sup> Харин өнөө үеийн хил хамгааллын чиглэлээр ажиллаж байгаа бие бүрэлдэхүүний талаарх мэдээлэл олдоц муутай байна. Гэхдээ зарим эх сурвалжийн мэдээлснээр 300-350 орчим хилийн застав ажиллаж буй ажээ.<sup>166</sup> Хилийн

Гаалийн байцаагч), # 5.5, 5.6 болон 5.7 (Өмнөговийн Гаалийн байцаагч), # UB5 болон #UB6 (Гаалийн ерөнхий газар)

160 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага #UB6 болон #UB7 (Гаалийн ерөнхий газрын ажилтнууд)

161 Холбогдох хуулиуд: Чөлөөт худалдааны бүсийн тухай хууль -2002; Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийн статусын тухай хууль -2003; Замын Үүдийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын талаар авах арга хэмжээний тухай хууль -2004.

162 USAID (2004). Assessment of Mongolia's Free Trade Zone Program and Site Evaluation. Mongolia Economic Policy Reform and Competitiveness Project (EPRC).

163 Мөн адил.

164 Монгол Улс нь БНХАУ-тай 4,677 км (57%) ОХУ-тай 3,543 км (43%) газраар хиллэдэг.

165 Mongolia – Хилийн цэрэг. Global Security (www.globalsecurity.org) Retrieved on May 24, 2017

166 Мөн тэнд.

аюулгүй байдлыг хангахад анхаарал хандуулж буйн нэг илрэл бол Монгол Улс нь өөрийн хилийг бүрэн хашаажуулсан цөөн орны нэг болсон явдал юм. (Зураг 2-г үзнэ үү).<sup>167</sup> Гэхдээ хилийн торон хашаа нь бат бэх биш, зарим газрууддаа тэр бүрий засвар сайжруулалт хийж чадахгүй байгаа нь ажиглагдаж байна.

Зураг 2. ЕвроАзийн бүсийн хил хамгааллын хашаажилтын байдал<sup>168</sup>



Хил хамгаалах хүн хүч, хашаажилтаас үл хамааран Монгол Улсын хил нь харьцангуй нээлттэй бөгөөд хяналт тавихад хүндрэлтэй байгааг нуух аргагүй. Алтайн нуруугаар тусгаарлагдах баруун хилээс бусдаар ямар нэгэн байгалийн саад (тухайлбал, уул нуруу, гол горхи, гэх мэт) байдаггүй тул аль ч газраар хил нэвтрэхэд саадгүй шахам байна. Өмнөд хэсгээрээ БНХАУ-тай говь цөл, тал хээрийн нутгаар хиллэдэг бол ОХУ-тай хиллэсэн газар нутгийн дийлэнх хэсэг нь тал хээр нутаг учир хэн нэгэн засмал замаар явж байгаа мэт автомашингаар хил нэвтрэх бүрэн боломжтой юм. Үндсэндээ хойд, урд аль ч талаараа хөрш орнуудтайгаа нилээд урт бөгөөд цөлөрхөг газраар хиллэсэн Монгол Улсын хувьд зэрлэг амьтны худалдаа эрхлэгчдийн хөдөлгөөнийг саатуулах боломж тааруу, тэд хашаа, саад бүхий газрыг давсан тохиолдолд баригдах эрсдэл багатайгаар хил дамнан худалдаа хийх боломж нөхцөл байна.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн ярианд ч мөн дээрх асуудлыг хөндөж байсан. Өвлийн цагт хөлдүү загас ачсан портер машинууд нууц замаар явж, зөвшөөрөгдөөгүй газраар БНХАУ руу орж байсан тохиолдол байсныг Баруун бүсийн Ховд аймгийн гаалийн ажилтан ярьж байсан.<sup>169</sup> Баян-Өлгий аймгаас ч мөн хилийн зөвшөөрөгдөөгүй хэсгээр зэрлэг амьтан

167 Судалгаагаар нотлогдоогүй. Хашааны уртын хэмжээ нь бүрэн тогтоогдоогүй.

168 Linnel, D., A. Trouwborst, L. Boitani, P. Kacenzsky, D. Huber, S. Relijc, J. Kusak, A. Majic, T. Skrbinesk, H. Potocnik, M. Hayward, E.J. Milner-Gulland, B. Buuveibaatar, and U. Breitenmoser (2016). Border Security Fencing and Wildlife: The End of the Transboundary Paradigm in Eurasia?. <https://doi.org/10.1371/journal.pbio.1002483> хаягаар үзнэ үү.

169 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага # 1.1 (Ховд- Гаалийн байцаагч)

наймаалагчид, мориор болон жижиг машинаар хил зөрчин худалдаа хийдгийг дурдаж байв.<sup>170</sup> Тус аймагт хийсэн судалгаанд хамрагдсан хүмүүсийн мэдээлэлд наймаачид Казахстан Улсаас зэрлэг амьтан оруулж ирэхдээ хэрхэн ажилладаг тухай дурдсан байдаг.<sup>171</sup> Нутгийн хойд хэсгийн Сэлэнгэ аймагт ой модтой газраар халхавчлан, нууцаар хурдтайгаар хил нэвтрэдэг машинууд байдгийг судалгааны явцад олж тогтоосон.<sup>172</sup> Нөхцөл байдлыг улам хүндрэлтэй болгож буй бас нэгэн үйлдэл нь худалдаачид илүү орчин үеийн, нарийн төлөвлөсөн арга ашиглах болсны жишээнд утсаар тохирон хилийн хамгаалалтгүй хэсгээр, жишээ нь ой модтой газруудаар бараа солилцох, хууль сахиулах байгууллагыг төөрөгдүүлэхийн тулд машиныхаа улсын дугаарыг солих зэрэг арга хэрэглэх болжээ.<sup>173</sup>

## Өргөн уудам газар нутгийг хамгаалах нь ярвигтай байна

Монгол Улсын өргөн уудам газар нутагт зэрлэг амьтад тархан амьдардаг учир тэр бүр эргүүл хяналт хийх боломж хязгаарлагдмал бөгөөд хүндрэлтэй. Хууль сахиулах үүрэг хүлээсэн ажилтнуудын тоо ч цөөн, үндсэндээ тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчид л хууль сахиулах үүрэг хүлээдэг. Эргүүл шалгалт хийх талбайн хэмжээ асар том тул хууль бус үйл ажиллагааг зохистой хэмжээнд таслан зогсоох боломж бага юм.

Энэ нь Монгол Улсын бодит байдал бөгөөд тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчид 265,000 км<sup>2</sup> газар нутаг буюу бараг тус улсын нийт нутаг дэвсгэрийн 17 хувийг хяналтандаа байлгах үүрэг хүлээж байна. Хэрэв энэхүү нутаг дэвсгэрийг нэг хавтгай дөрвөлжин км болгоноор цувруулан тавьбал Монгол Улсын тусгай хамгаалалттай нийт газар нутгийн хэмжээ нь дэлхийг бараг 7 удаа ороосонтой тэнцэхүйц урт болно. Эргүүл хяналтыг хүндрэлтэй болгож буй өөр нэгэн нөхцөл нь тусгай хамгаалалттай газар нутгууд нь тус улсын нутаг дэвсгэрээр тархсан 75 хэсэг газар нутагт (үндэсний хөшөө дурсгал бүхий газар нутаг, Дэлхийн өвд бүртгэгдсэн газар нутгийг оруулалгүйгээр) байршилтай байгаа явдал юм. Түүнчлэн тусгай хамгаалалттай газар нутгууд нь хүрч очиход төвөгтэй, алслагдсан, хүн амьтан суурьшаагүй уул нуруу, говь цөлд оршиж байна. Үүн дээр нэмээд сүүлийн жилүүдэд усан орчны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл эрс нэмэгдэж байгаагай холбоотой нийт 10,409 км урттай томоохон голууд, 13,418 км<sup>2</sup> нутаг

170 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага # 3.6 (Баян-Өлгий-Байгаль орчны байцаагч)

171 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага # 3.7 (Баян-Өлгий-Газрын байцаагч)

172 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага # 4.5 (Сэлэнгэ- Цагдаа)

173 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага # 3.13 (Баян-Өлгий-Алтайн нурууны байгаль хамгаалагч)

дэвсгэрийг бүрхсэн нуурын орчмоор өсөн нэмэгдэж буй ан агнуурын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хэрэгцээ гарч байна. Нэгтгэн дүгнэж үзвэл дэлхий дээрх асар том газар нутагтай, цөөн хүн амтай, хязгаарлагдмал хөрөнгө санхүүтэй цөөхөн орны тоонд Монгол Улс орж байгаагийн зэрэгцээ өргөн уудам нутаг дэвсгэртэй хэрээр өөрийн нөөцдөө хяналт тавих хүндхэн үүрэг, шаардлага тулгарч байна. (Зураг 12-г үзнэ үү).<sup>174</sup>

Зураг 3. Монгол Улсын өргөн уудам газар нутаг



Зураг 4-т Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн жишээ болгон Тосон Хулстайн байгалийн нөөц газар, Хөвсгөл нуурын тусгай хамгаалалттай газрын (ТХГ) хэмжээ болон тэндхийн байгаль хамгаалагчдын хариуцах газар нутгийн дундаж хэмжээг харьцуулж үзүүлээ. Албан ёсны мэдээгээр Тосон Хулстайд 6, Хөвсгөл нуурын ТХГ-т 15 байгаль хамгаалагч тус тус ажиллаж байна. Түүнчлэн 4,699 км² газар нутагтай Тосон Хулстай, 8,380 км² газар нутагтай Хөвсгөл нуурын ТХГ-т нэг байцаагчид 783 км² болон 559 км² газар нутаг тус тус ногдож байна. АНУ-ын Шар чулуут (Yellowstone) дархан цаазат газартай (нэг байцаагчид 27 км² ногдог) харьцуулахад дээрх хоёр ТХГ-т 20-30 дахин цөөн тооны байгаль хамгаалагч ажиллаж байна. Гэхдээ энэхүү харьцуулалтад зөвхөн байнгын ажилтнуудыг тооцсон бөгөөд Шар чулуутын дархан цаазат газарт зуны улиралд түр ажилтан авч ажиллуулдаг учир байцаагчийн тоо ахин хоёр дахин нэмэгддэг. Монгол Улсын хувьд аялал жуулчлалын улиралд түр ажилтнуудын тоог нэмэгдүүлдэг эсэх талаар тоо мэдээ байхгүй байгаагаас үзэхэд байгаль хамгаалагч маш дутагдалтай байдгийг илэрхийлж байна.

174 Эр сурвалж: Статистикийн мэдээллийн үйлчилгээ (www.1212.mn)- нийт газар нутаг (2016), томоохон гол нуур, хийлийн урт; World Database on Protected Areas (Wdpa) (www.protectedplanet.net) тусгай хамгаалалттай газар нутгийн тоо (2016). (UNEP-WCMC).

Зураг 4. Тусгай хамгаалалттай газар нутгийн ажилтны тоо, хариуцах талбай<sup>175</sup>



ТХГ-аас бусад газар нутагт ч хууль сахиулах чиг үүрэг бүхий ажилтнуудын нөхцөл байдал амаргүй байна. Монгол Улсыг зэрлэг амьтны диваажин болгодог (энэ утгаараа нийлүүлэгч орон болгодог) хүчин зүйл нь эргээд хяналт шалгалт, эргүүл хийх боломжийг ийнхүү хязгаарлаж байна. Нэг хавтгай дөрвөлжин километр газар нутагт 2 хүн ногдож<sup>176</sup> байгаагаараа Монгол Улс нь дэлхийн хүн ам хамгийн сийрэг суурьшсан орны нэг болдог.<sup>177</sup> Гурван сая гаруй хүн амынх нь бараг тал хувь нь нийслэл Улаанбаатар<sup>178</sup> хотдоо суурьшсан тул хөдөө орон нутгийн хүн амын нягтрал бүр ч бага, нийт 9 аймагт гэхэд нэг хавтгай дөрвөлжин километр газар нутагт ногдох хүний тоо нэг хүн хүрэхгүй байна.<sup>179</sup> Иймд тус улсын асар уудам, дэд бүтэц бүтээн байгуулалт сул газар нутагт зэрлэг амьтан өсөн үржих бүрэн боломжтой. Гэхдээ зөвхөн өргөн уудам газар нутагтайгаараа зэрлэг амьтад амьдрах нөхцөл бүрдэнэ хэмээн санаа амрах бус тэднийг хамгаалах байгаль хамгаалагч заавал шаардлагатай болно.

Хүн амын суурьшил багатай газар нутагт удирдлагын үйл ажиллагааг зохистой явуулах хүний болон

175 Sources www.protectedplanet.net for area protected. EU Biodiversity Conservation Report and US Forest Service for park rangers numbers.

176 2016 Үндэсний хүн амын нягтралын мэдээ, Статистикийн мэдээллийн үйлчилгээ (www.1212.mn) 4 сарын 23, 2017

177 World Atlas, *The 10 Least Densely Populated Places in the World* (2016) <http://www.worldatlas.com/articles/the-10-least-densely-populated-places-in-the-world-2015.html>.

178 The Mongolist Blog, *Rethinking Ulaanbaatar's Population* (May, 2014) quoting Data from table "Хүн амын тоо, хүйсээр, оны эхэнд, мянган хүн" at: <http://ubstat.mn/StatTable=11>, available at <http://www.themongolist.com/blog/society/89-rethinking-ulaanbaatar-s-population.html> хаягаар үзнэ үү.

179 Монгол улсын статистикийн мэдээллийн үйлчилгээ (www.1212.mn).



эдийн засгийн нөөц байхгүй байна. Монгол Улсын эдийн засгийн суурь нөхцөлийг авч үзвэл энэ нь амжилттай хэрэгжүүлэхэд хүндрэлтэй асуудал юм. Хөрөнгө оруулалтын чадамжийн хувьд Монгол Улс нь засаглалын хэрэгцээг хангах гурван гол үзүүлэлт болох хүн ам, хүн амын нягтшил, татварын орлого зэрэг үзүүлэлтээр ихээхэн доогуур эрэмбэлэгдэж байна (Зураг 5-г үзнэ үү). Гэхдээ байгаль орчинд хуваарилж буй санхүүжилтийн хэмжээ сүүлийн жилүүдэд харьцангуй нэмэгдэж байна. 2006 оноос өмнө байгаль хамгаалалд чиглэсэн хөрөнгө оруулалт бараг хийдэггүй байсан бол сүүлийн 10 жилд энэ чиглэлээр төсвийн хөрөнгө оруулалт бараг 10 дахин өсөж, 2006 онд 2.6 тэрбум төгрөг (\$1.1 сая ам.доллар) байснаас 2015 он гэхэд 28 тэрбум төгрөгт (\$11.6 сая ам.доллар) хүрсэн нь төсвийн ангилал дотроо хоёр дахь том хөрөнгө оруулалт болжээ.<sup>180</sup>

График 9. 2000-2015 Монгол Улсын Байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлд хийсэн хөрөнгө оруулалт



Зураг 5. Хүний нөөцийн болон санхүүгийн хязгаарлагдмал байдал<sup>181</sup>



180 Мөн адил.

181 Монгол улсын статистикийн мэдээллийн үйлчилгээ ([www.1212.mn](http://www.1212.mn)) for хүн амын тоо (2016), нягтрал (2016), болон татварын орлого (2016). CIA WorldFactBook ([www.cia.gov](http://www.cia.gov)) for data on Mongolia's position within Global Rankings.

Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчидтай харьцуулахад аймгийн түвшний байгаль хамгаалагчдын нөхцөл байдал тул тусгай байна. Сэлэнгэ аймагт 28 байгаль хамгаалагч 41,000 км<sup>2</sup> газар нутгийг хариуцаж байгаа бол Баян-Өлгий аймагт 30 байгаль хамгаалагч 45,700 км<sup>2</sup> газар нутгийг хариуцаж байна. Эдгээр аймгуудын нэг байгаль хамгаалагч дунджаар 1,500 км<sup>2</sup> газар нутагт эргүүл хяналт хийх үүрэг хүлээж байна.<sup>182</sup> Байгаль хамгаалагч нарт ногдох газар нутгийн харьцаа бараг бүх аймагт ижил хүндхэн байгаа хэдий ч зарим аймгийн захиргаад сүүлийн жилүүдэд анхаарал тавьж байгаль хамгаалагчдын үйл ажиллагаанд санхүүжилтээ нэмж байна. Үүнээс үүдэн аймгуудын хооронд ялгаатай нөхцөл байдал үүсчээ.

Судалгаанд хамрагдсан байгаль хамгаалагч, байгаль орчны байцаагч, гаалийн байцаагч, цагдаа зэрэг хууль сахиулах байгууллагын ажилтнууд санхүүжилт хүрэлцэхгүй байгаад санаа зовниж буйгаа илэрхийлж байсан. Цалин хөлс хангалтгүй, наад захын тоноглол, тоног төхөөрөмж (дүрэмт хувцас, дуран гэх мэт) байхгүй, байгаа нь хуучирсан ашиглах боломжгүй болсон байна. Судалгаанд хамрагдсан хүмүүс бие хамгаалах хэрэгсэл (тухайлбал, цахилгаан бороохой, хийн буу) дутмаг байгаа нь зэвсэглэсэн хулгайн анчидтай тулгарах тохиолдолд эрсдэлтэй байдгийг дурдаж байлаа. Автомашины хүрэлцээ муу байгаагаас олон тооны байгаль хамгаалагч нар хуучин мотоцикл, эсвэл мориор ажлаа гүйцэтгэж байгаа нь ялангуяа, өвлийн цагт эргүүл хийхэд хэцүү болж, зарим тохиолдолд тэдний амь насанд ч аюул учруулахуйц нөхцөл үүсч байна. Бусад тусгай хэрэгсэл болох камер, майхан, хөнжил, зөөврийн гэрэл, GPS, хураан авсан зэрлэг амьтныг хадгалах хэрэгсэл зэрэг нь онцгой нөхцөлийн ангилалд орж байна. Ихэнхдээ гадаад улс орнуудаас дэмжлэг үзүүлсэн тохиолдолд л дээрх тоноглолоор хангагдаж байна. Чухал хэрэгцээ гэж олонх нь үзэхгүй байгаа ч зарим байгаль хамгаалагчид сандал ширээ, компьютер зэргийг хэрэгцээтэй зүйлс хэмээн нэрлэж байлаа.

Төр засгаас хангах ёстой тоног хэрэгсэл дутмаг байгаагаас зарим тохиолдолд байгаль хамгаалагчид өөрийн хувийн эд зүйлсээ (тухайлбал, автомашин, зураг авах утас, гэр ч байтугай дүрэмт хувцас) хэрэглэж байгаагийн зэрэгцээ уул уурхайн компаниуд, байгаль хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын хандив тусламжаар тоног хэрэгсэлтэй болж байна. Байгаль хамгааллын үйл ажиллагааг санхүүжүүлэхийн тулд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих нь ухаалаг стратеги хэдий ч дутагдаж буй зүйлсийг түншлэлийн өнөөгийн түвшинд нөхөж чадахгүй байгаа тул шаардлагатай тоног төхөөрөмж дутмаг хэвээр, эргүүл хяналтын чадавхийг бүрдүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Судалгаанд хамрагдсан хууль сахиулах байгууллагын ажилтнууд бараг бүгд шагахуун хүрэлцэхгүй байгаагаа,

182 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага #3.13 (Баян-Өлгий – Алтайн нурууны байцаагч) болон #4.1 (Сэлэнгэ- Байгаль орчны байцаагч)

аль эсвэл цаг агаарын хүндрэл зэргээс хамааран эргүүл хяналтын төлөвлөгөө тасалдахад хүрч байгааг өгүүлж байсан.<sup>183</sup>

## Хүчирхийлэл хууль сахиулах ажиллагааг сулруулж байна

Байгаль хамгаалагч нарт тулгарч байгаа сорилт зөвхөн тэдний эргүүл хийх, хамгаалах талбайн хэмжээ ихээр хязгаарлагддаггүй, тэдэнд тулгардаг өөр нэг сорилт бол хүчирхийлэл юм. Дэлхий даяар байгаль хамгаалагч нар нь хулгайн анчидтай хийх гэмцлийн тэргүүн шугамд явж байдаг. Ардчилсан Конго Улсын Вирунга дархан цаазат газар гэхэд л 150 орчим байгаль хамгаалагч албан ажлаа гүйцэтгэж байхдаа амь насаа алдсан мэдээлэл байдаг.<sup>184</sup> Сүүлийн 10 жилийн хугацаанд дэлхийн хэмжээнд 10,000 орчим байгаль хамгаалагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдсэний 80 орчим хувь нь хулгайн анчид, зэвсэгт бүлэглэлүүдийн гарт эндсэн байна.<sup>185</sup>

Гэхдээ бусад улс оронтой харьцуулахад Монгол Улсын байгаль хамгаалагчдын хувьд хүчирхийлэл нь түгээмэл аюул биш юм. Судлаачдын тогтоосноор хулгайн анчид болон хууль бус загасчид байгаль хамгаалагч нараас хялбархан зугтах, баригдахгүй, ямар нэгэн зөрчил мөргөлдөөн үүсгэхгүйн тулд хурдан зайлах аргыг сонгодог ажээ.<sup>186</sup> Хяналт шалгалтын төлөвлөгөөг (эргүүл хийх өдөр, цаг, маршрутыг) урьдчилан ямар нэгэн аргаар олж мэдэх нь хулгайн анчдын хувьд баригдахаас зайлсхийх хамгийн түгээмэл арга болжээ. Увс аймгийн байгаль орчны байцаагчийн тооцоолсноор төлөвлөгөөг хоёр удаагийн хяналт тутмын нэгнийх нь талаар мэдээллийг гадагш алдсан байдаг ажээ.<sup>187</sup> Шөнийн цагаар амьтан агнах нь байгаль хамгаалагч нартай тулгарахаас сэргийлэх өөр нэгэн хялбар бөгөөд түгээмэл арга болсон байна. Дорнод аймгийн нэгэн загасчин “загас барих зөвшөөрөл авч чадахгүй байгаа болохоор бид хулгай хийж байгаа юм шиг л загасчилдаг. Нэгэнт л хууль зөрчиж байгаа болохоор сайн нуугдах шаардлагатай” хэмээжээ.<sup>188</sup>

183 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага #1.3, #2.6, #2.7, #2.8, #3.3, #3.9, #4.3, #4.12, #5.2, #5.8, #5.11, #5.13, #6.8

184 Neme, Laurel, *For Rangers on the Front Lines of Anti-Poaching Wars*, *Daily Trauma*, National Geographic (Jun. 27, 2014), <http://news.nationalgeographic.com/news/2014/06/140627-congo-virunga-wildlife-rangers-elephants-rhinos-poaching/> хаягаар үзнэ үү.

185 Thin Green Line Foundation, *What We Do*, <https://www.thingreenline.org.au/> хаягаар үзнэ үү.

186 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага #2.2 (Увс – Гаалийн байцаагч)

187 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага #2.9 (Увс – Байгаль орчны байцаагч)

188 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага #6.4 (Дорнод – Загасчин)

Монгол Улсын хуулиар тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчид нь бие даан хууль сахиулах арга хэмжээ авах болон хүч хэрэглэх талаар тодорхой хязгаарлалттай байдаг. Хуульд зааснаар зөвхөн биеэ хамгаалах зорилгоор галт зэвсэг хэрэглэж болно. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 32.2.1-д “байгаль хамгаалагчийн амь нас, эрүүл мэндэд гэмт этгээд хохирол учруулж болзошгүй нөхцөл байдал бодитоор бий болсон” эсвэл “байгаль хамгаалагчийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулж болзошгүй байдлаар зэрлэг амьтан довтолсон тохиолдолд” байгаль хамгаалагч нь зэвсэг хэрэглэж болно хэмээн заажээ. Гэхдээ ТХГ-ын дийлэнх дээр байгаль хамгаалагч нар зэвсэглээгүй байгааг судалгааны явцад тогтоосон. Тэдэнд мөн зөрчил гаргасан этгээдийг баривчлан саатуулах эрх байхгүй, зөвхөн торгуулийн хуудас бичих төдий эрхтэй байна. Үүнээс үүдэн ямар ч нөхцөлд зэвсэг, тусгай хэрэгсэлгүй гар хоосон байгаль хамгаалагч, зэвсэглэсэн этгээдтэй тулгарах, улмаар хэдэн арван километр зайд орших суурин газарт очиж, цагдаагийн албанд мэдэгдсэнээр сая гэмт этгээдийг саатуулах нөхцөл үүснэ. Ийм нөхцөлд нүүр тулгарахаас зайлсхийх нь зөвхөн хулгайн анчдын ч бус мөн байгаль хамгаалагчдын хамгийн боломжит сонголт болж байна.

Судалгааны явцад ямар нэгэн хүч хэрэглэсэн үйлдэл тогтоогдоогүй нь үүнээс шалтгаалсан ч байж магадгүй юм. Харин хууль бус бүлэг анчид болон байгаль хамгаалагчид нүүр тулгарсан олон тохиолдол байсан хэдий ч аль аль тал нь мөргөлдөөн үүсэхээс зайлсхийж байсан ажээ. Нэг бол хурдан машинтай хулгайн анчид зугтах, аль эсвэл амь насаа хамгаалахын тулд байгаль хамгаалагчид тухайн газраас зайлах замаар шийдлээ олж байжээ.<sup>189</sup>

## Зэрлэг амьтны хууль бус худалдаа ба мансууруулах бодисын наймааны адил төстэй тал

Зэрлэг амьтны хууль бус худалдааг байгаль орчны эсрэг гэмт хэрэг хэмээх ангилалд оруулдаг ч энэ нь аюултай хог хаягдлыг хууль бусаар хаях гэх мэт байгаль орчны гэмт хэрэгтэй адил гэхээсээ илүү мансууруулах бодис болон хүн худалдаалах гэмт хэрэгтэй төстэй юм. Зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэрэг нь зэрлэг амьтны бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэхдээ зэвсэг, мансууруулах бодис, хүний наймаа, алмаз худалдаалагчдын ашигладагтай адил ложистик, санхүүгийн аргуудыг ашиглан нарийн зохион байгуулалттай байдлаар үйлдэгддэг (Зураг 6-г

189 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага #5.2 (Өмнөговь – Анчин)

үзнэ үү). Зэрлэг амьтныг хууль бусаар худалдаалах гэмт хэрэг болон бусад хууль бус худалдааны гэмт хэргийн адил төстэй талыг сайтар судлах нь тэдгээртэй тэмцэх, мөрдөн шалгах стратеги, хууль сахиулах зохистой арга хэмжээг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд улс орнууд хамгийн дэвшилтэт шинэ арга техник, технологийг ашиглаж баймааж үр дүнд хүрсэн байдаг.

Зэрлэг амьтныг хууль бусаар худалдаалах гэмт хэргийн мөрдөн байцаагч нар, тухайлбал, АНУ-ын Аюулгүй байдлын алба (Homeland Security), АНУ-ын Загас, зэрлэг амьтны газар болон Далай, агаар мандлын үндэсний захиргааны тусгай ажилтнууд мансууруулах бодис дамлан худалдаалахтай тэмцэхэд ашигладаг арга техникийг аль хэдийнээс хэрэглэж эхэлсэн байна. Ялангуяа, хил дамнан хууль бус барааг илрүүлсэн ч “хяналттай хүргэлт” буюу тусгай хяналтын дор барааг эзэнд хүргэх замаар цаад сүлжээг илрүүлэх, түүнчлэн хэргийг газар дээр нь баримтжуулж, хэрэгтнийг цаг алдалгүй саатуулах “урьдчилсан зөвшөөрөл авах” аргыг ашигладаг байна.<sup>190</sup> Хууль сахиулах ажилтнууд ямар нэгэн хариуцах эзэнгүй, хууль бус бараа бүтээгдэхүүн бүхий ачаа илрүүлэх тохиолдолд эхний арга нь үр дүнтэй юм. Ийм тохиолдолд тухайн ачааг эцсийн цэг хүртэл нь мөрдөн хянах замаар тухайн сүлжээг илрүүлэн, холбогдогч этгээдийн эсрэг баримт нотолгоотой болгодог. Саатуулах урьдчилсан зөвшөөрлийг авахдаа тодорхой газарт, тодорхой цагт гэмт хэрэг үйлдэгдэж магадгүй гэсэн сэжгийн үндсэн дээр шүүхэд хүсэлт гаргадаг байна. Энгийн саатуулах зөвшөөрлийг зөвхөн гэмт хэрэг үйлдэгдсэний дараа авдаг бол хууль сахиулах байгууллагын ажилтан нь гэмт хэргийг илрүүлэх хангалттай итгэл үнэмшилтэй тохиолдолд мөн авч болдог байна. Эдгээр аргуудыг хослуулан хэрэглэснээр нэгжлэг хийх зөвшөөрөл урьдчилан авч, хууль бус ачааг хүлээн авах үед нь саатуулах, нэгжлэг хийх боломжтой болдог ажээ.

Зураг 6. Хууль бус худалдаа: Түгээмэл аргууд



Эдгээр аргуудыг ашигласнаар “жигжиг тоглогч” төдийг барьж, хууль бус худалдааны сүлжээг илрүүлж чадалгүй алдах эрсдлээс сэргийлж болно. Хууль бус худалдааны орчинд ‘илжиг’ гэсэн түгээмэл хэллэг байдаг бөгөөд энэ нь хууль бус худалдааны сүлжээтэй нарийн холбоогүй, тэдэнд ашиглагдаж, гар хөл нь болон хууль бус ачаа барааг зөөгч хүмүүсийг нэрлэдэг. Монголд амьдралын түвшин тааруу эмэгтэйчүүдийг ашиглан хууль бус ачаа барааг бага багаар нь тэдний цүнх сав, чихэр, жигнэмэгийн хайрцагт нууж хилээр гаргадаг болохыг энэхүү судалгааны явцад олж тогтоосон.<sup>191</sup> Ийм тохиолдолд хууль сахиулах үйл ажиллагааны гол зорилго нь зөвхөн “илжиг” барихад чиглэж, хууль бус худалдааны жинхэнэ сүлжээг барьж байгаа хэсэгт хүрч чадахгүй байна. “Хяналттай хүргэлт” хийх замаар дараагийн түвшинд гарч ажиллах, тухайн хууль бус худалдааны сүлжээний гэмт хэргийг нотлон тогтоох хэрэгтэй юм. Энэ түвшний нотолгоо цуглуулсан тохиолдолд холбогдогч нар хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллаж, ханган нийлүүлэгч, сүлжээний талаарх чухал мэдээллүүдийг гаргаж өгөх боломжтой. Жигжиг худалдаачид болон илжигнүүдийг шийтгэхээс илүүтэйгээр ханган нийлүүлэгчдийг тогтоон хариуцлага тооцож чадвал илүү их үр дүнтэй.

Өмнө нь мансууруулах бодисын худалдааг дэлхийн хэмжээнд мөрдөн шалгаж байсан туршлагадаа

191 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага 1.8 болон 1.12, Ховд аймаг

190 Sellars, J. (2017) What Wildlife Trade Enforcement Can Learn from Drugs and Arms Enforcement. Global Initiative Against Transnational Organized Crime.

суурилан Интерполиос зэрлэг амьтны хууль бус худалдааны чиглэлээр олон улсын тусгай ажиллагааг зохион байгуулдаг. Эдгээр тусгай ажиллагаанд цагдаа, гааль, хил хамгаалах байгууллага, байгаль орчин, зэрлэг амьтны чиглэлээр ажилладаг байгууллагын маш олон албан хаагчид оролцож, улс дамжин өргөн хүрээнд хэрэн сүлжилдсэн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй дэлхий даяараа тэмцэхээр нэгдэж байна. Монгол Улс ч хамгийн сүүлд зохион байгуулсан ийм ажиллагаанд оролцож, сэжигтнийг олж тогтоох, борлуулж буй бүтээгдэхүүн, эд хөрөнгийг хураан саатуулах зэрэгт тодорхой амжилт гаргасан (Зураг 7-г үзнэ үү). Олон улсын хууль бус худалдааны сүлжээтэй тэмцэх эдгээр дэлхий нийтийг хамарсан ажиллагаанд Монгол Улс оролцсоноороо ихээхэн туршлага хуримтлуулсан бөгөөд цаашид энэ үйлсээ тасралтгүй үргэлжлүүлэх нь чухал байна.

Зураг 7. Интерполын явуулсан “Аянгын шувуу” ажиллагаа



Монгол Улсын хувьд олон улсын зэрлэг амьтны худалдаанд түгээмэл ашигладаг эрүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах нэмэлт арга барилыг ашиглах боломж байна. Тавдугаар бүлэгт буй эрх зүйн асуудлаарх хэсэгт өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эрүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү үр дүнтэйгээр хангахуйц эрх зүйн шинэтгэл хийх шаардлагатай болохыг онцолсон.

## Монгол Улсын зэрлэг амьтны хууль бус худалдаа нь олон улсын зохион байгуулалттай гэмт хэргийн нэг хэсэг болж байна

Өндөр ашигтай, хууль бус бизнес нь зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээ бий болох, улмаар хөгжин цэцэглэх үндэс суурь нь болдог. Ийм гэмт хэргийн сүлжээ нь маш олон тооны хүмүүсийг хамарч, нарийн технологи бүхий тоног төхөөрөмж ашиглаж, өндөр үнэтэй тээвэр ложистикийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийж, цэрэг армийн зориулалттай техник хэрэгсэл ашиглан өөрийгөө хамгаалах бүтцийг бий болгож байдаг. Энэхүү үйл ажиллагаа нь олон улсын хэмжээнд хийдэг нарийн тооцоолсон мөнгөн гуйвуулгын сүлжээгээрээ дамжуулан шат шатанд нь хээл хахууль өгөх замаар өөрсдийн бүтээгдэхүүнийг (мансууруулах бодис, зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн, хуурамч бараа гэх мэт) авах, тээвэрлэх, боловсруулах, хадгалах, борлуулах сүлжээг “аюулгүй” байдлаар баталгаажуулж байдаг. Ихээхэн өндөр ашиг бүхий худалдаа л дээрх хууль бус бизнест хамаарах бүх үйл ажиллагаанд шаардагдах өндөр зардлыг төлж чадахын зэрэгцээ гэмт хэргийн сүлжээ хүрээгээ тэлж оршин тогтнох нөхцөл болж өгнө.

Өндөр ашиг олох зорилгоор Монгол Улсын нэн ховордсон амьтны (тухайлбал, халиун буга, хүдэр, хүрэн баавгай, саарал чоно, мануул, тахь, үнэг болон бөхөн гөрөөс зэрэг) бүтээгдэхүүнийг БНХАУ-ын уламжлалт эм үйлдвэрлэлийн салбарт ханган нийлүүлэх, мөн БНСУ-ын зах зээлд (бага хэмжээгээр) гаргах зэргээр зэрлэг амьтны хууль бус худалдааны зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэгдэж байна. Судалгаанд хамрагдсан хууль сахиулах байгууллагын өндөр албан тушаалтны мэдээлснээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын худалдааны сүлжээнд БНХАУ, БНСУ-ын худалдаачид оролцож байгаагийн зэрэгцээ тэд захиалга өгөх, худалдан авах, интернет болон утсаар аймаг сумдтай холбогдон сүлжээнийхээ хүрээнд хулгайн анчдад хүрэх улмаар тухайн анчид нь захиалгынх нь дагуу зэрлэг амьтныг агнах зэрэг ажлыг хийж байна. Захиалгыг гүйцэтгэхдээ хууль бус агнуурын олон төрлийн арга, өндөр хурдтай автомашин ашиглан, бүлэглэн үйлдэж байна. Шөнийн гэрэлтүүлэг, автомат галт зэвсэг ашиглах, автомашинаар зориуд зэрлэг амьтныг дайрах, автомашинаар хөөх зэрэг хууль бус аргууд хэрэглэж байна. Мөн гэмт хэргийн бүлэглэлүүд зэрлэг амьтны байршлыг тогтоохын тулд дрон ашиглаж байсныг цагдаагийн байгууллага тогтоожээ.<sup>192</sup>

192 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага.

“Худалдан авах захиалга” ихтэй үед хууль бус анчид нь аргаа өөрчлөн зэрлэг амьтныг мотоциклоор хөөж буудан агнаж, араас нь хурдтай ачааны машинаар агнасан амьтдыг цуглуулан ачиж явдаг байна. Цаг хугацаа яараагүй, гэнэтийн шалгалттай таарахааргүй бол хулгайн анчид агнасан зэрлэг амьтны хэрэгтэй эд эрхтнийг тухайн агнасан газраа эвдэн салган авч үлдэгдлийг хээр хаян орхиж байна. Агнуур хийснийхээ дараа тухайн орон нутаг, сум, аймгийн түвшинд буй сүлжээний гишүүд хэсэг хэсгээрээ тохирсон газраа цугларч зэрлэг амьтны эд эрхтнийг цуглуулан авдаг ажээ. Улмаар тэд Улаанбаатар хотоор дайрахаас зайлсхийж шууд БНХАУ-руу гаргахаар Замын-Үүд, Эрээнийг зорьж байна. Судалгаанд хамрагдсан гол мэдээлэгчдийн мэдээлж байгаагаар сүүлийн жилүүдэд ийм төрлийн 12 бүлгийг мөрдөн шалгаж гүйцэтгэх ажиллагаанд нь оролцож байсан бөгөөд тэдний хууль бус худалдааны ашиг 15 сая ам.долларт хүрсэн тооцоо байна. Хууль сахиулах байгууллагын ажилтнууд импортлогчдоос цаашир сүлжээнд оролцогчдын талаар мэдээлэл өгөөгүй хэдий ч тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрт хүргэх, боловсруулах, арилжааны зорилгоор бөөний болон жижиглэнгийн худалдаанд оруулахын тулд мэдээж тэдэнд хамтрагч талууд шаардлагатай нь ойлгомжтой билээ.

## Хууль бус худалдааг нуун далдлах бизнес эрхлэгчдийн башир арга

‘Фронт компани’ буюу ‘халхавч компани’ гэсэн нэр томъёо албан бизнесийн үйл ажиллагаанд хэрэглэдэг боловч заримдаа хууль бус бизнесийн нүүр царай ч болох нь бий. Бичиг баримтаас нь харахад фронт буюу халхавч компани нь ямар нэгэн төрлийн худалдаа, үйлчилгээ эрхэлдэг хараат бус, хууль ёсны этгээд байдаг. Гэтэл амьдрал дээр заримдаа тухайн компанийг өөр байгууллага удирдан хянаж мансууруулах бодис, хүн худалдаалах гэх мэт хорiotой үйл ажиллагааг далд хэлбэрээр явуулж байдаг.

Албан ёсны худалдааг ашиглан хууль бус үйл ажиллагааг далдлах нь түгээмэл тохиолддог бөгөөд энэ нь олон улсын зэрлэг амьтны худалдааны салшгүй нэг хэсэг болж илрүүлэхэд тун төвөгтэй байдаг. Үүний нэг тод жишээ бол “Зааны соёоны хатан” хэмээн нэрлэгддэг нэгэн этгээдийг 2015 онд Танзани Улсад баривчилсан явдал юм. Хятадын “Зааны соёоны хатан” гэгддэг тэрхүү этгээдийг хэд хэдэн охин компаниа ашиглан 200 гаруй зааны соёо хууль бусаар худалдаалсан учраас Танзани Улсад баривчилсан юм. Гэхдээ тэр олон арван жилийн туршид энэхүү хууль бус худалдаа эрхэлж байсан бөгөөд түүнийг хил давсных нь дараа л сая баривчлах боломж олдсон байдаг.<sup>193</sup>

193 Smith, David, *Chinese 'Ivory Queen' Charged with Smuggling 706 Elephant Tusks*, The Guardian (Oct. 8, 2015), <https://www.theguardian.com/environment/2015/oct/08/chinese-ivory-queen-charged-smuggling-706-elephant-tusks> хаягаар үзнэ үү.

Одоогоор Монгол Улсад хийсэн олон тооны судалгаа, мөн энэ судалгааны явцад ийм төрлийн аливаа үйл ажиллагааны талаарх мэдээлэл бүртгэгдээгүй байна. Гэхдээ Монгол Улсын хууль сахиулах байгууллагууд, гаалийн ажилтнуудын зүгээс зэрлэг амьтан худалдаалагчид, тээвэрлэгчид нь уул уурхайн үйл ажиллагаатай ихээхэн холбоо сүлбээтэй болсныг онцолж байсан.<sup>194</sup> Уул уурхайн үйл ажиллагааг эхлүүлэхэд ихээхэн өндөр зардал шаардагдах учир ийм төрлийн бизнес нь зэрлэг амьтны хууль бус худалдааг далдлах халхавч байдлаар ашиглагдаж байж болзошгүй юм. Энэ нь зэрлэг амьтны хууль бус худалдааг нуун далдлах, улмаар хил дамнуулан худалдах боломжийг нээж өгч байж мэдэх юм.

194 Өмнөговь аймагт гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага 5.8, 5.9, 5.10, 5.14 болон 5.15



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:

# ИНСТИТУЦУУД БА ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

# Институцийн орчин

## ЧАДАВХЫГ ДАХИН БЭХЖҮҮЛЭХ НЬ

Зэлүүд тал анхны тайланд 1990-ээд оны эхэн үед Монгол Улсын засаглалын шилжилт, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас хамааран зэрлэг амьтны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын тоо эрс буурсныг тэмдэглэжээ. Зэрлэг амьтад нь олон талын нөөц, эх үүсвэр ихээр шаарддаг ба энэ нь олон жилийн туршид Монгол улсын анхаарал татахуйц асуудал байсаар. Мөн зэрлэг амьтны удирдлагын асуудал нь Монгол улсын засаглалын бүтцийн нэгээхэн хэсэг болсоор иржээ. Ан агнуур болон зэрлэг амьтны худалдааны асуудлыг хянах, зохицуулах албан ёсны хүчин чармайлтыг 1900 оны үеэс хэрэгжүүлж, 1960 он гэхэд Монгол Улс өмнө хүрч байгаагүй амжилтад хүрч, энэ чиглэлийн үндэсний хэмжээний хөтөлбөрийг иж бүрэн институцийн түвшинд хүргэжээ.

Монгол Улс нь Чингис хааны үеийн цэргийн аравтын системийн зохион байгуулалтыг санагдуулам байдлаар анчдыг “Бригадын” систем болгон зохион байгуулалтад оруулав. Хуучны ан агнуурын нэгжүүдийг яамны удирдах газрын доор оруулж, тэдгээр ан агнуурын нэгжүүдийг хагуу хяналт доор үйл ажиллагаа явуулах (жишээ нь анчдын зөвшөөрөл, галт зэвсэг, сум хэрэгслийн хяналт, зорчих хөдөлгөөний хяналт) буюу зөвхөн зөвшөөрөл бүхий этгээд албан ёсоор зэрлэг амьтан агнах боломжтой болгожээ. Нийт 25,000 хүртэл гишүүнтэй байсан эдгээр ангийн бригад нь бүх аймаг, сумдад ажиллаж, улмаар хууль бус ан агнуурыг мөрдөн шалгах эрх бүхий байсан. Харьцангуй сайн зохион байгуулалттай, улсаас дэмжлэг туслалцаа сайтай байсан энэхүү бүтэц нь агнуурт тавих хяналтын хувьд ихээхэн нөлөөтэй байв. Үүнийг гэрчлэх нэг баримт нь 1970-аад оны үед олон улсын хэмжээнд худалдаалахыг хориглосон бүх зүйлийг агнахыг хориглож байв. Албан ёсны мэдээ, баримтаас үзвэл тухайн үед бүтэн 5 жилийн туршид зэрлэг амьтны олон улсын худалдаа огт хийгдэхгүй үе ч байжээ. Зарим зүйлийн хувьд олон улсад худалдах зорилгоор агнах зөвшөөрөл олгохгүй байсан бол бусад зүйлийн хувьд ангийн бригадууд нь өмнөх тооны 50%-аас бууруулахгүй байдлаар агнах, борлуулахыг зөвшөөрч байжээ.

1991 оныг хүртэл ангийн бригадууд нь зэрлэг амьтны менежментийн болон эрх зүйн хүчирхэг бүлэг болж байсан ч санхүүжилт, материал, хангамж (шатахуун, сум хэрэгсэл) нь тасалдан, улмаар санхүүжилтгүй болсноор үндсэндээ тэд эрх мэдэл хязгаарагдмал, тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжгүйд хүрсэн. Санхүүжилт хангалтгүй болсон, мөн хуучин Зөвлөлтийн үеийн

систем хэмээн үзсэн тул үйл ажиллагаа нь сэргэлгүй зогсчээ. ЦЕГ-ын Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн албан тушаалтны мэдээлснээр Анчдын нийгэмлэг нь “Ач холбогдол” болон түүхэн утгаа нэгэнт “Алдсан” байна. Ан агнуурын тусгай зөвшөөрөл шаардахгүй болсноор галт зэвсэг эзэмших эрх бүхий хүн бүр үндсэндээ анчин болох боломжтой болсон.<sup>195</sup>

Хуучин систем задран унасны дараачаас эрс нэмэгдсэн зэрлэг амьтны агнуур, худалдаа нь Монгол Улсыг зэрлэг амьтны асуудалд анхаарлаа хандуулахад хүргэжээ. **Өнгөрсөн жилүүдэд салбарын удирдлага болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагууд хамтран бүрэн төлөвшөөгүй, зарим талаар ухралт хийж буй амьтны худалдааны тогтолцоог эргэн харах, шаардлагатай арга хэмжээг авч ирсэн.** Өнгөрсөн 10-15 жилд гүйцэтгэсэн чухал үйл ажиллагаа бол байгаль орчны эсрэг гэмт хэрэг, үүнд зэрлэг амьтны хууль бус худалдааны асуудалд хяналт тавтх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зарим нэгж, байгууллагуудыг сэргээсэн явдал юм. Тухайлбал, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар (МХЕГ)<sup>196</sup>, Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс болон Хууль бус ан агнууртай тэмцэх явуулын нэгж зэрэг болно.

- **МХЕГ** нь 2002<sup>197</sup> онд Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хэлбэрээр байгуулагдсан ба өмнө нь хамаарах яамдын харьяанд тусдаа бие даан үйл ажиллагаа явуулж байсан хяналт шалгалтын чиг үүрэг бүхий байгууллагуудыг нэгтгэсэн бүтэцтэй. МХЕГ-д олон салбарын хяналтын чиг үүрэг төвлөрдөг бөгөөд байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхай болон санхүүгийн салбарын стандарт, хяналт шалгалтын нэгдсэн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Тус байгууллага нь одоо зэрлэг амьтны агнуур, худалдааны чиглэлийн хяналт шалгалтын үндсэн байгууллага болон хөгжиж, Монгол Улсын хэмжээний байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагчидтай хамтран ажиллаж байна.
- **Цагдаагийн Ерөнхий Газрын Мөрдөн Байцаах Албаны Хүрээлэн Буй Орчны Гэмт Хэрэг Шалгах Хэлтэс** цагдаагийн байгууллага дээр шинээр байгуулагдсан бүтэц бөгөөд 2010 оноос хойш хүрээлэн буй орчин, байгалийн нөөц, зэрлэг амьтны эсрэг гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах чиг үүргийг гүйцэтгэж байна.

195 Үндсэн оролцогч талын ярилцлага #UB17, Цагдаагийн ерөнхий газар.

196 Монгол хэлээр “Мэргэжлийн” нэрлэж буй англи хэлээр “expert” хэмээх үгээр орчуулагдаж болно. Энэхүү тайлангийн англи хувилбар дээр тухайн байгууллагын албан ёсны вэб сайт дээр үндэслэн “Specialized” хэмээн англи үгээр орчуулсан. (<http://eng.inspection.gov.mn>).

197 УИХ-ын 59 дугаар тогтоол, Засгийн газрын 2002 оны 126 дугаар тогтоол.



- Хууль бус ан агнууртай тэмцэх явуулын нэгж нь** ирвэс, бөхөн, аргаль хамгаалах эргүүл хяналтын үйл ажиллагааг эрхэлдэг. Анхлан Монгол дахь ДБХС-гийн санхүүжилтээр байгуулагдсан энэхүү нэгж нь байгаль хамгаалагчид, МХЕГ-ын улсын байцаагч, гаалийн ажилтан болон цагдаа зэрэг талуудын уялдаа, холбоог нэгтгэн, эргүүл хяналтын арга хэмжээг нэгдсэн байдлаар гүйцэтгэдэг.

Зураг 1. Байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлд хийгдэж буй хөрөнгө оруулалт



Дээр дурдсан болон бусад байгууллагуудын зэрлэг амьтны худалдаатай холбоотой чиг үүргийг дараагийн бүлэг, хэсгүүдэд тайлбарлав.

Зэрлэг амьтны менежмент болон хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч (байгаль хамгаалагчид)-ийн онцлогоос хамааруулан энэхүү тайланд үндсэн хоёр бүлэгт хуваан авч үзсэн. Үүнд:

- ”Зохицуулагч” эсвэл “Менежерүүд” –зэрлэг амьтан, тэдгээрийн худалдаатай холбоотой хууль тогтоомжийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх (амьтан барих, агнах худалдааны зөвшөөрөл олгох, CITES конвенцийн заалтыг мөрдөх, амьтдын тоо толгойн судалгаа гүйцэтгэх, агнуурын амьтдын тоо хэмжээг тогтоох гэх мэт) эсвэл,
- ”Хэрэгжүүлэгч” -зэрлэг амьтантай холбоотой гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах, яллах.

Сүүлийн жилүүдэд зэрлэг амьтны чиглэлтэй байгууллагуудыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулагдаж буй ч хангалтгүй байгаа бөгөөд олон нийт эдгээр хүндрэл, сорилтуудын талаар тодорхой ойлголттой болоод байна. Судалгааны хүрээнд ялгаатай гурван оролцогч талаас (өрх, аялал жуулчлалын байгууллагууд болон дэлгүүрүүд) зэрлэг амьтны хууль бус худалдаа, зэрлэг амьтан хамгааллын

үйл ажиллагааг үр дүнтэйгээр удирдах боломжийн талаарх саналыг нь тандан судалсан юм. Зэрлэг амьтан хамгааллын чиглэлээр өрхүүдээс авсан судалгааны дүнгээс үзвэл тэд энэ талаар сайн ойлголтоо буюу нийт 10-аас 9.6 оноо авсан. Үүнтэй ижил асуултаар зах зээл дээрх өөр талууд (аялал жуулчлалын компани, загасаар бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг ресторан мэт байгууллагууд)-ын ойлголтыг дүгнэхэд дээрхтэй ижил үр дүн гарсан. Харин зэрлэг амьтны эсрэг гэмт хэргээс сэргийлэх талаарх асуултанд хангалтгүй хариулсан буюу 10-аас 3.4 оноо авсан байна.

Зураг 2. Зэрлэг амьтны эсрэг гэмт хэргээс сэргийлэх төрийн чадамжийн талаарх олон нийтийн санал бодол



Зураг 3. Монгол улсын зэрлэг амьтны хууль бус худалдааг асуудлыг хариуцсан институци



## ХУУЛЬ ТОГТООГЧИД БА МЕНЕЖЕРҮҮД

Төрийн байгууллагуудын зэрлэг амьтны талаарх стандарт чиг үүргүүдэд эрх зүйн орчныг бий болгох, сайжруулах, зэрлэг амьтны хамгаалал, судалгааг хэрэгжүүлэх, тусгай хамгаалалттай газруудыг удирдах, агнуурын амьтны тоо хэмжээ, зөвшөөрөл болон агнуурын бүс нутгийг тогтоох зэрэг ан агнуурын удирдлагыг эрхлэх, мөн болон CITES-ын хүрээний худалдааг удирдах зэрэг багтдаг. Эдгээр үйл ажиллагааны ихэнх нь хууль бус худалдаатай шууд тэмцэхэд чиглэх тул эдгээр нь хууль ёсны болон хууль бус эсэхийг тогтоох үйл ажиллагааны үндэс болдог.

Монгол Улсын хувьд төрийн хууль тогтоохоос эхлээд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нийт 8 байгууллага (орон нутгийн захиргааг оруулан тооцоход) өөрсдийн чиглэлийн дагуу зэрлэг амьтны худалдаатай холбоо бүхий дээр дурдсан зохицуулах, удирдах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Төвийн болон орон нутгийн түвшинд чиг үүргийг хуваарилах нь нэг талаас амьдралаас гарсан зайлшгүй шаардлага, нөгөө талаас олон аймаг, сумдыг хамрах нэгдсэн зохицуулалт бүхий аргачлал шаарддаг ч орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай удирдлагын системийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Гэхдээ чиг үүргийн энэхүү хуваарилалтад зэрлэг амьтны худалдаатай холбоотой орхигдол, сул талууд ажиглагдаж байна. Түүнчлэн төрийн эдгээр байгууллагуудад зэрлэг амьтны зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй худалдааг үр дүнтэй хянахад шаардлагатай нөөц, эх үүсвэр, чадавх дутмаг байна.

Бид харьцуулалт хийх зорилгоор хууль тогтоомжид заасан үүргүүдийг 1) бодлого болон хамгаалал; 2) агнуур болон худалдаа; 3) CITES-ын удирдлага гэсэн гурван үндсэн бүлэгт хувааж, судалгааг гүйцэтгэв.

Эхний бүлэг буюу **бодлого болон хамгаалалд**

бодлого, хууль тогтоомжууд багтдаг. Энд хууль тогтоох түвшний байгууллагууд (жишээлбэл, УИХ) дангаар биш, мөн өөрийн чиг үүргийн хүрээнд тушаал, тогтоол, захирамж, журам гаргах эрх бүхий хэрэгжүүлэгч байгууллагуудыг хамааруулан ойлгодог. Эдгээр эрх мэдлийг УИХ, ЕТГ, БОАЖЯ болон хязгаарлагдмал хэмжээнд орон нутгийн захиргаад эдэлж буйг хүснэгт 1-т тусган харуулав.

Хоёрдугаар бүлэг буюу **ан агнуур болон худалдаа** нь зэрлэг амьтан болон худалдаалж буй амьтдаас хэрхэн, хэзээ, хаана, ямар тоогоор агнаж болохыг удирдан зохицуулах тухай юм. Зарим тохиолдолд энэхүү эрхийг хуулиар тусгайлан зааж өгдөг. Жишээлбэл, Монгол Улсын Амьтны тухай хуулиар БОАЖЯ-ыг агнуурын удирдлагын бүхий л хэлбэрийг, үүнд агнуурын хугацаа, бүс, агнах амьтны тоо болон бусад шаардлагатай нөхцлийг тогтоох чиг үүргийг дангаар хэрэгжүүлэх байгууллага хэмээн заажээ. УИХ нь ан агнуурын удирдлагын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй ч, үүнтэй хамаарах хууль тогтоомжийг батлан гаргах, Амьтны тухай хуульд хамаарах “Нэн ховор амьтны” жагсаалтыг батлах үүргийг хүлээнэ. Энэхүү эрхээ хэрэгжүүлэхдээ тухайн жагсаалтад орсон амьтдыг агнах үйл ажиллагааг хориглох эрхтэй. ЕТГ нь ан агнуурын чиглэлийн үйл ажиллагаанд тэр бүр оролцдоггүй ч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гаргах арга замаар зарим амьтныг агнахыг хориглодог. Зэрлэг амьтны худалдаатай холбоо бүхий гэхдээ энэ бүлэгт багтдаггүй өөр нэгэн байгууллага бол гааль юм. Тус байгууллага нь худалдаанд тавигдах шаардлагуудын хэрэгжилтийг хангах үүргийг хүлээдэг бөгөөд дараагийн “Хэрэгжүүлэгчид” хэсэгт энэ талаар өгүүлсэн болно.

Гуравдугаар бүлэг нь **CITES-ын удирдлага** бөгөөд үйл ажиллагааны хүрээ харьцангуй хязгаарлагдмал ч олон улсын худалдаа нь зэрлэг амьтдад үзүүлэх сөрөг нөлөө ихтэй байх учир чухал ач холбогдолтой. Үүнд хамаарах эрх бүхий нэгж нь шинжлэх ухаанд үндэслэсэн хохирлын дүгнэлтээс бусад үйл ажиллагааг хариуцсан CITES-ын үндэсний хороо болон эрсдийн үнэлгээ хийх, үндэсний хороонд бусад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй Шинжлэх ухааны байгууллага байдаг.

## Хүснэгт 1. Монгол улсад зэрлэг амьтны асуудал хариуцдаг байгууллагууд, тэдгээрийн үүрэг

ЗЭРЛЭГ АМЬТНЫ УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУД, ҮҮРЭГ РОЛЬ

	БОДЛОГО, ХАМГААЛАЛ			АГНУУРЫН УДИРДЛАГА			CITES-ЫН УДИРДЛАГА			
	Хууль, журам	Тоо толгойн судалгаа	Мэдээлэл, мэдлэг	Ангийн хормо	Агнуурын квот	Ангийн зөвшөөрөл	Худалдааны зөвшөөрөл	CITES-ын тайлан	CITES-ын импорт/экспортын зөвшөөрөл	CITES-ын Талуудын уулзалтад оролцох
УИХ	■	■	■	■	■	■	■	■	■	■
ЕТГ	■	■	■	■	■	■	■	■	■	■
ЗАСГИЙН ГАЗАР	■	■	■	■	■	■	■	■	■	■
БОАЖЯ	■	■	■	■	■	■	■	■	■	■
CITES-УДИРДАН ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГА	■	■	■	■	■	■	■	■	■	■
CITES-ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙГУУЛЛАГА	■	■	■	■	■	■	■	■	■	■
ОРОН НУТАГ	■	■	■	■	■	■	■	■	■	■

■ Бүрэн эрх   ■ Ажлаартай төсөл бусадтай хувьдсан эрх   ■ Эрхгүй

## УИХ-ЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ БАЙНГЫН ХОРОО

Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх байгууллагын анхдагч бүтэц, төсвийг УИХ-ын Байгаль орчны байнгын хороо тодорхойлдог. Хамаарах хууль тогтоомжид заасны дагуу УИХ нь зэрлэг амьтан хамгаалах, агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох чиглэлээр төрийн бодлогыг боловсруулах чиг үүргийг хариуцдаг. Үйл ажиллагааны хувьд энэхүү чиг үүрэг, үүнд зэрлэг амьтны агнуур болон худалдааны асуудлыг хамарсан эрх зүйн шинэтгэл зэргийг УИХ-ын Байгаль орчны байнгын хороо хариуцан ажилладаг.

Анхдугаар Зэлүүд тал тайлан гарсны дараах арван жилийн хугацаанд тус Байнгын хороо нь зэрлэг амьтны удирдлагатай холбоотой байгаль орчны болон байгалийн нөөцийн чиглэлийн гурван хуулийн төслийг боловсруулан, батлан гаргахад чухал үүргийг гүйцэтгэжээ. Эдгээрийн тоонд Ойн тухай хууль (2012), Ховор зүйлийн шинэчилсэн жагсаалт (2012) болон Амьтны тухай хуулийн шинэчилсэн найруулга (2012) багтана. Байнгын хороо нь мөн зэрлэг амьтны удирдлагыг сайжруулах чиглэлээр бусад суурь хуулиуд болох Татварын хууль (2008), Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль (2010), Эрүүгийн байцаан шийтгэх хууль (2015), Эрүүгийн хууль (2016) зэрэг хууль тогтоомжид зэрлэг амьтантай холбоотой зүйл заалтуудыг тусгахад ч хичээнгүйлэн ажиллажээ. Зэрлэг амьтны хууль бус худалдааны эрх зүйн орчны талаарх дараагийн хэсэгт энэхүү байнгын хорооны үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй дурдсан. Уг Байнгын хорооны үйл ажиллагаа нь зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх Монгол Улсын хандлага, чадавхыг шинэ хэлбэрт шилжүүлэхэд чухал эхлэл болсоор байна.

## ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхийлөгч нь үндсэндээ бэлгэдлийн шинж чанартай институц хэдий ч тодорхой хэмжээний эрх мэдэл, жишээ нь зарлиг гаргах эрхийг эдэлдэг. Ерөнхийлөгчийн зарлиг нь сэдвээр хязгаарлагдахгүй, гэхдээ Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд гарсан байх ёстой.

Тамгын газар нь чоно болон тарвага агнахыг хоригдох тухай Ерөнхийлөгчийн зарлиг гаргах зэрэг байдлаар зэрлэг амьтны хууль бус худалдааны асуудлыг хөндөж иржээ. Тодорхой үйл ажиллагаа хориглох эрхийг төрийн бусад байгууллага, албан тушаалтан мөн эдэлдэг бөгөөд (жишээ нь БОАЖЯ, Засгийн газар) тэдгээр яамд мөн чоно, тарвага агнахыг хориглох, зохицуулах олон тооны арга хэмжээг авч иржээ. Гэхдээ Ерөнхийлөгчийн зарлиг хэлбэрээр тухайн үйл ажиллагааг хориглох нь тодорхой ач холбогдолтой. Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх үүний гол үр дүн нь олон нийтийн мэдлэгийг бий болгох боломжтойд оршдог юм.

## ЗАСГИЙН ГАЗАР

Монгол Улсын Засгийн газар нь Ерөнхий сайдын удирдлагад бүхий л яамдыг нэгтгэсэн, гүйцэтгэх эрх мэдэл бүхий бүтэц юм. Байнга солигдох зэргээр хөдөлгөөнд байдаг Засгийн газар байгуулагдах бүрд УИХ-аас шинээр яамдын бүтцийг батлан, зарим тохиолдолд яам нэмж байгуулах зэргээр нийт яамдын тоог 11 байснаас 13 болгон нэмэгдүүлжээ. ЕТГ-ын ижил Засгийн газар нь мөн тодорхой түвшинд зохицуулах эрх мэдлийг эдлэх ба энэ хэсэгт дурдсаны дагуу ховордсон төрөл зүйлсийн ангийн квот тогтоох, ан агнуурт хориг тавих зэрэг эрх үүнд багтаж байна.<sup>198</sup> Амьтны тухай хуулийн дагуу “Нэн ховор” хэмээх жагсаалтад багтсан төрөл зүйлсийг агнахын тулд Засгийн газраас заавал зөвшөөрөл авахын зэрэгцээ тусгай зориулалтаар агнах ангийн квотыг мөн Засгийн газар тогтоодог.

Авлигаас сэргийлэх зорилго бүхий зохицуулалтын энэхүү хэлбэрт тулгарч буй томоохон сул тал нь албан ёсны квот тогтооход шинжлэх ухааны мэдлэгийг ашиглахгүй буй явдал байна. Өмнөх тогтолцоогоор олгож буй квотын тоо нь Биологийн хүрээлэнгийн зүгээс зөвлөмж болгосон тооноос хэтрэх ёсгүй.<sup>199</sup> Биологийн хүрээлэн нь шаардлагатай судалгаа хийхэд чадавх хангалтгүй байсан ч олгож буй квотыг мэргэжлийн үүднээс судлан шинжлэх хэрэгцээ байнга байсаар ирсэн. Квотын тооны талаарх зөвлөмжийг гэрээт мэргэжлийн байгууллагуудаас (зарим тохиолдолд ан агнуурын компаниудыг багтаадаг) ирүүлдэг шинэ аргачлал ашиглах болсон ч энэхүү шинжлэх ухааны хэрэгцээ арилж, алга болоогүй л байна.<sup>200</sup>

198 Жишээ нь Засгийн газрын 2013 оны 93 дугаар тогтоол.

199 Амгаланбаатар болон бусад., 2000.

200 Амьтны тухай хууль, Х зүйл; хуудас, L. (2015) Killing to Save: Trophy Hunting and Conservation in Mongolia. Independent

## БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР

БОАЖЯ-ны Хүрээлэн Буй Орчин, Байгалийн Нөөцийн Удирдагын Газар (ХБОБНГ) нь зэрлэг амьтны чиглэлээр дүрэм, журмыг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Монгол Улсын үндсэн байгууллага юм. Орон нутгийн зэрлэг амьтны менежментийг удирдан чиглүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгууд дахь зэрлэг амьтны асуудлыг мөн хариуцах, загасчлах болон бусад ан амьтны агнуурын горим, шаардлагуудыг тогтоох, CITES-ын жагсаалтад багтсан амьтны худалдааг зохицуулах, зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх зэрэг чиг үүрэгтэй. Зэрлэг амьтны хууль бус худалдааны асуудал хариуцсан яам нь зөвхөн хэрэгжүүлэгч бус захиргааны байгууллага болохыг дурдах нь зүйтэй. Тус газар нь орон нутагт шууд үйл ажиллагаа явуулахгүй, харин орон нутаг дахь амьтны менежментийн чиг үүргийг бусад байгууллагууд эрхлэнэ. Нэгэнт орон нутагт шууд хүрч ажиллахагүй учир ХБОБНГ нь тодорхой эрх мэдэл дутмаг, зэрлэг амьтны холбоотой гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, холбогдогчийг баривчлан саатуулах эрхгүй. Зарим орны уг газартай ижил төстэй байгууллага нь хэрэгжүүлэх эрх бүхий орон нутгийн ажилтнуудтай байдаг. Жишээлбэл, Мексик улсын Байгаль орчны яам нь “Байгаль орчны цагдаа”, АНУ-ын Загас, зэрлэг амьтны үйлчилгээ газар нь “Тусгай нэгж”-тэй хамтран үйл ажиллагаа явуулдаг.

Зохицуулалтын талаас нь үзвэл ХБОБНГ нь сүүлийн 10 жилд зэрлэг амьтантай холбоо бүхий гурван томоохон журам гарган, мөрдүүлж байна. Эдгээр нь Байгаль орчны чиглэлээр авах арга хэмжээний тухай журам (2005), Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай журам (2011) болон Ойн тухайн хуулийн хэрэгжилтийн хангах тухай журам юм. Зэрлэг амьтны хууль бус худалдааны тухай эдгээр болон бусад журам дүрмүүд нь зэрлэг амьтантай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх боломж, түүнд үзүүлж буй нөлөөг дүгнэсний үндсэнд гарсан.

Тус газар нь Нэн ховор болон ховордсон зүйлийн жагсаалтад өөрчлөлт оруулах ажлын удирдаж, бэлтгэсэн саналаа хамаарах байгууллагад хүргэнэ. Одоогоор тус жагсаалтад 31 зүйл нэн ховор, 76 зүйл ховор амьтан бүртгэгдээд байна. Нийт 107 зүйлийн амьтан дээр бүрэн, эсвэл хэсэгчилсэн байдлаар агнах, худалдаалах хориг хязгаарлалт тавиад байна. Жагсаалтад зүйлийг нэмэлтээр оруулах, анчид, олон улсын ба дотоодын худалдаанд өртөж буй зүйлийн агнах тоо хэмжээ нь заримдаа энэхүү газрын хамгааллын үйл ажиллагааны эсрэг мэт сэтгэгдэл төрүүлэхээр байна. Нэн ховор амьтны жагсаалтад сүүлд хийсэн өөрчлөлтөөр хургач бор (*Paradoxornis heudei*), цагаантолгой ямаансүүлт (*Oxyura leucocephala*), могойч загалай (*Circaetus gallicus*), цармын бүргэд

(*Aquila chrysaetos*), усны нөмрөгбүргэд (*Haliaeetus leucoryphus*) болон бор бүргэд (*Aquila clanga*) гэх 6 зүйл шувууг нэмж оруулсан. Түүнчлэн хилэм загасыг “Нэн ховор” зэрэглэлээс гаргаж, харин тул загасыг “Ховор” жагсаалтад багтаасан.

Хүснэгт 2. Монгол Улсын нэн ховор болон ховор амьтдын жагсаалт (2000 болон 2012 оны харьцуулалт)

МОНГОЛ УЛС			
НЭН ХОВОР БОЛОН ХОВОРДСОН ТӨРӨЛ ЗҮЙЛС (ЗЭРЭГЛЭЛЭЭР) ХАРЬЦУУЛСАН ЗУРАГЛАЛ (2000-2012)			
		2000	2012
БҮГД	Нэн ховор	25	31
	Ховор	10	76
<b>ТӨРӨЛ ЗҮЙЛ</b>		<b>35</b>	<b>107</b>
ХӨХТӨН	Нэн ховор	11	13
	Ховор	10	14
		<b>21</b>	<b>24</b>
ШУВУУ	Нэн ховор	8	9
	Ховор	2	23
		<b>10</b>	<b>32</b>
ЗАГАС	Нэн ховор	4	2
	Ховор	0	1
		<b>4</b>	<b>3</b>

Зэрлэг амьтны худалдаатай тэмцэхтэй холбоотой тус газрын хүлээдэг өөр нэгэн үүрэг бол амьтдын “Экологи-эдийн засгийн үнэлгээ”-г тооцон гаргах явдал юм. Амьтны тухай хуульд<sup>201</sup> энэ үнэлгээг өмнө нь хууль бус худалдаанд ноогдуулах торгуулийн хэмжээг тогтоох зорилгоор ашиглаж байжээ. Үнэлгээ нь тухайн амьтны үнэ цэнийг мөнгөн хэлбэрээр тодорхойлон гаргах зорилготой. Бодит амьдрал дээр энэхүү үнэлгээ нь хар захын үнийг ямар нэгэн байдлаар тусгадаг ба ингэснээр цаашид тухайн гэмт хэргийг гаргуулахгүй байх боломжийг хангадаг. Хүснэгт 2-г Монгол Улс дахь агнуурын зарим зүйлийн экологи-эдийн засгийн үнэлгээг Монгол төгрөг болон Америк доллараар харьцуулан харуулав.

Хүснэгт 3. Зэрлэг амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ

2016		
ҮНЭЛГЭЭНИЙ ЖИШЭЭ		
Төгрөгөөр болон ам. доллараар		
	Эр	Эм
<i>Panthera uncia</i>	₮ 22,400,000	₮ 26,000,000
ИРВЭС	\$9,739	\$11,304
<i>Ovis ammon</i>	₮ 22,000,000	₮ 26,000,000
АРГАЛЬ	\$9,565	\$11,304
<i>Pelecanus crispus</i>	₮ 13,140,000	
БОРЦГОР ХОТОН	\$5,713	
<i>Cervus elaphus</i>	₮ 6,000,000	₮ 7,500,000
ХАЛИУН БУГА	\$2,609	\$3,261
<i>Capra sibirica</i>	₮ 5,400,000	₮ 6,200,000
ЯНГИР	\$2,348	\$2,696
<i>Saiga tatarica mongolica</i>	₮ 4,000,000	₮ 4,400,000
МОНГОЛ БӨХӨН	\$1,739	\$1,913
<i>Procapra gutturosa</i>	₮ 1,000,000	₮ 1,100,000
ЗЭЭР	\$435	\$478
<i>Hucho taimen</i>	₮ 422,000	
ТУЛ	\$183	
<i>Tetraogallus altaicus</i>	₮ 260,000	
АЛТАЙН ХОЙЛОГ	\$113	
Валютын ханш 1 ам.доллар = 2,300 төгрөг		

Зэрлэг амьтны тоо толгойг тогтоох судалгааг удирдан хэрэгжүүлэх нь энэхүү газрын чиг үүрэгт мөн хамаардаг. Амьтны тухай хуульд заасанчлан<sup>202</sup> нотолгоонд суурилсан агнах амьтны тоо хэмжээг тогтооход зэрлэг амьтны судалгаа нэн шаардлагатай. Гэхдээ энэхүү чиг үүрэг нь өргөн хүрээг хамрах төдийгүй нөөц, эх үүсвэрийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан цаг хугацаанаас хоцрох, мөн сайн чанартай бус байна. Гэхдээ гарч буй тайлан, үр дүн нь илүү иж бүрэн, тогтмол шинжтэй хийгдэх шаардлагатай. Жишээлбэл, 2013 онд энэ чиглэлээр хийсэн ажлын тайлан 2016 онд буюу судалгаа хийгдсэнээс хойш 3 жилийн дараа л эцэслэн гарсан байх юм.<sup>203</sup> Хоёр жил тутамд үйл ажиллагааны тайланг CITES -ын Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлдэг. Монгол Улсын 2015- 2016 оны тайланд дурдсанаар зэрлэг амьтны тоо толгойн судалгаа хамгийн сүүлд CITES-ын жагсаалтад орсон 8 зүйл дээр гүйцэтгэсэн хэмээн заасан ч судалгааны тайлан, үр дүнгүүд эцэслээгүй байсан. Тухайн тайланд дурдсан зүйлсийн тоонд ирвэс (*Panthera uncia*),

202 Амьтны тухай хуулийн 5.3.2.-ийг үзнэ үү.

203 Гол оролцогч талын ярилцлага (БОАЖЯ).

шилүүс (*Lynx lynx*), мануул (*Otocolobus manul*), саарал чоно (*Canis lupus*), тахь (*Equus przewalskii*), Монгол бөхөн (*Saiga tatarica mongolica*), цагаан шонхор (*Falco rutilcolus*) болон начин шонхор (*Falco peregrinus*) багтжээ. Тухайн судалгаа нь зүйлийн тоо толгойг хамгийн сүүлийн байдлаар, цаг хугацаанд нь албан ёсоор нэгтгэн гаргаагүй нь улмаар 2005 оныхтой харьцуулах боломжгүй нөхцлийг бүрдүүлсэн. МУИС-ийн Биологийн тэнхимийг төлөөлсөн оролцогчдын үзэж буйгаар төрийн зүгээс зэрлэг амьтны тоо толгойг тогтоох судалгааг 5 жилд нэг удаа гүйцэтгэдэг ч мэдээ, баримт нь төдий л найдвартай, үнэн зөв, хэрэгцээтэй байж чаддаггүй нь судалгаа өргөн уудам газар нутгийг хамрах шаардлага, санхүүгийн хүндрэлээс шалтгаалдаг.

Анхдугаар “Зэлүүд тал” тайлан нь Монгол бөхөн, халиун буга, аргаль, идлэг шонхор болон гарваганы тоо толгой эрс буурсан нь тухайн үеийн хяналтгүй, хууль бус худалдааны тод илрэл юм. Монгол бөхөнгийн тоо толгой 5,000 байснаас 800 хүрэхгүй буюу 85% хүрч буурсан (ДБХС, 2004). Халиун бугын тоо толгой 1986 онд 130,000 байснаас 2004 онд 8,000-10,000 болж, харин 18 жилийн дараа гэхэд 92%-иар буурчээ. 1975 онд нийт 50,000-аар тоологдож байсан аргаль 1985 онд 60,000 болж, харин 2001 онд 13,000 болон 15,000 болж тоологдсон нь (Амгаланбаатар болон бусад, 2002) нь 16 жилийн хугацаанд 75% буурсан үзүүлэлт юм. Нэгэн үе 40 сая тоотой байсан тарвага 2002 он гэхэд 5 сая болсон нь 12 жилийн дотор 75%-иар буурсан (Батболд, 2002). Эцэст нь 1999 онд 3,000 хос хэмээн үзэж байсан идлэг шонхорын тоо 2004 онд 2,200 болсон нь 5 жилийн дотор тоо толгой нь 30% буурсан үзүүлэлт байна (Шагдарсүрэн 2001). Аман хэлбэрээр цуглуулсан нотолгооноос үзвэл зэрлэг амьтны бусад зүйлийн тоо толгой мөн л буурч буй бөгөөд нотлох мэдээлэл хараахан гараагүй.

Дээр дурьдсан зарим амьтдын тоо толгой нь хамгийн сүүлийн байдлаар гарсан ч хугацааны хувьд харьцангуй хоцрогдсон байна. Жишээ нь, хамгийн сүүлд хийсэн аргалийн судалгаа гэхэд 2009 онд хийгдэж, нийт тоог 19,700 бодгаль хэмээн тогтоосон нь өмнө тогтоосноос нэмэгдсэн дүнтэй байна<sup>204</sup>. Монгол бөхөнгийн тоо толгойд их өөрчлөлт гарсан ч 2017 оны мэдээгээр 5,000 толгой хэмээн тооцжээ. Хэдий энэ нь 2004 онд тооцсон 800 гэсэн дүнгээс хавьгүй илүү ч<sup>205</sup> бог малын мялзан төст өвчний улмаас тоо толгой нь 54.5%-иар буурсныг тогтоосон дүнгээс доогуур байна<sup>206</sup>

204 Lkhagvasuren, B, Y. Adiya, G. Tsogtjargal, G. Amgаланбаатар, and R. Harris. (2016) "Current Status and Conservation of Mountain Ungulates in Mongolia" (2016). *Erforschung biologischer Ressourcen der Mongolei / Exploration into the Biological Resources of Mongolia, ISSN 0440-1298*. 180.

205 Энэ нь анхдугаар Зэлүүд Тал тайланд ашигласан хүн амын тоон мэдээлэл болно.

206 Онлайн байдлаар тайланг дараах хаягаар үзнэ үү <http://www.panda.org/?296930/545-percent-of-the-Mongolian-Saiga-population-is-lost-due-to-disease-outbreak>.

Тус газар нь орон нутгийн засаг захиргаатай хамтран агнах зүйлийн бодгалийн тоо хэмжээг тогтоох үүрэгтэй. Зэрлэг амьтны тоо толгойг тогтоох байнгын, үнэн зөв судалгаа хангалтгүйгээс тогтоож буй тоо хэмжээ нь зарим талаар нарийвчлал дутмаг байдаг тал бий. Хуульд заасны дагуу тоо хэмжээний талаар санал гаргах эрхийг орон нутгийн захиргаа эдэлдэг. Гэхдээ орон нутгийн түвшинд шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааг гүйцэтгэх чадавх, санхүүжилт дутмаг. Мэргэжилтнүүд байсан ч өнөөгийн ашиглаж буй судалгааны арга зүй нь зарим талаар асуудал үүсгэх талтай. Монголд олон зүйл амьтан нүүдлийн, мөн улирлын шилжилт хийнэ. Тиймээс зөвхөн орон нутгийн хэмжээнд тооцон гаргасан тоо хэмжээ нь илүү өргөн уудам нутаг дэвсгэрийг төлөөлж чадахгүй.

Бодит байдлаас үзвэл орон нутгаас дэвшүүлсэн саналыг тус газар хянан үзэж, томоохон өөрчлөлтгүйгээр баталгаажуулдаг. Улсын хэмжээний нэгдсэн тоог жил тутам Засгийн газрын тогтоолоор батална. Шонхор болон шувууд (бүхий л зүйл дээр ерөнхий дүнгээр агнах тоог тогтоодог) аас бусад амьтны хувьд өнгөрсөн жил зөвхөн 8 зүйл (7 зүйлийн хөхтөн, 1 зүйлийн загас) дээр (хүснэгт 4) ашиглах тоо хэмжээг тогтоосон. Янгир ямаа, Монгол цагаан зээр, халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, аргаль болон чоно зэрэг анчдын гол гол бай болсон амьтад байна. Судалгааны мэдээлэлгүйгээр тухайн квот нь их, бага эсэхийг тогтоох боломжгүй ч үндсэндээ квотын хэмжээ тогтвортой байна. Харин тул загасны хувьд зөвхөн бариад, буцаан тавих нөхцөлтэй байна.

Яамны хэмжээнд чадавх буурч буй нь зэрэг амьтны хууль бус худалдааны асуудлаар ажиллах хүнд хэцүү чиг үүргийг улам бүр хүндрүүлж байна. Одоогийн байдлаар зэрлэг амьтны хамааралтай бүхий л хөтөлбөрийг (дотоодын болон олон улсын) нэг л ажилтан хариуцаж буй юм. Энэ нь зөвхөн сүүлийн үед гарсан өөрчлөлтийн үр дүн юм. 2011 – 2014 онуудад Яаман дээр “Монголын амьтан, ургамал хамгаалах үндэсний хороог” CITES болон зэрлэг амьтны худалдааны чиглэлээр ажилладаг 4 хүнтэй байгуулжээ. Гэхдээ УИХ-ын зүгээс хэд хэдэн үндэсний хорооны төсвийг бууруулсны тоонд дээрх хороо багтжээ. Төрийн санхүүжилтгүйгээр тус хороо үйл ажиллагаа явуулах боломжгүй болж, үйл ажиллагаагаа зогсоосон ба эргэн сэргээгээгүй байна. Одоо зэрлэг амьтан болон биологийн олон янз байдлын чиглэлээрх олон улсын гэрээ хэлэлцээр, хэрэгжилт, үндэсний хөтөлбөрүүд, тусгай зориулалтын ан агнуурын асуудлуудыг одоо нэг л ажилтан хариуцах болжээ.

#### Хүснэгт 4. Хувийн хэрэгцээнд олгосон агнуурын зөвшөөрөл

2014-2016			
Жил бүрийн агнуулах амьтны тоо хэмжээ			
	2014	2015	2016
Шувууд	-	300	400
Шонхор	40	300	400
Янгир	41	60	70
Зээр	200	150	150
Халиун буга	20	15	30
Гөрөөс	10	10	10
Тул (Барих- тавих)	310	350	400
Зэрлэг гахай	10	10	10
Аргаль	28	50	60
Чоно	20	20	20

#### ЭХ СУРВАЛЖУУД

Засгийн газрын 2014 оны 122 дугаар тогтоол (2014 оны 1 сарын 12)

Засгийн газрын 2015 оны 377 дугаар тогтоол (2014 оны 5 сарын 1), 2015 оны 4 сарын 27-нд нэмэлт өөрчлөлт хийгдсэн

2016 оны Засгийн газрын 463 дугаар тогтоол (2015 оны 11 сарын 23)

## CITES-ЫН УДИРДАН ЗОХИЦУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

CITES-ын Удирдан зохицуулах үндэсний зөвлөл нь БОАЖЯ-ны дэргэд байгуулагдсан ба бие даасан санхүүжилтгүй, жилд хамгийн багадаа хоёр удаа хуралдах тухай хуулиар заагдсан үүрэгтэй зохицуулах хороо хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг.<sup>207</sup> Конвенцийн удирдах зохицуулах үндэсний зөвлөлд БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын дарга, тус газрын нэг ажилтан, Монгол Улс дахь CITES-ын хэрэгжилтийн мэргэжлийн холбооны дарга ([www.cites.mn](http://www.cites.mn)) болон амьтан, ургамлын чиглэлийн байгууллагуудын нэгдсэн холбооны төлөөлөл (мөн Шинжлэх ухааны хороонд ажилладаг) багтдаг.<sup>208</sup> ЦЕГ, ГЕГ, МХЕГ зэрэг төрийн байгууллагууд, ДБХС зэрэг ТББ-ууд хорооны үйл ажиллагаанд оролцдог ч Монгол Улсыг төлөөлсөн албан ёсны бүртгэл CITES дээр байдаггүй.

CITES-ын Удирдах зохицуулах үндэсний зөвлөл нь Тусгайлсан байнгын ажилтангүй конвенцийн үйл

207 Гол оролцогч талын ярилцлага (БОАЖЯ).

208 CITES Үндэсний эрх бүхий талын мэдээлэл (<https://cites.org/eng/cms/index.php/component/cp/country/MN> хаягаар үзнэ үү.

ажиллагааг хэрэгжүүлэх, хоёр жил тутмын бага хуралд бэлтгэх, оролцох зэрэг идэвхтэй үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй. 2016 онд Өмнөд Африкийн Йоханесбург хотод зохион байгуулсан Конвенцийн Талуудын хурал (CoP17)-д Монгол улсаас зөвхөн нэг төлөөлөгч оролцжээ. ДНБ-ний хэмжээ багатай бусад улсууд энэхүү арга хэмжээнд харьцангуй олон тооны төлөөлөгч оролцуулсан байна. Жишээ нь Намиби (23 төлөөлөгч), Мозамбик (12) болон Мальдив (7).<sup>209</sup>Монгол Улстай хил залгаа улс орнууд мөн өргөн бүрэлдэхүүнтэй оролцож буй бөгөөд БНХАУ 26, ОХУ 10 төлөөлөгч илгээжээ.

Өмнөд Африкт 2016 онд хуралдсан Талуудын хурал нөхцөл байдал нь онцгой байжээ. Анхлан 1996 онд CITES-т нэгдэн орсноос хойш Монгол Улсын оролцоог түргэвчилсэн байдлаар дүгнэхэд өнгөрсөн 10 жилийн хугацаанд маш цөөхөн төлөөлөгч оролцуулж ирсэн байна (хүснэгт 5). Сүүлийн гурван удаагийн Талуудын бага хуралд Монгол Улсаас зөвхөн нэг төлөөлөгч оролцжээ.<sup>210</sup>Олон байршилд нэгэн зэрэг явагдах хуралдаан болон арга хэмжээнүүдэд нэг төлөөлөгч бүрэн оролцох боломжгүй.

Оролцоо хангалтгүй нь Монгол Улсын хувьд CITES-ын хүрээнд хөрш орнуудтай хамтарсан үйл ажиллагаа хөгжүүлэх, зохицуулах, хамтран ажиллах боломжийг хязгаарлаж байна. Жишээлбэл, CITES-ын Удирдан зохицуулах үндэсний зөвлөлийн тайланд ОХУ-тай хамтран гүйцэтгэсэн нэг удаагийн үйл ажиллагааны талаар (2003-2004 оны тайлан) дурджээ. Монгол Улс нь CITES-ын бусад улс орны ижил төрлийн байгууллагуудтай тогтмол бус харилцаатай байна. 2016 оны тайланд үндэсний болон олон улсын хэмжээнд арга хэмжээ хэрэгжүүлэх стратеги, эсвэл үйл ажиллагааны төлөвлөгөө хангалтгүй, албан ёсны олон улсын хамтын ажиллагаа хангалтгүй болохыг дурдсан. Монгол Улс Цоохор ирвэс, зэрлэг амьтны олон улсын сүлжээ (SLAWEN)-д албан ёсоор нэгдэн ороогүй. Агентлаг хоорондын болон хил дамнасан хамтын ажиллагаа, мэдээлэл харилцааны энэхүү сүлжээ нь зэрлэг амьтны хамааралтай хууль тогтоомжийн хэрэгжилтийн тухай мэдээллийг цоохор ирвэс тархсан улс орнууд хоорондоо хуваалцах боломжийг хангах зорилготой. Тус сүлжээ нь Өмнөд Азийн зэрлэг амьтны сүлжээ (SAWEN) болон АСЕАН-ны зэрлэг амьтны сүлжээ зэрэг улс орон дамнасан сүлжээний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Төв Азид ижил төрлийн системийг хөгжүүлэх, Өмнөд Азийн болон АСЕАН-ны сүлжээнд хамрагдаагүй бусад улс орнуудыг хамруулах чиглэлээр ажилладаг.

Хүснэгт 5. 1996 онд нэгдэн орсноос хойш Талуудын бага хуралд Монгол Улсын оролцсон байдал

CITES-ЫН ТАЛУУДЫН БАГА ХУРАЛ (CoP)					
Монгол улсын Засгийн газрын албан ёсны оролцоо					
			Удирдан зохицуулах хорооны төлөөлөл	Шинжлэх ухааны хорооны төлөөлөл	
10	дугаар хурал	1997	ЗИМБАБВЕ	2	-
11	дүгээр хурал	2000	КЕНИ	3	-
12	дугаар хурал	2002	ЧИЛИ	2	-
13	дугаар хурал	2004	ТАЙЛАНД	3	-
14	дүгээр хурал	2007	НИДЕРЛАНД	1	1
15	дугаар хурал	2010	КАТАР	1	-
16	дугаар хурал	2013	ТАЙЛАНД	1	-
17	дугаар хурал	2016	ӨМНӨД АФРИК	1	-

Монгол Улс нэгдэн орсноос хойш конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт тайлангаа тогтмол ирүүлээгүй. Улс орнууд нь үндэсний хэмжээнд гарч буй ахиц дэвшил, CITES-ын хэрэгжилтийн үзүүлж буй нөлөөг тогтооход чухал үүрэгтэй үндэсний тайланг хоёр жил тутам гаргадаг ч Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газар 2003 оноос хойш Монгол Улсаас 2003-2004, 2015-2016 оны ердөө хоёр тайланг хүлээн авсан. 2005- 2014 оны арван жилийн хугацаанд 5 тайлан ирүүлээгүйгээс гадна ирүүлсэн цөөхөн тайлан нь дэлгэрэнгүй бус, ерөнхий, бүрэн бичигдээгүй, хавсралт болон үнэлгээг (жишээ нь хуулийн орчуулга, хураан авсан зүйлсийн тухай мэдээлэл гэх мэт) нотолгооны хамт ирүүлээгүй байна.<sup>211</sup>

Монгол Улс нь зэрлэг амьтны хууль бус экспортыг хянахад конвенцийн хүрээнд олгогдсон доорх хоёр боломжийг ашиглах нь зүйтэй. Үүнд:

- Экспортод гаргах амьтдын тоо хэмжээ
- Гуравдугаар хавсралтад бүртгэгдсэн амьтны зүйлийн жагсаалт.

209 САЙТИС, Талуудын 17 дугаар хуралдаанд оролцогчдын жагсаалт. (<https://cites.org/sites/default/files/eng/cop/17/FinalCoP17ParticipantList.pdf>).

210 САЙТИС. Талуудын бага хурлуудад оролцогчдын жагсаалт.

211 CITES-Монгол Улсын хоёр жил тутмын тайлангууд <https://cites.org/eng/cms/index.php/component/cp/country/MN/national-reports> хаягаас үзнэ үү.

Экспортод гаргах амьтны бодгалийн тоо хэмжээг тогтоох нь Хавсралт II-т бүртгэлтэй зүйлийн хувьд тухайн орны сайн дурын сонголт бөгөөд Талууд сонгосон зүйлийн CITES-ын экспортын зөвшөөрлийн дээд хэмжээг конвенцийн газарт хүргүүлэн, санал болгодог. CITES-т нэгдэн ороод буй 186 улсын 36 нь өөрийн дотоодын агнах амьтдын тоо хэмжээг нөхөх зорилгоор энэхүү механизмын ашигладаг. Жишээлбэл, Узбекистан улс нэг жилд 6 аргалийн экспортын зөвшөөрлөтэй бол Румын улс чонын экспортын 30 зөвшөөрлөөр хязгаарлагдаж байна.<sup>212</sup>

Гуравдугаар хавсралтад багтсан зүйлүүдийн хувьд II хавсралтын зүйлийн нэгэн адил худалдах, хамгаалах асуудлыг хөндөхдөө Талуудын саналыг авч ашигладаг ба тухайн улсаас жагсаалтад ороогүй зүйлийг экспортод гаргахдаа хэрэгжүүлдэг. Хавсралт III-т багтсан зүйл нь бусад улсад тархаагүй, эсвэл дэлхийн хэмжээнд устах аюулд хүрээгүй, CITES-ийн бусад хавсралтад багтаагүй, экспортын хязгаарлалт хийх нь тухайн улсдаа үр ашигтай байх ёстой. Жишээ нь, конвенцийн хоёрдугаар хавсралтад Энэтхэг улс шар үнэгийг (*Vulpes vulpes*), Пакистан улс янгир ямааг (*Capra sibirica*) оруулсан байдаг ба эдгээр нь Монгол Улсад өргөн тархсан, гэхдээ агнуурын болон худалдааны хязгаарлалттай зүйлүүд юм. Аль ч улс нь хоёрдугаар хавсралтад нэмэлтээр амьтны зүйлийг оруулах хүсэлтийг Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газарт гаргаж болно. Энэ тохиолдолд тухайн зүйлийн худалдааг заавал экспортын зөвшөөрлөөр зохицуулж, тухайн улс, дамжин өнгөрч буй улс болон худалдан авч буй улсын хилээр нэвтрэхэд зөвшөөрөл хэрэгтэй болно.

CITES-ын Удирдан зохицуулах үндэсний зөвлөлийн өдөр тутмын нэг чиг үүрэг бол CITES-ын Хавсралт I болон II-т орсон бүхий л зүйлийн экспорт, импортын зөвшөөрөл олгох үйл ажиллагаа юм. Тухайн нэгжийн бүтэц, нөөц эх үүсвэрийн нөхцөл байдлаас үзвэл үйлчилгээг хүсэлт гаргагчдад үр ашигтай хүргэхэд хүндрэл үүсдэг. Тус зөвлөлийн ажлын ачаалал харьцангуй бага ч (CITES-т нэгдсэнээс хойш Монгол улсын импорт, экспортын зөвшөөрлийн нэгдсэн дүн нь жилд 100-гаас хэтэрч байгаагүй) цаашдын үйл ажиллагаанд зарим нөхцөлүүд шаардлагатай болж байна. Нэгдүгээрт өөрийн байршилд ойр экспортлогч, импортлогчдын зөвшөөрөл авах боломжийг хангах шаардлагатай.

Монгол улсын хувьд энэхүү нөхцлийг хангах нь хууль ёсны буюу зөвшөөрөлтэй худалдааг дэмжихэд ач холбогдолтой. Түүнчлэн зэрлэг амьтдын худалдааны мэдээллийн санд цагдаа, гааль зэрэг хууль сахиулах байгууллагын ажилтнууд нэвтрэх боломжийг байнга хангах шаардлагатай. Одоогоор эдгээр нөхцлийн аль нь ч Монгол улсад бүрдээгүй.

CITES-ын зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь

212 CITES-ын үндэсний шинжээчдийн тоо хэмжээг [https://cites.org/eng/resources/quotas/export\\_quotas](https://cites.org/eng/resources/quotas/export_quotas) хаягаас үзнэ үү.

төвлөрсөн байдлаар хийгдэж буйгаас үүдэн худалдаа эрхлэгчид заавал Улаанбаатар хотод ирэх шаардлага гардаг нь алсад байрлаж буй зарим байгууллага, хүмүүсийн хувьд хүндрэл үүсгэдэг. Монгол улсын 2016 оны CITES-ын тайланд дурдсанаар зөвшөөрөл олгох үйл явц нь өнөөг хүртэл цаасан хэлбэрээр явагдаж буйгаас гааль зэрэг бусад байгууллагатай мэдээлэл солилцох, цахим мэдээллийн удирдлагын систем хангалтгүй.<sup>213</sup> Цахим зөвшөөрлийн системд шилжих тухай төлөвлөгөө гарсан ч энэ талаар тайлан болон онлайн байдлаар дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй.

CITES-ын зүгээс Талуудын ирүүлсэн мэдээллийг ашиглан боловсруулсан зөвшөөрлийн мэдээллийн санг түргэн хугацаанд судлан үзэхэд Монгол Улсаас илгээсэн мэдээллийг цаашид сайжруулах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Мэдээ, баримтын бүрдүүлэлт хангалтгүй эсвэл дутуу (худалдаж буй эд, эрхтэн, нэгж, зориулалт гэх мэт) нь мэдээллийн үнэ зөв байдалд эргэлзээ төрүүлж, Монгол улс дахь CITES-ын худалдааны өнөөгийн дүр зургийг гаргахад хүндрэл учруулж байна.

Хууль сахиулах байгууллагын ажилтнууд зүйлийн хамгааллын түвшин, эх сурвалж, агнуурын улирал болон худалдааны төрөл зэргээс хамааран хэрэглэх хууль, тогтоомж, хураан авсан эд, эрхтэнд тулгуурлан зүйлийг тодорхойлох болон баримт нотолгоог хадгалах талаар ойлголт авахын тулд зэрлэг амьтны худалдааны бодит материалыг авах шаардлагатай байна.

Конвенц нь менежерүүд болон хэрэгжүүлэгчдийн хэрэгцээнд нийцсэн орчин үеийн мэдлэгийн сан болон сургалтын хөтөлбөрийг боловсруулсан байдаг ба үүнд CITES-ын хэрэгжилтийн загвар хууль тогтоомж, зэрлэг амьтныг тодорхойлох гарын авлага, хөтөч, зэрлэг амьтны гэмт хэргийн шинжилгээний аргачлал багтдаг. Идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг CITES-ын Удирдан зохицуулах үндэсний зөвлөл нь эдгээр эх үүсвэрийг ашиглаж, хилийн боомтын ажилтнууд, байгаль хамгаалагчид, цагдаа, шүүхийн системд хүргэх талаар арга хэмжээ авах шаардлагатай.

## CITES-ЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ЗӨВЛӨЛ

CITES-ын конвенцид заасны дагуу Шинжлэх ухааны зөвлөл нь эрсдлийн шинжилгээ буюу хохиролын дүгнэлт (NDFs) гаргах үүргийг хүлээнэ. Энэхүү дүгнэлт нь нэг болон хоёрдугаар хавсралтад багтсан зүйлийн худалдаа нь тухайн зүйл болон экосистемд хохирол учруулахгүй байх тухай шийдвэр юм.<sup>214</sup> Хор хохирлын дүгнэлтийг бичгээр, эсвэл аман хэлбэрээр хийж болно. Конвенц нь хор хохирлын дүгнэлтийн талаар ямар нэгэн зааварчилгаа өгөөгүй ч өмнөх баримт, материалаас үзвэл энэхүү дүгнэлтэд зүйлийн

213 CITES- Монгол Улсын хоёр жил тутмын тайлан, 2016.

214 CITES, III болон IV зүйл. Хавсралт III дээр заагдсан зүйлсийн хувьд эрсдэлийн шинжилгээ хийх шаардлага тавигдахгүй.



тархац, тоо толгойн статус болон хандлага, тулгарч буй аюулын судалгаа зэргийг багтаадаг.

Монгол Улсад CITES-ын Шинжлэх ухааны зөвлөлд ШУА болон бусад ТББ-ын төлөөлөл багтсан. Гэхдээ шинжлэх ухааны зөвлөлөөс хор хохирлын дүгнэлтийг гаргадаг нь тодорхойгүй ба энэ талаар олон нийгэд нээлттэй мэдээлэл байхгүй. Монгол улсын 2015- 2016 оны CITES-ын тайланд дурдсанаар хор хохирлын дүгнэлтийн стандарт байхгүй. <sup>215</sup>CITES-ын Удирдан зохицуулах үндэсний зөвлөлийн тайланд зүйлийн экспортын тоо хэмжээг тусгасан. CITES-ын мэдээллийн санд дурдсанаар Монгол улсын хувьд 2016 болон 2017 онд зүйлийн экспортын тоо хэмжээ харагдахгүй байна.<sup>216</sup>

Зэрлэг амьтны хууль бус худалдааны Монгол улсын CITES-ын тайланд шүүхийн шинжилгээний байгууллагууд бие даан зүйлийг тодорхойлох чадавх муутайг дурджээ. Бусад эх сурвалжаас үзвэл Шинжлэх ухааны зөвлөлийн төлөөлөл болох Биологийн хүрээлэн нь хууль сахиулах байгууллагаас зэрлэг амьтны холбоотой гэмт хэргийг мөрдөн байцаах явцад ирүүлсэн сорьц, дээжид дүгнэлт гаргадаг. Тоймлон авч үзвэл сүүлийн жилүүдэд төрийн багахан төсвөөс шалтгаалан Монгол улс нь Конвенцийн Талуудын бага хуралд оролцох боломжгүй, мөн <sup>217</sup>зэрлэг амьтны тоо толгойн судалгаа дутмаг байдаг нь Шинжлэх ухааны зөвлөлийн зөв шийдвэр гарахад сөргөөр нөлөөлж байна.

## ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГАА

Аймаг, сумын захиргаа нь Монгол Улсын нутаг дэвсгэрт загас болон бусад зэрлэг амьтны агнуурын нөөцийг удирдахад оролцдог чухал талуудын нэг юм. Орон нутгийн захиргаад хуулиар олгогдсон эрхийн хүрээнд зэрлэг амьтны тоо толгойн судалгаа<sup>218</sup>, зэрлэг амьтан хамгаалал<sup>219</sup>, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр БОАЖЯ-тай хамтран ажиллах, мөн Амьтны тухай хуулийн хэрэгжилтийг хангах (тоо хэмжээ болон<sup>220</sup> хориг) зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Монгол улсын хэмжээнд нийт 69 агнуурын бүсийг тогтоосон ба тэдгээрийн удирдлага, хяналт нь орон нутгийн түвшинд хэрэгжиж байна.<sup>221</sup>

Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд олгосон агнах зөвшөөрлийн тоо хэмжээнд нийцүүлэн агнуурын

215 CITES- Монгол Улсын хоёр жил тутмын тайлан, 2016.

216 CITES-ын үндэсний шинжээчдийн тухай [https://cites.org/eng/resources/quotas/export\\_quotas](https://cites.org/eng/resources/quotas/export_quotas) хаягаас үзнэ үү.

217 Монгол Улс нь САЙТИС-ын гишүүн байсан 20 жилийн хугацаанд Монгол улсын САЙТИС-ын Шинжлэх ухааны байгууллагын төлөөлөл 2007 онд болсон Талуудын 14 дүгээр уулзалтад л ганцхан удаа оролцсон байна.

218 Амьтны тухай хууль, 5.5.3, 2012.

219 Амьтны тухай хууль, 6.1.3 болон 6.1.7, 2012.

220 Амьтны тухай хууль, 26, 2012.

221 Гол оролцогч талтай хийсэн ярилцлага (БОАЖЯ)

зөвшөөрөл олгох эрхийг сум эдэлдэг. Амьтны тухай хуулийн 2012 оны нэмэлт өөрчлөлтөөр агнуурын зөвшөөрөл, трофи ангийн орлого нь улсын төсөвт бус харин сумын төсөвт шууд ордог.<sup>222</sup> Энэхүү механизм нь орон нутгийн захиргаад зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд түлхэц болж, орон нутаг ч мөн өөрийн нөөцийг хадгалан үлдээх илүү сонирхолтой болжээ.

## ХЭРЭГЖҮҮЛЭГЧИД

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хамтын хариуцлага бөгөөд үүнд нийт төрийн найман байгууллага чиг үүргийн дагуу оролцдог. Үйл ажиллагааны давхардал нь заримдаа тохиолдох ч менежментийн чиглэлийн байгууллагуудаас илүү тодорхой чиг үүргийг хэрэгжүүлнэ. Эдгээр хэрэгжүүлэгч байгууллагуудад олгосон эрхийг Хүснэгт 5-д тоймлон харуулав. Харьцуулалт хийх зорилгоор агентлагуудад хуулиар олгосон эрх мэдлийг гурван үндсэн төрөлд хуваан үзлээ. Үүнд: 1) баривчлан саатуулах; 2) үзлэг, нэгжлэг хийх, эд зүйлс хураан авах болон 3) мөрдөн шалгах болон гүйцэтгэх эрх мэдлүүд гэх мэт.

**Баривчлах, саатуулах** нь хууль сахиулах ажилтнууд орон нутагт зөрчил илрүүлсэн тохиолдолд хэрэгжүүлдэг. Зураг 5-д харуулсанчлан жагсаалтад багтсан бараг бүхий байгууллага энэ эрхийг эдэлдэг. Харин сумын байгаль хамгаалагч, гаалийн байцаагчдад энэ эрх хамаарахгүй.

- Сумын байгаль хамгаалагчдын хувьд Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар энэхүү эрхийн эдлэхийг шууд хориглосон ч өөр бусад хуулиар эрх олгосон тохиолдол байж болно.<sup>223</sup> Тухайн эрхийг сумын байгаль хамгаалагчдад олгоогүй тул хяналт шалгалт хийж, баривчлах, саатуулах эрхгүй. Эрүүгийн гэмт үйлдлийг олж тогтоох анхдагч үйлдэл болох хянан шалгах ойлголтыг “Нэгжлэг”-тэй хольж ойлгож болохгүй. Хяналт шалгалт нь эрүүгийн гэмт хэргийн үйлдлийг олж илрүүлэхийн өмнөх ажиглалтыг хэлнэ. Үүнийг ердийн үйл ажиллагааны хүрээнд (гаалийн шалгалт), эсвэл хууль бус үйлдлийн талаар ямар нэг сэжиг буй тохиолдолд (жишээ нь байгаль хамгаалагч анчдыг зогсоон баримт бичгийг нь шалгах) гүйцэтгэнэ.
- Үйл ажиллагааг саатуулан зогсоох сумын байцаагчийн эрх нь тэдний хяналт шалгалтын эрхийн нэгэн адил хязгаарлагдмал юм.
- Гаалийн байцаагчдын хувьд зөвхөн бараа, бүтээгдэхүүнд анхан шатны үзлэг хийснээр тэдний эрх хязгаарлагдана. Тухайн бараа, баримт бичиг эсвэл үйлдэл нь сэжигтэй буй бол тухайн асуудлыг гаалийн мэргэжлийн хяналтын албаны мэдэлд шилжүүлнэ.

222 Гол оролцогч талтай хийсэн ярилцлага (БОАЖЯ)

223 Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 28.1(2).

Хууль сахиулах эрх мэдлийн хоёр дахь багц болох **нэгжлэг хийх, эд зүйлс хураан авах** эрхийг зөрчил гарсан газар дээр хэрэгжүүлж болно. Зөрчил гаргасан сэжиг бүхий, гэхдээ албан ёсоор сэжигтнээр татаагүй тохиолдолд үзлэг хийх болон эд зүйлс хураан авах боломжтой. Тухайн холбогдогчийг саатуулсны дараа мөрдөн байцаалт үргэлжилнэ. Монгол Улс дахь хууль сахиулах ихэнх байгууллагын албан хаагчид үзлэг нэгжлэг хийх болон эд зүйлс хураан авах эрхтэй ч эрхийн хэмжээ нь ижил бус, бүх нөхцөлд тухайн эрхийг эдлэхгүй. Үзлэг нэгжлэг хийх, эд зүйлс хураан авахад дараах хязгаарлалтууд тулгардаг. Үүнд:

- о **Сумын байгаль хамгаалагч нарт тулгарч буй хязгаарлалтууд.** Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасанчлан сумын байгаль хамгаалагч нь бусад хуульд шууд зааснаас бусад тохиолдолд нэгжлэг хийх, эд зүйлс хураан авах эрхгүй. Энэхүү эрхийг тусгайлан олгосон цорын ганц хууль нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль бөгөөд тухайн эрхийг тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагч нар эдлэдэг.

авах эрх шууд заагдаагүй.<sup>224</sup>Гэхдээ хяналт шалгалтаас зайлсхийхийг оролдсон үед албадан зогсоох эрхтэй.<sup>225</sup>Хяналт шалгалтын үйл ажиллагаа дуусахад гаалийн байцаагч нь цаашид мөрдөн шалгалт хийх зорилгоор тээврийн хэрэгслийг саатуулах боломжтой эсэх нь тодорхойгүй. Авто машин, тээврийн хэрэгсэл хураан авах эрхийг мөн МХЕГ, улсын байцаагчид эдлэх ч хуульд зааснаар сэжигтэн этгээд зөрчил гаргасан тохиолдолд л энэхүү эрх хэрэгжинэ. Энэ эрх нь мөн сумын болон тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчдад олгогдоогүй.

Дараагийн багц эрх бол **мөрдөн шалгах болон гүйцэтгэх эрх мэдэл** юм. Энэхүү багц эрх нь хуулиар 1). хяналт шалгалт хийсний үндсэн дээр гэмт хэргийг цааш мөрдөн шалгах, эсвэл 2). албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр олгосон эрх мэдлийг хэлнэ.

- о **Баривчлан саатуулах, мөрдөн байцаах.** Гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулах бүрэн эрхийг эдлэх байгууллага бол цагдаа болон тагнуул юм. Хууль сахиулах үүрэг бүхий бусад байгууллагууд нь тодорхой түвшинд хяналт шалгалтын арга хэмжээг авах ч тухайн

Зураг 6. Зэрлэг амьтны чиглэлийн хууль тогтоомж хэрэгжүүлэх байгууллагууд, эрх мэдэл

	ИЛРҮҮЛЭХ, СААТУУЛАХ			НЭГЖЛЭГ ХИЙХ, ХУРААН АВАХ				МӨРДӨН БАЙЦААХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ					
	Таслан зогсоох	Байцаах	Шалгах	Үйл ажиллагааг саатуулах	Нэгжих	Тоног төхөөрөмж хураах	Эд хөрөнгө хураах	Автомашин хураах	Хөрөнгө, барилга байшин хураах	Баривчлан саатуулах	Мөрдөн байцаах	Торгууль ноогдуулах	Зөвшөөрөл хүчингүй болгох
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ХЭЛТЭС- ажилтнууд	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
МХЕГ- байцаагч	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
АЙМАГ- байцаагч	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
СУМ- байгаль хамгаалагч	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
ТХГ- байгаль хамгаалагч	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
ГААЛЬ- байцаагч	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
Тагнуулын ерөнхий газар	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■
ХИЛИЙН АЛБА	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■

■ Бүрэн эрх      ■ Хязгаартай, бусадтай хуваасан эрх      ■ Эрхгүй

- о **Автомашин, тээврийн хэрэгсэл хураан авах.** Энэхүү эрхийг үндсэндээ цагдаагийн ажилтан эдэлдэг. Гаалийн байгууллагын хувьд автомашин, тээврийн хэрэгсэл хураан

224 Гаалийн тухай хууль 276.1.5 дээр баримт бичиг, бүртгэлийг түр хугацаагаар хураан авахаар заасан. Автомашин хураах талаар энэхүү болон бусад зүйл дээр заагдаагүй.

225 Гаалийн тухай хууль. 280.2.

сэжигтэй тохиолдлыг цагдаагийн, эсвэл тагнуулын байгууллагад албан ёсны мөрдөн байцаалтад шилжүүлэх үүрэгтэй. Ярилцлагад оролцсон олон хүний хэлснээр хяналт, мөрдөн байцаах эрхийг (баривчлан саатуулах эрхийг мөн) салгасан нь тэргүүн шугамд ажилладаг хууль сахиулах ажилтнуудын (гааль болон байгаль хамгаалагч) үйл ажиллагаанд муугаар нөлөөлж, зарим тохиолдолд эргэн засах боломжгүй нөхцөлд хүргэж буй ажээ.

**о Түгээлт, тээвэрлэлтэд хяналт тавих.**

Графикт тусад нь харуулаагүй ч ач холбогдол бүхий мөрдөн байцаалтын нэг арга зам бол “Түгээлт, тээвэрлэлт хянах” (хяналттай хүргүүлэх) юм (Бүлэг 3-ийг үзнэ үү). Гаалийн байгууллага нь мөрдөн байцаалт явуулах эрхгүй ч бүтээгдэхүүний түгээлт, тээвэрлэлтийг хянах шууд эрх бүхий байгууллагын нэг юм. Тодруулан хэлбэл хуульд “Гаалийн байгууллагаас олон улсын гэрээний, эсвэл бусад улсын гааль болон эрх бүхий байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэнд Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хязгаарлалт тогтоосон барааны хууль бус эргэлтийг таслан зогсоох, оролцогч этгээдийг илрүүлэх зорилгоор уг барааг гаалийн хяналтын доор хүргэж болно” хэмээн заажээ.<sup>226</sup> Мөрдөн шалгах энэхүү арга техникийг ашиглах тусгайлсан хэм хэмжээг тусдаа хуулиар тогтооно гэсэн ч энэхүү хууль нь батлагдаагүй. Мөрдөн байцаалтын бусад хэм хэмжээнд зааснаар хууль сахиулах бусад байгууллагын хувьд тухайн хэргийг мөрдөн байцаах эрх бүхий байгууллагад шилжүүлэх үүрэг хүлээдэг.

**о Зэвсэг хэрэгсэл авч явах, ашиглах.** Хуулийн хэрэгжилтийн хангах чиг үүрэг бүхий найман байгууллагын төлөөлөл бүгд зэвсэг ашиглах эрхтэй. Эдгээр байгууллагын хоёр нь л хуулийн хэрэгжилт хангуулах зорилгоор зэвсэг хэрэглэх эрхтэй. Үүнд, автомашин зугтах оролдлого хийх, зөрчил гаргасан этгээд хүч хэрэглэж, байцаагчийн аюулгүй байдалд заналхийлэх тохиолдолд МХЕГ-ын улсын байцаагч нар зэвсэг хэрэглэж болно. Бусад байгууллагын ажилтнууд зөвхөн өөрийгөө хамгаалах хязгаарлагдмал нөхцөл байдал үүссэн тохиолдолд л зэвсэг хэрэглэнэ.

Хууль сахиулах үүрэг бүхий байгууллага нэг бүрийн талаар дараагийн хэсгүүдэд дэлгэрэнгүй танилцуулав.

## УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар нь Засгийн газрын Шадар сайдын хариуцах асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Тус газарт зэрлэг

226 Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль. 252.1.

амьтны худалдаатай холбоо бүхий хоёр нэгж ажилладаг нь Байгаль орчны болон Гаалийн хяналтын алба юм.

БОАЖЯ-наас МХЕГ-ын байцаагчдад олгосон хяналт шалгалтын эрх нь гурван төрлийн тусгай зөвшөөрөлд хамаардаг ба дараах хоёр нь зэрлэг амьтны худалдаанд хамааралтай. Үүнд: i). хүнс, хүнсний үйлдвэрлэлийн гэрчилгээ; ii). хувь хүнд олгох зэрлэг амьтны холбогдолтой гэрчилгээ, зөвшөөрөл болон iii). тусгай зориулалтын ангийн зөвшөөрөл (жишээ нь трофи ан агнуур болон гадаадын иргэдэд олгох ангийн зөвшөөрөл). Энэхүү үүргээ гүйцэтгэхийн тулд Байгаль орчны хяналтын алба нь улс орон даяар үйл ажиллагаа явуулж буй бүх байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагчдын дотоодын ан агнуур, загасчлал, зэрлэг амьтан тээвэрлэх болон худалдаалах үйл ажиллагааны чиглэлийг хянан<sup>227</sup> удирддаг.

Тус албаны даргын хэлснээр нийт байгаль хамгаалагчдын тоо нь одоогоор 669 (хүснэгт 7) буйгаас 71 нь улсын хэмжээнд, аймаг бүрт 4, (нийт 84), сумдад 352, үлдэх 162 нь тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж байна.<sup>228</sup> Байгаль хамгаалагчид нь МХЕГ-ын үйл ажиллагааны цөм хэсэг ч тэднийг ажилд шалгаруулан авах болон цалин хөлсийг нь орон нутгийн захиргаа хариуцдаг. Аймгийн ЗДТГ нь байгаль хамгаалагч ажилд авах, цалин хөлс, тоног төхөөрөмжөөр хангах, үйл ажиллагааны зардлыг гаргах үүргийг хүлээнэ.

Хүснэгт 7. Монгол Улсын нийт байгаль хамгаалагчид (түвшнээр, 2016)

2016	
Байгаль хамгаалагчид	
Байгаль хамгаалагчдын тоо	Үйл ажиллагааны түвшин
71	Үндэсний хэмжээнд
84	Аймгийн түвшинд
352	Сумын түвшинд
162	ТХГ-удад
669	<b>НИЙТ БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧДЫН ТОО</b>

227 Байгаль орчны байцаагч болон байгаль хамгаалагч хэмээх үгсийг зөв хэрэглэдэггүй ч эдгээр нь өөр өөр байршилд ажилладаг нэг ижил албан тушаалтныг хэлнэ. Жишээ нь, байгаль хамгаалагчийн эрх, үүргийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан ба арай өөрөөр нэрлэх Байгаль орны байцаагчтай нэгэн ижил эрх эдэлнэ.

228 Байгаль хамгаалагчид нь 107 тусгай хамгаалалттай газруудад ажилладаггүй. Зөвхөн эхний хоёр ангиллын (дархан цаазтай газар, Байгалийн нөөц газар) хамгаалалттай газар нь үндэсний хэмжээнд томилогдсон байгаль хамгаалагчтай.

МХЕГ-ын Гаалийн хяналтын алба нь CITES-ын зөвшөөрөл, худалдааны асуудлаар гаалийн байгууллагатай ажилладаг нэгж юм. Тус албаны байцаагчид хилийн боомтын байранд байрлан ажиллаж, гаалийн албан хаагчид анхдагч үзлэг хийсний дараа худалдаалж буй бараа, бүтээгдэхүүн нь хууль ёсны болохыг баталгаажуулдаг. Өөрөөр хэлбэл, хилийн мэргэжлийн хяналтын байцаагчид тухайн зөвшөөрөл нь хууль ёсны эсэх, худалдаалж буй зүйлийн тоо хэмжээ нь олгосон зөвшөөрөлтэй нийцэж буй эсэхийг батлах замаар хоёр дахь шалгалтыг хилийн бүсэд хийдэг. Одоо ашиглаж буй цаасан баримтад суурилсан зөвшөөрөл олгох систем болон зөвшөөрлийг баталгаажуулахад гаалийн байцаагчийн ашиглаж буй CITES-ын төвлөрсөн цахим мэдээллийн сан хангалтгүй нь хуурамч, эсвэл засварласан зөвшөөрлийг илрүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн тухайн ажилтнууд нь мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах бүрэн эрхгүй тул тухайн этгээдийн үйлдэл, тээвэрлэж буй бүтээгдэхүүн, эсвэл зөвшөөрөл нь сэжигтэй, хууль бус байгаа нь тогтоогдвол тухайн хэрэгт арга хэмжээ авахуулах зорилгоор цагдаагийн байгууллагад шилжүүлэхээс өөр сонголтгүй.

Энэхүү судалгааны хүрээнд МХЕГ-ын байцаагч нарын хууль сахиулах үйл ажиллагааны талаар тоо, баримтад үнэлгээ хийх боломжгүй.

Судалгааны баг МХЕГ-ын байранд 2016 оны 6 дугаар сард ажиллах үеэр тус байгууллагын хураасан уламжлалт эмийн бүтээгдэхүүн бүхий дээжийг зураг 4 үзүүлэв.

Зураг 4. МХЕГ-ын хураан авсан уламжлалт эмийн бүтээгдэхүүн



## АЙМГУУД ДАХЬ УЛСЫН БАЙЦААГЧ НАР

Аймгийн түвшинд Улсын ахлах байцаагч болон улсын байцаагч нь цагдаагийн байгууллагад үл хамаарах, хамгийн өндөр эрх мэдэл бүхий ажилтнууд юм. Эдгээр байцаагчид нь МХЕГ-ын ажилтнууд ч орон нутгаас санхүүждэг. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заагдсан байцаагч бүрийн эрх, үүрэг

нь ижил. Байцаагч нар хэрэгжүүлэх эрхийн хүрээнд хууль бус үйл ажиллагааг саатуулах, зогсоох, иргэний баримт бичгийг шалгах, авто тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, хураан авч саатуулах, мөн хууль бус эд хөрөнгө, зэвсэг, тоног төхөөрөмж, багаж зэргийг хураан авах үүргийг хүлээнэ. Өөр нэгэн томоохон эрх нь барилга байгууламж хураан авах эрх бөгөөд энэ нь тухайн шатны улсын байцаагч нарт олгогдсон өвөрмөц эрх байдаг. Байцаагчдын гүйцэтгэдэг хяналт, шалгалтын ажлын хувьд тэдний эдлэх эрх нь аж ахуйн нэгж, байгууллагуудад нэвтрэх эрх багтах ч хувийн орон сууцанд саадгүй нэвтрэх боломжгүй. Нөгөө талаар, байцаагчид бусдыг саатуулах эрхтэй ч мөрдөн байцаалт явуулах эрхгүй. Шаардлагатай тохиолдолд зэвсэг ашиглах эрх хязгаартай, тавьсан шаардлагыг биелүүлэхээс “Сэжигтэн илтээр татгалзах” тохиолдолд, эсвэл байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагчийн амь насанд аюул учруулсан нөхцөл үүссэн тохиолдолд л бие хамгаалах зорилгоор ашиглаж болно.<sup>229</sup>

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд<sup>230</sup> уг хуулийн хэрэгжилтийг хангах зорилготой хэд хэдэн эрхийг заажээ. Эдгээрийн зарим нь харилцан хамааралтай ба хуульд хамтад нь заагаагүй дараах гурван төрлийн эрх байдаг. Үүнд: 1). илрүүлэх, саатуулах, 2). нэгжлэг хийх, хураан авах болон 3). мөрдөн байцаах болон гүйцэтгэх гэх зэрэг болно.

Илрүүлэх, саатуулах эрх

- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас хянаж шалгахад шаардлагатай мэдээлэл авах<sup>231</sup>
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг саатуулах<sup>232</sup>
- Иргэний баримт бичиг шалгах<sup>233</sup>

Үзлэг, нэгжлэг хийх, хураан авах

- Аж ахуйн нэгж, байгууллагуудын байранд нэвтрэх, хяналт хийх<sup>234</sup>
- Сорьц дээж авах болон шинжлүүлэх<sup>235</sup>
- Автомашин, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх<sup>236</sup>
- Иргэний баримт бичиг, хууль бус эд хөрөнгө, зэвсэг, тоног төхөөрөмж, байгууламж болон багаж хэрэгслийг хураан авах<sup>237</sup>
- Авто машин, тээврийн хэрэгсэл хураан авч саатуулах<sup>238</sup>

Мөрдөн байцаах, гүйцэтгэх

- Лиценз, тусгай зөвшөөрөл эрх цуцлуулах

229 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 29.2(1).

230 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль. 31.2.

231 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 27.1(2).

232 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 27.1(3).

233 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 27.1(6).

234 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 27.1(4).

235 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 27.1(4).

236 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 27.1(6).

237 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 27.1(6).

238 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 27.1(9).

санал гаргах<sup>239</sup>

- Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн албан ёсны шийдвэрийг цуцлуулах, хүчингүй болгохыг шаардах, санал гаргах<sup>240</sup>
- Учруулсан хохирлыг барагдуулахыг шаардах<sup>241</sup>
- Захиргааны хариуцлага тооцох<sup>242</sup>
- Албан үүргээ гүйцэтгэж явахдаа зэвсэг, хэрэгсэл авч явах<sup>243</sup>

Дээр дурдсан эрхүүдийн хүрээнд зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх чиглэлээр Дорнод аймгийн ЗДТГ нь Хятад руу гардаг хууль бус худалдааны гол цэг болох аймгийн төвийн зүүн хэсэгт байх Хэрлэн гол дээр гүүр дээр хяналтын гурван пост ажиллуулж байна. Өвлийн улиралд гол хөлдсөн үед хууль бус бараа тээвэрлэгчид хяналтын цэгээс зайлсхийн голын мөсөн дээгүүр гарч, Хятад руу явдаг. Зураг 5-г хяналтын цэгийн барилга, гараар бичсэн зааварчилгаа болон тээвэрлэлтэд хяналт хийдэг аргачлалыг харуулав.<sup>244</sup>

**Зураг 5. Дорнод аймгийн ЗДТГ-ын байгуулсан зэрлэг амьтны худалдаатай тэмцэх хяналтын цэг**



## СУМЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ НАР

Сумын байгаль хамгаалагч нь хууль тогтоомж хэрэгжүүлэх тодорхой эрх бүхий дараагийн шатны албан хаагч юм. Байгаль хамгаалагчид нь сумын түвшинд ажиллаж, зэрлэг амьтны хууль бус агнуур,

239 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 27.1(10).

240 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 27.1(11).

241 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 27.1(3).

242 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 27.1(7).

243 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 29.1(3).

244 #1 Зах зээлийн асуумж – Ажиглалтын хуудас #804- 2016 оны 11 сарын 4.

худалдаатай тэмцэх эргүүл, хяналтын арга хэмжээг хэрэгжүүлдэг. Гэхдээ тэдний эдэлж буй эрх нь үндсэндээ хуулиар тусгайлан өөрөөр заагаагүй бол шалгалт хийх эрхээр хязгаарлагддаг. Ялангуяа байгаль хамгаалагч нь хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, аж ахуйн нэгж байгууллагуудад нэвтрэх, дээж сорьц авч, шинжилгээ хийх эрх эдэлнэ. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасны дагуу<sup>245</sup> сумын байгаль хамгаалагч нь дараах эрхийг мөн эдэлнэ. Үүнд:

Илрүүлэх, саатуулах

- Хуулийн биелэлтийн шалгах<sup>246</sup>
- Хяналт шалгалт хийхээр аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох<sup>247</sup>
- Сорьц, дээж авах, өөрийн хяналтад шинжлүүлэх<sup>248</sup>

Мөрдөн байцаах, гүйцэтгэх

- Албан үүргээ гүйцэтгэж явахдаа зэвсэг хэрэгсэл авч явах<sup>249</sup>.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу мөрдөн байцаах, үйл ажиллагааг саатуулах, нэгжлэг хийх болон хураан авах талаар 27.1(6) болон (7) зүйл дээр заасан эрх нь тэдний хэрэгжүүлэх эрхэд хамаарна.<sup>250</sup> Эдгээр нэмэлт эрхийн тоонд торгууль ноогдуулах болон бичиг баримт шалгах, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, хууль бус эд зүйлс, зэвсэг, хэрэгсэл, тоног төхөөрөмж, байгууламж, багаж зэргийг хураах үйл ажиллагаа багтдаг. Тодорхой бус шалтгааны улмаас хуульд тухайн эрхийг бусад хуулиар олгож болно хэмээн заасан. Тухайн эрх олгогдсон эсэхээс үл хамааран амьдрал дээр сумын байгаль хамгаалагч эдгээрийг хэрэгжүүлэх боломжгүй. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиас өөр бусад хууль тогтоомжоор энэхүү эрхийг байгаль хамгаалагч нарт олгоогүй.

Байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч нарт бусдыг баривчлан саатуулах болон мөрдөн шалгах боломжгүй. Улсын байцаагч нарын нэгэн адил зэвсэг хэрэглэх боломж нь зөвхөн өөрийгөө хамгаалахаар хязгаарлагдсан ба “Сэжигтэн шаардлагыг нь даган мөрдөхөөс илт татгалзах” тохиолдолд байцаагч..., эсвэл байгаль хамгаалагчийн амь насанд ямар нэгэн байдлаар аюул учруулахаар ямар нэгэн зэвсэг хэрэглэх тохиолдолд” л зэвсэг хэрэглэж болох ажээ.<sup>251</sup>

245 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 28.1(1) болон (2).

246 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 28.1(1), зүйл 27.1(1) дээрхийг заасан.

247 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 28.1(1), зүйл 27.1(4) дээрхийг заасан.

248 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 28.1(1), зүйл 27.1(4) дээрхийг заасан.

249 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 29.1(3).

250 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 28.1(2).

251 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 29.2(1).

Эрх мэдэлгүй, биет болон санхүүгийн дэмжлэг дутмаг нөхцөлд сумын байгаль хамгаалагчдын газар дээрх бодит байдал маш хүнд. Тухайлбал, байгаль хамгаалагч н.Бямбасүрэн нь Чандмань-Өндөр сумын 1 болон 2 дугаар багийг хариуцсан байгаль хамгаалагчаар 17 жил ажиллаж байна. Түүний хэлснээр зэрлэг амьтан бараг үгүй болсны улмаас сүүлийн жилүүдэд ой хамгаалах чиглэлд л түлхүү анхаарч байна. Тэрээр сүүлийн жилүүдэд ямар нэгэн хамгаалах хэрэгсэл, тусгай хувцас огт аваагүй. Түүний өөрийгөө хамгаалах цорын ганц зүйл нь Зураг 6 дээр харуулсан цагдаагийн борооной, албаны үнэмлэх хоёр л байна.

**Зураг 6. Цагдаагийн борооной болон албаны үнэмлэх бүхий сумын байгаль хамгаалагч**



Орон нутгийн түвшинд сайн дурын байгаль хамгаалагчид нь өөрсдөө бие дааж, эсвэл байгаль хамгаалагчтай хамтран ажиллах замаар шаардлагатай ажлын ихэнхийг гүйцэтгэж байна. Жишээлбэл, Төв аймгийн байгаль хамгаалагч н. Эрдэнэбаяр нь нутгийн иргэдээс сайн дурын 6 хүний бүрэлдэхүүнтэй багийг үүсгэж, тэд шатахууны хангалт хязгаартай нөхцөлд хамтдаа сумын хэмжээнд мотоциклоор эргүүл хийж байна.<sup>252</sup> Зураг 7-т судалгааны багийн гишүүн Баянхонгор аймгийн сайн дурын байгаль хамгаалагч нарын зургийг харуулав. Тэрээр хэлэхдээ нутгийн бусад иргэдийн адил зэрлэг амьтныг хамгаалахад хувь нэмэр оруулах хүсэлтэй ажээ. Албан ёсны нөөц эх үүсвэр, эсвэл тоног төхөөрөмжгүй тэрбээр жуулчид, аялагчдын байгаа газруудад мониторинг хийж, мөн чонын тоо толгойтой хамаарах асуудлаар нутгийн удирдлагад дэмжлэг үзүүлдэг. Түүний хэлснээр тэрээр БОАЖЯ-наас “Байгаль орчны тэргүүний ажилтан”<sup>253</sup> цолоор шагнуулсан нь эрх баригчдын зүгээс орон нутгийн сайн дурынхны ач холбогдлыг үнэлж буй хэрэг юм.

**Зураг 7. Баянхонгор аймаг дахь сайн дурын байгаль хамгаалагч (зүүн) болон судалгааны багийн гишүүн.**



## ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ НАР

Монгол Улс дахь тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчид нь Дархан цаазтай газар болон Байгалийн цогцолбор газарт буй зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд тэргүүн эгнээнд ажилладаг. Хуулийн дагуу тэдгээр байгаль хамгаалагчид нь “Байгаль орчны улсын байцаагчийн”<sup>254</sup> ижил статустай, бүтцийн хувьд МХЕГ-ын Байгаль орчны хяналтын албанд харьяалагдахын зэрэгцээ БОАЖЯ-ны удирдлага дахь тусгай хамгаалалттай газруудад үүргээ гүйцэтгэдэг. Бусад байгаль хамгаалагчдаас ялгаатай нь Амьтны тухай хуулиар эдгээр байгаль хамгаалагчдад тусгайлан хууль бус үйл ажиллагааг саатуулах, зогсоох, шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, хууль бус эд хөрөнгө, зэвсэг, хэрэгслийг хураан авах эрх олгосон. Тэд мөн тушаал өгөх, шаардлага тавих, зааварчлах эрхтэй ч хуульд эдгээрийг нарийн заагаагүй. Гэвч тэд баривчлах, тээврийн хэрэгсэл хураан саатуулах, мөрдөн байцаах эрхгүй. Улсын байцаагч нарын эдэлж буй эрхээс ялгаатай нь тэдний зэвсэг хэрэглэх боломж нь зөвхөн өөрийгөө хамгаалахаар хязгаарлагддаг.<sup>255</sup>

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар<sup>256</sup> тухайн газруудын байгаль хамгаалагчдад дараах эрхийг олгожээ. Үүнд:

Илрүүлэн тогтоох болон саатуулах эрх

- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох<sup>257</sup>
- Сэжигтэй зүйлсийн баримт бичгийг шалгах,

252 #2 – Өрхийн асуумж – 2016 оны 5 сар. Аймаг: Төв аймгийн Сэргэлэн сум.

253 #1 – Өрхийн асуумж – 2016 оны 5 сар. Аймаг: Баянхонгор.

254 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль. 31.1.

255 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль. 32.

256 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль. 31.2.

257 Мөн тэнд. 31.2(4).

хураан авах<sup>258</sup>

- Иргэний бичиг баримт, зэвсэг, багаж хэрэгсэл болон хууль бус эд хөрөнгийг хураах<sup>259</sup>

Нэгжлэг хийх, эд зүйлс хураан авах

- Автомашин, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх<sup>260</sup>
- Аж ахуйн нэгж, байгууллагуудад нэвтрэн орох, шалгалт хийх<sup>261</sup>

Мөрдөн байцаалт явуулах, гүйцэтгэх

- Ажил үүргээ гүйцэтгэж явахдаа зэвсэг хэрэгсэл авч явах<sup>262</sup>
- Торгууль ноогдуулах<sup>263</sup>
- Тушаал, зааварчилгаа өгөх, шаардлага тавих<sup>264</sup>

## ХУУЛЬ БУС АГНУУРТАЙ ТЭМЦЭХ ЯВУУЛЫН НЭГЖ

Ховордлын зэрэглэлтэй амьтны зүйлийг хууль бусаар агнах нь нэмэгдсэнтэй холбоотойгоор Монгол Улсад авч хэрэгжүүлсэн өөр нэгэн арга зам нь Монгол Улсын баруун, зүүн, төв бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй Хууль бус агнууртай тэмцэх явуулын нэгжийг байгуулсан явдал юм. Энэхүү явуулын нэгжид гааль, МХЕГ, цагдаагийн байгууллагын төлөөлөл орж, байгаль хамгаалагчидтай хамтран зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцдэг.

Хууль бус агнууртай тэмцэх явуулын нэгж нь зэрлэг амьтны хамааралтай гэмт хэрэгтэй тэмцэхэд гарч буй хийдлийг багасгах, хууль сахиулах байгууллагууд хоорондын байнгын, үр дүнтэй харилцааг хөгжүүлэх, мэдээлэл солилцоход үүсэж буй хүндрэлийг шийдэх зорилгоор байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байна.<sup>265</sup> Бодит амьдралд сумын, эсвэл тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагч дангаар ажиллах үед тулгарах асуудлуудыг хамтран шийдэж өгдөг.

Хууль сахиулах бүх байгууллагын ажилтнуудыг нэг бүлэг болгон ажиллуулах нь эдгээр байгууллага хоорондын мэдээлэл солилцоо нэмэгдэхэд нөлөөтэй. Явуулын нэгж нь хууль бус агнуур, ангийн худалдааны хэргийг илрүүлэх тохиолдолд холбогдогчийг саатуулах, үзлэг хийх, зэвсэг хэрэгсэл, эд зүйлс болон авто тээврийн хэрэгслийг хураан авах, хорьж саатуулах, мөрөн байцаалт явуулах бүхий л эрхийг нэг доор эдэлдэг.

Монгол Улсад явуулын анхны нэгжийг ДБХС-гийн дэмжлэгтэйгээр 2001 онд байгуулжээ. Үйл ажиллагаа явуулсан эхний 10 жилийн хугацаанд

258 Мөн тэнд. 31.2(3).

259 Мөн тэнд. 31.2(3).

260 Мөн тэнд. 31.2(3).

261 Мөн тэнд. 31.2(2).

262 Мөн тэнд. 31.2(5).

263 Мөн тэнд. 31.2(1).

264 Мөн тэнд. 31.2(4).

265 Гол оролцогч талтай хийсэн ярилцлага (ДБХС).

тодорхой амжилтад хүрсний дараа тухайн нэгжийн үйл ажиллагааг цааш үргэлжлүүлэх чиг үүргийг 2010 онд Засгийн газарт албан ёсоор шилжүүлсэн.<sup>266</sup> Гэхдээ 2012 оноос төрийн санхүүжилт багассаны улмаас нэгжийн үйл ажиллагааг бусад эх үүсвэр, хувийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх шаардлага үүссэн. Тэр үеэс хойш явуулын нэгжийн үйл ажиллагааг уул уурхайн Оюу Толгой компани санхүүжүүлж, сургалтыг Байгаль, Зэрлэг Амьтан Хамгаалах Нийгэмлэгээс хангах болжээ.<sup>267</sup> Эдгээр байгууллага нь тул хамгаалах зэрэг байгаль хамгааллын бусад үйл ажиллагааг гүйцэтгэсэн түүхтэй, нийтэд танигдсан юм. Хэдийгээр явуулын нэгжүүд тодорхой амжилтад хүрсэн ч төрөөс хэрэгжүүлж буй байнгын үйл ажиллагаатай холбох чиглэл суларснаас цаашид үргэлжлүүлэн үйл ажиллагаа гүйцэтгэхэд зарим хүндрэлтэй асуудлууд тулгарах боллоо.

## ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ХЭЛТЭС

Хууль зүй, Дотоод Хэргийн Яамны харьяанд үйл ажиллагаа явуулдаг Цагдаагийн байгууллага нь Монгол Улсад үйлдэгдэж буй гэмт хэргийг (зэрлэг амьтны хууль бус агнуур болон худалдаа) мөрдөн шалгах, хуулийн хэрэгжилтийн хангах чиг үүрэгтэй. Цагдаагийн байгууллага нь 2010 онд Байгаль Орчны Гэмт Хэрэгтэй Тэмцэх Хэлтэс байгуулсан нь анхдугаар “Зэлүүд тал” тайлан гарснаас хойш Монгол Улсад зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх чиглэлээр гарсан эерэг өөрчлөлтүүдийн нэг юм. Энэ хэлтэс нь байгаль орчны эсрэг гэмт хэргийг дагнан хариуцаж, энэхүү тусгайлан гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай мэдлэг, туршлагыг хуримтлуулах боломжийг хангадаг. Хэдий тус хэлтсийн анхаарал өнөөгийн байдлаар уул уурхайн холбоотой хэргүүд дээр төвлөрч буй ч тэдний шалгаж буй хэргийн 15% нь зэрлэг амьтны хууль бус ан, худалдааны хэргүүд эзэлдэг.<sup>268</sup>

Тус хэлтсийн ажилтнууд нь хууль сахиулах чиг үүрэг бүхий ажилтнууд болон прокурорын байгууллага хоорондын чухал цэгт үндсэн үүргээ гүйцэтгэж байна. Байгаль хамгаалагч, МХЕГ, ГЕГ, ТЕГ, хилийн албанаас зэрлэг амьтны гаралтай хууль бус бүтээгдэхүүн илрүүлж, цаашид мөрдөн байцаах шаардлага үүссэнээр тус хэлтсийн ажилтнуудын оролцоо эхэлдэг. Цагдаагийн байгууллага нь хууль бус агнуур, худалдааны мөрдөн байцаах үйл ажиллагааны хүрээнд дээр дурьдсан бүхий л байгууллагатай хамтран ажиллаж, мэдээлэл харилцан солилцох арга замаар хамтран ажилладаг. Цагдаагийн ажилтнууд мөн баримт нотолгоог тогтоох чиглэлээр Биологийн хүрээлэнтэй, мөн хууль бус үйлдлийг

266 ДБХС-гийн Монгол дахь салбар. Цаашдын зам, Монгол дахь 20 жил.

267 Гол оролцогч талтай хийсэн ярилцлага (ДБХС); Гол оролцогч талтай хийсэн ярилцлага (ОТ) болон ЗАХН.

268 Мэдээлэгчтэй хийсэн ярилцлага: Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс.

шүүхийн шатанд шийдүүлэхийн тулд прокурорын байгууллагатай хамтардаг.



**Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн ажилтнууд хууль бусаар ан хийсэн хэмээн сэжиглэгдэж буй этгээдийн гэрт нэгжлэг хийж, нуусан буй бугын махыг олж, эрүүгийн гэмт хэрэг үүсгэн шалгаж байна.**

Өмнөговь аймгийн Гурвантэс сум



Тус хэлтсийн боловсон хүчинд шаардлагатай нөөц, эх үүсвэр нь үүсгэн байгуулагдсанаас хойш жилээс жилд буурч байна. Анхлан 2010 онд үүсгэн байгуулахад 30 ажилтантай байсан тус хэлтэст 2016 оны байдлаар 12 болон цөөрсөн. Хэлтсийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагад энэ хэмжээний хүн хүчтэй байх нь улсын хэмжээний байгаль орчны бүхий л гэмт хэргийг бүрэн шалгах боломжгүй бөгөөд зэрлэг амьтны гэмт хэргийн хувьд нөхцөл байдал бүр ч тааруу байгааг дурджээ. Төсөв хасагдсан нь бусад үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, цагдаагийн ажилтнуудын үзэж буйгаар дээж, сорьц шинжилгээнд илгээж, амьтны зүйл, эсвэл агнасан хугацааг тогтоолгох зэрэгт төсөв хүрэлцэхгүй байна.<sup>269</sup>Цагдаагийн байгууллага энэ төрлийн зардлуудыг санхүүжүүлэхгүй байгаагаас хулгайн анчдад ял шийтгэлээс зайлсхийх боломжийг олгоно. Эерэг талаас нь үзвэл Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нь зэрлэг амьтны хууль бус худалдааг илрүүлэх чиглэлээр олон нийттэй хамтран ажиллаж, амжилтанд хүрч чадсан. Зэрлэг амьтны гэмт хэргийн талаар олон нийтээс мэдээлэл хүлээн авах утас Монгол Улсад олон жил үр дүнтэй ажиллаж буйг цагдаа болон

<sup>269</sup> Биологийн хүрээлэнгийн итгэмжлэгдсэн лабораторид цагдаагийн байгууллагын зүгээс зэрлэг амьтны сорьц, дээж явуулж, шинжлүүлдэг. Амьтны зүйл тогтоох шинжилгээний төлбөр нь 80,000 төгрөг (ойролцоогоор 35 ам.доллар) байдаг. Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага UB#17 (Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс).

бусад хууль сахиулах байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагууд нотолж байна. Хөдөөгийн малчид, рестораны үйлчлүүлэгчдээс ирүүлж буй мэдээлэл нь зэрлэг амьтны гэмт хэргийг амжилттай мөрдөн шалгах, яллах боломжийг бүрдүүлснээс гэмт этгээдүүдэд торгууль, шийтгэл ноогдуулсан олон тохиолдол байна. Оюу Толгой уул уурхайн компаний санхүүжүүлдэг утасны шугамын нэг нь сүүлийн хоёр жилд найман удаагийн дуудлага хүлээн авч, янгир, хулан, хар сүүлт зээр болон цоохор ирвэсийн найман хэрэгт мөрдөн байцаалт явуулжээ. Мөрдөн байцаалтын үр дүнд гурван хэргийн холбогчдоод хорих ял, 50 сая төгрөгийн торгууль оногдуулж, хамаарах урамшууллыг мэдээлэгчдэд олгожээ.<sup>270</sup>Цагдаагийн ажилтнуудын хэлснээр зэрлэг амьтны тоо толгой цөөрөхөд орон нутгийн иргэд хамтран ажиллаж, хулгайн анчдыг олж тогтоох хандлага нэмэгддэг. Харин зэрлэг амьтны тоо толгой нэмэгдэхийн хэрээр нутгийн иргэдийн зүгээс арга хэмжээ авах нь буурдаг ажээ.<sup>271</sup>

Зураг 8. ДБХС-гийн дэмжлэгтэйгээр бэлтгэсэн Зэрлэг амьтны эсрэг гэмт хэргийн тусгай дугаарын тухай зурагт хуудас. (Улаанбаатар хотын орон сууцны барилгын хананд буй. 2016 оны зун).

**ХУУЛЬ БУС АГНУУР, АН АМЬТНЫ ЭД ЭРХТНИЙ ХУДАЛДААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ АВЧ БАЙНА.**

**97177000**

БАТЛАГДСАН МЭДЭЭЛЭЛД ХУУЛИЙН ДАГУУ МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОНО.

**ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?**

ХЭРЭВ ТА ЗЭРЛЭГ АМЬТНЫГ ХУУЛЬ БУСААР АГНАВАЛ ДООРХ МӨНГӨН ТӨЛБӨРИЙГ ТӨЛЖ, ХУУЛИЙН ДАГУУ ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭНЭ.

<b>АРГАЛЬ ХОНЬ</b> 22,000,000₮ 26,000,000₮	<b>ЦООХОР ИРВЭС</b> 22,400,000₮ 26,000,000₮	<b>МОНГОЛ БЭХЭН</b> 4,000,000₮ 4,400,000₮	<b>ЯНГИР ЯМАА</b> 5,400,000₮ 6,200,000₮
<b>ЦАГААН ЭЗЭР</b> 1,000,000₮ 1,100,000₮	<b>СИБИРЬ ТУЛ</b> 422,000₮	<b>БОРЦГОР ХОТОН</b> 13,140,000₮	<b>АЛТАЙН ХОЙЛОГ</b> 260,000₮

<sup>270</sup> Мэдээлэгчтэй хийсэн ярилцлага UB# (ОТ уул уурхайн компани).

<sup>271</sup> Мэдээлэгчтэй хийсэн ярилцлага UB#17 (Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс).



Хууль бус агнуурын талаар бодит мэдээлэл өгсөн тохиолдолд ноогдуулсан торгуулийн 15%-тэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох замаар мэдээлэгч нартай хамтран ажиллах боломжийг хуулиар тогтоов.<sup>272</sup> Хэдийгээр урамшуулал олгох нь дэлхийн олон оронд амжилттай хэрэгждэг арга зам хэдий ч үүнийг хэрэгжүүлэх журам, дүрэм нь амжилттай хэрэгжих эсэхийг шийднэ. Урамшууллын систем тодорхой бус (мэдээлэгчийн нууцлал, төлбөрийн механизм тодорхой бус) байх нь иргэдийн бодит мэдээлэл өгөхөд сөргөөр нөлөөлдөг.

Энэ чиг үүргийг цагдаа болон ЗДТГ хамтран хэрэгжүүлж буй нь авлига үүсэх, эрх мэдлээ урвуулан ашиглахад онолын хувьд хүргэж болно. Нөгөө талаар, цагдаагийн байгууллага зэрлэг амьтны хууль бус худалдааны талаар мэдээлэл авах байнгын утас ажиллуулж, мэдээлэгчдээс тодорхой сэжүүрийг шууд хүлээн авч байна. Эдгээр байгууллага нь тухайн мэдээлэгчийн нууцлалыг хадгалах үүрэг хүлээнэ. Харин ЗДТГ нь ноогдуулсан торгуулийг төвлөрүүлж, хамаарах урамшууллыг олгох ажлыг хариуцдаг. Цагдаа болон ЗДТГ хооронд мэдээлэл солилцох, ялангуяа мэдээлэгчийн талаар судалгаанд оролцогчид хэд хэдэн асуудал буйг гаргаж ирсэн. Мэдээлэгчийг хамгаалахын тулд зарим тохиолдолд цагдаагийн байгууллагын зүгээс мэдээлэгчийн нэрийн эхний үсгийг л бичих аргыг хэрэглэдэг ч мэдээлэгчийн нэрийн өмнөөс урамшуулал авах тохиолдол гарч байжээ. Харин мэдээлэгчийн нэрийг бүтнээр нь гарган өгөх тохиолдолд тухайн мэдээлэл хүлгийн анчдын хамсаатан, садан төрлийнхөнд алдагдах, улмаар мэдээлэгчийг эрсдэлд оруулдаг. Түүнчлэн мэдээлэгч нь өөрийн урамшууллыг нээлттэй нэхэмжлэх боломжгүй байдлыг ашиглан ЗДТГ-ын ажилтнууд тухайн мэдээлэгчийн тухай мэдээлэл авч, мөнгөн шагналыг хувьдаа завших боломж онолын хувьд харагдаж байна. Мөн журамд төлбөрийг шилжүүлэх тухай дэлгэрэнгүй заагаагүй.<sup>273</sup> Энэхүү систем нь тодорхой амжилтад хүрсэн ч цаашид мэдээлэгчийн нууцлалыг хадгалах замаар урамшууллыг хүргэх чиглэлээр сайжруулах зүйл олон байгааг хэлэх нь зүйтэй.

Нэгдүгээрт, тус хэлтэс нь мэдлэг, туршлагаа сайжруулахын зэрэгцээ зэрлэг амьтантай холбоотой гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр амжилт олж байна. Хүснэгт 8-д 2013 -2016 оны тойм мэдээллийг харуулсан ч 2016 оны эхний 5 сарын мэдээлэл судалгаа хийж үед гарсан. Хандлагыг тогтооход энэхүү мэдээлэл хангалтгүй ч тодорхой мэдээллийг үүнээс үзэх боломжтой.

Хүснэгт 8. 2013-2016 оны хооронд Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн илрүүлсэн хэргүүд

2013 - 2016 ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ХЭЛТЭС												
Зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэргийн илрүүлэлт Хууль бус агнуур (Эрүүгийн хуулийн 203)												
		2013	2014	2015	2016*							
Нийт илрүүлсэн гэмт хэрэг		35	54	56	23	168						
Нийт шүүхэд шилжүүлсэн хэрэг		24	42	33	13	112						
		69%	78%	59%	57%	67%						
(*) 2016 оны эхний 5-н сар												
Эрүүгийн хуулийн 203-р зүйл, Хууль бус агнуурын тухай заалтын дагуу илрүүлсэн зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэргийн тоо баримт												
Хамгаалал статус	№	Зүйлийн нэр	2013-2016 хооронд нийт хураагдсан амьтан, тэдгээрийн эд, эрхтний тоо		Хураагдсан амьтан, тэдгээрийн эд, эрхтний тоо тус бүрээр		Хураагдсан амьтан, тэдгээрийн эд, эрхтний тоо хамгааллын статусар					
			2013	2014	2015	2016 (*)	2013	2014	2015	2016 (*)	2013	2014
НЭН ХОВОР	#1	Монгол бөхөн	21	11	10	-	-	-	-	33		
	#2	Цоохор ирвэс	4	1	3	-	-	-	-	-		
	#3	Бадагга хүдэр	3	-	-	1	2	-	-	-		
	#4	Аргаль хонь	3	3	-	-	-	-	-	-		
	#5	Молцог хандгай	2	-	1	1	-	-	-	-		
ХОВОР	-	Халиун буягн сүүл	30	-	-	30	-	-	-	97		
	-	Баавгайн савар	16	-	8	8	-	-	-	-		
	#1	Хулан адуу	12	8	-	-	4	-	-	-		
	-	Баавгайн доньд	8	-	-	8	-	-	-	-		
	#2	Халиун буга	8	1	1	3	3	-	-	-		
	#3	Хүрэн баавгай	7	2	4	-	1	-	-	-		
	#4	Тул	5	-	4	-	1	-	-	-		
	#5	Зэрлэг гахай	4	2	1	-	1	-	-	-		
	#6	Янгир ямаа	4	2	-	-	2	-	-	-		
#7	Хар сүүлт зээр	1	1	-	-	-	-	-	-			
#8	Зэрлэг гургуул	1	-	1	-	-	-	-	-			
#9	Ойн булга	1	-	1	-	-	-	-	-			
ЭЛБЭГ	#1	Тарвага	6,931	159	5,050	1,722	-	-	-	8,060		
	#2	Загас	901	901	-	-	-	-	-	-		
	#3	Цагаан зээр	148	48	100	-	-	-	-	-		
	#4	Чонын шагай	45	-	-	45	-	-	-	-		
	#5	Нөмрөг тас	16	16	-	-	-	-	-	-		
	#6	Идлэг шонхор	13	8	4	1	-	-	-	-		
	#7	Алтайн хойлог	3	-	-	-	3	-	-	-		
	#8	Шар үнэг	2	-	2	-	-	-	-	-		
	#9	Бор туулай	1	-	1	-	-	-	-	-		
				1,163	5,191	1,819	17			8,190		

<sup>274</sup>Прокурорын байгууллагын мэдээлснээр тус хуулийн 175 дугаар зүйл заасан зэрлэг амьтны хууль бус худалдаа хэмээн зүйлчлэгдсэн өөр 43 хэрэгт хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт хийжээ. Эдгээр нь тус хэлтсийн үйл ажиллагаатай шууд хамааралгүй байсан. Хууль сахиулах байгууллагууд нь хуулийн хүрээнд захиргааны торгууль, шийтгэлийг ямар хэмжээнд ноогдуулсан нь тодорхойгүй. Амьтны тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зэрэгт торгууль шийтгэлийг шууд тусгасан байв. Харин өнөөдөр эдгээрийг Зөрчлийн тухай хуульд нэгтгэж, тус хуулиар зэрлэг амьтны хамаатай зөрчилд ноогдуулах хариуцлагыг тусгасан (хүснэгт 8 болон 9) ба зарим нь нэлээд хатуудуулсан байна. Гэсэн ч өмнө дурдсанчлан тухайн асуудал нь гэмт хэргийн шинжгүй бол захиргааны хариуцлага, торгуулийг ноогдуулж мөн болно.<sup>275</sup>

272 Амьтны тухай хууль. 38.

273 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага #5.1, \$5.8, #5.10, #5.12, болон #5.13.

274 203.1 дүгээр заалт нь ерөнхийдөө хууль бус ан агнуурт (жишээ нь зөвшөөрөлгүй, хориглосон зэвгээр гэх мэт) хамаарна; 203.2 дугаар заалт нь нэн ховор амьтны ан болон тэдгээрийн улсын хил дамнанас шилжилт хөдөлгөөний асуудлыг хамарна.

275 Жишээ нь: Амьтны тухай хууль. 39; Тусгай хамгаалалттай

Хоёрдугаарт, мөрдөн байцаах ажиллагаа явуулсан нийт хэргийн тоо нь 4 жилийн хугацаанд 168 байгаа нь тун хангалтгүй мэт санагдана. Энэхүү тоо нь бодит хэргийн тоог доогуур харуулсан байх магадлалтай учир нь ГЕГ, МХЕГ, Прокурор зэрэг байгууллагаас гарган ирүүлсэн тоо болон мэдээлэгчидтэй хийсэн ярилцлагын дүнтэй нийцэхгүй байна. Жишээлбэл, 2015 онд МХЕГ-ын байцаагчид зарж борлуулах зорилгоор зээрийн 40 эвэр авч явсан этгээдийг илрүүлсэн тухай зарлав. Гэтэл Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн өгсөн мэдээлэлд зээрийн эвэр хураасан тухай дурдаагүй. Үүний нэгэн адил гаалийн гаргасан тайланд чоныг гулууслан гаргах оролдлогын тухай дурдсан ч энэ талаар цагдаагийн тайланд багтаагүй. Мэдээ, баримтын энэхүү зөрүү нь тус хэлтсийн зөвхөн эрүүгийн хэргийг мөрдөн шалгадагтай холбоотой байж болно. Тухайлбал, ГЕГ-ын Үнэрч нохойн албанаас өнгөрсөн гурван жилийн хугацаанд зэрлэг амьтны хууль бус худалдааны нийт 310 хэрэг (үүний 80% нь хууль бусаар худалдаалахаар оролдсон арьс) илрүүлсэн тухай мэдээлжээ. Энэхүү тоо нь өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд мөрдөн байцаасан хэргээс бараг хоёр дахин илүү байна. Хэдэн хэргийг захиргааны хэрэг байдлаар шийдсэн нь тодорхойгүй тул цагдаагийн мөрдөн байцаалтын тоонд ороогүй.

Гуравдугаарт, мөрдөн байцаалт хийж, шүүхэд шилжүүлсэн хэргийн хувьд нийт 67%-тай байжээ (168 хэргээс 112 нь). Мөрдөн байцаалтын шатанд цаашид яллах дүгнэлт үйлдэх эсэхийг тогтоох олон хүчин зүйлс (нотолгоо дутмаг байх, гэрч олдохгүй байх гэх мэт) байдаг ч нийт шүүхэд шилжиж буй хэргийн хувь хэмжээ нь бусад төрийн гэмт хэрэгтэй харьцуулбал доогуур байна.

Эцэст нь хууль бус агнуурт хамгийн ихээр өртөж буй амьтан бол тарвага бөгөөд хураан авсан нийт үүхий эдийн 98% нь тарвага байна. Дотоодын хэрэгцээ болон олон улсын үслэг эдлэлийн үйлдвэрлэлд зориулсан хууль бус тарвага агнуурт олон янзын хязгаарлалт хийж, хориглож буй ч 1990-ээд оны сүүлч үеэс байнга үргэлжилж байна. Худалдааны нөлөөнд өртөж буй “Ховор” болон “Нэн ховор” зүйлээс Монгол бөхөн (VR), цоохор ирвэс (VR), халиун буга (R) болон хүрэн баавгай (R) нь тэргүүн эгнээнд байсаар ирлээ.

## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Олон улсын зэрлэг амьтны худалдааны журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хилийн бүсэд гаалийн байцаагчид хяналт хийж, зөвшөөрлийг шалгаж, тээвэрлэлтийн баримт бичиг, авто тээврийн хэрэгслийн бүртгэл зэргийг нягталж, худалдааны хууль ёсны байдлыг шалгах зорилгоор бараа, бүтээгдэхүүнд үзлэг хийснээр эхэлдэг. Иймээс ч гаалийн байгууллага нь CITES-ыг хэрэгжүүлэхэд дэлхийд чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улсын хувьд ГЕГ нь<sup>276</sup>Гааль, татварын ерөнхий газрын нэг томоохон үндсэн

газар нутгийн тухай хууль, 43 дээр үзнэ үү.

276 www.customs.gov.mn

чиг үүрэг бүхий нэгж юм.<sup>277</sup>Үйл ажиллагаа явуулж ирсэн түүхэндээ олон яамдын (Сангийн Яам, Худалдаа,Үйлдвэрийн Яам, Батлан Хамгаалах Яам, Нийгмийн Хамгааллын Яам, Гадаад Худалдааны Яам, ЗГХЭГ) харьяанд байсан тус байгууллага нь хамгийн сүүлд татварын байгууллагатай нэгдсэн бөгөөд ярилцлагад хамрагдсан гаалийн ажилтнуудын хэлснээр экспорт, импортоос илүү хууль сахиулах чиг үүрэг нь тэргүүлэх болжээ. Энэ нь аюулгүй байдал, худалдааны хэм хэмжээ зэрэг бусад асуудлуудтай харьцуулбал анхаарал илүү татдаг асуудал буй болохыг харуулна. Монгол Улсын гааль нь 2011 онд нийт 3 их наяд төгрөгийн (1.3 тэрбум ам. доллар) гаалийн татварыг улсын төсөвт төвлөрүүлсэн нь улсын төсвийн орлогын 40%, ДНБ-ний 6%-тэй тэнцэнэ.<sup>278</sup>Ашигт малтмалын экспорт, газрын тосны бүтээгдэхүүн, автомашин, барилга, уул уурхайн тоног төхөөрөмжийн импорт нь гаалийн татварын орлогын үндсэн хэсгийг бүрдүүлдэг тул анхаарлын төвд байна. Экспорт, импортын барааны 90 орчим хувь нь Алтанбулаг (Сэлэнгэ), Сүхбаатар, Замын-Үүд боомтуудаар дамждаг тул гаалийн ихэнх нөөц, эх үүсвэр нь эдгээр боомтуудад төвлөрч байна.<sup>279</sup>

Гаалийн байгууллага татвар хураалтад хамгийн ихээр төвлөрдөг болохыг дараах хоёр жишээнээс харж болно. Үүнд: Дорноговь аймаг дахь Замын-Үүдийн боомт дээр саяхан болсон нэгэн сургалтад ГЕГ, МХЕГ, БОГХТХ-ийн 600 гаруй албан хаагч 2017 оны 4 дүгээр сарын 6-7-ны өдөр “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт семинарт оролцож хар тамхи, мансууруулах бодис худалдаалах, кибер гэмт хэрэг, хилийн хорио цээрийн хяналт, гэмт хэрэг зөрчлөөс сэргийлэх болон манлайлал зэрэг сэдвээр ярилцсан ч амьтны хууль бус худалдааны гэмт хэргийг бага дурьджээ. Гааль нь нийт 7 газарт өөрийн лаборатори ажиллуулж, Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогсон ба өндөр татвар бүхий (орлого төвлөрүүлэх боломж ихтэй) эм, согтууруулах ундаа, ашигт малтмал, тамхи, бензин, ноолуур зэрэг бүтээгдэхүүнд л шинжилгээ хийж байна. Эдгээр лабораторит зэрлэг амьтны эд, эрхтнийг шинжлэх төхөөрөмж одоо хир суурилагдаагүй. Өнөөгийн байдлаар гаалийн лабораториуд нийт 14,806 шинжилгээ хийж, худалдаа эрхлэгчдээс гаалийн татвараа бууруулахаар зориуд худал мэдүүлсэн бараа, бүтээгдэхүүний ангиллыг үнэн зөвөөр тогтоож иржээ. Үүний зэрэгцээ Гаалийн үнэрч нохойн албаны мэдээлснээр сүүлийн гурван жилийн туршид (2013- 2015) үнэрч нохдын илрүүлсэн 310 захиргааны зөрчил, эрүүгийн хэргийн 80% нь амьтны үс, арьс, үлдэх 20% нь бусад бүтээгдэхүүнтэй холбоотой байжээ.<sup>280</sup>

277 www.mta.mn

278 Гаалийн ерөнхий газрын вэб сайт дээрх мэдээлэл, Үйлчилгээ, аж ахуйн алба (www.customs.gov.mn)

279 Гаалийн ерөнхий газрын вэб сайт дээрх мэдээлэл, Өнөөгийн орчин (www.customs.gov.mn)

280 Гаалийн ерөнхий газрын вэб сайт дээрх мэдээлэл, Үйлчилгээ, аж ахуйн алба (www.customs.gov.mn)

Зураг 9. Хилийн боомт дээр автомашинд шалгалт хийж буй нохой



ГЕГ нь өөрийн ажилтнуудыг улс орон даяар буй 50 гаруй байршлуудад тараан ажиллуулж байна. Эдгээр нь төрөл бүрийн ангилалд хамаарах ба 14 гаалийн алба, 20 салбар нэгж 16 боомт юм.<sup>281</sup> Зураг 10-т судалгааны үеэр очиж ажилласан гаалийн газрууд, байгууламжуудын зургийг харуулав. Эдгээр байгууламж нь экспорт, импортын барааны, тэр дундаа зэрлэг амьтны бүтээгдэхүүний хяналт, шалгалтыг хийнэ.

Зураг 10. 2016 оны судалгааны үеэр авсан гаалийн зарим дэд бүтэц



Гаалийн байцаагч нь юуны өмнө тухайн бараа, бүтээгдэхүүний мэдүүлэг нь хууль ёсны эсэхийг тодорхойлно. Хэрэв хууль ёсны бараа байгаа бол МХЕГ-ын байцаагч нь тухайн барааны стандарт, чанар, гэрчилгээ, зөвшөөрлийг (СITES-ын экспорт, импортын зөвшөөрөл) шалгадаг. Гаалийн байцаагч нь тухайн барааг хууль бус хэмээн үзэх сэжиглэх бол тухайн асуудлыг цагдаад шилжүүлнэ. Тээврийн хэрэгсэлд мөн бараа, бүтээгдэхүүн нууцаар хил нэвтрүүлж буй эсэхэд шалгалт хийнэ. Зураг 11- д Хавиргын боомт дээр авто тээврийн хэрэгсэлд шалгалт хийж буйг харуулав.

Уг зураг дээр гаалийн байцаагч БНХАУ-тай хиллэсэн зүүн хилээр нэвтэрч буй барааг шалгаж буйг харуулав. Шалгалтын үеэр байцаагч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ачааг сонгон, доод хэсгийг нь толинд харж, дугуйг цохиж шалгана. Зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн нууж болох газруудын тоо, шаардлагатай тоног хэрэгслийн хомсдол зэргийг харгалзвал иймэрхүү шалгалт нь хууль бус худалдааны зөвхөн багахан хэсгийг илрүүлэх боломжтой. Захиргааны хариуцлага ноогдуулах торгууль болон зөрчлийн хэмжээнээс

281 Гаалийн ерөнхий газрын вэб сайт дээрх мэдээлэл. Зохион байгуулалтын бүтэц ([www.customs.gov.mn](http://www.customs.gov.mn))

хэтрэх тохиолдолд уг хэргийг тухайн гаалийн боомтод ажиллаж буй цагдаагийн ажилтанд шилжүүлдэг.

Зураг 11. Хавиргын боомт дээрх гаалийн шалгалт (2016 оны 11 сар)



Хэрэг зөрчлийг шилжүүлэх үйл явц нь бусад улс орныхоос ялгаатай <sup>282</sup>байгаа хууль сахиулах үйл ажиллагаанд томоохон хийдэл үүсгэж байна. Дэхийн гаалийн байгууллагаас (WCO) гаргасан хууль бус худалдааны тухай тайланд энэхүү “Тээвэрлэж буй барааг саатуулах эрх нь .... гаалийн үйл ажиллагааны нөхцлийг сайжруулахад ихээхэн нөлөө үзүүлнэ” хэмээн дурдаж, улс орнуудад энэхүү эрхийг гаалийн байгууллагад шууд олгохыг уриалжээ.<sup>283</sup> Гэвч Монгол Улсын гаалийн байгууллага нь мөрдөн байцаах хязгаарлагдмал эрхтэй, нэг чиглэлийн мэдээллийн урсгалтай байна. Үүний улмаас зэрлэг амьтны хууль бус худалдааг анхлан илрүүлсэн гаалийн ажилтан нь хэргийг цагдаа шилжүүлснээс хойш хэрхэн шийдэгдсэн талаар ямар нэгэн мэдээлэлгүй байдаг. Энэ нь нарийвчлан мөрдөн байцаах, хэргийг шалгах үйл явц, хэрэг шийдэхэд, мөн олон улсын худалдаанд ч нөлөөлнө. Өөр улсын гаалийн албаныхан хууль бус бараа, бүтээгдэхүүн илрүүлбэл тухайн барааны гарал үүслийг судлан тогтоож, мөрдөн байцаах хүсэлт гаргах боломжтой. Гэтэл гаалийн байгууллага бүр мөрдөн байцаах эрхгүй тул тухайн улс орны доторх аль байгууллагад мөрдөн байцаах асуудлаар хандах нь тодорхойгүй. Олон орны хил, гаалийн ажилтнуудын хувьд хууль бус байж болох бараа, бүтээгдэхүүний эх үүсвэрийг тогтоохын тулд бусад улс орны хил, гаалийн алба руу утасдаж байх цаг хомс байдаг.

282 Жишээ нь АНУ-д гаалийн алба нь (Дотоодын аюулгүй байдлын алба- Цагаачлал, гаалийн хяналтын газар) нь мөрдөн байцаалт явуулах эрхийг эдэлдэг байна.

283 Дэлхийн гаалийн байгууллага, Хууль бус худалдааны тайлан 2012, (2013) 36.

Өөр нэгэн асуудал бол гаалийн вэбсайт болон гаалийн зүгээс судалгаанд зориулан гаргаж өгсөн албан баримт, материалууд хоорондоо зөрүүтэй байна. Вэбсайт дээр онлайн байдалтай мэдээлэлд зэрлэг амьтны хууль бус худалдааны 234 хэргийг Гаалийн үнэрч нохойн алба илрүүлсэн хэмээн мэдээлсэн бол Гаалийн ерөнхий газраас судалгаанд зориулан өөрийн мэдээллийн сангаас гарган өгсөн мэдээлэлд 2014 оноос 2016 оны эхний хагасын хугацаанд ердөө 16 хэрэг, 2014 онд 4 хэрэг, 2015 онд 6 хэрэг, 2016 оны эхний таван сарын байдлаар 7 хэрэг илрүүлсэн хэмээн бичжээ. Хүснэгт 9-д ГЕГ-аас өөрийн тайланд дурдсан 16 хэргийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг харуулжээ. Нэгээс бусад бүх хэрэг нь БНХАУ-тай холбоотой байсан бөгөөд энэ чиглэлд нийт асуудлын 90% нь төвлөрдөг болохыг гаалийн ажилтнууд баталж байгаа юм. Тус улс руу хууль бусаар зарж буй зэрлэг амьтны зүйл, бараа, бүтээгдэхүүн нь Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн тайланд дурдсантай ижил байгаа ба үүнд зээр (эвэр), саарал чоно (гулууз болон арьс), тарвага (арьс), баавгай (савар, шинэ болон хатаасан цөс), халиун буга (цусан эвэр, чив, засаа, сүүл), борцгор хотон (хошуу), үнэг болон хярс (арьс) багтаж байна.

#### Хүснэгт 9. Гаалийн ерөнхий газар, Эрүүгийн хэрэг зөрчлийн тайлан (2014-2016)

Монгол улс			
Гаалийн ерөнхий газар			
Гэмт хэргийн шинжтэй тохиолдлын мэдээ			
	2014	2015	2016 (*)
Нийт тохиолдол	94	96	31
Зэрлэг амьтны хууль бус худалдааны тохиолдол	3	6	7
Зэрлэг амьтны хууль бус худалдааны эзлэх хувь	3%	6%	23%

\* 2016 оны эхний 5 сар

Зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэргийн тоо мэдээ (Эрүүгийн хуулийн 175-р зүйлд холбогдох: зэрлэг амьтны эд эрхтэн, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний худалдаа, хууль бусаар хил давуулах оролдлого)

Худалдаалах чиглэл	#	Аймаг	Огноо	Хураагдсан бүтээгдэхүүн	Хил зөрчсөн арга
БНХАУ уруу	1	Ховд	1/18/2016	8 Алтайн хойлог	тодорхойгүй
	2	Дорнод	1/15/2014	1 бугын засаа	🚗
	3		5/24/2014	386 зээрийн эвэр	🚗
	4	Дорноговь	2/1/2016	21 хярсны арьс, 4 үнэгний, 1 чонын арьс	тодорхойгүй
	5		1/12/2016	1 хөлдөөсөн чоно	🚗
	6		5/24/2015	74 тарваганы арьс	🚗
	7	Сүхбаатар	12/5/2014	1 шинэ болон 1 хатаасан баавгайн цөс	🚗
	8		11/29/2015	9 чонын арьс, 2 хөлдөөсөн шувуу, 11 чонын эрүү	🚗
	9		1/18/2016	1 бугыг цусан эвэр	тодорхойгүй
	10	Замын үүд	3/26/2016	2 бугын засаа, 3 согооны сүүл	🚗
	11		2/8/2015	13 баавгайн савар	🚗
	12		4/27/2015	18 ширхэг ясан эдлэл, 11 эвэр	🚗
	13		12/8/2015	3 бугын засаа, 4 бугын сүүл	🚗
ОХУ-аас	14	Баян Өлгий	4/28/2016	4 Борцгор хотон шувууны хошуу	🚗
	15	тодорхойгүй	1/20/2016	1 хөлдөөсөн чоно	🚗
	16	Говьсүмбэр	1/22/2015	3 хөлдөөсөн чоно	🚗

Хил зөрчсөн арга: 🚗 Хил бивээс нуусан, 🚚 Хувийн авчраад нуусан, 🚗 Тээврийн хэрэгслийн залас дугуйнд нуусан, 🚗 Тээврийн хэрэгслийн дотор нуусан, 🚗 Тээвэрлэх буй явцанд нуусан

Гаалийн байгууллагын зүгээс ноогдуулсан захиргааны арга хэмжээ (Хүснэгт 10) нь эрүүгийн хэргийн тооноос илүү буй ч Үнэрч нохойн албаны илрүүлсэн хэргийн тооноос бага. Чоно худалдаалахаар оролдсон 11 хэрэг дээр, мөн нэг жилийн эхний хагасын хугацаанд

(2016)<sup>284</sup> эдгээр нь өмнөх 2.5 жилийн хугацаанд гарсан чонын хууль бус худалдааны (n=5) нийт тооноос хоёр дахин өндөр байна.

#### Хүснэгт 10. CITES-ын худалдааны хүрээнд зэрлэг амьтны худалдааны чиглэлээр гарсан хэргүүд (2016)

МОНГОЛ УЛС							
ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХУУЛЬ БУС ХУДАЛДААНД ХОЛБОГДОХ ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛҮҮД (Зүйл 290-2.2)							
Монгол улс дахь САЙТИС-ын Удирдан зохицуулах зөвлөлөөс САЙТИС конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт 2016 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнасан мэдээ							
Зөрчлийн тоо	Курээсан бараанууд	Нийт хэмжээ	САЙТИС Хавсралт	Зөрчил гаргагчийн иргэншил	Хуулийн санц (Төгрөг)	Хуулийн санц (Ам.доллар)	Хуулийн санц (Ам.доллар / ширхэг)
4	Чонын арьс	15	II	Монгол (3) Хятад (1)	125,000	54	4
2	Чонын шэгийн арьс	49	II	Монгол (1) Хятад (1)	90,000	39	1
2	Чонын шүд	13	II	Монгол (1) Хятад (1)	80,000	35	3
2	Чонын хоншоор	14	II	Монгол (2)	45,000	20	1
1	<i>Clatsche deserticola</i>	250 гр	II	Хятад (1)	50,000	22	-
11 Зөрчил	2 зүйл/3 бүтээгдэхүүн	92 зүйл	Хавсралт II	11 бодгаль	390,000	170	8
1 ам.доллар = 2,300 төгрөг							

Гаалийн ажилтнуудын зүгээс мөн Казахстанас авч, ОХУ-аар дамжуулан, Монгол Улсад борлуулахаар оруулахдаа баригдсан борцгор хотонгийн 4 ширхэг хошуу худалдаалах хэргийн фото зургийг судалгааны багт гарган өгөв.<sup>285</sup> Борцгор хотон (*Pelicanus crispus*) шувуу нь Монгол улсын Амьтны тухай хуулийн дагуу “Нэн ховор” хэмээх зэрэглэлд хамрагдахын зэрэгцээ CITES-ын 1-р хавсралтад багтдаг. Борцгор хотонг агнах болон бүх хэлбэрээр худалдаалахыг Монгол улсад бүрэн хориглодог. Хурдан морьны хусуур хийж ашигладаг тул түүний хошуу Монгол улсад өндөр үнэ хүрнэ. Тухайн хэргийг үйлдсэн Монгол Улсын иргэн нь Алтанбулаг боомтоор ОХУ-аас тухайн хошууг, хувцас дотроо нуун оруулахаар завдаад баригджээ. Энэ нь тайлангийн гуравдугаар бүлэгт дурдсанчлан хавсралт I-д багтсан зүйлийн Монгол Улс дахь хууль бус худалдааны нэг тохиолдол болов.

284 Монгол улс дахь САЙТИС-ын Удирдан зохицуулах хорооноос САЙТИС-ын нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлсэнээр.

285 Гаалийн хэрэг #14.

Зураг 12. Алтанбулаг боомтын байцаагчид Казахстанас ОХУ-аар дамжуулан худалдаалахаар завдсан хотонгийн хошууг илрүүлсэн нь



Судалгааны баг Өмнөговь аймгийн БНХАУ-тай хиллэсэн хилийн боомт дээр 2017 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр ажиллахдаа хувцас дотроо 3 кг зээрийн эвэр нууж, БНХАУ руу гаргахаар завдаж, баригдсан эмэгтэйн хэргийг нүдээр үзжээ. Зураг 12-т гаалийн хяналтын үед түүнээс гадуур хувцас болон гутлаа тайлахыг шаардаж буй агшныг харуулав.

Зураг 13. Хятад руу зээрийн эвэр худалдаалахаар завдах явцдаа баригдсан эмэгтэй



Зураг 14-д Замын-Үдийн хилийн боомт дээр зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүнийг гаргахаар 2015 оны 11 дүгээр сард (өвөл болохоор зэрлэг амьтны хууль бус худалдаа ихэсдэг) завдсан оролдлогыг үзүүлэв. Хилийн боомт дээрх үнэрч нохойн алба БНХАУ руу гарч байсан УАЗ- 469 машины ачаанд хар өнгийн уутанд нуусан 31 төрлийн бүтээгдэхүүнийг илрүүлжээ. Үүнд чонын арьс (зураг дээр 9 нь харагдаж буй), 2 ширхэг нургийн сойр,<sup>286</sup> чонын шүд, (гаалийн ажилтнуудын хэлж буйгаар 9 ширхэг), мөн хоншоор буй ч зөрчил гаргасан этгээд гэрийн нохойных хэмээн мэдүүлж байжээ.

286 Эгэл сойрыг Монгол улс “Нэн ховор” болон “Ховор” хэмээн жагсаалтад оруулаагүй. Энэхүү зүйлийн агнах тоо хэмжээг тусад нь тогтоодоггүй.

Зураг 14. Замын-Үүд боомт дээрх үнэрч нохойн нэгж зэрлэг амьтны худалдааг илрүүлж буй нь



Зураг 16-т БНХАУ руу хөлдөөсөн чоно гаргадаг хамгийн түгээмэл аргыг харуулж байна. Тэд түүний урд хоёр хөлийг нийлүүлэн уяж, энгийн уутанд багтаадаг. Худалдаачид чоныг нууцаар гаргахын тулд үхрийн мах дунд нуусныг 2016 оны 1 дүгээр сард гаалийн ажилтнууд таслан зогсоожээ.

Зураг 15. Хятад руу гаргах зорилгоор үхрийн махны дунд нуусан байх үед илрүүлсэн хөлдөөсөн чоно (2016 оны 1 дүгээр сар)



Гаалийн ажилтнуудын хэлж буйгаар зэрлэг амьтны хууль бус худалдааг илрүүлэх боломж хязгаарлагдмал байдаг нь дараах хүчин зүйлстэй холбоотой. Үүнд: i). мөрдөн байцаах чадвар хомс, ii). CITES-ын зөвшөөрлийн үнэн зөв эсэхийг тогтооход хэрэгцээтэй БОАЖЯ-тай үүсгэсэн цахим холболт байхгүй, iii). Амьтны зүйлийг тодорхойлох тухай сургалт дутмаг буй гэх мэт.<sup>287</sup>

287 Оролцогч талтай хийсэн ярилцлага (гаалийн байгууллага).

## ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Тагнуулыг шинэчлэн зохион байгуулахаар олон жил ажилласны эцэст 2000 онд Монгол Улс нь орчин үеийн түвшинд хүрсэн ТЕГ-ыг байгуулж, үндэсний аюулгүй байдалд хамаарах 25 хууль, журмын хэрэгжилтийг хангах ялангуяа зэрлэг амьтны эсрэг гэмт хэргийг хамруулан үндсэн чиг үүргийг нь тогтоожээ. Түүнчлэн Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлээр ТЕГ-ыг Монгол Улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий харьяаллын байгууллага байхаар заасан. Тиймээс ТЕГ нь зэрлэг амьтны олон улсын хууль бус худалдаатай холбоотой хуулийн хэрэгжилтийг хангах үндсэн байгууллага юм.

ТЕГ-ын ажилтнууд нь мөнгө угаах, хүн худалдаалах, галт зэвсэг худалдаалах, авлига болон хил дамнуулан хууль бус худалдаа хийх зэрэг гэмт хэргийн чиглэлээр тагнах үйл ажиллагаа явуулдаг. Гэд өөрсийн шугамаар цуглуулсан мэдээллээ Цагдаагийн байгууллага болон ХЗЯ-нд гарган өгч, мөрдөн байцаах, яллах үйл ажиллагаанд шилжүүлдэг. ТЕГ нь мөн иргэдийн хамтын ажиллагааг хангах болон тухайн гэмт хэргийн сэжүүрийг олж тогтооход дэмжлэг авах зорилгоор өөрийн тусгай дугаарын утас, цахим шуудангийн хаяг ажиллуулж байна.

## ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР

Хил хамгаалах ерөнхий газар нь тус улсын 8,252 км урт хилийн бүсийг, 15 км өргөн хилийн зурвасыг хамтаар хамгаалан, хуулийн хэрэгжилтийг хангах үүргийг хүлээдэг ба хамрах нийт газар нутгийн хэмжээ нь 123,780 км<sup>2</sup> хүрнэ. 1993 оноос хойш нэр болон харьяалал (заримдаа дотоод хэргийн асуудал эрхэлсэн, заримдаа батлан хамгаалахын асуудал эрхэлсэн яамд)-д ажиллаж ирсэн ХХЕГ нь 2002 онд шинэчилсэн зохион байгуулалтын бүтцээр ХЗДХЯ-ны харьяа зохицуулагч нэгж хэлбэрээр ажиллах боллоо. Тус байгууллагын үндсэн зорилго нь алан хядагчид болон тухайн үйл ажиллагаанд ашиглаж болох зэвсэг, хэрэгсэл хил нэвтрэн орж ирэхээс сэргийлэхэд оршино. ХХЕГ нь мөн хууль бусаар хил зөрчигч, цагаач иргэд орж ирэхээс сэргийлэх болон хууль бус зүйлсийг хил дамнуулан худалдаагаас сэргийлэх үүрэгтэй. Тус газар нь хил нэвтрэх боомтууд дээр үйл ажиллагаа явуулж, нийт 46 шалган нэвтрүүлэх цэгтэй бөгөөд 14 олон улсын боомт, 14 хилийн түр боомт (хоёр улсын иргэд нэвтрэдэг), 10 ширхэг хоёр талын боомт, 7 транзит боомтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тухайн албад нь хил нэвтрэх баримт бичиг шалган нэвтрүүлэх үндсэн үүрэгтэй ч ХХЕГ-ын ажилтнууд нь гааль, цагаачлал, хөдөө аж ахуйн чиглэлийн хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлдэггүй. Үндэсний аюулгүй байдал, хил хамгаалах чиглэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахаас гадна энэхүү байгууллага нь бусад улс оронтой байгуулсан хил хамгааллын 53 гэрээг хэрэгжүүлэх үүргийг хүлээдэг

(эдгээрийн 15 нь ОХУ болон БНХАУ-тай байгуулсан). ХХЕГ-ын мэдээлснээр Монгол Улсын хилээр жилд 3 сая зорчигч, 1.5 сая тээврийн хэрэгсэл нэвтрэх байна.<sup>288</sup>

ХХЕГ-аас зэрлэг амьтантай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр олон сайхан ажил хийсний нэг бол 2010 онд БОАЖЯ, ДБХС болон ХХЕГ хоорондоо харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан үйл явдал байлаа. Энэхүү баримт бичгийн агуулга нь талууд “Аргаль, зээр зэрэг зүйлийг хамгаалах, зэрлэг амьтны хууль бус худалдаанаас сэргийлэх”-д хамтран ажиллахад оршино.<sup>289</sup> 2007 онд ДБХС нь зүйлийн мониторинг хийх “САРАН” хэмээх программ гаргаж, үүнийг Алтай Соёны бүс нутгийн Монголын талд туршжээ. ХХЕГ нь энэхүү үйл ажиллагаанд хамтран оролцсоноор энэхүү санаачилгыг улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлж, зэрлэг амьтан хамгааллын чиглэлээр үйл ажиллагаагаа уялдуулж, хил хамгаалалтын ажилтнуудын байгаль хамгааллын чиглэлийн чадавхыг бэхжүүлэхэд их түлхэц болжээ.<sup>290</sup>

## АВЛИГА

Бусад улс орны нэгэн адил авлигын гэмт хэрэг нь Монгол Улсад тулгараад буй асуудлуудын нэг болжээ. Транспаренси Интернейшнл байгууллагын 2016 оны Авлигын индексээр Монгол Улс 38 оноо авч (0 оноо нь авлига өндөр хэмжээтэй, 100 оноо нь авлигагүй), 176 улсаас 87 дугаарт эрэмбэлэгдсэн. Монгол Улс нь авлигын индексээр бага эрэмбэтэй бол хөрш БНХАУ -40, ОХУ-29 оноотой байна. Транспаренси Интернейшнл байгууллагын тайлбарлаж буйгаар “бага эрэмбэ” гэдэг нь төрийн байгууллагуудад итгэл итгэл бага, чиг үүргээ муу биелүүлдэг, авлигын эсрэг хуулийн хэрэгжилт тааруу, иргэд хээл хахууль өгөх шаардлагатай байнга тулгардаг хэмээх тодорхойлолтод хамаарч байна. Монгол Улсын хувьд сүүлийн 5 жилийн хугацаанд томоохон өөрчлөлт гараагүй буюу бага эрэмбэтэй хэвээрээ байна. Харин Монгол Улсын авлигын зэрэглэл 2017 онд хоёр оноогоор буурч 180 орноос 103 дугаарт орсон нь авлигатай тэмцэх хүчин чармайлт нь олон жилийн хугацаа шаардагдахыг харуулна. Монгол Улсад хийсэн хараат бус судалгаагаар дээрх асуудлыг нотлох зарим тоо баримтууд дурдагдсан. Үүнд, бизнесийн байгууллагуудын 31% нь “Төрийн албан хаагчдад бэлэг сэлт өгөх нь ажлаа бүтээхэд хэрэг болдог”<sup>291</sup>, худалдааны чиглэлээр ажилладаг

288 Хил хамгаалах ерөнхий газрын вебсайт <http://bpo.gov.mn>.

289 ХХЕГ болон ДБХС-гийн Монгол дахь төлөөгчийн газар ХОСБ-т гарын үсэг зурсан тухай мэдээ, 2011 оны 6 сарын 10, ДБХС-гийн вэбсайт (<http://mongolia.panda.org/en/?2200594/Ge>).

290 ХХЕГ болон ДБХС-гийн Монгол дахь төлөөгчийн газар ХОСБ-т гарын үсэг зурсан тухай мэдээ, 2011 оны 6 сарын 10, ДБХС-гийн вэбсайт (<http://mongolia.panda.org/en/?2200594/Ge>).

291 Аж ахуйн нэгжүүдийн судалгаа 2013, <http://www.enterprisesurveys.org/data/exploreconomies/2013/mongolia> хаягаар үзнэ үү.

компаниудын 10% нь авлигатай нүүр тулдаг, хувь хүмүүсийн 7% нь судалгаа хийгдэхээс өмнөх 3 сарын дотор ямар нэгэн байдлаар авлига өгч байсан гэсэн бол Монгол Улсын иргэд үндсэндээ гаалийн ажилтнуудыг хамгийн их авлига авдаг хэмээн үзсэн байна.<sup>292</sup>

Судалгаанд хамрагдсан хэд хэдэн мэдээлэгчдийн батлан хэлсэнчлэн зэрлэг амьтны хууль бус худалдаатай холбоотой хуйвалдаан, авлига, хувьдаа завших зэрэг үзэгдэл гарах боломжтой ажээ. Дээрх боломжит нөхцөлүүдээс дараах зүйлс нь нотлогдоогүй ч хамгийн боломжтой хэмээн үзэж байна. Үүнд:

- Байцаагч нар нь зөрчилд торгууль ноогдуулахдаа зохих баримт өгдөггүй. Улмаар тухайн торгуульд төлсөн мөнгийг цааш нь холбогдох ЗДТГ-г мэдээлэлгүйгээр хувьдаа завшдаг.<sup>293</sup>
- Төрийн албан хаагчид агнуурын зөвшөөрөл олгохдоо ангийн махыг өөрсдөө авдаг. Мэдээлэгчийн хэлснээр энэ аргаар олсон ангийн махыг сумын сургуулийн хүүхдүүдийн хоолонд нийлүүлж байжээ.<sup>294</sup>
- Хууль бус агнуур, загасчлахдаа байгаль хамгаалагч нарт хахууль өгч, тэд үйлдлийг харсан ч хараагүй мэт өнгөрөөдөг. Байгаль хамгаалагчийн цалин багаас хууль бус анчид тэднийг хэд хэдэн аргаар хахуульдаг. Тухайлбал, бэлэн мөнгө өгөх, архи өгөх, хүүхдийнх нь сургуулийн төлбөрийг төлөх, гэр бүлийн хүнийх нь эмчлүүлэх зардлыг гаргах<sup>295</sup> зэрэг болно.
- Өөртөө нэмэлт орлого олохын тулд байгаль хамгаалагчид өөрсдөө хууль зөрчин амьтан агнаж, худалддаг.
- Доогуур албан тушаалын гаалийн ажилтнууд худалдаачидтай хуйвалдан, барааг хилээр нэвтрүүлдэг.

Аймгуудын авлигын индексээс Хүснэгт 9-аас энэ талаар дэлгэрэнгүй баримтыг харж болно. Бүхий л аймгийн хэмжээнд авлигын түвшин өндөр байна (2013 онд дунджаар 0.65). Гэхдээ өнгөрсөн гурван хилийн хугацаанд худалдаа, бизнесийн гол цэгүүд болох гурван аймагт авлигын индекс хамгийн өндөр байжээ (Сүхбаатар (2016 онд 0.77), Төв (2009 онд 0.71), Дорноговь (2013 онд 0.65)). Олон улсын зэрлэг амьтны худалдаанд чухал үүрэгтэй эдгээр гурван аймаг нь иргэд хамгийн ихээр зорчдог, гаалийн транзит бүс юм. Эдгээр гурваас зөвхөн Төв аймгийн хувьд л нөхцөл байдал сайжирч 2013 онд 0.58 –д хүрсэн.

292 Азийн Сан, 2015 оны 6 сар.

293 Мэдээлэгчтэй хийсэн ярилцлага UB- Загасчин#11, Өгий нуур дээр нэр нь тодорхойгүй байцаагч нар хэрхэн загасчдыг ямар нэгэн баримт өгөлгүйгээр торгодог тухай ярьсан.

294 Мэдээлэгчтэй хийсэн ярилцлага UB-Анчин #7.

295 Мэдээлэгчтэй хийсэн ярилцлага UB-Загасчин#8 болон #9, Анчин #19.

Хүснэгт 9. Аймгуудын авлигын индекс (2009, 2011 болон 2013)

Аймгуудын авлигын индекс			
Аймаг	2009	2011	2013
Баян-Өлгий	0.54	0.46	0.56
Говь-Алтай	0.59	0.62	0.69
Завхан	0.64	0.63	0.46
Увс	0.54	0.54	0.64
Ховд	0.49	0.49	0.59
Архангай	0.47	0.60	0.73
Баянхонгор	0.58	0.58	0.59
Булган	0.66	0.66	0.69
Өвөрхангай	0.60	0.66	0.69
Хөвсгөл	0.55	0.53	0.53
Орхон	0.49	0.56	0.61
Дорноговь	0.66	0.64	0.65
Дундговь	0.66	0.55	0.63
Өмнөговь	0.55	0.53	0.63
Сэлэнгэ	0.64	0.69	0.58
Төв	0.71	0.68	0.58
Дархан-Уул	0.60	0.52	0.64
Говьсүмбэр	0.67	0.58	0.61
Дорнод	0.59	0.65	0.66
Сүхбаатар	0.58	0.67	0.77
Хэнтий	0.56	0.68	0.68
<b>Дундаж</b>	<b>0.64</b>	<b>0.63</b>	<b>0.65</b>

Авлига нь гэхдээ зөвхөн гаалийн байгууллагаар ч хязгаарлагдахгүй. Монголчуудын хувьд төрийн байгууллагад ажиллаж буй нэгнээ дарамтлан шахах замаар өөртөө ашигтай шийдвэр гаргуулах нь түгээмэл байна (зөвшөөрөл, торгууль хүчингүй болгуулах, нөгжлэг шалгалтаас зайлсхийх гэх мэт).<sup>296</sup> Агнуурын хувьд өөрийн найз, хамаатан, эсвэл танил нэгнээ хууль бусаар ан хийсэн хэмээн байгаль хамгаалагчийн зүгээс мэдээлэх боломж маш бага. Байцаагч нар нь өөрсдөө хуулийн хэрэгжилтийн хангах ёстой нутаг дэвсгэртэй амьдардаг тул нутгийн олон нийттэй сайн харилцаатай байх шаардлагатай. Хэрэв өөрийн найз нөхөд, хамаатан саданд хууль бусаар ан хийсэн хэргээр торгууль ноогдуулбал өөрсдөө тухайн орчиндоо амьдрахад хэцүү болдог. Заримдаа тэд хууль бус үйл ажиллагааг хараагүй мэт өнгөрөөхөөс өөр аргагүй байдаг ажээ. Жишээлбэл, хэд хэдэн удаагийн үйлдэлтэй этгээдэд торгууль шийтгэл ноогдуулбал байгаль хамгаалагч цаашид байнгын дарамтад өртдөг ажээ.<sup>297</sup> Гэвч Монгол Улсад ахиц дэвшил гарч байгаа бөгөөд эрх зүйн орчин сайжирч, зарим өндөр түвшний авлигын хэргүүдийг

296 Мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, UB #2 (ТББ-ын захирал).

297 Мэдээлэгчтэй хийсэн ярилцлага UB #2 (ТББ-ын Захирал) болон UB-Загасчин #8 болон Анчин #18.

илрүүлж байна.<sup>298</sup>Монгол Улс нь Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага (OECD)-ын Авлигатай тэмцэх конвенцид нэгдэн ороогүй ч НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийг соёрхон баталсан улс юм. Үндэсний хэмжээний хоёр хууль- Авлигатай тэмцэх тухай хууль (2006) болон Эрүүгийн хууль (2016)-д энэ чиглэлийн гэмт хэргийн заалтыг тусгажээ.

Авлигатай тэмцэх тухай хуулиар авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий гол байгууллага болох Авлигатай тэмцэх газрыг байгуулжээ. АТГ нь авлигын хэрэгт хяналт тавих, мөрдөн байцаах эрхтэй бөгөөд үүний хүрээнд гааль, хилийн ажилтнууд, байгаль хамгаалагчдын шалгах эрхийг эдэлнэ. Эрүүгийн хуулиар албан үүргээ урвуулан ашиглах, мөнгө угаах болон төрийн албан хаагчдын шууд болон дам байдлаар хахуульдах зэрэг хэрэгт эрүүгийн хариуцлага ноогдуулахаар тусгажээ. Хариуцлага нь 10 хүртэл жил хорих болон х хэмжээний мөнгөн торгууль ноогдуулах зэрэг шийтгэл юм.

Гарч буй ахиц дэвшилд саад учруулж буй хүчин зүйл бол төрийн удирдах болон хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа сул байдал юм. МХЕГ, ЦЕГ, ГЕГ болон БОАЖЯ-ны хувьд байгууллага хоорондын хамтын ажиллагаа хязгаарлагдмал байна. Ийнхүү хамтын ажиллагаа сул байгааг бидний судалгааны явцад хийсэн олон ярилцлага, оролцогч талуудын хэлснээр нотлогдож байна. Бас нэг анхаарах, сул тал бол 1). орон нутгаас өгч буй ан агнуурын зөвшөөрөл, 2). СITES-ын импорт, экспортын зөвшөөрөл, 3). зэрлэг амьтны хэрэг дээр хураан авсан бүх эд хөрөнгө болон ангийн зөвшөөрөл, торгуулийн орлогын төвлөрөл, урсгал, урамшуулал зэргийг нэгтгэсэн мэдээллийн сан байхгүй явдал байна.<sup>299</sup>

## Зэрлэг амьтны хууль бус худалдааны эрх зүйн орчин

Өмнөх бүлэг болон хэсгүүдэд сүүлийн арван жилд үзүүлсэн олон төрлийн дэмжлэг тусалцааны хүрээнд зэрлэг амьтны худалдааны менежментийг сайжруулах, хууль бус худалдаатай тэмцэх орчинтой холбоо бүхий эрх зүйн орчныг сайжруулах ажлыг гүйцэтгэж ирлээ. СITES-ын хэрэгжилтийг хангах тусгайлсан хуулийг 2002 онд шинээр, Зөрчлийн тухай хуулийг 2015 онд шинээр батлахын зэрэгцээ Амьтны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль болон Эрүүгийн хууль гэсэн 4 томоохон хуульд мөн шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулав. Тайлангийн энэ хэсэгт дээрх болон бусад өөрчлөлтүүдийн талаар өгүүлж, зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд эрх зүйн системд буй сул болон давуу талуудыг үнэлэн юм.

Энэ бүлгийг дараах үндсэн хоёр хэсэгт хувааж тайлбарлав. Үүнд:

**Эрх зүйн иж бүрэн орчин нөхцөл** – зэрлэг амьтны менежмент болон зэрлэг амьтны эсрэг гэмт хэргийг мөрдөн байцаах, яллах эрх зүйн орчны тухай.

**Зэрлэг амьтны эсрэг гэмт хэргийн тухай**–эрхзүйн баримт бичигт тулгуурласан энэ хэсэг нь зэрлэг амьтны эсрэг гэмт хэрэг, түүний тухай, үндэсний болон олон улсын түвшний агнуур болон худалдаа зэрэгтэй холбоо бүхий эрүүгийн болон захиргааны хариуцлагын тухай тодорхой дурдсан. Энэ хэсэгт мөн цаашид эрх зүйн хувьд сайжруулах шаардлагатай орхигдол, зарим зүйл заалтуудад хийсэн дүн шинжилгээний үр дүнг багтаасан юм.

Монгол Улс нь зэрлэг амьтны худалдааны чиглэлийн хууль эрх зүйн хувьд томоохон ахиц дэвшил гаргасан болохыг дурдах нь ёстой. Нэгэн чухал өөрчлөлт бол 1992 оны Захиргааны хариуцлагын тухай хуулийг орлосон 2015 онд шинээр баталсан Зөрчлийн тухай хууль юм. Энэ хууль нь өмнө нь 220 гаруй хуулиар зохицуулагдаж байсан захиргааны олон төрлийн зөрчил, хариуцлагыг нэгтгэх зорилготой юм. Тус хуулийн нэг бүлэг нь байгаль орчны тухай хуулийн эсрэг зөрчлүүд, мөн Амьтны тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдах тухай хууль зэрэг хуульд хамаарах зөрчлүүдийг тусгажээ. Бусад бүлгүүдэд хууль

298 Оролцогч талтай хийсэн ярилцлага (АТГ).

299 Оролцогч талтай хийсэн ярилцлага (АТГ).



тогтоомжоор заасан зөрчлүүд буюу Гаалийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Авлигатай тэмцэх тухай хууль, Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль зэрэгт хамаарах зөрчлүүдийг хамруулсан. Хууль эрх зүйд энэ өргөн хүрээг хамарсан өөрчлөлт хийснээр захиргааны хариуцлагын тогтолцооны зохистой байдал, ил тод байдлыг сайжруулжээ. Зөрчлийг дахин гаргуулахгүйн тулд бага хэмжээний торгууль ноогдуулж байсан өмнөх хуультай харьцуулбал энэ хуульд торгуулийн хэмжээг нэмэгдүүлсэн юм. Зөрчлийн тухай хуульд зэрлэг амьтантай холбоотой заалтууд орж, тайлбар өгсөн.

Дараагийн нэг томоохон ахиц нь Эрүүгийн хуульд томоохон өөрчлөлт оруулж, зэрлэг амьтантай хамаарал бүхий гэмт хэргийг эрүүгийн хуульд хамруулж, зохион байгуулалттай гэмт хэрэг, аж ахуйн нэгжийн эрүүгийн хариуцлагыг шинээр оруулж, үг хэллэгийг хоёрдмол утгагүй болгожээ. Зэрлэг амьтны хууль бус худалдаатай холбоотой Эрүүгийн хууль тодорхойлсон үйлдлүүдийн талаар дараагийн хэсэгт оруулсан болно.

холбоо бүхий гурван хууль үйлчилж байна. Амьтны тухай хууль нь эрх зүйн орчны үндсэн хэрэглүүр бөгөөд амьтны зүйлийн статус, агнах тоо хэмжээ, хорио болон зөвшөөрөл олгох үйл явц зэргийг тодорхойлсон шүхэр эрх зүйн баримт мөн.

Зураг 16. Зэрлэг амьтны хууль бус худалдааны эрх зүйн орчны схем (2017)



## ЭРХ ЗҮЙН ИЖ БҮРЭН ОРЧИН НӨХЦӨЛ

Сүүлийн жилүүдийн ангийн хорио, хязгаарлалт, эсвэл сүүлийн үед шинээр хэрэгжүүлж буй хууль тогтоомжуудыг оруулахгүйгээр тооцвол өнөөгийн эрх зүйн орчин үндсэндээ 20 гаруй хууль, эрх зүйн баримт бичгээс тогтох бөгөөд мөн тодорхой хугацаагаар гаргадаг ангийн хорио, хязгаарлалт, амьтны агнах тоо хэмжээ зэргээс бүрдэж байна. Эрүүгийн хуулийн 2002 болон 2015 оны хувилбарт дүн шинжилгээ хийсэн шалтгаан нь энэ хуулийн шинэчлэгдсэн сүүдлийн хувилбар нь 2017 оны 7 дугаар сараас буюу бидний судалгаа дууссаны дараахан хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх заалттай байснаас хамаарсан билээ.

Зураг 16-т амьтны агнуур, худалдаатай хамааралтай хууль тогтоомжуудыг дэс дарааллаар байрлуулсан ба Монгол Улсын Үндсэн хуулийг гол цөм болгож, улмаар бусад хамаатай хуулиудыг цогцоор үзүүлэхийг зорьсон.<sup>300</sup>Тус зурагт мөн хуулиудыг зэрлэг амьтны агнуур, худалдаа болон гүйцэтгэх чиг үүргийнх нь дагуу оруулав.

Зэрлэг амьтан агнахтай холбоотой үйл явцын дараалал болон хязгаарлалтуудыг тодорхойлоход Ойн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон Амьтны тухай хууль гэсэн байгалийн нөөцтэй

Зэрлэг амьтны худалдаанд өөр хуулиуд тухайлбал, Зар сурталчилгааны тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль (уламжлалт эмтэй холбоотой), Татварын тухай хууль Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль болон Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай хууль мөн чухал үүргийг гүйцэтгэдэг.

Эрх зүйн орчны дүн шинжилгээ хийхдээ зэрлэг амьтны хамаарал бүхий гэмт хэрэгтэй холбоотой хууль болох Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, мөн зэрлэг амьтны шууд хамааралгүй ч эрх зүйн орчинд багтаж болох Авлигатай тэмцэх хууль, Мөнгө угаахтай тэмцэх хуулийг судлан үзлээ. Хуулийн хэрэгжилт болон хэргийн бүртгэлтэй холбоотой сүүлийн хоёр хуулийг зэрлэг амьтны эсрэг гэмт хэрэгт хэрэглэж байсан туршлага бага. Эдгээр хуулийн хувьд тухайн гэмт хэрэгтэй холбогдох хамаарал практик дээр судлагдаагүй, эдгээрийг хэрэглэж болох тохиолдлын талаар Монгол Улсын болон олон улсын мэргэжилтнүүдийн хийсэн үнэлгээ болон бусад улс орны ижил төсөөтэй хуулийн хэрэглээнд тулгуурлан зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэрэгт ял ноогдуулах тухай зарим дүгнэлтийг таамаглан гаргах боломжтой. Монгол Улсын мөнгө угаах болон авлигатай тэмцэх чиглэлийн хуулиудад зэрлэг амьтан, зэрлэг амьтны хууль бус худалдааны талаар шууд дурдсан зүйл байхгүй. Харин эдгээр хуульд илүү ерөнхий байдлаар тусгагдсан тул онолын

300 2001 Үндсэн хууль, 6 дугаар зүйл.

хувьд хэрэглэх боломжтой бөгөөд мэдээлэгчдийн баталж буйгаар хуулийн хэрэглээнд зэрлэг амьтны хамааралтай гэмт хэргийг багтаан үзэж болох талтай. Энэхүү шалтгааны улмаас тухайн хуулиудыг эрх зүйн орчны шинжилгээнд хамруулав.

Дээрх эрх зүйн орчныг цаг хугацааны дарааллаар нь зураг 17-т харуулсан бөгөөд хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт хийсэн болон хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн хугацааг мөн үзүүлэв. Энэхүү дүрслэл нь анхдугаар “Зэлүүд тал” тайлан гарснаас хойш арван жилийн хугацаанд (2005-2016) эрх зүйн орчинд гарсан чухал ач холбогдолтой өөрчлөлт, хөгжлийг харуулах боломжтой. Ялангуяа хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үндсэн зорилго бүхий 5 хуулийн хувьд бүр ч өндөр ач холбогдолтой. Учир нь эдгээр таван хууль нь өнгөрсөн 10 жилийн хугацаанд батлагдсан, эсвэл нэмэлт өөрчлөлт хийгдсэнээр хууль хэрэгжүүлэгчдэд орчин үеийн эрх зүйн аргачлал, хэрэглүүрийг ашиглан зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах боломжийг нээн өгсөн билээ.

Хүснэгт 10-д эрх зүйн орчны өөр нэгэн судалгааг харуулсан ба хууль тогтоомжууд болон зэрлэг амьтны гэмт хэргийн хамаарлыг үндэслэн хоёр бүлэгт хуваан (ерөнхий болон хамаарах хуулиуд) авч үзлээ. Ингэхдээ хууль зүйн орчин нь ялгаатай олон хуулийг багтаасан онцлог, тухайн хууль, тогтоомж бүр нь зэрлэг амьтны гэмт хэрэгт гүйцэтгэх үүргийн талаарх тайлбарыг хамтатган оруулав.

Бид өмнө дурдсан жагсаалт, диаграммд зэрлэг амьтны хууль бус худалдаатай хамаарах, эсвэл үүнтэй тэмцэхэд ашиглаж болох аль болох олон хэсгийг багтаахыг зорьсон. Системийн бүхий л хэсгийн зургийг оруулснаар олон тооны чиг үүрэгт дэмжлэг үзүүлэх ба ялангуяа мөрдөн байцаах, яллах үйл ажиллагааны стратегийг харгалзан үзэх боломжийг нээж өгөв. Эрх зүйн орчны хувьд ч засаглалын бусад салбарын нэгэн адил мэргэжлийн байгууллага ажиллахдаа өөрсдийн хүлээсэн үүргийн дагуу мэдээллийг зөвхөн өөртөө төвлөрүүлэх хандлага элбэг байдаг. Үүний улмаас мөрдөн байцаалтын үйл ажиллагааг үр дүнд хүргэх, шаардлагатай баримт нотолгоог баталгаажуулахад хэрэглэж болох зарим хууль тогтоомжийг үл ойшоох, эсвэл тухайн боломжуудыг хангалттай хэмжээнд судлан үзэхгүй байх нь элбэг. Тухайлбал, Монгол Улсад CITES-ын жагсаалтад багтсан амьтдын олон улсын худалдааг нягтлахдаа Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай хуульд заасан заалтуудыг (Бүлэг Ш-ийг үзнэ үү) үл харгалзан хуучин Эрүүгийн хуулийн дагуу мөрдөн шалгах, эсвэл хэрэгсэхгүй болгож байжээ.

Судалгаанд хамруулан үзсэн хэд хэдэн хууль тогтоомж, эрх зүйн бусад баримт бичгүүд энэ чиглэлийн бүхий л эрх зүйн орчныг судалсан гэж үзэх үндэслэлгүй. Зэрлэг амьтны гэмт хэргийг мөрдөн шалгахад тодорхой оролцоотой байж болох зарим хууль

тогтоомжууд бидний үнэлгээнд багтаагүй байж болох талтай (Хөдөлмөрийн болон тээврийн тухай хууль тогтоомжууд). Тухайн жагсаалтыг үндэслэлтэй болгох зорилгоор эрх зүйн орчинд нь зэрлэг амьтны талаар шууд дурдсан, эсвэл ямар нэгэн эргэлзээгүйгээр энэхүү асуудлыг зохицуулсан хууль тогтоомжуудыг багтаалаа.

Зураг 17. Монгол Улсын зэрлэг амьтны хууль бус худалдааны эрх зүйн орчны товчоо



Хүснэгт 10. Монгол Улсын зэрлэг амьтны хууль бус худалдааны эрх зүйн орчин, үндсэн болон хамаарах хууль тогтоомжууд

2017

МОНГОЛ УЛС

**ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХУУЛЬ БУС ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Нэр	Он	Эрх зүйн салбар	Зэрлэг амьтны агнуур, худалдаатай хамаарах байдал
<b>ҮНДСЭН ХУУЛЬ ТОГТООМЖУУД</b>			
Амьтны тухай хууль	2012	Байгалийн нөөц	Монгол Улсын Амьтны тухай хууль нь зэрлэг амьтны агнуур болон худалдааг зохицуулсан чухал хууль юм. Уг хууль нь бүхэлдээ зэрлэг амьтны удирдлагатай хамаарах бөгөөд агнах болон худалдахтай холбоотой хэд хэдэн заалт, жишээлбэл, 7 дугаар зүйл "Нэн ховор" амьтны жагсаалт (арилжааны зориулалтаар агнах, худалдаалахыг хориглосон), "Ховор" амьтны жагсаалт, 12 дугаар зүйл дээр эх үүсвэр нь тодорхой зэрлэг амьтны гаралтай түүхий эд материалыг зарж борлуулахыг хориглох тухай зэрэг багтжээ. Амьтны тухай хууль нь нь 2002 оноос өмнө үйлчилж, Ан агнуурын тухай хуулийн оронд хэрэгжиж эхэлсэн.
Ховордсон төрөл зүйлсийн жагсаалтын талаарх ЗГ-ын тогтоол	2012	Байгалийн нөөц	Амьтны тухай хуулийн дагуу хамаарах яам нь "Нэн ховор" амьтны жагсаалтыг гаргаж, зарим зүйл амьтны хамгааллыг өндөрсгөж, агнах болон худалдахтай холбоотой эрэмбийг гаргадаг.
Ан агнуурын квот тогтоох тухай тушаал	Жил тутмын	Байгалийн нөөц	БОАЖЯ нь жил тутам агнах амьтны тоо хэмжээг гаргадаг. Энэ судалгаа нь 2010, 2012 болон 2014- 2016 онд энэ чиглэлээр гаргасан шийдвэрийг авч үзсэн.
Түр хугацааны агнуурын хорио, хязгаарлалт	Олон янз	Байгалийн нөөц	Сүүлийн жилүүдэд төрийн олон байгууллагууд агнуурт бүтэн болон хэсэгчилсэн байдлаар хориг тавьж ирлээ. Энэхүү судалгааны хүрээнд тарвага, аргаль, саарал чоно болон үнэг зэргийг агнахыг хориглосон долоон баримт бичгийг олж судлав.
Ан агнуурын нөөцийн ашиглалт, төлбөрийн тухай хууль	1995	Байгалийн нөөц; Санхүү	Энэ хууль нь агнуурын зөвшөөрлийн төлбөрийг шаардлагуудыг тогтоож, агнуурын үйл ажиллагаанд мониторинг хийх, мэдээллийн сан бүрдүүлэх арга хэмжээг зохицуулдаг.
Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	2000	Байгалийн нөөц; Санхүү	Тус хуулиар агнуурын зөвшөөрлөөс төвлөрсөн хөрөнгийг байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд хэрхэн зарцуулах тухай асуудлыг зохицуулдаг.
<b>ХАМААРАХ ХУУЛЬ ТОГТООМЖУУД</b>			
Үндсэн хууль	2001	Үндсэн хуулийн эрх зүй	Монгол улсын үндсэн хуульд зэрлэг амьтантай шууд хамаарах нэг заалт байгаа нь 1 дүгээр бүлгийн 6 дугаар зүйл дээр амьтан, ургамал нь төрийн хамгаалалтад байх тухай юм.
Ховордсон амьтан, ургамал болон тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль	2002	Худалдаа	Монгол Улсад олон улсын зэрлэг амьтны худалдааг удирдах чиглэлээр CITES-ын хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулдаг. Тиймээс тус хууль нь бүхэлдээ зэрлэг амьтны худалдаатай шууд хамааралтай. Гурван хэсгээс бүрдэх энэ хуулинд нэгдүгээрт хуулийн хамрах хүрээг заасан бүлэг, хоёрдугаарт Монгол Улсад зэрлэг амьтны худалдааг хэрхэн удирдах болон хамаарах тухай заасан бүлэг, гуравдугаарт ямар амьтанд хязгаарлалт хамаарах тухай заажээ.
Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль	1994	Байгалийн нөөц	Тусгай хамгаалалттай газар нутгуудын төрөл, зарим амьтны ашиглалтыг бүрэн хорьсон, эсвэл ямар нэгэн байдлаар хязгаарласан дотоод бүсүүдийг тогтоосон.
Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай УИХ-ын 18 дугаар тогтоол	2011	Байгалийн нөөц	Шинээр тусгай хамгаалалттай газар нутаг байгуулах, газар нутгуудын хил хязгаарыг шинэчлэх тухай энэ тогтоолыг эрх зүйн орчны шинжилгээнд хамруулсан шалтгаан нь тухайн газар нутгууд дахь агнуурын эрх зүйд нөлөө үзүүлдэгтэй холбоотой.
Ойн тухай хууль	2012	Байгалийн нөөц	Ойн тухай хуульд зэрлэг амьтны агнууртай холбоотой хоёр заалт бий. Тус хуулийн 18.2.14-д сумын Засаг даргад агнуурын зөвшөөрөл олгох эрхийг өгсний зэрэгцээ шаардлагатай үед энэ чиглэлийн үйл ажиллагааг хориглох, хязгаарлах санал гаргах эрхийг мөн заажээ. Хуулийн 29.7-д ойн сан бүхий газарт зохих зөвшөөрөлгүй ан хийх нь хууль зөрчсөн хэрэг болохыг бичжээ.
Байгаль орчныг хамгаалах тухай хууль	2005	Байгаль орчин	Монгол улсад хэрэгжиж буй байгаль орчныг хамгаалах тухай энэ ерөнхий хууль нь ихэнх төрлийн байгалийн нөөцийн менежментийн зарчмуудыг тогтоосны дотор зэрлэг амьтны менежмент ч мөн багтжээ. Тус хуульд зэрлэг амьтны холбоотой хэд хэдэн зүйл, заалт буйгаас 4 дүгээр зүйл болох байгалийн нөөцийн хууль бус ашиглалт, хор хохирол болон гэм хорын талаар мэдээлэх иргэдийн эрх; 15 дугаар зүйл болох зэрлэг амьтны нөөцийн ашиглалтыг хязгаарлахтай холбоотой төрийн бүрэн эрх; 17, 18 дугаар зүйл болох байгалийн нөөц ашиглах тусгай зөвшөөрөл олгох орон нутгийн Засаг даргын бүрэн эрх; 19 дүгээр зүйл буюу нэн ховор амьтныг агнах, барих, ургамлыг бэлтгэж ашиглахыг хориглох, нэн ховор, ховор амьтан, ургамлыг Монгол Улсын Улаан номд бүртгэж хамгаалах үүрэг зэргийг заасан.
Байгаль орчны талаар авах арга хэмжээний тухай тушаал	2005	Байгаль орчин	Уг тушаал нь зэрлэг амьтны худалдаатай холбоотой нэг зүйлийг багтаасан. Энэ тушаалын 1 дүгээр хэсэгт Засгийн газраас зэрлэг амьтны гаралтай бараа, бүтээгдэхүүнийг хууль бусаар түгээхтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тухай заасан. Эдгээр зэрлэг амьтдад мазаалай, хавтгай, цоохор ирвэс, буга, хүдэр, бөхөн, зээр болон ховордсон ургамлын зүйл хамаарна.

Зар сурталчилгааны тухай хууль	2002	Хэвлэл мэдээлэл, худалдаа	Монгол Улсын Зар сурталчилгааны тухай хуульд зэрлэг амьтны худалдаатай холбоотой нэг заалт байна. Тус хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт зааснаар "Амьтан, ургамлын ховор, нэн ховор зүйл, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх, худалдаалах болон худалдан авах" үйл ажиллагааг сурталчлахыг хориглоно. Тухайн зүйлийн 2 дугаар хэсэгт агнахыг хориглосон зэрлэг амьтны эд, эрхтнийг борлуулах болон худалдан авахыг сурталчлахыг мөн хоригложээ.
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль	2013	Санхүү; Эрүүгийн эрх зүй	Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд зэрлэг амьтны хууль бус худалдаатай шууд хамаарах заалт байхгүй ч энэ хуульд олон гэмт хэргийн суурь нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тухай хэрэг хэмээн үздэг. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа нь зэрлэг амьтны хууль бус худалдаатай хавсарч буй бүхий л тохиолдолд энэхүү хуулийг хэрэглэнэ.
Гаалийн тариф гаалийн татварын тухай хууль	2008	Худалдаа; Санхүү;	Зэрлэг амьтантай хамаарах гурван заалт бий. 3.1.1 дүгээр зүйл дээр амьтан, ургамлыг "бараа" хэмээх тодорхойлсон тодорхойлолт, 209 дүгээр зүйл дээр ховордсон амьтан, ургамал болон хамаарах бүтээгдэхүүнийг" устгалд оруулж болохгүй бараа гэж, 246.5 дугаар заалт дээр гаалийн ажилтан нь амьтан агуулсан бараа бүтээгдэхүүнийг мэдүүлсэн этгээд байхгүй үед ч шалгаж болох тухай заажээ.
Татварын хууль	2008	Санхүү	Татварын ерөнхий хуульд зэрлэг амьтны худалдаанд хамаарах хэд хэдэн зүйл, заалт байгаагаас 5.7 дугаар зүйл дээр ой болон ургамлын нөөцийн ашиглах, мөн ан амьтныг агнах замаар олсон орлогод ноогдуулах татварыг, 7.4 дүгээр зүйлд дараах орон нутгийн татваруудыг тогтоожээ. Үүнд: байгалийн ургамал ашигласны төлбөр (7.4.8), ан агнуурын нөөц ашигласны болон агнуурын зөвшөөрлийн төлбөр (7.4.10) болон галт зэвсгийн татварыг (7.4.13) заасан.
Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль	2010	Эрүүл мэнд	Эл хуульд зэрлэг амьтны худалдаанд хамаарах хоёр заалт багтсан нь 3 дугаар зүйл дээр "Уламжлалт эмийг" хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх зорилгоор тодорхой тун, хэмжээгээр хэрэглэдэг, уламжлалт анагаах ухааны жорын дагуу ургамал, амьтан, эрдсийн гаралтай бодис болон үнэт эрдэнэс оруулан уламжлалт болон үйлдвэрийн аргаар бэлдсэн байгалийн гаралтай бүтээгдэхүүн хэмээн тодорхойлсны зэрэгцээ 16 дугаар зүйлд уламжлалт бус эмийг эмийн сангаар худалдаалахаар заасан ч уламжлалт эм дээр ямар нэгэн шаардлага тавиагүй.
Эрүүгийн хууль	2015	Эрүүгийн эрх зүй	Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга 2015 онд батлагдсан ба улмаар 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Тус хуульд тусгай хамгаалалттай газар нутгуудад зэрлэг амьтан агнах, хавхдахыг, мөн нэн ховор болон ховор амьтныг агнах болон худалдаалахыг бүрэн хоригложээ. Бусад заалтуудын хувьд хориотой бараа бүтээгдэхүүн худалдаалах (зэрлэг амьтан мөн хамаарна), авлига, мөнгө угаалт зэргийг хамруулжээ. Дээрх тохиолдол бүрт гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, эсвэл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэмт хэрэгт илүү өндөр торгууль, эрүүгийн хариуцлага ноогдуулах тухай заажээ.
Эрүүгийн хууль	2002	Эрүүгийн эрх зүй	2015 онд шинэчилсэн найруулга, 2017 онд нэмэлт өөрчлөлт хийгдсэн. 2002 оны Эрүүгийн хуулийг зэрлэг амьтны худалдааны хууль эрх зүйн орчинд багтаасан бөгөөд тухайн хууль нь 2016 оны эцэс хүртэл хүчин төгөлдөр хэрэгжсэн юм. Тус хуульд эрүүгийн гэмт хэргийн үндэслэлийг тогтоосон хоёр зүйл байгаа нь зэрлэг амьтны хууль бус худалдаанд эрүүгийн хариуцлага ноогдуулах тухай 175 болон 203 дугаар зүйл байна.
Зөрчлийн тухай хууль	2015	Эрүүгийн эрх зүй	Энэхүү хууль нь 1992 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр батлагдсан Захиргааны хариуцлагын тухай хуулийг орлон хэрэгжиж байна. Тус хуульд өмнө нь 220 өөр хуульд зааж байсан зөрчлүүдийг нэгтгэн оруулсан. Тухайн үйлдэл нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогдохгүй тохиолдолд Зөрчлийн тухай хууль хэрэгжинэ. Тус хуульд зэрлэг амьтны холбоотой хэд хэдэн заалт бий. Үүнд: CITES-ын жагсаалтад орсон зүйлийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой 6.3-р зүйл; зөвшөөрөлгүй агнах, тусгай зөвшөөрөл, гэрээ болон гэрчилгээ шилжүүлэх, гэрээнд заасан тооноос илүү тоогоор амьтан агнах, хориглосон газарт агнах, хориотой арга ашиглах, зөвшөөрөлгүйгээр худалдах болон худалдан авахтай холбоотой 6.6 дугаар зүйл, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг зөрчих явдлыг хамруулсан 6.16 зүйл зэрэг болно.
Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль	2001	Эрүүгийн эрх зүй	Энэ хуульд зэрлэг амьтны хууль бус худалдаатай холбоо бүхий хоёр заалт бий. Тус хуулийн 26 дугаар зүйлд хилийн тагнуулын алба нь хууль бус эд зүйлсийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхтэй тэмцэх чиг үүргийг гүйцэтгэхийг заасан бол 27 дугаар зүйлд Тагнуулын ерөнхий газар нь Монгол Улсын хилээр хууль бус эд зүйлс нэвтрүүлсэн хэргийг мөрдөн байцаах эрх бүхий байгууллага болохыг тодорхойлжээ.
Авлигатай тэмцэх тухай хууль	2006	Эрүүгийн эрх зүй	Авлигатай тэмцэх тухай хуульд зэрлэг амьтан агнах болон худалдаалахтай холбоотой зүйл, заалтууд байхгүй. Гэхдээ энэхүү хуулиар төрийн алба дахь авлигын асуудалд хяналт тавих, мөрдөн шалгах эрх бүхий Авлигатай тэмцэх газрыг байгуулжээ. Авлига нь зэрлэг амьтны худалдаанд ч мөн хамаарч, энэ чиглэлээр хийгдэх хяналт, шалгалт нь зэрлэг амьтны худалдаатай холбоотой болохыг тусгасан.



үндэслэн агнуурыг хязгаарлах, эсвэл зөвшөөрөл олгодог. Жагсаалтад буй амьтад өөрчлөгдөж байдаг онцлогтой ч<sup>306</sup> эрх зүйн зохицуулалтын хэлбэр нь хэвээр байдаг. “Нэн ховор” амьтны жагсаалтыг шууд хуулиар зааж<sup>307</sup>, хамгийн өндөр түвшинд хамгаалдаг бөгөөд зөвхөн судалгааны зорилгоор ашиглах боломжтой. “Ховор” амьтны жагсаалт болон хамаарах агнуурын журмыг тусад нь Засгийн газраас тогтоодог.<sup>308</sup> Эцэст нь “Агнуурын амьтны” зохицуулалтын орчныг шууд Амьтны тухай хуульд заадаг ба үүнд агнуурын улирлыг тусгадаг ч амьтны тоо хэмжээг заадаггүй.<sup>309</sup> Энэ нь Амьтны тухай хуульд орсон шинэ зохицуулалт бөгөөд үүнийг 2002 оноос хойш хэрэгжиж байсан ан агнуурын тухай хуулийн оронд хэрэглэгдэж байна.

Шинээр баталсан Зөрчлийн тухай хуульд зэрлэг амьтны зүйлд шууд хамааралтай заалт байхгүй ч зарим зүйл, заалтууд ерөнхийдөө бүхий л зэрлэг амьтанд ижил хэрэглэгдэхээр байна. Гэхдээ зарим талаар тус хууль нь зарим амьтанд хамаарч болох ч Эрүүгийн хуулиар заагдаагүй зүйлд л хэрэглэгдэх боломжтой. Эрүүгийн хуулиар “Нэн ховор” амьтны жагсаалтад орсон бүх зүйлийн агнуур болон худалдаанд илүү өндөр хэмжээний торгууль, хатуу шийтгэл ноогдуулдаг. “Ховор” зүйлийн жагсаалтад багтсан амьтны хувьд тусгайлан заасан эрүүгийн гэмт хэргийн заалт нь агнах, хавхдах, худалдан авах, борлуулах, боловсруулах, тээвэрлэх болон экспортлох үйлдлүүд багтана.<sup>310</sup> “Нэн ховор” болон “Ховор” зүйлийн хувьд хүлээх хариуцлага нь бараг ижил бөгөөд ялгаатай заалт нь “Хадгалах”, “Амьдрах орчныг алдагдуулах” болно.<sup>311</sup> Ховор амьтны хувьд торгуулийн доод хэмжээ нь 5,400 нэгж (5.4 сая төгрөг), дээд хэмжээ нь 27,000 нэгж (27 сая төгрөг), мөн 1-5 жил хугацаагаар баривчлах, 1-5 жил хорих ял ноогдуулахаар заажээ. Нэн ховор амьтан дээр торгуулийн доод хэмжээ 10,000 нэгж (10 сая төгрөг), дээд хэмжээ нь 40,000 нэгж (40 сая төгрөг) эсвэл 2-8 жил хүртэл хорих ял ноогдуулах бөгөөд баривчлах ял ноогдуулаагүй.

## ГАЗАР НУТАГТ СУУРИЛСАН ГЭМТ ҮЙЛДЭЛ

Газар нутагт суурилсан зэрлэг амьтны агнуур, худалдаа нь зохицуулалтын өөр нэгэн түгээмэл хандлага юм. Тодорхой газар зүйн бүс (зураг дээр хил хязгаарыг нь тогтоох), эсвэл ерөнхийлөн тодорхойлсон орчин буюу амьдрах орчноор тогтоон хэрэгжүүлнэ. Аль ч тохиолдолд зэрлэг амьтныг агнах болон худалдаалах үйл явц нь тухайн зүйлийн статусаас үл хамааран агнуурын бүс нутагт хийгдэнэ. Энэхүү арга нь давуу талуудтай. Агнуурын хязгаарлалт хийхдээ тодорхой нутагт амьдарч буй амьтны зүйл болон тоо толгойгоос

хамааруулан, нийцүүлэх боломжтой. Зэрлэг амьтны тоо толгой газар нутаг бүрт ижил байдаггүй. Газар нутагт суурилсан менежментийн горим нь тодорхой газар нутаг дахь амьтны тоо толгой, түүний чиг хандлагаас хамааран өөрчлөгдөх боломжтой. Газар нутагт суурилсан худалдаа нь хууль бус агнуурын хяналт болон хууль сахиулах үйл ажиллагааг илүү удирдах боломжийг бүрдүүлнэ. Газар нутгийн хэмжээнээс хамаарсан хориг хязгаарлалт нь харьцангуй цөөн зүйл болон бага газар нутгийг хамрах учир байгаль хамгаалагчдын ажлыг хөнгөлдөг.

Монгол Улс нь орон нутагт суурилсан агнуур зохион байгуулах аргачлалыг ашиглан зэрлэг амьтны менежментийн арга хэмжээг хэрэгжүүлж байна. Жишээлбэл, Монгол Улсын бүх тусгай хамгаалалттай газар нутагт агнуур зохион байгуулахыг хориглосон бөгөөд зөвхөн нэг байгалийн цогцолборт газар хувийн хэрэгцээнд зориулан загас барихыг зөвшөөрч байна.<sup>312</sup> Амьтны тухай хуульд газар нутагт суурилсан хэд хэдэн аргачлал тусгасан бөгөөд тусгайлан заасан ангийн бүсийг тогтоох;<sup>313</sup> түр хугацааны ангийн хориог тодорхой газруудад тавих; өөрийн хамаарах нутаг дэвсгэрт орон нутгаас агнуурыг хориглох; түүнчлэн ангийн бүс нутгуудад зэрлэг амьтны үнэлгээ хийх, тоо хэмжээг тогтоох зэрэг багтаж байна.<sup>314</sup>

Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд газар нутагт суурилан хийгддэг гэмт үйлдэл болон хүлээлгэх хариуцлагын талаар тусгажээ. Зөрчлийн тухай хуульд 1). Монгол Улсад хилийн бүсэд мөрдөгдөх ан агнуурын журмыг зөрчих<sup>315</sup> болон 2). агнуур хийхийг зөвшөөрсөн газраас бусад газарт ан хийх<sup>316</sup> зэрэг үйлдлийг тусгажээ. Хилийн бүсэд ан хийсэн тохиолдолд ноогдуулах шийтгэл нь хувь хүнд 50 нэгжтэй (50,000 төгрөг) тэнцэх хэмжээний торгууль ноогдуулах, хэрэв тухай гэмт үйлдлийг хуулийн этгээд үйлдсэн бол энэхүү хэмжээг арав дахин нэмэгдүүлэн 500 нэгжтэй (500,000 төгрөг) тэнцэх торгууль ноогдуулахаар заажээ. Зөвшөөрсөн газраас бусад газарт ан хийх тохиолдолд ноогдуулах торгууль нь 6 дахин өндөр буюу хувь хүнд 150 нэгж, аж ахуйн нэгжид 6 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгуультай байна. Тусгай хамгаалалттай газар нутагт буудсан, хавхдах болон бусад аргаар аргаар агнасан бол Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн дагуу 5,400 - 27,000 нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль ноогдуулж байна.<sup>317</sup> Үүнтэй ижил үйлдэл нь мөн 1-5 жил баривчлах, эсвэл 1-5 жил хорих хүртэл ялтай. Өмнө дурдсанчлан энэ хэсэгт аж ахуйн нэгжүүдэд эрүүгийн хариуцлага ноогдуулсан заалт байхгүй.

306 2012 оны Амьтны тухай хууль нь анхлан 2000 онд тодорхойлсон жагсаалтад олон өөрчлөлт оруулжээ.

307 Амьтны тухай хууль 7.1. 2012 онд нэмэлт өөрчлөлт хийгдсэн.

308 Амьтны тухай хууль 7.6. 2012 онд нэмэлт өөрчлөлт хийгдсэн.

309 Амьтны тухай хууль 9.

310 Эрүүгийн хууль. 24.5.1, 2017 онд нэмэлт өөрчлөлт хийгдсэн.

311 Мөн тэнд. Зүйл 24.5.2.

312 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль. 16(2), 2012.

313 Амьтны тухай хууль. 4.1.9, 2012.

314 Амьтны тухай хууль. 5, 2012.

315 Зөрчлийн тухай хууль. 16.11.

316 Зөрчлийн тухай хууль. 6.6.3.

317 Зөрчлийн тухай хууль. 6.6.6.

## АГНАХ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ХОРИО ЗӨРЧИХ

Тогтоосон агнах тоо хэмжээ болон хориог зөрчих нь Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан өөр төрлийн гэмт үйлдэл хэмээн тооцогдоно. Эдгээр хуулиар заасан хариуцлагын үндэслэлийг Амьтны тухай хууль, Засгийн газар болон БОАЖЯ-ны гаргасан тогтоол, журамд заасан байдаг. Ан агнуурын хориог Амьтны тухай хуулийн 7.1 дээр тусгаж, нийт 30 зүйлийн амьтныг “Нэн ховор”;<sup>318</sup> зүйлийн жагсаалтад багтааж, зөвхөн судалгаа шинжилгээний зориулалтаар агнахыг зөвшөөрсөн бол 7.3 дугаар зүйл дээр эдгээр амьтныг агнах, худалдаалах бүхий л хэлбэрийг бүрэн хоригложээ. Эрүүгийн хууль нь мөн энэ төрлийн гэмт хэрэгт доод тал нь 10,000 нэгжтэй тэмцэх, дээд тал нь 40,000 нэгжтэй торгууль (20 сая төгрөг болон 80 сая төгрөг), эсвэл 2- 8 хүртэл жил хорих ял ноогдуулж байна.

Бусад төрлийн амьтны хувьд хорио нь тодорхой амьтан, эсвэл газар нутгийг хамран түр хугацаагаар тавигддаг. Жишээлбэл, 2012 онд чоно агнахад тавьсан хорио нь зөвхөн гурван аймгийн тодорхой сумдыг хамарч, нэг жилийн хугацаатай байв. Боломжит мэдээ, баримтаас авч үзвэл тарвага, чоно, аргаль зэрэг нь ийм төрлийн хориотой амьтад байна. Зөрчлийн тухай хуулиар хорио зөрчих үйлдлийг тусгайлан заагаагүй. Харин тус хууль нь “Бусад бүх хориглосон” зүйлсийг агнах тохиолдолд торгууль ноогдуулахаар заасан.<sup>319</sup> Ангийн тогтоосон хугацаа зөрчих нь тусдаа зөрчил хэмээн тооцогдоно. Дээрх гэмт хэрэгт ноогдуулах хариуцлагын хувьд хувь хүмүүсийг 150 нэгжтэй (150,000 төгрөг) тэнцэх хэмжээний мөнгөөр, аж ахуйн нэгжийг 1,500 нэгжтэй тэнцэх хэмжээний мөнгөн торгууль (1,5 сая төгрөг) ноогдуулдаг. Зөрчлийн тухай хуулиар баривчлах болон хорих ял ноогдуулахаар заагаагүй.

Амьтны тухай хуульд заасан хязгаарлагдмал нөхцөлд агнуурын тоо хэмжээг тогтоох арга хэрэглэдэг.<sup>320</sup> Энэ нь агнах тоо хэмжээг илүү өргөн хүрээнд, олон төрлийн амьтанд хамааруулсан 2000 оны Амьтны тухай хууль болон мөн оны Ан агнуурын тухай хуулиас ялгаатай юм. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар тухайн амьтны зүйлээс хамааран хувийн болон өрхийн хэрэгцээнд зориулан агнахыг хязгаарлаж,<sup>321</sup> Засгийн газарт загасчлах бүсүүдийг тухайн орон нутаг бүрээр тогтоох эрхийг олгодог. Агнах амьтны тоо хэмжээний тухай заасан ганц тохиолдол нь гэрээгээр заасан агнуур, хавхдах хязгаарыг зөрчсөн хэмээх заалт юм.<sup>322</sup> Хуулиар загасчлахтай холбоотой ижил үйлдэлд ямар нэгэн шийтгэл ноогдуулаагүй. “Бусад хориглосон хугацаанд” хамаарах заалтын хувьд гэрээгээр заасан хязгаараас хэтрүүлэхэд ижил түвшний хариуцлага тооцож байна.

318 Жагсаалтад 31 зүйлс багтсан.

319 Зөрчлийн тухай хууль. 6.6.2.

320 Амьтны тухай 26. 2012.

321 Амьтны тухай хууль 28. 2012.

322 Зөрчлийн тухай хууль. 6.6.2.

## ХОРИОТОЙ ҮЕД АГНАХ

Амьтны тухай хуулиар зарим улиралд ан агнуурыг хориглоно. 2006 оны “Зэлүүд тал” тайлан нь энэхүү заалтын хэрхэн хэрэгжүүлж буйтай холбоотой хоёр асуудлыг гаргажээ. Үүний нэг нь ангийн улирлыг тогтоохдоо зарим амьтныг тодорхойлсон байдал нь бүдэг, ойлгомжгүй байсан. Тодорхой зүйлээр бус ерөнхий өрлийн хэмжээнд тодорхойлжээ. Нөгөө асуудал нь хуульд заасан ан агнуурын зөвшөөрөгдсөн улирал нь тухайн зүйлийн тоо толгойн хэлбэлзлээс хамаараагүй хатуу тогтоосон.

Одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй Амьтны тухай хуульд ч дээрхийн адил заалт бий. Жишээлбэл, “Нугас, галуу болон усны шувуу” хэмээн ерөнхийлжээ. Гэхдээ өмнөх хуульд агнуурын нийт улирлын тоо нь 13 байсныг 23 болгон нэмсэн нь амьтны зүйл бүрээр тогтоох хандлагыг сайжруулсан. Ийнхүү илүү тодорхой заах болсон нь хууль сахиулах байгууллагын ажилтнууд тэр хэмжээгээр амьтны зүйлийг тодорхойлох болон хамаарах хугацааны талаар сургалтад байнга хамрагдах ёстойг шаардаж байна.

Агнуурын зөвшөөрсөн хугацааг зөрчин амьтан агнах үйлдэлд Зөрчлийн тухай хуулиар хувь хүмүүст 150 нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль (300,000 төгрөг), аж ахуйн нэгжид 1,500 нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль (3 сая төгрөг) ноогдуулахаар заажээ.

Хүснэгт 12. Ангийн болон загасчлалын улирлын эхлэх болон дуусах хугацаа

МОНГОЛ УЛС

Ахуйн болон тусгай зориулалтаар ан болон загасчлал хийх зөвшөөрөл эхлэх болон дуусах хугацаа

Дуусах хугацаа

Эхлэх хугацаа

ХӨХТӨН	Төрөл	Хүрээлэн	Улирлын эхлэх болон дуусах хугацаа	
			Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
ХӨХТӨН	Аргаль хонь (угалз)	<i>Ovis ammon</i>	07-08-09-р сар	
	Аргаль хонь	<i>Ovis ammon</i>	08.20-10.20	
	Янгир ямаа (тэх)	<i>Capra sibirica</i>	07.14-10.16	
	Янгир ямаа	<i>Capra sibirica</i>	08.20-10.20	
	Хар сүүлт зээр (ооно)	<i>Gazella subgutturosa</i>	09-10 сар	
	Хар сүүлт зээр	<i>Gazella subgutturosa</i>	07.15 - 10.15	
	Халиун буга (эр)	<i>Cervus elaphus</i>	07 - 08 - 09 сар	
	Халиун буга	<i>Cervus elaphus</i>	06.20 - 10.20	
	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>	09-10-11 сар	
	Зэрлэг гахай	<i>Sus scrofa</i>	09-10-11 сар	
	Бор гөрөөс	<i>Capreolus pygargus</i>	09-10-11 сар	
	Ойн булга	<i>Martes zibellina</i>		11.20 - 02.11
	Хадны суусар	<i>Martes foina</i>		11.20 - 02.11
	Америк усны булга	<i>Neovison vison</i>		11.20 - 02.11
	Шилүүс мий	<i>Lynx lynx</i>		11.20 - 02.11
	Нохой зээх	<i>Gulo gulo</i>		11.20 - 02.11
	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>		11.20 - 02.11
	Хярс үнэг	<i>Vulpes corsac</i>		11.20 - 02.11
	Бараан хэрэм	<i>Sciurus vulgaris</i>		11.20 - 02.11
	Ойн солонго	<i>Mustela sibirica</i>		11.20 - 02.11
	Өмхий хүрэн	<i>Mustela eversmanni</i>		11.20 - 02.11
	Хотны үен	<i>Mustela nivalis</i>		11.20 - 02.11
	Цагаан үен	<i>Mustela erminea</i>		11.20 - 02.11
	Мануул мий	<i>Otocolobus manul</i>		11.20 - 02.11
	Чандага	<i>Lepus timidus</i>		11.20 - 02.11
	Бор туулай	<i>Lepus tolai</i>		11.20 - 02.11
	Урт сүүлт зурам	<i>Spermophilus undulatus</i>	08.20- 10.16	
Тарвага	<i>Marmota spp.</i>	08.20- 10.16		
Заарт ондоотор	<i>Ondatra zibethicus</i>		11.15 - 1 сар	
Халздай дорго	<i>Meles leucurus</i>		2-р сараас - 11-н сарын 15	

ШУВУУ	Төрөл	Хүрээлэн	Улирлын эхлэх болон дуусах хугацаа	
			Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
ШУВУУ	Идлэг шонхор	<i>Falco cherrug</i>	06.20 - 11.15	
	Цармын бүргэд	<i>Aquila chrysaetos</i>	10-р сар	
	Шивэр хөтүү	<i>Tetrastes bonasia</i>		11-н сар - 3.15
	Дагуур ятуу	<i>Perdix dauurica</i>		11-н сар - 3.15
	Эрээн хавиргат хахилаг	<i>Alecton chukar</i>		11-н сар - 3.15
	Монгол ногтруу	<i>Syrhaptes paradoxus</i>		11-н сар - 3.15
	Хар хур	<i>Lyrurus tetrix</i>		11-н сар - 3.15
	Эгэр сойр	<i>Tetrao urogallus</i>		11-н сар - 3.15
	Галуу (бүгд) <sup>(1)</sup>	<i>Anser</i>	4.1 -20	09.01 - 10.20
	Модны анхир	<i>Dendrocygna javanica</i>	4.1 -20	09.01 - 10.20
	Хондон ангир	<i>Tadorna ferruginea</i>	4.1 -20	09.01 - 10.20
	Анхидал ангир	<i>Tadorna tadorna</i>	4.1 -20	09.01 - 10.20
	Хун (бүгд) <sup>(2)</sup>	<i>Cygnus</i>	4.1 -20	09.01 - 10.20
	Нургын сойр	<i>Tetrao urogalloides</i>	4.1 -20	09.01 - 10.20

ЗАГАС	Төрөл	Хүрээлэн	Улирлын эхлэх болон дуусах хугацаа	
			Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
ЗАГАС	Дархадын цагаан загас	<i>Coregonus lavaretus pidsch</i>	10.20 - 7-н сар	
	Тул загас	<i>Hucho taimen</i>	06.15 - 10-н сар	
	Амарын хөвчигас	<i>Hemiculter leucisculus war</i>	08.15 - 05.15	
	Байгалийн Омуйль	<i>Coregonus migratorius</i>	11-н сараас 8-р сар	
	Зарам загас	<i>Coregonus peled</i>	2 сараас 11.5	
	Алтайн сугас	<i>Oreoleuciscus potanini</i>	9-н сараас 6.15	
	Бусад загас			6.15 - 3 сар

(1) Бор галуу-*Anser anser*; Манхин галуу-*Anser albifrons*; Одой галуу-*Anser erythropus*; Буурал галуу-*Anser fabilis*; Хээрийн галуу-*Anser indicus*; Хошуу галуу-*Anser cygnoides* зэрэг шувууд

(2) Хуруут хун-*Cygnus olor*; Гангаар хун-*Cygnus Cygnus*; Гунгаар хун-*Cygnus columbianus* зэрэг шувууд



### Хүснэгт 13. Хууль бусаар “агнахтай” холбоотой хэрэг зөрчлүүд

2017

Монгол улс

## ХУУЛЬ БУСААР АГНАХ ГЭМТ ҮЙЛДЭЛ БА ТОРГУУЛЬ ШИЙТГЭЛ

	ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ НӨХӨН ТӨЛБӨР	ЗАХИРГААНЫ ТОРГУУЛЬ (2,000 ТӨГРӨГИЙН НЭГЖЭЭР)		ЭРҮҮГИЙН		ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ	
		ИРГЭНД	ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД	БАРИВЧЛАХ (Сараар)	ХОРИХ (Сараар)	ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ	ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
<b>АГНАХ</b>							
<b>БАРИМТ БИЧИГ</b>							
1		75 буюу түүнээс дээш	750 буюу түүнээс дээш			Зүйл. 6.6.1.	
2		150 буюу түүнээс дээш	1,500 буюу түүнээс дээш			Зүйл. 6.6.2.	
3		75 буюу түүнээс дээш	750 буюу түүнээс дээш			Зүйл. 6.6.1.	
4		75 буюу түүнээс дээш	750 буюу түүнээс дээш			Зүйл. 6.6.1.	
5		150 буюу түүнээс дээш	1,500 буюу түүнээс дээш			Зүйл. 6.6.2.	
6		150 буюу түүнээс дээш	1,500 буюу түүнээс дээш			Зүйл. 6.6.2.	
7		150 буюу түүнээс дээш	1,500 буюу түүнээс дээш			Зүйл. 6.6.2.	
<b>ГАЗАР НУТАГТ СУУРИЛСАН</b>							
8		25 буюу түүнээс дээш	250 буюу түүнээс дээш			Зүйл. 16.11	
9	Тийм	150 буюу түүнээс дээш	1,500 буюу түүнээс дээш			Зүйл. 6.6.3	
10		5,400 буюу 27,000		12- оос 60	12- оос 60		Зүйл. 24.5.1
<b>УЛИРАЛ</b>							
11	Тийм	150 буюу түүнээс дээш	1,500 буюу түүнээс дээш	12- оос 60	12- оос 60	Зүйл. 6.6.3.	
12	Тийм	150 буюу түүнээс дээш	1,500 буюу түүнээс дээш	12- оос 60	12- оос 60	Зүйл. 6.6.3.	
<b>АРГА ХЭРЭГСЭЛ</b>							
13	Тийм	150 буюу түүнээс дээш	1,500 буюу түүнээс дээш			Зүйл. 6.6.3.	
14		150 буюу түүнээс дээш	1,500 буюу түүнээс дээш			Зүйл. 6.6.2.	
<b>ЗҮЙЛД СУУРИЛСАН</b>							
15		5,400 буюу 27,000		12- оос 60	12- оос 60		Зүйл. 24.5.1
16		10,000 буюу 40,000			24- өөс 96		Зүйл. 24.5.2.
<b>БАРИХ</b>							
17		5,400 буюу 27,000		12- оос 60	12- оос 60		Зүйл. 24.5.1
18		75 буюу түүнээс дээш	750 буюу түүнээс дээш			Зүйл. 6.6.1.	
19		75 буюу түүнээс дээш	750 буюу түүнээс дээш			Зүйл. 6.6.1.	
20		150 буюу түүнээс дээш	1,500 буюу түүнээс дээш			Зүйл. 6.6.2.	
21		150 буюу түүнээс дээш	1,500 буюу түүнээс дээш			Зүйл. 6.6.2.	
22		5,400 буюу 27,000		12- оос 60	12- оос 60		Зүйл. 24.5.1
23		10,000 буюу 40,000			24- өөс 96		Зүйл. 24.5.2.
<b>ЗАГАСЧЛАХ</b>							
24		250 буюу түүнээс дээш				Зүйл. 6.6.16.	
25		150 буюу түүнээс дээш				Зүйл. 6.6.2.	
26		150 буюу түүнээс дээш				Зүйл. 6.6.2.	
27		150 буюу түүнээс дээш				Зүйл. 6.6.2.	

## ХУУЛЬ БУС ХУДАЛДААНЫ СҮЛЖЭЭНИЙ ГЭМТ ХЭРГҮҮД

Зэрлэг амьтны хууль бус худалдаанд энэ төрлийн гэмт хэргийг онцгойлон анхаарч, хэд хэдэн үйлдэлд Монгол Улсын хуулиар торгууль болон эрүүгийн хариуцлага ноогдуулаад байна.

Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулийн харьцуулаалтаас үзэхэд зэрлэг амьтны хууль бус худалдааны сүлжээнд дараах хууль бус үйлдлүүд багтаж байна. Үүнд:

- o Зарж борлуулах,
- o Худалдан авах,
- o Бэлтгэх,
- o Ашиглах,
- o Цуглуулах,
- o Тээвэрлэх,
- o Хадгалах,
- o Импортлох,
- o Экспортлох болон
- o Худалдаалах.

Тодорхойлон гаргасан эдгээр үйлдэл бүр нь амьтан бүрт үйлдэгдэхгүй ч, үйлдэл болон хамаарах зүйл дээр нь үндэслэн өөр өөр шийтгэлийг тухайн үйлдэл бүрт хэрэглэдэг. “Ховор”, эсвэл “Нэн ховор” жагсаалтад багтсан зүйлийг хамарсан бүхий л хориглосон хууль бус үйлдэл нь Эрүүгийн хуулиар, харин бусад зүйлийн хувьд торгуулын шийтгэл хүлээнэ. Нэн ховор болон ховор зүйлийн хувьд хууль бус хэмээн хориглосон үйлдлүүдийг дээр дурдсан бөгөөд харин “Импортыг” үүнд багтаагаагүй байна. Бусад амьтны зүйлийг зөвшөөрөлгүйгээр агнасан, нутагшуулсан бол ижил хэмжээний торгууль, шийтгэл ноогдуулж байна. Хэрэв харь амьтан буюу Монгол Улсад нутагшин амьдардаггүй зүйл бол ноогдуулах торгуулийн хэмжээ илүү өндөр. Хуулиар амьтныг хууль бусаар ашиглах явдлыг зүйлийн статус суурилан ялгаж үзээгүй, зөвшөөрөлгүй ашигласан тохиолдол бүрт мөнгөн торгууль ноогдуулахаар заасан. Эдгээр тохиолдолд худалдааны сүлжээ үйлдлийн хамгийн хөнгөн тохиолдол нь 74 нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль (хувь хүмүүст), улмаар дээшлэн 750 нэгж хүртэл (хуулийн этгээдэд) хэмжээний торгууль ноогдуулж буй нь 150,000- 1,5 сая төгрөг болж байна.<sup>323</sup>

**Ховор жагсаалтад** орсон зүйл дээр торгуулийн доод хэмжээ нь 5,400 нэгж, дээд хэмжээ нь 27,000 нэгж байхаар заасан нь 5.4 сая- 27 сая төгрөг болно. Ижил төрлийн гэмт хэрэгт ноогдуулах шийтгэл нь 1-5 жилийн хугацаагаар зорчих эрх хязгаарлах, эсвэл 1-5 жил хорих ял ноогдуулахаар заасан байна.

**Нэн ховор** амьтны хувьд хамгийн багадаа 10,000 нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль, ихдээ 40,000 нэгжтэй тэнцэх торгууль ноогдуулахаар заасан нь 10

323 Зөрчлийн тухай хууль. 6.6.1.

сая- 40 сая төгрөгтэй тэнцэнэ. Эрүүгийн гэмт хэрэг хэмээн үзэх бол энэхүү үйлдэлд 2- 8 жил хуртал хугацаагаар хорих ял ноогдуулна.

Хуульд зааснаар “Нэн ховор” эсвэл “Ховор” амьтны жагсаалтад багтаагүй ч СИТЕС-ын жагсаалтад багтсан амьтныг хууль бусаар хил давуулсан бол тусдаа шийтгэл ноогдуулахаар заасан.<sup>324</sup>Энэ тохиолдолд ноогдуулах торгуулийн хэмжээг Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэх ба энэ нь эрүүгийн хариуцлагатай ямар нэгэн холбоогүй. Торгуулийн хэмжээг 500 нэгжээс (хувь хүнд), 5,000 нэгж хүртэл (хуулийн этгээд) байхаар заасан нь 500,000- 5 сая төгрөгтэй тэнцэнэ.

Бусад амьтны хувьд хориглосон үйлдэл нь нэн ховор болон ховор амьтныхтай ижил ба доорх үйлдлүүдийг хууль бус хэмээн үзжээ. Үүнд:

- o Борлуулах,
- o Худалдан авах болон
- o Ашиглах.

Сүлжээний хэлбэрийн гэмт үйлдлээс доор дурьдсан үйлдлийг оруулаагүй. Үүнд:

- o Бэлтгэх,
- o Цуглуулах,
- o Тээвэрлэх, болон
- o Хадгалах.

Хуулийн үг, хэллэгээс үзвэл экспортыг багтаасан эсэх нь тодорхойгүй, ямар амьтныг худалдаалсан тохиолдолд торгууль ноогдуулах болох нь тодорхойгүй. Зохих зөвшөөрөлгүйгээр ямар ч амьтан экспортлоход хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой буюу шууд заалт байхгүй ба Зөрчлийн тухай хуулиар “Хориглосон” болон “Хязгаарлалт бүхий” бараа, бүтээгдэхүүнийг борлуулсан тохиолдолд ял ноогдуулахаар заалтаар шийдвэрлэх болмжтой.<sup>325</sup>Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн дагуу зэрлэг амьтан нь “Бараа бүтээгдэхүүн” хэмээн тооцогдох<sup>326</sup>ба БОАЖЯ-наас зохих зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Зөвшөөрөл шаардагдах тохиолдолд зэрлэг амьтан нь “Хязгаарлалт бүхий” зэрэглэлд орох ч энэ нь хуульд БОАЖЯ бүх төрлийн зэрлэг амьтны худалдаанд зөвшөөрөл шаарддаг, эсвэл зөвшөөрөл олгодог эсэх нь бүрхэг байна.

## ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ЖУРАМ ЗӨРЧИХ

Зар сурталчилгааны тухай хууль нь зэрлэг амьтан, түүнтэй хамааралтай бүтээгдэхүүнийг худалдах талаар заасан зүйл, заалттай бөгөөд үүнийг ашиглан зэрлэг амьтны худалдааг хязгаарлах боломжтой. Тус хуулийн 14 дүгээр зүйлд “Нэн ховор, ховор ургамал, амьтны жагсаалтад орсон болон тэдгээрийн үндэс, иш,

324 Мөн тэнд. 6.6.3.

325 Эрүүгийн хууль. 18.5.1.

326 Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, 3.1.1.

мөчир, навч, бугын цусан эвэр, чив, засаа, согооны сүүл болон сав, хүдрийн заар, баавгайн доньд зэрэг эрхтнийг бэлтгэх, худалдах, худалдан авах тухай зар сурталчилгааг хориглоно” хэмээн заажээ. Тус хуулиар мөн агнах, бэлтгэхийг хориглосон амьтан, ургамлын эд эрхтэн, түүхий эдийг худалдах, худалдан авах алаар зар сурталчилгаа явуулахыг хориглосон. Цагдаа, шүүхээс авсан мэдээлэлд энэхүү заалтыг зөрчсөний улмаас мөрдөн байцаагдсан, яллагдсан ямар нэгэн тохиолдлын талаар дурдаагүй.

Зөрчлийн тухай хуулиар зэрлэг амьтны худалдааг сурталчлахтай холбоотой гурван төрлийн үйлдлийг тодорхойлсон ба эдгээрд ижил хариуцлага ноогдуулдаг. Үүнд зэрлэг амьтны худалдааны хууль бус сурталчилгааг захиалах, бүтээх болон түгээх үйлдэл багтана.<sup>327</sup> Энэхүү тайланг бэлтгэж байхад тус заалт нь харцангуй шинэ байсан тул хариуцлага тооцон, шийтгэл ноогдуулсан эсэх нь бидэнд тодорхойгүй. Зар сурталчилгааны тухай хуулийн зөрчлийн тухай бүртгэлээс үзвэл энэ үндэслэлийг зэрлэг амьтны худалдааны хэрэг дээр ашиглаагүй ажээ.

## ЭМИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХУДАЛДААНЫ ЗӨРЧИЛ, ГЭМТ ХЭРЭГ

Зэрлэг амьтны хууль бус худалдааны нэгэн онцлог хэлбэр бол амьтны эд, эрхтнээр хийсэн эм, эмийн бүтээгдэхүүн юм. Анхдугаар “Зэлүүд тал” тайланд баримтжуулсан, мөн энэ удаагийн судалгаагаар тогтоогдсон зэрлэг амьтны эд, эрхтэн, бүтээгдэхүүний худалдаа нь Монгол Улсын дотоод ба гадаад худалдааны нэг хэсэг болж байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль нь зэрлэг амьтны худалдааны асуудалтай шууд бусаар холбогдох ч энэ чиглэлийн үйл ажиллагааг зохицуулахад хувь нэмэр багатай. Тус хуулиар уламжлалт эмийн бүтээгдэхүүний худалдааг зохицуулдаг ч зэрлэг амьтны худалдаанд хамаарах эм бэлдмэлийг эмийн сангаас гадуур худалдаалж болохыг заажээ. Өөрөөр хэлбэл, тухайн хууль нь уламжлалт эмийн бүтээгдэхүүний худалдаанд, уламжлалт эм үйлдвэрлэх бүтээгдэхүүнд шууд хяналт, зохицуулалт хийхээргүй байна. Энэ нь уламжлалт эмийн бүтээгдэхүүнд зэрлэг амьтны асуудал огт зохицуулалтгүй гэсэн үг биш юм. “Нэн ховор” болон “Ховор” амьтны хувьд хууль бусаар зэрлэг амьтны эд, эрхтнийг “Бэлтгэсэн” болон “Цуглуулсан” хэмээх үйлдэл мөн хамаардаг. Эдгээр нөхцлийг эмийн бүтээгдэхүүний худалдаанд тодорхой заагаагүй, эсвэл шууд хамааралгүй гэж үзэх талтай ч зориулалтаас үл хамааран бэлтгэх болон цуглуулах үйл ажиллагаа нь хуулинд хариуцлагын заалттай.

Ховордсон зүйлийн хувьд 5,400 - 27,000 нэгжтэй тэнцэх хэмжээний торгуулийг хувь хүмүүст ноогдуулахаар заасан нь мөнгөн дүнгээр 10.8 сая төгрөгөөс 54 сая төгрөг хүртэл байна.<sup>328</sup> Тухайн үйлдэлд мөн 1-5 жил

327 Зөрчлийн тухай хууль. 9.4.4.

328 Зөрчлийн тухай хууль. 6.6.6.

хүртэл баривчлах, мөн 1-5 жил хүртэл хугацаагаар хорих хүртэл ял ноогдуулж болно. Нэн ховор амьтны хувьд ноогдуулах торгуулийн хэмжээ 10,000 нэгжээс 40,000 нэгж хүртэл байж болох ба энэ нь 20 сая төгрөгөөс 80 сая төгрөг хүртэлх хэмжээний торгууль юм. Эрүүгийн хариуцлага нь 2-8 жил хүртэл хорих бол аж ахуйн нэгжүүдэд дээрх ял үйлчлэхгүй.

## ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРЭГТ НООГДУУЛАХ ШИЙТГЭЛ

Монгол Улс нь зохион байгуулалттай гэмт хэргийн талаар тусгайлсан хууль тогтоомжгүй, харин зохион байгуулалттай гэмт хэргийн тухай болон түүнд ноогдуулах хариуцлагыг Эрүүгийн хуулиндаа тусгасан байдаг. Уг хууль нь суурь гэмт хэрэг хэмээх ойлголтыг авч үздэг бөгөөд тусгайлан заасан төрлийн гэмт хэргүүд нь зохион байгуулалттай буюу бүлэглэлийн шинжийг агуулсан бол нэмэлт хариуцлага ноогдуулах арга замаар шийдэж байна. Ерөнхийдөө 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял ноогдуулахаар заасан.

2002 оны Эрүүгийн хуульд хууль бусаар агнасан амьтныг тээвэрлэх, худалдах<sup>329</sup>, мөн хориотой амьтныг олон тоогоор худалдаалах нь<sup>330</sup> зохион байгуулалттай гэмт үйлдэл болох нь тогтоогдвол хүлээх эрүүгийн хариуцлагын хэмжээг нэмэгдүүлж байв. Харин 2017 оны хуулиар зэрлэг амьтны хууль бус худалдаа болон зохион байгуулалттай гэмт хэрэгт хэрхэн холбогдох талаарх заалт байхгүй. Харин тус хуулиар зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлийн хүрээнд “Хориглосон болон хязгаарласан” бараа, бүтээгдэхүүнийг худалдсан бол хорих ялыг чангаруулан (5-12 жил) ноогдуулах болсон ч босго хэмжээг заагаагүй.<sup>331</sup> Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулийн бусад заалтуудын дагуу нэн ховор болон ховор амьтан, мөн CITES-ын жагсаалтад багтсан амьтны<sup>332</sup> импорт, экспортод<sup>333</sup> тусгай зөвшөөрөл шаарддаг нь тухайн зүйлийг хориотой, хязгаартай хэлбэр рүү оруулж тооцох боломжтой.

## ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД НООГДУУЛАХ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА

Өмнөх Эрүүгийн хуулиар зөвхөн хувь хүмүүсийг гэмт хэрэгт холбогдуулан шалгадаг байсан нь Герман болон Швед зэрэг улсад хэрэглэдэг аргачлал юм. 2015 онд УИХ-аас хуульд өөрчлөлт хийж тодорхой төрлийн гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, эсвэл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн тохиолдолд тухайн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага ноогдуулж, хувь хүнийг ялаас чөлөөлөхөөр тусгажээ. Шинэ Эрүүгийн хуульд гэмт

329 Эрүүгийн хууль. 161, 2002.

330 Эрүүгийн хууль. 175, 2002.

331 Эрүүгийн хууль. 18.5.1, 2017 онд нэмэлт өөрчлөлт орсон.

332 Зөрчлийн тухай хууль. 6.3.

333 Зөрчлийн тухай хууль. 6.6.5 болон 6.6.6; Эрүүгийн хууль. 24.5, 2017 онд нэмэлт өөрчлөлт хийгдсэн.

хэргийн хэлбэрээс хамааруулан хуулийн этгээдэд их хэмжээний торгууль ноогдуулах, үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах болон татан буулгах зэрэг шийтгэл ноогдуулахаар заажээ.

Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, ашиг сонирхлынх нь төлөө гэмт хэрэг үйлдсэн бүх тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээхгүй, харин зөвхөн хуулиар тодорхойлон заасан гэмт хэрэгт л шийтгэл хүлээнэ. Эрүүгийн хуулийн 2015 оны шинэчилсэн найруулгаар “Ховор” болон “Нэн ховор” зүйлийг хууль бусаар худалдаалсан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байсан.<sup>334</sup> Гэхдээ 2017 онд энэхүү заалтыг хуулиас хассан байна.<sup>335</sup> Худалдааны компани болон зэрлэг амьтны хууль бус худалдаа харилцан уялдаатай болж буй энэ үед эдгээр тохиолдолд эрүүгийн хариуцлага ноогдуулахгүй байх энэ хийдлийг залруулах шаардлагатай.

## МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТ НООГДУУЛАХ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА

Мөнгө угаах гэмт хэрэг, үүний хариуцлагыг өмнөх Эрүүгийн хуульд тусгасан ба эдгээр заалт нь зэрлэг амьтны хууль бус худалдаатай шууд холбоогүй. Цагдаа, гааль болон шүүхийн гаргасан мэдээ, баримтаас үзвэл мөнгө угаасан гэх үндэслэлээр зэрлэг амьтны худалдаатай холбоотой гэмт хэрэгт мөрдөн байцааж, ялласан тохиолдол байхгүй. Үүний шалтгаан тодорхойгүй. Хуучин Эрүүгийн хуулийн агуулга, зорилго нь ямартаа ч зэрлэг амьтны хууль бус худалдааны хувьд шууд биш ч тодорхой хамааралтай байжээ.<sup>336</sup>

Шинээр гарсан заалт нь суурь гэмт хэргийг тусгайлан заагаагүй, завдал/зорилгын шаардлагыг оруулаагүй нь хуулиар мөнгө угаах хэмээн заасан үйлдэлд хатуу шийтгэл ноогдуулахуйц хэлбэртэй болжээ. Эдгээр өөрчлөлт нь мөнгө угаах гэмт хэрэг нь зэрлэг амьтны худалдааны суурь гэмт хэрэг рүү хөтлөх эсэхийг цаашид тодорхой болгох ач холбогдолтой.

Мөнгө угаах гэмт хэрэг нь тухайн гэмт үйлдэлд хамаарал бүхий аж ахуйн нэгжид эрүүгийн хариуцлага ноогдуулах боломжийг олгоно. Мөнгө угаахтай тэмцэх чиглэлийн хуулийн заалтууд нь хуулийн этгээдэд ноогдуулах торгуулийн хэмжээг өндөрсгөж, тухайн гэмт хэрэгт холбогдсон хувь хүнд хорих хүртэл ял ноогдуулж болохоор заасан байдаг.<sup>337</sup> Ноогдуулах

торгуулийн хэмжээг 120- 400 сая нэгжтэй<sup>338</sup> тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан байна.

## ХЭРЭГ ЗӨРЧЛИЙН ХҮСНЭГТ

Захиргааны эсвэл эрүүгийн хариуцлага ноогдуулахаар хуульд заасан үндэслэлүүд бүхий зүйл, заалтуудын доорх хүснэгтээр үзүүлэв. Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулийн зүйл, заалт нэг бүрийг харьцуулан үзэж, гэмт хэрэг, зөрчил хэмээн тооцогдох “Үйлдэл” бүрийг олж тогтоов. Хуулиар эдгээр үйлдэл нэг бүрийг тусад нь заагаагүй тул илүү тодорхой болгох зорилгоор тус тусад нь яллах боломжтой үйлдэл бүрийг жагсааж, цэгцлэн хүснэгтлэв. Тухайлбал, зэрлэг амьтны бүтээгдэхүүнийг зөвшөөрөлгүй худалдах нь хууль бус үйлдлийн нэг хэлбэр бол зэрлэг амьтны бүтээгдэхүүнийг зөвшөөрөлгүй худалдан авах нь өөр нэгэн хууль бус үйлдэл болно. Хуульд эдгээр үйлдлийг нэг зүйл дээр оруулсныг хүснэг 13,14 -т тусад нь орууллаа.

334 Эрүүгийн хууль. 24.5.3, 2015 (хүчингүй болсон).

335 Эрүүгийн хууль. 24.5, 2017 оны 5 дугаар сард нэмэлт өөрчлөлт орсон.

336 Эрүүгийн хуулийн 163.1 дүгээр зүйл, 2002; “илт хууль бусаар олж авсан мөнгө, эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаанд оруулсан бол”

337 Хуулиар зорчих эрхийг хязгаарлах хэмээх шийтгэлийг заасан ч энэ шийтгэлийг аж ахуйн нэгж дээр хэрхэн хэрэглэх талаар тодорхой дурдаагүй.

338 Нэг тооцох нэгж нь 1,000 төгрөгтэй тэнцэнэ.

## Хүснэгт 14. Зэрлэг амьтны худалдааны хэрэг зөрчил, шийтгэл

2017

Монгол улс

### ХУДАЛДААЛАХ ГЭМТ ҮЙЛДЭЛ БА ТОРГУУЛЬ, ШИЙТГЭЛ

	ЗАХИРГААНЫ ТОРГУУЛЬ (2,000 Төгрөгний нэгжээр)		ЭРҮҮГИЙН			ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ	
	ИРГЭНД	ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД	АЛБАДАН АЖИЛ ХИЙЛГЭХ (цагаар)	БАРИВЧЛАХ (сараар)	ХОРИХ (сараар)	ЗӨРЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ	ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
<b>БЭЛТГЭХ</b>							
1	Ховор амьтны гаралтай түүхий эдийг тусгай зөвшөөрөлгүйгээр бэлтгэх	5400-с 27,000			12-с 60	12-с 60	Зүйл. 24.5.1
2	Нэн ховор амьтны гаралтай түүхий эдийг тусгай зөвшөөрөлгүйгээр бэлтгэх	10000-с 40,000				24-с 96	Зүйл. 24.5.2.
<b>ТЭЭВЭРЛЭХ</b>							
3	Ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр тээвэрлэх	5400-с 27,000			12-с 60	12-с 60	Зүйл. 24.5.1
4	Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр тээвэрлэх	10000-с 40,000				24-с 96	Зүйл. 24.5.2.
<b>ХАДГАЛАХ</b>							
5	Ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр хадгалах	5400-с 27,000			12-с 60	12-с 60	Зүйл. 24.5.1
6	Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр хадгалах	10000-с 40,000				24-с 96	Зүйл. 24.5.2.
<b>ЗАР СУРТАЛЧИЛГАА ХИЙХ</b>							
7	Амьтантай холбоотой хуулиар хориглосон зар сурталчилгаа захиалах	250 буюу түүнээс дээш	2,500 буюу түүнээс дээш				Зүйл. 9.4.4.
8	Амьтантай холбоотой хуулиар хориглосон зар сурталчилгаа хийх	250 буюу түүнээс дээш	2,500 буюу түүнээс дээш				Зүйл. 9.4.4.
9	Амьтантай холбоотой хуулиар хориглосон зар сурталчилгааг түгээх	250 буюу түүнээс дээш	2,500 буюу түүнээс дээш				Зүйл. 9.4.4.
<b>МОНГОЛ УЛСАД ХУДАЛДААЛАХ</b>							
10	Зэрлэг амьтан ба тэдгээрийн гаралтай эд эрхтнийг тусгай зөвшөөрөлгүйгээр худалдаалах	150 буюу түүнээс дээш	1,500 буюу түүнээс дээш				Зүйл. 6.6.4.
11	Зэрлэг амьтан ба тэдгээрийн гаралтай эд эрхтнийг гарал үүслийн гэрчилгээгүйгээр худалдаалах	150 буюу түүнээс дээш	1,500 буюу түүнээс дээш				Зүйл. 6.6.4.
12	Ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр худалдаалах	5,400 буюу 27,000			12-с 60	12-с 60	Зүйл. 24.5.1
13	Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр худалдаалах	10,000 буюу 40,000				24-с 96	Зүйл. 24.5.2.
<b>ХУДАЛДАН АВАХ</b>							
14	Тусгай зөвшөөрөл буюу эрхийн бичиггүйгээр зэрлэг амьтан ба тэдгээрийн гаралтай эд эрхтнийг худалдан авах	150 буюу түүнээс дээш	1,500 буюу түүнээс дээш				Зүйл. 6.6.4.
15	Ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр худалдан авах	5,400 буюу 27,000			12-с 60	12-с 60	Зүйл. 24.5.1
16	Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр худалдан авах	10,000 буюу 40,000				24-с 96	Зүйл. 24.5.2.
<b>ИМПОРТ/ЭКСПОРТ</b>							
17	Тухайн зүйлийг зөвшөөрөлгүйгээр Монгол улсад оруулж ирэх	250 буюу түүнээс дээш	2,500 буюу түүнээс дээш				Зүйл. 6.6.5.
18	Харь зүйлийг зөвшөөрөлгүйгээр Монгол улсад нутагшуулах	500 буюу түүнээс дээш	5,000 буюу түүнээс дээш				Зүйл. 6.6.6.
19	Ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр экспортлох	5,400 буюу 27,000			12-с 60	12-с 60	Зүйл. 24.5.1
20	Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр экспортлох	10,000 буюу 40,000				24-с 96	Зүйл. 24.5.2.
21	Хориглосон, хязгаарласан бүтээгдэхүүнийг хууль бусаар хил давуулах	450 буюу 5,400	200,000-с 400,000	240-с 720		1-с 12	Зүйл. 18.5.1.
22	САЙТИС-аар хамгаалагдсан зүйл амьтныг (ховор эсхүл нэн ховор амьтны жагсаалтанд багтаагүй) авч хууль бусаар хил давуулах	500 буюу түүнээс дээш	5,000 буюу түүнээс дээш				Зүйл. 6.3.
<b>ХЭРЭГЛЭХ БА ЦУГЛУУЛАХ</b>							
23	Зэрлэг амьтныг зөвшөөрөлгүйгээр хэрэглэх	75 буюу түүнээс дээш	750 буюу түүнээс дээш				Зүйл. 6.6.1.
24	Зэрлэг амьтныг хугацаа дууссан зөвшөөрөлтэйгээр хэрэглэх	75 буюу түүнээс дээш	750 буюу түүнээс дээш				Зүйл. 6.6.1.
25	Ховор амьтны трофи, түүхий эд эрхтэн ба түүнээс гаралтай бүтээгдэхүүнийг тусгай зөвшөөрөлгүйгээр цуглуулах	5,400 буюу 27,000			12-с 60	12-с 60	Зүйл. 24.5.1
26	Нэн ховор амьтны трофи, түүхий эд эрхтэн ба түүнээс гаралтай бүтээгдэхүүнийг тусгай зөвшөөрөлгүйгээр цуглуулах	10,000 буюу 40,000				24-с 96	Зүйл. 24.5.2.

## CITES-ын хэрэгжилт

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон төрөл зүйлсийг олон улсад худалдаалах тухай конвенц буюу CITES нь зэрлэг амьтны худалдааг зохицуулсан олон улсын хамгийн чухал арга механизмуудын нэг билээ.<sup>339</sup>CITES нь жагсаалтад багтсан зэрлэг амьтдын худалдааны нэг хэсгийг (гадаад худалдаа) хамарсан цорын ганц олон улсын гэрээ юм. Монгол Улс бусад 183 орны хамтаар 1996 оны 4 дүгээр сард CITES-ыг соёрхон батлав. Монгол Улсын хувьд 87 зүйлийн хөхтөн, шувуу, загас конвенцийн 1 ба 2р хавсралтад бүртгэлтэй бөгөөд конвенцийн гишүүн орнуудын дунд жагсаалтад орсон зүйлийн тоогоор өндөрт орохгүй. Гэсэн ч Монгол бол зэрлэг амьтны хууль бус худалдааны нөлөөнд ихээр өртдөг, өндөр үнэ цэнэ бүхий идлэг шонхор, монгол бөхөн, хүрэн баавгай зэрэг ховор зүйлийн тархалтын чухал нутаг юм. Манай орны “Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль” бол нь зэрлэг амьтны худалдаатай холбоо бүхий л эрх зүйн харилцааг зохицуулдаг чухал баримт юм. Энэ хууль 2002 онд батлагдаж, улмаар нэмэлт өөрчлөлт орсон нь Монгол Улс конвенцийн гишүүн болсон 20 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн томоохон үйл явдал болов.<sup>340</sup>Монгол Улсад конвенцийн хэрэгжилт тодорхой түвшинд сайжирч буй ч CITES-ын дүгнэлтээр хоёрдугаар шатлалд<sup>341</sup> байгаа нь Монгол Улсын эрх зүйн орчин CITES-ыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай дөрвөн шаардлагын 1-3-ыг бүрэн хангадаггүйтэй холбоотой.<sup>342</sup>

339 Дэлхийн хэмжээнд олон жил үргэлжилсэн зэрлэг амьтны хууль бус буюу зохицуулалтгүй агнуур болон худалдаа нь дотоодын болон олон улсын хууль тогтоомжийг боловруулах үндэс болсон. Жишээлбэл, гоёл чимэглэлийн зорилгоор зэрлэг шувуудын худалдаа ихсэх болсноор АНУ нь Ласигийн хуулийг 1900 оны үед батлан гаргахад хүрсэн нь АНУ-д анх удаа зэрлэг амьтны худалдаанд хариуцлага хүлээлгэж, улмаар амьтныг хууль бусаар хөнөөх болон гадаадад гаргахад өөрийн улсын хил хязгаараас гадна ч гэсэн хариуцлага тооцоход дөхөмтэй болсон. Нүүдлийн шувуудын тухай гэрээний хууль (МВТА) (1918) болон АНУ-Мексикийн нүүдлийн шувуу болон агнуурын хөхтөн амьтны тухай гэрээ (1936) нь мөн л ижил үндэслэлээр гарчээ. Тухайн үед халим агнуур хэт ихсэж, халимын нөөцийг хэтрүүлэн ашиглах болсноор Олон улсын халим агнуурын конвенц 1946 онд батлагдан гарчээ. Улмаар эдгээрийг даган олон улсын, бүс нутгийн бусад олон тооны гэрээ, конвенц дагалдан гарсны тоонд Их далайн загасчлал болон амьд нөөцийг хамгаалах тухай конвенц (1958 оноос улс орнууд нэгдэж эхэлсэн); Атлантын далайн туна загасыг хамгаалах олон улсын комисс (ИССАТ) (1969 онд байгуулагдсан); Антарктидын далайн хав загасыг хамгаалах конвенц (1972) болон Европын Холбооны зөвлөлийн (ЕС) No. 338/97 журам зэрэг багтана.

340 Монгол улс нь CITES –д нэгдсэн 133 дахь улс бөгөөд 1996 онд соёрхон баталсан.

341 CITES-ыг хэрэгжүүлэх хууль тогтоох явцын ахицын тайлан (2016 оны 9 сарын 1-нд шинэчилсэн, САЙТИС). [www.cites.org](http://www.cites.org) хаягаас 2017 оны 4 сарын 21-нд авсан.

342 Дотоодын хууль тогтоомждоо i) хамгийн багадаа нэг Удирдан зохицуулах хороо, нэг Шинжлэх ухааны хороог томилох; ii) Конвенцийг зөрчин худалдаа эрхлэхийг хориглох; iii)

Конвенцийн VIII зүйл “Талуудын авч хэрэгжүүлэх арга хэмжээ” нь гишүүн улс орнууд конвенцийг хэрэгжүүлэх шаардлагатай заалт бүхий хуулийг гаргадаг. Конвенцийн дагуу хуульдаа зарим заалтыг заавал багтаасан байх ёстой бол бусад заалтууд нь тухайн улсын сонголтоор орж болно. Эдгээрийг дараах бүлэгт тайлбарлав.

## ХУДАЛДАХ, ЭЗЭМШИХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ

CITES-ын хүрээнд дотоодын хууль тогтоомждоо заавал тусгасан байх заалт нь гишүүн орнууд 1-р хавсралтын зүйлийн арилжаа эсвэл тухайн амьтныг эзэмшихийг хуулиар хориглох тухай юм.<sup>343</sup> Одоогоор энэхүү жагсаалтад нийт 931 зүйлийн амьтан буйгаас 14 нь Монгол оронд тохиолддог. Дээр дурдсан хуулийн 7 дугаар зүйлд Монгол Улс нь “Конвенцийн 1-р хавсралтад орсон зүйлийг ашиг олох зорилгоор борлуулахыг хориглоно” гэж заажээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улс нь худалдааг хориглох сонголтыг хийсэн бөгөөд харин “болон/эсвэл эзэмших” хэмээх шаардлагыг орхигдуулсан.

Өмнө дурдсанчлан Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулиар зэрлэг амьтны худалдааны хэд хэдэн хэсэгт ял ноогдуулахаар заав. Гэхдээ CITES-ын жагсаалтад бүртгэлтэй амьтдыг Зөрчлийн тухай хуульд “Ховор” эсвэл “Нэн ховор” жагсаалтад ороогүй CITES-ын хавсралтад бүртгэгдсэн амьтныг хил давуулах тохиолдолд шийтгэл ноогдуулахаар заасан байна.<sup>344</sup> Ховор, эсвэл нэн ховор амьтныг худалдаалах (хил дамнуулах) тухайг Амьтны тухай хуулиар хориглож, Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлээр ял ноогдуулж буй тул энэ хуульд дахин дурдах шаардлагагүй байсан болов уу. CITES-ын жагсаалтад орсон зүйлсийг худалдаалах асуудлыг Эрүүгийн хуульд бус харин Зөрчлийн тухай хуульд багтаасан ч зөвхөн хил давуулах тохиолдолд хэмээн тодотгожээ. Амьтны зүйлийг эзэмших болон улс дотроо тээвэрлэхийг үүнд хамааруулан ойлгохгүй. Монгол Улсын “Ховор”, “Нэн ховор” амьтны жагсаалтад ороогүй ч CITES-ын жагсаалтад орсон буй хоёр амьтан бол шивэр хилэм (*Acipenser baeri baicalensis*) болон Амрын живэрт (*Mescottus haitej*) юм. Өнгөрсөн 10 жилийн туршид хилэм загас Монгол орны хувьд CITES-ын худалдааны нэгэн чухал зүйл байжээ. Энэ зүйл нь 2012 онд Монгол Улсын “Нэн ховор” амьтны жагсаалтаас хасагдсан бөгөөд одоогоор зүйлийн ховордлын жагсаалтад ороогүй.

тухайн худалдаанд хариуцлага ноогдуулах; эсвэл iv) хууль бусаар худалдаалсан, эзэмшсэн зүйлийг хураан авах зэргийг тусгаагүй улсууд.

343 САЙТИС Art. VIII, 1(a). “1. Талууд энэхүү конвенцийн заалтуудыг хэрэгжүүлэх болон энэ конвенцийн заалтуудыг зөрчиж худалдаалах явдлыг хориглон зогсоох талаар холбогдох арга хэмжээг авч байна. Эдгээр арга хэмжээнд дараах асуудал хамаарна. Үүнд: тухайн биесийг худалдаалсан буюу эзэмшсэний төлөө шийтгэл ногдуулах гэх мэт.

344 Зөрчлийн тухай хууль, 6.3.

Монгол Улсын хувьд “Эзэмшил” гэх зүйл дээр хуулийн цоорхой үүсэж буй нь хууль сахиулах үйл ажиллагааг илүү хүндрэлтэй болгоно. Практик дээр эзэмшиж буйг анзаарч мэдэхэд хялбар, үүний зэрэгцээ нотлоход хялбар байдаг. Эзэмшиж буй зүйлийг борлуулсан болохыг нотлохын тулд тухайн зүйлийг эзэмшдэг болон зарж борлуулах зорилготой байсан эсэхийг нотолно. Үүнийг гүйцэтгэх хялбар арга бол ажиглалт болон хуурамчаар худалдан авах ажиллагаа байж болно. Гэхдээ эдгээр аргачлал нь хүн хүч багатай, төсөв хомс хууль сахиулах байгууллагын хувьд хүндрэлтэй. Нөгөө талаар эзэмших гэдэгт тухайн хувь хүн олон улсын хууль бус худалдаа хийж байх үйлдэл дээрээ баригдсан байхыг шаарддаг. Зэрлэг амьтны гэмт хэргийн олонх нь тээврийн хөдөлгөөнийг зогсооход буурдаг, мөн зэрлэг амьтны эд, эрхтнийг “Эзэмшихийг” эрүүгийн гэмт хэрэгт тооцдог нь зэрлэг амьтны хууль бус худалдаатай гэмцэхэд эерэг үр дүн авчирдаг. Мөн эзэмших гэдэг нь ямар үйлдлийг хэлэхийг бүрэн тогтоолгүйгээр үүнийг эрүүгийн гэмт үйлдэл хэмээн үзэх нь алдаа болно. Хуулийн хэллэгээр эзэмшил “Бодит” эсвэл “Хамааралтай” эзэмшил байж болно. Бодитоор эзэмших гэдэг нь тухайн зүйл нь сэжигтэн этгээдийн гар дээр, биед, эсвэл хувцас хэрэгсэлд шууд байхыг хэлнэ. Хамааралтай эзэмшил гэдэг нь тухайн эд, эрхтэн, бараа нь сэжигтний гар дээр бус, түүний хяналтад байхыг хэлнэ. Жишээлбэл, хэрэв хоёр хүн ангийн арьс болон хориотой амьтан ачсан автомашинаар явж буй бол (тухайн эд зүйл машины хаана нь байгаагаас үл хамааран) тухайн ангийн арьс нь тэр хоёрын хяналтад байгаа хэмээн үзэх тул аль алиныг нь тухайн зүйлийг эзэмшсэн хэмээн буруутгаж болно. Хамааралтай эзэмшиж байсантай харьцуулбал энэхүү бодитоор эзэмшиж буйг нотлоход хялбар бөгөөд учир нь тухайн сэжигтэн нь өөрийн эзэмшиж буй зүйлээр хууль бус худалдаа хийж буй хэмээн үзэх боломжтой. Харин хамааралтай эзэмших замаар хийсэн хууль бус худалдаа нь хууль сахиулах байгууллагын зүгээс яллах боломжийг нэмэгдүүлэх учир нь тухайн худалдаа нь хэн нэгний гар дээр бус, харин хяналтад буйг тогтоох боломж өндөрсөх, эсвэл хууль сахиулах байгууллага ирэх үед тухайн эд зүйлс гар дээр нь бодитоор байсантай ижил хэмжээнд байна. Тиймээс “Эзэмшил” буюу шууд биедээ авч явах болон хяналтад байлгах гэх тусдаа элементүүдэд гол анхаарлаа хандуулах нь нотолгоо олж тогтоох явцыг хялбаршуулж, хууль сахиулах байгууллагад ажиллагаа явуулах, тухайн хэргийг яллах боломжийг нээж өгнө.

## ХУРААН АВАХЫГ ШААРДАХ НЬ

Хориглосон зүйлийг худалдаалахаар завдсан тохиолдолд хураан авч байх тухай CITES-ын шаардлагыг Монгол Улс хэрхэн даган мөрдөж буй нь тодорхойгүй. Үүнийг CITES-ын VIII зүйлийн 4 дээр дараах байдлаар заажээ. Үүнд:

“Энэхүү зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан арга хэмжээний хүрээнд амьд бие хураан авсан бол:

- (а) тухайн биеийг хураан авсан орны Удирдан

зохицуулах байгууллагын мэдэлд шилжүүлж маллуулах;

- (б) Удирдан зохицуулах байгууллага экспортлогч оронтой зөвлөсний дараа уг биеийг тухайн орны өөрийнх нь зардлаар буцаах, эсвэл аврах төвд юм уу энэхүү конвенцийн зорилгод нийцэх өөр аль нэг газар шилжүүлэх болон
- (с) энэ зүйлийн 6-д заасны дагуу шийдвэр гаргахад туслах ба түүний дотор аврах, сэргээх төв эсвэл газрыг сонгохын тулд үндэсний Удирдан зохицуулах зөвлөл нь шинжлэх ухааны байгууллагаас зөвлөгөө авах, шаардлагатай гэж үзвэл Нарийн бичгийн дарга нарын газартай санал бодол солилцож болно” хэмээн заажээ.

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 15.2-д “Хууль бусаар олж авсан зэрлэг амьтан, түүний бүтээгдэхүүнийг хураан авна” гэж заасан. Өнгөц харахад энэхүү заалт нь CITES-ын шаардлагатай нийцэж буй мэт боловч конвенцийн шаардлагатай яг ижил бус буюу хэрэглээг хязгаарлах санааг оруулсан байна. CITES нь зөвхөн “Амьтны агнахыг хориглосон зүйл, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнийг” хураан авахын шаарддаг. CITES болон бусад тохиолдолд нотолгоог энэ тохиолдолд үл шаарддаг. Монгол Улсын энэхүү хуулийн 15.2 дугаар зүйл нь “Хууль бусаар олж авсан” бүхий л амьтнаа энэхүү хураах үйл ажиллагааг журамлажээ. Эзэмшсэн үйлдлийг борлуулсантай харьцуулбал нотлоход хялбар байдаг. Амьтны зүйлийг хууль бус аргаар олж авч, эзэмшиж байсныг нотлоход мөн хялбар байх талтай.

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль нь хурааж авсан зэрлэг амьтныг хадгалах, харьцах талаар ямар нэгэн заалтгүй нь тулгарах асуудлуудын тоог нэмэгдүүлж байна. Монгол Улсын хуульд зааснаар хураан авсан эд зүйлсийг улсын орлого<sup>345</sup> болгох хэдий ч энэхүү үүргийг гүйцэтгэх эзэн, шилжүүлэх эзний талаар ямар нэгэн заалт байхгүй. Хуулиар хураан авсан сорьц, дээжийг хэрхэх талаар ямар нэгэн заалтгүй. Хураан авч буй байгууллагын хувьд тавих шаардлага, тухайлбал, тухайн зүйлийг худалдаанд гаргасан улсад нь илгээх зэрэг ямар ч шаардлага тавигдаагүй. Авран хамгаалах төвд хүргэх, эсвэл устгах зэргээр тухайн үеийн нөхцөл байдалд тохируулан хэрэглэж байна. Авах арга хэмжээний тухай хуулиар ямар нэгэн зааварчилгаа өгөөгүй тул авч хэрэгжүүлэх арга хэмжээнд саад учруулж байна. Хураан авахыг дурдсан тухайн хуулийн заалт нь чухал ач холбогдолтой ч энэхүү үүргийг тодорхой нэг байгууллагад ноогдуулахгүйгээр хураан авах үйл ажиллагаа ном ёсоор хийгдэхгүй гэдэг нь тодорхой. Иймээс хураан авсан эд зүйлсийг хэрхэх талаар ямар нэгэн арга хэмжээ авах боломжгүй болно. Үүнээс үүдэн тухайн нотолгоотой холбоотой ямар ч арга хэмжээ авагдахгүй байхад хүрч, улмаар

345 Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, 15.1.2.

нотолгоо устгах, алдагдах боломж бүрдэх эрсдэлтэй бөгөөд цаашид тухайн гэмт хэрэгт ял ноогдуулахад хүндрэлтэй болдог.

## АМЬТНЫ АРЧИЛГААНД ТАВИХ ШААРДЛАГА

Амьтан арчилж маллах, энэрэнгүй харилцах нь Монгол Улсын хуульд ямартаа ч хэсэгчилсэн байдлаар тусгагдсан хэдий ч хэрэглээтэй нь холбоотой тодорхойгүй асуудал гарна. CITES нь амьд амьтныг тээвэрлэх, хадгалах болон зөөвөрлөх үед зохих ёсоор хүнлэг харилцаж байх тухай заалт оруулахыг шаарддаг. Гэхдээ конвенцээр энэхүү шаардлагыг хэрхэн хангах тухай, эсвэл импорт, экспорт дээр шаардах эсэхийг заагаагүй. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль нь Удирдан зохицуулах хороо нь амьтан, ургамлыг тээвэрлэх, зөвшөөрөл, эсвэл гэрчилгээ олгохдоо “Зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх”, “Зохистой нөхцөл бүрдүүлэх” үүргийг хүлээдэг.<sup>346</sup> Хуулийн 6(1)(2) дээр зааснаар Шинжлэх ухааны хороо нь Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтныг импортолж буй этгээд тухайн амьтныг арчилж, маллах зохих нөхцөл бүрдүүлснийг нотолсон тодорхойлолт гаргах үүргийг хүлээдэг. Гэхдээ үүнтэй ижил шаардлага экспорт дээр заагдаагүй. Мөн тус хуулийн 10(4) дүгээр заалт дээр хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг дамжуулан өнгөрүүлэхэд аливаа зөвшөөрөл авахгүй хэмээн заажээ. Хуулийн 9(1)(5) дүгээр заалт дээр экспорттой хамаарах заалт байхгүй, 10(4) дээр заасанчлан зөвшөөрөл шаардлагагүй нь ерөнхийлсөн, CITES-тай зөрчилтэй харагдаж байна.

## БҮРТГЭЛ ХӨТЛӨХ НЬ

CITES-ын хүрээнд заавал ханган биелүүлэхийг шаардсан боловч Монгол Улсын хууль тогтоомжид заагдаагүй өөр нэгэн шаардлага нь CITES-ын гурван хавсралтад багтсан зүйлийн худалдааны бүртгэл хөтөлж байх явдал юм. Хавсралт III нь хууль дээр тусгагддаггүйн зэрэгцээ ямар нэгэн бүртгэл, мэдээллийн үйл ажиллагаа явуулах тухай заагдаагүй. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулиар Нарийн бичгийн дарга нарын газарт жил тутам тайлан гарган хүргүүлэх шаардлагатай. Гэвч тухайн тайланд юу тусгаж байх талаар хуульд заасан ямар нэгэн зүйл, заалт байхгүй. Хоёр жил тутам тайлагнаж байхыг CITES-ын хүрээнд шаарддаг ч үүнийг хуульд оруулсангүй.

## CITES-ЫН ЗҮГЭЭС САНАЛ БОЛГОЖ БУЙ ЗААЛТУУД

Конвенц нь хэрэгжилтийг хангах, илүү үр дүнтэй болгох үүднээс заавал даган мөрдөх үүрэггүй, өөрийн хууль тогтоомжид тусган оруулах зарим нэгэн саналыг

ерөнхийлөн томъёолдог. Үүнд:

- a. Хураан авсантай холбоотой зардлыг нөхөн төлөхтэй холбоотой механизм;
- b. Нэвтрэх цэгийг тогтоосон байх;
- c. Удирдан зохицуулах зөвлөл болон Шинжлэх ухааны хороон нь хураан авсан амьтны зүйлийг эргэн байгальд нь тавих чиглэлээр хамтран ажиллах болон
- d. Авран хамгаалах төв байгуулан ажиллуулах гэх мэт.

Дээрх санал болгосон заалтуудаас зөвхөн нэвтрэх цаг ашиглах талаар Монгол Улсын хуульд заажээ. Хуулийн 11 дүгээр зүйл хамаарах захиргааны байгууллага нь нэвтрэх цэгийг тогтооно хэмээн заасан ч бусад гурван заалтын хувьд хуульд ямар нэгэн шаардлага тусгагдаагүй.

<sup>346</sup> Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, 9(1)(5).



## Орхигдлын шинжилгээний ТОЙМ

Эрх зүйн болон хүний хөгжлийн чиглэлээр маргах зорилгогүй ч орчин үеийн түүхэн дэх өөрчлөлтийн хурд, мэдээлэл харилцаа, аялал жуулчлал, бизнесийн хэлбэр, технологид гарч буй дэвшил нь эрх зүйн ертөнцийг хөгжилтэй хөл нийлүүлэхийг хязгаарлаж байна. Монгол Улсын зүгээс зэрлэг амьтны худалдааны чиглэлийн эрх зүйн орчныг хөгжүүлэх хүчин чармайлт нь худалдааны шинэ шинэ төрлүүд (Хятад руу чонын шүд зарах) нэмэгдэн, шинэ амьтны худалдаа нээгдэж (тарвага, хэрэм), баригдахаас сэргийлэх шинэ аргачлал нэвтэрч (гар утсаар хил давуулах цэгийг тохирох гэх мэт) буйгаас үүдэн сорилтуудтай тулгарч байна.

Засгийн газрын хувьд зэрлэг амьтан хамгаалах, хууль бус худалдаатай тэмцэх ажил нь анхаарлын төвд байж, өнгөрөгч арван жилийн хугацаанд зэрлэг амьтны худалдааны эрх зүйн орчинд хэд хэдэн өөрчлөлт хийжээ. Тэмдэглүүштэй чухал өөрчлөлтүүдийн тоонд:

- Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар ноогдуулахаар заасан багц хариуцлага нь хараахан амьдрал дээр бүрэн шалгагдаагүй ч тухайн гэмт хэргийг дахин гарахаас сэргийлэх хэмжээнд байна.
- Нэн ховор болон ховор амьтныг хууль бусаар агнах болон худалдаалахад ноогдуулах торгууль болон хорих ялын хэмжээг доорх агуулгаар заажээ. Үүнд:
  - Ноогдуулах хариуцлагад торгууль ноогдуулах ял хамаарч буй бөгөөд хэмжээний хувьд ховор амьтны хувьд 4,700-23,500 ам.доллар, нэн ховор амьтны хувьд 8,700-34,700 ам.доллартай тэнцэнэ. Хамгийн багаар тооцсон ч ноогдуулж буй торгууль нь Монгол Улсын нэн ховор болон ховор амьтны зах зээлийн үнээс дээгүүр буй нь хууль бус худалдаа эрхлэгчдийг ашиг олох боломжийг хаахад үр дүнтэй.
  - Хорих ялын хувьд ховор амьтан агнасан, худалдаалсан тохиолдолд 1-5 жил, нэн ховор амьтны хувьд 2-8 жил байх бөгөөд Монгол Улсын хуулиар нэн ховор, ховор амьтныг хууль бусаар агнах, худалдаалах үйлдлийг “Ноцтой гэмт” хэрэг хэмээн зүйлчилж байна.
- Хууль бус худалдааг бүрдүүлж буй бүхий л сүлжээний олон үйлдлийг, үүнд худалдах, зарж борлуулах, бэлтгэх, ашиглах, цуглуулах, тээвэрлэх, импортлох, экспортлох зэргийг хамруулсан.
- Үүний нэгэн адил хууль бус худалдааны сүлжээний нэг хэсэг болох зар сурталчилгаа дээр захиалах, бүтээх, түгээх үйлдэлд хариуцлага ноогдуулсан байна.

Эдгээрээс гадна шинээр батлан гаргасан хууль, тэдгээрийн нэмэлт өөрчлөлтүүд нь үг хэллэг тодорхойгүй, нийлмэл өгүүлбэр хоорондын холболт дутмаг байх зэрэг сул талуудтай. Жишээлбэл, 2002 оны

Эрүүгийн хууль нь “Их хэмжээгээр” зарж борлуулсан, эсвэл “Хор хохирол” учруулсан, хууль бус агнуур хийсэн тохиолдолд хувь хүнд эрүүгийн хариуцлага ноогдуулж байсан ч эдгээрийг бүрэн тайлбарлаж өгөөгүй. Урт, ээдрээтэй өгүүлбэр хэд хэдэн удаа орсон, тулгараад буй эрх зүйн болон баримтын сорилтуудыг иж бүрэн ойлгуулах хэмжээнд хүрээгүй. Шинээр батлагдсан Эрүүгийн хуульд эдгээр асуудалтай буюу тодорхойгүй хэллэгүүдийг хассан. Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль нь өгүүлбэрийн бүтцийн хувьд илүү тодорхой, холбох болон салгах нь илт сайжирчээ.

## ОРХИГДОЛ БОЛОН ЗӨРЧИЛ

Эрх зүйн орчин зарим талаар сайжирсан ч орхигдол, хийдэл байсаар. Эдгээрийг тоймлон Зэрлэг амьтны хууль бус ан агнуурын эрх зүйн орчны мониторингийг хүснэгт 15-аар харуулав. Энэхүү хүснэгт нь ерөнхийлсөн буюу бүхий л агуулгыг үл багтаасан ч эрх зүйн орчинд хамаарах хууль нэг бүрийн зохицуулж буй зэрлэг амьтны худалдааны чухал салбарууд, үйл ажиллагааг харуулж чадна.

Хууль, журмуудын жагсаалт бүхий мөр нь тухайн хууль нь зэрлэг амьтны худалдааны тухай нэг эсвэл үүнээс дээш тооны заалтуудыг хамарсан, мөн тухайн хуулийн зохицуулж буй нийт салбар/үйл ажиллагааны тоо нь үндсэн үзүүлэлт болсон. Багананд зэрлэг амьтны худалдааны гол чиглэл/үйл ажиллагааг жагсаасан ба хамаарах хууль, тэдгээрийн давхцал, мөн зөрчилдөх байдлыг харуулна. Багана дээр хуулийн хэрэгжилттэй хамаарах нийт 21 үйл ажиллагааг өртгийн сүлжээний логикоор зохион байгуулж, зүүнээс баруун тийш 6 үндсэн бүлэгт хамааруулан оруулсан. Үүнд:

1. Эхний бүлэг нь зэрлэг амьтан эзэмших, хамгаалах үйл ажиллагаа, судалгааны ерөнхий асуудлуудыг тусгасан. Үүнд амьтны зүйлийн статус, хамгааллын түвшнийг оруулсан ба амьтны зүйлийг хууль ёсоор агнах, хамаарах захиргааны болон эрүүгийн хариуцлагын түвшнийг харуулах ач холбогдолтой.
2. Удаах бүлэг нь тусгайлан заасан газар нутгууд (зэрлэг амьтны хувьд үнэ цэнэтэй тусгай хамгаалалттай газар, агнуурын бүс, эсвэл амьтан хамгаалах зорилгоор байгуулсан амьтны хүрээлэн гэх мэт) дахь хамгааллын үйл ажиллагаа болон ноогдуулах хариуцлагыг багтаасан.
3. Гуравдугаар бүлэг нь агнуур болон худалдаатай холбоотой асуудлууд (зэрлэг амьтныг гэршүүлэх, өсгөн үржүүлэх, байгаль тавих болон авч ашиглах, агнуур, загасчлал)-ыг агуулсан. Тус бүлгийг маш ерөнхий байдлаар өндөр түвшний тойм мэдээлэл олгох зорилгоор оруулав. Шаардлагатай тохиолдол бүрт хамаарах дэлгэрэнгүй мэдээллийг дараагийн хэсэгт бичсэн.
4. Дөрөвдүгээрт бүлэгт хууль бус худалдааны

сүлжээний тодорхой элементүүд (амьтан эзэмших, тээвэрлэх, боловсруулах, хадгалах зэрэг)-ийг багтаасан.

5. Тавдугаар бүлэг нь эмийн худалдаа, зэрлэг амьтны бүтээгдэхүүний зар сурталчилгаа, цахим худалдаа, дотоодын болон олон улсын худалдаа зэрэг худалдааны хамаарал бүхий бүрэлдэхүүн хэсгийг хамааруулсан.
6. Эцэст нь хууль сахиулах үйл ажиллагаатай холбоотой онцлог элементийг жагсаан оруулсны тоонд хууль сахиулах эрх мэдэлтэй холбогдох тусгайлсан зүйл, заалтууд, захиргааны зөрчил, эрүүгийн хэргийг тодорхойлсон заалтууд, хүлээлгэх хариуцлагуудыг багтаасан болно.

Энэхүү хүснэгт нь зэрлэг амьтны худалдааны эрх зүйн орчныг бүрэн харуулахыг зориогүй, харин ерөнхий тойм байдлаар үзүүлж, гол шинжүүдийг үзүүлэх зорилготой. Өнгөөр ялгаж, тэмдэглэгээ тавьсан хэсэг нь тодорхой хуулийн тухайн бүлэг үйл ажиллагаа, асуудлуудтай холбогдох байдлыг илтгэнэ. Харин өнгөөр ялгасан хэсэгт тэмдэглэгээ байхгүй бол хуульд тухайн асуудалтай холбоо бүхий агуулга багтаагүй гэсэн утгатай. Гэхдээ энэ нь тодорхой хууль, журмын тухайн үйл ажиллагаатай шууд холбогдох байдлыг илэрхийлсэн болохоос зүйл заалтын чанарын үнэлгээ, хуулийн үр дүнгийн талаарх агуулгыг илэрхийлээгүй болно. Үүнээс харвал хамаарал байхгүй байгаа нь нэг талаас эрх зүйн орчинд үүссэн орхигдол, цоорхойг илэрхийлэх талтай. Үүний нэгэн адил тухайн нэг асуудал нэг, эсвэл үүнээс дээш тооны хуулиар зохицуулагдаж буй бол эдгээрт ямар нэгэн цоорхой, эсвэл зөрчил байна гэдгийг шууд харуулах нотолгоо болохгүй. Мөн энэ нь зохицуулалтын элементүүд хамтдаа байгаа, эсвэл байхгүйг харуулахгүй. Учир нь тухайн зүйл, заалтууд хамтдаа зохистой, иж бүрэн зохицуулалтыг системийг бүрдүүлдэг байж болно.<sup>347</sup>

Энэхүү хүснэгтээс ажиглаж болох ерөнхий хэв шинж бол:

- Зөвхөн зохицуулж буй үйл ажиллагааны тоо дээр үндэслэвэл амьтны худалдаатай хамгийн их хамаарал бүхий хууль бол Амьтны тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хууль байна.
- Амьтны тухай хууль нь Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд заасан олон тооны хариуцлагын эх үндэс нь болж байна. Уг хууль нь амьтны ховордлын зэрэглэл (ховор, нэн ховор)-ийг тодорхойлон гаргаж байна. Хуульд мөн агнуур хийхийг хориглосон улирал, аргачлал, нутаг дэвсгэр болон бусад зүйлсийг заажээ.

347 Энэхүү тайлан дээр статик байдлаар харуулсан дүрслэлийг Лийгэл Атласын үүсгэсэн платформ дээр динамик хэлбэрээр онлайн үзэж болох бөгөөд тухайн платформ нь салбар бүрт хамаарах заалтуудыг харуулж, хараат бус, байнгын үнэлгээг гаргадаг.

- Эрүүгийн хууль нь тодорхойлсон бараг бүхий л үйл ажиллагаагаар ямар нэгэн байдлаар хамааралтай тул чухал хуулиудын нэг болно. Гэхдээ энэ дүгнэлтийг тус хуулийн бүрэн бүтэн, хангалттай байдлын үнэлгээ хэмээн андуурч болохгүй. Энэхүү хуульд заасан хэд хэдэн элемент нь зарим тохиолдолд алдаатай байж болох шалгаан нь энэ хууль зөвхөн эрүүгийн хариуцлагыг тогтоох зорилготой. Энэ чиглэлийн хариуцлагыг заасан цорын ганц хууль болохын хувьд энэ нь мөн бүхий л боломжит зүйлийг хамраагүйг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, дараах зүйлстэй холбоотой эрүүгийн хариуцлага заагдаагүй байна. Үүнд:

- Хууль бусаар эзэмших,
- Эмийн худалдаа,
- Хууль бусаар гэршүүлэх гэх мэт.

Хуульд тээвэрлэх, эсвэл хадгалах зэрэг үйл ажиллагааг тусгасан ч зэрлэг амьтныг хууль бусаар эзэмших үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт багтаан оруулаагүй.

- Зэрлэг амьтан агнах нь 11 өөр хуульд заасан томоохон асуудал юм. Зарим хууль нь бусад хуульд заасан шаардлагыг зөвхөн хэрэгжүүлэх, эсвэл шаардлагатай зөвшөөрөл, эсвэл хориг тавих үүрэгтэй. Эдгээрийн ихэнх нь Монгол Улсын улс хэмээх статустай бүрэн нийцсэн, мөн хэрэглэгч болон дамжин өнгөрүүлэгч улс болохыг хамааруулсан зохистой заалт бүхий хуулиуд байна.
- Зэрлэг амьтны гаралтай эмийн худалдааг дээр дурьдсан хуулиудын аль нэгээр бүрэн зохицуулаагүй. Эрүүгийн хуульд ийм төрлийн худалдаанд хамааралтай байж болох хэд хэдэн үйлдлийг заасан ч эмийн худалдааг шууд эрүүгийн хэрэг хэмээн үзсэн зүйл заалтгүй. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль нь уламжлалт эмийн худалдааны тухай заалтыг багтаагаагүй.
- Дархан цаазтай зэрлэг амьтан эзэмших үйлдлийг хангалттай хэмжээнд зохицуулаагүй. Амьтны тухай хуулийн III бүлэг дээр эзэмшилтэй хамаарах хэд хэдэн шаардлагуудыг тусгасан ч аль ч “Эзэмших” хэмээх үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт хамруулаагүй. Эрүүгийн хууль нь хамаарах хэд хэдэн үзэл баримтлал болон тээвэрлэх, хадгалах, боловсруулах, ашиглах, цуглуулах зэргийг хамарсан ч хууль бусаар эзэмшихийг шууд заасан зүйл, заалтгүй.
- Тээвэрлэх, боловсруулах болон хадгалах үйлдлийг эрүүгийн гэмт хэрэг хэмээн зааснаас бусдаар өөр зохицуулалтгүй. Өөрөөр хэлбэл, эдгээрийн эрх зүйн хэлбэр нь ямар байх вэ гэдгийг харгалзаж үзсэн байх шаардлагатай.

Өмнө хийсэн дүн шинжилгээтэй хамаарах, гэхдээ Орхигдол/зөрчлийн мониторинг дээр харагдахгүй дараах бусад орхигдол байна. Үүнд:

- o Нэн ховор, ховор амьтныг худалдаалж буй хуулийн этгээдэд ноогдуулах хариуцлага тусгагдаагүй. Ерөнхийдөө ийм төрлийн хууль бус худалдааг аж ахуйн нэгжүүд үйлдэх нь түгээмэл. Энэ тохиолдолд ноогдуулж буй торгуулийн хэмжээ нь ховор амьтны худалдаанд ноогдуулах торгуулийн хэмжээний 5%-иас, нэн ховор амьтны худалдаанд ноогдуулах торгуулийн 3.8%-иас дээш байна. Хуулийн бүтцийг харвал энэхүү маш бага хэмжээний торгуулийг ноогдуулах, эсвэл хуулийн этгээдүүд эрүүгийн хариуцлагаас бүрэн мултрахыг нээж өгч байна.
- o Зэрлэг амьтны хууль бус худалдаа эрхэлж буй зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлд нэмэгдүүлсэн торгууль ноогдуулах тухай шууд заалтгүй. Зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлд хамааралтай шууд хамаарах цорын ганц заалт нь "Хориотой бараа, бүтээгдэхүүн худалдаалах болон мөнгө угаах" хэмээх үйлдэл байна. Хууль бус худалдааны хувьд тухайн бараа бүтээгдэхүүн нь "Хориотой" эсвэл "Хязгаарлагдсан" хэмээх ангилалд багтахгүй тохиолдолд торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх боломжгүй мэт харагдаж байна.
- o Худалдааны сүлжээний бүхий л хэсэг бүрэн хамрагдаагүй. Хууль бус худалдааны хамгийн чухал хэсгийн нэг болох "Хууль бусаар эзэмших" хэмээх үйлдлийг Эрүүгийн хууль дээр тусган оруулаагүй. Үүнд хамааралтай бусад үзэл баримтлал болох "Тээвэрлэх", "Цуглуулах", "Хадгалах" зэрэг үйлдлийг тусгасан ч "Эзэмших", "Худалдах" хэмээн үйлдэлтэй харьцуулбал хязгаарлагдмал байдлаар тусгажээ. "Эзэмших" гэдэг нь илүү өргөн ойлголт бөгөөд, илрүүлэх болон нотлоход (заавал тодорхой зорилго, завдал нотлохгүй) хялбар тул хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн аргачлалын нэг байдаг. Тиймээс энэ нь зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэргийг яллахад чухал үүрэгтэй.
- o Амьтны гаралтай эмийн худалдааг "Бэлтгэх", "Цуглуулах", "Хэрэглэх" хэмээн үйлдлийн хүрээнд авч үзсэн. Эмийн тухай хууль нь өөрийн зохицуулах хүрээнээс уламжлалт эмийн асуудлыг орхигдуулсан байна. Энэхүү цоорхойг "Нэн ховор" болон "Ховор" зүйлийг хамарсан ерөнхий заалтаар бөглөж болох ч бусад амьтанд хамаарахгүй сул талтай.
- o "Нэн ховор", "Ховор" жагсаалтад ороогүй, эсвэл CITES-д үл хамаарах амьтны зүйлийн экспортод оноох шийтгэл тодорхойгүй. Зөрчлийн тухай хуулиар зохих зөвшөөрөлгүйгээр экспортолсон тохиолдлыг шууд заасан заалтгүй. Харин энэ нь хэрэглээг "Хориотой" болон "Хязгаарлалтай" бараа

дээр хэрэглэхээс хязгаарласан ч<sup>348</sup>бүх төрлийн амьтан тухайн зөвшөөрөлд хамаарах эсэх нь тодорхойгүй.

## ЭРХ ЗҮЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХОД АНХААРАХ ЗҮЙЛС

Эрх зүйн тогтолцоонд түгээмэл байдагчлан нэг хуульд хийсэн нэмэлт өөрчлөлт нь өөр хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэлийг үүсгэнэ. Анхдугаар тайлан гарснаас хойш арван жилийн хугацаанд зэрлэг амьтны худалдаатай холбоотой гол хуулиудын ихэнхэд нэмэлт өөрчлөлт оруулж, зарим тохиолдолд шинэчилсэн найруулгыг батлан гаргажээ. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдээс үүдэн зарим хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарсан ч цаг хугацаанаас хамаарсан хүлээлт үүсэж, улмаар энэ нь шинээр хийсэн тухайн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд саад учруулдаг. Үүний уршиг нь хамаарах яам, агентлагуудыг өдөр тутмын үндсэн чиг үүргээ гүйцэтгэхэд мухардалд хүргэх байдлаар илэрнэ. Энэ нь судалгааны явцад батлагдсан бөгөөд ХЗЯ-ны зарим ажилтнуудын хэлснээр шинээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах тухай хууль батлагдан гарсны дараа олон хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлага үүссэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үндсэн үүргээ гүйцэтгэхэд нь саад тулгарч байсан тухай дурдсанаар батлагдаж байна.<sup>349</sup>

348 Гаалийн татвар, гаалийн тарифын тухай хууль. 3.1.1.

349 Гол оролцогч талтай хийсэн ярилцлага (ХЗЯ).

Хүснэгт 15. Зэрлэг амьтны хууль бус худалдааны эрх зүйн орчны байдал

2017 МОНГОЛ УЛС  
**ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХУУЛЬ БУС ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ БАЙДАЛ**  
 Голлох зохицуулах элементүүд хуульд багтсан/багтаагүй эсэх

	ЭЗЭМШИЛ СУДАЛГАА БОЛОН ХАМГААЛАЛТ СТАТУС	ГАЗАР ДЭЭР ГАЗАР ДЭЭР БУС	ГЭРШҮҮЛЭН ТЭЖЭЭХ ҮРЖҮҮЛЭХ БУЦААН ТАВИХ АГНАХ	ЭЗЭМШИХ ТЭЭВЭРЛЭХ	БОЛОВСРУУЛАЛТ ХИЙХ ХАДГАЛАХ	ЭМНЭЛГИЙН ХЭРЭГЦЭЭНД ХУДАЛДААЛАХ СУРТАЛЧЛАХ ЦАХИМААР БОРЛУУЛАХ ДОТООДЫН ХУДАЛДАА ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА	ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГА ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА
Зар сурталчилгааны тухай хууль						■ ■	·
Авлигатай тэмцэх тухай хууль							■ ·
Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль							■ ·
Ховор төрөл зүйлсийн жагсаалт	■						
Үндсэн хууль	■						
Эрүүгийн хууль	■ ■ ■		■ ■	■ ■ ■	■ ■ ■	■ ■ ■ ■	■
Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль							■ ·
Гаалийн тухай хууль							■ ·
Байгаль орчны чиглэлээр авах арга хэмжээний тухай тогтоол							■ ·
Байгаль орчныг хамгаалах тухай хууль	■ ■						■ ·
Амьтны тухай хууль	■ ■ ■	■	■ ■ ■ ■	■			·
Ойн тухай хууль	■	■					
Ангийн хорио		■					
Ан агнуурын квот							
Зөрчлийн тухай хууль				■ ■ ■		■ ■ ■ ■	■
Ан агнуурын нөөц ашигласан төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хууль							■ ·
Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	■						·
Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль	■ ■						■ ■
Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль						■	
Тусгай хамгаалалттай газар нутгийн талаар авах арга хэмжээний тухай тогтоол	■	■					
Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль	■	■					■
Татварын хууль							

# Зэрлэг амьтны хууль бус худалдааг

## яллах нь

### Хуваагдмал тогтолцоо

Зэрлэг амьтны холбогдолтой гэмт хэргүүд нь өмнөх хэсэгт дурдсан хууль сахиулах үүрэг бүхий ажилтнуудын оролцоотойгоор орон нутагт илрэх байдлаар эхэлдэг. Үндсэндээ энэхүү үйл явц нь байгаль хамгаалагч, гаалийн байцаагч, эсвэл хил хамгаалалтын ажилтан нь зэрлэг амьтны хууль бус худалдаа байж болох эсжигтэй тохиолдлыг саатуулан, улмаар Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст мэдэгдэх зэрэг арга замаар хэрэгждэг. Улмаар цагдаагийн газар тухайн асуудлаар хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт гүйцэтгэж, эрүүгийн байцаан шийтгэх журмын дагуу эд мөрийн баримт, нотолгоог бүрдүүлдэг. Хэрэв баримт нотолгоо хангалттай гэж үзвэл прокурорт хандах ба энэ шатанд тухайн хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах, эсвэл яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлэхэд хангалттай үндэслэл буй эсэхийг магадлан шалгадаг. Энэ тохиолдолд прокурор нь төрийг төлөөлөн, хэргийг хамаарах анхан шатны шүүхэд шилжүүлдэг.

Зураг 18. Хууль бус худалдааг мөрдөн шалгах, яллах үйл явц



Үүнээс харвал яллах үйл ажиллагаа нь шүүхэд шилжүүлэн, тухайн гэмт хэрэгт ял ноогдуулахаас өмнө хэд хэдэн байгууллагыг хамарсан олон үе шат, дараалал бүхий үйл явц байдаг (зураг 18). Цуглуулсан нотлох баримтын чанар, иж бүрдэл зэргээс хамааран прокурор нь тухайн хэрэгт яллах дүгнэлт үйлдэх, эсвэл

хэрэгсэхгүй болгох шийдвэрийг гаргана. Илрүүлэх, мөрдөн байцаах, яллах зэрэг эдгээр шагыг дамжих нь эрүүгийн хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэглэх, зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэрэгт ял шийтгэл ноогдуулах болон цаашид гарч болохуйц гэмт хэргийг таслан зогсооход нөлөө үзүүлэх боломжтой ял ноогдуулах зэрэгт чухал нөлөөтэй. Гэмт хэргийн газар дээр хамгийн түрүүнд ирж, ажиллаж буй ажилтнууд нь тухайн хэргийн газрыг хамгаалалтад авах, эд мөрийн баримтуудыг бэхжүүлэх, түүнчлэн биет баримт нотолгоо цуглуулах, дээж сорьц болон нотолгоог шүүхийн шинжилгээнд хамруулахад голлох үүргийг гүйцэтгэнэ. Энэхүү хуваагдмал тогтолцоо нь зөвхөн Монгол ч байдаг зүйл бус харин хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мөрдөн шалгах үйл ажиллагаанд дэлхий нийтээрээ ашигладаг түгээмэл хэрэглэдэг тогтолцоо юм. Хяналт шалгалт болон мөрдөн байцаалтын өмнөх шатанд авсан арга хэмжээг сайтар ойлгох нь тухайн хэргийн цар хүрээ, цаашид шийдэгдэх боломж зэрэгт ихээхэн нөлөө үзүүлэх ба зарим улсад (АНУ, Герман, Франц)<sup>350</sup> тэргүүн шугамд ажилладаг хууль сахиулах байгууллагын ажилтнуудад хэдэн хэдэн шагны мөрдөн байцаалтын эрхийг олгож, хамаарах сургалтад хамруулдаг. Монгол Улс ч энэхүү чиглэлд арга хэмжээ авч, Гаалийн байцаагч нарт хяналттай хүргэлт буюу тээвэрлэлт, хүргэлтийг мөрдөн хянах<sup>351</sup> (хууль бус бараанд ажиглалт хийн хил нэвтрүүлэн, улмаар эцсийн цэг хүртэл нь мөрдөх замаар хамаарах бүхий л баримт нотолгоог цуглуулан, хууль бус худалдааны сүлжээний гишүүдийг олж илрүүлэх арга техник) эрхийг олгожээ.

### ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГА

Эрүүгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг бий прокурорын байгууллага нь 85 жилийн түүхтэй, Үндсэн хууль (56 дугаар зүйл), Прокурорын тухай хуулиар (2002 оны шинэчлэгдсэн хууль) олгогдсон эрх бүхий хараат бус байгууллага юм. Тус байгууллага нь шүүх эрх мэдлийн салбарын нэг хэсэг бөгөөд гүйцэтгэх засаглалаас хараат бус, Ерөнхий прокурор болон түүний хоёр орлогчийг 6 жилийн хугацаагаар Монгол Улсын ерөнхийлөгч томилдог. Нөгөө талаар энэ байгууллага нь гүйцэтгэх засаглалын нэг хэсэг болох Хууль зүйн яамны харьяанд хамаарахгүй. Энэ байгууллагыг гүйцэтгэх засаглалаас бүрэн салгасан нь зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд дээр дурдсан харилцан уялдаа холбоог бууруулах (silo effect), (Хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэмээх хэсгийг үзнэ үү) сөрөг нөлөө үзүүлж байх талтай. Тухайлбал, хууль сахиулах байгууллагын ажилтнууд 2015 онд тулгарсан асуудал болох 31 ширхэг шонхорын хэргийг мөрдөн байцаах, прокурорын яллах үйл ажиллагааны талаар дурдсан. Тус хэрэгт эцэст нь 992 сая төгрөгийн торгууль ноогдуулан шийджээ. Гэтэл БОАЖЯ-наас тухайн

350 Жишээ нь АНУ-д Үндэсний паркийн алба болон Ойн алба нь мөрдөн байцаалт явуулах эрх бүхий тусгайлан сургагдсан ажилтнуудтай байдаг.

351 Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, 252 дугаарзүйл.

хэрэгт яллагдсан этгээдэд ан агнуурын зөвшөөрөл олгосон зөрчил гарчээ.<sup>352</sup>Прокурорын газар болон БОАЖЯ-ны хооронд захиргааны хуваагдал байдаг тул ийм төрлийн давхцал үүсэх магадал өндөр.

Прокурорын байгууллагын 5 нэгж нь бүгд эрүүгийн гэмт хэргийн мөрдөн байцаалтад хяналт тавих, яллах чиг үүргийг бусад техникийн, захиргааны болон консулын нэгж, газруудын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлдэг. Эдгээр нэгжүүд болох Мөрдөн байцаах хэлтэс (албаны хэмжээнд хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг), Шүүхэд төлөөлөх хэлтэс болон бусад гурван хэлтэс нь цагдаа, тагнуулын байгууллагын явуулж буй хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт болон ял эдлүүлэхэд хяналт тавих үүрэг гүйцэтгэдэг.

Газар зүйн хувьд Прокурорын газар нь 39 хэсэг болж хуваагдана. Үүнд: Нийслэлийн прокурорын газар, 21 аймгийн прокурорын газар, Тээврийн прокурорын газар, 8 дүүргийн прокурорын газар болон хилийн боомт бүхий газруудад үйл ажиллагаа явуулдаг 8 сум дундын прокурорын албанаас бүрдэнэ. Эрүүгийн гэмт хэргийг үйлдсэн газрын хамгийн ойр буй прокурорын газарт шилжүүлэх ба гэмт хэргийн төрлөөр нь ямар нэгэн хуваарилалт үл хийдэг.

2011 онд Прокурорын байгууллагын 80 жилийн ойд зориулсан байгууллагын тайлангаас үзвэл<sup>353</sup> (судалгааны хүрээнд нээлттэй олдсон цорын ганц тайлан) Прокурорын байгууллагад 381 прокурор, 73 туслах прокурор, 300 гаруй техникийн болон захиргааны ажилтнууд ажиллаж байна.

#### Зураг 19. 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдөр болсон прокуроруудын сургалтын арга хэмжээ



352 Нийслэлийн прокурорын газраас 2016 оны 6 сарын 10-ны өдөр зохион байгуулсан прокурорын сургалт дээр МХЕГ-ын байцаагчийн хийсэн танилцуулга.

353 Монгол Улсны Ерөнхий прокурорын газар, 2011.<http://www.track.unodc.org/LegalLibrary/LegalResources/Mongolia/Authorities/Mongolia%20-%20The%20State%20General%20Prosecutor's%20Office.pdf>

Эрх зүйн тогтолцооны хүрээнд нэг прокурор хэдэн хэрэг хариуцах буюу ажлын ачааллын хувьд зохистой байх тал дээр тогтсон зөвшилцөлд хүрээгүй ч График 1-д үзүүлсэн баримт нь прокурорын байгууллага нь энэхүү үүргээ гүйцэтгэх хангалттай хүн хүчтэй байгааг харуулна. Монгол улсад мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нийт эрүүгийн гэмт хэргийн статистикаас үзвэл өнгөрсөн 10 жилийн хугацаанд жил тутам шалгасан гэмт хэргийн тоо 20,000 хүрэхгүй байсан ч өнгөрсөн 3 жилд 25,000 хүрч нэмэгджээ. Энэ баримтаар бол нэг прокурорт жилд 50 хэрэг ойролцоогоор ноогдохоор байна.<sup>354</sup>Хэрэг болгон ялгаатай, цаг хугацаа болон шаардлагатай нөөц, эх үүсвэрээс хамаарах ялгаатай ч бусад улсад нэг прокурорт ноогдох хэргийн тоо хамаагүй өндөр байна.<sup>355</sup>Мөн прокурорууд нь хэргийн удирдлагад шаардлагатай бүхий л арга хэрэгслийг ашиглах, жишээ нь яллах боломжгүй хэргүүдийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэх, эсвэл хойшлуулах арга замаар өөрийн ажлын ачааллыг удирдах боломжтой. Ярилцлагад хамрагдсан хүмүүсийн баримтаас хэргийн ачаалал нь тэдний ажил үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд сөргөөр нөлөөлөх анхдагч хүчин зүйл бус ажээ.

График 1 нь прокурорын байгууллагын хяналт хийж буй байгаль орчны эсрэг гэмт хэргийн тоо 2006 онд 54 байсан бол 2012 онд хамгийн их буюу 410-д хүрчээ. Хэрэв прокурорын байгууллагын хянаж буй нийт хэргийн 1% хүрэхгүй нь зэрлэг амьтны эсрэг гэмт хэрэг бол эдгээр хэргийг яллахад шаардлагатай хүн хүч, нөөцийн хэмжээ нь (ажилтнуудын цаг, мөрдөн байцаалтын төсөв, тусгайлсан сургалт гэх мэт) мөн л тэр хувь хэмжээнд байна хэмээн таамаглаж болно.

хаягаар үзнэ үү.

354 Тооцоог гаргахдаа 2011 онд ажиллаж байсан прокуроруудын тоог (381) 2011 онд мөрдөн байцаалт хийсэн Эрүүгийн хэргийн тоотой (19,197) харьцуулав. Үүнээс гарсан үр дүн болох 50,8 нь нэг прокурорын жилд хянаж буй хэргийн тоо хэмээн тооцсон.

355 Gershowitz, A. and L.. Killinger. 2011. The State (Never) Rests: How Excessive Prosecutorial Caseloads Harm Criminal Defendants. Northwestern University Law Review. Vol. 105, No. 1.

График 1. Мөрдөн байцаалт явуулсан гэмт хэргүүд: Байгаль орчны эсрэг гэмт хэрэг (2006-2015)



## НОТОЛГООГ БЭХЖҮҮЛЭХ, ХАДГАЛАХ

Гэмт хэргийн биет нотлох баримт нь эрүүгийн хэргийн нэг чухал хэсэг байдаг. Зэрлэг амьтны хамааралтай гэмт хэргийн хувьд тухайн нөхцөлд биет нотлох баримт нь зөвхөн чухлаас гадна хэргийг шийдэх хамгийн гол бүрэлдэхүүн болдог. Зэрлэг амьтны хууль бус агнуур болон худалдааны хэрэг нь тухайн хууль бус үйлдлийг бодит баримтаар нотлохыг, тухайлбал, дээж сорьцоор (амьд амьтан, эд эрхтэн, эсвэл бүтээгдэхүүн), хэрэглэсэн зэвсэг, авто машин, баримт бичиг болон бусад олон зүйлсээр нотлохыг шаарддаг. Тухайн баримт нотолгоог хэргийн газар дээр бэхжүүлэн аваагүй, мөрдөн байцаалтын явцад зохих ёсоор хадгалаагүй бол яллагдагчаас тухайн нотлох баримтын хүчин төгөлдөр, үнэн бодит эсэхийг шүүх дээр хялбархан няцаах боломжтой. Хөдөлшгүй баримт нотолгоо дутмагаас тухайн гэмт хэргийг яллах прокурорын боломж хязгаарлагддаг.

Монгол Улсын хувьд Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар нотолгоотой холбоотой арга ажиллагаа болон техникүүдийг зааж өгсөн байдаг. Тус хуулийн Бүлэг 11 (нотлох баримт) болон Бүлэг 12 (Нотлох ажиллагаа) нь нийт 25 зүйлээр дамжуулан бүх төрлийн нотлох баримтыг цуглуулах, баримтжуулах, бэхжүүлэх, хадгалах болон устгах талаар заажээ. Харамсалтай нь биет нотлох баримтын хувьд Эрүүгийн хуулиар баримтжуулах, гэрэл зураг авах, битүүмжлэх, хэрэгт

хавсаргах боломжгүй тохиолдолд тусгай газарт хадгалах зэрэг ерөнхий аргачлалыг шаарддаг. Уг хууль нь эдгээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хэрэглэж болох аргачлал, тодорхойлолтыг заагаагүй дутагдалтай. Үүнээс үүдэн зэрлэг амьтны эсрэг гэмт хэрэг нь баримт нотолгооны хадгалалт болон танилцуулж буй байдлаас хамааран яллах боломжийг бууруулдаг. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нэг шүүгч өмнө өөрийн шүүж байсан хоёр яллагдагч хорио тавигдаагүй үед 230 тарвага агнасан хэргийн талаар ярьсан бөгөөд шүүхээс тухайн хэрэгт холбогдуулан хураан авсан дээж сорьцтой хамаарах нотолгоо дутмаг, гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсгийг олж тогтоогоогүй зэргээс үүдэн нотлох баримт хангалтгүй байна хэмээн үзэж байсан. Энэ тохиолдолд ял ноогдуулахдаа яллагдагчийн талд ашигтай шийдэх зарчмыг баримталжээ.<sup>356</sup>



Улаанбаатар хот дахь дүүргийн анхан шатны шүүх дээр эрүүгийн гэмт хэргийн талаар танилцуулахаар бэлтгэж буй улсын яллагч прокурор

Баримт нотолгоог зөв хадгалах нь Монгол Улсад зэрлэг амьтны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгахад тулгардаг томоохон хүндрэл хэмээн үзжээ. Түргэн муудах тул зэрлэг амьтны нотолгоог аюулгүй, уур амьсгалын хувьд нийцтэй хадгалах байгууламжид хадгалах шаардлагатай. Зарим улс орнуудын хувьд баримт, нотолгоог хөргөлттэй, 24 цагийн хяналттай, хуурай хадгалах байгууламжид баримт нотолгоог хадгалж, ажилтнуудын бүртгэлийг нарийн хийдэг. Монгол Улсын хувьд Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийтлэг үйл явцыг заагаагүй, баримт нотолгоог хадгалах тухай ямар нэгэн тусгайлсан дүрэм, журам байхгүй. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн хэлж буйгаар Монгол Улсад зэрлэг амьтны хамааралтай гэмт хэргийн баримт, нотолгоог хадгалах стандартын байгууламж байхгүй, зохих байгууламж барьж байгуулах нөөц эх үүсвэр шаардлагатай.

Биет баримт хадгалах талаар эрх зүйн зохицуулалт хангалттай байхгүйн улмаас прокурорууд тухайн хэрэг бүрт нийцүүлэн, зохицуулах арга замаар ажиллаж

<sup>356</sup> Нийслэлийн прокурорын газрын зүгээс 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан сургалт дээр шүүгч Дашдондовын хийсэн танилцуулга.

байна.<sup>357</sup>Хураан авсан шархадсан зэрлэг амьтны хувьд, амьтан асран хамгаалах байгууламжгүй тул хууль сахиулах байгууллагын ажилтнууд эргүүлэн байгальд суллан тавихаас өөр аргагүйд хүрдэг. Үхсэн тарвага хураан авсан тохиолдолд нийгмийн эрүүл мэндийн шалтгаанаар Зоонозын өвчин судлалын төвд шилжүүлэн устгалд оруулдаг. Бусад тохиолдолд судалгааны төвд хүргүүлэх, эсвэл нийтийн дуудлага худалдаагаар зарж борлуулдаг. Хавар, зуны улиралд ангийн мах хураан авах тохиолдолд тухайн нутгийн захиргааны байранд түр хадгалж, муудахаас нь өмнө устгалд оруулдаг. Түүнчлэн энэхүү судалгаагаар хууль бусаар загас барьсан этгээдийг торгосны дараа загасыг нь эргүүлэн өгч байсан тухай ярьж байсан. Хамгийн сайн нөхцөлд нотлох баримтыг муудахааргүй (эвэр, арьс зэрэг) хадгалах байр, сав байхгүй учир мөрдөн байцаагч, прокурорууд тухайн хураан авсан зүйлсээ хэрхэхээ мэдэхгүй болдог. Үүнээс үүдэн баримт гэмтэх, муудах, бохирдох, тэр ч байтугай нотолгооны чанараа алдана.

## ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ФОРЕНСИК НОТОЛГОО

Олон улсын хэмжээнд шүүхийн шинжилгээ нь зэрлэг амьтны гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал холбогдолтой. Энэ нь зэрлэг амьтны эд эрхтэн, эх үүсвэрийг тогтооход чухал үүрэгтэй. Шүүхийн шинжилгээний зарим ажилтнууд зөвхөн лабораторийн шинжилгээ хийдэг бол зарим нь гэмт хэргийн газар дээр ажиллаж шинжилгээ хийх стандартад нийцэхүйц баримт цуглуулах, бэхжүүлэх замаар дараагийн шатны шүүх дээр ашиглах нотолгоог бүрдүүлдэг.

Монгол Улсын хувьд нөөц эх үүсвэр хязгаартайн улмаас шинжээчид хэргийн газарт очиж үзлэг хийдэггүй. Харин цагдаагийн ажилтан дээж, сорьцыг Улаанбаатар хот дахь Биологийн хүрээлэнд шилжүүлэн шинжлүүлж, хураан авсан амьтны зүйл, агнасан хугацаа, нөхцөл байдлыг тогтоолгоно. Нотолгоог хадгалах тусгай сав, байгууламжгүйн улмаас шүүхийн шинжилгээний үр дүн хүндрэлтэй тулгарах ба шүүх дээр нотолгоог бохирдуулсан хэрэгт ордог.<sup>358</sup>

Шүүхийн шинжилгээг үр дүнтэй гүйцэтгэхэд саад тотгор учруулж буй өөр нэгэн зүйл нь тухайн шинжилгээний зардлыг сорьц дээж ирүүлсэн байгууллага хариуцаж байх зохицуулалт болдог. Төсөв хөрөнгөний дутагдалтай нөхцөл нь шинжилгээ байнга хийлгэх боломжгүй байдгийг судалгаанд хамрагдсан хууль сахиулах байгууллагын ажилтнууд өгүүлсэн (цагдаагийн байгууллага хэсгээс үзнэ үү).

357 Оролцогч талтай хийсэн ярилцлага (Нийслэлийн прокурорын газар); Мэдээлэгчтэй хийсэн ярилцлага # 4.12 (МХЕГ-ын байцаагч) болон Нийслэлийн прокурорын газрын зүгээс 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан сургалт дээр МХЕГ-ын байцаагчийн хийсэн танилцуулга

358 Оролцогч талтай хийсэн ярилцлага (Нийслэлийн прокурорын газар).

Ерөнхийлөн дүгнэвэл нөөц, эх үүсвэр хомс байх нь үйл ажиллагаа амжилттай явагдахгүйд хүргэх бөгөөд амьтны баримт, нотолгоо муудаж, хэрэгцээгүй болох нь Монгол улсад зэрлэг амьтны эсрэг гэмт хэргийг амжилттайгаар шийдвэрлэхэд томоохон саад тотгор болж байна.

## ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО

Монгол Улсад шүүх эрх мэдэл нь гурван түвшинтэй байх ба үүнд дээд шүүх, давж заалдах шатны шүүх (аймаг, нийслэлийн<sup>359</sup>) болон анхан шатны шүүх (сум, сум дундын болон дүүргийн) багтана. Дээд шүүх нь хамгийн дээд түвшнийх бөгөөд өмнөх шатны буюу нийслэл, аймгийн давж заалдах шатны шүүхээс гарсан шийдвэрийг судлан үзэх хяналтын шатны шүүх юм.<sup>360</sup>Эдгээр гурван шатны шүүх нь тусгайлан шүүхүүд бөгөөд Эрүүгийн, Иргэний хэргийн болон Захиргааны хэргийн шүүх болж хуваагддаг. Хүснэгт 16-д Монгол Улсын бүх 120 шүүх, тэдгээрийн хэрэг, маргаан шийдэх харьяалал, төрлийг харуулсан.<sup>361</sup>

Хүснэгт 16. Монгол Улсын шүүхийн системийн зохион байгуулалт

2016  
Монгол улс

## ШҮҮХИЙН СИСТЕМ

Шүүхийн шатлал	Шүүх, эрх мэдэл	Эрүүгийн хэрэг	Иргэний хэрэг	Захиргааны хэрэг	Нийт
Дээд шүүх	Улсын хэмжээнд	1	1	1	3
		1	1	1	
Давж заалдах шатны шүүх	Аймаг	8	8	8	27
	Нийслэлийн	1	1	1	
		9	9	9	
Анхан шатны шүүх	Сум	21	21	21	96
	Сум дундын	8	8	8	
	Дүүргийн	4	4	1	
		33	33	30	

Зэрлэг амьтны хамааралтай гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах онцлогийн талаар шүүх эрх мэдлийн тогтолцооны хэд хэдэн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд дээр

359 Зөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй шүүхийн харьяалалд нийслэл хот бүхлээр багтах ба үүнийг Нийслэлийн шүүх гэнэ. Дүүргийн анхан шатны шүүхүүд Улаанбаатар хотод байх ч тэдгээрийн харьяалал нь тодорхой хамаарах дүүргээр хязгаарлагдана.

360 Шүүх эрх мэдлийн салбарт хамаарах хамгийн сүүлийн эрх зүйн орчин нь 2013 оны 4 дүгээр сарын 15-наас хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн ба үүнд Шүүхийн тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хууль, Хуульчдын эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хууль болон Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль зэрэг багтаж байна. Дээд шүүхийн вэбсайтаас авав ([www.supremecourt.mn](http://www.supremecourt.mn)).


361 Монгол Улсын Дээд шүүхийн вэбсайтаас авсан мэдээлэл дээр суурилсан, [www.supremecourt.mn](http://www.supremecourt.mn).



тулгуурлан тайлбарлах шаардлагатай. Үүний эхнийх нь График 2-д үзүүлсэн Монгол Улс дахь эрүүгийн хэргийн шүүх хурлаар ял ноогдуулж буй хувь нь 2005-2014 онд 43% байжээ. Энэ нь прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэн, шүүхэд шилжүүлсэн нийт гэмт хэрэгт ял ноогдуулсан (өнгөрсөн 10 жилийн хугацаанд 19,927 байсан нь жилд ойролцоогоор 2000 орчим) хэмжээ юм (8,248 яллагдагч буюу жилд ойролцоогоор 800). Эрүүгийн мөрдөн байцаах үйл ажиллагааны үлдсэн 57% дээр баримт нотолгоо хангалтгүй, тухайн яллагдагчийн буруутайг хөдөлгөөнгүй нотолж чадаагүй.

График 2. Эрүүгийн хэргийг яллах үйл явцыг мөрдөн байцаалттай харьцуулсан нь

2005-2014  
МОНГОЛ УЛС  
ГЭМТ ХЭРЭГ ШАЛГАН  
ШИЙДВЭРЛЭЛТ  
ШҮҮХЭЭР ШИЙДСЭН ХУВЬ ХЭМЖЭЭ  
ДУНДАЖ



ХОЛБОГДОГЧИД  
2005 - 2014 жилийн дундаж

19,237


ЯЛЛАГДАГЧИД  
2005 - 2014 жилийн дундаж

8,248

ЭХ СУРВАЛЖ Монгол улсын статистикийн мэдээллийн үйлчилгээ (www.1212.mn)

Монгол улсын эрүүгийн эрх зүйн тогтолцооны өөр нэгэн үзүүлэлт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үр дүн юм. График 3-д 2004- 2014 онд шүүхээс гарсан бүх шийдвэрээс (эрүү, иргэн, захиргаа) бүрэн гүйцэтгэгдээгүй шийдвэр нь 30 орчим хувьтай байна. 2013 болон 2014 онд нийт шийдвэрийн 77% нь амжилттай гүйцэтгэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт бол 2010 онд нийт шүүхийн шийдвэрийн 52% нь биелэгджээ.<sup>362</sup>Тиймээс шүүхийг шийдвэр гүйцэтгэл нь зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэргийг талаар судлан үзэхэд анхаарах ёстой өөр нэгэн чухал хүчин зүйл болж байна. Яллаж буй хэргийн тоо нь ноогдуулсан ялыг гүйцэтгэж буй хувь хэмжээтэй нийцэхгүй. Иймээс цаашид энэ дутагдалтай талыг сайжруулах шаардлагатай.

График 3. Шүүхийн шийдвэрийн хэрэгжилт



Өмнөх үзүүлэлттэй хамаарал бүхий (шүүхийн шийдвэрийн хэрэгжилт) өөр нэгэн үзүүлэлт нь эдийн засгийн хохирлын үнэлгээ (төрийн болон хувийн байгууллагуудад учруулсан) байна. 2005-2016 онд нийт үнэлсэн хохирол болон нөхөн төлбөрийн харьцаа нь дунджаар 3:1 буюу нийт учруулсан хохирлын 36% нь л төлөгдсөн байна (зураг 19). Өмнөх 10 жилийн эхний үед жилд учирсан хохирлын хэмжээг ойролцоогоор 40 тэрбум төгрөг (17.4 сая ам. доллар) хэмээн тооцжээ. 2013 оноос эхлэн энэхүү жил тутмын хохирлын хэмжээ бараг гурав дахин нэмэгдэж, 150 тэрбум төгрөгийн босгыг (65.2 сая ам.доллар) давсан ч түүнээс хойш эргэн буураагүй байна. Нийт 10 жилийн хугацааны нийт хэмжээнд үнэлгээ хийж үзэхэд учруулсан нийт хохирол болох 953 сая ам. доллараас ердөө 348 сая нь нөхөн төлөгджээ. Үүнээс үзвэл эргэн төлөгдөөгүй 600 сая ам. долларын зөрүү нь илүү үр дүнтэйгээр гэмт хэргийг нотлох протокол, тоног төхөөрөмж болон дэд бүтэц дутмагаас үүдсэн алдагдсан мөнгөн дүн юм. Үүнээс дүгнэвэл мөрдөн байцаах, яллах чадавхыг бэхжүүлэх, баримт нотолгоог илүү сайн хадгалах, харьцах болон бэхжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрүүдийг бүрдүүлэх нь тэргүүлэх холбогдолтой үйл ажиллагаа болж буй бөгөөд дотооддоо энэ чиглэлээр хөрөнгө оруулах нь учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхэд илүү холбогдолтой байх юм.

362 Монгол Улсын статистикийн мэдээллийн үйлчилгээ (www.1212.mn).

График 4. Эрүүгийн гэмт хэргээс учирсан хохирлын төлбөр



## Зэрлэг амьтны эсрэг гэмт хэргүүд

Өнгөрсөн арван жилд байгаль орчны эсрэг гэмт хэрэг нь нийт гэмт хэргийн багахан хувийг эзэлж байна. Энэ нь График 1-д харуулсан 250,000 хэргийн 2,500 орчим буюу ойролцоогоор 1%-тай л тэнцэж байна. Үүний дунд зэрлэг амьтны хууль бус худалдаанд хамаарах гэмт хэргийн тоо тун бага буюу тухайн 1%-ийн 15%-ийг буюу 1,000 хэрэг тутмын нэг нь л зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэрэг юм. Энэхүү судалгаа нь зэрлэг амьтны хамааралтай хэргийг яллах үйл ажиллагааны талаар үндэсний хэмжээний статистик мэдээлэл ашиглаагүй ч Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн гаргасан тооцоогоор тэдний мөрдөж буй нийт хэргийн ердөө 15% нь л зэрлэг амьтантай холбоотой байдаг ажээ (уул уурхайн холбогдолтой хэрэг түлхүү байдаг тул илүү анхааралд, нөөц эх үүсвэрийг үүнд зарцуулдаг). Прокурорын газрын гаргасан 21 аймгийн 17-оос авсан зэрлэг амьтны хамааралтай гэмт хэргийн тухай мэдээлэл болон зураг 20-д дэлгэрэнгүй харуулсан мэдээлэл нь мөн л ижил үр дүнтэй харуулж байна. 2007- 2017 оны мөрдөн байцаалт хийсэн зэрлэг амьтны хамааралтай гэмт хэргийн тоо 263 (220 нь хууль бус ан агнуур, 43 нь зэрлэг амьтны худалдаа) байсан нь тухайн хугацааны байгаль орчны эсрэг нийт гэмт хэргийн 11%-тай тэнцэнэ. Энэхүү судалгааны хүрээнд 2013- 2015 оныг хамрах 3 жилийн мэдээллийг прокурорын газраас гаргаж өгсөнгүй. Гэвч тус албаны

ажилтнуудын зүгээс прокурорын байгууллагын хянаж буй нийт хэргийн тоонд зэрлэг амьтны эсрэг гэмт хэрэг маш бага байдгийг баталсан бөгөөд нийт 8,000 эрүүгийн хэргийн дунд зэрлэг амьтны хамааралтай гэмт хэрэг ердөө 17 байна.<sup>363</sup>


График 5-д мөн эдгээрээс 65%-ийг нь шүүхэд шилжүүлж, үлдэх 35%-ийг нь прокурорын шатанд хэрэгсэхгүй болгожээ. Үүний шалтгаан нь нотлох баримт нотолгоо хангалтгүй гэж үзжээ. Мэдээлэл авсан 17 аймагт зэрлэг амьтны хууль бус агнууртай холбоотой 142 хэрэг, хууль бус худалдаатай холбоотой 27 хэргийг шүүхэд шилжүүлжээ.<sup>364</sup>

Гарч буй нийт хэрэг болон шийдвэрлэсэн хэргийн тооны зөрүү нь (худалдаалахаас илүү агнуурын хэрэг олон) хууль хэрэгжүүлэхэд баримт нотолгоо цуглуулах нь хамгийн хүндрэлтэй үйл ажиллагаа болохыг харуулж байна. Харамсалтай нь зэрлэг амьтны эсрэг гэмт хэрэг дээр шүүхийн ноогдуулсан ял шийтгэлийн тухай мэдээлэл хангалтгүй.

График 5. Эрүүгийн хуулийн 203, 175 дугаар зүйлийн дагуу мөрдөн байцаалт, прокурорын хяналт хийгдсэн хэргийн тоо

2007 - 2016 оны 6 сар  
МОНГОЛ УЛС (17 аймаг)

## ЗЭРЛЭГ АМЬТНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙГ ЯЛЛАХ АЖИЛЛАГАА



Нийслэлийн таван дүүргийн Прокурорын газарт хийсэн судалгаагаар Улаанбаатар хот дахь зэрлэг амьтны хууль бус агнуур, худалдааны гэмт хэргийн прокурорын хяналт, яллах ажиллагааны үйл явцын талаарх дүр зургийг гаргаж, зураг 21

363 Оролцогч талтай хийсэн ярилцлага (Нийслэлийн прокурорын газар).

364 Прокурорын байгууллагаас гарган ирүүлсэн мэдээлэл.

-д үзүүлэв).<sup>365</sup> Үүнээс анхаарал татахуйц хэсэг бол гурван жилийн хугацаанд нийслэлийн хэмжээнд зэрлэг амьтны холбоотой зөвхөн 17 хэрэг дээр л ажилласан байна. Мөрдөн байцаалтаас шүүхэд шилжүүлж буй хэмжээ доогуур буй нь өөр нэгэн анхаарах элемент бөгөөд ердөө 3 хэрэг буюу 18% нь шүүхэд шилжиж буй нь өмнөх дурдсан улсын дунджаас ч доогуур байна. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд (нийт 17 хэргийн 28 холбогдогч) үндсэндээ эрэгтэйчүүд (28 холбогдогчийн 26 нь), Монгол улсын иргэншилтэй (28 холбогдогчийн 25 нь) байна.

Зураг 20-т хураан авсан эд зүйлсийн талаар харуулсан ч сонирхолтой нь тухайн 17 хэрэг дээр зэрлэг амьтан, тэдгээрийн эд эрхтнийг хураан авсан зүйл байхгүй. Нийслэлд илэрэн эдгээр хэргүүдийн амьтны агнасан газар нь зургаан аймаг байсан бөгөөд Улаанбаатар хотын хэрэгцээг хангах зорилгоор түүнээс хэдэн мянган километрийн алсад байрлах газар нутагт хууль бусаар амьтан агнах үйл ажиллагаа явагддаг болохыг харуулж байна. Мөн эдгээр хэргүүдийн бараг хагас нь тээвэрлэсэн хэмээх үндэслэлээр, ердөө л 25% нь хууль бус худалдаа гэсэн үндэслэлээр шалгагдсан болохыг дурдах нь зүйтэй. Үүнээс үзвэл ямартаа ч нийслэлд цөөн тооны хэрэг шалгагдсан ба эдгээр нь зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэргийн эсрэг тусгайлсан ажиллагааны хүрээнд бөөний болон жижиглэнгийн худалдааны газруудад хийсэн шалгалтаар бус, харин автозам, эсвэл авто тээврийн хэрэгсэлд шалгалт хийх үед илэрчээ (жолооны үнэмлэх, автомашины гэрчилгээ, согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгах үед). Улаанбаатар хот дахь мэдээлэгчийн хэлснээр тарваганы махыг Улсын их дэлгүүрийн өмнөх гудамжны зарим цэгүүдэд байнга борлуулж байдаг ажээ. Энэ судалгаа нь Улаанбаатар хотын зэрлэг амьтны худалдааны маршрутын дагуу цэгүүд дээр байнгын, нарийвчилсан шалгалт хийж байх шаардлагатайг харуулж байна.

Зураг 20. 2014- 2016 онд зэрлэг амьтны эсрэг 17 гэмт хэргийн прокурорын хяналт



Нийслэлийн прокурорын газраас гаргасан статистик мэдээллийн ерөнхий хэв шинж нь Ховд аймагтай ижил төстэй. Ховд аймгийн прокурорын газрын мэдээлснээр 2014- 2016 онд нийт 14 хэрэг мөрдөн байцааснаас (ихэвчлэн янгир хууль бусаар агнасан хэрэг) дөнгөж дөрвийг шүүхэд шилжүүлсэн нь өмнө дурдсан хуулийн цоорхойгоос хамаарчээ.<sup>366</sup>

## ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ХЯЗГААРЛАЛТУУД

Өнгөрсөн арван жилийн хугацаанд зэрлэг амьтны эсрэг гэмт хэргийн мөрдөн байцаалт, прокурорын хяналт нь зэрлэг амьтны эсрэг гэмт хэргийг тусгайлан заасан Эрүүгийн хуулийн хоёр зүйл дээр л үндэслэжээ<sup>367</sup> (зураг 22). Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйл нь зэрлэг амьтны гаралтай эд зүйл хууль бусаар хил нэвтрүүлэх, 203 дугаар зүйл нь хууль бус ан агнуурын тухай заасан. Зурагт харуулснаар хууль бусаар хил нэвтрүүлэх үйлдэлд хууль бус агнууртай харьцуулбал арай өндөр торгууль, хүнд ял ноогдуулдаг. Хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг дээр нэмэлтээр албадан ажил хийлгэхээс гадна зохион байгуулалттайгаар үйлдсэн бол ялыг нэмж өгдөг.

365 Нийслэлийн прокурорын газраас 2016 оны 6 сарын 10-ны өдөр зохион байгуулсан сургалтын үеэр гүйцэтгэсэн судалгаа.

366 Оролцогч талтай хийсэн ярилцлага (Ховд аймгийн прокурорын газар).

367 2002 оны Эрүүгийн хууль, 2015 онд хийгдсэн нэмэлт өөрчлөлтийн өмнөх.

Зураг 21. Зэрлэг амьтны гэмт хэргийг яллахад баримтлах Эрүүгийн хуулийн зүйл заалтууд



Эрүүгийн хуулиар зэрлэг амьтад, тэдгээрийн эд, эрхтэн эзэмших, эсвэл дотоодод зарж борлуулахад шууд шийтгэл ноогдуулаагүйгээс үүдэн хууль бус худалдаачид, тэр ч байтугай хулгайн анчид тухайн амьтныг өөрсдөө агнаагүй гэж мэдүүлсээр шийтгэлгүй өнгөрөх тохиолдол байдаг. Үүнийг албаны хүмүүс зарим гэмт хэргийг амжилттайгаар яллахад саад учруулж буй хуулийн цоорхой хэмээн хэлж байв. Тухайн сэжигтэн нь өөрөө агнасан этгээд нь байсан гэдгийг нотлохгүй бол шүүгч, эсвэл прокурорын зүгээс хэргийг хэрэгсэхгүй болгох магадлалтай. Мөн тухайн амьтан устах аюулд орсон ч зөвхөн Монгол улсад тархдаг бус бол хуулийн 203 дугаар зүйл нь зөвхөн дотоодод ан хийсэн тохиолдолд л ашиглагдах заалай. Тухайн амьтан нь Монгол улсад байдаггүй амьтан бол хулгайн анчид үүнийгээ гадаад улсаас гаралтай хэмээн мэдүүлснээр ял эдлэхээс зайлсхийх боломжтой. Ялангуяа эдгээр тохиолдол Казахстанас авчирсан бөхөнгийн эвэр болон гарал үүсэл нь үл мэдэгдэх арслангийн арьс дээр гарччээ. дгээр хоёр хэрэг нь Ховордсон амьтан ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль хэрэгжихээр байсан хуулийн дээрх цоорхойгоос үүдэн хэрэгсэхгүй болжээ.

Өнгөрсөн арван жилийн хугацаанд зэрлэг амьтны эсрэг гэмт хэргийн мөрдөн байцаалт, прокурорын хяналт нь Эрүүгийн хуулиар олгож буй бүхий л боломжуудыг иж бүрнээр нь судлан үзэлгүй явагдаж иржээ. Хуулийн бусад олон зүйл, заалтыг зэрлэг амьтны хууль бус худалдаа, ан агнууртай тэмцэхэд ашиглаж болно. Үүнд:

- 155 дугаар зүйл- Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр авсан, хадгалсан, борлуулсан;
- 161 дүгээр зүйл- хууль бус бүтээгдэхүүн тээвэрлэх;
- 304 дүгээр зүйл- амьтны зүйлийг хомрогдон агнах;
- 163 дугаар зүйл- хууль бус үйл ажиллагаанаас олсон мөнгийг угаах гэх мэт.

Дээр жагсаасан заалтуудын алийг ч зэрлэг амьтны эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд шийтгэл ноогдуулахад хэрэглээгүй. Дээр дурдсан Улаанбаатар хотод хийсэн судалгаагаар (зураг 20) нийт 17 хэргийг Эрүүгийн хуулийн 203 дугаар зүйлийн (хууль бус ан агнуур) дагуу шалгасан бөгөөд эдгээрт хэд хэдэн элемент (хууль бусаар агнасан амьтныг тээвэрлэх, хадгалах, борлуулах) багтсаныг харгалзаагүй ажээ.

### ТОРГУУЛЬ ЭСВЭЛ ХОРИХ ЯЛ

Сүүлийн жилүүдийн түгээмэл болж буй өөр нэгэн баримт нь хорих ялаас илүүтэйгээр торгуулийн ял түлхүү давамгайлах болов. Зураг 21-г хуулийн 175 болон 203 дугаар зүйлд баривчлах, албан ажил хийлгэх, хорих зэрэг ял хэрхэн туссаныг харуулсан. Бодит байдалд маш цөөн тохиолдолд гэмт этгээдүүдэд хорих ял ноогдуулж буй талаар прокурорын байгууллагаас баталж байсан.<sup>368</sup>Мөн менежерүүд болон хэрэгжүүлэгчдийн зүгээс ч гэмт этгээдүүдэд зөвхөн торгох ял ноогдуулдаг, хорих ял ноогдуулсан ч Өршөөлийн хуулиар өршөөгдөж буйг дурдсан.

Прокурорын газраас ноцтой гэмт хэрэг хэмээн үзэх хэмжээний амьтны хууль бус агнуурын хэд хэдэн хэргийг гаргасан ч эцэстээ торгууль ноогдуулсан байна. “Нэн ховор” зэрэглэлд багтах амьтан болох хандгай агнасан хэрэг 2015 оны 10 дугаар сард Хэнтий аймагт гарч, үйлдсэн этгээдүүдэд 3,500 орчим ам. доллартай<sup>369</sup> тэнцэх хэмжээний торгууль ноогдуулж, хорих ял оноогоогүй.<sup>370</sup>Зэрлэг амьтныг олон тоогоор агнахад ч дээрх нөхцөл мөн л ижил үйлчилж байна. Хэдэн зуугаараа хураагддаг тарвага, эсвэл бариад буцааж тавих нөхцөлтэй тул загас дээр ч байдал адилхан байдаг. Бүх тохиолдолд торгох шийтгэл ноогдуулдаг бөгөөд хорих ялаар шийтгэх тухай заагаагүй.

Тэр ч байтугай торгуулиас чөлөөлөгдөх явдал түгээмэл байна. Дээд шүүхээс зэрлэг амьтны худалдааны гэмт хэргийг хянан үзэж, эцэслэн шийдсэн байдлыг судлахад өмнө нь Давж заалдах шатны шүүхээс ноогдуулсан торгох ялыг Монгол улсад ардчилсан хувьсгал ялсны 25 жилийн ойг тохиолдуулан гаргасан өршөөлийн дагуу хүчингүй болгосон.<sup>371</sup>

368 Оролцогч талтай хийсэн ярилцлага (Нийслэлийн болон Ховд аймгийн прокурорын газар)

369 8 сая төгрөгийг 1 ам. доллар = 2,300 төгрөгөөр хөрвүүлсэн

370 Оролцогч талтай хийсэн ярилцлага (Прокурорын газар)

371 Анхан шатны шүүх дээр борцгор хотон шувуу хууль бусаар агнасан гурван яллагдагчийг 67 сая төгрөгөөр торгох, мөн 13

## ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТАНХИМЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Судалгааны багийн нэг гишүүн дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдаанд сууж, ажиглалт хийсэн бөгөөд тухайн хэрэг нь зэрлэг амьтны эсрэг гэмт хэрэг бус ч шүүх хуралдааныг ажиглах боломжийг олгож, мөн зэрлэг амьтны хамааралтай гэмт хэрэгт хэр хамааралтай байж болохыг ажиглах, судлах боломжийг олгов.

Өмнөх хэсэгт дурдсан асуудал болох нотолгооны төрөл, нотолгоог гаргах, нотолгоотой харьцах нь хэргийг шийдэхэд тулгарч буй хамгийн гол дутагдалтай зүйлс бөгөөд энэ нь зэрлэг амьтны хэрэг дээр ч тулгарах асуудал болно. Уг хэрэг нь бусдын эрх чөлөөнд халдсан үйлдэлтэй холбоотой байсан бөгөөд шүүх хурал дээр хохирогч (нэхэмжлэгч), цагдаагийн ажилтан эсвэл өөр ямар гэрч байгаагүй. Тухайн хэргийг сонссон шүүгч нь прокурорын зүгээс амаар болон бичгээр өгсөн мэдүүлгийг уншин сонсох боломж олгох арга замаар шүүх хуралдаан авагдаж байв. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 94 дүгээр зүйлийн дагуу шүүхийн лавлагаа болон мөрдөн байцаалт хоёрын хооронд ямар нэгэн ялгаа заагийг тодорхойлоогүй. Өөрөөр хэлбэл, хэрэв баримт нотолгоог цагдаагийн байгууллага “Хуулийн дагуу цуглуулсан бол” үүнийг шүүх дээр нотолгоо хэмээн үзэв. Шүүгчийн зүгээс баримт нотолгоог цуглуулахтай холбоотой зарим асуудлыг тодруулсан. Прокурорууд нь нотолгооны эх үүсвэр болон нотлох байдлыг хэргийн явцад хэд хэдэн удаа шалгадаг. Хууль сахиулах байгууллагын ажилтан байхгүй нь яллах үйл явцад тодорхой нөлөөлдөг. Нөгөө талаар, өмгөөлөгчийн зүгээс тухайн хэрэгт мэдүүлгүүд үндэслэл муутай байснаас шалтгаалан ихэнх нотолгоог хэрэгсэхгүй болгуулах хүсэлт гаргасныг шүүх хүлээн авч нэг нотолгоог хэрэгсэхгүй болгосон нь хэргийн эцсийн шийдвэрт тодорхой нөлөө үзүүлж байв.<sup>372</sup>

Энэхүү хэрэг дээр гарсан нотолгоотой холбоотой асуудлуудын ихэнх нь яллах үйл ажиллагаанд дэмжлэг болох, мөн сөрөг нөлөөтэй ч байж болно. Ажиглалт хийсэн энэ хэргийн хувьд тухайн нотолгоог илүү сайн хадгалж, шаардлагатай гэрчийг ирүүлэх арга замаар нотолгоотой холбоотой асуудлуудаас зайлсхийх боломжтой байсан ч ашиглаагүй тул хөнгөн ял ноогдуулсан.

сая төгрөгийн хохирлын төлбөр гаргуулахаар шийдсэн байна (30,000 ам доллар болон 5,700 ам.доллар). Гэсэн ч баримт нотолгоог хууль бусаар цуглуулсан хэмээн үндэслэлээр давж заалдах шатны шүүх дээр Монгол Улсад ардчилсан хувьсгал ялсны ойд зориулсан өршөөлийн хуулийн дагуу тухайн шийдвэрийг хүчингүйд тооцжээ. Прокурорын зүгээс Дээд шүүхэд хандсаны дараа өмнө ноогдуулсан торгох ялыг сэргээн, давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгожээ. Эрүүгийн хэрэг 153/2015/054/e, www.supremecourt.mn

372 Эдгээр тохиолдолд шүүгч нь ямар нэгэн байдлаар саналаа илэрхийлэхгүйгээр шууд шийдвэр гаргадаг. Тиймээс тухайн шийдвэрийн цаад үндэслэлийг баталгаажуулах ямар нэгэн арга зам байхгүй. Энэхүү гаргаж буй шийдвэр нь шүүх дээрх хэлэлцүүлэг, гаргасан тайлбараас л цэвэр хамааралтай.

Нотолгоог танилцуулахаас гадна өөр нэгэн ажиглагдсан томоохон асуудал бол яллагдагчийн өгсөн мэдүүлэг, ялангуяа байцаалт болон өгсөн мэдүүлгийг шалгах явдал дутмаг байв. Яллагдагчийн зүгээс асуух, эсвэл эсэргүүцэл үзүүлэх зэрэг боломжууд хязгаарагдмал байв. Энэ нь яллах талын зүгээс үр дүнтэйгээр зөрүүлэн шалгах боломжийг хаах, тэгснээр өгсөн мэдүүлгийг шалгах боломжийг хязгаарлаж байна. Ганцхан хэрэг дээр хийсэн энэхүү ажиглалт-судалгаа нь иж бүрэн гэж тооцогдохгүй нь мэдээж. Гэхдээ ажигласан практик болон өгсөн тайлбаруудыг прокурорын зүгээс энэ нь Монгол улсын шүүхийн практикт хэвийн хийгддэг үйл ажиллагаа хэмээн баталгаажуулж өгсөн. Тэдний зүгээс хуулиар тавигдсан шаардлага, ялангуяа нотолгоо цуглуулах болон танилцуулахтай холбоотой шаардлагуудыг энэхүү судалгааны бүхий л явцад гарган ирж байв. Ямар ч тохиолдолд хангалттай баримт нотолгоогүйгээр ямар ч хэрэг ч шийдэгдэхгүй нь тодорхой. Хууль ч, түгээмэл практик ч шүүх танхимд хамгийн хэрэгцээтэй, хамгийн сайн нотлох баримт цугларч буйг баталгаажуулах боломжгүй юм.

## Ял ноогдуулах сүүлийн шатан дахь бэрхшээл

Зэрлэг амьтны хууль бус агнуур, худалдааны хэрэгт ял ноогдуулахад тулгарах дараагийн саад бэрхшээл бол гэмт хэргийн шийтгэх заалтаас гадна эрх зүйн системийн нийтлэг чиг үүрэг байна. Шүүх танхимд шүүх үйл явц хэрхэн өрнөх, ялыг баталгаажуулж шийдвэрлэх нь эрх зүйн систем (иргэний эрх зүйн эсвэл нийтийн эрх зүйн системтэй эсэх), хуулийг ойлгон хэрэглэх шүүгчийн үүрэг, хэргийг авч хэлэлцэж буй хэлбэр, баримт нотолгоо, шинжээч болон гэрчтэй холбоотой зарим төрлийн зааварчилгаа болон хууль тогтоомжуудын зөрчил зэрэг олон хүчин зүйлсээс хамаарна.

Энэхүү дүн шинжилгээний эхлэл нь Монгол улсын эрх зүйн өв уламжлал болох Европын ихэнх оронд ашигладаг, улмаар Орост хэрэглэж, эцэст нь Монгол улсад баримтлах болсон иргэний эрх зүйн систем юм. Энэхүү дамжин ирсэн иргэний эрх зүйн систем нь хуучны Зөвлөлтийн үеийн хандлагыг тусгасан, заримдаа социалист эрх зүйн систем хэмээн нэрлэгддэг.<sup>373</sup> Хэдийгээр хууль тогтоомжуудад олон тооны ахиц дэвшил гарч, бусад улс орны дэвшилт системээс шинээр заалт, үзэл баримтлал орж ирж буй ч эрх зүйн системийн үндэс нь хэвээр хадгалагдан, уг хуулийн бүтэц болон хэрэглээг тодорхойлж байна. Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх, иж бүрэн, үр дүнтэй хууль тогтоомжийг боловсруулан гаргахад ч энэ бүх зүйл хамааралтай.

373 "Socialist Legal Systems" lawin.org. 07, 2013. 2017 оны 6 сарын байдлаар. <http://lawin.org/>.

## ХУУЛЬ ТОГТООХ ЭРЭМБЭ

Хууль тогтоох эрэмбэ гэдэг нь хуулийн засаглалын суурь хэсэг юм. Тодорхой нэг улсад энэхүү эрэмбэ нь хууль боловсруулах болон хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй байдаг. Эрх зүйн хувьд эрэмбэ нь тухайн систем бүхэлдээ хэрхэн ажилладаг болохыг тодорхойлох бөгөөд үе шат болон хуулийн төрөл нэг бүр нь зохист агуулгатай байхыг баталгаажуулдаг. Хуулийн хэрэглээнд энэхүү эрэмбэ нь хуулийг дээдэлсэн шүүхийг удирдах, зарим тохиолдолд хууль зөрчилдөх асуудал гарахад шийдвэрлэх үүргийг гүйцэтгэдэг.

Монгол улсын хувьд Үндсэн хууль нь эцэг хууль бөгөөд батлагдан гарч буй бусад бүх хууль<sup>374</sup> болон Монгол улсын нэгдэн орж буй олон улсын гэрээ, конвенц<sup>375</sup> нь үндсэн хуульд нийцсэн байхыг шаарддаг. Энэ нь дэлхийн ихэнх улсад байх түгээмэл тогтолцоо юм. Энэхүү эрэмбэд олон улсын эрх зүй ямар нэгэн маргаангүй нийцдэг ч байгаль орчны хэд хэдэн хууль нь олон улсын шаардлагатай хамаарах зарим зөрчилдөөнийг хамтдаа шийдэх шаардлагатай болдог. Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ нь үндсэн хууль болон дотоодын бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй байх нь зүйтэй. Жишээлбэл, Иргэний хуульд “Монгол улсын Үндсэн хуультай зөрчилдөхгүй тохиолдолд олон улсын иргэний эрх тогтолцоонд хамаарах эрх зүйн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ”-г хэрэглэхийг зөвшөөрчээ.<sup>376</sup> Үүнээс гадна зэрлэг амьтны хууль бус худалдааны эрх зүйн орчинд багтах цөөн тооны хуульд Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид тухайн хуульд зохицуулах заалт үгүй бол олон улсын гэрээ, конвенцийн заалтыг баримтлахаар тусгасан.<sup>377</sup> Монгол улсын нэгдэн орсон зэрлэг амьтны холбогдолтой олон улсын гэрээ, конвенцийн тоонд CITES, Нүүдлийн зүйлийн конвенц, Биологийн олон янз байдлын тухай конвенц зэрэг багтдаг.

Дотоодын хууль тогтоомжууд (УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар болон хамаарах яамны гаргасан хууль, тогтоол, зарлиг, шийдвэр, захирамж зэрэг) нь энэхүү эрэмбийг дагадаг. Энэ судалгаанд хамрагдсан зэрлэг амьтны хууль бус худалдааны эрх зүйн орчны ихэнхийг УИХ, Засгийн газар, яам, Ерөнхийлөгчийн баталсан зэрлэг амьтны холбогдолтой чухал дүрэм, журам, шийдвэр бүрдүүлдэг. Бусад төрийн байгууллага мөн зэрлэг амьтны худалдаатай холбоотой чиг үүргийг хүлээх бөгөөд, тэд мөн тухайн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай зохих эрх мэдэлтэй байдаг. Эдгээрт ХЗЯ (Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс), Тагнуулын ерөнхий газар, Сангийн яам (Гаалийн ерөнхий газар) багтана.

374 Иргэний хууль. 10.1.

375 Иргэний хууль. 10.5.

376 Иргэний хууль. 10.5.

377 Жишээ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2 дугаар зүйл, Амьтны тухай хуулийн 2 дугаар зүйл, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийг үзнэ үү.

Монгол улс дахь зэрлэг амьтны хууль бус худалдаанд хамаарах эрх зүйн орчин нь энэхүү эрэмбийн бараг бүх түвшинд өөрийн суурь, үндэслэлтэй байдаг. Бидний судалгааны зорилго нь тухайн эрх зүйн орчны хаана нь зэрлэг амьтны худалдааны тодорхой хэсгүүд зохицуулагдаж буйг харуулах, тодорхой болон боломжит үйлчлэл бүхий хэсгийг тодорхойлох, энэхүү эрэмбэ нь хууль тогтоомж хоорондын зөрчил үүсэх тохиолдолд хэрхэн шийдэж болохыг олж тогтоох явдал байв.

## ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗӨРЧИЛДӨӨН

Хууль хоорондын зөрчилдөөн байх нь зайлшгүй зүйл юм. Зөрчилдөөн нь хууль тогтоох нэг байгууллагын гаргасан хууль хооронд, мужуудын хооронд, эрх мэдэл нь давхардсан агентлагуудын хооронд, тэр ч байтугай нэг хууль дотор ч байж болно. Эрх зүйн тогтолцоог үр дүнтэй ажиллуулахын тулд гарч болох зөрчилдөөнийг урьдчилан таамаглаж, зөрчил үүсэх тохиолдолд баримтлах зарчмыг шүүгч нарт зориулан тогтоон өгсөн байх шаардлагатай. Гэсэн ч Монгол улсад ийм төрлийн зөрчилдөөнийг шийдэж болох хэд хэдэн эрх зүйн заалтуудыг хэрэглэж байна. Иргэний хууль нь энэ талаар зарим заалтууд гаргасан байдаг. Жишээ нь, тус хуулийн 10.5-д шүүх нь “Монгол улсын Үндсэн хуультай зөрчилдөөгүй” олон улсын хэм хэмжээг ашиглаж болохоор заажээ. Тус хуулийн 10.7-д хууль тогтоомж зөрчилтэй, шударга бус, эсвэл нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээний эсрэг гэсэн үндэслэлээр хуулийн хэм хэмжээг хэрэглэхээс татгалзаж болохгүйг заажээ. 10.7 дахь өгүүлбэрийн бүтцээс үзвэл хуулиуд хоорондоо харилцан зөрчилдөх, эсвэл нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээтэй зөрчилдөхийн алийг заасан болох нь тодорхойгүй. Ямар ч тохиолдолд 10.5 болон 10.7 заалт дотоодын хууль тогтоомжид зөрчилдөөн үүсэх тохиолдолд хэрхэн шийдэх талаар зааварчилгаа болохооргүй харагдаж байна.

## ХУУЛИЙГ ТАЙЛБАРЛАХ

Монгол улс дахь хууль зүйн судалгаанд “Хууль тайлбарлах” болон “Хэрэглээ” нь тусгай эрхүүд хэмээн тооцох ба тайлбарлах эрхийг Үндсэн хуулиар Дээд шүүхэд олгодог.<sup>378</sup> Шүүхээс гарсан бусад шийдвэрээс ялгаатай нь дээд шүүхийн гаргасан тайлбар (тогтоол байдлаар) нь хуулийн нэг хэсэг болж<sup>379</sup> улмаар доод шатны шүүх дээр баримтлах жишиг болдог. Иргэний хуулийн дагуу доод шатны шүүх “Зөвхөн хуулийг хэрэглэх” үүрэгтэй.<sup>380</sup> Эрх зүй болон онолын хувьд энэ нь эрх мэдлийн чухал хуваарилалт гэж харагдах

378 1992 оны Үндсэн хуулийн 50(1) дүгээр зүйл дээр Дээд шүүх нь шүүх эрх мэдлийн эрхийг хэрэгжүүлэгч дээд байгууллага бөгөөд Үндсэн хуулиас бусад хууль тогтоомжийн тайлбарыг албан ёсоор гаргах эрхийг эдэлдэг.

379 Melville, C., O. Erdenedalai, and A. Woolley (2015). Overview of the Mongolian Legal System and Laws. GlobalLex, Hauser Global Law School Program.

380 Иргэний хууль. 10.1.

ч ерөнхий гэмт хэрэг болон зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэргийг амжилттай яллан шийтгэхэд шууд нөлөөлдөг.

Олон улс оронд эдгээр хоёр үзэл баримтлалыг салшгүй, шүүхийн үйл ажиллагааны үндэс хэмээн үздэг. Өөрөөр хэлбэл, шүүгч нь хуулийг заавал хөрвүүлэн тайлбарлахгүйгээр хуулийг ашиглах боломжгүй гэж үздэг. Ямар ч хуульд зарим зүйл заалтууд нь энгийн байдаг тул шууд хэрэглэх боломжтой (жишээ нэн ховор амьтныг агнах). Гэтэл тухайн хууль тодорхой нэг зүйл дээр хамаарах талаар юу ч дурдаагүй, эсвэл олон салаа утгатай байж болно (жишээ нь их хэмжээний хохирол учруулах). Монгол улсын Иргэний хуулиар энэхүү бодит байдлыг хүлээн зөвшөөрч, шүүгч нарт тодорхой заавар, чиглэлийг өгсөн байдаг. Юуны өмнө тус хууль нь шүүгч нарт “Харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ”<sup>381</sup> гэсэн чиглэл өгсөн байна. Өөрөөр хэлбэл, шүүгч нь өмнөө буй хуульд ямар нэгэн цоорхой байгаа бол бусад хэм хэмжээг хэрэглэж болно. Түүнчлэн ямар нэгэн баримтлах хууль тогтоомж байхгүй бол шүүх нь тухайн маргааныг Үндсэн хуулийн дагуу шийднэ.<sup>382</sup> Эцэст нь эрх зүйн хэм хэмжээ байхгүй, эсвэл хэм хэмжээ тодорхойгүй гэсэн шалтгаанаар хэргийг шийдэхээс татгалзах боломжгүй.<sup>383</sup>

Хэм хэмжээ байхгүй байсан ч, олон салаа утгатай байсан ч Монгол улсын шүүх нь хууль тогтоомжийг тайлбарлах бус, харин шууд хэрэглэх үүргийг хүлээж байна. Практикт анхан шатны шүүхийн шүүгчид үндсэндээ зэрлэг амьтны хууль бус худалдааны хэргийг шийддэг бөгөөд сүүлийн таван жилд цөөн тооны хэрэг давж заалдах шатанд очиж, цаашлаад 10 орчим хэрэг хяналтын шатанд шийдэгджээ.<sup>384</sup> Олон салаа утга илэрхийлэх тохиолдолд шүүгчид үүнийг дефакто байдлаар тайлбарлах боломжтой. Ямар нэгэн чиглэл, зааваргүйгээр зохистой бус шийдвэр гаргах эрсдэл буй бөгөөд иргэний эрх зүйн системтэй улсуудад ‘jurisprudence constante’ хэмээх онолыг (өмнө гарсан ижил хэрэг дээрх багц шийдвэрүүдийг баримтлах) ашиглан тухайн нөхцөл байдлаас зайлсхийдэг.<sup>385</sup> Монгол улсын шүүгчдийн хувьд хууль тайлбарлах цор ганц эх үүсвэр нь Дээд шүүхийн гаргасан тайлбар байдаг. Үүнээс үүдсэн олон салаа утга, эсвэл орхигдол нь зарим хэргийг хэрэгсэхгүй болгох боломжийг бүрдүүлдэг. Энэ тохиолдолд шүүх нь техникийн хувьд нэхэмжлэлийг шийдэхээс татгалзаагүй, харин тухайн үйлдлийг хийх шалтгаан байхгүй хэмээн үздэг.

381 Иргэний хууль. 10.4.

382 Мөн тэнд.

383 Мөн тэнд. 10.6.

384 Дээд шүүхээр шийдвэрлэсэн хэргийн онлайн мэдээллийн сан (Supremecourt.mn)

385 Иргэний эрх зүйн тогтолцоо бүхий улсуудын эрх зүйн онолоор тодорхой хуулийн зарчим, эсвэл журмыг баримтлан өмнө гаргасан багц шийдвэрүүд нь ихээхэн чухал байдаг.

## “ЖИЖИГХЭН” ҮГС ТОМООХОН ТОДОРХОЙГҮЙ БАЙДАЛ ҮҮСГЭДЭГ

Хуулийн хэллэг олон салаа утгатай байх нь тухайн хуульд ашигласан үг хэллэгийг хүмүүс өөрийн туршлага болон мэдлэгийн хүрээнд нэгээс илүү арга замаар ойлгож болдог. Үүнийг хэрхэн шийдэх нь улс орон бүрт өөр өөр ба эрх зүйн ээдрээтэй салбар юм. Бидний гол зорилго нь олон салаа утгыг зэрлэг амьтны хууль бус худалдааны гэмт хэрэгтэй хэрхэн холбогдох талаас нь судлан үзэхэд оршино.

2002 оны Монгол улсын Эрүүгийн хуульд Зэрлэг амьтны хууль бус худалдаатай холбоотой бүлэгт<sup>386</sup> мөрдөн байцаагч, прокуроруудад асуудал үүсгэсэн тодорхой бус хэллэгүүдийг ашиглажээ. Энэ хуулийн 175 дугаар зүйл нь зэрлэг амьтны эд, эрхтнийг хил дамнуулан худалдаалахад эрүүгийн хариуцлага ноогдуулахаар заасан (2015 оны Эрүүгийн хууль хүчин төгөлдөр болсноор 18.5 дугаар зүйл болсон). Энэ зүйлийн асуудал үүсгэж буй хэллэгийг хаалт дотор оруулан, доор үзүүлэв. Энэ хуулийн 175.1 дүгээр зүйлд зааснаар:

“Хориглосон буюу хязгаарласан эд зүйлийг [бага бус хэмжээгээр], ховор амьтан, түүнчлэн их хэмжээний валют, валютын үнэт зүйл, ... улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол ...”. Мөн Гаалийн тухай хуулийн 295-д дээрхтэй ижил үйлдэлд захиргааны хариуцлага тооцохоор заасан. Эрүүгийн хуулиар шийдвэрлэх боломжгүй нөхцөлд энэ заалтыг хэрэглэх боломжтой (Зөрчлийн тухай хуулийн 10.20).<sup>387</sup> Тус хуулийн 295.1-д заахдаа:

“Хориглосон бараа, бүтээгдэхүүнийг улсын хилээр хууль бусаар борлуулсан эсвэл борлуулахаар завдсан [эрүүгийн гэмт хэрэгт тооцогдохгүй] ...”<sup>388</sup> гэж заажээ.

Дээрх хоёр хууль хориотой бараа, бүтээгдэхүүнийг худалдахыг зааж байгаа бөгөөд Эрүүгийн хуулийг ашиглах босго үзүүлэлт нь “Их хэмжээний” гэдэг агуулгаар тайлбаргүй ашиглах боломжтой.

386 Монгол Улс нь Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд батлан гаргаж тухайн оныхоо 9 дүгээр сард хүчин төгөлдөр мөрдүүлж эхлэхээр тогтсон байсан. Гэхдээ хууль хүчин төгөлдөр болох хугацааг хойшлуулан бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, сургалт болон олон нийтийн мэдлэг нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулсан. Тиймээс шинэ хууль хүчин төгөлдөр болох хүртэл 2002 оны Эрүүгийн хууль хэрэгжиж байсан нь энэхүү тайлангийн дүн шинжилгээнд багтсан бөгөөд нөгөө талаар 2002 оны энэхүү хууль нь тайлангийн төвлөрч буй 2006- 2015 онд хэрэгжиж байсан тул шинжилгээнд хамруулсан.

387 Энэхүү заалтыг цаашид Зөрчлийн тухай хууль орлох болсон ч 2016 оны 9 дүгээр сарыг хүртэл тухайн заалт нь Гаалийн тухай хууль дахь эрүүгийн болон захиргааны хариуцлагыг заагласан гол заалт байсан тул судалгаанд хамруулсан. Түүнээс хойш Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн ба Эрүүгийн хуулиар хариуцлага тооцохгүй нөхцөлд Зөрчлийн тухай хуулийг баримталдаг хэлбэр хэвээр хадгалагдан үлдсэн.

388 Лийгэл Атласын албан бус орчуулга.

Гаалийн байгууллагын бүртгэлээс үзвэл ямар нэгэн үйлдлийг эрүүгийн, эсвэл захиргааны хэрэг үүсгэн яллахад зарим нэгэн асуудлыг үүсгэдэг. Жишээлбэл, Гааль нэг хөлдөөсөн чоныг хоёр удаа гаргахаар оролдсон үйлдлийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзсэн байдаг. Гэтэл 15 чонын арьсыг 4 удаагийн үйлдлээр, 49 чонын шагайг 2 удаагийн үйлдлээр хил нэвтрүүлэхээр завдсан хэргийг (хамгийн багадаа 12 толгой чоно) захиргааны хэрэг болгон шийдсэн байна. 2015 оны Эрүүгийн хуулиар энэхүү бүрэн бусаар тодорхойлсон хэллэгийг асаж, хэмжээнээс үл хамааран хил нэвтрүүлэхээр завдсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.

## “БОЛОН”, “ЭСВЭЛ” ХЭМЭЭХ ҮГС ИЙН ОНЦГОЙ ТОХИОЛДЛУУД

Эдгээр холбогч үг ашигладаг нь шинээр гарсан Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулийн аль аль нь бүрэн арилгаж чадаагүй, гэхдээ нэлээд дэвшил гарсан. Техникийн шинжтэй байхын зэрэгцээ “Болон”, “Эсвэл” гэх холбоос үг эрх зүйн хувьд давхар утга үүсгэж болох ба үүнд зарим тайлбар хийх шаардлагатай. Эдгээр үг нь Англи болон Монгол хэлээр, мөн бусад хэлээр ч ижил утга, үүрэгтэй бөгөөд холбох болон салгах утгаар хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, бичвэрт багтсан жагсаалт дахь зүйлсийг хамтатган ойлгох, эсвэл салган ойлгохыг уншигчид харуулж өгдөг. “Болон” хэмээх үг нь нөгөө талаар холбох болон салгах үүргийг мөн гүйцэтгэдэг бөгөөд харин “Эсвэл” нь дараа нь орж буй үгээ дангаар болохыг (жагсаалтын дотроос нэг л зүйл, цорын ганц зэрэг), эсвэл “Оруулаад” хэмээх (нэг зүйл, эсвэл илүү тооны) утгыг илэрхийлж байна. Олон тохиолдолд энэ нь бичвэрийн ерөнхий утгаас хамаардаг. Энэ нь бидэнд тухайн холбогч үгсийг ямар зорилгоор ашигласан болохыг тогтооход тусалдаг. Үүнийг энгийн зохиомол жишээгээр авч үзье. Эдгээр жишээ нь зөвхөн ямар асуудал байж болохыг л харуулах зорилготой болохоос Монгол Улсын аль нэгэн хуулиас жишээлээгүйг хэлэх нь зүйтэй.

- a. **Нийлмэл өгүүлбэрт “Болон” үг хэрэглэх:** “Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх болон галт зэвсэг авч явах нь хууль бус үйлдэлд тооцогдоно”. Энэ өгүүлбэрээс дүгнэвэл гэмт хэрэгт тооцогдохын тулд хоёр үйлдэл нь зэрэг хийгдэх шаардлагатай гэж ойлгогдож болно. Мөн тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх нь хууль бус, мөн галт зэвсэг биедээ авч явах нь ч хууль бус гэж харагдаж байна.
- b. **Салгасан утга бүхий өгүүлбэрт “Болон” хэмээх холбогч хэрэглэх:** “Хориглосон хугацаанд болон хориглосон газарт ан агнуур нь хийх хууль бус үйлдэл”. Энэ тохиолдолд аль алиныг нь хууль бус хэмээн үзэж болох ба учир нь эдгээр хоёр нь тусдаа үйлдэгдэхийг хууль бус хэмээн үзэхгүй утга гарна. Хориотой үед ан хийхэд, мөн хориотой газар ан хийхэд хууль бус үйлдэл хэмээн үүний дагуу тооцно. Энэ

тохиолдолд хоёр үйлдэл заавал зэрэг хийгдсэн байх албагүй.

“Эсвэл” хэмээх үгийг салгасан утгатай өгүүлбэрээс бусад тохиолдолд бараг ашиглахгүй. Гэхдээ тусдаа “Эсвэл” (олон сонголтын дундаас нэг нь), хамтдаа “Эсвэл” (олон сонголтоос нэг, эсвэл дээш тооны) хэмээх утгыг мөн зааж болно. Олон салаа утгатай байхыг үл зөвшөөрөх өгүүлбэр дээр (ялангуяа хууль дээр), эсвэл хэмээх үгийг бус өөр үгийг ашиглах хамтдаа, эсвэл тусдаа болохыг тодорхойлж өгдөг (жишээлбэл, нэг нь эсвэл нөгөө нь, гэхдээ хоёулаа бус).

- o **Эсвэл хэмээх үгийг тусгаарлах утгаар ашиглах нь:** “Өдөрт хоёр загас, эсвэл долоо хоногт зургаан загас барьж болно”. Энэ тохиолдолд, эсвэл гэсэн үг нь тусдаа утгыг зааж буй бөгөөд хувь хүн өдөрт хоёр загас барьж болох ч өдөр бүр хоёрыг бариад байх боломжгүй бөгөөд учир нь долоо хоногт зургаа гэсэн хязгаарлалт тавигдсан байна. Тиймээс долоо хоногт зургаа гэсэн хязгаар нь өдөрт хоёр гэсэн хязгаараас тусдаа утгатай.
- o **“Эсвэл” хэмээх үгийг хамтдаа гэсэн утгаар хэрэглэх:** “Энэ голоос зэвэг, эсвэл цагаан загас барьж болно”. Энэ тохиолдолд “Эсвэл” гэдэг нь хамтатгасан холбогч байна. Хувь хүн нь тухайн заасан газарт зэвэг болон цагаан загас хуулийн дагуу барих боломжтой.

Монгол Улсын хууль тогтоомж боловсруулахад холбогч үгс нь заримдаа ашиглагдахгүй байх, эсвэл бага хэмжээнд хэрэглэгдэж байна. Жишээлбэл, гэмт хэрэг хэмээн тооцогдох үйлдлүүдийг жагсаахдаа таслал ашигладаг ч холбогч ашиглахгүй тохиолдол байна. Шинээр хэрэгжиж буй Зөрчлийн тухай хуульд зэрлэг амьтны худалдаатай холбоо бүхий чухал заалт (6.6.2) дараах байдалтай байна. Үүнд:

“Ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусад шилжүүлсэн бол ...”.

Ямар нэгэн холбогч ашиглаагүйгтгэс дүгнэвэл энэхүү өгүүлбэр нь дараах утгатай. Үүнд:

“Гэрээ нь ан агнахтай холбоогүй, зөвхөн загас барихтай холбоо бүхий утгатай”.

Монгол Улсын зарим хуульд байдаг түгээмэл бичвэр бөгөөд уншигчид тухайн холбогчийг бүрэн ойлгодог. Холбогч байгаа хэмээн шууд ойлгох нь түгээмэл ч хууль хэрэглэх, тайлбарлах тохиолдолд энэ нь асуудал үүсгэх боломжтой. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 203 дугаар зүйлийн заалтын нэг хэсгийг доор тайлбарлав. Эрүүгийн элемент нэг бүрийг хаалт дотор бичсэн. Эрүүгийн гэмт хэргийн мөрдөн байцаалтын талаар ойлголтгүй хүмүүсийн хувьд “Элемент” гэдэг нь гэмт хэргийн тусдаа тогтоосон хэсгүүдийг хэлэх ба тухайн элементүүдийн жагсаалтын бүтцээс хамааран нотолгоог гарган тухайн элемент нь үйлдэгдсэн болохыг батлах шаардлага үүснэ. Элементүүд нь



барилгатай зүйрлэвэл хэсэг бүрийг бүрдүүлж буй блок юм. Энэ хуулийн 203.1 дүгээр зүйл дээр доорх байдлаар заажээ. Үүнд:

“203.1. Улсын [тусгай хамгаалалттай газар нутагт] болон [хориотой үед], [хориглосон арга, зэвсэг, хэрэгслээр][ан амьтан агнасан, барьсны] улмаас [үлэмж хэмжээний] [хохирол учирсан], [ховор ан амьтныг] [зохих зөвшөөрөлгүйгээр] [агнасан, барьсан, ... бол”

Энэ өгүүлбэрийг задлан үзвэл хамгийн багадаа долоон нөхцлийг багтаажээ. Тухайн хүчин зүйлсийг нэгтгэн оруулсан буйг хам эсдвээс нь хараад хялбархан ойлгох боломжтой. Заавал шаардагдахгүй байж болох ч хувь хүн 1) зөвшөөрөлгүй ан хийх болон 2) хориглосон хугацаанд болон 3) хориглосон газарт тухайн үйлдлийг хийснээр хариуцлага тооцох нөхцөл үүснэ. Эхний хоёр элементэд хамаарах асуулт бол эдгээрийн аль нэг нь дангаараа бие даасан үйлдэлд тооцогдох уу? юм. Өөрөөр хэлбэл, зөвшөөрөлгүйгээр “Их хэмжээгээр агнах” нь хууль бус уу?, үүнийг заавал “Хохирол учруулсан” болохыг батлахгүйгээр хууль бус хэмээн үзэж болох уу? Эсрэгээр зөвшөөрөлгүй ан хийх замаар “Хохирол учруулсан” болон “Их хэмжээгээр” хоёр нийлж байж буруутай болох уу?

Холбогч үг байхгүй энэхүү асуудал нь шинээр батлагдан хэрэгжиж буй Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд засвар хийх шаардлага байгааг илэрхийлнэ. Хэд хэдэн заалт дээр “Эсвэл” үгийг хэрэглэсэн нь хамаарах элементэд болон ноогдуулах торгууль, шийтгэл ч зөвхөн нэгд нь хамаарч болохыг зааж байна.

Тухайн холбогч байхгүй байх нь ээдрээтэй, нийлмэл өгүүлбэртэй хуулийн заалтыг хоёрдмол утгатай болгодог. Жишээлбэл, 2015 оны Эрүүгийн хуулийн 24.5.1-д хэд хэдэн элементийн жагсаалт буй ч эдгээрт холбогч үг мөн л байхгүй. Энэхүү заалт нь утгын асуудал үүсгэхгүй ч хууль боловсруулахад энэхүү бүтцийг хэрэглэссээр байгаа бөгөөд цаашид хууль тогтоох үйл ажиллагаанд анхааран үзэх шаардлагатай. Хоёрдмол утга байгаа бол үүнийг буруугаар тайлбарлах, эсвэл хэргийг хэрэгсэхгүй болгох явдал гарсаар байх болно.

## Дүгнэлт

Сүүлийн арван жилд зэрлэг амьтны гэмт хэргийг Монгол Улсад мөрдөн шалгах болон яллах үйл явцыг цаашид үргэлжлүүлэн сайжруулах шаардлагатай. Орон нутагт, ялангуяа агнуурын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй хууль сахиулах чиг үүрэг бүхий ажилтнуудад үйл ажиллагааны чадавх болон мөрдөн шалгалт хийх эрх мэдэл дутмаг байгаа бол гаалийн ажилтнууд нь тамхи, архи зэрэг гаалийн татвараас зайлсхийсэн хэргүүд дээр түлхүү анхаарал хандуулж байна. Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нь үндсэндээ ашигт малтмалын нөөцийн төлбөр болон татварын орлогод түлхүү нөлөөлөх уул уурхайн чиглэлд үйлдэгдэж буй

гэмт хэрэгт төвлөрдөг. Энэ бүхний үр дүнд харьцангуй цөөн тооны гэмт хэрэг илэрч, тулгарч буй олон тооны асуудлуудаас (баримт нотолгоо цуглуулахтай холбоотой бүтэц, үйл явц, ложистик, хураан авсан зэрлэг амьтны бүтээгдэхүүнийг зохих ёсоор хадгалах экспертийн чадавх дутмаг, шүүхийн шинжилгээний чадавх сул, дотоод болон гадаадын хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоо сул зэрэг) хамааран олон тооны хэргүүд шийдэгдэхгүй үлдэж, цөөн тохиолдолд л шүүхээр шийдэгдэж байна. Энэ нь олон тооны гэмт хэрэгтнийг шударга шийтгэлээс мултрахад хүргэж байна.<sup>389</sup> Шүүхийн шийдвэрээр тухайн гэмт хэргүүдэд тохирсон ял ноогдуулж буй ч Өршөөлийн хуулийн дагуу шийтгэлээс чөлөөлөгдөж, Зураг 19-т үзүүлсэн торгуулийг бүрэн төлөхгүй тохиолдол элбэг байна.

Энэ бүхний эцэст Монгол Улсад үйлдэгдэж буй хууль бус агнуур, худалдаа өнөөг хүртэл үргэлжилж, эрүүгийн болон санхүүгийн багахан хариуцлага хүлээхүйц, эсвэл илрүүлэхэд хүндрэлтэй, эрсдэл багатай үйл ажиллагаа хэмээн тооцогдох болжээ. Сүүлийн үед хийгдэж буй эрх зүйн шинэтгэлийн хүрээнд ноогдуулах шийтгэл, торгуулийн хэмжээг өндөрсгөж, эрүүгийн хэргээр зүйлчлэх болсон нь цаашид энэ төрлийн гэмт хэргийг яллаж буй хэмжээ нэмэгдэх итгэл төрүүлж буйн зэрэгцээ, шинэтгэлийн үйл ажиллагааг цааш үргэлжлүүлэх шаардлагатай.

389 Гол оролцогч талтай хийсэн ярилцлага (Нийслэлийн прокурорын газар)



ТАВДУГААР БҮЛЭГ:

ЗЭРЛЭГ АМЬТНЫ  
АГНУУР БА  
ХУДАЛДАА

# Зэрлэг амьтны агнуур

## Анчид, загасчдын тоо

Арав гаруй жилийн өмнөөс галт зэвсэгт тавих хяналт суларсан, буу, ангийн хэрэгслийн үнэ хямдарсан, хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаа суларсан зэрэг давхацсан олон шалтгаан нь зэрлэг амьтны хууль бус ан агнуур ихээхэн хэмжээнд нэмэгдэхэд хүргэжээ. 2005 оны байдлаар 15-аас дээш насны эрчүүдийн 30 гаруй хувь нь зэрлэг амьтны агнуурт оролцсон байсны дийлэнх хувь нь ан агнахад, үлдсэн цөөн хувь нь загасчлахад оролцжээ. Харин 2015 онд хийсэн судалгаагаар ан хийж буй хүмүүсийн тоо үндсэндээ өмнөх түвшиндээ хадгалагдаж байгаа боловч мэдээлэл өгөхөөс цааргалах хүний тоо олон байна. Түүнчлэн уг судалгаагаар загасчдын тоо ихээхэн нэмэгдсэнийг тогтоосон байна.

## 2005 ОНЫ ТООЦООЛЛЫН АРГЫГ ДАХИН АШИГЛАСАН НЬ

Энэ удаагийн судалгааны үр дүнг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахуйц байлгах зорилгоор 2005 оны судалгаанд ашигласан анчдын тоог тооцоолсон аргачлалыг дахинаашигласан болно. 2005 оны судалгааны дүнгээр эмэгтэйчүүд ан агнадаггүй, загас барьдаггүй болох нь тогтоогдсон тул дан эрэгтэйчүүдийг тооцоонд хамруулсан. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн хариултад зөвхөн экстрополяц хийн нийт хүн амд тархаах, улмаар хүйсээр задалж тооцох нь бодитой мэдээлэл биш билээ. Иймээс анхны түүврийн 4,021 нэгжийг 2,995 болгож багасган (анхны түүврийн 74 хувь) анчдын тоог насны бүлгээр тооцох суурь түүвэр болгож авсан. 2005 оны судалгааны тооцоонд 15-аас доош болон 65-аас дээш насны бүлгийн судалгаанд хамрагдсан хүмүүсийн тоо (n=4) хэт цөөн, төлөөлөх чадваргүй байсан учир тооцоонд оруулаагүй хассан байдаг. Улмаар насны бүлгээр тооцсон анчдын тоог нийт эрэгтэйчүүдийн насны бүлгийн тооцоог хийхэд ашигласан. Өмнөх судалгаатай ижил аргачлалаар тооцсон 2015 судалгааны үр дүнг дараах хэсгээс үзнэ үү.

## ЗАГАСЧИД

Энэхүү судалгаанд загасчдын тоог тооцохдоо 2005 оныхтой ижил аргачлал ашигласан бөгөөд судалгааны шууд асуулгад хариулсан үр дүнг (6 хувь) нэгтгэж тооцсон. Ингэхдээ анчдын тооны тооцоололд хийсэн шиг дутуу мэдээлсэн өгөгдлийг харгалзан тохируулах ажил хийгээгүй болно. Судалгаанд орсон шууд асуулгад хариулсан үр дүнг ашиглан загасчдын нийт тоо, улмаар тэдгээрийн олборлож буй загасны хэмжээг тооцоолсон.

Доорх Хүснэгт 1-д тооцоолж гаргасан нийт 69,988 загасчдыг насны бүлгээр ангилан үзүүлсэн.

Хэдийгээр загас агнагчдын тоо нэмэгдэж байгаа эсэх, судалгаанд хамрагдахад асуултад хариулахаас цааргалах эсэх талаар бид урьдчилан бодсон зүйлгүй байсан ч шууд асуулгын хариултаас харахад 2005 онтой харьцуулахад загасчдын тоо ихээхэн нэмэгдсэн, өрхийн судалгааны явцад загасчлахаас олж буй орлогоо мэдээлэхээс татгалзах явдал ихсэж буйг олж мэдсэн юм. Зарим загасчдын барьсан загасны тоо хэмжээ нилээд их (жишээ нь жилд 500 зэвэг загас) байгаа нь тэд арилжааны зорилгоор загас агнуур эрхэлдэг байж болохоор ажиглагдаж байсан. Гэхдээ судалгаанд хамрагдсан хүмүүст барьсан загасаа зарж борлуулдаг эсэх, борлуулах оролдлого хийсэн эсэх талаарх асуулт тавиагүй юм. Үүний зэрэгцээ олон өрх захаас загас худалдан авч, хүнсэндээ хэрэглэдэг болохоо мэдээлж байсан. Түүнчлэн, зарим ресторанууд загасчаас шууд худалдан авах сонирхолтойгоо илэрхийлж байсан. Өөрөөр хэлбэл, судалгааны асуултад сайн хариулт өгөөгүй ч өрхийн болон зах зээлийн судалгааны дүнгээс үзэхэд хувиараа загасчилж байгаа хүмүүс тодорхой хэмжээгээр загас арилжааны харилцаанд орж байгааг ажигласан юм.

Хүснэгт 1. Загасчдын тоо, насны бүлгээр, 2015 он

2015					
Насны бүлэг	Эрэгтэйчүүдийн тоо	Эрэгтэйчүүдийн тоо, насны бүлгээр	Асуултанд хариулсан загасчдын тоо, насны бүлгээр	Асуултанд хариулсан загасчид (хувиар), насны бүлгээр	Нийт загасчдын тоо
(i)	(N <sub>mi</sub> )	(m <sub>ai</sub> )	(m <sub>ni</sub> )	(m <sub>ni</sub> /m <sub>ai</sub> )	(N <sub>n</sub> )
15-19	121,780	170	16	9.412%	11,462
20-24	135,073	172	16	9.302%	12,565
25-29	157,118	298	27	9.060%	14,236
30-34	130,591	291	20	6.873%	8,975
35-39	114,492	292	26	8.904%	10,194
40-44	100,801	265	8	3.019%	3,043
45-49	84,610	219	15	6.849%	5,795
50-54	71,155	279	4	1.434%	1,020
55-59	51,524	198	4	2.020%	1,041
60-64	28,448	130	3	2.308%	656
65-69		(a)	(b)		
70+		(c)	(d)		
	995,592	2,314	139	6%	68,988

65-аас дээш насны судалгаанд оролцогчдын мэдээллийг дараах байдлаар задлан шинжилж үзэв: a=79, b=2, c=125, and d=1.

Хүснэгт 2. Анчдын тоо, насны бүлгээр, 2015 он

2015					
Насны бүлгээр	Эрэгтэйчүүдийн тоо	Эрэгтэйчүүдийн тоо, насны бүлгээр	Асуултанд хариулсан анчдын тоо, насны бүлгээр	Асуултанд хариулсан анчид (хувиар, насны бүлгээр)	Нийт анчдын тоо
(i)	(N <sub>m</sub> )	(m <sub>ai</sub> )	(m <sub>ni</sub> )	(m <sub>ni</sub> /m <sub>ai</sub> )	(N <sub>n</sub> )
15-19	121,780	170	7	4.118%	5,014
20-24	135,073	172	11	6.395%	8,638
25-29	157,118	298	16	5.369%	8,436
30-34	130,591	291	18	6.186%	8,078
35-39	114,492	292	11	3.767%	4,313
40-44	100,801	265	7	2.642%	2,663
45-49	84,610	219	7	3.196%	2,704
50-54	71,155	279	5	1.792%	1,275
55-59	51,524	198	4	2.020%	1,041
60-64	28,448	130	4	3.077%	875
65-69		(a)	(b)		
70+		(c)	(d)		
	995,592	2,314	90	4%	43,038

65-аас дээш насны судалгаанд оролцогчдын мэдээллийг дараах байдлаар задлан шинжилж үзэв: a=79, b=0, c=125, d=1.

2005					
Насны бүлгээр	Эрэгтэйчүүдийн тоо	Эрэгтэйчүүдийн тоо, насны бүлгээр	Асуултанд хариулсан анчдын тоо, насны бүлгээр	Асуултанд хариулсан анчид (хувиар, насны бүлгээр)	Нийт анчдын тоо
(i)	(N <sub>m</sub> )	(m <sub>ai</sub> )	(m <sub>ni</sub> )	(m <sub>ni</sub> /m <sub>ai</sub> )	(N <sub>n</sub> )
10-14		(a)	(b)		
15-19	149,199	154	40	25.974%	38,753
20-24	134,528	315	98	31.111%	41,853
25-29	114,801	458	160	34.934%	40,105
30-34	98,999	410	152	37.073%	36,702
35-39	89,901	410	151	36.829%	33,110
40-44	73,299	444	138	31.081%	22,782
45-49	50,801	344	105	30.523%	15,506
50-54	33,901	235	58	24.681%	8,367
55-59	28,400	137	27	19.708%	5,597
60-64	23,105	88	9	10.227%	2,363
65-69		(c)	(d)		
70+		(e)	(f)		
	796,932	2,995	938	31%	245,138

15 ба 65-аас доош насны судалгаанд оролцогчдын мэдээллийг дараах байдлаар задлан шинжилж үзэв: a=18, b=4, c=60, d=3, e=46, f=4.

АНЧИД

Нийт анчдын тоо нь 2015 оны судалгааны үр дүнг ашиглан хийсэн тооцоогоор 2005 оныхтой ижил түвшинд буюу 250.000 орчим байгаа тооцоо байна. Энэ тооцоог хийхдээ 2005 оны судалгааны тооцоотой харьцуулахуйц байлгах зорилгоор (анчдын тоог тодорхойлоход гол анхаарлаа хандуулсан) үндсэн хоёр аргачлалыг ашигласан. Эхний аргачлал нь судалгааны шууд асуулгын хариултыг нэгтгэн 2005 онд ашигласан экстрополяцийн аргыг хэрэглэн нийт хүн амд тархаан тооцох арга байсан. Хоёр дахь аргачлал нь шууд бус асуулгыг (Үл ижилсүүлэх тооллогын арга) ашиглаж тухайн анчдын өөрсдийнхөө эрхэлдэг ан агнуурын үйл ажиллагааг нууцлах, хариулахаас цааргалж байгаа эсэхийг тогтоож тооцох арга юм.

Эхний аргачлалд судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийг (n<sub>r</sub> = 1,552) түүврээс хасах (хэдийгээр 5 эмэгтэй ан хийдэг, загас барьдаг хэмээн хариулсан ч) замаар түүврийн хэмжээ 4,070 байсныг 2,518 болтол бууруулж (анхны түүврийн 62 хувь) тооцсон. Түүнчлэн өмнө нь тодорхойлсон 2,314 (анхны түүврийн 52 хувь) түүврийн нэгжээсээ 15-аас доош болон 65-аас дээш насны эрэгтэйчүүдийг (n<sub>15>m<65</sub> = 204) дахин хасч тооцоо хийсэн. Улмаар насны ангиллыг 2005 оныхтой ижлээр бүлэглэж, тухайн насны бүлэг бүрээр тооцоог хийсэн. Улсын нийт дүн нь насны бүлэг бүрээр хийсэн тооцооны нийлбэр бөгөөд 43,038 болсон нь 15-аас дээш насны эрэгтэйчүүдийн 4 орчим хувь болж байна (Хүснэгт 2-г үзнэ үү).

ҮЛ ИЖИЛСҮҮЛЭХ ТООЛЛОГЫН ДҮНГ ТООЦООНД ТУСГАСАН НЬ

Урьдчилан дэвшүүлсэн таамаглал болон шууд бус асуулгаар авсан Үл ижилсүүлэх тооллогын (УСТ)<sup>390</sup> дүнгээс үзэхэд судалгааны шууд асуулгын хариултаас тооцсон үр дүн бодит байдлаас ихээхэн зөрүүтэй байна. Иймээс ан агнуур эрхэлж буй хүмүүсийн тоог илүү бодитойгоор тогтоох зорилгоор дараах аргачлалыг судалгаанд давхар ашигласан болно. Хүснэгт 3-т анчдын жинхэнэ тоог тодорхойлох зорилго агуулсан шууд бус асуулгаар Үл ижилсүүлэх тооллогын аргыг ашиглан хийсэн хоёр дахь тооцоог үзүүлсэн бөгөөд үүнийг загасчид гэхээсээ илүү зөвхөн анчдын тоог тодорхойлох оролдлогыг хийсэн 2005 оны үр дүнтэй харьцуулж<sup>391</sup> болно. Шууд бус асуулгын судалгааг (Үл ижилсүүлэх тооллого) Монгол Улсын хэмжээнд санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгогдсон 15-аас дээш насны 1,500 орчим хүний дунд хийсэн. Эдгээр судалгаанд оролцсон хүмүүсийн тэн хагасаас нь ан агнууртай холбоотой эмзэг сэдэвтэй ‘тохиолдлын’ (case) талаарх асуултыг, харин үлдсэн хэсгээс нь ‘хяналтын’ (control) талаарх асуултыг тус тус асуусан. Ан агнууртай холбоотой эмзэг сэдэв бүхий

390 Бүлэг II. Аргачлал хэсгээс үзнэ үү.

391 2005 оны судалгаагаар нийт оролцогчдын 15% нь загас барьдаг нь тогтоогдсон ч хэн нь зөвхөн загас агнуурыг дагнан эрхэлдэг гэсэн хариулт өгөөгүй.

‘тохиолдлын’ (case) асуултад хариулсан хүмүүсээс 2015 онд ямар нэгэн ан хийсэн эсэхийг нь лавласан. Энэ хэсгийн хариултын дүн шинжилгээг 15-65 насны нийт 553 эрэгтэйчүүдээс авсан хариултад үндэслэн хийсэн болно (Хүснэгт 3-г үзнэ үү).

### Хүснэгт 3. Үл ижилсүүлэх тооллогын арга ашиглан гаргасан анчдын тоо.

ҮЛ ИЖИЛСҮҮЛЭХ ТООЛЛОГЫН АСУУЛТ				
Дараах үйл ажиллагаануудаас өнгөрсөн жилд хэдийг нь хийсэн бэ?				
Би эмнэлэгт очсон				
Би наадам тэмдэглэсэн				
Би ан агнахаар явсан (эмзэг зүйл)				
Би шинэ утас худалдан авсан				
ТОХИОЛДЛЫН БҮЛЭГ			ХЯНАЛТЫН БҮЛЭГ	
Хариулт	Оноо		Хариулт	Оноо
(N <sub>i</sub> )	(N <sub>i</sub> )*(J <sub>i</sub> )	J <sub>i</sub>	(N <sub>i</sub> )	(N <sub>i</sub> )*(J <sub>i</sub> )
27	0	Тэг	22	0
130	130	Нэг	101	101
132	264	Хоёр	61	122
48	144	Гурав	23	69
9	27	Дөрөв		
346	565	Нийт	207	292
1.658959538		Дундаж (N <sub>i</sub> )*(J <sub>i</sub> )/(N <sub>i</sub> )	1.410628019	
Дундаж утгын стандарт ялгаа 24.38 %				

Дээрх аргаар тооцоход нийт анчдын тархалтын хувь 24.83 байна. Үүнийг 2015 оны байдлаарх нийт 15-65 насны эрэгтэйчүүдийн ( $N_{15>m<65} = 995,592$  хүн) дүнд тархааж тооцвол нийтдээ 247,205 хүн ямар нэгэн хэмжээнд ан агнуур эрхэлж байгаа бөгөөд энэ нь бодит утгаараа 2005 оны судалгааны үр дүнтэй адил байна. Харьцангуй утгаар нь авч үзвэл, нийт анчдын тоо 7 хувиар буурсан нь Монгол Улсын нийт эрэгтэй хүн ам 2005-2015 оны хооронд 19 хувиар өссөнтэй холбоотой байна.

### ШУУД АСУУЛГА БОЛОН ҮЛ ИЖИЛСҮҮЛЭХ ТООЛЛОГЫН ҮР ДҮНГ ХАРЬЦУУЛСАН НЬ

2005 онд хийсэн шууд асуулгын судалгааны үр дүнг доорх зургуудад үзүүлэхдээ, нэгдүгээрт, 2015 онд хийсэн шууд асуулгын судалгааны үр дүнтэй, хоёрдугаарт, 2015 онд хийсэн шууд бус асуулгын үр дүнтэй тус тус хийсэн харьцуулалтыг харууллаа. График 1-д 2005 оны тооцоо болон 2015 оны шууд асуулгын судалгааны тооцооны харьцуулалт байна. График 2-г 2015 оны тооцоо болон Үл ижилсүүлэх тооллогын аргаар гаргасан тооцоог харьцуулан үзүүллээ. 2015 онд хийсэн үл ижилсүүлэх тооллого нь зөвхөн анчдын тоог тооцсон бол 2005 оны тооцоонд

зөвхөн загас барьдаг хэмээн хариулсан цөөн тооны хүмүүс орсныг анхаарна уу.

Нэгтгэн дүгнэж үзэхэд, Үл ижилсүүлэх тооллогын аргаар гаргасан тооцоо шууд асуулгын судалгааны тооцооноос бараг зургаа дахин өндөр байна. Өөрөөр хэлбэл, ан хийж байгаа 6 хүн тутмын зөвхөн нэг нь (нийт анчдын 17 хувь) ан хийдэг болохоо өөрсдөө мэдээлж байна. Монгол орны нийт ан агнуур эрхлэгчдийн дийлэнх нь (83 хувь) ямар нэгэн шалтгааны улмаас энэ талаараа мэдээлэхийг хүсэхгүй байгаа ажээ. Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлагаас харахад хууль сахиулах үйл ажиллагаа чангарснаас үүдэн энэ талаар хүмүүс ярих хүсэлгүй байж магадгүйг дурдсан байлаа.

График 1. Шууд асуулгын судалгаанаас тооцсон нийт анчдын тоо





График 2. Шууд бус асуулгын судалгаанаас тооцсон нийт анчдын тоо



Түүвэр судалгааны үр дүнд экстраполяц хийж нийт хүн амд тархах зорилгоор 2015 онд хийсэн Үл ижилсүүлэх тооллогын аргаар тооцсон нийт анчдын тоог (247,504) энэхүү тайланд ашигласан. Энэ нь хэдийгээр өндөр тоо мэт харагдаж байгаа ч дараах хоёр шалтгааны улмаас энэ тоо дутуу ч байж болох талтай.

Нэгдүгээр шалтгаан нь шууд бус асуулгад зориуд асуусан эмзэг асуулт нь хариулж байгаа тухайн хүнд илэрхий ойлгомжтой байсан байж болох юм. Үл ижилсүүлэх тооллогын арга техник нь чухамдаа маш эмзэг нууцлаг асуулгад аль болох өндөр хувийн үнэн зөв хариулт авах зорилго агуулж байдаг. Гэхдээ аргачлалыг хэр зөв хянамгай ашигласнаас хамаарч зарим тохиолдолд дутуу, зарим тохиолдолд илүү мэдээ гарах боломжтой. Бодит байдлаас дутуу мэдээ гарахад нөлөөлөх нэг хүчин зүйл бол тухайн эмзэг асуудал чухамдаа хэр хэмжээний анхаарлын төвд байгаа, өөрөөр хэлбэл, тухайн асуултын цаад утга санаа судалгаанд хамрагдсан хүмүүст хэрхэн тусч байгаагаас хамаарна. Энэхүү судалгааны хүрээнд шууд бус асуулгаар авсан цорын ганц эмзэг асуулт нь ан агнууртай холбоотой асуулт байсан. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн орчин, судлаачдын баримтжуулсан тайлан, цааргалсан хариултын хувь нилээн байсан, өрхийн судалгааны дүн зэргээс үзэхэд судалгаанд хамрагдсан тодорхой бус тооны хүмүүс энэхүү асуулгад үнэн зөв хариулах хүсэлгүй байсан нь ажиглагдаж байна. Түүнчлэн

зориуд асуусан эмзэг асуулт нь илэрхий ойлгомжтой байсан ч байж магадгүй юм.

Дараагийн нэг гол шалтгаан нь зориудын эмзэг асуулгын илэрхийлэл, хэллэгээс хамаарсан байж болно. Өмнө өгүүлсэнчлэн, эмзэг асуулт нь зөвхөн ан агнуур хийдэг эсэхийг асууснаас биш загас барьдаг эсэхийг асуугаагүй байна. Судалгааны явцад, зэрлэг амьтан агнаж, ашиглаж буй хүмүүсийн нэлээд хувь нь загас агнуур бас эрхэлж байгаа нь ажиглагдсан бөгөөд тэд энэ талаар мэдээлэх хүсэлгүй байгааг тогтоосон. Мөн өмнөх хэсэгт дурдсан өрхийн болон зах зээлийн судалгааны үр дүнгээс харахад хүмүүс ямар нэгэн хэмжээгээр арилжааны зорилгоор загас агнаж байгаа хэдий ч барьсан загасаа худалдаалдаг эсэх талаараа мэдээлээгүй байна. Магадгүй, өнгөрсөн жил хэр хэмжээний ан агнасан, загас барьсан талаарх асуулт асуусан бол тийм гэсэн хариултын хувь хэмжээ нэмэгдэх магадлалтай байсан байж болох юм.

## ҮЛ ИЖИЛСҮҮЛЭХ ТООЛЛОГЫН СУЛ ТАЛ

Энэхүү Үл ижилсүүлэх тооллогын арга нь зөвхөн ан хийж буй хүмүүсийн тоог тодорхойлох зорилготой байдгаараа тодорхой хязгаар, сул талтай. Иймээс тодорхой төрлийн ан амьтныг дагнан агнадаг хувь хүмүүсийн талаарх мэдээллийг шууд асуулгын судалгаагаар зөвхөн тогтоосон, тухайлбал, судалгаанд хамрагдсан анчдын 19 хувь нь тарвага агнадаг хүмүүс байгааг өрхийн судалгаанд хамрагдсан 90 анчны мэдээлэл дээр үндэслэн тодорхойлсон. Дээрх 19 хувийг нийт анчдын тоонд экстраполяц хийн тархааж үзэхэд улсын хэмжээнд 46,969 хүн дагнан тарвага агнаж байгаа тооцоо гарч байгаа талаар дараах хэсэгт дэлгэрэнгүй өгүүлнэ. Түүнчлэн нэг тарвагачин ойролцоогоор долоон (7) тарвага агнадаг болох нь шууд асуулгын дүнгээс гарч байна.

Ямар нэгэн нөлөө орсон байлаа ч гэсэн нөхцөл байдлыг тодорхой хэмжээгээр илэрхийлж байгаа учир энэхүү судалгааны үр дүн маш хэрэгцээтэй мэдээлэл болж байгаа юм. Өөрөөр хэлбэл, хүмүүс судалгааны асуулгад хариулахдаа цааргалсан, татгалзсан нь нөлөө үзүүлсэн гэж тооцвол энэ тайланд дурдаж байгаа тоо мэдээлэл нь бодит байдлаас доогуур байна гэсэн үг. Мөн тодорхой нэг амьтныг агнахыг зориуд бай болгодог эсэх, аль эсвэл, тухайн амьтныг улирлын чанартайгаар агнадаг эсэх талаарх мэдээллүүд ач холбогдол багатай байж болно. Гэсэн хэдий ч энэхүү судалгааны суурь мэдээллүүд нь зэрлэг амьтны хууль ёсны болон хууль бус агнуурын талаарх мэдлэгийг шинэ түвшинд гаргахад чухал юм.

Судалгаанд хамрагдагсадын зүгээс хариулахаас татгалзах, цааргалах зэргээс үүдэх нөлөөллийг аль болох багасгах зорилгоор судалгааны дизайн хийж эхэлсэн үеэс эхлэн гол мэдээлэгчтэй ярилцлага хийх, оролцогч талуудтай ярилцлага хийх, ажиглалтын хуудас хөтлөх, утсаар эргэн холбогдох, судлаачид

өөр хоорондоо мэдээлэл солилцох, зэрлэг амьтны худалдаатай холбоотой мэдээллийг зохион байгуулах, хэрэгжүүлэгч байгууллагуудаас олж авах зэрэг хэд хэдэн тоон болон чанарын судалгааны арга хэлбэрүүдийг нэмэлтээр ашигласан. Дээрх олон эх үүсвэрээс цуглуулсан мэдээллийн цар хүрээндээс харахад шууд болон шууд бус асуулгын судалгаагаар тогтоосноос ч илүү олон тооны хүмүүс ан агнуурын үйл ажиллагаа эрхэлж байх магадлалтай байна.

## Агнуурт өртөж буй төрөл зүйлүүд

Өрхийн судалгааны дүнгээс үзэхэд 2015 оны байдлаар 24 төрлийн амьтныг агнасан байна. Тэдгээрийн 10 нь хөхтөн, 3 төрлийн шувуу, 11 төрлийн загас байна. Энэ нь зөвхөн бодит тоон утгаараа ч бус төрөл зүйлийн ангиллаараа 2005 оны судалгааны дүнтэй харьцуулахад (34 төрлийн амьтныг агнан худалдаалж байсан) нилээд ялгаатай байна (Хүснэгт 4). Өнгөц ажиглахад зэрлэг амьтны агнуур, худалдааны үйл ажиллагаа ихээхэн хэмжээгээр буурсан байна. Магадгүй энэ нь судалгаанд хамрагдсан хүмүүс өөрийн эрхэлдэг ан агнах, загас барих үйл ажиллагааны талаар хариулт өгөхөөс цааргалж байсантай холбоотой байж болох юм.

Энэ утгаараа дээрх тоо мэдээ бодит байдлыг бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүй юм. Зах зээлийн судалгаа, ажиглалтын хуудас, гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, хуулийн хэрэгжилтийн талаарх албан ёсны мэдээлэл зэрэг бүхий л мэдээллийн эх сурвалжаас харахад хулгайн анчид, худалдаачид өөр олон төрлийн амьтныг агнаж байгаа ажээ (тухайлбал, цоохор ирвэс, хүрэн баавгай, баданга хүдэр, Алтайн хойлог, хулан адуу гэх мэт). Бодит байдал дээр хөхтөн амьтныг агнан худалдаалж байгаа нь хэн бүхэнд мэдэгдэж байгаа боловч анчид эрүүгийн хариуцлага хүлээхээс (зөвхөн захиргааны хариуцлага тооцоод өнгөрөхгүй) болгоомжлон 2015 оны судалгаанд мэдээлээгүй байгаа нь ажиглагдаж байна. Өрхийн судалгаанд анчдын агнасан 16 хөхтөн амьтны талаарх мэдээлэл тусаагүй, харин анчдын агнасан 11 хөхтөн амьтны талаарх мэдээлэл хууль сахиулах байгууллагуудаас гаргаж өгсөн мэдээлэл, мөн гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлагын үеэр олж авсан мэдээлэлд байсан. Эдгээрийн ес нь (асуулгад мэдээлэгдээгүй амьтдын 81 хувь) Нэн ховор болон Ховор амьтны ангилалд хамаарах амьтад байсан учир тэдгээрийг агнасан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх ёстой байжээ. 2005 онд агнаж байсан дийлэнх амьтад мөн Нэн ховор болон Ховор амьтны ангилалд орсон амьтад байжээ. Эдгээр амьтдыг агнаснаа мэдээлээгүйн гол шалтгаан нь иргэдийн дунд эдгээр амьтдыг агнах нь хууль бус үйл ажиллагаа болох талаар мэдлэг нэмэгдсэнтэй холбоотой байж болно.

Хүснэгт 4. Агнаж буй амьтны нэр (цагаан толгойн үсгийн дарааллаар) 2005 болон 2015 он.

МОНГОЛ УЛС 2005 - 2015

### Агнагдсан зүйлүүд

Үсгийн дарааллаар		2005	2015
<b>ХӨХТӨН</b>	Усны булга	<i>Mustela vison</i>	•
	Алтайн тарвага	<i>Marmota baibacina</i>	•
	Аргаль хонь	<i>Ovis ammon</i>	•
	Хулан адуу	<i>Equus hemionus</i>	•
	Хар сүүлт зээр	<i>Gazella subgutturosa</i>	•
	Хүрэн баавгай	<i>Ursus arctos</i>	•
	Хярс үнэг	<i>Vulpes corsac</i>	•
	Дагуур зараа	<i>Mesechinus dauuricus</i>	•
	Халздай дорго	<i>Meles meles</i>	•
	Шилүүс мий	<i>Lynx lynx</i>	•
	Саарал чоно	<i>Canis lupus</i>	•
	Сүүлэрхэг зурам	<i>Citellus undulatus</i>	•
	Цагаан зээр	<i>Procapra guttorosa</i>	•
	Молцог хандгай	<i>Alces alces</i>	•
	Баданга хүдэр	<i>Moschus moschiferus</i>	•
	Заарт ондоотор	<i>Ondatra zibethicus</i>	•
	Мануул мий	<i>Otocolobus manul</i>	•
	Халиун буга	<i>Cervus elaphus</i>	•
	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	•
	Бараан хэрэм	<i>Sciurus vulgaris</i>	•
	Бор гөрөөс	<i>Capreolus pygargus</i>	•
	Ойн булга	<i>Martes zibellina</i>	•
	Янгир ямаа	<i>Capra sibirica</i>	•
	Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	•
Цоохор ирвэс	<i>Uncia uncia</i>	•	
Зэрлэг гахай	<i>Sus scrofa</i>	•	
<b>ШУВУУ</b>	Алтайн хойлог	<i>Tetraogallus altaicus</i>	•
	Нөмрөг тас	<i>Aegypius monachus</i>	•
	Дагуур ятуу	<i>Perdix dauuricae</i>	•
	Бор галуу	<i>Anser anser</i>	•
	Монгол ногтруу	<i>Syrhaptes paradoxus</i>	•
Цагаан ахууна	<i>Lagopus lagopus</i>	•	
<b>ЗАГАС</b>	Алтайн сугас	<i>Oreoleuciscus potanini</i>	•
	Амарын цулбуурт	<i>Parasilurus asotus</i>	•
	Шивэр хадран	<i>Thymallus arcticus</i>	•
	Нохон далайн мөгер	<i>Lampetra japonica</i>	•
	Булуу цагаан мөгер	<i>Cyprinus carpio</i>	•
	Ердийн цагаан амар	<i>Ctenopharyngodon idella</i>	•
	Шөвгөр хоншоорт мөрг	<i>Branhymystax lenok</i>	•
	Ердийн цурхай	<i>Esox lucius</i>	•
	Голын алгана	<i>Perca fluviatilis</i>	•
	Тул	<i>Hucho taimen</i>	•
Дархадын цагаан загас	<i>Coregonus lavaretus</i>	•	

Ямар төрлийн амьтан агнаснаа мэдээлж байгаа байдал ялгаатай байгаа нь цаанаа өөр утга учрыг өгүүлж байна. 2015 онд нийт агнасан амьтдын 75 гаруй хувийг хөхтөн амьтан эзэлж байсан (нийт 34 төрлөөс 26 нь буюу нийт агнуурын 76 хувь) бол загасны төрөл зүйлс дөнгөж 12 хувь (34 төрлөөс 4 нь) байжээ. Энэ харьцаа сүүлийн үед эрс өөрчлөгдөж, агнасан загасны төрөл зүйл 11 болсны 7 нь өмнөх судалгаанд огт дурдагдаж байгаагүй зүйлүүд байна. Шинээр нэмэгдсэн загасны төрөл зүйлд Алтайн сугас, Амарын лах, шивэр хадран, булуу цагаан, цагаан амар болон цагаан загас зэрэг оржээ.



## Агнуурын тоо хэмжээ

Судалгаанд оролцогчдын мэдээлснээр 2015 онд нийт 3,698 амьтан агнасан байна. Энэ мэдээллийг ашиглан нийт агнуурын хэмжээг тооцох зорилгоор экстраполяц хийхэд (хэт зөрүүтэйг хассан) агнасан ангийн тоо 1,893 болж буурсан. Аль ч тохиолдолд 2005 оны судалгаанд оролцогчдын мэдээлсэн тооноос хамаагүй бага байна. Түүнчлэн агнасан ангийн төрөл зүйлийн хувьд ч гэсэн ялгаатай байна.


Нийт агнуурын бараг 78 хувийг загас агнуур эзэлж байгаа нь агнасан 5 төрлийн амьтны дөрөв нь загас болж байна (График 3). Угаасаа зэрлэг амьтны агнуурт загас агнуур илүү өндөр хувь эзлэх байх гэсэн урьдчилсан таамаг байсан билээ. Загасчдын хувьд нэг удаа гараад л хүссэн хэмжээнийхээ хирээр загас барьчихна гэсэн ойлголт байдаггүй бөгөөд хууль эрх зүйн хувьд ч загас барих тоог хязгаарлаагүй байдаг. Хамгийн сонирхолтой гайхал төрүүлэм зүйл бол ерөнхийдөө зэрлэг амьтны агнуурт загас агнуурын эзлэх хувийн жин бага байсан төдийгүй монголчуудын хүнсний бүтцэд загасны хэрэглээ хязгаарлагдмал байсан явдал юм. 2005 онд зэрлэг амьтан агнаж байсан хүмүүсийн 15 орчим хувь нь загас барьдаг гэж мэдүүлсэн нь нийт агнуурын багахан хувь хэмжээг эзэлж, ерөнхийдөө монголчууд загасыг маш бага хэрэглэдэг байв. 2005 олон 2015 оны судалгааны аль нь ч монголчуудын хоол хүнсэнд загасны хэрэглээ ямрыг тогтоох зорилго агуулаагүй ч судалгааны дүнгээс харахад ерөнхийдөө загасны хэрэглээ бага гэдэг нь тодорхой байна.

Нөгөө талаар загасчлалын хэмжээ нэмэгдсэн нь загасчлах нь тусгай хамгаалалттай, хориглосон хөхтөн амьтан агнаснаас илүү хялбар, хүндрэл багатай (төрөл зүйлээс нь хамаарч хууль эрх зүйн хувьд харьцангуй чөлөөтэй) зэргээс тодорхой хэмжээнд шалтгаалсан байх магадлалтай. Үүнийг 2015 оны судалгаанд ан хийдэг гэхээс илүүтэй загас барьдаг болохоо хүлээн зөвшөөрч мэдээлсэн нь олон байснаар тайлбарлаж болох юм. Түүнчлэн 2005 онд ан агнуур нь харьцангуй чөлөөтэй эмзэг асуудал биш (хуулиар хатуу хориогүй) байж, ан хийдгээрээ бараг бахархах үе байсан учир судалгаанд хамрагдсан хүмүүс ан хийдэг талаараа чөлөөтэй мэдээлж байсан нь ангийн тоо өндөр гарахад нөлөөлж, улмаар загас агнуурыг бага мэдээлсэн байх магадлалтай.

Эдгээр болзошгүй нөлөөллүүдээс үл хамаарч энэхүү судалгааны мэдээлэл нь Монгол Улсын зэрлэг амьтны агнуур, худалдаанд загасчлал илүү өндөр хувийг эзлэх болж, хараахан бүрэн судлагдаагүй огцом бөгөөд гэнэтийн өөрчлөлт гарсныг илтгэн харуулж байна. Гэхдээ энэ хандлагыг бодлого шийдвэр гаргагчид хараахан бүрэн мэдрээгүй байна. Тухайлбал, шинээр батлан мөрдүүлж буй Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд хууль бус загасчлалд торгуулийн хариуцлага ноогдуулах тухай цөөхөн хэдэн заалт (Бүлэг

4-г үзнэ үү) орсон нь ан агнуур, амьтныг хавхдан агнах гэмт хэрэгтэй харьцуулахад тооны хувьд маш цөөн байна.

График 3. Судалгаанд оролцогчдын мэдээлсэн хөхтөн амьтан болон загас агнуурын тоо хэмжээ, 2015.



## Агнуурын хэмжээг тооцоолсон нь

2015 оны судалгааны мэдээллийг экстраполяц хийн үндэсний хэмжээнд тархааж тооцоод 2005 оны судалгаатай харьцуулахад илүү төвөгтэй байлаа. Түүвэрлэлтийн болон түүвэрлэлтийн бус алдааны стандарт хазайлтуудаас гадна судалгаанд оролцогчид үнэн зөв хариулт өгөхөөс цааргалж байсан нь ан хийдэг хэмээн мэдүүлсэн хүмүүсийн тоо, агнуурын хэмжээ бодит байдлаас хамаагүй бага гарахад нөлөөлсөн байна. Өмнөх судалгаанд ан хийсэн (n=90 анчин) хэмээн хариулсан 15-65 насны судалгаанд оролцогч эрэгтэйчүүдийн тоо 2005 оны нийт хүний <10 орчим хувь байсан (n=949 анчин). Мөн 2005 оны судалгаанд зарим төрлийн амьтны тооцоог олон зуун хүмүүсийн судалгаанд өгсөн хариултад үндэслэсэн (жишээ нь, тарвага n=479) бол 2015 оны судалгаа нь харьцангуй цөөн тооны хариултад үндэслэн (жишээ нь, тарвага n=19) тооцох шаардлагатай болсон юм.

Ажиглалтын тоо хэт цөөн байснаас асуултад хариулаагүй тохиолдлын тоо өндөр болж, бодит хариулт өгсөн хүмүүсийн мэдээлэл нь өгөөгүй хүмүүсийн мэдээллээс эрс ялгаатай болох алдааг үүсгэж байгаа юм. Түүнчлэн ан агнуур эрхэлдэг хэмээн хариулсан хүмүүсийн тоо цөөн байгаа учир агнуурын тоо хэмжээ бага байна хэмээн тооцож бас болохгүй. 2005 оны судалгаанаас харахад их хэмжээгээр ан хийдэг болохоо мэдүүлсэн анчид ч байсан (нэг улиралд 70 тарвага агнасан). Цөөн анчид байсан ч хэрэв тэд их хэмжээгээр ан хийж байгаа бол нийт агнуурын хэмжээнд өндөр нөлөөлөл үзүүлэх боломжтой юм. Иймээс судалгааны дүнг нийт хүн амд тархах экстраполяц хийхийн өмнө

тухайн судалгааны бичлэг, бүртгэл нэг бүрийг нягтлан үзэж ямар нэгэн үл хамаарах утга, мэдээлэл байгаа эсэх, хариулт хүчинтэй эсэхийг тогтоох, мөн ижил төрлийн амьтан агнаж буй анчдын агнаж байгаа амьтных нь тоо хэмжээтэй харьцуулж хэт зөрүүтэй (жишээ нь, дундаж нь 8.2 байхад, 500 зэвэг загас барих, гэх мэт) байгаа эсэхийг нягталсан. Ажиглалт цөөн байх тохиолдолд ийм төрлийн мэдээллийн шалгалт маш чухал бөгөөд дундаж утгаас хэт өндөр утга/тоо хэмжээг (хэт өндөр бус байсан ч) хасч тооцсон. Жишээ нь, зэрлэг гахай агнадаг 4 анчин жилд дунджаар 1.8 гахай агнадаг гэсэн хариулт өгсөн байсан учир судалгаанд оролцсон зэрлэг гахай агнадаг өөр нэг анчин жилд 8 гахай агнадаг гэсэн хариултыг хассан. Эцэст нь тус бүрт нь ганцхан хариулт өгсөн бүх төрлийн амьтан агнагчдыг агнуурынх нь тоо хэмжээнээс үл хамааран судалгааны дүнгээс хасч тооцсон. Эдгээр засварыг хийсний дараа нийт агнасан хөхтөн амьтны тоо 411 (анх нийт 761 байсан), загасны тоо 1,482 (анх 2,937 байсан) болж буурсан. Энэ нь судалгааны үр дүнг нийт хүн амд тархаан тооцохын өмнө ан агнуур, загас агнуур гэсэн хоёр багцыг 50 болон түүнээс дээш хувиар бууруулсан гэсэн үг юм.

Анхны “Зэлүүд тал” тайланд дурдсан агнуурын тоо хэмжээг тухайн агнуурын байршилд үндэслэн дахин боловсруулж тооцсон. Энэ нь Монгол Улсын хэмжээнд амьтны тархац жигд бус болохыг харгалзан тооцох, мөн Хоёрдугаар бүлэгт дурдсан түүвэрлэлтийн тархалтын хазайлтыг хязгаарлах зэрэг зорилго агуулсан. Агнуурын тоо хэмжээг тооцохдоо эхлээд аймаг бүрийн анчдын тоог гаргаж, улмаар тухайн амьтныг агнадаг гэж хариулсан анчдын хувийн жингээр үржүүлж, түүнийгээ тус аймагт агнаж буй тухайн амьтны засварласан дунджаар дахин үржүүлж тооцсон. Ингээд аймаг бүрийн тухайн амьтны агнасан нийт дүнгийн нийлбэрээр улсын нэгдсэн дүнг гаргахдаа судалгаанд дурдсан 34 төрлийн амьтны 12 төрлөөр тооцож гаргасан. Тооцоолол хийгээгүй үлдсэн 22 төрлийн амьтны 21 төрлийг нь 10-аас цөөн тооны анчин (тооцоонд ашигласан доод босго утгыг хангаагүй) агнадаг гэсэн хариулт өгсөн байв. Чоно агнадаг гэж хариулсан хүмүүсийн тоо олон, мөн хэтрүүлэгтэй хариулт олон байснаас шалтгаалан улсын хэмжээнд агнасан чонын тоо нь Монгол Улсын нийт чонын тоо толгойноос давж мэдэхээр байсан учир саарал чоно агнуурын тооцоог хийгээгүй болно.

2015 оны судалгааны үр дүнг ашиглан аймгийн түвшний анчдын тоог тооцох нэг талаар боломжгүй, нөгөө талаар шаардлагагүй хэмээн үзсэн. Өрхийн судалгааны үр дүнгээр тооцсон анчдын тоог (4 хувь) Үл ижилсүүлэх тооллогоос гарсан үр дүнгээр засварлаж нийт анчдын тоог гаргасан талаар өмнөх бүлэгт дурдсан билээ. Ийм аргаар үндэсний хэмжээнд анчдын тоог гаргах экстраполяцийн хувийг тодорхойлсон (15-65 насны эрэгтэйчүүдийн 24.83 хувь) учир энэ нь аймгуудын анчдын тооны нийлбэр биш болно. 2015 онд хийсэн судалгааны Монгол Улсын нийт хүн амыг төлөөлөх чадвар 2005 оныхоос давуу болохыг Хоёрдугаар бүлэгт дэлгэрэнгүй өгүүлсэн билээ. Ийм

ч учраас улсын хэмжээний анчдын тоог эргүүлээд экстраполяц хийн агнасан амьтны төрөл, тоо хэмжээг гаргахад ашигласан.

Анчдын тоог гаргамагц хэдийгээр хариултын тоо цөөн байсан ч, байгаа бүхий л мэдээллийг ашиглан ядаж агнасан амьтны доод хэмжээг ч болов тогтоох нь чухал хэмээн үзсэн. Ямарч амьтны агнуурын тоо хэмжээний талаар албан ёсны бүртгэл мэдээлэл байхгүй байгаа учир ийм мэдээлэл нь зэрлэг амьтны хамгаалалт, менежментийн арга хандлагад үнэлгээ өгч цаашид өөрчлөн сайжруулах, улмаар хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чухал эхлэл болох юм.

## ХАМГИЙН ИХЭЭР АГНАЖ БУЙ 10 ЗҮЙЛ

2005 оны судалгаатай харьцуулахад 2015 оны судалгаагаар илрүүлсэн томоохон өөрчлөлт гэвэл хамгийн ихээр агнаж буй 10 зүйлийн агнуурын тоо хэмжээг судалж үзэхэд зургаа нь загасны (хөхтөн амьтны мэдээлэлд Үл ижилсүүлэх тооллогын аргыг ашиглан засвар оруулсны дараа) зүйл байсан явдал юм (Хүснэгт 5). Үл ижилсүүлэх тооллогын аргыг ашиглан мэдээлэлд засвар хийгээгүй тохиолдолд ч 2015 онд агнасан нийт тарваганы тоо 147,764 болж, хамгийн ихээр агнаж буй 10 төрөл зүйлд тарвага орж байна. 2005 оны судалгаагаар гарсан ихээр агнаж буй амьтны жагсаалтад 2015 оны судалгааны жагсаалтад багтсан бүх зүйл болон хэд хэдэн зүйлийн загас дотоодын зах зээл дээр худалдаалагдаж байсныг тогтоосон байдаг. Гэхдээ тэр судалгаанд хамрагдсан нийт анчдаас (n=949) ямар амьтныг зориуд агнадаг болохыг асуухад зэвэг загас хэмээн хариулсан хүмүүсийн тоо дөрөв, тул, алгана барьдаг нь гурав, нэг л хүн цурхай барьдаг гэжээ. Анчдын 0.04 хувийнх нь агнаж, барьж байгаа төрөл зүйлийн тоо хэмжээ нь маш цөөн байгаа учир тооцоонд оруулах боломжгүй байсны зэрэгцээ ач холбогдол муутай гэж үзсэн.

Харин 2015 оны судалгааны үр дүн эрс ялгаатай. Зөвхөн судалгаанд оролцогчдын өөрсдийнх нь өгсөн хариулт дээр үндэслэн хөхтөн хоёр төрлийн амьтныг (тарвага, чоно) оруулалгүйгээр судалж үзэхэд маш олон хүмүүс бусад зүйлээс илүүтэйгээр загас агнаж буй нь ажиглагдаж байна. Харин барьж буй загасны тоо хэмжээ 2005 оныхтой харьцуулахад онцлох ялгаа байхгүй (2005 онд нэг загасчинд дунджаар 10 зэвэг ногдож байсан бол 2015 онд 9.5 байна) байна. Гэхдээ, маш олон тооны хүн загас агнаж байгаагийн хирээр агнасан загасных нь тоо хэмжээ ч бусад хөхтөн амьтад, шувуудын агнуурын тоо хэмжээнээс илүү байх нь дамжиггүй юм.

Хүснэгт 5. Хамгийн ихээр агнаж байгаа 10 зүйл, тэдгээрийн агнуурын тоо хэмжээ, 2015

**Хамгийн ихээр агнаж байгаа 10 зүйл, тэдгээрийн агнуурын тоо хэмжээ, 2015**

			Тооцоолон гаргасан агнуурын тоо
1	Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	849,764
2	Шөвгөр хоншоорт зэвэг	<i>Branhymystax lenok</i>	216,890
3	Голын алгана	<i>Perca fluviatilis</i>	192,075
4	Саарал чоно	<i>Canis lupus</i>	99,002
5	Ердийн цурхай	<i>Esox lucius</i>	96,782
6	Алтайн тарвага	<i>Marmota baibacina</i>	82,501
7	Амарын цулбуурт	<i>Parasilurus asotus</i>	75,440
8	Булуу цагаан мөрөг	<i>Cyprinus carpio</i>	46,654
9	Дархадын цагаан загас	<i>Coregonus lavaretus</i>	43,676
10	Хярс үнэг	<i>Vulpes corsac</i>	41,251

(\*) Хөхтөн амьтдын тооцооллыг УСТ асуултанд, загасны тооцоог тайланд үндэслэсэн болно.

Тэмдэглэл: Энэхүү судалгаагаар Монгол Улсад хийж байгаа шувуудын худалдааны талаарх хангалттай мэдээлэл цуглуулаагүй юм. Ам дамжсан ярианаас үзвэл Алтайн хойлог, цэвдгийн ахууна шувуу нь Монгол Улсын баруун хэсэгт их хэмжээгээр хууль бус худалдаанд өртөж байгаа аж.

## ХАМГИЙН ИХЭЭР АГНАЖ БУЙ ХӨХТӨН АМЬТАД

2015 оны судалгаанаас хамгийн олон тоогоор агнуурт өртөж буй 10 төрөл гэхээсээ 8 төрлийн хөхтөн амьтны талаарх мэдээллийг гаргаж чадсан юм. Судалгааны дутуу хариултын хувь хэмжээ өндөр байснаас шалтгаалан хэд хэдэн төрлийн амьтныг агнадагаа ганцхан буюу маш цөөхөн хүн мэдээлсэнээс болж нэгдсэн тооцоо хийхэд хүндрэл учирч байсан юм. Гэсэн хэдий ч хамгийн ихээр агнаж буй амьтдын жагсаалт үндсэндээ 2005 оны жагсаалттай ижил бөгөөд тун бага өөрчлөлттэй гарсан.

Тарвага, саарал чоно нь хамгийн олон тоогоор агнаж буй амьтны жагсаалтыг өмнөхийн адил тэргүүлж байгаа нь цагдаа, гаалийн байгууллагын мэдээлэл, гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, зах зээлийн ажиглалтаар нотлогдож байна. Шууд асуулгаас үзэхэд нийт анчдын хамгийн багадаа 48 хувь нь тарвага, 17 хувь нь чоно агнаж байна. Энэ судалгааны үр дүнд экстраполяц хийж үзэхэд (Үл ижилсүүлэх тооллогын дүнгээр засварлалгүйгээр) улсын хэмжээнд ойролцоогоор 21,000 анчин тарвага, 7,600 анчин чоно тус тус агнаж байна. Хэрэв эдгээрийг Үл ижилсүүлэх тооллогын дүнгээр засварлаж тооцвол нийт 121,000 анчин тарвага, 44,000 анчин чоно агнаж байгаа тооцоо байна.

Нэг анчинд ногдох тухайн хоёр төрлийн амьтны дундаж тоог 2005 оныхтой харьцуулахад буурсан хэдий ч нийт ан агнуурын тоо хэмжээнээс үзэхэд хууль бус агнуур өндөр түвшинд байгааг илэрхийлж байна (Чиг хандлага гэсэн хэсгийг үзнэ үү). Агнуурын тоо хэмжээ ерөнхийдөө буурч байгаа хэдий ч агнуурын тоо хэмжээ нь олгосон квотын тооноос олон дахин хэтэрч байгаа нь нийт чонон сүргийн тоо толгойтой харьцуулж үзвэл хэт өндөр байна. 2015 оны байдлаар тооцсон (Хүснэгт 6) тарвага агнуурын тоо хэмжээ нь 150,000-с (анчдын мэдээлснээр) 850,000-ын (Үл ижилсүүлэх тооллогын аргаар засварласны дараа) хооронд хэлбэлзэж байна. Агнасан чонын тоо 17,000-99,000 хооронд хэлбэлзэж байна. Эдгээр тооцооны хоёр дахь тооцоо нь зарим талаараа хэтрүүлэн тооцсон байх магадлалтай хэдий ч аль ч тооцоонд агнасан чонын тоо толгойн хэмжээ 10,000-20,000 хооронд хэлбэлзэх тохиолдолд ч асуудалтай хэвээр байна. Эдгээр тус тусдаа хийсэн хоёр судалгаагаар (2005 оны болон 2015 оны судалгаа) нийт агнуурын тоо хэмжээ ижил төстэй гарсан хэдий ч судалгаанд оролцогчид чоно агнадаг тухайгаа итгэлтэйгээр мэдээлсээр байгаа нь чонын сүргийн тоо толгойн судалгааг нарийвчлан хийж, жинхэнэ агнуурын тоо хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тооцох шаардлагатайг харуулж байна. Жилд агнах чонын квот 20 байгааг анчид хэтрүүлж байгаа нь тодорхой бөгөөд магадгүй олгосон зөвшөөрлийг 1,000 дахин хэтрүүлж байж ч мэдэх юм.

## 2005-2015 оны чиг хандлага

Дараах гурван хүснэгтэд хөхтөн амьтан дагнан агнаж буй анчдын тоо (Хүснэгт 7); нэг анчинд ногдох агнасан амьтны дундаж тоо (Хүснэгт 8); болон жилийн нийт агнуурын тоо хэмжээ (Хүснэгт 9) зэргийг тус тус харьцуулан үзүүлэв. Мөн 2005 оны судалгааны мэдээллийг хүснэгт бүрт агнасан амьтны төрлөөр оруулсан. Загас агнууртай холбоотой мэдээллийг тусд нь оруулсан (Хүснэгт 10, 11). CITES-ын болон хууль сахиулах байгууллагуудын мэдээллээс өөр ямар нэгэн нэмэлт бүртгэл, мэдээлэл байхгүй тул шувуудыг оруулаагүй.

## АНЧДЫН ТООНД ГАРЧ БУЙ ЧИГ ХАНДЛАГА

Бид тухайн амьтны төрлийг дагнан агнаж буй анчдын тооны өөрчлөлт дахь чиг хандлагын шинжилгээг хийсэн. Ихэнх тоо мэдээлэл нь бодит байдлаас дутуу тоологдсон байж мэдэх ч 2015 оны судалгаагаар гарсан бүхий л төрлийн амьтны агнуурын тоо хэмжээ нь өмнөх 2005 оны судалгаатай харьцуулахад бага байх магадлалтай байна. 2005 он болон 2015 оны судалгаанд багтсан 7 хөхтөн амьтныг агнадаг анчны тоо нь 13-87 хувийн хооронд буурчээ. 2005 онд хамгийн ихээр

Хүснэгт 6. Анчдын тоо, агнуурын тоо хэмжээ, хамгийн ихээр агнадаг амьтад, 2015

МОНГОЛ УЛС 2015

Анчдын тоо болон агнуурын тоо хэмжээ, хамгийн ихээр агнагддаг амьтад

			ТҮҮВЭР				ПОПУЛЯЦИЙН ТОО			
			Шууд ярилцлаганд тулгуурлаж тооцсон анчдын тоо		Үл ижилсүүлэх тооллогын аргачлалын асуултад тулгуурлаж тооцсон анчдын тоо		Нийт анчдын тоо		Нийт агнасан амьтны тоо	
			Анчдын тоо	Анчдын эзлэх хувь	Нийт агнасан амьтны тоо	Нэг анчны агнасан тоо	Нийт анчдын тоо	Нийт агнасан амьтны тоо	Нийт анчдын тоо	Нийт агнасан амьтны тоо
		$n_{hi}$	$(n_{hi})/n_h$	$t_i$	$t_i/n_{hi}$	$N_{hi}$	$T_i$	$N_{hi}$	$T_i$	
<b>ХӨХТӨН</b>	Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	44	48.8889%	309	7.0	21,041	147,764	121,002	849,764
	Саарал чоно	<i>Canis lupus</i>	16	17.7778%	36	2.3	7,651	17,215	44,001	99,002
	Алтайн тарвага	<i>Marmota baibacina</i>	3	3.3333%	30	10.0	1,435	14,346	8,250	82,501
	Хярс үнэг	<i>Vulpes corsac</i>	6	6.6667%	15	2.5	2,869	7,173	16,500	41,251
	Зэрлэг гахай	<i>Sus scrofa</i>	4	4.4444%	7	1.8	1,913	3,347	11,000	19,250
	Бор гөрөөс	<i>Capreolus pygargus</i>	4	4.4444%	6	1.5	1,913	2,869	11,000	16,500
	Цагаан зээр	<i>Procapra guttorosa</i>	3	3.3333%	5	1.7	1,435	2,391	8,250	13,750
	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	3	3.3333%	3	1.0	1,435	1,435	8,250	8,250
			<b>90</b>	<b>100%</b>	<b>411</b>	<b>4.6</b>	<b>43,038</b>	<b>196,540</b>	<b>247,504</b>	<b>1,130,268</b>

агнаж байсан 10 амьтны тоонд орж байсан гурван амьтны (халиун буга, бараан хэрэм, буурал шилүүс) агнуур 2015 оны судалгаанд бүртгэгдээгүй байна.

Хүснэгт 7. Анчдын тоонд гарч буй чиг хандлага, 2005 - 2015

МОНГОЛ

Анчдын тоонд гарч буй чиг хандлага 2005, 2015 он

	2005 эрэмбэ	Анчдын тоо	2005	2015 (*)	2005-2015 чиг хандлага
#1	Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	139,000	121,002	↓ 13%
#2	Саарал чоно	<i>Canis lupus</i>	75,000	44,001	↓ 41%
#3	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	44,000	5,500	↓ 87%
#4	Цагаан зээр	<i>Procapra guttorosa</i>	34,000	8,250	↓ 76%
#5	Бор гөрөөс	<i>Capreolus pygargus</i>	29,000	16,500	↓ 43%
#6	Хярс үнэг	<i>Vulpes corsac</i>	25,000	19,250	↓ 23%
#7	Зэрлэг гахай	<i>Sus scrofa</i>	20,000	13,750	↓ 31%
#8	Бараан хэрэм	<i>Sciurus vulgaris</i>	6,500		
#9	Халиун буга	<i>Cervus elaphus</i>	5,000		
#10	Шилүүс мий	<i>Lynx lynx</i>	3,000		

(\*)Үл ижилсүүлэх тооллогын дүн

АГНУУРЫН ДУНДАЖ ТОО ХЭМЖЭЭНД ГАРЧ БУЙ ЧИГ ХАНДЛАГА

Хоёр дахь анхааруштай хандлага нь нэг анчинд ногдох агнасан амьтны дундаж тоонд гарч байгаа өөрчлөлт юм. Хэт зөрүүтэй мэдээллийг хасч тооцоход нэг анчинд ногдох агнасан амьтны дундаж тоо бараг 70-80 хувиар буурсан. Тухайлбал, нэг анчинд ногдох агнасан тарваганы дундаж тоо 70 хувиар буурч, 2005 онд нэг анчинд 24 ногдож байсан бол 2015 онд 10 болж буурсан. Нэг анчинд ногдох агнасан Алтайн тарваганы дундаж тоо 79 хувиар, зээрийнх 74 хувиар; үнэгнийх 79 хувиар; хярсных 75 хувиар тус тус буурсан. Хүснэгтэд ороогүй ч нэг анчинд ногдох агнасан чонын дундаж тоо ч ижил түвшинд буурч (32 хувиар) 2005 онд 3.4 байсан бол 2015 онд 2.3 болсон.

Судалгаанд оролцогчид ерөнхийдөө өөрсдийн ан агнуурын үйл ажиллагааны талаар бодит хариулт өгөхөөс цааргалж байсан нь судалгааны үр дүнд сөрөг нөлөө үзүүлсэн байж болох нь ан агнуурын үйл ажиллагааныхаа талаар мэдээлсэн хүмүүсийн тооноос харагдаж байна. Бодит байдал дээрээ ан хийж буй хүмүүсийн тоо хамаагүй өндөр байх боломжтой байсныг тооцоо хийх явцад зарим тохиолдолд дундаж хязгаараас дөнгөж давсан зарим мэдээллийг (судалгааны бусад хариулттай нийцэж байсан хэдий ч) хасч тооцсон нь хязгаарласан байж болох юм. Тухайлбал, зарим тарвага агнагчид 40, 50 тарвага агнадаг хэмээн хариулсан байсан хэдий ч гучаас

дээшхийг нь бүгдийг тооцооноос хассан юм. Өөрөөр хэлбэл, зарим анчны агнаж буй амьтны тоо бусдаасаа өндөр байх нь бодит байдал дээр энгийн тохиолдол байж болох ч дундаж хэмжээг тогтоох зорилгоор зарим хэт өндөр өгөгдлүүдийг хасч тооцсон болно.

Хүснэгт 8. Нэг анчинд ногдох агнасан амьтны дундаж тоо, 2005 – 2015 он.

МОНГОЛ УЛС

### Нэг анчинд ногдох агнасан амьтны дундаж тоо 2005, 2015 он

2005 эрэмбэ		Агнасан амьтны дундаж тоо	Агнасан амьтны дундаж тоо		2005-2015 чиг хандлага
			2005	2015	
#1	Алтайн тарвага	<i>Marmota baibacina</i>	47	10	↓ 79%
#2	Бараан хэрэм	<i>Sciurus vulgaris</i>	27		
#3	Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	24	7	↓ 70%
#4	Голын алгана	<i>Perca fluviatilis</i>	15	10	↓ 33%
#5	Хярс үнэг	<i>Vulpes corsac</i>	10	3	↓ 75%
#6	Шөвгөр хоншоорт зэвэг	<i>Branhymystax lenok</i>	10	10	↓ 0%
#7	Цагаан зээр	<i>Procapra guttorosa</i>	7	2	↓ 74%
#8	Заарт ондоотор	<i>Ondatra zibethicus</i>	5		
#9	Ердийн цурхай	<i>Esox lucius</i>	5	9	↑ 80%
#10	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	5	1	↓ 79%

### АГНУУРЫН НИЙТ ХЭМЖЭЭНД ГАРЧ БУЙ ХАНДЛАГА

2005 оны судалгаагаар харьцуулахад нийт ан агнуурын тоо хэмжээ бага гарсан хэдий ч Монгол Улсын ан агнуур, худалдааны холбогдох хууль тогтоомжид тогтоосон хэмжээнээс өндөр байна. Тухайлбал, тарвага агнуурын асуудал онцгой анхаарал татаж байна. 2015 онд тарваганы квот олгоогүй учир шууд асуулгын судалгаагаар гарсан 150,000 тарвага агнуурын тухай мэдээлэл, мөн Үл ижилсүүлэх тооллогын үр дүнгээр засварласан тооцоогоор 800,000+ тооны тарвага агнуурын тухай мэдээллийн аль аль нь хууль бус агнуур болно. Бор гөрөөсний агнуурын хувьд ч нөхцөл байдал адилхан, тухайлбал, 2015 онд улсын хэмжээнд бор гөрөөс агнах 10 квот тогтоожээ. Гэтэл судалгааны үр дүнгээс харахад хэдэн мянган бор гөрөөс агнасан тооцоо байна. 2005 оны судалгаагаар агнасан чонын тоо хэмжээг тооцоогүй бөгөөд 2015 оны судалгаанд ч мөн адил тооцоо хийгээгүй, гэсэн хэдий ч цуглуулсан мэдээлэл ихээхэн зөрүүтэй байгаа юм. Үл ижилсүүлэх тооллогын үр дүнгээс харахад чоно агнаж буй анчдын тоо (44,000) 2005 оныхоос (75.000) буурчээ, гэтэл үүнийг шууд асуулгын судалгааны дүнгээр тооцвол дахин 90 хүртэл хувиар (7.600) буурах магадлалтай. Шууд асуулгын судалгааны үр дүн болон нэг анчны

агнасан чонын дундаж тоо болох 2.3-ыг ашиглан 2015 онд агнасан байж болох чонын тоог тооцож үзвэл тухайн жилд агнахаар тогтоосон 20 квотоос 2000 дахин илүү олон байна. Түүгээр ч барахгүй агнаагүй амьтны зүйл гэж үгүй болсны зэрэгцээ тэдгээрийн олонх нь худалдаалагдаж, тоо хэмжээний хувьд ч зөвшөөрөгдөх хэмжээнээс давж, зэрлэг амьтанд учрах аюул үргэлжилсээр байна.

Хүснэгт 9. Агнуурын тоо хэмжээ, жилээр, 2005, 2015 он

МОНГОЛ УЛС

### Агнуурын тоо хэмжээ жилээр 2005, 2015 он

Эрэмбэ		Агнуурын тоо хэмжээ		2005-2015 чиг хандлага	
		2005	2015		
#1	Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	3,300,000	849,764	↓ 74%
#2	Цагаан зээр	<i>Procapra guttorosa</i>	250,000	13,750	↓ 94%
#3	Хярс үнэг	<i>Vulpes corsac</i>	200,000	41,251	↓ 79%
#4	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	185,000	8,250	↓ 96%
#5	Бараан хэрэм	<i>Sciurus vulgaris</i>	170,000		
#6	Бор гөрөөс	<i>Capreolus pygargus</i>	100,000	16,500	↓ 83%
#7	Алтайн тарвага	<i>Marmota baibacina</i>	66,000	82,501	↑ 25%
#8	Зэрлэг гахай	<i>Sus scrofa</i>	30,000	19,250	↓ 36%
#9	Алтайн хойлог	<i>Tetraogallus altaicus</i>	14,600		
#10	Халиун буга	<i>Cervus elaphus</i>	6,000		

Хүснэгт 10. Загасчдын тоо, төрөл зүйлээр, 2015

МОНГОЛ УЛС 2015

## ТООЦОЖ ГАРГАСАН ЗАГАСЧДЫН ТОО, ЗҮЙЛЭЭР

$n_f=139, N_f=68,988$

			ТҮҮВЭР		ПОПУЛЯЦИЙН ТОО	
			Загасчдын тоо	Загасчдын эзлэх хувь	Шууд ярилцлаганд тулгуурлаж тооцсон загасчдын тоо	
			$a = (nf)$	$b = (nf)/nf$	$c = b * N_f$	
<b>ЗАГАС</b>	Зэвгэ	<i>Branhymystax lenok</i>	46	33.0935%	22,831	
	Голын алгана	<i>Perca fluviatilis</i>	40	28.7770%	19,853	
	Цурхай	<i>Esox lucius</i>	22	15.8273%	10,919	
	Ердийн цулбуурт	<i>Parasilurus asotus</i>	21	15.1079%	10,423	
	Буллу цагаан	<i>Cyprinus carpio</i>	13	9.3525%	6,452	
	Цагаан загас	<i>Coregonus lavaretus</i>	10	7.1942%	4,963	
	Тул	<i>Hucho taimen</i>	9	6.4748%	4,467	
	Сибирь хадран	<i>Thymallus arcticus</i>	7	5.0360%	3,474	
	Цагаан амар	<i>Ctenopharyngodon idella</i>	5	3.5971%	2,482	
	Номхон далайн могор	<i>Lampetra japonica</i>	5	3.5971%	2,482	
Потанины алтайн сугас	<i>Oreoleuciscus potanini</i>	1	0.7194%	496		

Хүснэгт 11. Загас агнуурын тоо хэмжээ, 2015

МОНГОЛ УЛС 2015

## Загас агнуурын тоо хэмжээ, 2015

			ДЭЭЖИЙН ТОО				ПОПУЛЯЦИЙН ТОО	
			Загасчдын тоо	Загасчдын эзлэх хувь	Барьсан загасны тоо	Загасчдын дундаж тоо	Шууд ярилцлаганд тулгуурлаж тооцсон загасчдын тоо	Тооцоолон гаргасан агнуурын тоо
			$n_i$	$(nf)/nf$	$t_i$	$t/nf_i$	$N_{ni}$	$T_i$
<b>ЗАГАС</b>	Шөвгөр хоншоорт зэвэг	<i>Branhymystax lenok</i>	46	33.0935%	437	9.5	22,831	216,890
	Голын алгана	<i>Perca fluviatilis</i>	40	28.7770%	387	9.7	19,853	192,075
	Ердийн цурхай	<i>Esox lucius</i>	22	15.8273%	195	8.9	10,919	96,782
	Амарын цулбуурт	<i>Parasilurus asotus</i>	21	15.1079%	152	7.2	10,423	75,440
	Буллу цагаан мөрөг	<i>Cyprinus carpio</i>	13	9.3525%	94	7.2	6,452	46,654
	Дархадын цагаан загас	<i>Coregonus lavaretus</i>	10	7.1942%	88	8.8	4,963	43,676
	Тул загас	<i>Hucho taimen</i>	9	6.4748%	41	4.6	4,467	20,349
	Шивэр хадран	<i>Thymallus arcticus</i>	7	5.0360%	37	5.3	3,474	18,364
	Ердийн цагаан амар	<i>Ctenopharyngodon idella</i>	5	3.5971%	30	6.0	2,482	14,889
	Номхон далайн могор	<i>Lampetra japonica</i>	5	3.5971%	21	4.2	2,482	10,423
			139	100%	1,482	10.7	68,988	735,541

## Ан агнуурын улирал

Ан агнуурын үйл ажиллагаа бүтэн жилийн турш явагддаг боловч зуны улиралд 17 төрлийн амьтныг, намрын улиралд 20 төрлийн амьтныг хамгийн идэвхтэйгээр зорин агнаж байна. Түүнчлэн өвлийн улиралд 14 төрлийн амьтныг, хаврын улиралд 12 төрлийн амьтныг агнаж байна. Агнуурын олз омог хаврын улиралд эрс буурдаг хэдий ч бусад улирлуудад тодорхой хэмжээгээр ан хийх боломж бий хэмээн олон тооны анчид, загасчид мэдээлсэн.


График 4. Ан агнуурын улирал, амьтны төрлөөр, 2015



Амьтны тухай хуулиар заасан ан агнуурын хугацаа болон хориотой улирлуудтай харьцуулахад, нийт анчдын тоо, агнуурын тоо хэмжээ тодорхойгүй байсан ч олон ховор амьтны хулгайн агнуур байнга үйлдэгдэж байгаа нь илт байна. Гэтэл зөвшөөрсөн улирал хамаарахгүйгээр ан агнуур хийсээр байна, тухайлбал, бор гөрөөсийг (зөвхөн намар агнахыг зөвшөөрдөг) бүтэн жилийн туршид; хярсныг (намрын сүүлээс өвлийг дуустал зөвшөөрдөг, арьс үсний чанар нь улирлаас шалтгаалан өөрчлөгддөг) зарим анчид бүтэн жилийн турш чанар харгалзахгүй агнаж байна; зуны сүүлээс намрын сүүл сар хүртэл зөвшөөрдөг Монгол болон Алтайн тарвагыг (Алтайн тарвагыг ичээнийх нь үед хүртэл) бүтэн жилийн туршид; тул загасыг мөн жилийн туршид барьж байна (График 4). Амьтны тухай хуулиар заасан бусад амьтны агнуурын хугацааг Дөрөвдүгээр бүлгээс үзнэ үү.

Агнуурын тоо хэмжээ улирлаар хэлбэлзэх нь Монгол Улсын ан агнуурын хэвийн үзэгдэл болсон байна. Намрын улирал нь хөхтөн амьтан, шувуудын агнуурын улирал бол зуны улиралд загас агнуур хамгийн дээд цэгтээ хүрдэг. Бусад улиралтай харьцуулахад хаврын улиралд ан агнуурын идэвх эрс буурдаг байна.

График 5. Агнуурын тоо хэмжээ, улирлаар, 2015



## Өнгөрсөн, эдүгээ үеийнхний ялгаа

Монголчууд хүрээлэн буй байгаль орчноо бишрэн шүтэж хайрлаж ирсэн уламжлалтай. Хүүхдүүддээ бага наснаас нь ургамал мод, гол нуур, уул нуруудыг хамгаалж байдаг эзэн савдгийн тухай ярьж, уул усаа хүндлэхгүй, хилэгнүүлбэл муу зүйл дагалддаг тухай сургаж иржээ. Өсвөр насанд нь хөгшдийн ярьж байсан ан авын уламжлал хүүхэд багачуудыг насанд хүрэх үед нь шидэт үлгэр мэт санагдах нь гарцаагүй юм. Ахмад үеийнхнийхээ ан авын талаар ярьж байсныг дурсахын зэрэгцээ судалгаанд оролцсон зарим ахмадууд хүүхэд байхдаа ан хийж байсан тухайгаа, бүр 9 наснаасаа эхлэн ан хийж байсан тухайгаа ярьж байв. Нам гүмхэн, өглөө үүрээр, чөмөг ташим хүйтэнд удаан отож хүлээсний эцэст ангаа агнаж байсан дурсамж олон хүнд хадгалагдан үлджээ. Морьтой, тэмээтэй, цаг агаарын ямар ч үед, буу, хавх ашиглан ан хийж байсан хүмүүсийн талаар олон оролцогч дурсаж байв. Ахмад үе нь тэдэнд зөвхөн эр, хөгшин, сүрэг дундаа хамгийн

сул доройг нь агнах замаар ан амьтнаа хайрлаж байх ухааныг өвлүүлжээ. Зарим амьтдын хувьд тэд эр, эмийг нь холоос ялгаж, зөвхөн эр амьтныг агнаснаар тоо толгой цаашид өсөн үржих боломжийг хангаж байжээ. Настан буурлууд үлгэрээр дамжуулан ан ав хийх гэдэг бол тун амаргүй, ихээхэн ур ухаан, чадвар, хүч тамир шаардсан, байгаль орчноо хайрлан дээдэлсэн үйл болохыг ойлгуулж байжээ.

Харин өнөө үеийн ан хийж буй аргыг харахад олон анчдын хувьд өмнөх уламжлалтай эрс зөрчилдөх болжээ. Өмнө нь анд явахдаа мориор явдаг байсан бол өнөө үед автомашин, мотоцикл хөлөглөх болж, эдгээр орчин үеийн техникийг даган ан хийх нь ур чадвар, хүч тамир үл шаардах хялбархан агнуурын шинэ үе ирсэн байна. Зарим судалгаанд оролцогчид үүнийг ан ав бус харин мөнгөний төлөөх хядлага хэмээн нэрлэж байна. Мөн ан агнуур эрхлэгчдийн хувьд өмнө нь авто машин, бензин тос хомс байснаас үүдэн агнуур сонгодог хэлбэрээр явагдаж байсан үе байсан. Ахмад настнууд өнөөгийн залуу үеийнхэн байгалиас холдож, байгаль орчны тогтвортой байдлыг үл тоомсорлож, зэрлэг амьтанд дэндүү хайр найргүй хандах болсон хэмээн үзэж байна.

## Хууль бус ан агнуур нэмэгдэж байна

Энэхүү судалгааны явцад урьд өмнө хэзээ ч хэрэглэж байгаагүй, сонсогдож ч байгаагүй, амьтны амь насанд халдах хууль бус олон арга хэрэгсэл улам ихээр ашиглах болсныг баримтжуулж тогтоосон юм. Эдгээрийн тоонд, амьтныг автомашинаар дайрч мөргөж алах, амьтныг эцэж цуцтал нь машинаар хөөн бахардуулж алах зэрэг аргууд орж байна. Монгол Улсын өргөн уудам, цэлгэр тэгш тал нутагт дээрх аргуудын алиныг нь ч ашиглахад хялбар байдаг бололтой. Эхний аргыг хэрэглэхдээ заавал батлагдсан зам маршрутын дагуу явах шаардлагагүй, замтай, замгүй эсэхээс үл хамааран хаана дайралдсан газраа амьтан хөөж, газрын бартаа л тулгарахгүй бол тухайн амьтныг дайрч алах хүртэл хөөж агнадаг байна. Амьтныг мөргөн унагасны дараа сүх, хутгаар амийг нь тасалдаг ажээ. Зээрийг мотоциклоор хөөж агнахад дээрх аргыг түгээмэл ашиглаж байна. Амьтныг эцэж цуцтал нь хөөх аргыг гөрөөс, хар сүүлт, үнэг, хярс, чоно зэрэг харьцангуй хурдтай амьтдыг агнахад хэрэглэж байна. Удаан хугацаагаар хөөж цуцаасны эцэст тухайн амьтан сульдан зогсохоос өөр аргагүй болж, агнуур хийж буй хүмүүст улам л хялбархан алах боломжтой болдог ажээ (Зураг 1).

Зураг 1. Автомашинаар зориуд мөргөж алсан зээрийн зураг



”

2015 оны 2 дугаар сард Баянхонгор аймгаас ирсэн хулгайн анчид мотоциклоор зээр мөргөж агнасан. Тэд нийт 6 хар сүүлт агнасны ихэнх нь шаргачин, янзага байсан. Мөргөж алсныхаа дараа хүзүүг нь хугалаад, махыг нь авч, арьс, толгойг нь үлдээсэн байсан.

Нутгийн иргэн

Өмнөговь аймгийн Гурвантэс сум



Анхны “Зэлүүд тал” тайланд амьтныг автомашинаар зориуд дайрах аргыг шинээр гарч ирж буй арга хэмээн тодорхойлжээ. Үүнээс хойш 10 жилийн дараа хийсэн энэхүү судалгаанд хамрагдсан хэд хэдэн гол мэдээлэгч судалгааны асуулгад энэ аргын талаар дахин мэдээлсэн байна. Автомашин хөлөглөн хууль бусаар ан хийх асуудал өнөө үед өргөн дэлгэрсэн арга болж, тэр ч байтугай ан хийх хамгийн түгээмэл хэлбэр болсон хэмээн тэд үзэж байна. Дорнод аймгийн мэргэжлийн хяналтын байцаагчийн<sup>392</sup> мэдээлснээр тус аймагт явагдаж буй ан агнуурын бараг 70 орчим хувь нь автомашин, мотоцикл ашиглан үйлдэгдэж, амьтныг албаар хөөн дайрч агнаж байгаа бөгөөд буудаж агнах нь нийт агнуурын 20 хүрэхгүй хувийг эзлэх болжээ.

Шөнийн цагаар гэрэлтүүлэг ашиглан амьтан агнах нь бас нэг хууль бус арга болоод буйг мэдээлэгчид өгүүлж байна. Судалгааг боловсруулах шатанд Үл ижилсүүлэх тооллогын үр дүнг ашиглан энэхүү хууль бус ан агнуурын аргын талаарх мэдээллийг тооцох зорилгыг урьдчилан тавьж, ядаж нэг төрлийн хориотой аргын талаар бодитой тоон мэдээлэл гаргахаар төлөвлөсөн. Үл ижилсүүлэх тооллогын үр дүнгээс харахад нийт анчдын 8-с илүү хувь нь шөнийн гэрэлтүүлэг ашиглан ан агнаж байна. Үүнийг улсын хэмжээнд тархаан тооцоход нийт 10,790 анчин энэ аргыг хэрэглэж байна.

392 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага #6.7 (Дорнод- МХЕГ-ын байцаагч).



Ан агнуурт галт зэвсгийг хэрэглэж байгаа нь ан хийх бас нэг түгээмэл арга бөгөөд одоогоор бүрэн үнэлгээ хийхэд хүндрэлтэй байна. Судалгаанд хамрагдсан ан агнуур эрхлэгчдийн дөнгөж 58 хувь нь галт зэвсэг эзэмшдэг хэмээн хариулсан байна. Энэхүү үр дүн нь 2005 онд бараг бүх анчид (96 хувь) галт зэвсэг эзэмшдэг хэмээж байсантай харьцуулахад эрс өөрчлөлт гарсан хэрэг болж байна. Энэ өөрчлөлтийг галт зэвсэг ихээр хураан авсантай холбон тайлбарлаж болох ч дангаараа гол шалтгаан болохгүй. Хууль бус ан агнуур хийсэн тохиолдолд галт зэвсгийг нь тэр бүр хурааж авдаггүй, хураан авсан зарим тохиолдолд галт зэвсгийг хууль зөрчигчдөд эргүүлэн олгох, эсвэл бусдад дамжуулах тохиолдол ч гарч байна. Галт зэвсэг эзэмших зөвшөөрлийн хязгаарлалт, орон нутагт сум хэрэгсэл хууль ёсоор худалдан авахад хүндрэлтэй байдаг зэрэг нь ан агнуурын аргадаа өөрчлөлт хийхэд хүргэж, буудахаас илүүтэйгээр автомашин ашиглах аргыг түлхүү хэрэглэдэг болж байгаагийн нэг шалтгаан байж мэдэх юм.

“ Эзэмшигчид нь зөвшөөрөлгүй эсвэл хууль бус ан агнуурт ашигласан үндэслэлээр бид эдгээр бууг хураан авсан.

Баасанжаргал  
Цагдаагийн ажилтан  
Өвөрхангай аймгийн  
Тарагт сум



Галт зэвсгийн хэрэглээ буурч буйг тайлбарлах өөр нэгэн шалтгаан нь хавх эзэмшиж буй хүмүүсийн тоо ихээр нэмэгдэж байгаа явдал байх магадлалтай. 2005 оны судалгаагаар нийт ан агнуур эрхэлж буй хүмүүсийн тоонд хувьдаа хавхтай хүмүүсийн эзлэх хувийн жин 8 орчим хувь байсан. Харин энэ нь 2015 оны судалгаагаар 21 хувь хүрч өссөн байна. Үүнийг гаалийн ажилтнууд хавхны импорт нэмэгдсэнтэй холбон үзэж байна. Судалгаанд хамрагдсан гаалийн ажилтан энэхүү өсөн нэмэгдэж буй хандлагын талаар

санаа зовниж буйгаа илэрхийлж, холбогдох хууль тогтоомжийг боловсруулан гаргах шаардлагатайг хэлж байлаа. Гэхдээ энэхүү үзэл бодолтой санал нийлэхгүй байгаа зарим судалгаанд оролцогчид тарвага, чоно хавхдан агнах үйл ажиллагаа буурч байгааг тэмдэглэж байлаа.

Зураг 2. Өрхийн болон зах зээлийн судалгааны үеэр судалгааны багийнхны харсан галт зэвсэг, хавхнууд.



Зураг 3-д Ховд аймагт хураан авсан хөл цоожлогч хавхны зургийг харууллаа. Тус хавхыг хэрэглэж байсан этгээд ямар амьтан агнаж байсан талаарх мэдээлэл байхгүй байв. Ерөнхийдөө ийм төрлийн хавхыг үслэг ан агнахад ашигладаг бөгөөд амьтны явах зам дээр байрлуулдаг. Энэхүү хавх нь ангийн үсийг худалдах учир гэмтээхгүйгээр агнах зорилгоор амьтны хөлийг хавхдан барьдаг. Монгол Улсын хувьд голлон агнаж буй үслэг амьтны тоонд үнэг, хярс, шилүүс, цоохор ирвэс, чоно зэрэг амьтан багтаж байна.

Зураг 3. Ховд аймагт авсан хавхны зураг




## Хураагдсан хавх

Ховд аймаг

Түүнчлэн судалгааны дүнгээс харахад анчдын 26 хувь нь хувийн автомашинтай, 22 хувь нь морьтой, 12 хувь нь анч нохойтой байна (График 6). 2005 оны судалгаагаар ийм мэдээлэл цуглуулаагүй тул энэ чиглэлээр гарсан өөрчлөлтийг тодорхойлох боломж бүрдээгүй. Харин бодитоор гарсан өөрчлөлт гэвэл автомашиныг зөвхөн ан хийх газраа хүрэх болон буцахын тулд бус ан агнуурын зэвсэг болгон ашиглаж, амьтныг эцэж цуцтал нь хөөх, дайрч мөргөх зэрэгт хэрэглэх болсон байна.

Казак иргэд ан хийхдээ бүргэдийг түгээмэл ашигладаг талаар судалгаанд оролцсон олон хүмүүс дурдаж байсан хэдий ч судалгааны түүврийн хүрээнд бүргэдийг ангийн хэрэгсэл болгон ашиглаж буй тохиолдол бүртгэгдээгүй. Энэ нь казак иргэд олноор оршин суудаг баруун бүсийн аймгийг судалгааны түүвэрт хамруулаагүйгээс гарсан түүврийн хазайлт юм.

График 6. Ан агнуурын хэрэгсэл (өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй анчдын хувийн жин)



ЭХ СУРВАЛЖ: Өрхийн асуумж (Асуулт #10)

## Загас: тарвагатай адил агнуурт өртөж буй зүйл

Дэлхийн хэмжээнд зэрлэг амьтны хууль бус худалдааны талаарх эрэн сурвалжлах мэдээлэл нь үндсэндээ хоёр хэсэгт хуваагдаж байгаагийн эхний хэсэгт нь зэрлэг амьтны худалдааны бараг бэлгэ тэмдэг шахуу болсон хирс, заан зэрэг амьтны зүйлийн хууль бус худалдаа, нөгөө хэсэгт нь усан орчны зүйлүүдийн хууль бус худалдаа тус тус орж байна. Эдгээрийн зарим нь агуулга, бодит байдал гэхээс илүү сүржин гарчиг байх тохиолдол элбэг. Нөгөө талаар дэлхийн хэмжээнд худалдаалж буй зэрлэг амьтны зүйлсийн тоо нь тайлан, судалгаанд дурдаж байгаасаа хэд дахин олон байна. Тухайлбал, CITES-ын гишүүн орнуудын зүгээс олон улсын худалдааны улмаас устах аюул нүүрлэж буй хэмээн үзсэн 30,000 гаруй амьтныг жагсаалтад оруулсан байдаг. Эдгээрээс гадна жагсаалтад багтаагүй, судлаачдын зүгээс оруулах ёстой хэмээн үздэг бусад олон амьтан байна. Тэдгээрийн тун цөөн хэдийнх нь хувь заяаны талаар сонсох боломж бидэнд олдож байгаа юм.

Бодит байдал дээр юу болж байгаа нь хэвлэл мэдээллийн анхааралд хүрэх хүртэл харьцангуй нууцлаг далд

хэлбэртэй байна. Хуягт гүрвэл (панголин)-ний агнуур үүний нэг тод жишээ юм. Саяхныг хүртэл үл мэдэгдэм байдлаар худалдаалагдаж байсан энэ амьтан сүүлийн хэдхэн жилийн дотор л зэрлэг амьтдад тулгараад буй хямралыг илтгэгч бэлгэ тэмдэг болсон байна.

Хуягт гүрвэлийн монгол хувилбар нь тарвага болж байгаа ч хамрах хүрээний хувьд бага, дөнгөж л дотоодын хэвлэл мэдээллээр хөндөгдөж байна. Хуягт гүрвэлийн нэгэн адил тарвага агнах хэмжээ их болсон байж болох ч тарвага агнуурын талаар дорвитой яриа хэлцэл явагдахгүй байна. 1990-ээд оны дунд үеэс эхлэн тарвагыг тоо хэмжээ хэтрүүлэн агнаж буй талаар цөөн тооны хүмүүс ярьж эхэлсэн хэдий ч энэ асуудлаар яриа хэлэлцүүлэг өрнөхгүй явсаар хямралын байдалд хүрч, сонин хэвлэлийн тэргүүн нүүрэнд гарах болсон түүхтэй. Үүний үр дүнд тарвага агнахад тодорхой хэмжээний зохицуулалт хийж, квот тогтоон, бүрэн болон хэсэгчилсэн байдлаар хориглож буй зарим үр дүн гарч байна.

Нөгөө талаар энэхүү түүхийг давтах дараагийн амьтан нь загас болж байж мэдэхээр байна. Тул загаснаас бусдаар Монгол Улсын хэмжээнд загас агнуурын талаар дорвитой анхаарал тавихгүй байна хэмээн үзэхэд хилсдэхгүй. Гэтэл загас нь Монгол Улсад өрнөөд буй зэрлэг амьтны худалдааны шинэ түүх болж, биологийн олон янз байдлын чухал өв байхын зэрэгцээ дотоодын хүнсний хэрэглээний нэг чухал хэсэг болох нь нэмэгдэж байна. Энэхүү судалгааны өргөн хүрээнд авсан баримт мэдээллээс харахад загас агнах, худалдаалах явдал урьд өмнө байгаагүй их хэмжээгээр нэмэгдэж байгаа бөгөөд тул зэрэг ховор төрлийн загасыг ч хамарч байна. Илүү олон тооны хүмүүс загас барьдаг болсон талаараа өгүүлж, агнаж буй хэмжээ нь 10 жилийн өмнө агнаж байсан тарваганы тоо хэмжээтэй зэрэгцэж иржээ. Зэрлэг амьтны хууль бус худалдааны золиос болох дараагийн амьтан буюу загасны хямрал үүсэж, анхаарлыг дорвитой татаж эхлэх хүртэл хэр удаан хугацаа шаардагдах нь өнөө хир тодорхойгүй байна.

## ‘Бид яг л хулгайч шиг загасчилж байна’

Одоогоор Монгол Улсад загасчлалын нөхцөл байдал ихээхэн нуугдмал хэмжээнд байна. Энэ чиглэлээр цөөн тооны судалгаа хийгдсэн хэдий ч нийт нөөцийн тоо хэмжээ, зохистойгоор ашиглахын тулд агнаж болох тоо хэмжээний талаарх мэдлэг мэдээлэл хомс байна.<sup>393</sup> Нөгөө талаар өнөөгийн хууль бус загасчлалын цар хүрээний талаар мэдэгдэж буй зүйл маш бага байна. Зэрлэг амьтны талаарх хууль тогтоомж, хэрэг илрүүлэх, яллах чиглэлийн арга хэмжээ, шүүхээр шийдсэн бараг бүх хэрэг нь хөхтөн амьтанд хамааралтай байгаа талаар Дөрөвдүгээр бүлэгт өгүүлсэн.

393 A. Dulmaa. 1999. Fish and Fisheries in Mongolia. in Fish and Fisheries at Higher Altitudes: Asia. FAO Fisheries Technical Paper No. 385. by T. Petr Toowoomba, Queensland 4350 Australia.

Энэхүү судалгааны үр дүнгээс харахад загас агнуурын хууль бус ажиллагаа нилээд түгээмэл байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан нэг загасчин “Бид яг л хулгайч шиг загасчилж байна” хэмээсэн нь мөн үүнийг гэрчилж байна. Загас агнуурын зөвшөөрөл авах нь хүндрэлтэй байдаг учраас хулгайгаар агнахаас өөр сонголт үлддэггүй хэмээн судалгаанд хамрагдсан хүмүүс гомдол мэдүүлж байв. Ресторан, жижиглэнгийн дэлгүүрүүд, ил захуудад хийсэн зах зээлийн судалгааны үр дүнгээс харахад агнуурын зөвшөөрөлгүй байх нь загас агнахад ноцтой саад болох зүйл биш ажээ.

2016 МОНГОЛ УЛС

## ХУУЧИН АНЧИД, ШИНЭ ЗАГАСЧИД




Өвөг дээдэс маань надад буу, хутгаа өвлүүлэн үлдээсэн ч 7 жилийн өмнөөс би ан хийхээ болисон.

Одоо би 5 уурга дэгээтэй, тул барьж, эргүүлэн тавьж загасчилдаг. Мөн би Тул хамгаалах нийгэмлэгийн гишүүн болсон.

Сурахбаяр  
Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сум

Анчин асан




Загас барихад орчин үеийн арга хэрэгсэл, тоног төхөөрөмж хэрэглэх болсноор хуучны олз омог багатай, зугаа гаргах төдий ажил байхаа болжээ. Судалгааны үр дүнгээс харахад нийт загасчдын 74 хувь нь өөрийн эзэмшлийн загас агнуурын хэрэгсэл, 15 хувь нь гар хийцийн тоног хэрэгсэл, 13 хувь нь гараар бэлдсэн тор ашиглан загасчилж байгааг График 7-т үзүүлээ.

График 7. Загас барих тоног хэрэгсэл (тухайн төрлийн тоног хэрэгсэлийг эзэмшиж буй загасчдын хувийн жин)



ЭХ СУРВАЛЖ: Өрхийн асуумж (Асуулт #10) n=142

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж, нэр цуутай брэндүүдийн тоног хэрэгсэл борлуулдаг дэлгүүрүүдэд хийсэн ажиглалтын үр дүн судалгааны дүнтэй нийцж байсан. Өнөөдрийн загас агнуурын өртгийн сүлжээ нь загасчлалын хэрэгслийг ханган нийлүүлэх, толгойлох хэмжээний ханган нийлүүлэгч түншүүдийг урьд өмнө байгаагүй тоогоор бий болгож байна.



Нийт загасчдын 74 хувь болох загас агнуурын хэрэгсэлтэй (уурга, дэгээ) загасчдын дунд нэгээс илүү тооны хэрэгсэлтэй загасчид олон байна (нийт загасчдын 27 хувь). Дунджаар нэг загасчин 1.6 ширхэг уурга, дэгээ эзэмшиж байна. Үүний үр дүнд сүүлийн 7-8 жилийн хугацаанд загас дэлбэлж агнах аргыг хэрэглэхээ больж байгаа (гэсэн ч эргэлзээтэй), зөвхөн

арилжааны зорилгоор загас барьж буй хүмүүс л тор тавих аргыг стандарт хэлбэрээр ашиглаж байгаа хэмээн мэдээлэгч нарын өгүүлсэнтэй нийцж байна. Өрхийн хэрэглээний түвшинд үндсэндээ уурга ашиглан загас барьдаг аж. Нөгөө талаар загасчдын дунд хувьдаа машинтай хүмүүс цөөн, анчидтай харьцуулбал бараг гурав дахин цөөн байгаад гайхах зүйлгүй юм.



Нийт загасчдын 27% нь нэгээс илүү тооны уурга, дэгээ эзэмшиж байна



## Анчид, загасчдын ерөнхий шинж байдал

Анчид, загасчдын тоог тооцохоос илүүтэйгээр тэдний ерөнхий дүр төрх, шинж байдлыг тодорхойлоход судалгааны асуулгад өгсөн хариулт хангалтгүй байснаас үүдсэн мэдээллийн хазайлт гол санаа зовоох асуудал болж байна. Шууд асуулгын судалгаанд хамрагдсан хүмүүсийн нилээд хувь нь ан агнуур хийдэг болохоо хүлээн зөвшөөрөхгүй, нуун дарагдуулж байгаагаас анчдын тоо нь байвал зохих хэмжээнээс доогуур гарч байна. Иймээс тэдний ерөнхий дүр төрх, шинж байдлыг тодорхойлоход судалгааны хариултын түвшин бага байсан нь ихээхэн нөлөөлсөн. Ядаж 5 хувийн алдааны хүлцэх түвшин бүхий 95 хувийн итгэлцлийн түвшинтэй үр дүн гарган авахын тулд нийт 247,504 хүнийг төлөөлөх (Үл ижилсүүлэх тооллогоор тогтоосон ан агнуур эрхлэгчдийн тоо) чадвартай түүврийн хэмжээ нь 384 байх ёстой билээ. 2005 оны судалгааны түүврийн хэмжээ үүнээс даруй 300 хувиар илүү байна. Харин 2015 оны судалгаанд анчид, загасчдын түүврийн хэмжээ 195


байсан бөгөөд хүлээгдэж байсан хэмжээнээс дутсан нь алдааны хүлцэх түвшинг 7.02 буюу статистикийн шинжилгээний хүлээн зөвшөөрөгдөх стандартаас 2 хувиар илүү болгосон байна.

Энгийнээр хэлбэл судалгаанд хариулт өгсөн тухайн хүмүүсийн шинж байдал нь судалгаанд хариулт өгөөгүй хэсгийнхнээс ялгаатай байж болох асуудал үүсч байна. Иймээс зөвхөн хариулт өгсөн хүмүүсийн мэдээлэлд суурилсан тооцоо хийсэн нь анчид, загасчдын шинж байдлыг тодорхойлох элементүүдийг орхигдуулсан байж болох талтай. Гэхдээ энэхүү судалгааны үр дүн нь ан агнуур буурч, загасчлал нэмэгдсэнтэй холбоотойгоор тодорхой өөрчлөлт гарч байгааг илэрхийлж буйг энэхүү тайланд онцолсон.

Шууд асуулгын судалгааны үр дүнгээс харахад (Үл ижилсүүлэх тооллогын үр дүнг түр орхиё) судалгаанд оролцогчдын 32 хувь нь (n=195) зөвхөн ан хийдэг; 13 хувь нь ан хийж, загасчилдаг; харин 55 хувь нь зөвхөн загас барьдаг хэмээн хариулжээ. Эдгээр хувь хэмжээг нийт хүн амд тархаан экстраполяц хийж тооцоход нийт 43,038 анчин, 69,988 загасчин байгаа гэсэн тоо гарсаныг өмнө өгүүлсэн билээ. Харин Үл ижилсүүлэх тооллогын үр дүнгээр засварлан тооцоход нийт анчдын тоо нь 247,540 болж байна. Гэхдээ дээрх тооцооны хамгийн чухал хэсэг нь судалгааны хариултын хувь хэмжээ хангалтгүй байсныг үл харгалзан авч үзвэл зэрлэг амьтан агнаж буй хүмүүсийн дийлэнх хэсэг нь анчид бус харин загасчид байгааг илэрхийлж байгаа явдал юм. Өмнөх 2005 оны судалгаагаар загас агнагчдын тоо бага гарсан хэдий ч бодитой тооцоо хийж чадаагүй байдаг. Давган хэлэхэд гарч байгаа өөрчлөлтийн нөлөөлөл нь хангалттай хэмжээнд судлагдаагүй байна.

Ан агнуураас загасчлалд шилжиж буйг дахин баталгаажуулж байгаа өөр нэгэн шинж нь тухайн хүмүүсийн агнуур, загасчлал эрхэлсэн хугацаа, туршлагаас ажиглагдаж байна. Судалгааны дүнгээс үзвэл ан агнуур эрхэлж буй хүмүүс нь илүү олон жилийн туршлагатай (дунджаар 12 жил), харин загас агнуур эрхэлж буй хүмүүс туршлага багатай (8 жил) байна (График 8). Өөр нэг баталгаажуулах зүйл нь бүлэг бүрийн 5 хүртэлх жилийн туршлагатай хүмүүсийн хувийн жингээс тухайн салбарт шинээр орж байгаа хүмүүсийн хувийн жин хир өндөр байгааг харж болох юм. Анчдын бүлэгт шинэ хүмүүсийн хувийн жин 38 хувь, загасчдын бүлэгт 68 хувь тус тус байна. Өөрөөр хэлбэл харьцангуй болон бодит утгаар нь авч үзвэл маш олон тооны хүн зэрлэг амьтны агнуур, худалдааны салбарт загасчин хэлбэрээр шинээр орж ирж буй нь шинээр анчдын эгнээнд нэгдэж байгаа хүмүүсийн тооноос өндөр байна. 2005 оны судалгаагаар агнуур эрхлэгчдийн 44 хувь нь 15-28 насныхан байжээ. Харин 2015 оны судалгаагаар 15-30 насныхан нийт анчдын дөнгөж 30 хувийг бүрдүүлж байна. Ан хийж байсан дундаж хугацаанд гарч буй өөрчлөлтийг тусган тооцож үзвэл ан агнуур эрхэлж буй хүмүүсийн томоохон хэсэг нь (41 хувь) насжиж, 31-50 насныхан зонхилж байна.


График 8. Анчид, загасчдын туршлага, жилээр, 2015



ЭХ СУРВАЛЖ: Өрхийн асуумж (Асуулт #9) n=195

Ан агнуур эрхлэгчдийн шинж байдлын талаарх статистикийн мэдээлэл нь ан агнуур, загас агнуур эрхлэгчдийн ихэнх хэсэг нь Улаанбаатар хотод (41 хувь), үлдэх хэсэг нь (59 хувь) хөдөө орон нутагт амьдарч байгаа нь (Зураг 4) гол мэдээлэгч нартай хийсэн ярилцлага, зах зээлийн судалгааны үр дүнтэй нийцэж байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн тоо маш цөөн учир нарийвчилсан үнэлгээ хийх боломж муутай байна. Гэхдээ дээрх тоо мэдээллээс дүгнэж үзэхэд хараахан бүрэн нотолгоогүй ч зэрлэг амьтан агнах нь чинээлэг хэсгийнхний хийдэг ажил, мөн орон нутагт түлхүү хийдэг, мэргэшсэн ажил болон хувирч буйг харуулж байна.

Зураг 4. Анчид, загасчдын тоо, Улаанбаатар хот болон орон нутгаар



# Зэрлэг амьтны худалдааны зах зээл

## Өрхийн борлуулалт тоо хэмжээ



Би Туул голоос өдөрт ойролцоогоор 30-60 загас барьдаг. Загасаа гэртээ аваачиж хүнсэнд хэрэглэхээс гадна зах дээр аваачиж, хэмжээнээс нь хамааруулан ширхэгийг нь 1000-15000 төгрөгөөр зардаг.



Өнөрөө Загасчин

Төв аймгийн Гачуурт сум

2005 оны судалгаанаас ялгаатай нь энэхүү судалгааны үеэр айл өрхүүд зэрлэг амьтан агнадаг эсэхээ мэдүүлэхээс ихээхэн цааргалж, тун цөөн тохиолдолд л мэдээлж байв. Гэхдээ судалгааны явцад загас барьдаг болохоо цааргалалгүйгээр 1,000 гаруй хүн хэлсэн. Нөгөө талаар зэрлэг амьтан, тэдгээрийн эд эрхтэн худалдан авдаг болохоо мэдүүлж (тусдаа хэсэг бий) байсан нь маш өөр нөхцөл байдлыг илэрхийлж байгаа бөгөөд үүнийг захууд, ресторан, жижиглэн худалдааны дэлгүүрүүдэд хийсэн ажиглалтаар мөн нотолж байгаа болно. Судалгааны явцад цуглуулсан өрхийн хэмжээний худалдан авалтын мэдээллийг доор харуулсан бөгөөд хууль тогтоомж хэрэгжүүлж буй орчин нь худалдаанд оролцогчдод нөлөөлж байгаа нь тодорхой байна. Тухайлбал, нийт агнаж буй загасны тоо хэмжээгээ дурдахдаа зөвхөн өрхийн хэрэглээний хэмжээгээр агнадаг хэмээн мэдээлж байв. Барагцаагаар 736,000 загас барьсныг 30,000 орчмыг өрхүүд хэрэглэсэн байгаа нь нэг өрхөд 24 ширхэг загас ногдохоор байгааг өмнө

Хүснэгт 11-г үзүүлсэн билээ. Энэ тооцооноос харахад загас барихыг зөвшөөрдөг зуны улиралд буюу загас агнуур дээд хэмжээндээ хүрдэг үеэр тухайн өрхүүд хоёр өдөр тутмын нэгд нь хүнсэндээ загас хэрэглэж байна. Мэдээж хүн амын загасны хэрэглээ нэмэгдэж байгаа хэдий ч ийм хэмжээнд нэмэгдсэн гэж үзэх нь учир дутагдалтай, яагаад гэвэл монголчуудын загасны хэрэглээ бага хэвээр, жилд дунджаар нэг хүнд нэг килограмм хүрэхгүй хэмжээний загас ногдож байгаа зэргээс үзэхэд бүр ч эргэлзээ төрүүлэхээр үр дүн гарч байна.<sup>394</sup>

Мэдээллийн энэ хэсгийг шинжлэхдээ түүврийн нэгжийг  $n=1,893$  (статистикийн хувьд үлэмж ялгаатай утгуудыг хассаны дараа) байхаар тооцсон. Улмаар хэрэглээний талаарх мэдээлэлгүй 6 ажиглалтыг хасах замаар түүвэртээ тооцооллын тохиргоо хийж, нийт түүврийн хэмжээг  $n=1,887$  болгосон. Хэдийгээр зарим төрлийн хөхтөн амьтан, шувуудыг худалдаалж байгаа нь илэрхий байсан ч цөөн тооны тарвага, чоныг л борлуулж байгаа гэж мэдээлсэн, түүнчлэн өрхийн хэрэглээнд хэрэглэж байгаагаасаа цөөн хэмжээний худалдаа хийсэн гэсэн үр дүн гарсан. Судалгаанд оролцогчид агнасан тарваганыхаа 4 хувийг, чонын 10 хувийг л зарж борлуулдаг хэмээн хариулжээ. Үүнийг нь улсын хэмжээнд нэг жилийн хугацаанд агнаж буй амьтны тоотой харьцуулж үзэхэд (Хүснэгт 12-г үзнэ үү) 2015 оны судалгаагаар айл өрхүүд 15,431 тарвага, 4,422 чоно худалдаалсан байхаар тооцоо гарч байна.

Хүснэгт 12. Өрхийн түвшний зэрлэг амьтны борлуулалт, тоо хэмжээ

МОНГОЛ УЛС, 2015

### ӨРХИЙН ХИЙСЭН ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХУДАЛДААНЫ ТОО ХЭМЖЭЭ

Экстраполяци

	Судалгаанд хамрагдсан өрхүүд				Улсын хэмжээнд		
	n	Агнасан	Өрхийн хэрэглээнд хэрэглэсэн	Зарж борлуулсан	Агнасан, тооцоолж гаргасан	Хэрэглэсэн, тооцоолж гаргасан	Зарж борлуулсан, тооцоолж гаргасан
Монгол тарвага <i>Marmota sibirica</i>	44	309	297	12	392,199	376,768	15,431
		100%	96%	4%	100%	96%	4%
Саарал чоно <i>Canis lupus</i>	16	31	28	3	45,693	41,271	4,422
		100%	90%	10%	100%	90%	10%

## ҮНЭ

Өрхийн түвшин дэх ангийн зүйлийн борлуулалтын зах зээлийн үнийн дүнг тухайн өрхийн худалдан авсан үнийн мэдээллийг үндэслэн тооцсон.

Тарваганы үнийг судалгаанд хамрагдсан нийт 279

<sup>394</sup> Дулмаа (1999).

ажиглалтын дундаж үнээр тогтоосон бөгөөд энэ нь ойролцоогоор 32,000 төгрөг (14 ам.доллар) байсан, мөн нэг тарваганы үнэ 7,000 төгрөгөөс 70,000 төгрөгийн хооронд хэлбэлзэж байв. Энэхүү үнийн дээд, доод түвшний хооронд эрс өндөр хэлбэлзэл байгаа нь дараах хэд хэдэн хүчин зүйлээс хамаарч байна. Үүнд: i) улирал, ii) амьтны жин, iii) махыг нь түүхийгээр, аль эсвэл боловсруулсан байдлаар худалдан авсан эсэх, iv) дундын зуучлагчдын тоо, v) байршил зэргээс шалтгаалж байна. Ерөнхийдөө үнийн түвшин сум, аймгийн төвүүдэд нэмэгдэж, улмаар Улаанбаатар хотод хамгийн дээд цэгтээ хүрч байна. Улаанбаатар хотод нэг тарвагыг айл өрхүүд дунджаар 35,000 төгрөгөөр худалдан авч байгаа бол хотоос гадагш энэхүү үнэ 25,000 төг орчим болж буурч, зарим тохиолдолд хамгийн хямдаа 7,000 төгрөг болж байна. Үнийн энэхүү хэлбэлзэл нь мэдээлэгчдээс цуглуулсан чанарын судалгааны тоо мэдээллээр мөн нотлогдож байгаа юм.

Зураг 5. Хувийн хэрэглээнд зориулан агнасан тарвага, зэрлэг гахайн зураг



Улаанбаатар хотын иргэний агнаж, өрхийн хэрэглээнд зориулан хөлдөөгчид хадгалсан тарвага

Хэнтий аймгийн Дадал суман агнаж, өрхийн махны хэрэгцээнд зориулан хадгалсан зэрлэг гахайн мах



Чонын арьсны үнийн талаар дөнгөж 5 ажиглалтын мэдээлэл ирснийг үндэслэн тооцоход нэг чонын арьс дунджаар 150,000 (63 ам.доллар) төгрөг байна. Үүнийг судалгаанд хамрагдсан гол мэдээлэгчид анчдын борлуулдаг үнэ хэмээн нотолж байсан бөгөөд тэдний хэлж байгаагаар чонын арьсны үнэ нь 100,000 төгрөгөөс 250,000 төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Тайлангийн энэхүү бүлгийн төгсгөлд чонын тохиолдлын кейс судалгааны үр дүнг оруулсан бөгөөд тэр хэсэгт чонын арьсны үнийг өртгийн сүлжээний

бүхий л урсгалын туршид судалж гаргасан үр дүнг үзүүлсэн болно. Өрхийн дүн шинжилгээний тухайд бол үнийн дүн бага байгаа нь тоо мэдээлэлд экстраполяц хийхэд ашигласан анчдын тоо цөөн байгаатай холбоотой юм.

## НИЙТ БОРЛУУЛАЛТЫН ТООЦОО

Өрхийн гишүүдийн өөрсдийнх нь мэдээлснийг үндэслэн тооцоход тэдний хийж буй нийт борлуулалтын хэмжээ нь хагас сая ам.долларын хэмжээнд хүрч байна (Хүснэгт 13). Нэг тарваганы үнэ болох 14 ам.долларын үнийг ашиглан Монгол Улсад жилд нийт 15,431 тарвага агнаж байгаа хэмээн тооцвол өрхийн нийт орлого нь 216,000 ам.доллар, 4,422 чононоос олох орлого 280,000 ам.доллар болж, түүн дээр нэмэлтээр нэг бүр нь 63 ам.долларын үнэ бүхий арьс худалдсанаас мөн нэмэлт орлого олж байна.

Хүснэгт 13. Өрхийн хэмжээнд борлуулж буй зэрлэг амьтны үнэ

### 2015 МОНГОЛ УЛС

Өрхийн хийсэн зэрлэг амьтны худалдааны тоо хэмжээ  
Экстраполяци

	Хэмжээ Зарж борлуулсан, тооцоолж гаргасан	Үнэ		Худалдааны үнэ	
		Дундаж үнэ (төгрөг)	Дундаж үнэ (ам.дол)		
Монгол тарвага <i>Marmota sibirica</i>	15,431	279	31,749	\$14	\$216,034
Саарал чоно (арьс) <i>Canis lupus</i>	4,422	5	146,000	\$63	\$280,701
					\$ 496,735

## Өрхийн худалдан авалт

### ТОО ХЭМЖЭЭ

Айл өрхийн зэрлэг амьтан, тэдгээрийн эд эрхтэн худалдан авалтын талаарх мэдээлэл болон өрхийн түвшинд худалдаалж байгаа зэрлэг амьтны тухай мэдээлэл зэрэг нь өөр хоорондоо ялгаатай дүр зургийг илэрхийлж байна. Ан агнуур эрхлэгчид хоёр төрлийн амьтан (чоно, тарвага) зарж борлуулдаг гэж мэдээлсэн бол айл өрхүүд 34 төрлийн амьтан, эд эрхтэн худалдан авдаг хэмээн мэдээлжээ. 4,070 өрхийн дөнгөж 60 нь (1.5 хувь) ямар нэгэн зэрлэг амьтан зарж борлуулдаг гэж байсан бол 791 өрх (19 хувь) зэрлэг амьтан худалдан авдаг тухайгаа мэдээлсэн байна. Судалгаанд оролцогчид өөрийн худалдан авалтын тухай мэдээлэл (тарвага зэрэг хориотой амьтан байсан ч) өгөхдөө санаа зовсон шинжгүй санал бодлоо чөлөөтэй илэрхийлж байсан. Магадгүй энэ нь зэрлэг амьтны хууль бус худалдааны сүлжээний нэг хэсэг болох хууль бусаар агнасан зэрлэг амьтан, эд эрхтэн худалдан авах,

ашиглах болон хадгалах тохиолдолд хариуцлага тооцох журам хэрэгжиж эхлээд удаагүй байгаагийн зэрэгцээ энэ талаарх мэдлэг хараахан бүрдээгүй байгаатай холбоотойгоор энэхүү асуултад эмзэг хандаагүй байж мэдэх юм.

Ерөнхийдөө айл өрхүүд зэрлэг амьтан, тэдгээрийн эд эрхтнийг худалдан авах нь нилээд идэвхтэй байгаа нь ажиглагдаж байна. Улаанбаатар хотын өрхийн 22 хувь, орон нутгийн айл өрхийн 18 хувь нь зэрлэг амьтан, тэдгээрийн эд эрхтэнг худалдан авдаг талаарх мэдээлэлтэй байсан учир энэ мэдээлэлд экстраполяц хийж улсын хэмжээний тархаалтыг тооцохдоо судалгаанд оролцогчийн байршлыг оруулж тооцсон. 2015 оны албан ёсны тооллогоор бүртгэгдсэн нийт өрхийн тоог үндэслэн тооцоход тус улсын 170,000 гаруй өрх буюу нийт өрхийн 20 орчим хувь нь зэрлэг амьтны бүтээгдэхүүн худалдан авч байна (График 9).

График 9. Айл өрхийн зэрлэг амьтны бүтээгдэхүүн худалдан авалт, өрхийн тоогоор

МОНГОЛ УЛС 2015

### Зэрлэг амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн худалдан авч буй өрх

Худалдан авдаг өрхийн экстраполяци

	Судалгаанд хамрагдсан өрх		Улсын хэмжээнд	
	n	Худалдан авсан өрхийн тоо	N	Худалдан авсан өрхийн тоо, тооцоолж гаргасан
Хөдөө, орон нутаг	1,771	18%	376,419	67,755
Улаанбаатарт	2,299	22%	482,687	106,191
	4,070		859,106	173,947
			100%	20%



Өрхүүдийн 20% нь зэрлэг амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн худалдан авдаг.

Судалгааны үр дүнгийн тооцоог улам чамбайруулах, зэрлэг амьтан, тэдгээрийн эд эрхтэн худалдан авалтын хэв шинжийг нухацтай судлах зорилгын хүрээнд өрхийн худалдан авах чадварыг тодорхойлохын тулд айл өрхийн хийж буй худалдан авалтад дүн шинжилгээ хийсэн. Үүнээс гарсан үр дүнг График 10-д харуулсан болно. Энэхүү дүн шинжилгээнд өрхийн худалдан авах чадварыг илэрхийлэх албан ёсны тооллогод ашигладаг 5 бүлэг ангиллыг хэрэглэсэн. Эдгээр ангилал нь өрхийн орлогыг бодит утгаар нь илэрхийлдэггүй, харин тухайн өрх төрөл бүрийн зардлаа хэрхэн хангаж байгаагаар худалдан авах чадварыг нь илэрхийлдэг. Тухайлбал, өдөр тутмын үндсэн хэрэгцээний зардлаас эхлээд хувцас хэрэгсэл, үнэт зүйлс худалдан авах, улмаар

хуримтлал бүрдүүлэх боломж зэргийг нь харгалзан тухайн өрхийн худалдан авах чадварын түвшинг тогтоож ангилан бүлэглэдэг. Энэхүү аргачлалд мөнгөн үнэлэмж бүхий асуултуудыг хэрэглэдэггүй учир судалгааны асуултад хариулах түвшин өндөр, үнэн бодитой хариулт сайтай байдаг. Энэ утгаараа өрхүүд дотоод хэрэгцээгээ зэрлэг амьтны нөөцөөр хангах нь Монгол Улсын хувьд түгээмэл байгааг илрүүлж байгаагаараа ач холбогдолтой. Бид судалгааны асуултад 100 хувийн хариулт авсны зэрэгцээ ангилал бүрийн төлөөлөх чадвар нь албан ёсны бүртгэл мэдээтэй нийцэж байсан.


График 10. Зэрлэг амьтан, тэдгээрийн бүтээгдэхүүн худалдан авч буй өрхүүд, орлогын түвшнээр

МОНГОЛ УЛС 2015


### Зэрлэг амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн худалдан авч буй өрх

Худалдан авч буй өрхүүдийн орлогын түвшин


n = 4,070




Өрхийн орлого өдөр тутмын амьдралд хангалттай биш




Өрхийн орлого өдөр тутмын амьдралд дөнгөж хүрэлцдэг



Өрхийн орлого өдөр тутмын амьдрал, хувцас хунарт хангалттай хүрэлцдэг



Өрхийн орлого өрхийн бүхийл хэрэгцээ, өөр бусад үнэт эдлэлд хангалттай хүрэлцдэг



Өрхийн орлого өрхийн бүхийл хэрэгцээ, өөр бусад үнэт эдлэлд, хадгаламжинд хангалттай хүрэлцдэг



Өрхүүд худалдан авах чадвараа нэмэгдүүлэх тусам үндсэн хэрэгцээнээс бусад зүйлд мөнгө зарцуулах боломж нь нэмэгдэж, улмаар зэрлэг амьтан, тэдгээрийн эд эрхтэнийг худалдан авч буй өрхийн хувийн жин өсч байгааг Зураг 15 үзүүлж байна. Ядуу өрхийн 11 хувь нь зэрлэг амьтан, тэдгээрийн бүтээгдэхүүн худалдан авч байгаа бол өрхийн худалдан авах чадвар нэмэгдэхийн хэрээр энэ хувь нэмэгдэж байгаа нь чинээлэг өрхийн 34 хувь нь ийм худалдан авалт хийж чадаж байгаагаас харагдаж байна.



Бид зарим зүйлийн зэрлэг амьтны худалдааны эрэлт уламжлалт эмийн бүтээгдэхүүн байдлаар ашиглах хэрэгцээнээс шинээр олж авсан хөрөнгө чинээгээ гайхуулахын тулд ашиглагдах хэрэгцээ рүү шилжин буй сэтгэл түгшээм шилжилтийг харж байна... Энэ нь тухайн уламжлалт соёлтой холбоотойгоор зэрлэг амьтныг ашиглах явдлаас эдийн засгийн сүр хүчээ олны өмнө гайхуулахын тулд эд барааг хэрэглэх явдал рүү шилжин буй үзэгдлийн нэгээхэн хэсэг юм.

Жон Е.Скантон  
CITES-ын Ерөнхий нарийн  
бичгийн дарга

Зэрлэг амьтны бүтээгдэхүүний хэрэглээний цаашдын хандлагыг судлахад худалдан авалтын шинж байдлыг сайтар ойлгох нь чухал. Эдийн засгийн өсөлт, хотжилт, хүн амын орлогыг нэмэгдүүлснээр “хөдөөгийнхөн зэрлэг ан амьтныг гол амьжиргаагаа болгохыг таслан зогсоож, ядуурлыг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах харилцан ашигтай чухал шийдэл” болно гэсэн үзэл уламжилж ирсэн билээ.<sup>395</sup> Гэвч дэлхийн олон оронд, ялангуяа, Латин Америк, Африкийн уугуул иргэдийн дунд хийсэн төрөл бүрийн судалгааны дүнгээс үзэхэд “эд баялаг нэмэгдэхийн хэрээр хэрэглээ нэмэгдэж, зэрлэг амьтан агнах үйл ажиллагааны цар хүрээ, олз ашгийг улам бүр нэмэгдүүлдэг” хэмээх дүгнэлт гарах болжээ.<sup>396</sup> Яг ийм хэв шинж Монгол Улсад бий болж байх магадлалтай юм. Хөрш зэргэлдээ БНХАУ-ын хөгжил, хотжилт, эд баялаг зэрэг нь зэрлэг амьтны хэрэглээтэй эерэг хамааралтай болж зарим талаараа зэрлэг амьтны хэрэглээ нь нийгмийн статус, байр суурийг илэрхийлэх бэлгэдэл болж байна. Энэхүү хандлага (хөрөнгө чинээ болон зэрлэг амьтны хэрэглээ цуг нэмэгдэх) нь Монгол Улсад ямар хугацаанд үргэлжлэхийг таахын аргагүй байна. Үүний зэрэгцээ хотжилт улам нэмэгдэж, уул уурхайн салбарын хөгжлийн үр шимээр баян чинээлэг хэсэг нэмэгдэх хандлагатай байна.

395 Brashares, Justin & Golden, Christopher & Z Weinbaum, Karen & Barrett, Christopher & V Okello, Grace. (2011). Economic and geographic drivers of wildlife consumption in Africa. Proceedings of the National Academy of Sciences of the United States of America. 108. 13931-6. 10.1073/pnas.1011526108.

396 Idem 2.

## ЗЭРЛЭГ АМЬТАН, ТҮҮНИЙ ЭД ЭРХТЭН

Зэрлэг амьтан худалдан авдаг, хэрэглэдэг гэсэн хүмүүсээс чухам ямар амьтан, эд эрхтэн, бүтээгдэхүүн худалдан авдаг болохыг тодруулсан юм. Үүнд хамаарах хариултуудаас өрхүүд худалдан авч хэрэглэдэг 34 амьтны 31-ийнх нь худалдааны нөхцөл, үнэ, тоо хэмжээ зэрэг мэдээллийг тодорхойлон гаргасныг Хүснэгт 18-д тусгасан бөгөөд үүнд 16 төрлийн хөхтөн, 7 төрлийн шувуу, 11 төрлийн загас орж байна. Зэрлэг амьтан худалдан авч хүнсэндээ хэрэглэх явдал нилээд түгээмэл байгаа бөгөөд зэрлэг амьтныг бүтэн гулуузаар нь, аль эсвэл жижиглэн килограммаар (махыг) нь худалдан авч байгаагийн зэрэгцээ түүхийгээр нь, боловсруулалт хийсэн байдлаар мөн худалдан авч хэрэглэж байна (жишээ нь, чанаж болгосон тарвага, утсан загас, гэх мэт). Амьтны арьс, үс, тос зэрэг бүтээгдэхүүн худалдан авах нь мөн ихээхэн элбэг болж байна. Судалгааны үр дүнгээс харахад чоно, дорго, баавгай зэрэг гурван төрлийн амьтны цөс, тархи, ходоод, элэг зэрэг дотор эрхтэн худалдан авах тохиолдол олширсон байна. Бариад эргүүлэн тавих нөхцөлтэй тул загасыг 2015 онд худалдан авч хэрэглэсэн тохиолдол бүртгэгдсэн бөгөөд тухайн тохиолдолд мах, тосыг нь ашиглажээ.

## НИЙТ ХУДАЛДАН АВАЛТЫН ХЭМЖЭЭ

Өрхийн худалдан авалтын тоо хэмжээг гаргасны зэрэгцээ улсын хэмжээний нийт өрхөд тархаан тооцсоныг гурван тусдаа хүснэгтээр, тухайлбал, хөхтөн амьтан (Хүснэгт 15), шувуу (Хүснэгт 16) загас (Хүснэгт 17) тус тус үзүүлээ. Өрхийн судалгаанд оролцогчдын хариултаас нийт худалдаалагдаж буй 34 төрлийн амьтнаас 31 төрлийн амьтны үнэ ханш, тоо хэмжээний талаарх мэдээллийг нэгтгэн гаргасан. Харин Борцгор хотон, усны булга, хонин тоодог зэрэг амьтны худалдаалсан тоо хэмжээг тооцох боломжгүй байлаа. Түүнчлэн зэрлэг амьтны зарим эд эрхтэн, тухайлбал чонон хэл, тарваганы элэг зэрэг бүтээгдэхүүний худалдааны талаарх өгөгдөл байхгүй байсан тул шинжилгээнд ороогүй. Дээр дурдсан хүснэгтүүдэд амьтны зүйлийг худалдан авсан өрхийн тоо, худалдаалсан нийт тоо хэмжээ, нийт үнэ зэргийг тусгасан. Амьтны үнийг тооцохдоо өрхүүд тухайн амьтныг худалдан авсан үнэ, тоо хэмжээний үржвэрийн нийлбэр дүнгээр гаргасан. Өрхийн жилийн дундаж зарцуулалтыг төгрөг болон ам.доллараар илэрхийлж харуулсан. Өрхүүд хамгийн ихээр худалдан авч буй таван төрлийн амьтанд тарвага, чоно, зээр, бор гөрөөс болон зэрлэг гахай багтаж байна. Загасны хамгийн ихээр худалдаалж буй таван зүйлд цагаан загас, зэвэг, хэлтэг, алгана болон тул зэрэг загас орж байна.

Судалгааны үр дүнд экстраполяц хийж нийт хүн амд тархах зорилгоор тодорхой зүйлийн амьтан худалдан авч буй өрхийн, судалгаанд хамрагдсан нийт өрхөд (n=4,070) эзлэх хувийн жинг тооцож гаргасан. Энэхүү

хувийн жинг улсын хэмжээний нийт өрхийн тоонд (n=859,106) экстраполяц хийн тархааж Монгол Улсад нийт хэдэн өрх зэрлэг амьтан, тэдгээрийн эд эрхтний худалдан авалт хийж буйг амьтны зүйл нэг бүрээр тооцсон. Түүнчлэн нэг өрхөд ногдох тухайн төрлийн амьтны жилийн дундаж худалдан авалтын мэдээллийг ашиглан үндэсний хэмжээний нийт өрхийн жилийн зардлыг амьтны төрлөөр гаргасан. Нийт худалдан авалт улсын хэмжээнд жилд дунджаар 4 сая орчим ам.долларт хүрч байна.

Энэ тооцоо нь борлуулалтын тооцооны дүнгээс өндөр байгаа тул болгоомжтой хэрэглэвэл зохих дүн юм. Судалгааны энэ хэсэгт худалдан борлуулж буй зэрлэг амьтан бүрийн эд эрхтний нэр төрөл, үнэ, тоо хэмжээний талаар их олон төрлийн мэдээлэл цуглуулсан учир тооцоход амаргүй байсан. Мөн судалгаанд оролцогчид асуулгад доторх олон асуултуудад дарагдсаны улмаас зэрлэг амьтны тоотой хамаатай асуултуудад өмнөх худалдан авалтынхаа тоо, хэмжээг эргэн саналгүй, эргэн санахыг хичээлгүйгээр шууд хариулт өгсөн байж болох юм. Нийт судалгаанд оролцогчдын дөнгөж 11 хувь нь л нэгээс дээш төрлийн амьтан, эд эрхтэн худалдан авдаг гэж хариулсан нь анхаарал хандуулах асуудал бөгөөд энэхүү нэгдсэн дүн нь бодит хэмжээнээс ихээхэн доогуур байж магадгүй юм.

Дээрх хүснэгтүүдээс ажигласан нэг чухал зүйл бол нийт өрхийн худалдан авч хэрэглэж буй зэрлэг амьтан, эд эрхтэн, бүтээгдэхүүний тоо хэмжээ нийт өрхийн борлуулж байгаа хэмжээнээс ойролцоогоор найм дахин их буюу ойролцоогоор 0.5 сая ам.долларт хүрч байна. Энэ нь зарж борлуулж буй тоо хэмжээгээ дутуу мэдээлж байгааг, мөн худалдан авалт дээр ч энэ тохиолдол гарч байгааг тод харуулж байна. Худалдан авалттай нь шууд харьцуулан үзэхэд л борлуулж буй тоо хэмжээг дарж мэдээлсэн нь харагдаж байна. Үндсэндээ судалгаанд хамрагдахаас цааргалах тохиолдол их байсныг авч үзвэл худалдан авалт дээр ч бодит хэмжээнээс доогуур мэдээлсэн байх магадлалтай. Судалгаанд оролцогчид өөрсдийнхөө хийж буй борлуулалт, худалдан авалтын талаар ийнхүү зөрүүтэй мэдээлэл өгч байгаа нь магадгүй тэгш бус зохицуулалтын механизмын нөлөөллийг илэрхийлж байж болох талтай. Ан агнуур эрхлэгчид голдуу судалгаанд хариулахаас эрс цааргалж байсан хэдий ч өрхүүд зэрлэг амьтан, эд эрхтнийг ашиглах, худалдан авах, хэрэглэх нь хууль бус болсон нөхцөлд ч хууль бусаар агнасан зэрлэг амьтан, эд эрхтэн худалдан авдагаа нуулгүй мэдээлж байсан.

Өөр нэгэн анхаарууштай асуудал нь нийт худалдаалагдаж байсан 34 зүйлийн амьтнаас цөөн хэдэн төрлийг нь өрхүүд худалдан авч байгаа явдал юм. Хүснэгт 14-д өрхийн хамгийн ихээр худалдан авсан 10 төрлийн амьтан, тэдгээрийн эд эрхтний худалдан авалтын үнийн дүнг нэгтгэн тооцсон. Эдгээр 10 төрлийн амьтны худалдан авалт нийт худалдан авалтын 90 гаруй хувийг бүрдүүлж байна. Эдгээр 10 төрлийн амьтнаас ердөө гурван төрлийн амьтны (тарвага, чоно, зээр) худалдан авалт нийт зэрлэг амьтны худалдан

авалтын 60 орчим хувьтай тэнцэж байна. Үлдсэн долоон төрлийн амьтан (бүгд загасны зүйлүүд) дунд хоёр төрлийн загас, тухайлбал, цагаан загас, зэвэг загасны худалдан авалт нийт худалдан авалтын бараг 25 хувийг эзэлж байна. Эцэст нь нэгтгэн дүгнэж үзэхэд гурван төрлийн хөхтөн амьтан, хоёр төрлийн загас нийлээд нийт худалдан авалтын 85 хувийг бүрдүүлж байгаа нь уламжилж хэвшсэн дадал соёл, шинээр бий болж буй хэв шинж цаашид өөрчлөгдөх магадлал бага байгааг илэрхийлж байна.

#### Хүснэгт 14. Хамгийн ихээр худалдан авч буй амьтны 10 төрөл, жилийн зардал

МОНГОЛ УЛС 2015  
Өрхүүдийн зэрлэг амьтан худалдан авалт

Хамгийн их худалдан авдаг 10 зүйл амьтан, жилээр

#	Түгээмэл нэр	Шинжлэх ухааны нэр	Өрхийн жилийн дундаж зарцуулалт (ам.дол)	Худалдан авалт хийсэн өрхүүдийн тоо	Жилд тухайн зүйл амьтны худалдан авалтанд зарцуулсан нийт хэмжээ (ам.дол)	Нийт хэмжээний эзлэх хувь
1	Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	\$29	61,847	\$1,796,129	46%
2	Дархадын цагаан загас	<i>Coregonus lavaretus</i>	\$18	31,451	\$570,565	15%
3	Шөвгөр хоншоорт мөрөг	<i>Brachymystax lenok</i>	\$19	17,520	\$335,759	9%
4	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>	\$44	5,910	\$264,954	7%
5	Саарал чоно	<i>Canis lupus</i>	\$65	1,689	\$203,006	5%
6	Булуу цагаан мөрөг	<i>Cyprinus carpio</i>	\$17	5,488	\$92,050	2%
7	Гольн алгана	<i>Perca fluviatilis</i>	\$11	7,810	\$84,552	2%
8	Амарын цулбуурт	<i>Parasilurus asotus</i>	\$16	4,222	\$68,005	2%
9	Тул	<i>Hucho Taimen</i>	\$13	4,433	\$59,929	2%
10	Ердийн цурхай	<i>Esox lucius</i>	\$11	3,588	\$42,308	1%
					\$3,517,259	90%

Хүснэгт 15. Өрхийн зэрлэг амьтны худалдан авалт: Жилийн зардал, Хөхтөн амьтан

МОНГОЛ УЛС 2015

## Өрхүүдийн зэрлэг амьтан худалдан авалт

Жилийн зарцуулалтын экстраполяци

ХӨХТӨН	Судалгаанд оролцсон өрхүүдээс			Улсын хэмжээнд								
	Худалдан авалт хийсэн өрхүүдийн тоо	Худалдан авсан өрхүүдийн эзлэх хувь	Жилийн худалдан авалт тоо	Жилийн худалдан авалтын нийт дүн	Дунджаар нэг өрхийн жилийн зарцуулалт	Худалдан авалт хийсэн өрхийн тоо (тооцож гаргаснаар)	Жилийн нийт зарцуулалт (тооцож гаргаснаар)	Тухайн зүйл амьтанд жилд нийт зарцуулсан				
#	Түгээмэл нэр	Шинжлэх ухааны нэр	Худалдаалагдах хэлбэр	(a) = n <sub>p</sub>	(b) = (a)/4,070	(c)	(d) = e <sub>i</sub>	(e) = (d)/(a)	(f) = (3)/2,300	(g)=(b) * 859,106	(h) = (g) * (f)	(i) = Σ h <sub>i</sub>
1	Алтайн тарвага	<i>Marmota bobacina</i>	Мах	4	0.0009828	12	185,000	46,250.00	\$20	844	\$16,978	
			Арьс	1	0.0002457	1	50,000	50,000.00	\$22	211	\$4,589	\$21,567
2	Усны булга	<i>Mustela vison</i>	Тодорхойгүй	1	0.0002457	n.a.	n.a.	n.a.	n.a.	211	-	-
3	Аргаль хонь	<i>Ovis ammon</i>	Эвэр	2	0.0004914	2	160,000	80,000.00	\$35	422	\$14,684	\$14,684
4	Хүрэн баавгай	<i>Ursus arctos</i>	Цөс (грамм)	5	0.0012285	1300	28,450	5,690.00	\$2	1055	\$2,611	
			Арьс	1	0.0002457	1	80,000	80,000.00	\$35	211	\$7,342	\$12,247
			Тос (грамм)	1	0.0002457	100	25,000	25,000.00	\$11	211	\$2,294	
5	Хярс үнэг	<i>Vulpes corsas</i>	Мах (тодорхойгүй)	1	0.0002457	1	30,000	30,000.00	\$13	211	\$2,753	
			Арьс	6	0.0014742	8	86,000	14,333.33	\$6	1266	\$7,893	\$10,646
6	Халздай дорго	<i>Meles Meles</i>	Тос (грамм)	5	0.0012285	265	80,000	16,000	\$7	1055	\$7,342	\$7,342
7	Хар сүүлт зээр	<i>Gazella subgutturosa</i>	Мах	2	0.0004914	2	65,000	32,500.00	\$14	422	\$5,965	\$5,965
8	Саарал чоно	<i>Canis lupus</i>	Мах	8	0.0019656	7	1,200,000	150,000	\$65	1689	\$110,130	
			Арьс	6	0.0014742	6	680,000	113,333	\$49	1266	\$62,407	
			Яс	1	0.0002457	1	10,000	10,000	\$4	211	\$918	
			Тархи	3	0.0007371	3	260,000	86,667	\$38	633	\$23,862	\$203,006
			Ходоод	1	0.0002457	2	50,000	50,000	\$22	211	\$4,589	
			Төмсөг	1	0.0002457	1	12,000	12,000	\$5	211	\$1,101	
9	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>	Мах	28	0.00687961	91	2,857,000	102,035.71	\$44	5910	\$262,201	
			Арьс	1	0.0002457	1	30,000	30,000.00	\$13	211	\$2,753	\$264,954
10	Заарт ондоотор	<i>Ondata zibathicus</i>	Мах (грамм)	1	0.0002457	1	3,000	3,000	\$1	211	\$275	\$275
11	Халиун буга	<i>Cervus elephus</i>	Арьс	2	0.0004914	3	350,000	175,000.00	\$76	422	\$32,121	
			Эвэр	1	0.0002457	1	20,000	20,000.00	\$9	211	\$1,836	\$36,251
			Цөс (тодорхойгүй)	2	0.0004914	1	25,000	12,500.00	\$5	422	\$2,294	
12	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	Мах (тодорхойгүй)	2	0.0004914	2	50,000	25,000	\$11	422	\$4,589	
			Арьс	4	0.0009828	5	275,000	68,750	\$30	844	\$25,238	\$29,827
13	Ойн булга	<i>Martes zibellina</i>	Арьс	1	0.0002457	1	450,000	450,000.00	\$196	211	\$41,299	\$41,299
14	Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	Мах	293	0.07199017	649	19,451,000	66,386	\$29	61847	\$1,785,116	
			Арьс	4	0.0009828	8	120,000	30,000	\$13	844	\$11,013	\$1,796,129
			Элэг	1	0.0002457	n.a.	n.a.	n.a.	n.a.	211	-	
15	Бор гөрөөс	<i>Capreolus pygargus</i>	Мах (грамм)	5	0.0012285	20	291,250	58,250.00	\$25	1055	\$26,729	
			Арьс	1	0.0002457	1	25,000	25,000.00	\$11	211	\$2,294	\$31,777
			Тос (грамм)	1	0.0002457	n.a.	30,000	30,000.00	\$13	211	\$2,753	
16	Зэрлэг гахай	<i>Sus scrofa</i>	Мах	14	0.0034398	15	255,000	18,214	\$8	2955	\$23,403	
			Тос (грамм)	1	0.0002457	100	20,000	20,000	\$9	211	\$1,836	\$37,169
			Элэг	1	0.0002457	1	130,000	130,000	\$57	211	\$11,931	

\$2,513,140

## Хүснэгт 16. Өрхийн зэрлэг амьтан худалдан авалт: Жилийн зардал, Шувуу

МОНГОЛ УЛС 2015

### Өрхүүдийн зэрлэг амьтан худалдан авалт

Жилийн зарцуулалтын экстраполяци				Судалгаанд оролцсон өрхүүдээс						Улсын хэмжээнд	
ШУВУУД				Худалдан авалт хийсэн өрхүүдийн тоо	Худалдан авсан өрхүүдийн эзлэх хувь	Жилийн худалдан авалт тоо	Жилийн худалдан авалтын нийт дүн	Дунджаар нэг өрхийн жилийн зарцуулалт		Худалдан авалт хийсэн өрхийн тоо (тооцож гаргаснаар)	Жилийн нийт зарцуулалт (тооцож гаргаснаар)
#	Түгээмэл нэр	Шинжлэх ухааны нэр	Худалдаалагдах хэлбэр	(a) = n <sub>pi</sub>	(b) = (a)/4,070	(c)	(d) = e <sub>i</sub>	(e) = (d)/(a)	(f) = (3)/2,300	(g)=(b) * 859,106	(h) = (g) * (f)
17	Алтайн хойлог	<i>Tetragalus altaicus</i>	Max (rp)	13	0.0031941	5	130,750	10,057.69	\$4	2744	\$12,000
18	Сохор элээ	<i>Milvus lineatus</i>	Элэг	1	0.0002457	1	20,000	20,000.00	\$9	211	\$1,836
19	Хон хэрээ	<i>Corvus corax</i>	Max	1	0.0002457	2	50,000	50,000.00	\$22	211	\$4,589
20	Борцгор хотон	<i>Pelecanus crispus</i>	тодорхойгүй	1	0.0002457	n.a.	n.a.	n.a.	n.a.	211	-
21	Хонин тоодог	<i>Otis tarda</i>	тодорхойгүй	1	0.0002457	n.a.	n.a.	n.a.	n.a.	211	-
22	Бор галуу	<i>Anser anser</i>	Max	3	0.0007371	7	210,000	70,000.00	\$30	633	\$19,273
23	Цагаан ахууна	<i>Lagopus lagopus</i>	Max	2	0.0004914	2	73,000	36,500.00	\$16	422	\$6,700
										\$44,396	

## Хүснэгт 17. Өрхийн зэрлэг амьтан худалдан авалт: Жилийн зардал, Загас

МОНГОЛ УЛС 2015

### Өрхүүдийн зэрлэг амьтан худалдан авалт

Жилийн зарцуулалтын экстраполяци				Судалгаанд оролцсон өрхүүдээс						Улсын хэмжээнд	
ЗАГАС				Худалдан авалт хийсэн өрхүүдийн тоо	Худалдан авсан өрхүүдийн эзлэх хувь	Жилийн худалдан авалт тоо	Жилийн худалдан авалтын нийт дүн	Дунджаар нэг өрхийн жилийн зарцуулалт		Худалдан авалт хийсэн өрхийн тоо (тооцож гаргаснаар)	Жилийн нийт зарцуулалт (тооцож гаргаснаар)
#	Түгээмэл нэр	Шинжлэх ухааны нэр	Худалдаалагдах хэлбэр	(a) = n <sub>pi</sub>	(b) = (a)/4,070	(c)	(d) = e <sub>i</sub>	(e) = (d)/(a)	(f) = (3)/2,300	(g)=(b) * 859,106	(h) = (g) * (f)
24	Ердийн цурхай	<i>Esox lucius</i>	Max Тос (rp)	17 1	0.0041769 0.0002457	67 100	449,000 12,000	26,411.76 12,000.00	\$11 \$5	3588 211	\$41,207 \$1,101
25	Шөвгөр хоншоорт зэвэг	<i>Brachymystax lenok</i>	Max	83	0.02039312	447	3,658,500	44,078.31	\$19	17520	\$335,759
26	Алтайн сугас	<i>Oreoleuciscus potanini</i>	Max	10	0.002457	120	385,000	38,500.00	\$17	2111	\$35,333
27	Шивэр хадран	<i>Thymallus arcticus</i>	Max Тос (rp)	5 2	0.0012285 0.0004914	15 100	111,000 15,000	22,200.00 7,500.00	\$10 \$3	1055 422	\$10,187 \$1,377
28	Амарын цулбуурт	<i>Parasilurus asotus</i>	Max	20	0.004914	118	741,000	37,050.00	\$16	4222	\$68,005
29	Номхон далайн мөгер	<i>Lampetra japonica</i>	Max	1	0.0002457	1	25,000	25,000.00	\$11	211	\$2,294
30	Дархадын цагаан загас	<i>Coregonus lavaretus</i>	Max	149	0.03660934	660	6,217,000	41,724.83	\$18	31451	\$570,565
31	Булуу цагаан мөргө	<i>Cyprinus carpio</i>	Max	26	0.00638821	153	1,003,000	38,576.92	\$17	5488	\$92,050
32	Голын алгана	<i>Perca fluviatilis</i>	Max	37	0.00909091	234	921,300	24,900.00	\$11	7810	\$84,552
33	Тул загас	<i>Hucho Taimen</i>	Max Тос (rp)	21 2	0.00515971 0.0004914	80 7	646,000 7,000	30,761.90 3,500.00	\$13 \$2	4433 422	\$59,287 \$642
34	Ердийн цагаан амар	<i>Grass carp</i>	Max	13	0.0031941	42	314,000	24,153.85	\$11	2744	\$28,817
-	Загас (бусад)	-	Max	11	0.0027027	40	381,000	34,636.36	\$15	2322	\$34,966
										\$1,366,145	

## Хүснэгт 18. Өрхийн зэрлэг амьтан худалдан авалт, Эд эрхтэн

Монгол улс 2015

### Өрхүүдийн зэрлэг амьтан худалдан авалт

Худалдаалагддаг эд, эрхтнүүд

			Худалдаалагддаг эд, эрхтнүүд															
			Мах	Тос	Арьс үс	Эвэр	Цусан эвэр	Яс	Цус	Элэг	Уушги	Тархи	Холоод	Төмсөг	Хэл	Цөс	Согооны сүүл	
ХӨХТӨН & ШУВУУ	Алтайн тарвага	<i>Marmota baibacina</i>	•		•													
	Алтайн хойлог	<i>Tetra gallus altaicus</i>	•															
	Аргаль хонь	<i>Ovis ammon</i>				•												
	Сохор элээ	<i>Milvus migrans</i>								•								
	Хүрэн баавгай	<i>Ursus arctos</i>		•	•												•	
	Хон хэрээ	<i>Corvus corax</i>	•															
	Хярс үнэг	<i>Vulpes corsas</i>	•		•													
	Халздай дорго	<i>Meles meles</i>		•					•		•							
	Хар сүүлт зээр	<i>Gazella subgutturosa</i>	•															
	Саарал чоно	<i>Canis lupus</i>	•		•			•				•	•	•	•	•		
	Бор галуу	<i>Anser anser</i>	•															
	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>	•		•													
	Заарт ондоотор	<i>Ondata zibathicus</i>	•															
	Халиун буга	<i>Cervus elaphus</i>			•	•	•											
	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	•		•													
	Ойн булга	<i>Martes zibellina</i>	•		•													
	Бор гөрөөс	<i>Capreolus pygargus</i>	•		•													
	Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	•		•													•
	Зэрлэг гахай	<i>Sus scrofa</i>	•	•					•	•								
Цагаан ахууна	<i>Lagopus lagopus</i>	•																
ЗАГАС	Шөвгөр хоншоорт мөрөг	<i>Brachymystax lenok</i>	•															
	Дархадын цагаан загас	<i>Coregonus lavaretus</i>	•															
	Булуу цагаан мөрөг	<i>Cyprinus carpio</i>	•															
	Ердийн цурхай	<i>Esox lucius</i>	•	•														
	Ердийн цагаан амар	<i>Stenopharyngodon idella</i>	•															
	Тул	<i>Hucho Taimen</i>	•	•														
	Номхон далайн мөрөг	<i>Lampetra japonica</i>	•															
	Алтайн сугас	<i>Oreoleuciscus potanini</i>	•															
	Амарын цулбуурт	<i>Parasilurus asotus</i>	•															
	Голын алгана	<i>Perca fluviatilis</i>	•															
	Шивэр хадран	<i>Thymallus arcticus</i>	•	•														
	Загас (бусад зүйл)	-	•															

(\*) Дараах 3-н зүйл амьтны худалдаалагддаг эд эрхтний мэдээлэл гарах боломжгүй (Хонин тоодог, Борцгор хотон, Америк усны булга)

## Ресторанууд

Нийт хүн ам нь хэрэгцээт уургаа мах, цагаан идээнээс авдаг уламжлал бүхий Монгол Улсын хувьд өрхийн судалгаагаар тогтоосон загас агнах, худалдаалах хувь хэмжээ ихээхэн өндөр хэмжээнд хүрсэн нь анхаарал татсан билээ. Үүнээс үүдэн зах зээлийн судалгааны асуулгад загасны хэрэглээний талаар асуултуудыг нэмж оруусан юм. Хэдийгээр судалгаанд хамрагдсан өрхүүд барьсан загасаа зарж борлуулдаггүй гэж хариулсан ч захууд болон ресторануудад тухайн орон нутгаас барьж нийлүүлсэн загас, загасан бүтээгдэхүүн борлуулагдаж буйг 2005 болон 2015 оны судалгаа тогтоосон. Загасчдын тоо болон агнуурын хэмжээ нь дээрх хоёр судалгааны хоорондох хугацаанд ихээхэн өөрчлөгджээ. Иймд загасны хэрэглээ болон худалдааны түвшинг хэмжих нэг арга болсон рестораны хоолны цэс, түүнд санал болгож буй загасан бүтээгдэхүүний талаар тусгайлан нарийн судалж үзсэн үр дүнг энд танилцуулж байна.

### СУДАЛГААНЫ ТҮҮВЭР

Зах зээлийн судалгаанд хамруулахаар тодорхойлсон газарт загасны махан хоолоор үйлчилж буй нийт 108 рестораныг олж тогтоон ярилцлага хийсэн. Эдгээрийн ихэнх нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг (108 рестораны 87 нь буюу түүврийн 81 хувь) бөгөөд Улаанбаатар хотод байрлаж буй ресторануудад загасны махны дийлэнх хэрэглээ байгааг судалгааны дүн харуулж байна. Гадаад нэр төрлийн хоолоор, гадаадын иргэдэд гол төлөв үйлчилгээ үзүүлж буй ресторанууд энэ төрлийн зах зээл давамгайлж байгаа хэмээн таамагласан бөгөөд судалгаанд хамрагдсан ресторан бүрийг голлон хийж үйлчилдэг нэрийн хоолных нь төрлөөр ангилж авч үзсэн. Хүснэгт -д үзүүлэв.

Судалгаанд хамрагдсан ресторануудын дийлэнх нь Монгол үндэсний хоолоор үйлчилдэг хэдий ч ресторануудад хэрэглэж буй загасны хамгийн их хувь хэмжээг хараахан эзлэхгүй байгаа юм. Судалгаанд хамрагдсан загасаар бэлтгэсэн хоол хүнсээр үйлчилдэг нийт рестораны 42 хувийг уламжлалт Монгол хоолны ресторан эзэлж байна. Үүний дараа Солонгос (30 хувь), Хятад, Итали, Европ (тус бүр 17 хувь) үндэсний хоолоор үйлчилдэг ресторанууд орж байна. Энэ мэтээр бусад үндэсний хоолоор үйлчилдэг ресторанууд нийт түүврийн багахан хувийг эзэлж байна. Ресторануудын нийт тоо байхгүй эсвэл тухайн үндэсний хоолоор үйлчилдэг ресторанууд яг хэд байгааг мэдэхгүй тохиолдолд энэ салбарт нийт хэрэглэгдэж буй загасны тоог экстраполяцийн аргаар тооцож гаргах боломжгүй юм. Гэхдээ Монгол үндэсний хоолны ресторанууд нь загасны хоол хүнсний зах зээлд давамгайлж байгаа нь харагдаж байгаа юм.

Хэдий Монгол үндэсний хоолны ресторанууд загасны махан хоолны зах зээлд давамгайлж байгаа ч тэр чинээгээр их загас борлуулдаг гэж үзэх боломжгүй юм. Учир нь хүн амынх нь суурьтай харьцуулахад гадаадын

иргэд загас хэрэглэгчдийн томоохон хувийг эзлэх ба Монголоос бусад үндэсний хоолны ресторанууд нийт түүврийн 58 хувийг эзэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл Монгол Улсад оршин суугчдын маш бага хувийг гадаадын харьяат иргэд бүрдүүлдэг ч (0.6 хувь),<sup>397</sup> тэд ресторан, зоогийн газруудад загасаар бэлтгэсэн хоол захиалж буй хэсгийн ихэнх хувийг эзэлдэг. Загас захиалдаг хамгийн түгээмэл үйлчлүүлэгчдийн талаар асуухад ресторануудын 40 хувь нь гадаад иргэд болон монголчууд бараг тэнцүү байдаг хэмээн хариулсан бол 37 хувь нь монголчууд, 20 хувь нь гадаадын иргэд, 3 хувь нь сайн мэдэхгүй гэж тус тус хариулав.<sup>398</sup>

### Хүснэгт 19. Загас зарж буй ресторануудыг үйлчилдэг үндэсний хоолоор нь ялган харуулсан байдал

МОНГОЛ УЛС 2015  
ЗАГАС ЗАРЖ БУЙ РЕСТОРАНУУДЫГ  
ҮНДЭСНИЙ ХООЛНЫХ НЬ ТӨРЛӨӨР  
АНГИЛСАН БАЙДАЛ N=108  
n=108

ҮНДЭСНИЙ ХООЛНЫ ТӨРӨЛ	Ресторануудын эзлэх %
Уламжлалт Монгол	42%
Солонгос	30%
Хятад	17%
Итали	17%
Европ	17%
Япон	7%
Орос	6%
Ирланд	4%
Мехсик	4%
Энэтхэг	3%
Унгар	3%
Ази	3%
Турк	2%
Азарбажейн	2%
Герман	1%
Украйн	1%
Америк	1%

397 United Nations Department of Social and Economic Affairs, Trends in International Migrant Stock: The 2015 Revision.

398 Ресторануудын судалгаа (Асуулт 3, n=108).

## ЗҮЙЛИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ

Рестораныхаа хэрэгцээнд худалдан авдаг загасных нь зүйлийн талаар асуухад судалгаанд оролцогчид нийт 37 зүйлийн загас нэрлэсэн. Өрхийн судалгаанаас ялгаатай нь бүх оролцогчид худалдан авдаг загасныхаа зүйлийн нэрийг сайн мэдэж байсан ба “том загас” эсвэл “жижиг загас” гэсэн хариулт огт өгөөгүй. Хэдийгээр энэхүү судалгаа нь бүх рестораныг хамарсан иж бүрэн судалгаа биш ч гэсэн ресторан үйлчилгээний салбарт дөрвөн зүйлийн загас түгээмэл хэрэглэгддэг болохыг ажигласан. Үлдэх 33 зүйлийн загасыг нийт судалгаанд хамрагдсан ресторануудын 5 хүрэхгүй хувь нь дурдсан. Хоолонд хэрэглэгддэг нийт загасны жагсаалтад Монгол оронд байдаггүй, импортоор оруулж ирдэг хэдэн зүйлийн далайн загас болон амьтан (жишээ нь туна, наймаалж, хар хайван, сам хорхой) байв. Гэхдээ нийт нэрлэсэн 37 зүйлийн загасны зөвхөн долоон зүйл нь Монгол оронд байдаг ба үүнд цагаан загас, тул, алгана, шивэр хадран, булуу цагаан, цагаан амар, зэвэг загаснууд багтаж байна (Хүснэгт 20). Ресторанууд эдгээр зүйлийн загасыг зөвхөн Монголоос худалдан авсан гэж мэдээлсэн бөгөөд хоёр зүйлийн загасыг дотоод болон гадаадаас худалдан авсан байна (нийт тохиолдлын 56 хувь нь цагаан загасыг дотоодоос, 44 хувь нь гадаадаас, алгана загасны 50 хувийг дотоодоос худалдан авсан гэв).

Монгол Улс дахь ресторануудын хоолны цэсэд тул загас байсаар байна. 2005 оны судалгаагаар хүнсний зах болон ресторануудад тул загас худалдаалж байгааг баримтжуулсан ч энэ талаар оролцогчид хангалттай хариулт өгөөгүй тул тодорхой тоо баримт гаргах боломжгүй байсан. Харин 2015 оны судалгаанд хамрагдсан ресторануудын 9 хувь нь тул загасны махаар хийсэн хоолоор үйлчилж байгаа гэж мэдээлэл өгсөн. “Ховор” амьтны жагсаалтад багтдаг учир тул загасыг барьсан тохиолдолд заавал эргүүлэн тавих зохицуулалт байдаг. Зөвхөн судалгааны явцад илэрсэн 9 хувь ч гэлтгүй тул загас нь аливаа рестораны хоолны цэсэд ил тод байгаа нь гайхмаар зүйл юм. Өнөөгийн хууль тогтоомжид заасны дагуу зөвхөн хууль бусаар тул загасыг барьсан гэлтгүй мөн худалдаалсан тохиолдолд (худалдах, худалдан авах) мөн эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу 1-5 жил хүртэлх хугацаагаар хорих, 5,400-27,000 нэгжтэй тэнцэх хэмжээний мөнгөн торгууль (10,800-54,000 төгрөг) төлөх захиргааны шийтгэл оногдуулах хууль үйлчилж байна. 2005 оны судалгааны тайланд тул загас хаана өвөлждөг, жилийн бусад улиралд нэг газартаа эргэн ирдэг эсэх гэх мэт тэдний “Монгол орон дахь амьдралын түүхийн талаарх мэдээлэл хомс байна” гэж дурджээ. Мэдэгдэж байгаа зүйл нь тул загас 6-7 нас хүртлээ үржилд ордоггүй, 30 ба түүнээс олон жил насалдаг тухай юм. Ийм учраас тул загасыг хэт их агнуурт маш эмзэг амьтан гэж үздэг.

## Хүснэгт 20. Ресторануудын худалдан авдаг загасны зүйлүүд

Монгол улс 2015

### Ресторануудын загас худалдан авалт

Зүйлээр нь эрэмбэлсэн

n = 108

#	Загасны зүйлийн нэр	Тухайн зүйл загасаар үйлчилж буй ресторанууд эзлэх хувь	Унаган зүйл
#	Загасны зүйлийн нэр		○
#1	Дархадын цагаан загас	44%	
#2	Яргай	27%	
#3	Туна	13%	
#4	Тул	9%	○
#5	Тилапия (Tilapia)	4%	
#6	Гунчи (Gunchi)		
#7	Алгана		○
#8	Шивэр хадран	3%	○
#9	Хорхой загас		
#10	Булуу цагаан		○
#11	Ердийн цулбуурт		
#12	Ердийн цагаан амар		○
#13	Зэвэг		○
#14	Наймаалж		
#15-37	Бусад	1%	

Ресторануудын загаснаас олдог бизнесийн ашиг орлогын хэмжээг тооцож гаргахын тулд судалгаанд оролцогчдоос хамгийн сайн борлуулалттай саруудын борлуулалтын дундаж дүнг асууж тодруулсан. Энэхүү асуултад хариулах хэд хэдэн сонголт байсан бөгөөд үүнд нийт борлуулсан загасны орц бүхий хоолны тоо (таваг), хэрэглэсэн загасны нийт жин (килограмм), борлуулсан загасны тоо эсвэл загасны орцтой хоол борлуулсны орлогын аль нэг үзүүлэлтээр хариултаа өгөх боломж байв. Хариултаас харвал загасны бизнес нь дунджаар нэг ресторанд сар бүр 355 ам.доллар хүртэлх орлого (n=99) оруулдаг бөгөөд загасны орцтой 55 таваг хоол (n=96) эсвэл 2,000 ширхэг загас (n=59) зарж борлуулдаг байна. Хэрэв нэг жилийн бүх саруудад дээрх үзүүлэлтийн 80 хувьтай тэнцүү хэмжээний борлуулалтыг хамгийн ихдээ хийдэг (сард 280 ам.доллар) гэж үзвэл тэдгээр 99 рестораны нийт борлуулалтын орлогыг сараар тооцон, нэг жил рүү хөрвүүлбэл 337,000 ам.доллар гэсэн тооцоо гарч байна.


Энэхүү судалгаанаас гарсан мэдээллийг нийт улсын хэмжээний бүх ресторануудад экстраполяци хийх буюу тархаан тооцох боломжгүй юм. Учир нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй нийт рестораны тоо эсвэл загас орсон хоолоор үйлчилж буй ресторануудын нэгдсэн тоо баримт байхгүй юм. Албан ёсны статистик мэдээллээр тус үйлчилгээний салбарын 2015 оны

нийт орлогын хэмжээг 205.5 тэрбум төгрөг буюу ойролцоогоор 90 сая ам.доллар хэмээн тооцсон бөгөөд үүний 86 хувь нь Улаанбаатар хотоос үүсэлтэй гэж дурджээ.<sup>399</sup> Ийм хэмжээний орлогоос харвал загаснаас олох бизнесийн ашиг нь бидний судалгааны үр дүнгээс хэд дахин их орлого оруулж байж болох юм.

## ХУДАЛДАН АВАЛТЫН УЛИРАЛ

Худалдан авалтын улирлын талаар хийсэн дүн шинжилгээ нь дотоодын захууд дээр бүх улирлын турш загас зарагддаг, рестораниуд хүссэн үедээ загас худалдан авах боломжтойг харуулж байна. Зөвхөн шивэр хадран болон Алтайн сугас хоёр хавар худалдаанд байдаггүй ба шивэр хадран мөн намар байхгүй болдог байна. Түүнчлэн рестораниудын худалдан авч буй бүх загас хөлдүү биш байгааг харвал (дараагийн хэсгийг үзнэ үү) борлуулалтын улирал болон барьсан цаг хугацаа нь өөр байх боломжтой юм. Худалдан авах давтамж болон хөлдөөсөн бүтээгдэхүүн удаан хадгалаагүй байгаагаас үзвэл худалдаалж буй загасны тодорхой хэсгийг зөвшөөрсөн агнуурын улиралд, бусад үед хууль бусаар барьж буйг харуулж байна. Тулаас бусад бүх зүйлийн загасны агнуурын улирал нь ерөнхийдөө урт байдаг, ихэнх загасны хувьд зуны эхэн үеээс өвөл дуустал үргэлжилдэг. Рестораниудын 4 хувь нь өдөр бүр, 55 хувь нь долоо хоногт нэг удаа, 36 хувь нь сард нэг удаагийн давтамжтайгаар загас худалдан авдаг байна. Рестораниудын зөвхөн 11 хувь нь улирлаас хамааран загас худалдан авдаг гэж хариулсан байна. Жишээ нь бариад, суллан тавих ёстой ганц зүйл болох тул загасны агнуурын улирал зун болон намар байдаг ч бүх улирлын турш борлуулагдаж байна (График 11).

График 11. Рестораниудын загас худалдан авдаг улирлын байдал



## БОЛОВСРУУЛАХ ХЭЛБЭР


Судалгааны түүвэрт хамрагдсан рестораниуд хөлдөөсөн загас гол төлөв худалдаж авдаг байна. Оролцогчдын мэдээлсэн нийт загас худалдан авалтын (n=159) 70 хувь нь хөлдөөсөн загас байсан бөгөөд эдгээрт График 12-д үзүүлсэн Монгол оронд байдаг 8 зүйл загас бүгд багтаж байв. Дөнгөж барьсан шинэ загас нь хоёрдах чухал хэлбэр хэдий ч нийт худалдан авалтын дөнгөж 13 хувийг эзэлж байна. Монгол оронд байдаг 5 зүйлийн загас шинэхэнээр нь худалдан авдаг загасны жагсаалтад бүртгэгдсэн бөгөөд үүнд цагаан загас, хадран, тул, зэвэг болон сугас гэсэн зүйлүүд байна. Хөлдүүгээр тэвэрлэх боломж байхгүй гэдгээс үзвэл шинээрээ байгаа загас худалдан авч буй газрууд тухайн загас барьсан байршилтай ойролцоо байрладаг болохыг илтгэж байна. Дараагийн нэг хэлбэр болох лаазалсан загас нийт худалдан авалтын 8 хувийг бүрдүүлж байна. Лаазалсан загасны хувьд Монгол оронд байдаг загас илрээгүй. Мөн даршилсан (шилэнд саванд) загасны хувьд дээрхтэй ижил байсан ба энэ боловсруулалтын хэлбэр нь худалдан авалтын 4 хувийг эзэлж байна. Лаазлах болон даршлах байдлаар боловсруулалт хийх нь илүү боловсронгуй тоног төхөөрөмж шаарддаг бөгөөд Монгол Улсын загас бэлтгэлийн салбарт энэ технологи хараахан нэвтрээгүй байна. Гэрийн нөхцөлд ч хийх боломжтой илүү анхан шатны аргаар боловсруулдаг утсан загас нь худалдан авалтын 6 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд үүнд цагаан

399 Монгол улсын статистикийн мэдээллийн үйлчилгээ (www.1212.mn).



загас, тул, ердийн цурхай гэсэн Монгол оронд байдаг гурван зүйл загас багтаж байна.

График 12. Ресторануудын худалдан авдаг загасыг боловсруулсан хэлбэрээр нь ялгаж харуулсан байдал



## ХУДАЛДАН АВАХ ЭХ ҮҮСВЭР


Дараах зургуудад Монгол оронд байдаг загасны зүйлийг хэрхэн худалдаж авдаг судалгааны үр дүнг харуулж байгаа бөгөөд ресторануудад загас нийлүүлж буй хамгийн гол ханган нийлүүлэгч нь бөөний худалдаа эрхлэгч буюу ченжүүд (нийт худалдан авалтын 67 хувь) байгаа бол загасчдаас шууд худалдан авах тохиолдол харьцангуй бага (15 хувь), жижиглэн худалдаа эрхлэгчдээс худалдан авах тохиолдол (17 хувь) өмнөхтэй ойролцоо байна. Улаанбаатар хотын ресторанууд нь ихэнхдээ бөөний худалдаачдаас загас худалдан авдаг бол орон нутгийн ресторануудын хувьд шууд загасчдаас худалдан авах боломж нь илүү өндөр байдаг боловч гэсэн таамаг гарч ирж байна. Гэхдээ өрхийн судалгааны хүрээнд ярилцлагад хамрагдсан загасчдын хэн нь ч өөрийн барьсан загасаа зарж борлуулдаг гэж хариулаагүйг санах хэрэгтэй.

График 13. Ресторануудад Монголд байдаг загас ханган нийлүүлэгчид



Гадаадаас орж ирдэг загасны зүйлийг ханган нийлүүлэлтийн төрлөөр нь авч үзвэл нийт тохиолдлын 55 хувьд нь ресторанууд импортлогчдоос шууд худалдан авдаг бол нийт тохиолдлын 33 хувьд нь бөөний худалдаа эрхлэгчдээс, 12 хувьд нь шууд гадаадын экспортлогчдоос худалдан авдаг (График 14) байна.

График 14. Гадаадаас орж ирдэг загасны ханган нийлүүлэгчид



Эдгээр бүх мэдээ баримт нь загасан бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн сүлжээ нь харьцангуй сайн хөгжсөн, олон тооны оролцогч талуудтай болохыг харуулж байна. Үнэ болон бүтээгдэхүүний байдлыг харвал дотоодын загасны худалдаа сайн хөгжөөгүй байгаа нь тодорхой байна. Жишээ нь загасыг килограммаар бус ширхгээр нь үнэлэн борлуулж байгаа нь бүхэлдээ үнэн бодит биш эсвэл ил тод бус үнийн тогтолцоог бий болгож байна. Ресторанууд дотоодоос худалдан авдаг цагаан загасанд 5,000-60,000 төгрөг (2.17- 26.08 ам.доллар) төлдөг бөгөөд үнэ өртөг нь боловсруулалт хийсэн хэлбэрээс (шинэ, хөлдөөсөн, утсан, n=38) биш харин тухайн загасны хэмжээнээс илүү хамаардаг байна. Тул загасыг худалдан авдаг үнэ нь 17,000-48,000 төгрөгийн (7.39- 20.87 ам.доллар) хооронд хэлбэлзэж байна.

Зураг 6. Увс аймагт үйл ажиллагаа явуулж буй рестораны загасчнаас шууд худалдан авсан шинэ загас



Увс аймгийн Улаангом сумын зоогийн газар нь Хяргас нуурын загасыг нэг бүрийг нь 2000 төгрөгөөр загасчдаас шууд худалдан авч байна.

хэдэн удаа дурдагдсан давтамжаар нь дараах байдлаар эрэмблэн тайлбарлав.

Зураг 7. ОХУ-аас импортоор оруулж ирсэн уламжлалт эмийн бүтээгдэхүүн

## ОХУ-аас импортлосон уламжлалт эмийн бүтээгдэхүүн



Баавгайн тос

## Уламжлалт эм, эмчилгээ

Монгол уламжлалт эмчилгээний эмнэлгүүд болон эмч нар гол төлөв ургамлын гаралтай эм бэлдмэл ашиглан эмчилгээ хийдэг бөгөөд амьтны гаралтай эм, бүтээгдэхүүн бага хэрэглэдэг байна. Уламжлалт эмчилгээний эмч нар ургамлын гаралтай эм бэлдмэл ашиглан зүрх, бөөр, элэг, цөс, уушги, ходоод зэрэг дотор эрхтний олон төрлийн өвчнийг анагааж байна. Түүнчлэн ургамлын гаралтай эм бэлдмэлүүдийг яс болон цустай холбоотой тодорхой өвчнүүд, ханиад, үе мөчний үрэвсэл, мэдрэлийн олон асуудлыг эмчлэхэд ашиглаж байна. Ургамлын гаралтай эм танг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх (үс бэхжүүлэх, нойр сайжруулах, дотор цэвэрлэх гэх мэт), өвчин намдаах зорилгоор бичиж өгдөг. Эмч нар болон эм хэрэглэгчдийн аль аль нь ургамлын бараг бүх хэсгийг (үр, иш, навч, үндэс, цэцэг гэх мэт) ашиглан эм бэлдмэлээ өөрсдөө бэлтгэдэг.

Нөгөө талаар амьтны гаралтай бүтээгдэхүүнийг судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь (55 хувь, n=34) хэрэглэдэг гэж хариулсан. Судалгааны үр дүнд нийт 6 зүйлийн амьтанг уламжлалт эмчилгээнд хамгийн түгээмэл ашиглаж буйг илрүүлсэн. Тухайн эмчилгээнд ашиглаж буй зэрлэг амьтны эд эрхтний гарал үүслийн талаарх мэдээлэл тодорхой бус байгаа нь уламжлалтын эмч нар гарал үүсэл гэхээсээ хэрхэн хэрэглэх тухай илүү мэддэг болох нь харагдаж байна. Дотоодод бэлтгэсэн (Зураг 8) болон гадаадаас (Зураг 7) импортоор оруулж ирсэн уламжлалт эмийн бүтээгдэхүүний нэр төрлийн талаар баримт нотолгоо цуглуулж, гэрэл зураг авсан ч гэсэн энэхүү судалгаагаар худалдан авалтын хэмжээ болон үнийн талаарх мэдээлэл цуглуулаагүй болно. Гэхдээ судалгааны үр дүнд уламжлалт эмчилгээнд хэрэглэдэг зэрлэг амьтны эд эрхтэн болон тэдгээрийн шинж чанарын талаарх мэдээллийг тодорхой хэмжээнд олж авсан. Амьтны зүйлүүдийг судалгааны хариултад



Доргоны тос

**Хүрэн баавгай.** Хүрэн баавгайн тос болон цөсийг үе мөчний өвчин, архаг өвчнүүд, үрэвсэлт өвчин, арьсны түлэгдэлт болон ходоодны өвчинг анагаахад хэрэглэдэг. Судалгаанд оролцогчид санал нэгтгэйгээр Монголоос гаралтай баавгайн тосыг үйлчлүүлэгчид илүүд худалдан авдаг гэж хэлсэн бөгөөд ОХУ-аас оруулж ирсэн, боломжийн үнэтэй уламжлалт эмийн бүтээгдэхүүнүүд ч мөн худалдаанд түгээмэл (Зураг 7) байдаг гэж дурдаж байсан.

**Халздай дорго.** Доргоны тосыг арьсны түлэгдэлт, ходоодны шарх, бүдүүн гэдэсний үрэвсэл зэргийг эмчлэхэд Улаанбаатар хот болон Сэлэнгэ аймагт түгээмэл хэрэглэдэг гэжээ.

**Тарвага.** Тарваганы тосыг ходоодны шарх болон үе мөчний өвчний (үе мөчний үрэвсэл, ясны шохойжилт) үед хэрэглэдэг хэмээн дурдсан.

**Шар үнэг.** Уушгины өвчинг эмчлэхэд үнэгний уушги хэрэглэдэг гэжээ.

**Саарал чоно.** Саарал чонон махыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Улаанбаатар хотод түгээмэл хэрэглэхийн зэрэгцээ ханиад томуу, уушгины үрэвслийг эмчлэхэд хэрэглэдэг хэмээн хоёр оролцогч хариулсан. Оролцогчдын хэлснээр гол хангалт нь

Сүхбаатар аймгаас ирдэг бөгөөд тухайн орон нутгийн худалдаачид ханган нийлүүлдэг гэж мэдээлсэн.

**Хүдэр.** Улаанбаатар хотоос судалгаанд оролцогчид хүдрийн эд эрхтнээр бэлтгэсэн бүтээгдэхүүнийг (төмсөг, сав) нийслэлд хэрэглэдэг, гэхдээ тийм ч түгээмэл биш байдаг гэжээ. Эдгээр бүтээгдэхүүнийг өвчлөлөөс сэргийлэх, дархлааны системийг сайжруулах зорилгоор хэрэглэхээс гадна мэдрэлийн өвчин, саажилт, үрэвслийг анагаахад хэрэглэдэг гэж үздэг аж.

Зураг 8. Гэрийн нөхцөлд бэлтгэсэн уламжлалт эмийн бүтээгдэхүүн

## Уламжлалт Монгол эмнэлгийн бүтээгдэхүүн



Тарваганы тос



Зэрлэг гахайн тос



Доргоны тос

хэмжээг тооцох гэж оролдохоос илүүтэйгээр дэлгүүрүүд өөрсдөө хамгийн их зарагддаг гэж хэлсэн зэрлэг амьтны бүтээгдэхүүнүүд дээр анхаарсан. Хамгийн их зарагддаг бүтээгдэхүүний талаар асуухад тухайн дэлгүүрүүд нийт 64 төрлийн амьтны гаралтай бүтээгдэхүүний тухай мэдээлэл өгсөн. Эдгээрээс хэд хэдэн дэлгүүр нэгээс дээш бүтээгдэхүүнийг хамгийн сайн зарагддаг гэснээс үүдэн нийт 106 дэлгүүрт 175 удаагийн ажиглалт хийлээ.

Зураг 9. Дэлгүүрүүдэд зарагдаж буй зэрлэг амьтны гаралтай хувцас, үнэт эдлэлийн зүйлс



Чоно, булга, үнэг, цаа буга, тарваганы арьсаар хийсэн дотоодын үйлдвэрийн бэлэн хувцас



Чоно, үнэг, буга, зээр, тарваганы эд эрхтнээр хийсэн гоёл, чимэглэлийн зүйлс

## Жижиглэн худалдааны зах зээл

### СУДАЛГААНЫ ТҮҮВЭР

Жижиглэн худалдааны зах зээлийн судалгааг зэрлэг амьтны эд эрхтэн, түүхий эд худалдаалж буй 106 дэлгүүрийг хамруулан хийсэн бөгөөд эдгээрийн 63 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байв. Судалгааны баг олон төрлийн дэлгүүрийг хамруулахыг зорьсны тоонд бэлэг дурсгалын зүйлс, бэлэн хувцас, эртний эдлэл, уламжлалт эмийн бүтээгдэхүүн, гэр ахуйн чимэглэл зардаг дэлгүүрүүд, загасны болон үнэт эдлэлийн дэлгүүрүүд багтсан. Зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний төрөл, тоо, борлуулалтын

Хүснэгт 21-т зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлийн салбараар нь ангилсан нэгдсэн жагсаалтыг харууллаа. Эдгээр төрөлд 1) бэлэн хувцас, гутал, 2) үнэт эдлэл, 3) хүнсний бүтээгдэхүүн, 4) эмийн бүтээгдэхүүн, 5) бэлэг, дурсгалын зүйлс, 6) шашны эд зүйлс, 7) тавилга, гоёл чимэглэлийн зүйлс багтаж байна. Зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний жагсаалт бүхий баганаас гадна дараагийн 8 багана дээр дараах мэдээллийг оруулсан:

- Тухайн бүтээгдэхүүнийг хамгийн сайн зарагддаг гэж мэдээлсэн дэлгүүрийн тоо;
- Тухайн зах зээлийн салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан ба судалгаанд хамрагдсан бүх дэлгүүрийн хувь хэмжээ;
- Жагсаалтад орсон бүтээгдэхүүн нэг бүрийн гарал үүслийн улс. Үүнийг Монгол, БНХАУ, ОХУ болон бусад улс гэж ялгасан;

- Тодорхой нэг бүтээгдэхүүнийг хамгийн сайн зарагддаг гэж мэдээлсэн бүх дэлгүүрийн хамгийн өндөр борлуулалттай сарын нэгтгэсэн дүн, жишээ нь 13 дэлгүүрийн борлуулалтын хэмжээ хамгийн өндөр байсан сард үнэгэн малгай сайн зарагдсан гэж мэдээлсэн байна. Энэ бүтээгдэхүүний нийт борлуулагдсан тоог тооцон нийлбэрийг нь тус баганад жагсаасан;
- Борлуулдаг дундаж үнэ;
- Бүх дэлгүүрийн бүтээгдэхүүн тус бүрийн борлуулалтаас сар бүр олдог хамгийн их нийлбэр орлогын тооцоо;
- Зэрлэг амьтны гаралтай бүх бүтээгдэхүүний сар тутмын борлуулалтын нийт орлогын дүнд зэх зээлийн салбар тус бүрийн эзлэх байр суурийг хувиар илэрхийлсэн дүн.

## БОРЛУУЛАЛТЫН ХЭМЖЭЭГ ТООЦОХ НЬ

Борлуулалтын хэмжээг судалгаанд оролцсон хүмүүсийн ой санамж дээр зөвхөн үндэслэн тооцож гаргасан. Нэмэлт ямар нэгэн ажиглалт хийж, мэдээ баримт цуглуулж, бүртгээгүй. Дэлгүүрүүдээс нэг сарын хугацаанд зэрлэг амьтны гаралтай тодорхой нэг бүтээгдэхүүнийг хамгийн ихдээ хэдийг борлуулсныг (нэгжээр илэрхийлсэн) асууж, нийлбэр дүнг 7 дугаар баганад оруулсан. Тухайн баганад мөн 106 оролцогчийн борлуулсан гэж мэдээлсэн бүх төрлийн бүтээгдэхүүний нийлбэр дүнг (n=1,860 бүтээгдэхүүн) харуулсан. Зарим оролцогчид тодорхой борлуулсан тоо гарган өгөх боломжгүй байсан тул энэ тохиолдолд хүснэгтэд хамаарах утга оруулаагүй (n.a.). Энэ баганад харуулсан нийт дүн нь зөвхөн түүврийн хэмжээнд хамаарах үнийн “ажиглалтаас” гарсан тоог харуулж байгаа болно. Энд гаргасан тоон мэдээлэл нь аль нэг бүтээгдэхүүний эсвэл тухайн зах зээлийн нийт борлуулалтыг тооцож гаргахад зориулагдаагүй болно.

## ҮНЭ БА БОРЛУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ

Судалгааны хүрээнд бүтээгдэхүүн нэг бүрийн болон тухайн зах зээлийн салбарын борлуулалтын нийт хэмжээг тооцохын тулд дэлгүүрүүдээс хамгийн сайн зарагддаг гэж тодорхойлсон бүтээгдэхүүнийх нь дундаж үнийг асуусан. Хэд хэдэн бүтээгдэхүүний хувьд нэгээс дээш дэлгүүр адилхан борлуулж байсан тохиолдол гарсан бөгөөд ийм нөхцөлд хийсэн ажиглалт мэдээлэлдээ үндэслэн дундаж үнийг нь тооцсон. Нийт борлуулалтын хэмжээг хялбархан мэдэх боломжгүйн улмаас үнийг дундажлан тооцох нь зарагдсан бүтээгдэхүүний тоо хэмжээний ялгаанаас бус харин зөвхөн нэг бүрийн үнээс хамаарах юм. Энэ мэдээллийг хамгийн сайн зарагддаг бүтээгдэхүүнүүдийн сар тутмын худалдааны нийт үнэ цэнийг тойм байдлаар тооцон гаргахад ашигласан.

Судалгаанд хамрагдсан дэлгүүрүүд болон энэ төрлийн зах зээлийн бүхий л салбаруудын хувьд нийт худалдааны үнэлгээ нь сард бараг 170 сая төгрөг буюу 74,000 ам.доллар болж байна. Үүнийг бүтэн жилд экстраполяци хийж тооцвол Монгол болон гадаадаас гарал үүсэлтэй бүтээгдэхүүнийг хамруулаад борлуулалтын хэмжээ нь хамгийн ихээр зарагддаг бүтээгдэхүүнүүдийн хувьд 888,000 ам.доллар гэсэн дүн гарсан.

Дээр дурдсанчлан энэхүү тоо нь дэлгүүр нэг бүрийн хамгийн ихээр зарагддаг бүтээгдэхүүнд хамааралтай бөгөөд үүнд ихэнхдээ нэг, зарим тохиолдолд хоёр төрлийн бүтээгдэхүүн багтаж байгаа юм. Ихэнх тохиолдолд судлаачид зэрлэг амьтны гаралтай илүү олон төрлийн бүтээгдэхүүн буйг олж тогтоосон бөгөөд энэ нь олж байгаа нийт орлогын хэмжээ нь хэд дахин өндөр байж болохыг харуулж байна. Одоогийн гарсан тооцоог нэлээд нэмэгдүүлж болох өөр нэгэн хүчин зүйл нь гэвэл судалгаанд хамрагдсан 106 дэлгүүр нь Улаанбаатар хотод болон 8 аймагт байрлаж байгаа юм. Үлдсэн 13 аймагт судалгаа хийгдээгүй тул ямар нэгэн тоо баримтыг энд харуулаагүй болно. Рестораны судалгаатай адилаар дэлгүүрүүдийн борлуулалтын хэмжээг экстраполяци хийж тооцох боломжгүй байсан бөгөөд энэ нь Монгол Улсын хэмжээнд зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн худалддаг дэлгүүрийн нийт тоо байхгүйтэй холбоотой юм.

## БОРЛУУЛАЛТ САЙТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

Бүхэлд нь авч үзвэл түүврийн хүрээнд хамгийн борлуулалт сайтай зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүнүүдийг худалдааны салбарт тэргүүлэх дарааллаар нь харуулбал доорх байдалтай байна:

- **Бэлэн хувцас, гутал:** Судалгаанд хамрагдсан дэлгүүрүүдийн дунд энэхүү ангилал нь хамгийн чухал байр суурийг эзэлж байна. Нийт дэлгүүрийн тал гаруй нь (54 хувь) зэрлэг амьтны арьс, үсээр үйлдвэрлэсэн бэлэн хувцас хамгийн борлуулалт сайтай бараа гэдгийг хэлж байсан. Хамгийн өндөр борлуулалттай сарын тооцоонд үндэслэвэл энэ төрлийн худалдааны салбар нь дангаараа бүх төрлийн зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн борлуулдаг салбаруудын нийт орлогын 83 хувийг бүрдүүлж байна. Зэрлэг амьтны гаралтай түүхий эдээр хийдэг бэлэн хувцсанд малгай, хүрэм, гутал багтаж байна. Бэлэн хувцасны үйлдвэрлэлд хамгийн түгээмэл ашигладаг зэрлэг амьтан нь чоно, булга, цаа буга болон дорго байна. Хоёр төрлийн бүтээгдэхүүнээс (матрын арьсан гутал, могойн арьсан гутал) бусад бүх төрлийн хувцсыг хийхэд ашиглаж буй зэрлэг амьтад нь Монгол орны нутагт тархсан зүйлүүд байна. Ихэнх тохиолдолд дэлгүүрүүд тухайн зэрлэг амьтны түүхий эдийг дотоодоос худалдан авдаг

тухай хэлж байсан. Түүнчлэн зарим дэлгүүр БНХАУ, ОХУ-аас оруулж ирсэн бүтээгдэхүүн, ялангуяа үнэг болон булганы арьсаар хийсэн хувцас нөөцөлсөн байна.

- **Үнэт эдлэл:** Хамгийн өндөр борлуулалт бүхий дараагийн салбар нь үнэт эдлэл бөгөөд судалгаанд хамрагдсан дэлгүүрүүдийн 40 хувь нь энэ чиглэлийн худалдааг чухал гэж мэдээлсэн. Энэ салбар нь зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний нийт худалдаанаас орж ирэх орлогын 8.76 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд хоёрдугаарт эрэмбэлэгдэж байна.

Дэлгүүрүүдийн мэдээлснээр бэлэн хувцаснаас ялгаатай нь энэ төрлийн бүтээгдэхүүнийг хийхэд ашиглаж буй бүхий л зэрлэг амьтны түүхий эдийг зөвхөн Монголоос худалдан авдаг байна. Ажиглалтын давтамжаас харвал хамгийн ихээр саарал чоно (соёо, шагай), дараа нь бүргэд, сар, тасын хумс сарвуу, зэрлэг гахайн соёо, баавгайн соёо, идлэг шонхорын хумс сарвуу зэрэг эд эрхтэн үнэт эдлэлийн зүйлс хийхэд ашиглагдаж байна.

- **Загас:** Рестораны судалгааны хэсэгт дурдсанчлан жижиглэн худалдааны дэлгүүрүүдийн хувьд загас нь зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн худалдааны бас нэг чухал хэсэг болох нь харагдаж байна. Судалгаанд хамрагдсан дэлгүүрүүдийн гуравны нэг хүрэхгүй хэсэг нь (28 хувь) загас борлуулж байсан. Хямд үнээр зарагддаг тул энэ чиглэлийн худалдааны нийт орлого нь зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн борлуулалтаас үүсэх нийт орлогын 2.16 хувийг бүрдүүлж байна.

Дэлгүүрүүдэд зарагдаж буй 13 зүйл загасны 8 нь Монголд барьж бэлтгэсэн зүйлүүд байна. Бусдаас илүү түлхүү зарагдаж байгаа ганц зүйл нь дотоодоос нийлүүлсэн зэвэг загас байлаа.

- **Уламжлалт эмийн бүтээгдэхүүн:** Бусад төрлийн зэрлэг амьтны бүтээгдэхүүн худалдааны салбарт их түгээмэл биш ч гэсэн нийт дэлгүүрүүдийн 16 хувь нь уламжлалт эмийн бүтээгдэхүүнийг борлуулалт хамгийн өндөртэй хэмээн мэдээлсэн. Судалгааны энэ хэсэгт уламжлалт эм, эмчилгээний судалгаанд дурдсантай ижил зарим зүйлийн амьтан болон бүтээгдэхүүний талаар тайлбарласан болно (жишээ нь баавгайн тос). Уламжлалт эм, эмчилгээний судалгаатай адилаар тухайн амьтны зүйл болон гарал үүсэл заримдаа тодорхой бус байв (зарим тохиолдолд зөвхөн “загас”, “шувуу”, “баавгай” гэх мэтээр хариулсан). Зүйлийн түвшинд тодорхойлсон амьтанд халиун буга, Алтайн хойлог болон халздай дорго орж байлаа.

Уламжлалт эм, эмчилгээний бүтээгдэхүүнүүд гол төлөв Монголоос гаралтай байсан бол хоёр дэлгүүрт хамгийн өндөр борлуулалттай гэж

бүртгэгдсэн баавгайн тосны гарал үүслийг нь “бусад” гэсэн ангилалд оруулсан.

- **Бэлэг, дурсгалын зүйл:** Нийт дэлгүүрийн 13 хувьд зарагдаж буй энэ төрлийн бүтээгдэхүүнүүд нь зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний бас нэг чухал салбар болж байна. Гэвч Монгол Улсаас гаралтай 3-4 төрлийн бүтээгдэхүүний талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй тул нийт борлуулалтын орлогод эзлэх хувийг тооцох боломжгүй байв.

Энэ төрлийн худалдааны анхаарах нэг зүйл нь “Нэн ховор”, “Ховор” жагсаалтад багтсан цоохор ирвэс болон аргаль хонь зэрэг амьтны гаралтай бүтээгдэхүүнийг ил ил худалдаалж буй явдал юм.

Сүүлчийн хоёр төрөл болох **Шашны эд зүйлс** (10 хувь) болон **Тавилга ба гоёл чимэглэлийн зүйлс** (4 хувь) нь жижиглэн худалдааны дэлгүүрүүдэд ажигласан зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн худалдааны 14 хувийг бүрдүүлж байна. Энэ төрлийн худалдаанд тогосны өднөөс бусад бүх зүйлийн амьтны түүхий эдийг дотоодод агнаж бэлтгэсэн бөгөөд үүнд чоно, үнэг, тарвага, халиун буга, цагаан зээр зэрэг амьтад багтаж байна. Бусад нилээд хэдэн зүйлийн амьтан болон тэдгээрийн эд эрхтэн худалдаалагдаж буй нь мэдэгдэж байгаа боловч эдгээрийг судлаачид тусгайлан шалгаж судлах боломжгүй байсан. Эдгээрт эгэл шар шувуу, хон хэрээ, идлэг шонхор, тарважи болон цармын бүргэд, хондон ангир зэрэг шувууны өд хамаарч байгаа юм.

## Хүснэгт 21. Зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн, тэдгээрийн гарал үүсэл, үнэ, жижиглэн худалдааны дэлгүүрүүд дэх борлуулалт<sup>400</sup>

Монгол улс, 2015

Зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний жижиглэн худалдааны дэлгүүр

Хамгийн өндөр борлуулалттай бүтээгдэхүүнүүд, эх сурвалж, үнэ, борлуулалт

n=106

Бүтээгдэхүүний ангилал	j	n <sub>i</sub>	Аль улсаас гаралтай болох	Монгол улс БНХАУ ОХУ Бусад	Бүтээгдэхүүн борлуулж байгаа дэлгүүрийн тоо	Σn <sub>i</sub> /n <sub>i</sub>	Σs <sub>i</sub> /n <sub>i</sub>	Σp <sub>i</sub> /n <sub>i</sub>	(Σs <sub>i</sub> /n <sub>i</sub> )*(Σp <sub>i</sub> /n <sub>i</sub> )	Бүтээгдэхүүнээс сард олох орлого хамгийн ихээр тооцров.		
										Монголоос гаралтай бүтээгдэхүүнээс олох сарын орлого хамгийн ихээр тооцров.	Монголоос гаралтай бүтээгдэхүүнээс олох сарын орлого хамгийн ихээр тооцров.	Монголоос гаралтай бүтээгдэхүүнээс олох сарын орлогын хувь, бүтээгдэхүүний ангилалаар, хамгийн ихээр тооцров.
										MNT	MNT	%
ГУТАЛ, ХУВЦАС	1	13				53	107,500	5,697,500		5,697,500		
	2	12				28	333,000	9,324,000		9,324,000		
	3	10				49	1,485,000	72,765,000		72,765,000		
	4	5				10	186,000	1,860,000		1,860,000		
	5	5				25	588,000	14,700,000				
	6	2				3	535,000	1,605,000				
	7	2				1	100,000	100,000				
	8	1				2	40,000	80,000				
	9	1	54%			10	200,000	2,000,000			93,956,500	82.84%
	10	1				6	30,000	180,000			180,000	
	11	1				3	30,000	90,000				
	12	1				1	1,300,000	1,300,000				
	13	1				1	1,500,000	1,500,000			1,500,000	
	14	1				1	150,000	150,000			150,000	
	15	1				1	300,000	300,000			300,000	
ҮНЭТ ЭДЛЭЛ	16	9				44	25,200	1,108,800		1,108,800		
	17	8				51	33,444	1,705,667		1,705,667		
	18	8				31	57,500	1,782,500		1,782,500		
	19	7				26	77,857	2,024,286		2,024,286		
	20	3				20	12,000	240,000				
	21	3	40%			2	174,000	348,000			348,000	
	22	2				13	125,000	1,625,000			1,625,000	
	23	1				2	250,000	500,000			500,000	
	24	1				5	120,000	600,000			600,000	
	ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН	25	7				72	14,000	1,008,000		1,008,000	
26		6				88	31,500	2,772,000				
27		3				6	12,500	75,000			75,000	
28		2				60	12,000	720,000				
29		2				60	17,000	1,020,000				
30		2				29	4,000	116,000				
31		2	28%			40	6,000	240,000			240,000	
32		1				30	6,000	180,000			180,000	
33		1				100	2,000	200,000			200,000	
34		1				200	3,000	600,000			600,000	
35		1				3	15,000	45,000			45,000	
36		1				2	44,000	88,000				
37		1				100	1,000	100,000			100,000	
ЭМЧИЛГЭЭНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН	38	5				3	17,050	51,150		51,150		
	39	2				2	14,800	29,600				
	40	2				4	13,000	52,000			52,000	
	41	2				32	2,125	68,000			68,000	
	42	1				n.a.	-	-			-	
	43	1	16%			500	2,000	1,000,000			1,000,000	
	44	1				30	600	18,000			18,000	
	45	1				10	9,000	90,000			90,000	
	46	1				1	75,000	75,000			75,000	
47	1				n.a.	5,000	-			-		
БЭЛЭГ ДҮРСГЭЛ	48	5				10	360,000	3,600,000				
	49	3				11	2,600,000	28,600,000				
	50	1				n.a.	800,000	-			-	
	51	1				1	900,000	900,000				
	52	1	13%			n.a.	60,000	-			50,000	0.04%
	53	1				n.a.	500,000	-			-	
	54	1				5	10,000	50,000			50,000	
	55	1				3	250,000	750,000				
ШАШНЫ ЭД ЗҮЙЛС	56	3				6	55,000	330,000		330,000		
	57	3				36	6,500	234,000			234,000	
	58	3	10%			6	250,000	1,500,000			1,500,000	2.24%
	59	1				2	15,000	30,000			30,000	
	60	1				3	150,000	450,000			450,000	
ТАВИЛГА ЧИМЭГЛЭЛ	61	1				1	80,000	80,000		80,000		
	62	1				6	500,000	3,000,000			3,000,000	
	63	1	4%			10	5,000	50,000			50,000	2.76%
	64	1				n.a.	250,000	-			-	
								1,860	169,707,502	113,416,902	100.00%	
									\$ 73,785.87	\$ 49,311.70		

400 Тасын хумсыг бүргэдийнх хэмээн буруу тодорхойлсон байж болно.



## Ил захууд

Албан ёсны жижиглэн худалдааны дэлгүүрүүдээс гадна зэрлэг амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн зарж борлуулдаг нийтээрээ сайн мэддэг ил захуудаар мөн очиж судалгаа авсан бөгөөд эдгээр захуудын зарим нь анхны “Зэлүүд тал” судалгааг хийсэн үеэс хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. Судалгааны түүвэр хийх газрын хамрах хүрээнд сонгосон сумдад байрлах захууд, Улаанбаатарт хотод үйл ажиллагаа явуулдаг зургаан зах (Хархорин, Нарантуул, Номин, Баянзүрх, Хүчит Шонхор, Барс) болон Улаанбаатарын ойролцоо байрлах Эмээлт, Багануур, Налайх гэсэн гурван худалдааны цэг хамрагдсан.

Зураг 10. Судалгааны явцад ил захууд дээр худалдаалагдаж байгаа нь ажиглагдсан зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүнүүд



Аюулгүй байдлыг хангах үүднээс судлаачид нь судлаач эсвэл ердийн худалдан авагчийн дүрээр ажиглалт хийгээгүй, харин тэд “нууцлаг” худалдан авагчийн дүр эсгэн эргэн тойрон явж, зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүнтэй таарсан тохиолдолд борлуулж буй үнэ болон холбогдох мэдээллийг тохиолдлын байдлаар асууж тодруулсан. Мөн дээрхийн адил аюулгүй байдлын үүднээс зөвхөн цөөн тохиолдлыг л гэрэл зургаар баримтжуулж чадсан (Зураг 10 болон Зураг 11-ийг үзнэ үү).

Ил захуудаар хийсэн ажиглалт судалгааны дүнд үндсэндээ хоёр баримт тодорхой болсон. Нэгдүгээрт

хууль сахиулах байгууллагуудын зүгээс зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн худалдаа эрхлэгчдэд тодорхой хэмжээнд шахалт үзүүлж, энэ төрлийн бүтээгдэхүүний худалдааг хар зах руу шахан гаргасан байна. Худалдаачид бүтээгдэхүүнээ огт ил ил тавьж борлуулахгүй байсан бөгөөд ихэнхдээ цөөн тооны буюу нэг эсвэл хоёр ширхэг бүтээгдэхүүнийг хар уутанд хийж нуусан байдлаар тухайн газар дээр бэлэн байлгаж, хэрэв худалдан авагч сонирхвол өөр газар илүү хэмжээгээр байгаа гэж хэлж байв. Хэд хэдэн тохиолдолд худалдаачдын зүгээс тухайн бүтээгдэхүүнийг худалдаж авахаар сонирхож буй дүрд тоглосон судлаачдыг гэртээ эсвэл захтай ойрхон өөрийн эзэмшлийн газарт очиж худалдаалж байгаа бүтээгдэхүүнээ бүхэлд нь үзэхийг урьж байсан. Үүнээс харвал нууц байдлаар худалдаалах нь хэвийн зүйл болжээ.

Хоёрдугаарт, Монгол Улс дахь зэрлэг амьтны хууль бус худалдаа нь “захиалгад суурилсан” бизнес болсон байна. Жирийн худалдан авагчийн дүр тоглож буй судлаачдаас хэдий хэмжээний бүтээгдэхүүн худалдан авах хүсэлтэй байгаа талаар нь худалдаачид дахин дахин асууж байв. Олон худалдаачдын зүгээс чоно, үнэг, булга, тарвага зэрэг амьтдыг хүссэн хэмжээгээр олж өгч чадна гэж хэлж байв. Нэг тохиолдолд судлаачид худалдаачдын нэгээс авсан утасны дугаар луу залгаж, улмаар Замын-Үүдэд байдаг нэг худалдаачинтай холбоо барьсан байна. Тус худалдаачин авахыг хүссэн тоо хэмжээгээр бусдаар агнуулан нийлүүлэх боломжтой, мөн ямар ч төрлийн арьс үсийг бэлдэж нийлүүлж чадна гэж хэлсэн байна. Энэ төрлийн эрэлтэд суурилсан захиалгаар хийгддэг худалдаа нь Улаанбаатар хотын албан ёсны жижиглэн худалдааны дэлгүүрүүдэд бас явагдаж байсан. Ингэж харилцаа холбоо тогтоосон явдал нь судалгааны багийн гишүүд зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээнд хамгийн ойр очсон тохиолдол болсон бөгөөд Гуравдугаар бүлэгт харуулсан зэрлэг амьтны хууль бус худалдааны дүр зургийг илүү өргөн хүрээнд гаргахад тус болсон.

2016 оны 9, 10 дугаар сард хийсэн судалгааны явцад ил захуудаас нийт 258 үнэ ханшийн ажиглалтын мэдээллийг бүртгэсэнээс 124 нь Улаанбаатар хотоос (48 хувь), 134 нь аймгуудаас (52 хувь) авсан мэдээлэл байна. Судалгааны хүрээнд худалдаа хийж буй онцлог газрууд, зарж буй амьтны зүйл, тэдгээрийн эд эрхтэн, үнэ ханш зэрэг мэдээ баримтыг цуглуулсан. Судалгааны мэдээнд хийсэн дүн шинжилгээнээс гадаадаас импортоор оруулж ирсэн бүх бүтээгдэхүүний (ихэвчлэн БНХАУ, ОХУ-аас орж ирсэн загас, үслэг хувцас эдлэл) болон бусад тодорхойгүй мэдээллийг хасаад зөвхөн Монгол Улсаас гаралтай бүтээгдэхүүний 122 үнийн ажиглалтыг (нийт мэдээллийн 50 орчим хувь) авч үзсэн. Дүн шинжилгээ нь түүхий эдийн мэдээнд төвлөрч хийгдсэн бөгөөд үүнээс боловсруулснаас танихад төвөгтэй өвөрмөц хэсгүүдийн ажиглалтуудыг хассан. Учир нь эдгээр ажиглалтыг аль нэг ангилалд (өөрөөр хэлбэл өвөрмөц бэлэг дурсгалын зүйл, үнэт эдлэлийн зүйлс) нэгтгэж оруулахад бэрхшээлтэй байсан юм. Иймд цөөн тооны ажиглалтад суурилсан үнийн шинжилгээ хийсэн



боловч үр дүн нь өрхийн, рестораны болон зах зээлийн бусад судалгаанаас гарсан үнийн мэдээлэлтэй ихэнх тохиолдолд тохирч байгаа тул худалдааны үнэ цэнийг тооцоход тохиромжтой гэж үзсэн юм.

Зураг 11. Улаанбаатар хотод худалдаанд тавьсан чонын арьс



Хүснэгт 22-т үнийн шинжилгээний үр дүнг харуулсан бөгөөд үүнд Улаанбаатар хотын захуудад хийсэн 48 ажиглалт, нийслэлээс гадна байрлах захуудад хийсэн 74 ажиглалтын мэдээг ашигласан. Үнийн мэдээллийг бүтээгдэхүүний төрлөөр нь нэгтгэж, дараа нь хамгийн үнэтэй бүтээгдэхүүнээс хамгийн хямд руу бууруулах байдлаар жагсаасан. Бүтээгдэхүүнийг доорх байдлаар ангилсан:

- o Бүтэн амьтан
- o Мах
- o Арьс үс
- o Бугын цусан эвэр
- o Тос
- o Бусад эд эрхтэн

Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн захуудын хооронд үнийн тодорхой зөрүү байгаа учир Улаанбаатар хот дахь дундаж үнэ, аймгууд дахь дундаж үнэ, улсын хэмжээний дундаж үнэ гэсэн гурван янзын дундаж үнээр ялган харуулсан. Улаанбаатар хот болон аймгуудын үнийг төгрөгөөр, харин улсын дунджийг ам.доллар луу хөрвүүлж харуулав.

Ихэнх тохиолдолд Улаанбаатар хот дахь үнэ нь бусад газрын үнээс нэлээд өндөр байна. Жишээ нь тарвага гэхэд аймгуудад дунджаар 37,500 төгрөгөөр зардаг бол Улаанбаатар хотод 41,500 төгрөг байна. Үнийн тархалт их байгаа тохиолдолд илүү бага үнийг ашигласан.

Хүснэгт 22. Ил захууд дээр зарагдаж буй зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн ба тэдгээрийн үнэ, 2015

Монгол улс 2015

## Ил захууд дээрх зэрлэг амьтны бүтээгдэхүүний худалдаа

### Үнийн судалгаа

Бүтээгдхүүний ангилал	Худалдах нэгж	Амьтны зүйл	Дундаж үнэ, Улаанбаатарт (төг)	п <sub>1</sub>	Дундаж үнэ, Аймгуудад (төг)	п <sub>2</sub>	Дундаж үнэ, Улсын хэмжээнд (төг)	п	Дундаж үнэ Улсын хэмжээнд ам. дол
Амьтан (бүтнээрээ)	ширхэг	Саарал чоно	175,000	(1)	195,000	(6)	193,000	(7)	\$ 84
		Алтайн хойлог			120,000	(2)	120,000	(2)	\$ 52
		Цагаан зээр	92,500	(2)	22,500	(2)	65,000	(4)	\$ 28
		Тарвага	41,500	(6)	37,500	(6)	40,000	(12)	\$ 17
		Хар сүүлтий			25,000	(1)	25,000	(1)	\$ 11
		Дорго			20,000	(1)	20,000	(1)	\$ 9
		Зээр (тодорхойгүй)			13,000	(2)	13,000	(2)	\$ 0
		Цурхай	9,000	(1)	14,250	(2)	12,800	(3)	\$ 6
		Амарын цулбуурт	7,000	(1)	13,750	(2)	11,500	(3)	\$ 5
		Буллуу цагаан мөрөг			11,250	(2)	11,250	(2)	\$ 5
		Алтайн сугас			8,000	(1)	8,000	(1)	\$ 3
		Булга			5,000	(1)	5,000	(1)	\$ 2
		Алгана			5,000	(1)	5,000	(1)	\$ 2
		Шөвгөр хоншоорт мөрөг					4,750	(2)	4,750
Шивэр хадран	1,000	(1)	4,000	(2)	3,000	(3)	\$ 1		
Тогос	1,500	(1)			1,500	(1)	\$ 1		
Мах	кг	Зэрлэг гахай			14,650	(3)	14,650	(1)	\$ 6
		Цурхай	8,000	(1)	15,000	(1)	11,500	(2)	\$ 5
		Дархадын цагаан загас	10,200	(2)			10,200	(2)	\$ 4
		Шөвгөр хоншоорт мөрөг	9,750	(3)			9,750	(3)	\$ 4
		Буллуу цагаан загас	9,500	(2)			9,500	(2)	\$ 4
		Шивэр хадран			9,000	(1)	9,000	(1)	\$ 4
		Ердийн цагаан амар	8,000	(1)			8,000	(1)	\$ 3
		Алтайн сугас			4,000	(1)	4,000	(1)	\$ 2
		Цагаан зээр			3,000	(1)	3,000	(1)	\$ 1
Арьс	ширхэг	Чонын арьс	695,000	(4)			695,000	(4)	\$ 302
		Үнэгний арьс	252,500	(4)	177,000	(5)	252,500	(9)	\$ 110
		Туулайн арьс			182,000	(3)	182,000	(3)	\$ 79
		Булганы арьс	132,000	(2)			132,000	(2)	\$ 57
		Тарваганы арьс	8,000	(1)			8,000	(1)	\$ 3
Эвэр	ширхэг	Цагаа бугын эвэр			167,000	(3)	205,000	(3)	\$ 89
		Бөхөнгийн эвэр			175,000	(1)	175,000	(2)	\$ 76
		Зээрийн эвэр	32,500	(1)	14,500	(1)	23,500	(2)	\$ 10
		Халиун бугын ясан эвэр	15,000	(1)			15,000	(1)	\$ 7
		Халиун бугын цусан эвэр			4,800	(1)	4,800	(1)	\$ 2
Тос	100 мл	Бугын тос	66,000	(1)	150,000	(1)	108,000	(2)	\$ 47
		Тарваганы тос			30,000	(1)	30,000	(1)	\$ 13
		Баавгайн тос	28,000	(1)	19,500	(1)	22,500	(2)	\$ 10
		Доргоны тос	14,000	(1)	13,300	(5)	13,500	(6)	\$ 6
		Загасны тос			12,050	(3)	12,050	(3)	\$ 5
Бусад		Чонын яс			100,000	(1)	100,000	(1)	\$ 43
		Чонын тархи			40,000	(1)	40,000	(1)	\$ 17
		Тарваганы яс	40,000	(1)			40,000	(1)	\$ 17
		Тасын хумс	40,000	(1)			40,000	(1)	\$ 17
		Зээрийн туурай (kg)			25,000	(1)	25,000	(1)	\$ 11
		Чонын шагай	50,000	(1)	25,300	(5)	22,000	(6)	\$ 10
		Тарваганы шагай	25,000	(2)	7,000	(1)	19,000	(3)	\$ 8
		Бүргэдийн толгой	15,000	(1)			15,000	(1)	\$ 7
		Шар шувууны толгой	15,000	(1)			15,000	(1)	\$ 7
		Чонын шөрмөс	15,000	(1)			15,000	(1)	\$ 7
Тогосны өд	1,750	(2)			1,750	(2)	\$ 1		
			(48)		(74)		(122)		

## Цахим худалдаа

Монгол Улсад бүртгэлтэй цахим сайтаар дамжуулан зэрлэг амьтны худалдаа хийж буй эсэхийг судлаж үзэхэд доорх хоёр төрлийн сайт илэрсэн. Үүнд:

- **Шууд худалдааны сайт** - онлайн байдлаар худалдан авах боломжтой зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүнийг үнийн хамтаар байршуулсан сайтууд;
- **Онлайн сурталчилгаа** - зөвхөн бүтээгдэхүүний нэр, үнийг байршуулан, харин эцсийн захиалга, бүтээгдэхүүний хүргэлт болон төлбөр тооцоог худалдагч болон худалдан авагч шууд хоороондоо холбогдож ярилцсаны үндсэнд оффлайн хэлбэрээр хийдэг сайтууд.

Судалгаагаар эхний төрөлд хамаарах зөвхөн ганц сайтыг ([www.emonos.mn](http://www.emonos.mn)) илрүүлсэн бөгөөд энд импортоор оруулж ирсэн байх магадлалтай цөөн тооны уламжлалт эмийн бүтээгдэхүүн байна. Монгол Улсад зэрлэг амьтны худалдааг интернет ашиглан хийж буй зонхилох хэлбэр нь онлайн сурталчилгаа бөгөөд худалдагч зөвхөн холбоо барих мэдээллээ байршуулж, улмаар жинхэнэ худалдан авалтыг оффлайн хэлбэрээр дараа нь хийдэг байна. Судалгааны баг 2016 оны 9 дүгээр сарын турш зэрлэг амьтантай холбоотой 40 зар бүхий хоёр вэб сайтыг олж тогтоосон. Эдгээрийн нэг нь төрөлжсөн зарын хамгийн том сайт болох [www.unegui.mn](http://www.unegui.mn) бол нөгөө нь дэлхий нийтэд ашигладаг нийгмийн сүлжээ болох Фейсбүүк байна.

Дараах зургуудад хамгийн түгээмэл зар гардаг таван зүйлийн амьтан болох тарвага, чоно, буга, баавгай болон доргоны төрөл бүрийн бүтээгдэхүүний үнийг ам.долларт хөрвүүлэн харуулж байна. Хамгийн үнэтэй бүтээгдэхүүн нь эдгээрийн дунд байгаагүй бол энэ нь борцгор хотонгийн хоёр ширхэг хошууг 3.5 сая төгрөг буюу 1,500 ам.доллараар худалдах зар байв.

Зөвхөн заруудад үндэслэн тухайн нэг сарын эсвэл жилийн хугацаанд хийж буй онлайн худалдааны хэмжээг тооцох боломжгүй юм. Гэхдээ доорх зургуудад ямар зүйлийн амьтан хамгийн чухал болохыг хамгийн их зарлагдаж байгаа давтамжид нь үндэслэн ерөнхийд нь харуулж байгаа юм. Эдгээр зургуудаас мөн зэрлэг амьтны ямар төрлийн бүтээгдэхүүний зар гарч байгааг харахаас гадна бусад сүлжээгээр худалдаалж байгаа ижил төрлийн бүтээгдэхүүний олж тогтоосон үнэтэй харьцуулж үзэх боломжийг олгож байна. Дөрөвдүгээр бүлэгт дурдсанчлан Монгол Улс нь зэрлэг амьтан худалдах зар сурталчилгаанд илүү чанга шийтгэл оногдуулдаг болсон бөгөөд “Нэн ховор” болон “Ховор” жагсаалтад багтсан зэрлэг амьтны хууль бус худалдаанд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хууль бусаар барьсан, агнасан аливаа амьтныг худалдах талаар зар сурталчилгаа хийсэн тохиолдолд захиргааны шийтгэл оногдуулах арга хэмжээ авч байна.

## СААРАЛ ЧОНО

Өрхийн судалгаанаас зах зээлийн судалгаа, хууль хэрэгжилтийн судалгаа хүртэлх энэ бүх хугацаанд Монгол орны саарал чоно хамгийн ихээр агнаж, худалдаалдаг амьтны нэг болох нь тодорхой харагдаж байна. Онлайн худалдаанд ч мөн ялгаагүй чоно болон чонын эд эрхтнийг худалдах зар бусад зүйлийн амьтнаас илүү их байна. Онлайнаар худалдаалж байгаа бүтээгдэхүүнүүд үнийн хувьд ч бусад төрлийн судалгаагаар тогтоосон үнэтэй ойролцоо, тийм ч хямд биш байна. Онлайнаар зарж буй бүтэн чонын үнэ 110 ам.доллар байгаа нь ил зах дээр борлуулж буй дундаж үнээс (84 ам.доллар) 24 хувиар өндөр үнэтэй байгаа бол элдэж боловсруулсан чонын арьсны (302 ам.доллар) үнээс нэлээд бага байна. Энэ нь мөн гол мэдээлэгчдээс ирүүлсэн БНХАУ дахь чонын үнээс олон дахин бага байна. Чоно нь мөн амьдаараа зарагддаг хоёр амьтны нэг (нөгөө нь халздай дорго) юм.

График 15. Онлайн худалдаагаар зарагдаж буй саарал чонын бүтээгдэхүүн ба тэдгээрийн үнэ




## ТАРВАГА

Тарвага нь онлайнаар хамгийн ихээр зарж буй бас нэг амьтан болох нь гайхах зүйл биш байлаа. Чонотой нэгэн адил судалгааны бүхий л шатанд тарвага нь чухал үүрэгтэй байсан юм. Учир нь энэ зүйл нь хамгийн ихээр агнаж, худалдаалдаг зүйлүүдийн нэг юм. Жишээ нь нэг худалдаачин ганц удаагийн зараар 300 ширхэг тарваганы шагайг нэг бүрийг нь 5 ам.доллараар зарна гэсэн байв. Өөр нэг зараар бүтэн тарвагыг 17 ам.доллараар зарна гэсэн байв. Эдгээр зар

дээр тавьсан үнэ нь зах зээлийн судалгаагаар тогтоосон дундаж үнэтэй ижил байгаа бол Улаанбаатар хотод зарагддаг дундаж үнээс ялимгүй өндөр байна. Зар сурталчилгааны тухай хуулиар агнахыг хориглосон зэрлэг амьтны “эд эрхтэн, түүхий эд”-ийг худалдах, худалдан авах тухай зар сурталчилгаа явуулахыг хориглодог бөгөөд хэрэв зөрчвөл “Зөрчлийн тухай” хуулийн дагуу захиргааны шийтгэл оногдуулдаг. Тарвага агнахыг бүрэн хориглохгүй л бол тухайн зарж буй тарваганы шагайг (түүхий эд гэсэн ангилалд багтах боломжтой) сурталчилж байгаа нь хууль бус үйлдэл эсэхийг шийдэх боломжгүй юм.

График 16. Онлайн худалдаагаар зарагдаж буй тарваганы бүтээгдэхүүн ба тэдгээрийн үнэ



## ХАЛИУН БУГА

Халиун буга нь 2005 оны судалгаагаар хамгийн ихээр агнаж буй 10 амьтны тоонд багтаж байсан бол 2015 онд ч мөн хамгийн их агнадаг зүйлүүдийн нэг байсаар байна. Судалгаанд хамрагдсан анчид хангалттай хариулт өгөөгүйн улмаас өмнөх болон энэ удаагийн судалгаагаар халиун буганы агнуур болон худалдааны хэмжээг тооцох боломж бага байсан. 2005 онд халиун буганы интернет худалдааны талаар мэдээлэл байхгүй байсан бол харин өнөө үед бусад зүйлийн ихээр агнадаг амьтдын хамт халиун бугын эд эрхтэн, түүхий эд онлайн-аар худалдаалагддаг болжээ. Зар сурталчилгааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “нэн ховор, ховор” гэсэн жагсаалтад орсон амьтны, тухайлбал бугын цусан эвэр, чив, засаа зэрэг эрхтнийг бэлтгэх, худалдах, худалдан авах тухай зар сурталчилгаа явуулахыг хориглоно” гэж тодорхой заасан байгаа нь халиун бугатай холбоотой бүх төрлийн зар нь хууль бус үйлдэл болохыг харуулж байна.

Үнийг хэмжих нэгж нь нэг стандартад ороогүй байгаа тул интернетээр худалдаалж байгаа үнийг бусад судалгааны үнэтэй харьцуулахад төвөгтэй байсан. Халиун бугын цусан эвэр 110 ам.долларын үнэтэй байсан нь цаа бугын цусан эвэрийн үнэ болох 89 ам.доллараас илүү өндөр байна.


График 17. Онлайн худалдаагаар зарагдаж буй халиун бугын бүтээгдэхүүн ба тэдгээрийн үнэ



## ХҮРЭН БААВГАЙ

Монгол орны хүрэн баавгай нь 2005 онд хамгийн ихээр агнадаг 10 амьтанд ороогүй байсан бол энэ удаагийн судалгааны интернет худалдааны судалгаагаар илэрсэн цөөн зүйлийн амьтны нэг байсан юм. 1986 онд хийсэн тоо толгойн судалгаагаар 100 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 1 баавгай буюу нийт улсын хэмжээнд 500 орчим байна гэж үнэлжээ. Аман мэдээлэл болон зарим судалгаагаар олж мэдсэн үнийн мэдээлэл нь хүрэн баавгай эрс цөөрснийг харуулж байна. Баавгайн хос савар 2005 онд 100 ам.доллараар зарагдаж байсан бол одоо байгаа зар дээрх үнэ нь 750 ам.доллар хүрсэн байна. 2005 онд нэг литр баавгайн тос 0.90 ам.доллар байсан бол одоо 60 ам.доллараар зарагдаж байна. Интернетэд байгаа энэ ганц зар нь зах зээлийг бүхэлд нь төлөөлөхгүй байж болох ч Монгол Улсын ил захууд дээр зарагдаж байгаа нэг литр баавгайн тосны дундаж үнэ болох 100 ам.доллартай ойролцоо байна. Дээрхийн аль ч тохиолдолд хүрэн баавгайн бүтээгдэхүүний үнэ нь өнгөрсөн 10 жилийн хугацаанд 60-100 дахин өссөн байгаа нь тоо толгой нь цөөрч буй гэсэн таамагтай логикийн хувьд тохирч байна.

График 18. Онлайн худалдаагаар зарагдаж буй хүрэн баавгайн бүтээгдэхүүн ба тэдгээрийн үнэ



## ХАЛЗДАЙ ДОРГО

Халздай дорго нь онлайн судалгаагаар тогтоосон зүйлүүдийн сүүлийн амьтан болж байна. Анчид болон худалдан авагчдын мэдээлсэн түгээмэл ашигладаг зүйлд багтахгүй ч гэсэн доргоноос гаралтай бүтээгдэхүүнүүд нь БНХАУ болон бусад газар эрэлт ихтэй, идэвхтэй худалдаалагддаг байна. Зах зээлийн судалгааны явцад Улаанбаатар хотод нэг дэлгүүр, аймгуудад таван дэлгүүр зөвхөн доргоны тосыг литр тутмыг нь 135,000 төгрөгөөр (58.70 ам.доллар) зарж байсныг илрүүлсэн бөгөөд энэ нь онлайнгаар борлуулж буй нэг литр нь 60 ам.доллар гэсэн үнэтэй бараг ижил байна. Зөвхөн ганц дэлгүүр доргыг бүтнээр нь 9 ам.долларын үнэтэй зарж байсан нь онлайнгаар зарж буй үнэ болох 110 ам.доллараас маш хямд байсан юм. Нэг дэлгүүрт доргоны элдсэн арьс 40 ам.долларын үнэтэй байсан бол онлайн зар дээр нэг арьсыг 22 ам.доллараар зарна гэсэн байв. Судалгааны аль ч хэсэгт амьд доргоны худалдаа тэмдэглэгдээгүй.

График 19. Онлайн худалдаагаар зарагдаж буй доргоны бүтээгдэхүүн ба тэдгээрийн үнэ



## Трофи ан агнуур

Трофи агнуурын тухай мэдээ баримт цуглуулах нь энэхүү судалгааны олж нэгтгэхэд хамгийн хэцүү мэдээлэл байлаа. Судалгааны баг нь гадаадын жуулчдад зориулан ан агнуур хийдэг, загасчлалын аялал зохион байгуулдаг мэргэшсэн аялал жуулчлалын 13 газрыг олж тогтоосон бөгөөд албан ёсны тоогоор илүү олон аялал жуулчлалын компаниуд бүртгэгджээ. Судалгааны үйл ажиллагаанд хамтран ажиллах хүсэлтийг БОАЖЯ-ны албан бичгийн хамт илгээсэн ч компаниудын дийлэнх нь судлаачидтай уулзаж ярилцахаас татгалзсан. Эцэст нь хоёр компани л судалгаанд оролцож, мэдээлэл хуваалцсан бөгөөд тэдний мэдээллийг ашиглан ямар нэгэн тооцоолол эсвэл экстраполяци хийх боломжгүй байсан. Тиймээс үр дүнг зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилгоор оруулж байна.

Дээрх хоёр компанийн эхнийх нь Улаанбаатар хотод байрладаг, зөвхөн Хөвсгөл аймагт загасчлалын аялал зохион байгуулдаг байна. Тус компанийн мэдээлснээр 2015 онд АНУ, Англи, ОХУ, Япон болон Франц улсаас 40 орчим загасчин аялагч хүлээн авч, нийтдээ 12 тул, 250 шивэр хадран, 250 зэвэг загас барьжээ. Тус компани нь гадны аялагчдын загас барих зөвшөөрлийг хариуцдаг ба зарим онлайн сайтуудад нэг тул барих зөвшөөрлийг 400 ам.доллар гэжээ.<sup>401</sup>

Хоёр дахь компани нь Баян-Өлгий аймагт байрладаг бөгөөд тус аймгийн нутаг дэвсгэрт том биетэй хөхтөн амьтны ан зохион байгуулдаг байна. Тус компани нь Испани хэлээр ярьдаг орнуудаас (Испани, Латин Америк) зочдоо хүлээн авч, аргаль, янгир, халиун буга агнуулах үйлчилгээг үзүүлдэг байна. 2015 онд тэдний хүлээн авсан зургаан анчин 6 аргаль, 2 халиун буга агнаж, харин янгир агнаж чадаагүй ажээ. Тус компани нь галт зэвсэг болон ангийн зөвшөөрөл авч өгөх (авсан квотын дагуу), чихмэл хийх, үлдсэн эд эрхтнийг нь орон нутгийн зах дээр борлуулах, трофи агнуурын олзыг экспортлох CITES-ын зөвшөөрөл авах зэрэг олон төрлийн үйлчилгээг мөн үзүүлдэг байна.

401 <http://fishmongolia.com>.

# Тохиолдлын судалгаа: Саарал чоно

” Дээр тэнгэрээс заяат  
төрсөн Бөртэ-чино, гэргий  
Монголын нууц Гуа-Маралын хамт тэнгис  
товчоо далайг гэтэлж иржээ.



” "Энэ нутгийн хаан нь юу л бол юуг барьж  
иддэг, гөрөөс болон хандгай ч барьж  
иддэг баавгай байхаа. Гэхдээ заримдаа  
чоно сүргээрээ баавгай барьчихдаг тул  
чоно л энэ нутгийн хаан нь юм даа".

Дадал сумын анчин Жүгдэрнамжил(\*)

(\*) Сэм ЛеГрисиин бичсэн чонын ан болон худалдааны талаарх тайлангаас иш татав: Гарчиг: Саарлаас ногоон руу: Чоно нь Монгол Улсад соёл болон ашиг болох нь, чоно оршин тогтнохын ач холбогдол, СИТ Дээд сургууль, 2009.

Монголчуудын өвөг дээдэс чоноос гаралтай тухай домог байдаг талаар юуны өмнө дурдах нь зүйтэй. Энэ зүйл нь чонын эрх зүйн статус, чонын экосистемд эзлэх байр суурийн тухай хүмүүсийн төсөөлөл, агнадаг учир шалтгаан болон олон янзын ашиглалтад нөлөө үзүүлдэг. Гэвч ийнхүү хүндэтгэн үздэг статус нь чоныг бүрэн хамгаалах тухайд хэрэгждэггүй, харин ч бодит байдал дээр эсрэгээрээ байна. Үнэн хэрэгтээ хүч чадалтай амьтан гэдэг үүднээс чоныг өргөн дэлгэр агнаж байна. Анхны “Зэлүүд тал” тайланд дурдсанчлан чоно агнах нь тухайн анчны хүч чадал, ур чадварыг илэрхийлдэг тул гэмдэглүүштэй үйл явдал болдог байна. 2015 оны судалгаанд хамрагдсан анчдын нэг нь нэг чоныг 5 хүртэлх хоног мөрийг мөшгиж байж агнадаг тухайгаа бахархалтайгаар ярьж байсан. Чоно

авлах нь эртнээс өнөөг хүртэл соёлын гүн гүнзгий илэрхийлэл, Монголчуудын гарал үүсэлтэй холбоотой үйлдэл байсаар иржээ.

Чоно нь махчин амьтан тул олон хүний амьжиргаанд аюул занал учруулж байдаг. Ярилцлагад хамрагдсан олон хүн ан хийхээ больсон гэж хэлж байсан ч малруу нь чоно дайрах тохиолдолд бууддаг гэдгээ хүлээн зөвшөөрч байв. Үл ижилсүүлэх судалгааны үр дүнгээс үзвэл ан хийдэггүй гэж мэдэгдсэн зарим хүмүүс бодит байдал дээр ан хийсээр байдаг байна. Ямар ч тохиолдолд энэхүү амьтныг агнаж болохгүй, агнах ёсгүй гэсэн үзэл санаа нь уламжлал, соёл төдийгүй малчдын мал сүргээ хамгаалах бодит хэрэгцээний эсрэг зүйл болох юм. Саяхныг хүртэл саарал чоно нь зөвшөөрөгдсөн улирал, хорио, агнах квот зэрэг ямар ч хязгаарлалтгүйгээр агнадаг цөөн хэдэн зүйлийн нэг байсан. Тэр ч байтугай чоно агнасан бол урамшуулдаг, төрийн зүгээс чоно устгах аяныг ивээн тэтгэдэг явдал хэвийн зүйл байжээ.

Энэ бүгдийг даван туулсны дараа ч чоно оршин тогтносоор байгаа бөгөөд хэзээ ч Монгол орны нутгаас бүрэн устаж алга болоогүй юм. Сонирхолтой нь чоно агнахыг тодорхой хэмжээнд зохицуулдаг, чоныг бүрэн устахаас сэргийлсэн байх магадлалтай нэг харилцаа бол Бөртэ чонын тухай буюу чоно Монголчуудын өвөг дээдэс болдог, байгаль эх дэлхийн нэг хэсэг гэсэн итгэл үнэмшил юм. Хуучин социализмын үед явуулж байсан чоно устгах кампанит ажил (өнөөдөр ч хэрэгжиж буй) нь үнэндээ бүрэн амжилт олж чадаагүй бөгөөд учир нь анчид чонын үүрнээс бэлтрэг суйлахдаа үргэлж нэг хоёр бэлтрэгийг заавал үүрэнд нь үлдээдэг байсан юм. 2005 онд хийсэн судалгаагаар чоны тухай түүх, уламжлал нь чоныг агнаж, ашиглах зах зээлийн хэрэгцээний эсрэг дийлж чадах эсэхийг тандан судалжээ. Энэ асуултын хариулт тодорхойгүй үлдсэн бөгөөд өнөөгийн байдлаар түүх, уламжлалаас илүүтэйгээр зах зээл нь давамгайлж байгаа мэт харагдаж байна.

## ЭРХ ЗҮЙН СТАТУС

### Олон улсын эрх зүй

Саарал чоно нь CITES-ын Хавсралт II-д багтсан амьтан. Олон улсад худалдаалахыг тус конвенцоор зөвшөөрдөг ч тухайн улсаас экспортлох зөвшөөрөл авсан байх ёстой. Хэдийгээр чонын хувьд тулгарч байгаа олон янзын аюул занал байгаа боловч ч Олон улсын байгаль хамгаалах холбооны (IUCN) Улаан дансанд “Анхааралд өртөхөөргүй” гэсэн ангилалд орсон байна.

### Дотоодын эрх зүй

2015 онд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид саарал чоныг “элбэг зүйл” гэсэн жагсаалтад бүртгэсэн байна. Тухайн хуулиар чоно агнахад ямар нэгэн зөвшөөрөл авах шаардлага тавиагүй, агнуурын зөвшөөрөгдсөн хугацаа заагаагүй, квот тогтоогоогүй байна. Түүнээс хойш нөхцөл байдал эрс өөрчлөгджээ. Тухайн элбэг амьтны жагсаалтаас чоныг хасаагүй

байгаа тул үнэндээ одоог хүртэл “элбэг” гэж үзсэн хэвээр байна. Гэхдээ одоо чоно агнахыг бүрэн хориглох, нарийн квот тогтоох зэрэг арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлдэг болсон. Сүүлийн жилүүдэд (2014-2016) Монгол Улсын хэмжээнд чоно агнах квотыг жилд 20 ширхэг байхаар тогтоож байжээ.<sup>402</sup> Түүнчлэн 2010 оноос эхлэн зарим газруудад чоно агнахыг бүрэн хориглож байсан ч улсын хэмжээнд бүрэн хориглож байгаагүй юм.<sup>403</sup>

#### Тархац, тоо толгой

Түүхэн хугацааны хувьд чоно нь хамгийн өргөн тархсан хөхтөн амьтны нэг байсан бөгөөд хойд өргөргийн 15 градусаас хойших бараг бүх газар нутагт тархаж байжээ. Өнөөдөр ч 60 гаруй улсад чоно тархан амьдарч байгаа бөгөөд бүхэлдээ ховордсон зүйл амьтны жагсаалтад багтах шалгуурыг хангахгүй байна. Гэхдээ зарим нутагт тоо толгой нь эрчимтэй цөөрч байгаа популяциуд байгаа бөгөөд зөвхөн тухайн бүс нутагтаа устаж болзошгүй гэсэн жагсаалтад орсон байна. Үүний нэг жишээ нь Альпийн нурууны Баруун-Төв хэсэгт тархсан популяци юм.

Монгол орны саарал чонын тоо толгойн талаар хийгдэж, бүтээл болгож хэвлэсэн цөөхөн судалгаа байна. 1980 онд Монгол Улсын ШУА-ийн хийсэн судалгаагаар 30,000 толгой чоно байна хэмээн үнэлжээ. Мейх болон Бойтани (Mech and Voitani) нар 2004 онд чонын тоо толгой буурч 10,000 орчим үлдсэн байх магадлалтай гэж үзсэн. 2005 онд Аляскад хийсэн судалгаагаар популяцийн нягтшилд нь үндэслэн 20,000-30,000 толгой чоно байх боломжтойг таамаглаж тооцжээ. Энэ бүхнээс үзвэл чоно нь үндсэн тархац нутгийнхаа нийт хэмжээнд тохиолдож байгаа боловч сүүлийн жилүүдэд тоо толгой нь эрс буурсан байна. 1970-аад онд Монгол биологчдын боловсруулсан тархац нутгийн газрын зураг нь маш ерөнхий тойм байдалтай байгаа бөгөөд тархац нутгийнх нь нийт хэмжээнд тоо толгойн хэмжээг нь ялгаж харуулалгүйгээр жигд тархсан байдлаар зурагласан байна. Гэвч мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар албан ёсоор зөвшөөрсөн, олон арван жилийн туршид үргэлжилсэн чоно устгах аян болон урамшуулал нь чонын тоо толгойг ихээхэн хэлбэлзэхэд нөлөөлжээ. Тоо толгой нь хэт буурсан асуудал нь цаашлаад 1976-1980 оны хооронд чоно агнахыг бүрэн хориглоход хүргэж байжээ. 2015 оны байдлаар чонын агнуур болон худалдааг хориглох чиглэлээр шинээр арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа хэдий ч чонын тоо толгой дахин буурч, чухал анхаарал хандуулах шаардлагатай хэмжээнд хүрсэн гэж үзэх шалтгаан бий болсон байна.

402 Засгийн газрын тогтоол, Дугаар. 122, 2014, Дугаар. 377, 2014, болон Дугаар. 463, 2015.

403 Жишээ болгон Хэнтий (12 сум), Дорнод (7 сум), Сүхбаатар (12 сум) гэсэн 3 аймгийн зарим сумдад 2 жилийн хугацаанд чоно агнахыг хориглосон Байгаль орчны яамны 2009 оны 411 дүгээр тушаалыг үзнэ үү. Энэхүү хорио нь хоёр жил хэрэгжиж, улмаар 2012 онд Байгаль орчны яамны А-06 тоот тушаалаар дахин хоёр жилээр сунгагдсан.

Эдгээр тоо толгойн үнэлгээтэй хүмүүс санал нийлэхгүй байгаа нь зарим газар нутагт чонын тоо толгой өссөн нь идэш тэжээл болох амьтдынх нь тоо толгой буурахад нөлөөлсөн гэж үздэг олон нийтийн дунд тогтсон ойлголттой холбоотой юм. Үүний нэг жишээ нь Говь Гурван Сайханы байгалийн цогцолборт газар чоноос болж янгирын популяци буурсан гэж ярьдаг явдал юм.<sup>404</sup> Энэ үзэл бодол нь 2005 онд мөн байсан ба энэ үед чонын худалдааны түвшинг нарийн хэмжих боломжгүй байсан хэдий ч мэдэгдэхүйц өндөр байсан юм. Чонын идэш тэжээл болдог амьтны тоо толгой буурч байгаа эсвэл чонын идэш тэжээлээ өөрчилдөг зан төрх нь чонын популяци эрүүл, өсөж байгааг харуулж байна гэх мэт ард иргэдийн өнгөц ажиглалтад суурилсан дүгнэлт нь Монгол орон дахь чонын тоо толгойн хэмжээг тогтоох судалгааны баримт мэдээтэй байнга зөрчилдөж байгаа юм.

Дээрх янз бүрийн үзэл бодлыг баталгаажуулах судалгаа хийлгүйгээр зөвхөн тоо толгой нь өсөж байна гэсэн хувь хүмүүсийн бодолд итгэж чоныг агнасаар байгаа бөгөөд тэр ч байтугай тусгай хамгаалалттай газар нутагт ч чоно агнаж байна. Жишээ нь Өмнөговь аймагт орших орон нутгийн тусгай хамгаалалттай газрын захиргааны зүгээс аргаль, янгирын тоог нэмэгдүүлэх зорилгоор чоно агнахаар төлөвлөж байсан. Өөр нэг аймгийн засаг дарга орон нутагтаа чоно агнах кампанит ажил зарлаж байжээ. Бас нэгэн тохиолдолд УИХ-ын нэг гишүүн өөрийн нэрэмжит чонын ав хүртэл зохион байгуулсан байна.

## АГНУУР

### Ан агнуурын түүх

Анхны “Зэлүүд тал” тайлангийн хүрээнд хийсэн судалгаанд дурдсанчлан Монгол Улс нь 1920 оноос хойш чонын тоо толгойг хянах зорилготой албан ёсны хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн бөгөөд албан тоогоор жилд 5,300 гаруй чоно, хамгийн ихдээ 1933 онд 18,000 чоно агнаж байсан гэж бүртгэгджээ.

2005 онд гарсан тайланд тухайн үеийн судалгаанд оролцогчид өөрсдийн агнадаг чонын тоог зөрүүтэй мэдээлж байсан учраас хичнээн тооны чоно агнагдаж байгааг нарийн үнэлж тооцох боломжгүй байсан. Гэхдээ 949 оролцогчийн 321 нь буюу нийт анчдын 40 хувь нь чоно агнадаг гэж хариулсан нь тарваганы (949 оролцогчийн 675 нь тарвага агнадаг гэж хариулсан) дараа хоёрдугаарт орох хамгийн ихээр агнадаг амьтан болохыг тогтоожээ.

### Өнөөгийн агнуурын хэмжээг тооцох нь

Хорио тавьж, квот тогтоож буйгаас үл хамааран чоно нь 2015 оны байдлаар тарваганы дараа хамгийн их хэмжээгээр агнадаг амьтны хоёрдугаарт жагсаж байна. Гэхдээ одоогийн агнаж байгаа тоо нь 2005 оны мэдээлэлтэй харьцуулахад харьцангуй бага байна.

404 Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага – Орон нутгийн байгаль хамгаалагч.

Судалгаанд оролцсон 91 анчны дөнгөж 20 гаруй хувь нь (19) чоно агнадаг гэж мэдээлсэн бөгөөд улсын хэмжээнд 44,000 анчин байна гэсэн тооцоо гарсан (үл ижилсүүлэх судалгааны үр дүнд үндэслэв). Судалгаанд хамрагдсан оролцогчдын нийт агнасан чонын тоо 47 буюу нэг анчин дунджаар 2.5 чоно агнасан байна. Энэ нь 2005 онд нийт анчдын 40 хувь нь буюу нэг анчин дунджаар 3.4 чоно агнадаг гэсэн мэдээлэлтэй ойролцоо байгаа юм. Тухайн үеийн жилийн нийт худалдааны тоо хэмжээ нэлээд зөрүүтэй харагдаж байсан учраас 2005 онд тооцсон нийт агнуурын хэмжээг асуудалтай гэж үзсэн. Гэхдээ нэг жилд 20,000-30,000 тооны чоно агнадаг гэсэн барагцаа тооцоо гарсан бөгөөд боломжит зах зээлийн үнэ цэнэ нь 7 сая ам.доллар байжээ.

2016 хийсэн судалгаанаас нийт агнуурын хэмжээг нарийн тооцон гаргах боломжид анчдын өөрийн ан агнуур хийдэг талаараа хэт их мэдээлэл өгсөн биш харин эсрэгээрээ агнуурын талаар ярилцахаас татгалзаж байснаас үүдэн тодорхой саад бэрхшээл учирсан. Ямартай ч одоогийн анчдын тархалтын тооцоо болон агнуурын хэмжээг бодит байдлаас дутуу үнэлсэн байх магадлал ихтэй. Тоо толгойн үнэлгээтэй харьцуулж үзэхэд агнуулж буй чонын тоо нь хэт өндөр байсаар байгаа харагдаж байна. Шууд өгсөн хариултаас харахад судалгаанд оролцсон анчдын 21 хувь нь чоно агнадаг гэжээ. Үүнийг улсын хэмжээнд экстраполяция хийж тооцож үзвэл нийт 21,000 орчим чонын анчин байх боломжтой байна. 2005 онд нэг анчин 3.4 чоно агнадаг байсан бол 2015 онд энэ тоо 2.5 болж 32 хувиар буурсан байна.

Хэдий ийнхүү буурсан ч тооцож гаргасан агнуурт өртөж буй чонын тоо нь агнуурын квотоос хэдэн арав дахин хэтэрсэн байгаа бөгөөд тоо толгойн нийт хэмжээтэй нь харьцуулсан ч хэт өндөр байгаа юм. 2015 онд агнасан чонын тоог улсын хэмжээнд 45,000 гэж тооцсон нь Монгол орны хэмжээнд нийт 10,000-20,000 тоо толгой чоно байгаа гэсэн тооцоотой зөрчилдөж байна. Хэдий энэ хоёр тусдаа хийсэн судалгааны аль аль нь агнуурын тоог хэтрүүлж тооцсон ч гэсэн энэ нь хичнээн тооны чоно агнаж байгаа нарийн тооцоог гаргаж өгөхгүй юм гэхэд чонын агнуур түгээмэл байгааг илтгэж байна. Энэхүү судалгаа нь мөн чонын тоо толгойн нарийвчилсан судалгаа хийж, агнуурын тоог шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох шаардлагатай байгааг онцлон харуулж байна. Одоогийн албан ёсоор тогтоож буй жилд 20 чоно агнах квотыг анчид маш ихээр, магадгүй зөвшөөрсөн хэмжээг 1,000 дахин хэтрүүлэн агнаж байх боломжтой байна.

#### Агнах арга барил, хэв маяг

Хэдийгээр чоно нь Монгол орны бүх бүс нутагт тархсан зүйл хэдий ч судалгаанд баримтжуулснаас үзвэл чоно агнуур нь орон зай болон цаг хугацааны хувьд харилцан адилгүй байгаа бөгөөд энэ нь магадгүй ангийн хорио, худалдааны боломжууд, тухайн орон нутагт чоно байдаг эсэх зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс хамааралтай байж болох юм.

Судлаачдын зүгээс чоно нь хамгийн гол ан болдогийг тогтоосон газар нутгуудад дараах аймгууд багтаж байна:

- Сэлэнгэ
- Сүхбаатар
- Дорнод
- Ховд
- Увс<sup>405</sup>

Сонирхолтой нь дээр дурдагдсан эхний гурван аймаг нь сүүлийн жилүүдэд чоно агнахыг хориглосон аймгуудын тоонд орж байна. Гэвч агнуурын хорио нь тухайн аймгуудын нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг хамарсан учраас тэдгээр газруудад хориог дагаж мөрдөж байж болох юм. Харин хорио тавигдаагүй газруудад амьдардаг бараг бүх айл чоно агнадаг гэдгээ судлаачдад хэлсэн байна. Гэвч энэ нь айл өрх бүр жил болгон чоно агнадаг гэсэн үг биш юм. 2005 оныхтой харьцуулсан нийт чоно агнуурын тооцоонд үндэслэн үзвэл энэ зүйлийн агнуурын хэмжээ буурсан мэт харагдаж байна.

Үүнийг нийт агнуурын тоо хэмжээнээс гадна ярилцлагад хамрагдсан хүмүүсийн ан хийх боломж багассан учраас зарцуулах цаг бага болсон гэж ярьж байсан явдлууд ч мөн харуулж байна. Нэг анчин хэлэхдээ 7-10 жилийн өмнө идэвхтэй ан хийдэг байсан бол одоо бугаа зөвхөн мал сүргээ хамгаалах зорилгоор ашигладаг болжээ.

## ХУДАЛДАА

Ангийн квот тогтоож, зүүн аймгуудад чоно агнахыг хориглох арга хэмжээ хэрэгжүүлж байгаагаас үл хамааран одоо ч гэсэн саарал чоныг маш их хэмжээгээр агнаж дотоод, гадаадад худалдаалж байгааг энэхүү судалгааны үр дүн дахин харуулж байна.

#### Дотоодын зах зээл

Чонын тоо буурсныг багтах популяцийн хэмжээ болон агнуурын тоог нарийн тогтоосон судалгааны тоо баримт байхгүй ч гэсэн зах зээлийн нөхцөл байдал чонын тоо бодитойгоор буурч байгааг харуулж байна. 2005 оноос хойш дотоод, гадаадын зах зээл дээрх чонын арьсны үнэ ойролцоогоор 47 орчим хувиар өссөн байна. 2005 онд хамгийн өндөр үнэтэй чонын арьс 150 ам.доллар гэж бүртгэгдэж байсан бол чанарын хувьд доод зэрэглэлийн арьс 50 ам.долларын үнэтэй байжээ. Харин 2015 оны байдлаар чонын арьсны дээд үнэ 302 ам.доллар (695,000 төгрөг) орчим байсан бол доод үнэ 87 ам.доллар (200,000 төгрөг) орчим байв. Улсын их дэлгүүрт хийсэн судалгааны үед судлаачид 157 ам.долларын (360,000 төгрөг) үнээр зарагдаж буй арьстай таарсан бөгөөд олон тоогоор худалдан авах тохиолдолд 139 ам.доллар (320,000 төгрөг) болж хямдрах боломжтой гэж байв. Өмнөговь болон Дорнод

405 Судлаачдын тайлангаас.



аймгуудад чонын арьсны үнэ ойролцоогоор 152 ам.доллар (350,000 төгрөг) байжээ.

Чонын бусад эд эрхтнийг арьснаас нь тусдаа өөр зорилгоор ашиглаж, борлуулж байна. Монгол улсын нийт хэмжээнд дотоодын зах болон дэлгүүрүүдээр чонын соёо бүхий үнэт эдлэлийн зүйлс, хүзүүний зүүлтийг хүч чадал, далдын хүчний бэлэгдэлтэй холбон худалдаалж байна.<sup>406</sup> Чонын соёоны үнэ хэмжээнээсээ хамаардаг боловч эдгээр төрлийн бүтээгдэхүүн нь дан соёотой харьцуулахад үнийн хувьд гоёл чимэглэлийнхээ төрлөөс хамаараад янз бүр байна. Чонын шагай нь мөн нэлээд эрэлттэй байдаг бөгөөд ширхэг нь 11 ам.доллар (25,000 төгрөг) орчим үнээр зарагддаг байна. Шашны болон эмчилгээний зориулалтаар чонын мах, уушги, хэл, бөөр, дэлүү, ходоод, яс зэрэг бараг бүх эд эрхтнийг нь хэрэглэж байна. Бүх эд эрхтнийг нь оруулаад нэг саарал чоно 2015 онд дотоодын зах зээл дээр 400-450 ам.долларын үнэлгээтэй байгаа нь 2005 оны үнээс 30-40 хувиар өндөр байна.<sup>407</sup>

### Олон улсын худалдаа

Чоно агнуурын гол шалтгаан нь олон улсын худалдаа болж байна. Саарал чоно нь CITES-ийн II хавсралтад хязгаарлалтгүй худалдаалдаг зүйлүүдийн ангилалд багтсан бөгөөд Монгол Улс энэ конвенцэд нэгдэн орсноос хойш саарал чонын экспортын зөвшөөрөл нь олон улсад худалдаалдаг зүйлүүдийн жагсаалтыг тэргүүлсээр иржээ (1996-2015 оны хооронд нийт 987 агнах зөвшөөрөл олгосны 290 нь экспортлох зөвшөөрөл авсан байна). Энэ нь нийт зэрлэг амьтны худалдааны зориулалтаар албан ёсоор олгосон нийт зөвшөөрлийн 29 хувийг эзэлж байгаа бөгөөд Гуравдугаар бүлэгт өгүүлсэнчлэн экспортын зөвшөөрөлд 1,904 арьс, 317 бүтэн чоно, 309 трофи агнуурт өртсөн чоно багтсан байна.

Чонын худалдааны олон улс дахь гол түнш орон 2005 оноос хойш өөрчлөгдөөгүй хэвээр байна. Олон улсын зах зээлийг БНХАУ бараг дангаараа бүрдүүлж байгаа бөгөөд ОХУ-ын хил орчимд худалдан авч буй тохиолдол бүртгэгдээгүй байна. Ярилцлагад хамрагдсан хүмүүсийн хэлж буйгаар чоно нь Цагаан сар баярын үеэр “хил дээр худалдаалдаг хамгийн ашигтай амьтан” бөгөөд Монголын цагаан сар нь Хятадын цагаан сартай ойролцоо болдог боловч давхцдаггүй байна. CITES-ын зөвшөөрөлтэй худалдаа болон албаны эх сурвалжийн зүгээс мэдээлсэн Монгол-БНХАУ-ын хил дээр ихээр худалдаалдаг талаарх баримтуудыг нийлүүлж үзвэл агнуурын квотыг огт баримталдаггүй, жил бүр 20-иос хавьгүй олон тооны чоно агнаж байгааг баталгаатай хэлж болохоор байна.

Бүхлээр нь эсвэл эд эрхтнээр нь салган худалдахаас гадна заримдаа бөөнөөр нь худалдаалж байгаагаас

406 Хэдий тухайн соёоны зарим нь нохойных байж болох магадлал бага боловч дэлгүүрийн эздийн хэлсэн үнэлгээнээс харахад ихэнх соёог чонын хэмээн үзэж болох юм.

407 Зэлүүд тал I: “Монгол Улсад нэг саарал чонын зах зээлийн үнэлгээ нь 300-350 ам.доллар хүрч байна.”

үзвэл чонын худалдаа нь зүгээр нэг энгийн худалдаа биш харин эрчимтэй хөгжиж байгаа зах зээл болохыг харуулж байна. БНХАУ-ын хилийн дагууд ярилцлагад хамрагдсан хүмүүсийн хэлснээр нэг чонын тогтсон үнэ нь 295 ам.доллар (2,000 юань буюу 678,500 төгрөг) байдаг байна. Зарим хүмүүс “хэрэв хилээр нэвтрүүлж чадвал хамаагүй өндөр үнээр худалдах боломжтой” гэж хэлж байсан нь чонын худалдааны зэх зээл илт өсөлттэй байгаагийн илрэл юм. Нэг тохиолдолд бүтэн чоно 15-20 мянган юань (2,215-2,954 ам.доллар) хүрч үнэлэгдэж байжээ. Өндөр чанартай арьс илүү тогтмол үнэтэй байдаг буюу 1,500 юань (221 ам.доллар) хүрдэг бол шагай 300 юань (44 ам.доллар) хүрч байна.

### Хуулийн хэрэгжилт

Монгол Улс дотооддоо хуулийн хэрэгжилтийг сайжруулах боломжтой. Чонын арьс, шагай болон соёо зэргийг үндсэндээ бараг бүх дэлгүүрт чөлөөтэй худалдаалж байна. Зөвхөн Улсын их дэлгүүрт ажигласан тоо л гэхэд чоно агнуурын жилийн квот болох 20 гэсэн тооноос хавьгүй илүү хэтэрсэн байна. 2016 онд судлаачид Улсын их дэлгүүрт авсан зурагны татаж ойртуулсан хувилбарыг Фото 5-д харуулав. Эх зураг дээр 15 гаруй чонын арьс харагдаж байгаа бөгөөд энэ нь лангуун дээр тавьсан нийт арьсны зөвхөн багахан хэсэг нь юм. Дэлгүүрийн худалдагч нар эхлээд албан бус асуултуудад болгоомжтойгоор хариулж байсан ч удалгүй чонын арьсыг хүссэн тоогоор нь олж өгөх боломжтой тухайгаа хэлж байв.

Анчдын зүгээс ямар нэгэн мэдээлэл өгөхөөс цааргалж байсантай харьцуулахад энэ төрлийн худалдаа нээлттэй хийгдэж байгаа явдалаас харвал хуулийн хэрэгжилт нь худалдааны сүлжээний нөөц олзворлох шат болох чоно агнаж буй үйл явцад илүү анхаарал хандуулж байгаа нь тодорхой болж байна. Худалдааны сүлжээний бусад хэсгийг (тээвэрлэх, хадгалах, борлуулах гэх мэт) тусгайлан хамруулах зорилгоор хуулинд нэмэлт сайжруулалт хийсэн боловч ийнхүү чөлөөтэй худалдаалж байгаа явдал нь хуулийн хэрэгжилт дотоодын зах зээлд хангалтгүй байгааг харуулж байна.

Гэхдээ улсын хил дээр хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа тодорхой түвшинд явагдаж байгаа нь илт байна. Үүний нэг жишээ нь 140 гаруй чоныг 2016 оны 2 дугаар сард Монгол Улсын хилийн ойролцоо хураан авсан бөгөөд БНХАУ-д чоныг ихэнхдээ бүтнээр эсвэл хөлдөөсөн байдлаар бэлэгт зориулан худалдаж авдаг байна.<sup>408</sup> Энэ нь Монгол улсын хэмжээнд нэг жилд тогтоодог агнуурын квотоос 7 дахин их байгаа юм. Гааль болон Цагдаагийн газраас гаргасан тоо баримтаас харахад чоно нь олон жилийн турш хамгийн ихээр хураагдаж байгаа амьтны нэг байсаар байна.

БНХАУ-ын хилийн дагуу нөхцөл байдал дээрхтэй ижил байна. Хил дээр хураагдсан гэж мэдээлсэн эд зүйлсийн бүртгэлд чонотой холбоотой доорх зүйлс

408 БНХАУ-ын цагдаагийн ажилтан хил дээр 148 чонын арьс болон гулууз хураан авчээ, Daily Mail UK.

багтсан байна:

- 30-40 чонын арьс
- 300 чонын шагай (150 чоно)
- 200-300 хөлдөөсөн гулууз (Байтаг боомт дээр хураагдсан)

Өөрөөр хэлбэл хил дээр зөвхөн гурван удаагийн үйлдлээр хураагдсан (Монгол Улсын гаалиар саадгүй өнгөрч БНХАУ-руу нэвтэрсэн) чонын тоо тухайн зүйлийн агнуурын бүтэн жилийн квотоос 20 дахин өндөр байна.

Зах зээлийн үнэ болон худалдааны түвшний аль аль нь агнуурыг бууруулж, эрэлтийг багасгах нь хүндрэл бэрхшээлтэй асуудал болохыг харуулж байна. Чонын жижиг хэмжээний эд эрхтэн, бүтээгдэхүүнийг нууж далдлан, хууль бусаар хилээр нэвтрүүлэх нь хялбархан зүйл мэт харагдаж байна. Жишээ нь чонын соёог хогны хар уутанд хийн нууж асуудалгүй хил нэвтрэх боломжтой юм. Автомашин дугуй болон чоно багтах том зайтай хэсгүүдэд бүтэн чоно нуун хилээр гаргах гэж байгаад баригдсан тохиолдол гарч байсан байна.

## Тохиолдлын судалгаа: Тарвага



*‘Сүхбаатар аймагт тухайн орон нутагт агнаж, бэлтгэсэн тарваганы арьсаар төрөл бүрийн эд зүйлс хийх явдал маш их хэмжээгээр буурсан. Одоо бид Улаанбаатар хотоос үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүн авчирч зардаг болсон.’*

Анхны “Зэлүүд тал” тайланд хэд хэдэн шалтгааны улмаас тарваганы талаарх тохиолдлын (кейс) судалгааг өргөн хүрээнд авч үзсэн бөгөөд үүний гол шалтгаан нь энэ амьтан тухайн үед Монгол Улс дахь зэрлэг амьтны агнуур болон худалдааны цөм хэсгийг бүрдүүлж байсан юм. Хэдийгээр агнуур болон худалдааны хэмжээ нь одоо буурсан харагдаж байгаа ч тарвагыг өнөөг хүртэл ихээр агнасаар байгаа бөгөөд агнуурт өртөж буй тоо хэмжээ нь энэ зүйлд үргэлжлүүлэн анхаарал хандуулах шаардлагатайг илтгэж байна. Энэхүү кейс судалгаанд анхны тайланд багтсан зарим мэдээллийг давтаж байгаа бөгөөд эдгээр нь өнөөг хүртэл хүчин төгөлдөр байгаа юм.

Монгол оронд тархан амьдардаг тарваганы хоёр зүйл болох Алтайн тарвага (*M. baibacina*) болон Монгол тарвага (*M. sibirica*) нь уламжлалт уургийн эх үүсвэр, эмчилгээ, арьс үсний хэрэгцээ болдог бөгөөд жил тутмын тарваганы арьсны худалдаа 1800-аад оноос хойш дунджаар 1.2 саяд хүрч байжээ. Нийт агнуурын хэмжээг 1999 онд 1-1.5 сая, анхны “Зэлүүд тал” судалгаагаар 2004 онд 3 сая гаруй, харин энэ судалгаагаар 2015 онд 850,000 орчим гэж тооцсон байна.

Дээрх хоёр зүйлээс хамгийн түгээмэл нь Монгол тарвага бөгөөд дорнын талаас эхлээд баруун талд

Алтайн нуруу хүртэлх Монгол орны өргөн уудам тал хээр нутагт тархан амьдардаг. Харин Алтайн тарваганы тархац нутаг нь Алтайгаас баруун тийш орших ба энэ бүс нутаг 2005 болон 2015 онуудын судалгаанд зөвхөн хэсэгчилсэн байдлаар хамрагдсан. Тиймээс энэ зүйлийн судалгаанаас гарсан үр дүн нь Монгол тарвагатай харьцуулбал харьцангуй цөөн тооны ажиглалтад суурилсан юм. Гэсэн хэдий ч Алтайн тарвага нь хамгийн ихээр агнадаг амьтдын нэг байсаар байгаа бөгөөд Монгол тарваганы талаар ярьсан олон асуудлууд Алтайн тарваганд мөн хамаатай байх магадлалтай юм.

## ЭРХ ЗҮЙН СТАТУС

### Олон улсын эрх зүй

2005 оны байдлаар Алтайн болон Монгол тарваганы хамгааллын асуудлыг олон улсын, олон талт эсвэл хоёр талт ямар нэгэн гэрээ хэлэлцээрээр зохицуулаагүй байсан. Олон улсын байгаль хамгаалах холбооны (IUCN) Улаан дансанд (1996) энэ хоёр зүйлийг “эрсдэл багатай/Анхааралд өртөхөөргүй” гэсэн ангилалд оруулсан байсан. Түүнээс хойш Монгол тарвага нь өнгөрсөн гурван үеийн туршид хэт их агнуурт өртсөний улмаас тоо толгой нь 50-иас дээш хувиар буурсныг илтгэх баримтад үндэслэн “Устаж болзошгүй” гэсэн ангилалд оруулжээ. Харин Алтайн тарвага нь одоог хүртэл “Анхааралд өртөхөөргүй” гэсэн ангилалдаа байгаа бөгөөд тоо толгойн чиг хандлага нь тодорхойгүй хэвээр байна.

### Дотоодын эрх зүй

2005 оноос өмнө Монгол Улсын “Ан агнуурын тухай” хуулиар 8 дугаар сарын 10-наас 10 дугаар сарын 16-ныг хүртэл Алтайн болон Монгол тарвага агнахыг зөвшөөрдөг байв. Анчин бүр гурав хүртэл тооны тарвага агнахыг тус хуулиар зөвшөөрч байжээ. 1999 оноос хойш, ялангуяа 2005 оноос эхлэн тарвага агнах удаа дараагийн хорио тогтоож, бусад хууль журмын зохицуулалтын арга хэмжээ авч байсны зарим жишээг доор дурдав:

- 2005-2008 – улсын хэмжээнд хориглосон
- 2010-2011 – улсын хэмжээнд хориглосон<sup>409</sup>
- 2012-2013 – улсын хэмжээнд хориглосон<sup>410</sup>

### Тархац, тоо толгой

Монгол тарвага нь далайн түвшнээс дээш 600-3,000 метрийн өндөрлөг бүхий Монгол орны хээр тал, өндөр уулын тагийн нуга, ойн зах хэсгээр тархан амьдардаг (Новак 1999). Түүхэн хугацаанд авч үзвэл Монгол тарвага нь Монгол орны хойд хэсгийн ой тайгын

бүсийн өмнөд захаас эхлэн хээрийн бүсээр дайран говь цөлийн бүс хүртэл, зүүн талд Нөмрөгийн уулсын бэлээс эхлээд баруун тийш Алтайн нуруу хүртэлх өргөн уудам газар нутагт тархдаг байжээ.<sup>411</sup> Харин Алтайн тарвага нь өндөр уулын тагийн нуга бүхий орчинд амьдардаг бөгөөд Монгол Алтайн нурууны хойд хэсэг, үүнтэй залгаа орших Сибирийн баруун өмнөд хэсэг, Казахстаны зүүн хэсэг, Киргизстан болон Шиньжаны уулсаар тархдаг байна.<sup>412</sup>

Сүүлийн үеийн судалгааны тайлан болон аман мэдээллээр тухайн хоёр зүйл нь өмнө нь маш элбэг байсан олон газар нутагт устаж алга болсныг харуулж байгаа юм. 1970-аад оны үед тарваганы тархац нутаг нь Монгол орны газар нутгийн ойролцоогоор 68 хувь буюу 1.07 сая километр квадрат талбай бүхий нутгийг хамарч байжээ. 2002 онд зүүн бүсэд хийсэн судалгаагаар тус бүс нутгийн хэмжээнд Монгол тарваганы тархац ихээхэн хумигдсан болохыг тооцоолж гаргасан<sup>413</sup> бөгөөд нийт нүхний 5 хувь нь л идэвхтэй байснаас үзвэл Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн газар нутгийн хэмжээнд 159,000 орчим тарвага үлдсэн байх боломжтой байна.<sup>414</sup> 2007-2009<sup>415</sup> онуудад хийсэн судалгаагаар Монгол орны тарваганы нийт тоо толгойг 8 сая хэмээн үнэлсний 88 хувь (7 сая) нь Монгол тарвага, үлдэх 12 хувь (930,000) нь Алтайн тарвага байна гэсэн үр дүн гарчээ. Тус тайланд дурдсанаар Монгол орны байгаль хамгийн тааламжтай нөхцөл дор 8 сая гэж тооцож гаргасан тооноос гурав дахин олон тарвагыг (21 сая) тэтгэх боломжтой байна.<sup>416</sup>

Энэ хоёр зүйлийн тарваганы тоо толгой буурахад нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйл нь ан агнуур гэж үзэж байгаа бөгөөд үүнд нийт агнуурт өртөж байгаа тоо хэмжээний шууд нөлөөлөл болон агнаж байгаа арга барил, цаг улирлаас хамааралтай хоёрдогч нөлөөллүүд багтаж байна.

## АГНУУР

### Ан агнуурын түүх

1920-иод оноос 1991 он хүртэл зөвхөн ОХУ-руу экспортод гаргаж байсан бол 2005 оны судалгаагаар тарваганы арьсны худалдааны урсгал БНХАУ-руу голлон чиглэж, багахан хувь нь ОХУ-руу худалдаалагдаж байгааг баримтаар тогтоожээ. Ан агнуурын тоог албан ёсоор бүртгэж эхэлснээс хойш жилд 2 саяас дээш тооны тарвага агнаж байсан хэд хэдэн тохиолдол (1906-1910, 1927, 1929, болон 1946-1954) бүртгэгдэж байсан бөгөөд хамгийн ихдээ 1910 онд 3.2 сая тарвага агнаж байжээ. Дорнод талын

411 Адьа, 2000.

412 Новак 1999; Adiya 2000.

413 Батболд 2002.

414 Townsend S.E. & Zahler P. 2006. Marmots in the Eastern Steppe: Evidence of a severe decline. *Mongolian Journal of Biological Sciences* 4: 37-44.

415 Y. Adiya and O. Brandler (2011). Status of Marmot Populations in Mongolia, *Steppe Bulletin*, No. 31, Winter 2011.

416 Монгол орны хөхтөн амьтны улаан данс.

409 Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Сайдын 411 дүгээр тушаал, 2009 оны 12 дугаар сар.

410 Монгол Улсын Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Сайдын Тушаал Агнуурын Зарим Амьтныг Агнах Барихыг Хориглох, Ан Амьтны Хууль Бус Агналт, Ашиглалтад Тавих Хяналтыг Чангатгах Тухай, А-06, 2012.

биологийн олон янз байдлын төсөл 1999 онд нийт агнуурын хэмжээг жилд 1-1.5 сая гэж тооцжээ.

Анхны “Зэлүүд тал” судалгаагаар 2004 оны агнуурын хэмжээг 3-4 сая гэж тооцсон бөгөөд нэг анчин жилд дунджаар 54 Монгол тарвага, 46 Алтайн тарвага агнадаг гэсэн тооцоо гарчээ.

### Өнөөгийн агнуурын хэмжээг тооцох нь

Тухайн нэг зүйлийг тусгайлан агнадаг анчдын тоог харахад Монгол тарвага нь Монгол Улсад агнаж буй хөхтөн амьтны дундаас хамгийн олон тоогоор агнаж буй амьтан байсаар байна. 2005 онд судалгаанд хамрагдсан анчдын 60 хувь нь (n=675 анчин) нь тарвага агнадаг хэмээн хариулсан байна. Харин 2015 онд хийсэн зэрлэг амьтны худалдааны судалгаанд оролцсон анчдын (n=91) 44 нь буюу 49 хувь нь тарвага агнадаг гэсэн байна. Шууд өгсөн хариултад зөвхөн үндэслэн тооцвол улсын хэмжээнд хамгийн багадаа 21,000 хүн тарвага агнадаг гэсэн үг юм. Үл ижилсүүлэх судалгааны үр дүнг ашиглан тооцвол Монгол Улсын хэмжээнд нийт 120,000 орчим тарвага агнадаг хүн байх боломжтой юм. Энэ нь тарвага агнадаг хүний тоо өмнөхөөс 13 хувиар буурсныг харуулж байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан амьтад дотроос анчдын тоо нь хамгийн бага буурсан амьтан болж байгаа юм. Бусад бүх зүйлийн амьтны хувьд тооцоолсон идэвхтэй анчдын тоо нь 23 хувиас (хярс) 87 хувь (үнэг) хүртэл буурчээ.

Бусад мэдээллийг оруулж тооцохгүйгээр судалгаанд оролцогчдын мэдээлсэн нийт агнасан амьтны тоо нь 309 байсан бөгөөд энэ нь дунджаар нэг анчин 7 Монгол тарвага, 10 Алтайн тарвага агнасан байна гэсэн үг. Хүн тус бүрийн агнаж буй тарваганы тоо нь 2005 онд тооцоолж гаргасан дүнтэй харьцуулахад нэлээд их буурсан (70-80 хувь) бөгөөд 2005 онд нэг анчин дунджаар 24 Монгол тарвага, 47 Алтайн тарвага агнадаг байжээ. Нэг хүнд ноогдох энэхүү агнуурын тооноос харвал тухайн хоёр зүйлийн тарвага хамгийн ихээр зорьж агнадаг хөхтөн амьтдын нэг болон гуравдугаарт жагсаж байна. Нийт агнуурын тоо хэмжээний хувьд нөхцөл байдал 2005 оныхтой ижил байгаа бөгөөд агнуурт өртөж буй Монгол тарваганы нийт тоо нь 850,000 (үл ижилсүүлэх судалгааны үр дүнг ашигласан), Алтайн тарваганых 82,000 гэж үнэлэгдсэн нь хамгийн ихээр агнадаг амьтны нэг болон дөрөвдүгээрт тус бүр жагсаж байна (Хуудас 11, Хүснэгт 5-г үзнэ үү).

Ийнхүү огцом буурсан үзүүлэлт нь арван жилийн өмнө хэдэн арван мянгаараа хураагдаж байсантай харьцуулбал одоо хэдэн зуугаар хураагдаж байгаа мэдээ баримттай тохирч байгаа юм. Жишээ нь 2003 онд БНХАУ-руу гаргахаар завдсан хоёр удаагийн тохиолдлоор 37,000 гаруй тарваганы арьс хурааж байжээ. 2005 онд гэхэд холбогдох хууль хяналтын байцаагчид 8 дугаар сарын эцсийн байдлаар 26,000 арьс хураан авсан байсан нь тарвага ичээнээсээ гараад хэдхэн сар болж байсан, зөвшөөрсөн ангийн хугацаа эхлэхээс бүтэн нэг сарын өмнө болсон хэрэг явдал

байв. Өнгөрсөн хэдэн жилийн хугацаанд хураасан тарваганы арьсны тоо нь өмнө нь хурааж байсан тооны багахан хувьтай тэнцүү байна. Жишээ нь ЦЕГ-ын Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэсээс бүтэн жилийн хугацаанд 1,152 (2013 он) болон 5,181 (2014 он) ширхэг тарвага хураан авсан гэж мэдээлжээ. Гаалийн албаны зүгээс ч 2014-2016 онуудад мөн цөөн тооны арьс хураан авсан талаар мэдээлж байснаас нэг удаад 74 арьс хураан авч, эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байжээ.

### Агнуурын улирал

Амьтны тухай хуулиар Монгол болон Алтайн тарвагыг зуны сүүлээс эхлэн намар дуустал хугацаанд агнахыг зөвшөөрдөг. Ярилцлагад оролцсон анчдын өгсөн мэдээллээр аль ч зүйлийг нь өвлөөс бусад улирлын турш агнадаг байна. Монгол тарвагыг хавар, зун, намар агнадаг бол Алтайн тарвагыг зун, намар болон өвлийн эхэн үе буюу ичээндээ орохынх нь өмнө агнадаг гэсэн мэдээлэл нь тарвагыг зөвхөн арьсыг нь худалдаалах зорилгоор (хаврын агнуурыг илэрхийлнэ) биш мөн хоол хүнс, эмчилгээний зориулалтаар агнаж хэрэглэдэг болохыг харуулж байна.

Анхны “Зэлүүд тал” тайланд зарим анчдын зүгээс тарваганы үс нь илүү шигүү, сор сайтай байдаг тул хавар эрт агнаж, зарах нь илүү ашигтай байдаг гэж дурдаж байжээ. Үүнийг 2005 оны болон энэ удаагийн судалгааны алинд нь ч тусгайлан баталгаажуулаагүй. Гэхдээ бусад улиралтай харьцуулахад тарвага хаврын улиралд нүхнээсээ гарч илүү удаан хугацаанд идээшилдэг тул агнахад хялбар байдаг нь тодорхой юм.

### ХУДАЛДАА

2005 онд агнуурын хорио тавьсан ч энэ амьтны худалдааг бүрэн зогсоож чадаагүй л байна. Анчид ч зөвшөөрөл авалгүйгээр тарвагыг үргэлжлүүлэн агнаж, худалдаалж байгаа нь илт байна. Агнуур болон худалдааны хэмжээ ихээхэн буурсан харагдаж байгаа нь дан ганц хуулийн хэрэгжилт сайжирснаас болоогүй байх магадлалтай юм. Тарваганы худалдаа буурсан ч гэсэн одоог хүртэл нэлээд түгээмэл байгаа бөгөөд судлаачдын зүгээс ямар нэгэн хүчин чармайлт гаргалгүйгээр хялбархан олж тогтоох боломжтой байв. Жишээ нь судлаачид Улсын их дэлгүүрийн өмнөх талбай мэт газруудад тарвага зарж буйтай тааралдсан тохиолдол гарчээ. Худалдаа буурсан тухай илүү бодитой тайлбар гэвэл тарваганы тоо толгой маш их хэмжээгээр буурсан бөгөөд албан ёсны тоо баримт болон аман мэдээллээс үзвэл 10-20 жилийн өмнө тарвага байсан олон газар бүр мөсөн устаж үгүй болсонтой холбоотой юм.

### Дотоодын зах зээл

Дотоодын зах зээлийн талаар хийсэн судалгааны үр дүн нь хуулийн хэрэгжилтийн орчин сайжирсан болоод тарваганы нөөц багассаар байгааг ил тод гэрчилж байна. 2005 оны судалгааны үр дүнгээс харвал 15-аас дээш насны иргэдийн 30 орчим хувь нь (n=445,000, 2005 он) тарваганы гаралтай ямар нэгэн

бүтээгдэхүүнийг тогтмол хэрэглэдэг гэжээ. Ихэнх хүмүүс гол төлөв махыг нь идэх зорилгоор (85 хувь, 370,000 хүн) ашигладаг бол тарваганы тос (5 хувь), бөөр (3 хувь), уушги болон ходоодыг (тус бүр 1 хувь) эмчилгээний зориулалтаар хэрэглэдэг гэсэн байна. Эдгээр бүтээгдэхүүний ихэнхийг өөрсдөө шууд агнах эсвэл дотоодын захаас зээлээс худалдан авдаг байна. Дөнгөж 25 хувь (110,000) нь ан хийдэг найз нөхөд, хамаатан саднаасаа авдаг гэжээ. Дунджаар авч үзвэл хэрэглэгчид жилд 25 ам.долларыг тарваганы гаралтай бүтээгдэхүүнд зарцуулж байсан бөгөөд дотоод худалдааны жилийн үнэлгээг нь 4 сая ам.доллар гэж тооцжээ.

2015 оны судалгаанд оролцогчдын мэдээлснээр хэрэглээнд бараг өөрчлөлт гараагүй ч борлуулалтын хэмжээ нь 2005 онд 25 хувь байснаас 2015 онд 4 хувь болж буурчээ. Магадгүй энэхүү ажиглагдсан борлуулалтын бууралт нь зарим судалгаанд оролцогчдын зүгээс үнэн зөв хариулт өгөхөөс цааргалж байсантай холбоотой байж болно. Үүнээс гадна борлуулалт ийнхүү буурсны нэг шалтгаан нь тарваганы нөөц бодитойгоор багассантай холбоотой юм.

Бүх зүйлийн амьтантай адилаар онлайн худалдаа болон худалдан авсан тухай судалгааны мэдээлэл зэрэг бусад төрлийн худалдааны эх сурвалж нь нөхцөл байдал өөр байгааг харуулж байна. Жишээ нь, тарвага онлайн худалдаанд хамгийн түгээмэл сурталчлан борлуулж буй амьтны нэг байна. Нэгэн тохиолдолд борлуулагч нэг удаагийн зараар тарваганы 300 шагайг нэг бүрийг нь 5 ам.доллараар (11,500 төгрөг) худалдана гэсэн байв. Онлайнар сурталчилж байсан өөр нэгэн бүтээгдэхүүн нь 17 ам.долларын (39,100 төгрөг) үнэтэй бүтэн тарвага байв. Бүтэн тарваганы үнэ зах зээлийн судалгаагаар зарим газруудад (Хэнтий, Дорнод) ажигласан дундаж үнэтэй ижил байсан бол Улаанбаатар хотод ажиглагдсан дундаж үнээс (34,940 төгрөг) арай өндөр байлаа. Зар сурталчилгааны тухай хуулиар агнахыг хориглосон зэрлэг амьтны “эд эрхтэн, түүхий эд”-ийг худалдах, худалдан авах тухай зар сурталчилгаа явуулахыг хориглодог бөгөөд хэрэв зөрчвөл “Зөрчлийн тухай” хуулийн дагуу захиргааны шийтгэл оногдуулдаг. Тарвага агнахыг бүр мөсөн хориглохгүй л бол тухайн зарж борлуулж буй шагай болон бүтэн тарвагыг (түүхий эд гэсэн ангилалд багтах боломжтой) сурталчилж байгаа нь хууль бус үйлдэл болохыг мэдэх боломжгүй юм.

Монгол тарваганы хувьд судалгааны явцад нийт улсын хэмжээнд 653 удаагийн үнийн ажиглалт хийсэн бөгөөд нэг тарваганы дундаж үнэ нь 32,000 төгрөг орчим (14 ам.доллар) байсан бол хамгийн доод үнэ нь 7,000 төгрөг, дээд үнэ нь 70,000 төгрөг байв. Үнийн хэлбэлзэл ийм өндөр байгаа нь хэд хэдэн хүчин зүйлстэй холбоотой байна. Үүнд:

- i) улирлын шинж чанар,
- ii) тухайн амьтны биеийн жин,

- iii) мах нь түүхий эсвэл бэлтгэн борлуулж буй эсэх,
- iv) тухайн худалдаанд оролцож буй дундын зуучлагчдын тоо,
- v) байршил.

Хүснэгт 23-г зах зээлийн судалгаанд хамрагдсан 13 аймаг, Улаанбаатарт хийсэн үнийн ажиглалтыг газар тус бүрээр ялган харуулсан. Эдгээр ажиглалтын дийлэнхийг Улаанбаатар хотод (41 хувь; n=268, нийт 653-аас) хийсэн бол дараагийн хамгийн олон ажиглалт хийсэн аймгуудад Баянхонгор (10 хувь; n=68), Өвөрхангай (9 хувь; n=62) болон Завхан (8 хувь; n=53) аймаг багтаж байна. Түүхэндээ тарваганы тоо толгой ихтэй, мөн худалдаа ч гэсэн их хэмжээнд явагддаг байсан нь хангалттай тогтоогдсон Дорнод аймагт тарвага борлуулж байгаа зөвхөн зургаан тохиолдол ажигласан. Судлаачдын үзэж буйгаар бүх хар захууд дээр, ялангуяа хотын төвийн хар зах дээр тарваганы худалдаачид байдаг байна. Судлаачид тарвага эсвэл тарваганы бүтээгдэхүүн тусгайлан борлуулдаг ямар нэгэн дэлгүүр, лангуу олж илрүүлээгүй байна.

Хүснэгт 23. Тарвага борлуулж буй нь ажиглагдсан газар нутгууд

Тарваганы худалдаа ажиглагдсан газар нутгууд		
	Борлуулсан тоо	%
Улаанбаатар	268	41%
Баянхонгор	68	10%
Өвөрхангай	62	9%
Завхан	53	8%
Говь-Алтай	47	7%
Хэнтий	40	6%
Архангай	39	6%
Ховд	27	4%
Хөвсгөл	15	2%
Дархан-Уул	13	2%
Увс	9	1%
Дорнод	6	1%
Өмнөговь	5	1%
Төв	1	0%

Сум, аймгийн төвүүд дээр ерөнхийдөө тарваганы үнэ мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. Тарваганы үнэ Хэнтий (44,375 төгрөг), Дорнод (40,000 төгрөг) аймаг болон Улаанбаатар хотод (39,940 төгрөг) хамгийн өндөр байгаа нь тарваганы нөөц хомсдсон, эрэлт ихтэй байгаа газар нутагтай давхцаж байна. Эдгээр аймаг, нийслэлээс бусад газар дундаж үнэ ойролцоогоор 25,000 төгрөг байгаа ба хамгийн багадаа 7,000 төгрөгөөс эхэлж байна. Үнийн энэ хэлбэлзэл мэдээлэгч нараас цуглуулсан чанарын мэдээтэй таарч баталгаажсан юм.

Үнэ ийнхүү нэмэгдсэн нь тарваганы нөөц хомсдож буйг хүчтэй илтгэх нэг үзүүлэлт бөгөөд хуулийн хэрэгжилт, түүнд нөлөөлсөн өөр нэг хүчин зүйл байж болно. 2005 онд тэмдэглэсэн үнэтэй ойролцоо эсвэл доогуур үнэтэй байгаа газрууд нь Монгол орны баруун хэсэгт байгаа бөгөөд энэ нь Алтайн тарвагатай холбоотой худалдаа байж болох юм. Бусад нутагт бүртгэсэн үнэ нь 10 жилийн өмнөх үнээс 200-400 хувиар өссөн байна.

Ерөнхийдөө бүс нутаг болон улирал хооронд үнийн зөрүү их байгаа нь нийт борлуулалтын үнэлгээг нарийвчлан тооцоход хүндрэл учруулж байна. Энэ судалгаанд тооцсон дундаж үнэ 30,000 гаруй төгрөг байгаа бол зарим нэг газар хамгийн багадаа 10,000 төгрөг (Увс аймаг), хамгийн ихдээ 45,000 төгрөгийн (Хэнтий аймаг) үнэтэй (Хүснэгт 24) байна. Нэг тарваганы дундаж үнэ болох 14 ам.долларыг Монгол Улсын хэмжээнд жилд нийт 15,431 тарвага агнадаг гэсэн тооцоогоор үржүүлбэл улсын хэмжээнд ойролцоогоор 216,000 ам.долларын өрхийн орлого болж байна.

#### Хүснэгт 24. Тарвага борлуулж буй нь ажиглагдсан газар нутгууд

Тарваганы махны бүс нутгийн болон улсын хэмжээний дундаж үнэ (төгрөг)		
Хэнтий	44,375	Улсын дундаж 30,795
Дорнод	40,000	
Улаанбаатар	34,940	
Дархан-Уул	30,000	
Баянхонгор	27,941	
Архангай	27,436	
Өвөрхангай	25,161	
Төв	25,000	
Завхан	23,679	
Өмнөговь	20,000	
Говь-Алтай	16,511	
Хөвсгөл	15,667	
Ховд	15,000	
Увс	10,000	

Зах зээлийн судалгаанаас гарсан бүхий л үр дүн нь тарваганы тоо толгой их хэмжээгээр буурсныг харуулж байна. Судалгааны анхан шатны үр дүнг танилцуулах уулзалтын үеэр судлаачдын зүгээс Сүхбаатар болон Дорнод аймгуудад тарвага маш ховор, тарваганы худалдаа явагдаж байвал гайхмаар зүйл болох тухай дурдаж байв. Судлаачдад Дорнод аймгийн хойд хэсэгт цөөн тооны тарвага үлдсэн ч өнөөг хүртэл идэвхтэй агнан, борлуулж буй талаар шууд мэдээлэл өгч байсан байна. Тус аймагт хийсэн судалгааны үеэр ганцхан худалдаачин Монгол тарвагыг 40,000 төгрөгийн үнээр борлуулна гэсэн тохиолдолтой таарсан нь бусад хараат бус байдлаар ажигласан үнэтэй ижил байна. Тарваганы

нөөц ховордож буйг илтгэх үүнтэй адил нэг нотолгоо нь судлаачдад Хэнтий аймгаас ирдэг гэж хэлж байгаа тарвага нь өөр бүс нутгаас ирдэг байх магадлалтай гэж мэдээлжээ. Сүхбаатар аймагт тухайн орон нутагт агнасан тарваганы арьсаар янз бүрийн зүйлс хийдэг байсан хуучин уламжлал эрс багассан байна. Нутгийн оршин суугчид “Одоо бид Улаанбаатар хотоос үйлдвэрийн бүтээгдэхүүн авчирч зардаг болсон” хэмээн хэлж байв. Зах зээл дээр худалдаалж байгаа нь ажиглагдсан тарвага хаанаас ирсэн нь тодорхойгүй байлаа.

Дотоодын болон олон улс дахь эрэлтээс хамааран тарваганы худалдаа үргэлжлэн явагдсаар байна. Хэдий тарвага ховордсон ч гол мэдээлэгч нарын хэлж буйгаар худалдаачид тарваганы арьс, үсийг сонирхсон хэвээр байгаа ажээ.

#### Хуулийн хэрэгжилт

Өмнө дурдсан тарваганы арьс болон бусад бүтээгдэхүүнийг хураан авсан талаарх бүртгэл мэдээллээс гадна судлаачдад хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл олж авах боломж маш хязгаарлагдмал байсныг дурдах нь зүйтэй. Тарвагатай холбоотой хууль хэрэгжилтийн талаарх судлаачдад ганц олдсон мэдээлэл нь нэгэн байгаль хамгаалагчийн ажиглалт байсан бөгөөд тэрбээр “хууль бусаар тарвага агнасан тохиолдолд залилангийн гэмт хэрэгт оногдуулдаг торгуулиас хоёр дахин өндөр хуулийн шийтгэл хүлээлгэдэг, гэвч хөдөөгийн иргэд орлого багатай учраас энэхүү торгуулийг төлөхөд маш хэцүү байдаг, үүний улмаас хууль хэрэгждэггүй” гэж хэлсэн юм.

# Ашигласан бүтээл

Actman, Jani. Four Tons of 'Plastic' Discovered to Be Smuggled Pangolin Scales. (Jun. 26, 2016). In National Geographic: Wildlife Watch. <http://news.nationalgeographic.com>.

Block, B. Illegal Pangolin Trade Threatens Rare Species. WorldWatch Institute. (2017). Eye on Earth online news service.

China Daily, Official Statistics Key to China's Fur Farming Industry, (Aug. 20, 2016) [http://www.chinadaily.com.cn/business/2015-08/20/content\\_21659731.htm](http://www.chinadaily.com.cn/business/2015-08/20/content_21659731.htm).

Chimed-Ochir B., Hertzman T., Batsaikhan N., Batbold D., Santjmyatav., Onon Yo, and Munhchuluun B. WWF Mongolia Report 2010: Filling the Gaps to Protect the Biodiversity of Mongolia. (2010). WWF Mongolia Programme Office.

Chow, A., Cheung, S. and Yip, P. (n.d.). Wildlife Markets in South China. (Spring 2014). Human-Wildlife Interactions 8(1), 108-112.

How CITES Works. CITES. <https://cites.org>.

CITES Trade Database (<https://trade.cites.org>)

Clark, Emma L. and Munkhbat, J., Dulamtseren, S., Baillie, J. E. M., Batsaikhan, N., King, S. R. B., Samiya, R., and Stubbe, M. (compilers and editors). (2006). Summary Conservation Action Plan for Mongolian Mammals. London: Zoological Society of London.

Conniff, R. (2016). Chinese Investors Are Driving the Slaughter of Rhinos. TakePart. Available at [www.takepart.com](http://www.takepart.com).

Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora. Programme for the Conservation and Sustainable Use of Falco Cherrug in Mongolia. Twenty-fifth meeting of the Animals Committee. Geneva, Switzerland. (18-22 July 2011).

COP17, CITES COP17 Proposals <https://cites.org>.

Coutts, E. and Jann, B. (2008). Sensitive Questions in Online Surveys: Experimental Results for the Randomized Response Technique (RRT) and the Unmatched Count Technique (UCT). ETH Zurich Sociology Working Paper, No. 3.

Decision 15/2: African Common Strategy on Combating Illegal Trade in Wild Fauna and Flora. available at <http://web.unep.org>.

Dixon, A., Nyambayar, B. Purev-Ochir, G., and Fox, N.

(2011). Developing a Sustainable Harvest of Saker Falcons (Falco Cherrug) for Falconry in Mongolia. Environment Agency, Abu-Dhabi and Mongolian Ministry of Nature, Environment, and Tourism.

Dizikes, Peter. (Dec. 16, 2013). The Surprising Story of Mongolian Shamanism. MIT News Office. <http://news.mit.edu>.

Donegan, John. (Nov. 2013). Traditional Medicine in Mongolia: Contrast and Continuity. The Acupuncturist, 8-9. Available at <http://thepindocor.blogspot.com>.

Drews, Carlos. (2001). Wild Animals and Other Pets Kept in Costa Rican Households: Incidence, Species, and Numbers. Society and Animals, 9:2. Koninklijke Brill NV: Leiden.

Droitcour, J., R. A. Caspar, M. L. Hubbard, T. L. Parsley, W. Visscher, and T. M. Ezzati. P. P. Biemer, R. M. Groves, L. E. Lyberg, N. A. Mathiowetz, and S. Sudman, editors. (1991). The item count technique as a method of indirect questioning: a review of its development and a case study application. In Measurement errors in surveys, 185-210. John Wiley: New York.

Duffy, Rosaleen & Dr. St. John, Freya. (Jun. 2013). Poverty, Poaching and Trafficking: What are the links? Evidence on Demand, 3.

Enterprise Surveys 2013, available at <http://www.enterprisesurveys.org/data/exploreconomies/2013/mongolia>

European Commission, The EU Approach to Combat Wildlife Trafficking, <http://ec.europa.eu>

Farmed Fur, Int'l Fur Trade Fed'n, ; We Are Fur, Fur Farming, [www.wearefur.com](http://www.wearefur.com).

Fernquest, Jon. (March 5, 2013). Rhino Horn Smuggling: Caught on Suvannabhumi Video. Bangkok Post. Available at [www.bangkokpost.com](http://www.bangkokpost.com).

Fijn, Natasha. (Apr. 2011). Living with Herds: Human-Animal Coexistence in Mongolia: The Domestic and the Wild. Cambridge University Press, 213.

Foley, K., Stengel, C., & Shepherd, C. (2011). Pills, Powders, Vials, and Flakes: The Bear/Bile Trade in Asia. TRAFFIC Southeast Asia Report.

Glanfield, Emma. (Mar. 27, 2014). Poaching Gang Caught Slicing Off Frogs' Legs and Selling Them To French Chefs on the Black Market. DailyMail UK. <http://www.dailymail.co.uk>.

Glynn, A.N. (2013). What can we learn with statistical truth serum? Design and analysis of the list experiment. Public Opin. Quart., 77(S1), 159-172.

Gratwicke, Brian, Mills, Judy, Dutton, Adam, Gabriel, Grace, Long, Barney, Seidensticker, John, Wright, Belinda,

- You, Wang and Zhang, Li. (July 2, 2008). Attitudes Toward Consumption and Conservation of Tigers in China. *Plos One*, 3(7).
- Haken, Jeremy. (February 2011). Transnational Crime in the Developing World. *Global Financial Integrity* 11. <http://www.gfintegrity.org>.
- Harper, Jennifer. (May 2015). \$60K a Pound: Illegal Rhino Horn Now Declared More Valuable than Gold, Diamonds, and Cocaine. *Washington Times*.
- Hastie, Jo and Tania McCrea-Steele. (2014). Wanted- Dead or Alive: Exposing Online Wildlife Trade. *International Fund for Animal Welfare*.
- Hinsley, A., Nuno, A., Ridout, M., St John, F., and Roberts, D. (Oct 2016). Estimating the Extent of CITES Noncompliance among Traders and End-Consumers: Lessons from the Global Orchid Trade. *Conservation Letters*, 00(0). 1–8.
- IUCN Red List, [www.iucnredlist.org](http://www.iucnredlist.org).
- Jagodinski G. 2001. "Region 3 News. e Federal Wildlife Officer." *Federal Wildlife Officers Association, Inc.* 15 (1) (Winter).
- Jenkins, Anna, Neil Bridgland, Rachel Hembery, Ulrich Malessa, James Hewitt, and Chen Hin Keong. Chatham House Workshop: Tackling the Trade in Illegal Precious Woods. April 23-24, 2012. Background Paper 1: "Precious Woods: Exploitation of the Finest Timber."
- Jila, N. (2006). Myths and Traditional Beliefs about the Wolf and the Crow in Central Asia Examples from the Turkic Wu-Sun and the Mongols. *Asian Folklore Studies*, 65, 169.
- Kaczensky, Petra, Namtar Enksaikhan, Oyunsaikhan Ganbaatar, and Chris Walzer. (2008). The Great Gobi B Strictly Protected Area in Mongolia- Refuge or Sink for Wolves *Canis Lupus* in the Gobi. *Wildlife Biology*, 14(4).
- Kimenyi, Mwangi S. March 6, 2015. The Dilemma of Destroying Ivory as an Anti-Poaching Strategy.
- Kuklinski, Cobb, and Gilens. (1997).
- Legal Atlas. <http://www.legal-atlas.net>.
- LeGrys, Sam. Grey to Green: The Wolf as Culture and Profit in Mongolia and the Importance of Its Survival, SIT Graduate Institute, 2009.
- Linnel, D., A. Trouwborst, L. Boitani, P. Kaczensky, D. Huber, S. Reljic, J. Kusak, A. Majic, T. Skrbinesk, H. Potocnik, M. Hayward, E.J. Milner-Gulland, B. Buuveibaatar, and U. Breitenmoser (2016). *Border Security Fencing and Wildlife: The End of the Transboundary Paradigm in Eurasia?*. <https://doi.org/10.1371/journal.pbio.1002483>
- Lkhagvasuren, B, Y. Adiya, G. Tsogtjargal, G. Amgalanbaatar, and R. Harris. (2016) "Current Status and Conservation of Mountain Ungulates in Mongolia" (2016). *Erforschung biologischer Ressourcen der Mongolei / Exploration into the Biological Resources of Mongolia*, ISSN 0440-1298.
- Martini, Maira, U4 Expert Answer: Wildlife Crime and Corruption, U4 Anti-Corruption Resource Centre (Feb. 15, 2013) (5). Mongolian Government. 2015. National Biodiversity Program (2015-2025). Mongolian Ministry of Environment, Green Development, and Tourism, World Wildlife Federation, United Nations Environment Program, GEF. *Mongolian Hunting Quota (2016): Дугаар 463 ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР 2016 ОНД АГНАХ АГНУУРЫН АМЬТНЫ ТООГ ТОГТООХ ТУХАЙ*.
- McConnell, Tristan. October 29, 2015. "The Ivory-Funded Terrorism Myth."
- Melville, C., O. Erdenedalai, and A. Woolley (2015). Overview of the Mongolian Legal System and Laws. *GlobaLex*, Hauser Global Law School Program
- "Монгол кирил үсгийн латин хөрвүүлгийн шинэ стандарт батлагдлаа" [New latinization standard for Mongolian cyrillic script approved]. 18 February 2012 (in Mongolian). [GoGo.mn](http://www.gogo.mn). Retrieved 16 January February 2017.
- Mongolia. (January 12, 2017). *CIA World Factbook*.
- Mongolia Customs General Authority at <http://customs.gov.mn>
- Mongolia General Authority for Border Protection at <http://bpo.gov.mn>
- Mongolia Government at <http://zasag.mn>
- Mongolia Tax Authority at <http://mta.mn>
- Mongolia Supreme Court at <http://supremecourt.com>
- Mongolia. Border Troops / Border Forces. *Global Security* ([www.globalsecurity.org](http://www.globalsecurity.org))
- Mongolia. *Trafficking in Persons Report 2016*. US State Department (July 1, 2016).
- Mongolia's Nesting Program Helps Save the Prized Saker Falcon. (Jul 2016). *Al Jazeera*. video available at <http://video.aljazeera.com>.
- Mongolian Statistical Information System ([www.1212.mn](http://www.1212.mn))
- Myagmaruren, Sh., Gombobaatar, S., Munkhjargal, M., Conaboy, N. (2014). *The Fifth National CITES Report of Mongolia*. (p. 54). (
- National Statistical Office of Mongolia. (2010). *Population and Housing Census of Mongolia*. Statistical Database. [www.1212.mn](http://www.1212.mn)
- Neme, Laurel. (Jun. 27, 2014). *For Rangers on the Front*



- Lines of Anti-Poaching Wars, Daily Trauma. National Geographic. (Jun 27, 2014)
- Nixon, Ron and Davenport, Coral. (October 5, 2015). Environmentalists Praise Wildlife Measures in Trans-Pacific Wildlife Pact.
- Nixon, Ron. December 22, 2015. "U.S. Pours Millions into Fighting Poachers in South Africa."
- Nowell, Kristin, Juan Li, Mikhail Paltsyn, and Rishi Kumar Sharma. October 2016. "An Ounce of Prevention: Snow Leopard Crime Revisited." TRAFFIC.
- Odaga, D. (2016) Where an Owl Egg Is Worth More Than Ivory or Rhino Horn, Explorers Journal on October 4, 2016 – citing cost of ivory in China in November 2015. Citing rhino horn prices in Vietnam in September of 2016.
- Official Statistics Key to China's Fur Farming Industry. (Aug. 20, 2016). China Daily. <http://www.chinadaily.com>.
- Only 7 Full Time Park Rangers Patrol 14 Million Hectares of Protected Areas in British Columbia. (Jun. 30, 2016). BCGEU.
- Otgonsaikhan, N. The Current Situation for Mongolian Foreign Trade and Cooperation with Northeast Asian Countries, Erina Report 127 (Dec. 2015) (8), available at <http://www.erina.or>.
- Oxford Business Group. Mongolia builds new partnerships in trade and investment, with China and Russia and beyond. Accessed online at <https://www.oxfordbusinessgroup.com/overview/mongolia-builds-new-partnerships-trade-and-investment-china-and-russia-and-beyond-0>
- Parkinson, Andrew M., Odonchimeg Nyamtseren, Tuvshinjargal D., Amanda Fine. May 2008. "World Bank FLEG Ulaanbatar Wildlife Trade Survey: Wildlife Conservation Society Report." Wildlife Conservation Society.
- Peru Seizes 8 Million Seahorses Illegally Bound for Asia On Chinese-Flagged Vessel [Television broadcast]. (2016, June 22). In ABC News Australia. AFP/ABC.
- Plumer, Brad. November 6, 2013. Washington Post. Wonkblog. "The Grisly Economics of Elephant Poaching."
- Plumptre AJ, RA Fuller, A Rwetsiba, F Wanyama, D Kujirakwinja, M Driciru, G Nangendo, JEM Watson & HP Possingham, Efficiently Targeting Resources to Deter Illegal Activities in Protected Areas. *Journal of Applied Ecology* (79) (2014) doi: 10.1111/1365-2664.12227.
- Poppick, L. (2014). The Women Who Removed Birds From People's Hats. Popular Science. Available at <http://www.popsoci.com/blog-network/ladybits/women-who-removed-birds-peoples-hats>.
- Post "General Authority for Border Protection and WWF Mongolia have a Memorandum of Understanding" on June 10, 2011 at WWF Mongolia site (<http://mongolia.panda.org/en/?200594/Ge>)
- Prices of Exotic Animals and Wildlife. Harvoscope Global Black Market Information.
- Raghavarao, D. and W. T. Federer (1979). Block Total Response as an Alternative to the Randomized Response Method in Surveys. *Journal of the Royal Statistical Society, Series B.* 41 (1): 40–45.
- Relations Between the Netherlands and Mongolia. Government of Netherlands: International Relations. <https://www.government.nl>.
- Report on the Review of Vietnam's Wildlife Trade Policy. 2008. CITES Scientific Authority of Vietnam.
- Sellers, J. (2017) What Wildlife Trade Enforcement Can Learn from Drugs and Arms Enforcement. Global Initiative Against Transnational Organized Crime.
- Shepherd, C., Eaton, J., & Chng, S. C. L. Pittas for Pittance: Observations on the Little Known Illegal Trade in Pittadae in West Indonesia, *BirdingASIA* 24(2015): 18-20, available at <http://www.traffic.org>.
- Sindelar, Daisy. (December 9, 2009). Mongolian Democracy: From Post-Soviet Success to Post-Transition Struggle. Radio Free Europe/Radio Liberty.
- Shagdar, Enkhbayar, Recent Trends in Mongolian Foreign Trade with Northeast Asian Countries, Purdue: Global Trade Analysis Project (Apr. 2010), available at <https://www.gtap.agecon.purdue.edu>.
- Smith, David, Chinese 'Ivory Queen' Charged with Smuggling 706 Elephant Tusks, *The Guardian* (Oct. 8, 2015), <https://www.theguardian.com>.
- Sneath, David, Russia's Borders: Mongolia Looks to Its Old Big Brother to Counterbalance China, *The Conversation* (Jan. 27, 2015), <https://theconversation.com>.
- "Socialist Legal Systems" at <http://lawin.org>. 07, 2013.
- Steyn, Paul. May 26, 2015. National Geographic. "As Animal Poaching Surges, Organized Crime Plays Bigger Role." Available at [news.nationalgeographic.com](http://news.nationalgeographic.com).
- Stibich, Mark, Use of Traditional Medicine in Mongolia: A Survey. *Contemporary Therapies in Medicine* (Mar. 2002) (43).

- “Summary of Reports and Other Documents, Delivered to the World Bank Mongolia Office During Preparation and Implementation of Mongolia Ungulate Surveys, which was Supported by the NEMO II Project.”
- TanzaniaInvest.com, Tanzania Tourism Sector Report 2015: Record Of Arrivals In 2014, (Dec. 14, 2015)
- The Conversation, The Changing World of Perfume and Why Some Chemicals are Being Taken Out, (Nov. 27, 2014) <https://theconversation.com>.
- Thin Green Line Foundation, What We Do, <https://www.thingreenline.org.au/>.
- The Guardian, African Elephants Could Be Extinct in Wild Within Decades, Experts Say, (Mar. 24, 2015).
- The Mongolist Blog, Rethinking Ulaanbaatar’s Population (May, 2014) quoting Data from table “Хүн амын тоо, хүйсээр, оны эхэнд, мянган хүн” at: <http://ubstat.mn/StatTable=11>, available at <http://www.themongolist.com>.
- The Mongolist Blog, Rethinking Ulaanbaatar’s Population (May, 2014), available at <http://www.themongolist.com/blog/society/89-rethinking-ulaanbaatar-s->
- The White House. National Strategy for Combating Wildlife Trafficking, <https://www.whitehouse.gov>.
- Theunissen, Tirza, Poverty, Inequality, and the Negative Effects of Mongolia’s Economic Downturn, The Asia Foundation (Jun. 25, 2014).
- Thin Green Line Foundation, What We Do, <https://www.thingreenline.org.au/>.
- TRAFFIC. May 1997. “Rhinoceros Horn and Tiger Bone in China: An Investigation of Trade Since the 1993 Ban.”
- TRAFFIC. July 3, 2014. “Market Survey Finds Disturbing Increase in Thai Ivory Market.”
- TRAFFIC, Background: Trade, <http://www.traffic.org/trade>
- Tsuchiya, Hirai, and Ono 2007; Holbrook and Krosnick 2010; Coutts and Jann 2011.
- UN Chronicle Vol. LI No. 2 2014.
- UNEP. Emerging Issues Update: Illegal Trade in Wildlife. Available at <http://www.unep.org/yearbook/2014/PDF/chapt4.pdf>
- UNEP’s illegal Trade in Wildlife Factsheet from May 2016, available at <http://www.unep.org>.
- UNDP. 2011. Mongolian Human Development Report 2011. Ulaanbaatar, Mongolia: Government of Mongolia, United Nations Development Programme Mongolia, and Swedish International Cooperation Agency. (Available at [mn.undp.org](http://mn.undp.org))
- UNDP, Inequality in Mongolia, (Aug. 13, 2015), <http://www.mn.undp.org>.
- United Nations, New York.
- United Nations Department of Social and Economic Affairs, Trends in International Migrant Stock: The 2015 Revision.
- United Nations Economic and Social Council resolution 2013/40, Crime prevention and criminal justice responses to illicit trafficking in protected species of wild fauna and flora, E/RES/2013/40 (25 July 2013), available from <https://www.unodc.org>.
- United for Wildlife, What is SMART?, available at <http://www.unitedforwildlife.org>.
- UNODC, Estimating Illicit Financial Flows Resulting From Drug Trafficking and Other Transnational Organized Crimes, Oct. 2011 (38). <https://www.unodc.org>.
- UNODC. 2016. World Wildlife Crime Report: Trafficking in Protected Species.
- USAID (2004). Assessment of Mongolia’s Free Trade Zone Program and Site Evaluation. Mongolia Economic Policy Reform and Competitiveness Project (EPRC).
- USAID: Mongolia (Apr. 16, 2016), <https://www.usaid.gov/mongolia>.
- U.S. Fish & Wildlife Service International Affairs, US Conservation Laws: Lacey Act, <https://www.fws.gov>.
- Vallianas, Christina. 2014. “Rhino Horn Demand.” WildAid.
- Vallianos, Christina. “Ivory Demand in China 2012-2014.” WildAid.
- Voice of America. November 2, 2009. “Thailand calls for Wildlife Trade Enforcement.”
- Wassener, Bettina. March 12, 2013. “No Species is Safe from Burgeoning Wildlife Trade.”
- Waymer, J. (2014) Could Sharks Be Headed for Extinction? (Aug. 13, 2014)
- Wildlife and Science Conservation Center of Mongolia, Cinereous Vulture Research and Conservation, <http://www.wssc.org>.
- Wildlife Conservation Society. March 31, 2009.

“Protecting Mongolia’s Wildlife through Wildlife Trade Law Enforcement.”

Wilford, N. 2005. In Mongolia, an Extinction Crisis Looms. The New York Times. Science Section. Available at <http://www.nytimes.com/2005/12/06/science/in-mongolia-an-extinction-crisis-looms.html>

Winchester, Levi, Rhinos ‘Could Become Extinct in Just Over 10 Years Time’ if Poaching Continues, UK Express Mail (Jan. 17, 2015)

Wingard, J and P. Zahler. (2006) Silent Steppe: The Illegal Wildlife Trade Crisis in Mongolia. Wildlife Conservation Society.

Wong, Chun Han. December 31, 2016. “China to Shut Down Ivory Trade by End of 2017.”

World Atlas, The 10 Least Densely Populated Places in the World (2016) <http://www.worldatlas.com>

World Bank. 2010. Mongolia Economic Retrospective 2008-2010. World Bank.

World Bank, WB Update Says 10 Countries Move Up in Income Bracket (Jul. 1, 2015), <http://www.worldbank.org>.

World Customs Organization. Guidelines For The Procurement And Deployment Of Scanning/NII Equipment. April 2015.

World Customs Organization, Illicit Trade Report 2012, (2013) 36.

World Integrated Trade Solution. The World Bank. [www.wits.worldbank.org](http://www.wits.worldbank.org)

World Trade Organization Trade Policy Review of Mongolia, WT/TPR/G/297, 2014.

World Wildlife Fund, Asia: China and Mongolia, <http://www.worldwildlife.org>.

Yellowstone National Park, Wolf Reintroduction Changes Ecosystem, <http://www.yellowstonepark.com>.



Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл та манай веб хуудсаар зочлоорой: [zsl.org/conservation](https://zsl.org/conservation)

**ZSL** | **LET'S WORK  
FOR WILDLIFE**

Animals and their habitats face increasing threats across the world. Donate to ZSL to help build a future where animals are valued and their conservation assured.  
ZSL is a registered charity in England and Wales no: 208728